



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

АГШИНЗУУРГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 7



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

АГШИНЗУУРГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 7

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

**АГШИН ЗУУР  
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР**

Долоодугаар дэвтэр

**АГУУЛГА**

Хайрын замаар замнахуй.....	6
Нирваанаас гараад дэлхийд ирж залрахуй.....	11
Бурхнаас бидэнд заяасан элбэг баян амьдралыг нандигна .....	29
Үнэний тухай хүүрнэл яриа.....	39
Чанагуухи ертөнцийн нууц.....	91
Бид аль хэдийнээ гэтлэгдчихсэн .....	122
Бурхны бүх бүтээл нэгдмэл.....	130
Үргэлж нирваанд орших арга.....	146
Лууз, Жуанз болон тэнгэрийн хөгжим.....	151
Өөрийгөө уучил.....	165
Амьдралдаа өнгө нэмж солонгоруулъя.....	187
Асар их шунал хүсэлтэй хаан.....	199
Гэгээн хааны нигүүлсэл .....	208
Сэтгэлийн авшиг-Арьяабалын бясалгалын арга .....	220
Таван сахил .....	222
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт.....	223
“Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр Үлгэр дэвтэр.....	229
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ?.....	230

## БЯЦХАН ИЛГЭЭЛТ

Оройн Дээд Бурхан болон Дээд Сүнсний тухай ярихдаа Бурхан эр, эсвэл эм хүйстэй аль нь болох тухай гарч болзошгүй маргаанаас зайлсхийж, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүйсийн ялгаа заадаггүй нэр томъёог хэрэглэдэг.

She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)

Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)

Hers + His = Hiers (Dears гэдэгтэй адил дуудна.)

Жишээлбэл: Бурхан хүсвэл Тэрбээр (Hes) юмсыг Өөрийн (Hirmself) таалалд нийцүүлж, Түүний (Hiers) хүсэл зоригийн дагуу зохицуулдаг.

Уран бүтээлч, бурханлаг багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоод гоо сайхны аливаа илэрхийлэлд дуртай. Тиймээс ч Тэрбээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь “Аз жаргал” гэсэн утгатай Вьетнам орны эртний нэр. “Үзэсгэлэнтэй” гэсэн утгатай Формоса хэмээх нэр энэ арлын орон болон хүн ардынх нь гоо сайхныг илүү төгс төгөлдөр илэрхийлдэг.

Төгс Гэгээрсэн Их Багш энэ нэрсийг хэрэглэх нь нутаг орон хийгээд оршин суугчдад нь бурханлаг хөгжил дэвшил, аз хийморь авчирна гэж үздэг юм.

“Би Бурханы юмуу Католик шаашинтны аль нь ч биш. Би Үнэнд хамаарч, Үнэнийг л номлодог. Та үүнийг Бурханы шаашин, Католик шаашин, Бумбын шаашин гэх юмуу ер хүссэнээрээ л нэрлэ, би бүгдийг нь дуртайяа хүлээн авна.”

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

“Дотоод амар амарлингуйгаа олж авснаар бид бусад бүх зүйлийг олж авна. Сэтгэл бүрэн ханаж, тэнгэрлэг диваажин болоод газар дэлхийн эрмэлзэл хүслэн бүхэн биелэн гүйцэлдэх нь бидний хамгийг чадагч хүч, мөнхийн билгүүн ухаан, мөнхийн нийцэл зохирлын дотоод ухаарахуй болох - Бурхны орноос ирдэг юм. Энэ бүхнээ эс олвоос бид хэчнээн их мөнгө хөрөнгөтэй, нийгэмд хэчнээн өндөр байр суурьтай байлаа ч хэзээ ч сэтгэл хангалуун болж чадахгүй.”

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

“Сургаал маань та энэ дэлхий дээр юу л хийх ёстой, түүнийгээ хий, хамаг зүрх сэтгэлийн угаас хий, хариуцлагатай байж, түүнийхээ зэрэгцээ өдөр бүр бясалгал хий гэдэгт оришино. Өөртөө болон дэлхий ертөнцөд үйлчлэхийн тулд та улам их амар амирлангуй, улам их билгүүн ухаан, улам их эрдэм мэдлэгийг олж авна. Таны дотор өөрийн тань сайн сайхан чанар оршин буйг бүү март. Бие цогцост тань Бурханлаг оршихуй буйг бүү март. Зүрх сэтгэлд тань Бурхан оршиж буйг бүү март.”

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

## ХАЙРЫН ЗАМААР ЗАМНАХУЙ

### Амьд Төгс Гэгээрсэн Их Багшийн мөрөөр замнахуй

Хорвоогийн өнцөг булан бүхний  
Хамаг амьтанд зориулах гэж  
Дэндүү жаахан хайрыг,  
Дэндүү жаахан хайрыг,  
Дээгүүр чиг, доогуур чиг  
Эрэн хайнам, бид.

Уулзан учирч эсвэл хамтран ажиллах аз завшаан тохиосон хэн бүхэнд танигдан хайрлагдаж байдаг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хайрын замаар замнах тухай захиасаа үлдээдэг билээ.

Дэлхийд нэрд гарсан оюун санааны хөтөч, хүмүүнлэг үзэлтэн, уран бүтээлч Тэрбээр гачигдаж дутагдсан болон орон гэргүй хүмүүс, ДОХ болон хорт хавдрын салбар дахь анагаах ухааны судалгааны хүрээлэнгүүд, АНУ-ын дайны ахмад дайчид, гачигдалтай ахмад настан, бие махбодын болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, дүрвэгсэд, ядуурал, газар хөдлөлт, үер, хар салхи, гал түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүс гэхчлэн дэлхийн өнцөг булан бүрд сая сая хүмүүст аливаа арьс өнгө, соёл суртлын ялгааг үл харгалзан хайр халамж, тусламжийн гараа сунгаж байдаг билээ. Түүний нинжин сэтгэлд хүмүүс төдийгүй мөн хамаг амьтан адислагдаж, цаглашгүй ивээл хайрыг хүртдэг юм.

Энэхүү халамжит хатагтайн хайр нигүүлсэл, түүний хайрын үлгэр дууриаллаас үүссэн олон улсын сангийн олон сайн үйлсийг хүмүүс бид дурсаж байдаг билээ. «Бид юуг хуваалцаж болохоор байна, тэр бүхнээ хуваалцахаас эхэлдэг. Ингэснээр бид дотооддоо нарийн өөрчлөлтийг мэдэрнэ - бидний ухамсарт илүү их хайр урсан ороход бид ямар нэг зүйлийг ухаарч сэхээрнэ. Энэ бол ердөө л эхлэл. Бид энд суралцах гэж, өсч хөгжихийн тулд суралцах, түүнчлэн бид хаана байлаа ч гэсэн эх дэлхийгээ улам сайхан болгохын төлөө өөрсдийн хязгааргүй хүч чадал, хайр, бүтээх чадвараа ашиглаж сурахаар энд ирсэн билээ».

### Амьдралын эхэн үе

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Ау Лак (Вьетнам)-ын төв нутагт мэндэлжээ. Бага насандаа эмнэлэгийн өвчтөн, зовж зүдэрсэн хүмүүс, мөн шархадсан амьтдад чадах чинээгээрээ хичээн тусалж байхыг нь хүмүүс олонтоо хардаг байжээ. Хожим нь Европт суралцахаар ирж, улмаар тэндээ Улаан Загалмайн нийгэмлэгт орчуулагчаар ажиллажээ.

Удалгүй Тэрбээр зовлон зүдгүүр дэлхийн хаана ч, аль ч ард түмний дунд нэгэн адил орших байгааг ухаарч, үүнээс гэтлэн гарах арга замыг эрж олохыг амьдралынхаа эрхэм зорилго болгожээ. Тухайн үед Герман эмчтэй гэрлэж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх амаргүй шийдвэрийг гаргажээ. Ийнхүү Тэрбээр сүнслэг ойлголтыг эрэлхийлэх хоёр жилийн аянд мордсон билээ.

### Хималайд бадарчилсан нь

Эцэст нь, Энэтхэгийн Хималай уулын хамгийн гүнд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшаас дотоодын Гэрэл, Аялгууг ажих Арьяабалын Бясалгалын Аргыг (Гуан Инь бясалгал) уламжлан авчээ. Хэсэг хугацааны турш бясалгасны дараа Тэрээр төгс гэгээрсэн байна.

Хималайн уулнаас буцаж ирснийхээ дараа эргэн тойрны хүмүүсийн шаргуу гуйлт хүсэлтээр Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг бусадтай хуваалцаж, тэднийг агуу мөн чанараа танихын тулд өөрийн дотоод руугаа хандахыг урамшуулан зоригжуулсан юм. Нийгмийн бүхий л давхаргын хүмүүс Арьяабалын бясалгалын аргын тусламжтайгаар өдөр тутмынхаа амьдралд амар амгалан, аз жаргал, асар их сэтгэл ханамжийг олсон байдаг. Удалгүй АНУ, Ази, Европ, Австрали, Африк болон Өмнөд Америк, мөн түүнчлэн томоохон байгууллагуудаас ном сургаал айлдах урилга хүлээн авдаг болжээ.

### Амьдарч буй дэлхийгээ үзэсгэлэн төгөлдөр болгоё

Их Багш Чин Хай хүмүүнлэгийн үйлсийн эрхэм үлгэр жишээ болохын зэрэгцээ бас хүмүүсийг амьдарч байгаа дэлхийгээ улам сайхан болгохыг урамшуулан дэмждэг билээ. Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг дадуулснаар аяндаа олж нээсэн олон авъяас чадвараа чамин тансаг гэрэлтүүлэг дэнлүү, хөгжим, яруу найраг, уран зураг гэх мэт бүтээл туурвилаараа дамжуулан илэрхийлж, түүнчлэн уулзан учирсан ард түмэн болон соёлын дотоод болон гадаад гоо сайхныг

илтгэсэн хувцасны загвар дизайн, гоёмсог сайхан үнэт эдлэлүүдийг зохион бүтээжээ. 1995 онд олон нийтийн хүсэлтээр Түүний хувцас загварын бүтээлүүд нь Лондон, Парис, Милан, Нью-Йорк зэрэг олон улсын хувцас загварын тоглолтуудаар аялан оролцжээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн уран бүтээлийн орлого нь Бурханы хүүхдүүдэд шаардлагатай үед нь тус хүргэх эрхэм зорилгыг нь дэмжих хүмүүнлэгийн үйлсийг санхүүжүүлэх бие даасан эх үүсвэрийг бий болгох боломж олгодог байна.

### Шагнал өргөмжлөл ба Их Багшийн мөрөөдөл

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүнлэг ажил үйлсийнхээ хариуд ямарваа нэг гавьяа шагнал горьддоггүй ч дэлхийн улс орнуудын төр засаг, хувийн байгууллагууд түүнд хүндэт шагналуудаа олгодог билээ. Эдгээрийн дунд Дэлхийн Энхтайвны Шагнал, Дэлхийн Оюун санааны Удирдагч шагнал, Хүний эрхийг хөхиүлэн дэмжсэний төлөө шагнал, Дэлхийн Иргэн Хүмүүнлэгийн үйлсийн төлөөх шагнал, Хүн төрөлхтний Гарамгай зүтгэлтний шагнал, 2006 оны Гүси Энхтайвны шагнал, Лос Анжелесийн Хөгжмийн Долоо Хоногийн Сайшаалын гэрчилгээ, 2006 оны 27 дахь Телли шагналын Тэргүүн байрын Мөнгөн цом зэрэг багтаж байна. Үүнээс гадна АНУ-д жил бүрийн 10 дугаар сарын 25 болон 2 дугаар сарын 22-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” хэмээн зарлан тунхаглажээ. Хонолулу хотын дарга асан Фрэнк Фази “Тэр бол агуу хүний гэрэл гэгээ, бид бүгдийн хувьд энэрэл нигүүслийн сахиулсан тэнгэр” хэмээжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол ирээдүйгээ үзэсгэлэнтэй сайхнаар төсөөлөн бүтээхэд бид бүхэнд тусалж буй манай эрин үеийн жинхэнэ үнэнч, гарамгай хүмүүсийн нэг билээ.

Түүхэнд үе үеийн олон агуу хүн мөрөөдөлтэй байсан лугаа адил Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай мөрөөдлөө ийнхүү өгүүлсэн байдаг:

*“Бүх дэлхий даяараа амар амгалан болоосой гэж би мөрөөддөг.*

*Бүх аллага зогсоосой гэж би мөрөөддөг.*

*Бүх хүүхэд амар амгалан, эв зохиролтой алхаасай гэж мөрөөддөг.*

*Бүх улс үндэстэн гар барилцан мэндчилж,  
бие биенээ хамгаалж, харилцан туслаасай гэж  
би мөрөөддөг.*

*Олон тэрбум, их наяд жилийн хөдөлмөрөөр  
бүрэлдэн тогтсон энэ гараг дэлхий маань  
машид үзэсгэлэнтэй бөгөөд гайхамшигтай.  
Түүнийг энэ л чигээрээ, гэхдээ амар амгалан,  
гоо үзэсгэлэнтэй, хайраар дүүрэн үргэлжлэн  
оршоосой гэж би мөрөөддөг.”*

## ETTV хиймэл дагуулын сувгуудаар гарч буй Урлагийн ертөнцөөр аялахуй нэвтрүүлэг:

RTDS Африк	Cell суваг 21, Бямба гарагийн 20:00-21:00 цагт (Того Ломе)
ETTV	ETTV Super X суваг: Ням гарагт 12:00-12:30 цагт (Тайбэйгийн цагаар)
ETTV Asia	Ази, Номхон далайн 27 улсыг хамардаг. Ням гарагт 10:00-10:30 (Тайбэйгийн цагаар) кабель/сансрын хиймэл дагуулаар
ETTV Америк	Хамрах хүрээ: Хойд Америк: АНУ (үүнд Хавай, Аляска, Канад) Бямба гарагт 10:00-10:30 (PDT [Лос Анжелес ийн цагаар]) кабелиар /хиймэл дагуулын ТВ Кабелийн телевизийн үйлчилгээ: Өмнөд Калифорни (Time Warner; Charter Communications; Adelphia; Champion; Altrio; Cox)
ETTV Латин Америк	Хамрах хүрээ: Хойд Америк: АНУ, Төв Америк, Өмнөд Америк, Карибын тэнгисийн бүс: 14 улс орно. Үүнд Доминиканы Бүгд Найрамдах Улс, Гаити, Куба багтаж байна. Ням гарагт 10:00-10:30 (PDT [Лос Анжелесийн цагаар]) кабелийн/хиймэл дагуулын телевизээр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэг нь Төгс Гэгээрсэн Их Багшийн үнэний тухай мэргэн ухааны айлдваруудыг хуваалцах “Урлагийн ертөнцөөр аялах нь” телевизийн нэвтрүүлгийн цуврал бичлэгүүдийг дэлхийн улс орнуудын телевизийн станцуудад санал болгодог. Дэлгэрэнгүй мэдээллийг TV@Godsdirectcontact.org хаягаар захидал илгээн лавлана уу.

## НИРВААНААС ГАРААД ДЭЛХИЙД ИРЖ ЗАЛРАХУЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1992 оны 2 дугаар сарын 23 (Дүрс бичлэг 214)  
Малайз улс, Пенанг (Эх нь Англи хэлээр)*

Энэ бүхэн аймшигтай байна. Жимсний хаягдлыг ч ялзмаг болгоод дараа нь эргүүлээд бордоо болгож болдог шүү дээ. Яагаад тэнгист хаячихдаг юм бэ? Жишээлбэл, тэр хаягдал нь органик ургамал болж болно эсвэл байгалийн бордоо ашигладаг ургамлын аж ахуй болог л доо. Хүмүүс үүнийг яагаад хаях ёстой гэж!?

Ямар ч байлаа гэсэн энэ бүхэн нь замбараагүй явдал; улс үндэстэн бүхэн өөрийн гэсэн ашиг сонирхолтой. Би бүх улс үндэстнийг ийм гэж хэлээгүй байна, гэхдээ ихэнх нь ийм байна. Бүх дэлхий даяараа аль хэдийнээс мэддэг, хамаг Будда (төгс гэгээрсэн хүн) нарын мэддэг байсан зүйлийг хүн бүр өөрийн нууц хэмээгээд, хардаж сэрдэн хамгаалаад байх юм. Тэд энэ бол нууц гэж боддог. Тэд энэ бүх нууцаа л хамгаалаад байхаас биш, бие биедээ олигтойхон тусалдаггүй. Тус хүргэсэн нэгнээ бусад нь ашиглаж хонжихыг л боддог, инээж тохуурхана, бас тэгээд дахиад өгч чадахгүй болтол нь дарамталдаг; тэгэнгүүт л тэд дахин тусалж чадахаа болино, эсвэл маш олон таагүй зүйл хийх болно.

Манай дэлхий бүх зүйлээр элбэг баян. Бид бүхнийг, бүх гараг дэлхийгээ ч тэжээж чадахаар барахгүй, тариалан эрхлэх хөрс шороогүй, эсвэл ашигт малтмал нь устаж үгүй болсон ч юмуу, “Оддын дайн” мэтийн зүйлд өртөн уур амьсгал нь хордсон зэргэлдээ оршигч гучин гурван гараг эрхэс рүү экспортолж болох билээ. Бид тэдэнд шинэхэн ногоо жимсээ экспортолж, үүнийхээ оронд тэдний ҮМНБ (Үл Мэдэгдэх Нисдэг Биет) гэх мэтийн зүйлийг нь импортоор авч болно шүү дээ. Тийм шүү. Бид харилцан солилцож болно. Тэдний гойд сайн машин тоног төхөөрөмжийг импортоор авч, оронд нь тэдэнд өөрсдийнхөө дүфү (Инээлдэв), улаан шош, тутарга, улаан буудай гэх мэтийг экспортолж; тэр ч байтугай үзэж хараг гээд муур, нохой, шувуугаа ч өгч болно. Тэдний зарим гараг эрхэст ийм зүйл тийм ч олон байдаггүй. Уур амьсгал нь сүйтгэгдсэн учраас тэнд хүмүүсээ арай чүү л байлгадаг. Тэд уур амьсгал, хүчил төрөгч болон бусад элдэв зүйлээ дахин боловсруулж

эргүүлэн ашиглах хэрэгтэй болдог тул хүн амынхаа тоог хязгаарладаг учраас тэжээвэр амьтан байлгаж байх боломжгүй. Гэтэл харин бидэнд тэр бүү хэл уур амьсгалаа ч тэдэнд экспортлох боломж бий; Дэлхийнхээ хүчил төрөгчөөс савлаанд тэдэнд тус бүрт нь нэгийг хайрлан энэрэх сэтгэлээр бэлэглэж болно. Тэд ингэж чадна шүү дээ.

Хэрвээ дэлхийн удирдагчид амиа хичээсэн шунахай зантай байх нь ямар хор хөнөөлтэйг; иймэрхүү хандлага өөрсдийнх нь хувьд ч өнө үүрдийнх байж чадахгүйг; эцсийн эцэст өөрсдөд нь, тэр бүү хэл дараа үеийнхэн, үр хойчид нь ч хичнээн хор хохиролтойг ойлгож ухаарсан бол. Хэрвээ бүх Ертөнц даяар бидний холбоо тогтоож, харилцвал зохих бусад гараг эрхэс, соёл иргэншил байдгийг, бид тэднээс суралцахыг хичээж, нэг нэгнээсээ ашиг тус хүртэж болохыг ойлгож ухаарвал тэд хоорондоо маргалдаж, дайтаж байлдахаа зогсооно. Тэд ядахнаа л дайтахын оронд энх тайвныг тогтоох арга замыг эрж олох ба үүнд хамаг санхүүгийн нөөц юмуу эрч хүчээ чиглүүлэх ёстой юм.

Гэвч одоо би хэн нэг хүнтэй хэрхэн ярьж чадах билээ? Бид ерөнхийлөгч нарыг нэг нэгээр нь ээлж дараалан эрж хайж эхлэх ёстой юу? Тэднийг Хайр болон Гэрлийн туяа - T.L.C. (T.L.C. нь “Tender Loving Care” – “Зөөлөн Хайр Халамж” гэсэн үгийн товчлол ажээ) - гаараа цохиж унагаана. (Инээлдэв) Бид тэднийг T.L.C. - зөөлөн хайр халамжаараа буулгаж авна. Бид тус бүрд нь гурван уут хайр бэлэглэнэ. Харин тэд үүнийг залгичихвал – хэрвээ би дэлхийн удирдагч нарт хандвал тэд намайг өөрсдөөс нь ямар нэг зүйл хүсээд байна гэж бодож магадгүй, учир нь хүн болгон л бусдаас ямар нэг зүйл хүсэн хүлээж байдаг. Тийм учраас тэд ингээд бодчихож мэднэ. Хэн нэг хүн ямар нэг зүйл хийсэн л бол хариуд нь юу ч горьдохгүй байх нь тун ховор. За тэгвэл, надад харин ч хариуд нь хүсэх зүйл бий шүү. Би тэднээс хүмүүсийг халамжлаасай, ард түмнийхээ төдийгүй, бас бүх гараг дэлхийнхээ төлөө амьдралаа чин сэтгэлээсээ зориулаасай; бидний буруу хийсэн зүйлсийг залруулж; гараг дэлхийгээ үзэсгэлэнтэй сайхан байлгаасай, бидний арга барил, машин техник, амьдрах хэв маяг, ухаарч ойлгох арга байдлыг сайжруулж, энэ дэлхийн болон боломжтой бол бусад гараг дэлхийн зовлонг нимгэлэхийн төлөө энэ дэлхийгээс чанадад орших бусад ертөнцтэй холбоо тогтоохыг хичээгээсэй гэж хүснэ.

Хэрвээ бид үнэхээр л дэлхийн удирдагчид, эсвэл улс үндэстний удирдагчид мөн юм бол уужим ухаанаар сэтгэж, ажил үйлсээ тийм далайцаар хийх ёстой; ердөө л багахан бүлэг: улс төрчид, үндэстний хэсэг бүлэг, сонирхож буй хүмүүсээ л анхаарч халамжлахын оронд, эсвэл бидний тусламж, бидний бүлэг, бидний дэмжигчид, тэр бүү хэл ганцхан манай улс үндэстэн гээд байхын оронд маш уужим дэлгэр бодож сэтгэх хэрэгтэй. Оюун ухаан, зүрх сэтгэлээ тэлэхийн оронд ийм явцуу хүрээнд бодож сэтгэх аваас бид өөрсдийгөө л доройтуулна.

Энэ тун хэцүү, гэхдээ бид засаж чадна. Хэрвээ цаг нь болж, дэлхийн байдал муугаар эргэвэл тэр цагт хүмүүс ухаарч сэхээрэн нэгдэж нийлнэ. Бид нэгдэж нягтарна. Заримдаа бид ухаарч сэхээрэхгүй байгаад байхаар Биднийг нойрноос маань дугтран сэрээхийн тулд Бурхан байгалийн гамшигийг үр дагавар, мөн засах арга хэрэгсэл болгож ашигладгийн учир нь энэ юм. Гэвч ингэх нь дэндүү эмгэнэлтэй хэрэг бөгөөд үр нөлөө нь маш урт удаан үргэлжилдэг. Бид байгалийн гамшгаас урьтаад өөрсдөө ухаарч сэрчихвэл тун сайнсан. Бид нэг хэсэгтээ сэгсэрч дугтруулна, тэгснээ муу дадал зуршилдаа буцаж автаснаар туулж өнгөрүүлсэн урьдын ач тустай туршлагаасаа суралцан сайжрах чадваргүй болчихдог.

Бид хангалттай уруудаж доройтсон тул дэлхийн удирдагчид бидний амьдралын хэв маягийг өөрчлөх ёстойгоо ухаарах байх гэж би найддаг. Тэд амьдралаас илүү томоор сэтгэх ёстой. Тэд өөрийн улс үндэстний хил хязгаараас давж сэтгэх ёстой. Манай дэлхийн уур амьсгалын хил хязгаараас давж сэтгэх ёстой. Эс тэгвэл бид аугаа сүр хүчээ дэмий үрсэн хэрэг болно: гэдсээ тэжээхийн тулд амьтад, эсвэл шоргоолж шиг л ажиллаж амьдарна, зөвхөн ойр тойрныхон, хамаатан садан, найз нөхөд, эсвэл улс үндэстнийхээ тухайд л анхаарч халамжилна. Шоргоолжнууд ингэдэггүй гэж үү? Зөгийнүүд ингэдэггүй гэж үү? Тэд бидний заримаас ч илүү зохион байгуулалттай. Тэр ч байтугай заримаас маань ч илүүтэйгүүр нэг нэгнээ дэмжиж тусалдаг. Тэд бидний заримаас ч илүүтэй бие биенээ хайрладаг. Тэд “олзоо” өөр хоорондоо адил тэнцүү хуваадаг. Тэд хамтарч ажилладаг, байгаа юмсаа нийлүүлээд өөр хоорондоо хуваалцдаг.

Бидэнд юм бүхэн хүрэлцээтэй. Бидэнд дэндүү их юм байна. Дэлхий маань урьдынх шигээ маш баян тансаг хэвээрээ байна. Янз бүрийн ашигт малтмал, байгалийн нөөц баялаг гээд бүх зүйлээр элбэг баян. Тэр бүү хэл нефть байхгүй байлаа ч бид машинаа ажиллуулах өөр нэг зүйлийг олчихно Үл Мэдэгдэх Нисдэг Биетэд түлш шатахуун байдаггүй. Тэдэнд тос шатахуун хэрэг болдоггүй. Та нар Ангараг гарагаас энд хангалттай их түлш шатахуун аваад ирж чадах уу? Далан найман сая километр хол. Тийм билүү? Ангараг бол хамгийн ойрхон гараг, тийм биз дээ? Юутай ч очоод буцаж ирэхэд бидний түлш шатахуун хүрэлцэхүйц ойрхон. Үнэндээ бол тийм ч ойрхон биш ээ. Эндээс Хонг Конг орохтой адилгүй; бид бүгдээрээ л мэдэж байгаа!

Янз бүрийн зориулалтаар ашиглаж болдог шатахуун байдаг. Дээд ертөнцүүдэд бидэнд хэрэгтэй шиг тийм шатахуун байдаггүй. Энэ нь дэндүү төвөгтэй, дэндүү хэцүү зүйл. Тэд эрчим хүчний янз бүрийн төрлийг ашигладаг бөгөөд тэр нь заавал нарны эрчим хүч байх албагүй. Бидэнд ч бас агаар мандалд оршдог өөр төрлийн эрчим хүчнүүд байдаг. Зарим эрдэмтэн үүнийг олж мэдэж эхэлсэн, гэхдээ үүнийг хэрэглээгүй

л байгаа гэж би бодож байна. Учир нь заримдаа эрдэмтэд ямар нэг нээлт хийхэд өөр хэн нэг нь түүнийг нь нурааж, олон нийтэд мэдээлэхгүй байхыг завддаг эсвэл түүнийг дэмжихийг боддоггүй. Магадгүй санхүүгийн дэмжлэггүй болсны улмаас тэрээр туршилтаа үргэлжлүүлж чаддаггүй байх; эсвэл түүнийг өөр хүн мөрдөж мөшгөн патентыг нь хулгайлж, устгадаг, эсвэл түүнийг нь өөдгүй зорилгод ашиглах юмуу, бусдад зарж худалдахыг оролддог. Үүнд маш их мөнгө хэрэгтэй, тиймээс хэн ч худалдаж авахыг хүсдэггүй. Тэгээд хэний ч гарт очилгүй, тэндээ гацаж, хэрэгцээгүй хэвтэж байдаг.

Ийм төрлийн сэтгэхүйтэй хүмүүс байсаар байгаа цагт манай дэлхий ч, бид өөрсдөө ч ирээдүй рүү, соёл иргэншилтэй ертөнц рүү, хүмүүний амьдрал үнэ цэнтэй байдаг - жинхэнэ, эрхэм хүндтэй, намбалаг сайхан амьдрах ертөнц лүү гавьтай дөхөж чадахгүй. Энэ маш хэцүү.

Ийм учраас бидний ажил тийм ч муу биш байгаа гэж би боддог. Бид наад зах нь л үнэнч шударга байх, шаргуу хөдөлмөрлөх, өөртөө найдах, өөрийнхөө билиг ухааныг нээх тухайд хүмүүсийг сургаж сэнхрүүлэхээр хичээж болохоор байна. Тэд жижиг сажиг ажлыг ч чин сэтгэлээсээ, өөрийгөө бүрэн зориулан байж хийгээсэй. Тэр байтугай ажлаа хийж чадахгүй байлаа ч тэд наандаж л нийгмийн өмнө үнэнч шударга байх болно. Тэд хүмүүсийг хуурч мэхлэхгүй. Тэд асуудал үүсгэхгүй. Тэд тэвчээр хүлцэмжтэйгээр үйлчилнэ. Эсвэл ядаж л яршиг төвөг удахгүй. Ингэвэл тэд бусдад атаархахгүй эсвэл шинжлэх ухааны юмуу ажиллаж буй салбартаа олсон амжилтыг нь эвдэн бусниулах гэж хүмүүсийг өдөөж турхирахгүй.

Ихэнх шавь нар маань гудамжинд юмуу, хаа нэгтээ уулзалдах үедээ, харийн оронд ч бие биетэйгээ санаандгүй тааралдвал нэг нэгийгээ ах дүүс шигээ л санадаг. Тэгээд тэд энэ хүнд итгэж болно гэдгээ мэдэж байдаг. Тэд тэр хүн өөрийг нь хайрлана, тусална, эсвэл ядаж л гэм хор хүргэхгүй гэдгийг мэдэж байдаг. Тэгдэг байх аа? (Сонсогчид: Тийм.) Тийм учраас, хэрвээ дэлхий даяараа ийм байвал ямар байх бол гэж та бодож байна? Би шашны байгууллага гэгддэг бусад газрынханд ийм ахан дүүсийн холбоо үүсгээч ээ хэмээн зүрхлэн уриалж байна. Та нар тиймийг нь нэрлэ л дээ, та нэгийг ч олохгүй. Бие биедээ бидэн шиг итгэж чаддаг ахан дүүсийн холбоо хэмээх зүйлийг олохуйяа бэрх. (Сонсогчид: Тийм шүү!) (Бүгд алга ташив)

Бидэнд бие хүний зан чанар, алдаа дутагдал маань мэдээжээр байж л байгаа, гэсэн ч бид бие биедээ итгэж болно гэдгээ мэдэж байдаг, бидэнд хайр байгааг мэдэж л байдаг. Бид хайраа бэлэглэж чадна гэдгээ мэддэг. Бид байгаа бүхнээ бусдад өгч чадна гэдгээ мэддэг. Үүнд л бидний харилцан итгэл оршдог. Хэрвээ бид ийм дэлхийг бүтээчихвэл бидэнд диваажинг зорих хэрэг ч байхгүй; Нирвааны тухай ярьж хэлэлцэх ч

хэрэг байхгүй. Бид эндээ үлдэнэ. (Алга ташив)

Тийм учраас л бид Нирваанаас гараагаа эхлээд хөрст Дэлхийд ирж заларсан. Энэ бол зүй ёсны юм. Үнэн хэрэгтээ хүлээсэн үүргээсээ, эсвэл энэ Дэлхийгээсээ зугтаах нь бидний сэдэл биш. Ер нь бол бид хэрвээ энд үлдэж чадахгүй бол, хэрвээ эндхийг өөрчилж чадахгүй юм бол явах л хэрэгтэй болно.

Тэгэхлээр, та хэрвээ дэлхийгээ хайрладаг бол; газарт буусан хүн юм бол, энэ хорвоогийн хүмүүс үнэ цэнэтэй, итгэл дааж чадах хэвээрээ байгаа гэж боддог бол тэднийг авраач. Тэднийг өөрийнхөө билиг ухаан, сүнслэг бясалгалын тухай, энэрэл нигүүлслийн тухай, хайр нигүүлслийн тухай, Арьяабалын бясалгалын аргын тухай мэддэг зүйлээрээ авраарай. Энэ бол бидний үүрэг даалгавар. Тэгээд ч эцэстээ хүн бүр Арьяабалын бясалгал болон ургамал хоолонд шилжиж өөрчлөгдлөө ч танд энэ гараг дэлхий ер таалагдахгүй байгаа бол өөр бусад гараг бэлэн байж л байна. Та нарыг өөр газар орон хүлээж л байгаа. Бидэнд маш олон бий. “Эцгийн маань гэр үй олон ордонтой гэсэн үг яг үнэн юм шүү. Дээшээ гарч чадсан хүн үргэлжид доошоо бууж чаддаг, харин доор байгаа нь үргэлж дээшээ гарч чаддаггүй юм шүү дээ.

Хэрвээ та шинэ авшигтан бол, эсвэл өөрийн гайхалтай туршлагаа өгүүлсэн хөрш шигээ “цочирдом” ахуй ойлголт үзэж амжаагүй яваа; эсвэл өөр зам мөр юмуу өөр бясалгалын арга дадуулж яваа нэгэн бол; эсвэл мэдсээр байж зохисгүй хоол хүнс идсэн зэргийн улмаас танд миний сургаалын талаар, бидний санаа сэдэл болон аргын талаар ямарваа эргэлзээ төрсөн бол баттай итгэн үнэмшихийн тулд дахиад эхнээс нь эхлээрэй гэж би танд сануулж чадна. Би хэзээ ч хувийн ашиг сонирхлоо дагадаггүй гэдгээ та нарт шударгаар хэлье. Би ойр тойрныхон болон эсвэл өөрийн биедээ ашиг тустай зүйлийн талаар нэг хором ч бодож байгаагүй. Би үргэлж ингэж л хэлдэг, үүнийг хүн бүхэн гэрчилнэ.

Жишээлбэл, Ау Лак нутагт байгаа гэр бүлийнхэн маань намайг явснаас хойш (хорин долоон жилийн дараа) ердөө л хоёр сарын өмнө анх удаа зурагттай болсон байна. Би тэдэнд хэдхэн мянган доллар илгээсэн учраас л тэр. Тэд яагаад зурагт авахыг хүссэн гээч? Миний бичлэгүүдийг л үзэхийг хүссэн ажээ. (Алга ташилт) Тэгэхлээр, энэ жишээнээс та нар намайг амин хувийнхаа, тэр байтугай гэр бүлийнхээ ч ашиг сонирхлыг боддоггүйг мэдэж авч магадгүй.

Тэд тусална уу гэж хүсвэл би мэдээж тусалдаг. Тэгэхгүй бол анзаарахгүй л орхичихдог. Тэднийг амьдарч чадна гэж би боддог. Би тэдний бие махбодын байдалд тэгтлээ их санаа зовдоггүй. Тэд энх тунх амьдарч байгаа цагт бүх юм болох нь тэр. Би тэднийг халамжлахыг Бурхны таалалд үлдээдэг. Гэхдээ би тэднийг өлсөх, үхэх, эсвэл иймэрхүү зүйлд нэрвэгдэхийг мэдээж зөвшөөрөхгүй. Би бусдад тусалж чадаж байгаа л бол тэдэнд эд баялаг, алдар нэр бэлэглэлгүйгээр гэр



бүлдээ тусалж байгаа хэрэг. Би хэн юм бэ? Би чам шиг л мөхөс нэгэн. Би тэр байтугай шавь нартаа ч эцэг, эх дээр минь явж очоод мөргөж сөгдөх, эсвэл гэр орныг минь үзэхийг зөвшөөрдөггүй. Тэр бүү хэл, энэ нь намайг, эсвэл эцэг эхийг минь алдаршуулах тухайд байвал би тэдэнд очихыг нь хориглодог. Хүрээд очсон нэгэнд нь над руу буцаж ирэхийг нь ч хориглодог. Хоёр гурван бие цогцоос бүтэж бүрэлдсэн материаллаг оршихуйг магтан алдаршуулах нь ямар ч утгагүй хэрэг. Хамгийн сайхан яруу алдрыг та бясалгалын үедээ, өөрийгөө төгөлдөржүүлж байхдаа, энэ дэлхийн маш сайн иргэн болох тэр үедээ л олж авдаг юм. Та нар намайг ингэж л алдаршуулна. Өөр арга зам байхгүй.

Тийм учраас та сайн зам мөр, сайн Их Багш, сайн сургаалыг сонгосон өөрийн сонголтдоо дахин итгэж үнэмш. Та нар намайг Их Багш гэж нэрлэж болно, энэ зүгээр ээ. Та нар намайг гуйлгачин гэж дуудвал би алдаршихаа больчихно. Гэхдээ бидний мэдэхийг хүссэн зүйлийг мэдэж байгаа нь энэ хүн, хэрэгжүүлэхийг хүссэн зүйлийг маань хэрэгжүүлж чадсан нь энэ хүн гэдгийг та нар ойлгосон учраас л намайг Их Багш гэж нэрлэж дууддаг. Энэ бол бидний хүрэх зорилго. Энэ эмэгтэй бол бид хэн болохыг хүсэж байгаагийн маань төлөөлөл. Тэр өөрөө өөртөө эзэн болж чаджээ, тийм учраас л бид энэ эмэгтэйд “Их Багш” гэж нэрлэн дуудах болсон билээ.

Эрт, орой нэгэн цагт өөрөө өөртөө эзэн болсон үедээ бид өөрийгөө Их Багш гэж дуудаж болно. Өөртөө эзэн болсон тэр нэгэн бол жинхэнэ Их Багш мөн. Намайг Их Багш гэж нэрлэж дууддагийн цорын ганц шалтгаан нь энэ. Түүнээс биш, би энэ “ажил хэрэг”-ийг эрхэлж оролдохоос өмнөх үеэсээ илүү алдар нэртэй болчихсон юм биш. Ялгаагүй л байна! Тиймээс хувийн ашиг сонирхол гэх огт юм алга.

Түүнчлэн бидний энэ зам мөр бол хүмүүст хамгийн ач тустай, хамгийн түргэн, үнэнхүү зөв нь юм. Дэлхий даяарх хэзээ нэг цагт миний олж мэдсэн өөр аль ч байгууллагын шавь нараас манай шавь нар хамгийн хурдан ахиж дэвшдэг. Би чин үнэнээсээ хэлж байна, та нар үүнийг олж мэдэх гэж оролдоод үзэж болно шүү. Та нар бусад зам мөрийг үзэж мэдэхийн тулд үүндээ яарахгүй байж болно, би атаархахгүй, бас айж эмээх ч үгүй. Та нарыг надаас зугтаачих вий гэж би айж эмээхгүй. Таныг зөвхөн цаг хугацаагаа үрэн таран хийчихээд “Цагийн гарз боллоо!” гээд буцаж ирэхэд байх гэхээс л би эмээж байна. (Алга ташив)

Тиймээс олж мэдэхийг хүссэн зүйлээ олж мэд, тэгээд өөртөө итгэлтэй бай. Хэрвээ миний тухайд үнэхээр мэдмээр байгаа бол бүхий л арга замаар олж мэд. Биднийхээс илүү дээр зам мөр байдаг эсэхийг үнэхээр мэдмээр байгаа бол, түргэхэн шиг мэдээд ав. Эргэлзэж суусаар нэг нэгийнхээ цагийг дэмий үрэх хэрэггүй. Хэрвээ та өөр, илүү дээр зам мөрийг олчихвол би таныг тун баяртайгаар тавьж явуулна, яагаад гэвэл шавийн тоо цөөн байх тусам миний хувьд ядрах нь бага. Тэгтэл бас,

би өөрөө ч бас очоод тантай нийлчихэж магадгүй. Хоёулаа л бясалгагч шавь болчихож болно. Одоо та нар ямар нэг үүрэг хариуцлага үүрэггүй, бүх зүйл сайхан, хайрлуулж халамжлуулаад шавийн жаргалыг амсаж эдэлж байгаа шиг л би тэнд сууж байж чадахсан. Тэгээд та нар шиг л нэг Гүрү багшийг даган ийш тийш явж байх биз. Ингэх чинь эрүүл мэндэд тун ашигтай, бас дэврэнгүй сайхан хэрэг.

Би таныг үүнд итгүүлэх гэж хүчлээгүй, бас энэхүү “галзуу” хүмүүсийн (Инээлдэв) бүлгэмд албадан оруулах гэж ямар нэг ид шидийн хүч юмуу, эсвэл зөвхөн учир зүйгээр ярьж хэлэхээс өөр арга саам хэрэглээгүйг та нар мэдэж байгаа. Та ирье гэж өөрөө л шийдсэн! Хэрвээ та ямар нэг сонголт хийж байгаа бол тэр зүйл чинь сайн эсэхийг лавтай мэд, учир нь та муу зүйл сонгочихвол тэр чинь бас л сонголт. Бас үр өгөөж муутай ямар нэг зүйлийг дагах гэж та эрч хүч, цаг заваа дэмий үрнэ. Ямар нэг зүйлийг дагаж эхэлсэн бол та түүнийгээ зүгээр, сайн, зөв эсэхийг нь магадлаарай. Зөв бөгөөд үр өгөөжтэй гэдэгт нь итгэлтэй болсон бол түүндээ тууштай байж, үр өгөөжийг нь хамгийн дээд зэргээр хүртээрэй. Түүндээ бүх эрч хүчээ зориулаарай, тэгэхгүй бол та ердөө хагас хугасыг нь л хүртэнэ, ингэвэл цагийн гарз болж, тэгээд үүнийгээ орхиж хаяж ч юуны магад. Тийм биш үү? (Сонсогчид: Тийм.)

Зүйрлэвэл гэрлэлт шиг л юм: та хань ижлээ сонгомгоцдоо гэрлэлтээ хамгаалахын тулд бие биетэйгээ ажиллахыг хичээдэг, яагаад гэвэл гэрлэлт чинь аз жаргалгүй байвал та бас үүнээсээ гадуурх ажлаа ч хийж чадахгүй; та эрч хүчгүй, сонирхолгүй болж орхидог. Гэрлэлтийнхээ төлөө хоёулаа л хичээх хэрэгтэй. Харин сайн хань ижил сонгочихсон гэж бодоод ихэд чармайн ажиллаж байтал яагаад ч юм бүтэлгүйтэж, бас хэн хэн нь байдлыг засахыг хүсэхгүй байвал зүгээр орхисон нь дээр. Бие биеийнхээ цаг хугацаа, эрч хүчийг үрэн таран хийж, нэг нэгийгээ зовоохын хэрэг юу байх билээ. Энэ нь өөрийн чинь хувьд сайн, үүнгүйгээр амьдарч чадахгүй гэж бодож байвал та тэрнийхээ төлөө ажиллах л ёстой. Бид бүхнийг болгож бүтээхийн төлөө шаргуу чармайх ёстой.

Манай дэлхий Нирваан шиг үзэсгэлэнтэй байх боломжтой. Хамгийн гол нь хорвоогийн хүмүүс ийм болгоё гэж чармайдаггүй; чармайдагсан бол ямар ч Нирваантай адил үзэсгэлэнтэй сайхан болох боломжтой. Цэрэг зэвсэг, дайн байлдаан, бие биенээ алж хөнөөх, баривчлах, дэлхийгээр нэг мөрдөж мөшгөхөд цацаж зарцуулсан тэр бүх мөнгөөр бид энэ гарагийн бүх гудамжинд засмал зам тавьж, янз янзын сайхан мод, тансаг цэцэг, хамгийн амт шимттэй жимс, хоол хүнсийг ядаж л харж баясахын төлөө ч болтугай тариалж болох билээ. Бид түүнийг идэх албагүй! Хэрвээ бидэнд энэ бүхэн дэндүү элбэг арвин байгаа бол тэд нүд баясгаж, жамаараа газар унан ялзарч, ахин бордоо болж л байг. Бид анхилам сайхан үнэрийг нь мэдэрч, гараг дэлхийгээ

ширтэн харж, үзэсгэлэнт энхжин болгож болно шүү дээ.

Зам талбайгаа Амиитаба Буддагийн орон шиг алт, болор эрдэнэсээр хучих хэрэг бидэнд байхгүй. Цемент юмуу, эсвэл хар давирхай байсан ч бид сэтгэл ханана. Тэр нь цэвэрхэн л бол бидэнд хангалттай. Бид шаварт хутгалдалгүй алхчихна; хэрэв эргэн тойронд хогонд дарагдаагүй байвал; цацраг идэвхт зай хураагуур газар сайгүй ажиллахгүй байвал; хаа хамаагүй хуванцар, резин хөглөрөөгүй байвал; машины бензин тосны бохирдол хамраар цоргихгүй байвал л шавар шавхай байлаа ч цэвэрхэн л бол бас л үзэсгэлэнтэй сайхан шүү дээ. Бид мөнгө хөрөнгө, байгалийн нөөц баялаг, эрч хүчээ ашиглан шинжлэх ухаанд хөрөнгө оруулснаар суудлын машинаа одоогийнхоос илүү дээр ажиллуулах арга олж чадна, хүмүүсийн аюулгүй байдлыг илүү сайн хангах арга зам олж, тэгш хүртээж чадна. Ядууг нь баячуудын төвшинд өргөж аваачихын оронд хүн бүрийг ядуурлын төвшин рүү доош татдаг зарим тогтолцоо, эсвэл “изм” гэгдэх зүйлд байдаг шиг биш. Ийм л байх ёстой, харин үүний эсрэгээр биш.

Би улс төрч биш, ердөө л учир зүй ярьж байна. Би улс төрд дургүй, гэвч заримдаа улс төрийг шашны, эсвэл ёс суртахууны гэгдэх сургаалуудаас салгах боломж байдаггүй, учир нь эрт дээр үед зөвхөн мэргэд нь улс үндэстнээ захирч залдаг байсан билээ. Тийм ч учраас бидэнд Яау, Швэн, Алтан Египет, Алтан Грекийн цаг үе байсан хэрэг. Бясалгагчид улс төртэй хутгалдахгүй байвал зохино гэж хэлэх хэрэг байхгүй. Бид хутгалддаг ч үгүй; бүр хүсдэг ч үгүй. Хэрэв хутгалдлаа гэхэд бид юу ч хийж чадахгүй. Гэхдээ бид учир зүйтэйгээр ярьж тунгааж, улс төр яагаад бүтэлгүйтлийг тэвчдэггүйг танд ойлгуулж чадна. Яагаад гэвэл энэ чинь жинхэнэ улс төр биш. Жинхэнэ улс төр бол улс үндэстэн болон хорвоо дэлхийн төлөө зогсож, ач тус авчирдаг юм.

Яг одоо бидэнд шилдэг сайн удирдагч цөөхөн байна. Би ч бас тэдэнд дуртай. Хэрвээ чадахаар бол би тэднийг дэмжинэ. Би очоод гар барин мэндчилж, дэмжиж байна гэж хэлэх гэсэн юм биш, харин эрх мэдэлдээ удаан үлдэхийг нь өөрийнхөө арга замаар дэмжинэ. Дэлхий маань бага ч болов Гэрэлтэй байж, Бурхан ажлаа хийхэд хэрэг болох хэдэн сайн багажтай байхын төлөө, дэлхийгээ ядаж л там болгочихгүйн тулд би үл үзэгдэх арга замаар тэдэнд тусалж болох билээ. (Алга ташив.)

Хэрвээ бид өөр арга замаар дэлхийд туслах боломжгүй бол бясалгах нь зүйтэй. Бид өөрийгөө хөгжүүлж, хэм хэмжээгээ ёс суртахуунлаг болгоно. Энэ ч бас том ач тус юм. Алдаа дутагдал, шударга бус бүхнээр дүүрчихсэн дэлхийд, хэрвээ амьтны амийг тасалдаггүй, бүр ургамал хоолыг ч ариг гамтай иддэг, юунд ч учиргүй шунахайрдаггүй, авшигтан мөн биш нь хамаагүй, чадах үедээ, байгаа боломжоороо бидэнд тусалчихдаг тийм сайхан хүмүүстэй маш олон бүлэг байх юм бол бид энэ дэлхийд аль хэдийнээ том үйл хэрэг бүтээчихсэн гэсэн үг.

Бусад нь ч төд удалгүй, бидний үлгэр жишээг аажуухнаар дагана. Бид үгээр биш, үйл хэргээрээ зааж сургадаг.

Мэдээжээр, би та нарт бас үг хэлээр зааж сургадаг. Учир нь би яагаад үүнийг хийж байгаа, та нар яагаад тэгэх ёстойг үг хэлээр л мэдэж авна. Энэ нь ч бас ач тустай. Харин зөвхөн яриад л байхаас биш, юу ч хийхгүй байвал ямар ч ашиггүй. Бид хог новшоо бусад хүнд сонгох гэж өөрсдийн эрч хүч, бусдын цаг хугацааг дэмий үрэх учраас энэ нь бүр ч хор хөнөөлтэй хэрэг болно. Жимс шиг харагдаж байвч ямар ч шим тэжээлгүй бол тэр жимс хог шүү дээ. Үгүй гэж үү!? Тийм биз дээ. Онол гэхэд л өөрөө өөрөөсөө хэрэгжих хүчний тулгуургүй, үйлдэж бүтээх хүчний тулгуургүй хоосон үг байх юм бол бас л хог новш, хий хоосон үг, эрч хүч ба цагийн гарз юм.

Хүмүүс энэ бүх цаг хугацаагаа илүү үнэ цэнэтэй зүйл сонсоход зарцуулж болох байсан, эсвэл илүү сонсууштай хүнийг олж болох байсан, эсвэл бүх цаг хугацаагаа унтахад зориулж болох байсан, ингэх нь бүр ч илүү үр өгөөжтэй. Магадгүй, тохиолдлоор сайн номтой тааралдаж, сайн зүйл уншиж; эсвэл өөрт их ач тус авчирч мэдэх нэгэн Их Багш, эсвэл авшигтан бясалгагчтай тааралдвал энэ нь дэмий хоосон яриа сонсохоос илүү өгөөжтэй байх. Ийм учраас бид ямар нэг зүйл ярих үедээ мэддэгийгээ, бас үнэнхүү итгэж үнэмшсэн зүйлээ л ярих ёстой, тэгвэл л энэ нь хүч агуулна, улмаар түүнд эрч хүч оршиж, хүмүүст ач тусаа өгөх болно.

Ихэнх хүний залбирал биелдэггүйн учир нь энэ, яагаад гэвэл тэд үүндээ ямар ч эрч хүч шингээгээгүй хэрэг. Тэд зүгээр л амандаа бувтнаж, эсвэл сул дорой, эрч хүчгүй, зурвас бодоод л өнгөрдөг. Тиймээс тэдний бодол нь хэрэгжихгүй; залбирал нь биелэхгүй. Тэр байтугай тэдэнд залбирал хийхэд хангалттай хүрэлцэх эрч хүч, дэмжин тэтгэгч санаа сэтгэл ч байдаггүй. Энэ бол жинхэнэ залбирал биш. Жинхэнэ залбирал үргэлжид биелдэг юм. Яагаад гэвэл хэрвээ түүнд нь энерги байвал тэдний хүссэн зүйлийг татчихна. Тагагч энерги байхгүй бол юу ч ирэхгүй. Хэрэв та хоёр зүйлийг - соронз шиг харагдахаар будсан нэг модыг соронзтой хамт тавибал энэ хоёрын өөртөө татах хүч адилгүй байж таарна. Зөвхөн жинхэнэ соронз нь төмөр юмуу металлыг өөртөө татдаг. Нөгөөх нь хэзээ ч юуг ч татахгүй. Түүнийг тэнд хичнээн удаан тавьсан ч, хичнээн соронз шиг харагдлаа ч нэмэргүй.

Тийм учраас, Арьяабалын бясалгагч та бүхнийг залбирах үед та нарт Хүч байгаа учраас залбирал чинь биелдэг. Одоо та нарт бүр хүссэнээ хүртэх гэж залбирах Хүч байдаг болсон байна. Өмнө нь чамд байгаагүй шүү дээ. Залбирал гэж чухам юу болохыг та нар мэддэггүй байсан. Та нар ердөө л “Ээ, Бурхан минь надад үүнийг өгөөч. Ээ, Бурхан минь түүнийг өгөөч” гэж хэлдэг байсан. Бурхан тийм хямдхан гэж бодоо юу? (Инээлдэв) Тэр байтугай ширхэг сүлбээр зүү ч хэрчим мод эсвэл ердийн төмөрт тагагдахгүй. Бурхан яаж танд, таны “шал пал”

гэсэн дэмий үгэнд татагдана гэж!? Мөн та хэлж ярьж байгаа шигээ ч биш байдаг, тэр байтугай залбирч байгаа зүйлдээ ч итгээгүй байдаг.

Тэгэхлээр, та Их Багшийг мэддэг болсны дараа л залбирал эхэлдэг, учир нь Их Багш таны дотоод дахь залбирлын Хүчийг, залбирах Хүчийг, бодох Хүчийг, юмыг биелүүлэхэд өөрийнхөө энергийг ашиглах Хүчийг тань сэрээж өгдөг юм. (Алга ташилт.)

Тэгэхлээр, авшиг хүртсэний дараа, залбирсан зүйл чинь хэрвээ өөрт чинь сайн зүйл мөн бол ихэнхдээ биелдэг; харин өөрт чинь сайн биш зүйлийг бол Их Багш өгдөггүй. (Инээлдэж, алга ташив) Тийм. Яг л хүүхэд маш их чихэр хүсэхэд эцэг, эх нь “болохгүй” гэж хэлдэг шиг л юм. Тэд ганц хоёр ширхэг бол зүгээр, харин өдрийн болон оройн хоолноос нь хэтрээд дэндүү олон болоод ирвэл “Болохгүй!” л гэнэ. Тэд хааяа галаар тоглох гэвэл эцэг, эх нь бас л «Болохгүй! Та нар галтай харилцах, галаар наадах чадвартай болох, гал сайн бишийг мэдрэх хэмжээнд хүртлээ өсөж том болоогүй байна – та нарын үүнийг ойлгохыг хүлээх юм бол дэндүү оройтно. Та нар хангалттай өсөж том болоод үүнийг зохицуулж, галтай харилцах туршлагатай болж чадна. Одоо ч гэсэн та нар дэндүү балчир хэр нь галаар оролдох сайн биш гэдгийг мэдэж байгаа, гэхдээ сайн биш зүйлтэй яаж харилцахаа л мэдэхгүй байгаа. Том болсон хойноо ч гал аюултайг мэдэж байдаг, гэхдээ түүнтэй харилцах аргаа мэдчихсэн байдаг. Тийм учраас галаар тоглож наадаж болно. Гал нөгөө л хэвээрээ байгаа, харин та өөр болсон байдаг» гэх болно.

Тийм учраас, зарим зүйлийг ганц хүн хийчихэж чаддаг байхад бусад хүмүүс хийж чаддаггүй. Эсвэл Их Багшийн хийж чадаж байгааг та нар хийж чаддаггүй. Их Багш авшиг хүртээж, хүмүүсийн үйлийн үрийг авч чаддаг, харин та нар үүнийг дуурайж болохгүй. (Инээлдэж, алга ташив) Таны хийж чаддаггүй олон зүйлийг Их Багш хийж чаддаг. Гэхдээ та чаддаг болно! Та үүнийг ирээдүйд хийж чаддаг болно. Өөрийнхөө чадавч ба хүч чадал, Өөрийгөө-танин мэдэх талаараа өсөж хөгжсөн үедээ та Их Багшийн хийдэг яг тэр зүйлсийг хийж чадна, та бүр илүү ч хийж магадгүй! Хэрвээ Бурхан таны үүрэг хариуцлагыг нэмэхийг хүсвэл та юм бүхнийг чадна. Их Багшийн гадна өнгөн талын үйлдлүүдийг хэлж байгаа юм биш; энэ бол дотоод билиг ухаан, яагаад тэр эмэгтэй, эсвэл эрэгтэй үүнийг хийж байна вэ гэдгийг Их Багш хэрхэн мэддэг шиг л юм. Бид мэдэх аргагүй! Заримдаа бид мэддэг. Заримдаа мэддэггүй. Бид “Аан, Их Багш зүгээр л ярилцаж, хүмүүсийг өдрийн хоолонд урин цай ууж, духыг нь илдэг. Би ч энэ бүхнийг чадна, бүр илүү сайн чадна” гэж боддог. (Инээлдэж, алга ташив) «Ариун Нэрсийг давтан уншдаг, үүнийг ч би бас чадна. Тэр бас олон номтой, би ч бас ном бичиж чадна» гэж боддог. Гэвч энэ бол өөр зүйл. Аливаа зүйлийн гадна талдаа харагдах байдал нь биш; харин үүний цаана нь байгаа үл үзэгдэх Хүч нь л чухал.

Тэгэхлээр, өнөөдөр гэхэд л биднийг гадаа сэтгүүлчидтэй ярилцаад байж байхад жишээлбэл, бидний зам мөрд одоо тун итгэл бишрэлтэй, бас надад маш их хайртай нэг авшигтан шавь манай Коста Рикад байдаг тухай нэг хүн ярихыг та нар санамсаргүй сонсоо биз дээ. Намайг явах юмуу, эсвэл ирэх бүрийд тэр нялх хүүхэд шиг л уйлдаг. Тэр эр бас тун сайн бясалгадаг, маш сайн ахуй ойлголттой. Хамгийн шилдэг нь гэж би хэлэхгүй ч тэр дажгүй сайн, маш шаламгай. Гэхдээ тэр намайг мэддэг болохоосоо бүр аль эрт, өөр их багш гэгдэх хүнээс авшиг хүртсэн юм байна лээ. Тэр нь адилхан л арга техник, зам мөр байсан ч тэр тэсвэрлэн давж чадаагүй байх л даа. Түүнд маш аймшигтай хариу нөлөө үзүүлсэн учраас тэр больчихжээ. Үүнийхээ дараа тэр ахиж дэвшсэн байна. Манай авшгийг хүртэж, надтай уулзсаны дараа тун хурдан ахиж дэвшсэн байна.

Өөр нэг Америкийн хүн байна. Тэр мөн л над шиг Гэрэл, Аялгууны бясалгал заадаг, алдартай Энэтхэг Гүрү багшаас авшиг хүртсэн аж. Гэвч арав, эсвэл арван хоёр жил болсон ч тэр ахиж дэвшсэнгүй. Тэгээд өөр нэг зам мөрд орсон ч мэхлэгдэж, янз бүрийн л юм амсаж туулсан ч бүр өмнөхөөсөө дорджээ. Тийм учраас тэр бүр итгэл алдарч, хамтдаа бясалгахаа бүрмөсөн зогсоожээ. Мөн магадгүй ямар нэг гунигтай, бүр харамсалтай ч гэмээр зүйлийг хийжээ. Харин надтай уулзсаныхаа дараа ахин итгэлтэй болж, бясалгаж эхэлсэн бөгөөд маш түргэн ахиж дэвшсэн билээ. Тэгээд тэр надаас “Яагаад тэр вэ? Чухамдаа ижилхэн л сургаал хэр нь яагаад өөр нөлөө үзүүлж байна вэ?” гэж асууж байсан. (Алга ташилт)

Тэд бас л Гэрэл, Аялгуу гэх нэртэй ижил зүйл заадаг ч, энэ бол өөр зүйл! Үүнийг би өөрөө ч бас мэддэг. Зарим нь бас энэ Гэрэл болон Аялгууны бясалгалыг мөнгө олох гэж заадаг юм шүү. Нэг хүний хэдээр ч юм! Хичээлд суухын тулд та эхлээд мөнгө төлөх ёстой болдог, сар бүр хэдийг ч юм төлнө, хэдэн жил өнгөрсний дараа ч Гэрэл, Аялгууг хүртэнэ гэсэн баталгаагүйгээр танд авшиг хүртэнэ. Ганц хоёр хүн үүнийг хүртэж магадгүй, гэхдээ тэр нь доогуур дэсийн Аялгуу байдаг. Би хэн нэгнийг шүүмжилмээргүй байна, бас тэр хүний нэрийг хэлэхгүй. Миний хэлэх гэсэн санаа бол ямар нэг зүйлд, ялангуяа сүнслэг талдаа ямар нэг зүйлд хүрэхийн тулд бид гадна талын үйлдлийг биш, бидний олох ёстой дотоод Хүчийг л дуурайж, түүгээр шүүн тунгаах ёстой юм.

Их Багшийг дуурайж, ингэж алхаж гишгэж, эсвэл тэгж хувцаслаж; энд эсвэл тэнд гараа хүргэж, ийш тийшээ гараа даллаж, чихэр тарааснаар болчихдог юм биш. (Инээлдэв) Их Багшийн хийдэг зүйлс ердөө энэ төдийхөн биш. Энэ бүхний цаана бүр ч их зүйл бий. Хайр байдаг; Хүч байдаг; адислал байдаг; Хайр болон энэрэл нигүүслэлийн Далайгаас, Оройн Дээдээс хүртээдэг туйлын анхаарал, халамж байдаг юм. (Алга ташив) Та бясалгахгүй л бол энэ бүхэн хэцүү. Хэрвээ та хангалттай

өндөрт гараагүй л бол ийм зүйлсийг мэдэж чадахгүй. Харин та юу ч юм хүлээж авч байгаа тохиолдолд, Их Багшаас ямар нэг зүйл хүлээж авах үед ялгааг нь мэдэрч магадгүй. Та бүр ерөөс огт мэдрэхгүй ч байж магадгүй. Гэсэн ч энэ бас бага багаар тус болно.

Жишээлбэл, манай нэг бясалгагч хэлэхдээ Их Багш гурван удаа адисалсаны дараа л гэргий нь Гэрэл харсан гэсэн. Тэр эхний удаад хараагүй; хоёрдох удаад ч хараагүй; харин гуравдах удаад “Хөөх!” гэжээ. Гэргий нь “Харчихлаа! Харчихлаа!” гэжээ. Тийм ээ, зарим хүн удаан байдаг. Миний таньдаг нэг бясалгагч байна; тэр авшиг хүртэх үедээ юу ч сонсоогүй гэнэ. Тэр хүн бол өөр нэг шашны жижиг удирдагч нарын нэг байсан. Тэр бидэнд дээр ирээд авшиг хүртсэн юм. Гэвч тэр магадгүй, урьд өмнө олж авсан төсөөллөөсөө болоод ч юмуу хаа нэгтээ гацсан. Тэр анх удаа Аялгуу сонсох хүртэл нь долоо хоног өнгөрчээ. Гэхдээ тэр маш шаргуу чармайж, их бясалгасан байна. Тэр мацсаар байж эцэст нь “тэр дээр” очсон байна. Би түүний чармайлыг үнэлдэг. Тэр одоо хамгийн шилдэг дэмжигч, хамгийн үнэнч бясалгагч нарын нэг болжээ. Гэхдээ тэр авшиг хүртсэний дараа маш их хөдөлмөрлөсөн. Тийм ээ. Маш хүнд байжээ.

Гэхдээ ингэх нь ховор; авшиг хүртээд долоо хонож байж сонсох нь ховор байдаг. Тэр юу ч сонсоогүй аж. Тэр өөрөө удирдагч хүн, бас бусад нь бүгд үүнийг хүртчихээд байхад тэр тэргүүлэгч гэх хэрнээ юу ч хүртээгүй учраас их уурласан. Тэр урам хугарч, өөртөө уур хүрчээ. Гэхдээ түүний энэ алба тушаалаас нь болж түүнд саад тогтор үүссэн байжээ. Тэр өөрийгөө хорвоогийн ямар нэг гайхалтай оюун ухаан мэтээр бодсон байж, ойлгож байна уу! Тэр бас чадамгай сайн ярьдаг. Тэр бүх Судрыг мэддэг бөгөөд нэг ярихаараа огт зогсдоггүй. Тэр олон үүх түүх мэддэг, бас түүнийгээ зогсолтгүй ярьж чадна. Өндөг хэрэглэдэг байсан байж магадгүйг нь эс тооцвол тэр ургамал хоолтон байгаагаа л хангалттай гэж бодсоор олон жил болсон байв. Тиймээс тэр өөрийгөө зуун хувь, зуун найман хувь бэлтгэгдэж, бэлэн болсон гэж бодож байж л дээ. Харин тэгээд л дараа нь тэр тун их гонсойжээ.

Бид өөрийгөө маш сайн, эсвэл төгс сайн гэж бодож байх үед оюун ухаан маань биднийг хуурч байж мэднэ. Оюун ухаан бол алдар суу, магтаал өргөмжлөлд дуртай, чамин тансаг төсөөлөлд дуртай, тэгээд л бид сайн гэж боддог. Нөгөө талаар оюун ухаан биднийг бас басамжилж дордуулж байдаг. Биднийг хэлмэгдүүлж, өөрийгөө дорд үзэх эмгэгт живүүлж, мөн түүнчлэн алдар суугаас маань хагацуулж байдаг. Энэ нь хоёр замаар болдог. Тийм шүү.

Энэ дэлхий дэх хамгийн их хууран мэхлэгч тогтолцоо бол хүмүүсийг шүтэх ёсгүй зүйлээ шүтэхэд хүргэдэг явдал: Будда үүнийг маань мэдэх болно гэж найдан модонд мөргөдөг, чулуунд мөргөдөг, элдэв янзын амыгүй эд зүйлийг шүтэж мөргөдөг. Будда мэдэж чадаж магадгүй ч хүмүүс бид мэдэхгүй байж мэднэ, яагаад гэвэл бид дотоод

холбоосоо олоогүй байгаа. Тийм учраас, тэр байтугай Будда бидэнтэй ярилцахыг хүслээ ч хүмүүс бид сонсож чадахгүй. Хэрвээ телефон утас маань салчихсан байвал бид нөгөө талыг хэрхэн сонсож чадах билээ? Бид энд телефон утсандаа хичнээн их мөргөлөө ч нэмэр болохгүй. (Алга ташив.)

Энэ бол хэний ч мэддэггүй Маяя<sup>1</sup>- гийн урхи! Хүмүүс ямар нэг зүйлтэй зууралдаж, өөрийгөө алдаршуулах дуртай: өөрийгөө шашин шүтлэгтэй; гүн ухаан мэддэг; ямар нэг зүйлийг бясалгадаг гээд л. Тийм учраас хуурмаг үзэгдлийн хаан гэгдэх Маяя иймэрхүү урхи занга бэлтгээд тавьчихдаг нь хүмүүсийг сэтгэлээ цатгаж, “Би шүтэж байна. Би шашин шүтлэгтэй. Би Буддист. Би ийм. Би тийм. Би бол бүх зүйл. Би завгүй. Би бясалгал дадуулж байна” гээд л тэндээ үүрд уягдахад хүргэдэг. Шашны дэг ёсонд баригдсан энэ бүх материаллаг хэлбэрийн хүлээс нь ердөө л сэтгэлийг цатгаж хангахын төлөө л байдаг юм. Гэтэл энэ нь тэднээс үнэт цагийг нь мэхлэн хороосноор үүнээс илүү дээр зүйлийг эргэцүүлж бодох, эсвэл илүү сайн зүйлийг эрж олох боломж өгдөггүй. Тиймээс л тэд та нарт модон хөшөө баримлыг шүтэж мөргөөд бай, нэг л өдөр чи тэрийг Будда гэдгийг нь ухаарч танина гэж хэлсээр байдаг. Тийм ээ, ингэж ч магадгүй, гэхдээ модоор хийсэн, модон Буддаг л таних байх даа. (Инээлдэв)

“Бурхан таны дотоодод буй” гэж Будда үргэлж айлдаж байсан. Тэгвэл бас Есүс “Бурхан таны дотор амьдардаг. Та бол Бурханы сүм” гэж айлдсан. Тэд үүгээрээ чухам ямар санааг хэлсэн бэ? Та өөрөө Бурхныг ямар байлгахыг хүсч байна, тиймээрээ л бүтээдэг. Та өөрөө Буддаг ямар байлгахыг хүсч байна, тиймээрээ л бүтээдэг. Ойлгож байна уу?, Таны ухаарч сэхээрсэн байдал, дэс төвшин, хүч чадалд тань таарсан тийм л Будда байдаг. (Алга ташив)

Жишээлбэл, би та нарт Арьяабалын бясалгалын аргыг арга хэрэглэхгүйгээр заадаг, гэвч бид үүнийг Арга гэж нэрлэх ёстой болдог. Эс бөгөөс би хэрвээ наашаа хүрээд ир, би бас та нарт юу ч өгөхгүй, арга гэх ямар ч юм байхгүй гэж хүмүүст хэлбэл хэн ч ирэхгүй биз. Харин та хэсэг хугацааны дараа үнэндээ арга гэх юм байхгүйг ухаарч мэддэг. Танд гагцхүү Их Багшийн Хүч л тусалдаг. Тийм бишсэн бол хүмүүс тэр аргуудыг зуун доллароор зарчихна, тэгээд та юу ч олж авч чадахгүй. Эсвэл бусад сургууль, Гүрү хэмээх хүмүүс танд мөн ижилхэн аргыг

*1- МАЯА (МАЙЯ) - самгарьд: Брахманы хүч чадал. Ид шид. Хуурмаг үзэгдэл. Зэрэглээ. Униар манан. Хууран мэхлэлт. Брахман (Эсэрваа тэнгэр. мон) Маяагийн тусламжтайгаар ертөнцийг өөрөөсөө бүтээдэг. Маяа өөрөө хуурмаг юм үзэгдлийг үүсгэн бүтээдэггүй, тэрээр нэг бол ертөнцийн тухай мэдээллийн нэг хэсгийг нуун дарагдуулж, юм үзэгдлийг хөшиглөн хааж, нөмрөг (аварана)-өөр бүрхдэг, эсвэл мэдээллийг сарниулж, юм үзэгдлийн нэг хэсгийг үл үзэгдүүлж, арилган (википена) алга болгодог. Ингэхлээр ертөнц хуурмагаар хуваагдаж, үй олон, түгшүүртэй мэт харагддаг ажээ. (Голуб Другова-Популярный словарь по буддизму и близким к нему учениям).*

зааж өгсөн ч та юу ч олж хүртэхгүй байж магадгүй. Тэд бас л таныг энд суугаад тэндээ төвлөр гэж хэлнэ. Тэд бас танд гараа хүргэнэ.

Тэд танд хоёр мянган жилийн турш гараа хүргэж чадна, харин таны толгой таных хэвээрээ л байж байх болно. (Инээлдэв) Танд хамаарагдах юм таных л учраас таны толгой Буддагийн толгой болчихгүй.

Гэтэл одоо би та нарт, жишээлбэл, Арьяабалын аргыг өгсний дараа та бясалгадаг. Та өөртөө ямар Хүч агуулдаг, ямар авьяас чадвараа мартчихсан, оюун ухааны чадвараа хэдий хэмжээгээр ашиглаагүй байна, энэ ертөнцөд та ямар байр суурь эзэлдэг, бас өөрөө чухам хэн бэ гэдгээ дотоодоосоо эрж олохыг хичээдэг. Та хайсаар байгаад үүнийгээ олно. Ингээд та Нэгдүгээр Төвшин хүртэлхийг олж мэднэ, тэгээд та одоо нэн их хайрлаж байгаагаар олж мэднэ. Таны сэтгэлийн дарамт өмнөхөөсөө багасаж, та “Өө Бурхан гэдэг чинь, энэ юм байна. Бурхан надад тусалж байна.

Бурхан надад сэтгэлийн дарамтаас салж, өвчнөө эдгээхэд тусалж чадах юм байна” гэж бодно. Нэгдүгээр Төвшинд та зарим өвчнөөсөө салж эдгэрнэ. Зарим үед та хэн нэг хүнд гараа хүргэтэл тэр хүн бас эдгэрдэг. Тэгэхлээр та анагаагч хүчтэй юм байна! Та “Аяа!, Бурхан анагаах хүчтэй юм байна. Бурхан ийм юм байна. Бурханд хайр байна. Бурхан надад хайр өгчээ. Одоо би хайрлагдаж байгаагаар, би өөрөө хэн нэгнийг хайрлаж байгаагаар мэдэрч байна” гэнэ. Гэлээ ч гэсэн энэ хайр бол бас л сул дорой төвшнийх юм. Гэхдээ энэ хамаагүй ээ, та өөрийгөө өмнөхөөсөө илүү сайнаар мэдэрч байна шүү дээ. Бас ургамал хоол идэх болсноор таны бие махбод илүү дээрдсэнийг та мэдэрч байгаа. Бодол сэтгэлгээ тань урьдынхаас илүү дээрдэж, ойр дотныхноо илүү ихээр хайрладаг болсон байгаа.

Ингээд та миний Будда бол хайр; миний Будда бол илааршуулагч хүч; миний Будда бол анагаагч хүч, шидийн хүч юм байна гэж тунхаглан зарлаж эхэлдэг. Тэр маань ид шид гэх мэтийн элдэв зүйлийг хийж чадна. Бурхан байдгийг та мэдчихсэн. Бурхан байдаг юм байна, бас ийм тийм шинж чанартай юм байна гэдгийг та мэдчихдэг.

Ахиад багахан бясалгаад та Хоёрдугаар Төвшинд хүрнэ. Одоо хэн нэг хүн танаас гэнэт асуулт асуухад та тун уран цэцэн ярьж чадна. Та тэдний хэзээ ч сонсож байгаагүй байдлаар, ингэж хариулж чадна гэж өмнө нь зүүдэлж ч байгаагүйгээр тэдэнд хариулт өгч чадна. Та энэ дэлхийн бүх Судар, бүх Библийг ойлгоно. Таван шашин бүгд л ижил зүйлийг ярьж сургасан гэдгийг та ойлгоно. Тийм ээ, нэг үгээр хэлбэл, та жинхэнэ уран илтгэх гэж юу байдгийг ухаарч мэднэ.

Та бас хааяа өнгөрсөн цаг үеийг, өрөөл бусдын өнгөрсөн болон ирээдүйг нь нэвт харж чадна. Та нар хоорондоо яагаад ингэтлээ уягдаж холбогдсоныг мэдчихнэ. Та бусад хүмүүстэй үүсгэсэн ямар нэг үйлийн үрийн уяа холбоосоо нүдэнд үзэгдэхээр, эсвэл үзэгдэхгүйгээр

зохицуулж чадна, ингэнгүүт таны бусадтай үүсгэсэн холбоо харилцаа гэнэтхэн л жигдэрнэ. Бясалгалын үед таны Их Багшийн хүч нүдэнд үзэгдэлгүйгээр таны амьдрал болон харилцаа холбооноос урьдын дайсагналыг арилгачихдаг учраас гэнэт л хоёр дайсан эргэж уулзалдаад дахин бие бие хайрлаж ч мэднэ. Тэгээд л та “Бурхан оюун сэтгэлгээний хүчтэй! Бурхан бол Будда! Бурхан бол гэгээрэл! Бурхан бол уран цэцэн үг! Энэ бол Бурхан!” гэж тунхаглан зарлаж эхэлдэг. Тэгэхлээр таны Бурхан жаахан өндөрсжээ дээ. (Инээлдэв) Бурхныг та ингэж л бүтээдэг, Буддаг та ингэж л бүтээдэг. Та “Өө! Бид бүх зүйлийг дотооддоо харж чадахад зориулсан тийм ач тустай сайхан бичлэг Бурханд байдаг юм байна” гэнэ.

Тэр үеэс та анхааран сонсож эхэлнэ, та “Аянгын нүргээн” эсвэл “Их усны Чимээ” сонсоно. Тийм учраас, Бурхан “аянгын нүргээн” болон “их усны чимээ”-гээр ярьдаг гэж Библи сударт өгүүлсэн байдаг. Ингэж л тэд өөрийнхөө Бурхныг зарлан мэдэгдсэн байна. Тэд Гэрлийн том дөл харахаараа “Бурхан том дөл шиг ирдэг”, “Бурхан бол галын том дөл мэт” гэж хэлдэг. Тиймээс тэдний Бурхан ялгаатай. Одоо таны Бурхан урьд өмнөх Бурхнаас чинь, эсвэл ердөө Нэгдүгээр төвшинд хүрсэн, эсвэл Гуравдугаар төвшинд хүрсэн өөр нэгэн авшигтан хүнийхээс ондоо байх болно. Түүний Бурхан таныхаас ялгаатай, гэхдээ харамсалтай нь, энэ нь өөр өөр нүд, өөр өөр өнцгөөс хараад байгаа нөгөөх л Бурхан байдаг.

Энэ нь Будда амьд сэрүүн байхдаа өгүүлсэн дөрвөн сохор хүн зааныг тэмтэрч үзээд дүрслэн хэлсэн тухай түүхтэй төстэй. Зааны чихийг илж үзсэн нэг нь “Хөөх! Заан чинь яг дэвүүр, маш том дэвүүр шиг л юм байна” гэжээ. Зааны хөлийг нь тэмтэрч үзсэн өөр нэг нь “Өө! Заан чинь том багана шиг юм байна” гэжээ. Зааны хамрыг нь илж үзсэн өөр нэг нь “Өө! Заан чинь усны хоолой шиг юм байна” гэжээ. Харин удаах нь зааны сүүлийг илж үзээд “Хөөх! Заан гэдэг чинь шүүрийн иш шиг юм аа” гэжээ. Жирийн хүмүүс Бурхныг ийм л байдлаар хардаг. Оюун санааны янз бүрийн дэс төвшинд байгаа хүмүүс болон бясалгагч нар Бурхныг ямар янзаар харж, хувийнхаа Бурхныг бүтээдэг нь энэ юм. Тийм учраас л Бурхан дотоод чинь буй; Будда оюун ухаанд чинь буй гэдэг ажээ. Үүний утга агуулга нь энэ л юм. (Алга ташив)

Тэгэхлээр Буддаг бүтээж чадна, Бурхныг бүтээж чадна гэдгээ та одоо мэдлээ. Тийм учраас би танд үүгээрээ хамгийн шилдэг Бурхныг бүтээгээрэй гэж зөвлөмөөр байна. Бидний цаг хугацаа, эрч хүч, анхаарлыг татахуйц байхын тулд бидний Бурхан Оройн Дээд, Хамгийн Дээд нь байх ёстой. Цаг бол мөнгө гэдэг биз! Үүн шиг бид хамгийн шилдэг Бурхныг худалдаад авчихаж ч магадгүй. (Инээлдэв.)

Бурхан яагаад танаар шүтүүлж мөргүүлэхийн тулд байдаг бус, харин биднийг Түүний Хүчийг ашигла гэж шаарддагийг та одоо ойлгож авлаа. Бид энэхүү Бурхныг өөрийн хүчээрээ ашиглаж хэрэглэхгүй л

бол бид залбираад ч бүтэж биелсэн юмгүй байваас үүнд өөр хэнийг ч буруутгах аргагүй. Шаталсан зиндааны хамгийн оройгоос эхлээд тамын хамгийн доод төвшин хүртэл та зөвхөн өөрийгөө л буруутгах ёстой. Та буруу замаар явчихсан байна. Та буруу зам мөрөөр явчихаж. Та буруу арга хэрэглэн буруу зүг чигт байгаа юмс үзэгдэлд ханджээ.

Арьяабалын бясалгалын арга бол та Бурхныг ямраар бүтээдэг яг тэр дүр төрхөөр нь, Бурхан гэдэг бол та өөрөө гэдгийг ухамсарлуулан ойлгуулахын тулд зориулагдсан зүйл. Хэрвээ та өөрөө чийгийн хорхой шиг бол Бурхан мөн л тийм доогуур байх болно. Та өөрийгөө чийгийн хорхойноос дээгүүр төвшинд өсгөж дэвшүүлэхгүй байвал Бурхан үүрд өт хорхой хэвээрээ үлдэнэ. Та нар өөрсдийгөө илүү өндөр дэвшүүлчихвэл, таны Бурхан илүү өндөр байх тусам, Бурхан илүү өндөрт байх тусам Бурхан төдий чинээ өндөрт алдаршина.

Тийм учраас та өөрийнхөө бясалгалын хүч болон ухаарлаараа Бурхныг яруу алдрыг бадраа. Энэ бол хамгийн шилдэг залбирал. Энэ бол Бурханд зориулах хамгийн шилдэг яруу алдар, Энэ бол хэзээ нэгэн цагт таны зүгээс Бурханд зориулж чадах хамгийн чухал ажил, хамгийн чухал залбирал. (Алга ташив) Хэрвээ бид Бурхныг, Буддаг, Аллахийг, эсвэл өөр хэнийг ч юм шүтдэг гэх атлаа мунхаг харанхуй хэвээрээ үлдвэл үүгээрээ Бурхныг үнэнхүү басамжилж байгаа хэрэг; Бурхан болон Буддаг үнэнхүү гутааж байгаа хэрэг.

Тийм учраас Бурхан багш: “Хэрвээ та Буддад итгэн сүсэглэдэг атлаа Буддаг ойлгодоггүй бол Буддаг гутааж байгаа хэрэг” гэж хэлжээ. Энэ үнэн. Та Буддаг яаж гутаана гэж? Та мунхгийн харанхуйд хэвээр үлдэж, бас та бол мунхаг Бурхан, Бурханд огт итгэж биширдэггүй гэж үзэх боломжийг бусдад өгч буйгаараа л тэгчихэж байгаа юм, яагаад гэвэл таны өөрийн мунхаг сэтгэлгээ, үзэл бодлоос болж Бурхан мунхаг болчихож байна. Та Бурхныг тийм л гэж боддог. “Би Түүнд залбиравч, Тэр сонсдоггүй. Намайг энд мөлхөж байхад Тэр хардаггүй” гэдэг. Энэ харахгүй байгаа нь Бурхан биш. Харин Бурхан харж байгааг та өөрөө л мэддэггүй; бас Бурхны адислалыг шууд хүлээж авахгүй байгаа нь та л өөрөө юм, яагаад гэвэл та өөрийгөө тойруулан маш их саад тотгор босгочихсон байна. Бурханаас ирдэг ач тус болон адислалыг та л өөрөө үгүйсгэдэг, яагаад гэвэл та олон үе дамжин нөхцөлдсөн ухаан сэтгэхүйнхээ улмаас өөрийгөө үнэ цэнэгүй; андуурч эндүүрч байгаа; мунхаг харанхуй; Бурхан чанарынхаа эсрэг элдвийн буруу зүйл хийсэн гэж боддог.

Тийм учраас тэр байтугай таныг залбирах үед, яг одоо ч, далд ухамсрын иймэрхүү бодол тань та бол Бурхан гэдгээ мэдэх, Бурхны ач тусыг мэдэхэд саад болдог. Тэгээд л та Бурхныг ердөө л энэ гэж боддог. Бурхан ердөө л таны залбирал, гомдол, хүсэлт шаардлагын төлөө л байгаа юм шиг, гэтэл тийм биш. Бурхан болгон үнэнхүү ялгаатай. Таны хэрхэн боддог болон таны сүнслэг дэсээс хамаараад Бурхан

ялгаатай байдаг. Нэг их олон Бурхан байгаа ч юм биш, харин бидний үзэл бодлууд ялгаатай учраас Бурхан ялгаатай байгаа хэрэг. Бурхныг үнэнээсээ шүтэн мөргөдөг гэж хэлэхийн тулд бид Бурхныг яагаад ойлгож, ухамсарлах ёстойг та нар одоо ойлгов уу? (Алга ташив) Тийм ч учраас Бурхан багшийн айлдвар буруу биш. Хэрвээ та Бурхан багшийг ойлгодоггүй бол Бурхан багшид сохроор итгэн сүсэглэх хэрэггүй, эс бөгөөс та Бурхан багшийг гутаачихна.

Ямар ч байлаа гэсэн та нар зөв зам мөрд орсон байна. Үүнийг өдийд ухаарсан байлгүй дээ, тийм биш бол надтай уулзахаар ирэхгүй л байсан байх гэж бодож байна. Тэр байтугай бүтэлгүйтсэн хүмүүс ч бас надтай уулзахаар ирсэн, үгүй ядаж л ирж уулзахыг хүссэн. Тэдэнд над дээр ирэх нүүр байхгүй байж магадгүй, гэхдээ хамаагүй ээ! Хэрвээ тэд хянуулахгүйгээр, өөрт нь үргэлж сануулж, үглэж чангааж байдаг хүнгүйгээр гадаа гудамжинд аажуухан бясалгалгахыг хүсэж байгаа бол гэртээ үлдээд алгуурхан мөлхөж болно. Харин намайг хурдан түргэн дагахыг хүсэж байгаа хүмүүс их ажиллаж, бас түргэн байх ёстой. Хурдан шаламгай байхад би дуртай. Миний хувьд та нар хэзээ ч дэндүү хурдан байж чадахгүй (Алга ташив), учир нь манай дэлхийд ийм түргэн шаламгай ажилладаг хүмүүс хэрэгтэй байна. Хурдан сэтгэдэг, ухаалаг, шударга үнэнч, ёс суртахуунтай, голч шулуун хүмүүсээр нэн гачигдаж байна. Тиймээс тэд олон байх тусмаа төдий чинээ сайн.

Таны Бурхан хэр аугаа вэ гэдгийг түргэн мэдэх тусмаа илүү сайн. Та хайраа түгээж чадна. Бусдад харуулахын тулд та өөрийн Бурханаа тулган хүлээлгэж болно. Хүмүүс таныг харах үедээ Бурхныг харсан мэт болно. Тэд айсандаа дагжин чичирч магадгүй. Тэд хайраас болж өөрийгөө эрхэм дээд болсон шиг, эсвэл зүгээр л өөрийгөө ондоогоор мэдрэх байх. Бурхан хүмүүсийг ингэж л – танаар өөрөөр чинь дамжуулж адисалдаг юм, яагаад гэвэл та Бурхны дэсэд хүртлээ аажуухан өсөн дэвшсэн байна. Бид дэлхийгээ ингэж л адисладаг. Бид Бурхныг ингэж л шүтдэг юм. Бид ингэж л жинхэнээр залбирдаг юм.

Энэ мөчид бид бүр залбирдаг ч үгүй, харин бурхан таныг, юм бүхнийг, таныг харж буй хэнийг ч адисалдаг юм. Тэгэх цагт та аль хэдийнээ Их Багш болчихсон хэрэг. Эсвэл та Их Багшийн чадварт хүрээгүй байгаа ч тийм хүч, тийм хайр, тийм адислах хүчийг их, бага ямар нэг хэмжээгээр аль хэдийнээ эзэмшихсэн байдаг. Бид дэлхийд ингэж л үйлчилдэг. Тэгсэн цагтаа л бид “Бурхан үнэхээр л хайр юм байна” гэж хэлж чадна. (Алга ташив) Бас хүмүүс таныг магтан сайшаана.

За, онол хангалттай ярилаа. (Инээлдэв) Гэхдээ миний онол бол онол төдийхөн биш. Та хүч чадал мэдэрнэ. Та хүч чадал мэдэрнэ. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл би ярьж буй зүйлээ аль хэдийнээ ухаарч мэдсэн. Би үүнийг номноос уншсан юм биш. Би үүнийг дотооддоо таниад мэдчихсэн. Тийм учраас, миний хэлж ярьсан бүх зүйл, танд ач тусгаа

өгч байдаг, та ч мөн үүнд итгэдэг, яагаад гэвэл энэ нь итгэн үнэмшүүлэх хүчтэй. Өөр хэн нэг хүн миний үгийг давтан хэлбэл зүгээр л хоосон үг болох байх. Тийм шүү. Тиймээс бид бясалгаж, өөрийгөө танин мэдэх ёстой, тэгсэн цагт л бид Их Багшийн үгийг давтан хэлсэн байлаа ч тэр нь мөн яг өнөөх хүч чадлыг агуулж байх болно, яагаад гэвэл тэр хүч бидний өөрийнх болчихсон байгаа хэрэг. (Алга ташив)

Намайг энд урьсан та бүхэнд баярлалаа. Бас нисэх буудал дээр намайг сэтгэл хөдлөм хайрласанд, мөн өнөөдөр болон ирэх гурав, дөрвөн өдрийн төлөө баярлалаа. Миний аялалын зорилгыг биелүүлэхийн төлөө шаргуу ажилласанд талархаж байна. Яагаад гэвэл миний аялал бол бас таны ч аялал юм, миний ажил бас таны ч ажил юм. Надаас, бас та нараас, хамтран ажилласан, тусалсан, сэтгэл санаагаар, эсвэл бүр биечлэн энэ ажлыг дэмжсэн бүх хүнээс ач тус хүртсэн, эсвэл хүртдэг хэн бүхэн хүн төрөлхтний ач буянтан юм. Энэ бол Бодьсадва нарын (гэгээрсэн төрөлхтнүүд) арга зам юм. Энэ бол гэгээнтүүдийн зам мөр. Өөр арга зам гэж байхгүй, үсээ хусуулж, Хималайн ууланд шигдэх хэрэг алга, яахын ч хэрэггүй, хадаастай орон дээр унтахын ч хэрэг байхгүй. Тийм ээ, зүгээр л эгэл жирийн атлаа билиг ухаантай бай.

Та ямар үзэсгэлэнтэй юм бэ! Таныг сайжирсанд баяртай байна, бас итгэл бишрэл тань бат бэх байгаад баяртай байна. Та багагүй сорилтыг туулж гарсныг би мэдэж байгаа, гэхдээ бид өөрийн дэс төвшнийг ингэж байж л мэдэж авдаг юм. Бидний алагчлах үзэл айхтар уу, үгүй юу; жинхэнэ Их Багш болон хуурамч Их Багшийн хоорондын ялгааг мэдэж байна уу, үгүй юу; Их Багшид сайн сайхан чанар байна уу, үгүй юу гэдгийг мэдэж байна уу; эсвэл зүгээр л ухаан санааг сэвтүүлсэн элдэв хов жив, цуурхал сонсоод байна уу гэдгээ бид ингэж л мэддэг. Хэрвээ бид үүнийг давтан хэлж – өрөөлийн ухаан санааг буртаглавал энэ нь яг л үргэлжлэн түгэн тархаж байгаа өвчинтэй адил. Тиймээс бид ам нээвэл зөвхөн сайн сайхныг ярих нь өлзийтэй. Хэрвээ үүнээс ерөөсөө зайлсхийх аргагүй байвал бид ямар нэг зүйл хэлэх хэрэгтэй ч зөвхөн хүмүүст зааж сургах, эсвэл тэднийг сайжраасай гэсэндээ хэлэх хэрэгтэй. Тийм биш бол үнэн, худал алин ч байлаа гэсэн сөрөг муу зүйлийг хэлж ярих нь утгагүй хэрэг. Үүнийг тарааж байгаа хүн л хамгийн түрүүнд бүхнээс илүүгээр өртөн зовох болно. Мөн үүнийг сонсож байгаа хүн энэ үгэнд автах эсвэл итгэх юм бол бас л энэ нөлөөнд өртөнө.

За, тавтай сайхан нойрсоорой!

## БУРХНААС БИДЭНД ЗАЯАСАН ЭЛБЭГ БАЯН АМЬДРАЛЫГ НАНДИГНА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1992 оны 3 дугаар сарын 11, (Дүрс бичлэг 227)  
Япон, Токио хот (Эх нь Хятад хэлээр)*

Хэрвээ хэн нэг хүн маш баян бөгөөд саадгүй өрнөх амьдралынхаа бүх зүйлд сэтгэл хангалуун, бас Бурханд, Хамгийн Чадагч Хүчинд сүсэг бишрэлтэй, өөрийгөө сүнслэг талаараа хөгжүүлж байдаг бол тэр хүн аугаа билиг ухаантай хүн мөн гэж Буддын судар номд өгүүлсэн байдаг. Амьдралдаа сэтгэл хангалуун ихэнх хүн энэ хорвоогоос чанагш байх нөхцөл байдлын талаар эргэцүүлэн боддоггүй. Бид голдуу л хүнд хэцүү байх үедээ л Бурхныг дурсдаг, гачигдал хэрэгцээгээ сүнслэг байдлаар ухаардаг. Хэрвээ ямар нэг зүйлээр гачигдаагүй л бол бид тэр тухай боддоггүй. Гэвч үнэн хэрэгтээ, ямар ч нөхцөл байдалд байсан Бурхнаас бидэнд заяасан хамгийн аугаа хайр хишгийг бид санаж явах ёстой. Энэ хорвоогийн хөрөнгө баялаг, эсвэл үнэт цаас үүрдийнх биш. Энэ бүхэн нь биднийг үргэлжид сэтгэл хангалуун байлгаж чадахгүй.

Үнэний зам мөр хөөхөөс өмнөх амьдрал маань тун сайн байсан. Миний (хуучин) нөхөр эрдэмтэн бөгөөд хоёр докторын зэрэгтэй, харин би Улаан Загалмайд орчуулагчийн ажил хийдэг байлаа. Бидэнд усан сан, ууранд суух газартай хувийн байшин, бас машин гэх мэтийн зүйл байсан. Нөхөр маань залуухан, царай зүс сайтай. Би хэдийгээр ийм жаргалтай амьдарч байсан ч, миний үнэхээрийн хүсдэг зүйл болох дотоодын аз жаргалыг мэдэрдэггүй байлаа. Энэ дэлхийд надад ямар нэг зорилго байгаа, бас материаллаг баялаг хэзээ ч зүрх сэтгэлийг минь хангаж чадахгүй гэдгийг бүр бага залуу байхаасаа л мэдэрсэн билээ.

Би олон улс орны үүх түүхийг уншсан. Олон баян, хүчирхэг улс орон гэнэт ядуурсан байдаг. Япон улс дахин сэргэх боломжтой болох хүртлээ олон салхи шуурга, үймээн самууныг амсаж туулсан. Энэ бол тун сайн хичээл сургамж, туршлага байсан. Бурхан хүмүүн биднийг үргэлж хайрлаж, янз бүрийн арга замаар асарч халамжилдаг. Тэр ч байтугай байгалийн гамшиг ч ивээлийн нэг хэлбэр бөгөөд бидэнд хорвоо дэлхийн хувьсамхай мөн чанарыг сануулсан маш хатуу хичээл сургамж юм. Хэрвээ хичээл сургамжийг нь хүлээгээд авчихвал Бурхан биднийг халамжилж, бидний амьдралын тав тухыг хангах материаллаг

зүйлс, эд баялгийг өгдөг. Гэхдээ бид тав тухаар хангагдчихаад Бурхны бидэнд заасан зүйлсийг мартаж өгсгүй, яагаад гэвэл хэрвээ бид хичээл сургамжийг нь мартаж аваас түүндээ дахиад л суралцах хэрэгтэй болж магадгүй. Бид Бурхны хайр ивээл дор оршиж, бүх зүйлээр хангагдсан байх үедээ Бурхны хуулийг, бас бүр түүнээс ч илүүгээр ертөнцийн хуулийг нандигнан хүндэтгэвэл зохино. Тэгвэл л бидний амьдрал улам баян тансаг, илүү тав тухтай болно.

Эрт дээр цагт бусад боолчлогдсон Моисей<sup>2</sup>-н ард олон Бурхнаас тусламж эрэн залбирчээ. Ингээд Моисейгээр дамжуулан Бурхан тэднийг зовлонгоос гэтэлгэж, аюулгүй газар аваачин эрх чөлөө болон бусад хэрэгцээтэй зүйлээр нь хангасан гэдэг.

Гэвч баян тансаг, тав тухтай амьдралд тэд биеэ оторлон дэмий сэлгүүцээд зогсохгүй, бас Бурхны дүрэм журмыг мөрдөхөө огоорон мартаж, бусармаг амьдралаар замнах болжээ. Бурхан тэднийг урьдынхаараа хайрлаж байсан ч тэдэнд өөр байдлаар хичээл сургамж өгч эхэлжээ. Цаашдаа тэдний амьдрал урьдын адил тав тухтай байхаа больж, бас тэд бие биеэсээ тусгаарлагдан янз бүрийн газар орон луу тарж бутарснаар хэрэн тэнэсэн, аюул осолтой амьдралд шилжжээ.

Энэ дэлхийн түүхийн туршид үүнтэй төстэй олон үйл явдал болсныг бид харж байна. Баян тансаг, хүчирхэг улс орон, эсвэл нэр алдартай олон гүрэн улс гэнэт л сүйрч мөхсөн байдаг. Энэ хүн зон орчлон ертөнцийн хуулийг хүндэтгээгүй учраас ийм зүйл болжээ. Тэд Бурханд огтхон ч талархал дэвшүүлээгүй. Ной<sup>3</sup>-гийн цаг үед ч үүнтэй төстэй үйл явдал тохиолдсон байдаг. Тэр цагт дэлхий бүхэлдээ бусармаг болсон тухай Библи сударт тодорхой тэмдэглэсэн байдаг. Хүмүүс хорвоогийн эд баялгаас өөр бусад зүйлийг хайхрахаа больж, ёс суртахуунгүй болсон байж, тийм учраас Бурхан энэ Дэлхийг цэвэрлэх гэж үер ус буулгажээ.

Мэдээж, хүн байх гэдэг нь нэн бэрх; бид Бурхнаас илүүтэйгээр эд материалыг түшиглэдэг. Бидний хувьд материаллаг зүйл илүү бодитой, харин Бурхан хийсвэр байдаг. Гэтэл үнэн хэрэгтээ Бурхан Бидэнд тун ойрхон. Тэр бидний дотоодод байж байдаг. Гэвч энэ дэлхийн зарим тодорхой нөхцөл байдлын улмаас бид Бурхныг олж харж чаддаггүй. Харин бусад гараг дээрх төрөлтнүүд Бурхныг амархан олж харж чаддаг. Гэсэн ч бидэнд Бурхан оршиж буйг нягтлан мэдэх арга зам бас байж л байдаг. Буддизмд Бурхныг Бурхан чанар гэж нэрлэдэг; янз бүрийн

2- Моисей (эртний евр. Моше), Таван номд (Ахуй амьдралын номоос бусад нь) еврей ард түмнийг египтийн дарлал боолчлолоос чөлөөлөгч, мөн түүнчлэн Бурхан болон еврейчүүдийн хоорондын зуучлагч. Бурхан Синайн ууланд Моисейд хуулийг нээж өгсөн гэдэг (Исх. 19–20; Второз. 4–5). (Мирча Элиаде. Ион Кулиаде. Словарь религий, обрядов и верований)

3- Ной. Библийн сударт бүх дэлхийн үерийн үед Бурханд сонгогдон завин дээрээ газар дэлхийд амьдарч байсан амьтдыг авран хамгаалах зарлиг айлдвар хүлээн авсан хүн гэдэг. (Мирча Элиаде. Ион Кулиаде. Словарь религий, обрядов и верований)

шашинд Түүнийг өөр өөрөөр нэрлэдэг.

Арьяабалын аргыг бясалган дадуулах нь бидэнд Бурхантай, эсвэл өөрийнхөө Бурхан чанартай харилцах боломж олгодог бөгөөд ингэснээр бидний ухамсрын төвшин аажмаар бусад гараг дээрх тэдгээр төрөлхийтнүүдийн мөн ижил төвшин рүү нэн хүчтэй дэвшдэг. Тэгвэл л бид илүү дээд төвшний гараг дээр амьдарч чадна, хэрвээ ингэе гэж хүсвэл! Бидний билиг ухаан, соёл иргэншил бусад өндөр дэсийн ертөнцийнх шиг өндөр дээд биш учраас л энэ Дэлхий дээр зовлон зүдүүр нь аз жаргалаасаа илүү арвин байдаг бөгөөд соёл иргэншил болохынхоо хувьд ч тийм дээгүүр болж хөгжөөгүй байдаг. Гэсэн ч Арьяабалын аргыг дадуулан бясалгавал бид өөрийгөө хэрхэн ариусгах арга замаа мэдэж, илүү дээд соёл иргэншилтэй хүмүүс болж, дээд гараг ертөнцөд амьдарч чадахуйц үнэ цэнэтэй хүмүүс болно.

Энэ дэлхийд зарим нь баян тансаг, ихэд хөгжсөн, зарим нь ядуу буурай, хөгжлөөр дорой гэхчлэн олон улс орон байдаг. Үүн лүгээ адил, орчлон ертөнцөд олон янзын гараг байдгаас өндөр дээд төвшний гарагууд нь аугаа билиг ухаантай төрөлтнүүдэд зориулагддаг билээ. Бидний билиг ухаан дэвшин гэгээрсэн ч бид энэ Дэлхий дээр байсаар байж болно. Тэр үед бид билиг ухаантай, өндөр дэсийн аз жаргалтай хүн болсон байх бөгөөд энэ дэлхийгээ илүү өндөр дээд дэстэй болгон өөрчлөхөд тусалж чадна. Хэрвээ бид бусад дээд гараг дээрх төрөлтнүүдтэй амьдрахыг хүсвэл тэгж бас болно.

Япон улсын амьжиргааны төвшнийг гүйцэх орлогогүй бол гадаад хүн Япон улсад ирж амьдрахад амаргүй. Бидний ихэнх маань, жирийн хүмүүс хөгжлөөр дээгүүр, амьжиргааны өртөг ихтэй энэ улсад амьдарч чадахуйц хэмжээний хангалттай их мөнгө олж чаддаггүй. Япон эмэгтэйтэй гэрлэх нь Япон улсад үлдэх нэг арга зам гэж би сонссон. Тэглээ ч гэсэн тэндээ үлдэж амьдрахад бидэнд япон үндэстний санаа сэтгэл, үзэл баримтлал зохих хэмжээгээр байх хэрэгтэй, эс тэгвээс Японд байгаа сахилга бат, цэвэр цэмцгэр байдал болон дээгүүр төвшний аж төрөл нь биднийг уйтгарлан ганцаардахад хүргэнэ. Бид бас л ийм сэтгэл санааг өөртөө хөгжүүлж, япончуудын сахилга батыг дагаж мөрдөх хэрэгтэй болно.

Үүнтэй адилаар энэ орчлон ертөнцөд зарим гараг, зарим ертөнцөд илүү соёл иргэншилтэй, илүү сахилга багтай төрөлтнүүд байдаг. Тэд илүү дэвшсэн соёл иргэншилтэй, илүү өндөр дэстэй. Хэрвээ бид тэнд амьдрахыг хүсвэл эхлээд билиг ухаанаа хөгжүүлэх ёстой болно. Манай дэлхий дээр, эсвэл Ази тивдээ Япон бол соёл иргэншилтэй, хөгжиж дэвшсэн улс орон билээ. Гэхдээ зөвхөн материаллаг талаас авч үзвэл л ийм юм. Сүнслэг үзэл санааны үүднээс авч үзвэл дэлхий дэх нэг ч улс орон дэвшиж тэргүүлээгүй байна. Дэлхий дээрх аль ч орон хэдийгээр соёл иргэншилтэй ч гэлээ дээгүүрх ертөнцүүдтэй эн зэрэгцэж чадахгүй.



Энэ дэлхийгээс чанадад олон ертөнц байдаг бөгөөд тэдний орон байр биднийхтэй адилгүй, болор, алт, үнэт эрдэнэсээр хийгдсэн байдаг. Тэдний орон байртай харьцуулахад бид тун ч ядуу хүмүүс билээ. Материаллаг эд баялаг хүсэж байгаа учраас л бид сүнслэг бясалгал дадуулах ёстой юм биш, би ердөө л бусад дээгүүр төвшний гарагуудаас манай Дэлхий ямар ялгаатай байдгийг л өгүүлж байна. Бид алт, болор, үнэт эрдэнэсээр хийсэн байшинд амьдрах дуртай учраас дээд ертөнцүүдэд очих гэж дурлаад байгаа ч юм биш, харин тэр ертөнцүүдийн амьдрал нь эрх чөлөөтэй, тав тухтай, амар хялбар, аз жаргалтай учраас л тэр юм. Бид үхэх төрөх, өвдөх, өглөх гэх мэтийн зовлон шаналлыг тэнд амсахгүй. Энэ ертөнцүүдэд бид үүрд мөнх оюунлаг, үзэсгэлэнтэй, залуухан, баян чинээлэг байх болно.

Би үүнтэй төстэй сэдэвтэй олон япон кино үзэж байсан. Япон хүмүүс сүнслэг ертөнцүүдийг харьцуулж судалсан л байгаа юм. Та нар урьд өмнө аль нэгийг нь үзэж байсан уу? Би үзсэн! Заримдаа Японы телевизүүдээр сүнслэг сэдэв, эсвэл бусад ертөнцөд хамаарах нөхцөл байдлын тухай нээлттэй хэлэлцүүлэг гарч байдаг. Япон улс ийм баян чинээлэг атлаа сүнслэг сэдвүүдийг сонирхсоор байгаа төдийгүй хамаг найдвараа зөвхөн материаллаг зүйлсийн хүч чадалд тавьчихгүй байгаад нь би баяртай байна. Хэрвээ бид Бурханд итгэсэн, ёс суртахуунд итгэсэн ийм чиг хандлагаар явбал манай улс орон баян чинээлэг болох нь гарцаагүй юм. Гэхдээ миний үзэж харж, сонсож мэдсэнээр бол тэр кинонд гарч буй ертөнцүүд тийм ч өндөр дээд төвшнийх нь биш. Тийм атлаа, ерөөсөө манай дэлхийг тэдэнтэй харьцуулахын аргагүй тийм үзэсгэлэнтэй сайхан, бас нэр алдартай ажээ. Хэлэлцүүлгээс харж байхад тэр Япон хүмүүс өөрсдөө тэр ертөнцүүдээр аялсан бололтой. Зөвхөн тэнд очиж үзсэн болоод л ийм сайхан, жинхэнэ бодит кино хийж чадсан хэрэг.

Зөв аргыг бясалган дадуулснаар, бид дээд ертөнцүүдэд очиж чадна. Бид энэ дэлхийд амьдарч байхдаа ч – бясалгаж байх үедээ, унтаж байхдаа, бидэнд энэ биеэ орхих цаг хугацаа байвал тийшээ очиж чадна. Бид кинон дээрх хүмүүс шиг эхлээд заавал үхэх ёстой ч юм биш.

Үүнээс гадна, бид Арьяабалын аргаар хичээнгүй бясалгаваас бүр илүү дээгүүр ертөнцүүдэд ч очиж үзэж чадах бөгөөд бас үхсэнийхээ дараа ч очихыг хүссэн ертөнцөө сонгож чадна. Үнэн хэрэгтээ, бид илүү дээгүүр ертөнцүүдэд хүрэхээсээ ч өмнө, аль хэдийнээ баяр жаргалыг мэдэрчихнэ. Өмнө нь ойлгож ухаараагүй олон зүйлээ бид ойлгодог болчихно. Авшигтан шавь нар дэлхий даяараа хичээнгүй бясалгаж байгаагийн учир нь энэ. Ач тусаа өгдөг учраас л бид бясалгалаа хичээнгүйлэн дадуулсаар байх дуртай байдаг. Бизнестэй адилаар, хүсэл сонирхол байх юмуу, эсвэл олз ашиг олж байвал л бид үргэлжлүүлэн шаргуу хичээн ажилладаг. Энэ дэлхийн хүмүүс хэрвээ эрхэлж буй ажил

үйлс нь үр шимээ өгөхгүй байвал сонирхохоо больдог.

Япончууд бол маш сайн бизнес эрхлэгч! Тэд үнэнч шударга, тийм ч учраас их амжилт олдог. Тэд амжилттай байх тусмаа улам шаргуу ажилладаг. Ихэнх Япончууд алба ажил, эсвэл бизнесийнхээ төлөө хувийн амьдралаа золиосолдгийн учир нь энэ. Япон улсыг бүр цоо шинээр сэргээн босгох хэрэгтэй болсон учраас л үйлдвэртээ, улс орондоо туслахын тулд тэд хамаг эрч хүч, цаг хугацаагаа харамгүй зориулсан! Ард түмнийхээ шаргуу хөдөлмөр, асар их чармайлтын ач үрээр энэ улс орон шинэ амьдралаа олж, баян чинээлэг болсон билээ. Энэ нь япон хүний үнэнч шударга, нэгдмэл сэтгэл санаа болон ажил хөдөлмөртөө үнэнч шударга байдгаас болжээ. Ийм байдлаар ажиллаж хөдөлмөрлөх нь амжилтанд хүргэж, улс орныг улам баян чинээлэг болгодог. Үүнийг дагаад ард иргэд нь ч ажил хөдөлмөртөө улам бүр сонирхолтой болж, улам шаргуу хичээн ажилладаг. Улс эх орны сайн сайханд хэрэгтэй гэж мэдэрсэн учраас тэд заримдаа үйлдвэртээ хөлс мөнгө авалгүй илүү цагаар ажилладаг! Эцсийн дүнд ач тусыг нь улс орон нь хүртдэг! Иймэрхүү аминч бус сэтгэл зүрхийг энэ дэлхийгээс олохуйяа ховор билээ.

Гэтэл бас алба ажлаа дуусгасан хэр нь л тэд оройн цагаар ажил хэргийн уулзалтад очиж, үйлдвэрээ, эсвэл бизнесээ сайжруулах арга замыг олох гэж цугладаг. Ард түмэн нь амин хувийнхаа ашиг тусыг золин байж, нийлж нэгдэх болон өгч зориулахад бэлэн байдаг учраас Япон улс асар түргэн хугацаанд нэн чинээлэг, хүчирхэг улс болж чадсанд гайхах юмгүй. Шалтгаан байгаа цагт үр дүн байдаг.

Үүн лүгээ адил, Арьяабалын аргыг бясалган дадуулснаар бид энэ аргыг бүх дэлхий даяар ахархан хугацаанд түгээж чадна. Энэ нь авшигтан бясалгагч нар энэ арга дэлхийд маань ач тусаа өгнө гэж мэдэрч байгаа учраас тэр юм. Бид энэ дэлхийд байгаа учраас дэлхийд ач тус хүргэснээр өөртөө ч ач тус хүргэнэ гэсэн үг. Жишээлбэл, амьдардаг байшин маань эвдэрч нурвал түүнийг засаж элбэснээр бид чухамдаа өөрсдийгөө л хамгаалж байгаа хэрэг.

Энэ нь Япон хүний сэтгэл санаа гэх зүйлтэй төстэй. Тэд өөрийнхөө цаг зав, хувийн амьдралаа үйлдвэр, бизнес, улс орныхоо ач тусын төлөө золиослож байгаа юм шиг сэтгэгдэл төрдөг. Гэтэл ингэх нь Япон хүнд өөрт нь ач тус хүртээж байна, учир нь Япон орон баян чинээлэг байвал ард иргэд нь жаргалтай байх болно. Тэгвэл Япон орны нэр хүнд өсөж, дэлхий дахинаараа Япончуудыг, бас улс орныг нь хүндэтгэнэ. Тиймээс үүнийг би ухаалаг бөгөөд зөв арга зам гэж бодож байна.

Бидний хувьд бас л ийм юм. Бидний сүнслэг бясалгал хийхийн зорилго бол билиг ухаанаа нээснээр хамаг амьтанд тусалж, энэ дэлхийн хүч чадал болон соёл иргэншилд дэвшил авчрахад оршино. Үүний зэргэцээ энэ бүхнээс аяндаа л өгөөж хүртдэг нь бид өөрсдөө болон гэр

бүл маань, өнгөрсөн, одоо ирээдүйн хамаатан садан, найз нөхөд маань байдаг. Тийм учраас биднийг Үнэний зам мөрөөр замнаж эхлэхэд өвөг дээдэс маань илүү дээд ертөнцүүд рүү дэвшин гэтлэгдэж, бүр ч амар хялбар, баян чинээлэг, аз жаргалтай амьдардаг гэдгийг бид мэддэг.

Хэрвээ энэ дэлхийд хүн бүр сүнслэг бясалгал дадуулж чадах юм бол Дэлхий маань бусад гараг шиг маш өндөр соёл иргэншилтэй, өндөр дэсийн гараг болох болно. Тэр үед бид юуг ч зохион бүтээх чадвар боломжтой, ямар ч материаллаг хэрэгцээгээ хангах чадвартай болно, яагаад гэвэл бидний оюун санаа дэвшсэн, билиг ухаан дээшилсэн тул бид юуг ч хийх чадвартай болсон байдаг.

Бусад гараг яагаад Үл Мэдэгдэх Нисдэг Биет болон орчин үеийн хөгжингүй машинтай байдаг вэ? Тэдний билиг ухаан биднийхээс хавьгүй өндөрт очсон байдаг учраас тэр юм. Бусад гарагт машинаа жолоодоход яагаад бензин хэрэглэдэггүй вэ? Тэдний оюун ухаан биднийхээс илүү учраас тэр, бас энэ Дэлхийд байж магадгүй ч бидний олж нээгээгүй элдэв төрлийн түүхий эдийг нээж илрүүлсэн байдаг. Бид тэр түүхий эдүүдийн талаар мэдээгүй байгаа, эсвэл яаж ашиглахыг нь мэддэггүй. Хэдий тийм ч бид заримыг нь аль хэдийн мэддэг болсон байна!

Тиймээс ч бидэнд зурагт, телефон утас, компьютер, анагаахын болон шинжлэх ухааны олон дэвшилтэт багаж хэрэгсэл байдгийн учир нь энэ. Гэвч бусад ертөнцөд байдаг зүйлсийн хажууд бол хог новш шиг л юм. Бусад ертөнцөд бидний хэрэглэдэг багаж зэмсгүүдийг хоцрогдсонд тооцдог. Гэтэл тэд бол тийм ч их өндөр төвшний ертөнцүүд биш билээ! Тэд өндөр төвшний ч гэлээ хамгийн өндөр нь биш. Эдгээр дээгүүр ертөнцийнхөн Үл Мэдэгдэх Нисдэг Биетийг хэрэглэхгүйгээр нисэж чаддаг. Тэд үг хэл, эсвэл телефон утасгүйгээр харилцаж чаддаг. Тэд хүссэн ямар ч зүйлээ зурагт ашиглахгүйгээр харж чаддаг.

Эдгээр ертөнцөд билиг ухаанаа дайчилдаг хувь хэмжээ нь манай дэлхийнхээс хавьгүй өндөр. Бид болон тэдний хоорондох ганц ялгаа нь энэ л юм. Манай дэлхийн хамгийн ухаантай хүн гэхэд л оюун ухааныхаа ердөө дөрвөн хувийг нь л ашигладаг. Төсөөлж чадаж байна уу? Ердөө л дөрвөн хувь! Тийм учраас л дэлхий маань харьцангуй хоцрогдчихоод байгаа хэрэг. Дээд ертөнцийн оршихуйнууд билиг ухаан болон оюун сэтгэлгээгээ илүү ихээр ашиглаж хэрэглэх арга замаа мэддэг.

Эрт дээр цагт дээд ертөнцөөс хүмүүс бидэнд зааж сургахаар Дэлхийд ирдэг байжээ. Тэдний зарим нь дунд төвшнөөс, зарим нь илүү дээгүүр төвшнөөс, бас нэг хэсэг нь хамгийн өндөр дээд төвшнөөс ирдэг байж. Дунд төвшний хүмүүс бидэнд дэвшилтэт машин төхөөрөмж хэрхэн хийхийг зааж өгсөн бөгөөд бидэнд илүү ая тухтай, баян чинээлэг, соёлжиж иргэншин амьдрах боломж олгосон зарим гайхамшигт ер бусын хүч чадлаа хэрхэн хөгжүүлэхийг зааж өгсөн. Атлантын цаг үе шиг Дэлхийд байсан гайхамшигт эрин үеүд бол дунд төвшний ертөнцүүдээс

ирсэн багш нарын ажлын үр дүн байсан юм. Тэр үед манай дэлхий маш их соёл иргэншилтэй байсан. Өнөөгийн археологичид заримдаа тэр цаг үеийн соёл иргэншлийн нотолгоог олдог.

Заримдаа зурагтаар сурвалжлага гардаг. Та нарт хэлэхэд би зурагт үзэж, эсвэл сонин унших нь ховор. Та нарын үздэг телевиз, эсвэл сонинд энэ талаар мэдээлсэн үү? (Сонсогчид:Тийм.) Энэ сайн хэрэг, тийм бол ярьж байгаа маань үнэн зөв л байгаа юм байна! Тэр цаг үед Дэлхий дээр нэн өндөр соёл иргэншил байсан ч нэг хэсэг хүмүүс нь ёс суртахуунаар дорой байсны улмаас тэр дэвшилтэт машин төхөөрөмжүүдээ өөрсдийгөө устгах багаж зэмсэг болгож хувиргажээ. Анхандаа дэвшилтэт багаж хэрэгсэл байсан зүйлсийг сүүлдээ өөрсдийнхөө соёл иргэншлийн хэв журмыг устгахад ашиглажээ. Хүмүүс хоорондоо алалцаж хөнөөлцсөн. Бид дээд ертөнцөөс ирсэн багш нарт талархалтай байсангүй, сэтгэл ханалгүй, бүр улам их зүйлийг нэхэж шаардсаар эцэстээ гараг хоорондын дайн гарахад хүргэсэн. Дэлхий бусад гарагт ялагдаж, соёл иргэншлээ алдсан. Түүнчлэн үүний дараа урт хугацааны туршид өөр гарагийн соёл иргэншилтэй оршихуйнууд бидэнд зааж сургахаар ирж зүрхлэхээ больжээ.

Гэсэн ч дээд ертөнцүүдийн зарим нэг хүн бидэнд зааж сургахаар бууж ирсэн л байдаг юм. Тэд бидэнд дэвшилтэт машин төхөөрөмж, багаж хэрэгсэл хэрхэн хийхийг заадаггүй. Тэд биднийг илүү соёл иргэншилтэй газар амьдрахаар очиж чаддаг болог хэмээн билиг ухаанаа хэрхэн хөгжүүлэхийг бидэнд заадаг. Учир нь зарим хүн энэ дэлхийгээс олоход тун бэрх, тогтвортой, соёл иргэншилтэй, жаргалтай тийм л газар байхыг хүсэмжилдэг. Бас энэ Дэлхийн бүх хүнийг соёл иргэншлийн нэг ижил төвшин рүү дэвшүүлэхийн тулд бүгдийг нь соёл гийгүүлэх нь тун бэрх. Тиймээс тэд тодорхой тооны хүмүүст зааж сургаад тэднийг илүү тогтвортой, соёл иргэншилд хүрсэн, жаргалтай гарагт аваачдаг.

Дэвшилтэт тоног төхөөрөмжийг манай дэлхийд ашиглах нь сайн гэхээсээ муу хор хөнөөлтэй байж ч магадгүй. Жишээлбэл, хэрэв тэд Дэлхий дээр болор, эсвэл алгаар байшин босговол тэр нь их хурдан алга болчихож магадгүй. Эсвэл манай дэлхийд дэвшилтэт багаж төхөөрөмж авч ирвэл хүмүүс түүнийг бие биеэ хөнөөхөд ашиглаж магадгүй. Дэлхий дээрх хүмүүс эрхэм ариун, аминч бус, соёлжиж иргэншсэн сэтгэл санаатай байх үе шатанд хүрээгүй байгаа учраас ийм явдал болж болох талтай. Хамгийн өндөр дээд гарагуудын төрөлтнүүд биднийг багаж хэрэглэлийг нь хувийн ашиг хонжоо, алдар нэр, хөрөнгө баялаг олж авахын төлөө урвуулан ашиглахыг вий гэж эмээдэг. Тэгэх юм бол хамгийн шилдэг сайн багаж төхөөрөмж ч хамгийн аюултай нь болчихож болно. Тиймээс биднийг өөрсдийн газарт аваачихын тулд соёл иргэншилтэй гарагуудаас багш нар ийшээ ирэх хэрэгтэй болжээ. Тэд биднийг эхлээд оюун санаа, билиг ухаанаа хөгжүүлэхэд сургаж

бэлтгэдэг, тэгснийхээ дараа л биднийг тогтвортой бөгөөд аюулгүй ертөнц рүү аваачна.

Тиймээс л Шагжамуни Будда, эсвэл Есүс Христ энэ дэлхийд заларч байх цаг үедээ зөвхөн тэнгэрийн тухай, Бурхны орон болон дээрх Нирвааны тухай л өгүүлдэг байсан байгаа юм. Тэд биднийг эндээ үлд гэж уриалаагүй.

Их сайн өмгөөлөгч, эсвэл сайн найз шиг л бидний нэрийн өмнөөс ярьж, биднийг шоронд суулгүй, харин хурдхан чөлөөт иргэн болох нь илүү дээр гэдгийн төлөө эрх чөлөөг маань баталгаажуулж өгчээ. Хамгийн сайн найз маань бидэнд хичнээн их хайртай байлаа ч гэсэн «Мерседес» юмуу «Тобота» гэх мэтийн өөрт нь байгаа хамгийн шилдэг машинаа бидэнд хэрэглүүлэх гэж шорон руу авчрахгүй. Шоронд үүний хэрэг тус байхгүй учраас тэд үүнийгээ гадна талд хадгалж байгаад биднийг суллагадахад өгнө шүү дээ. Түүнээс гадна, хэрэв тэдэнд маш их мөнгө, алт, үнэт эдлэл байсан ч шоронд байгаа биднийг халаасандаа хадгалаг гээд явуулахгүй, учир нь ингэвэл бидэнд бүр ч аюул осолтой болно. Биднийг гадаа аюулгүй газар байх үед л тэд энэхүү үнэт зүйлсээ бидэнд өгөх байх. Харин шоронд байж байвал тэд мэдээж хамгийн сайнаараа халамжилж, аль болох тав тухтай амьдруулахыг чармайна.

Яг үүн шиг Арьяабалын аргыг бясалган дадуулагч бидний хувьд Бурхан буюу Хамгийг Чадагч мэдээжээр, бидний тухайд хамгийн сайнаар халамжилж, амьдралыг маань илүү тав тухтай болгодог. Гэхдээ энэ нь бидэнд бүх юм байж байна гэсэн үг биш! Хэрвээ үнэхээр үүрд амар амгалан, үүрд эрх чөлөөтэй, үүрд баян чинээлэг, үүрд амьд байхыг хүсэж байвал бид эдгээр зүйлээр цэнгэн жаргахын тулд зарим нэг дээд гараг эрхэст зочлох ёстой болно. Мэдээжээр, бид энэ дэлхийд байх үедээ тэр ертөнцүүдээр хэсэг зуур айлчилж болно. Харин хожим энэ дэлхийгээсээ хальж одохоороо тэнд очоод үүрд үлдэж болно. Тэглээ ч гэсэн энэ дэлхийд амьдарч байхдаа тэр ертөнцүүдийг хааяа үзэж харах нь биднийг итгэн үнэмшүүлдэг. Энэ бол Арьяабалын аргыг дадуулснаар хүртдэг үр дүн, баталгаа нотолгоо юм. Нотолгоо байхгүй бол бид энэ арга сайн уу, үгүй юү гэдгийг мэдэх аргагүй.

Есүс “Миний эцгийн гэрт олон харш бий” гэжээ. Түүнийг дагаж байхдаа шавь нар нь олон янзын ахуй ойлголт, сүнслэг хариуг хүлээн авна гэсэн санааг Тэр ингэж өгүүлжээ. Тэрээр шавь нартаа энэ Дэлхийд амьдарч байхдаа бусад ертөнцийг зэрвэс ч болтугай үзэж харах боломж өгчээ. Шагжамуни Будда айлдахдаа: “Орчлон ертөнц даяар Бурхны орон (диваажин, Бурхны Хаант Улс, Нирваан) олон байдаг, арван зүгт Бурхны орон олон бий” гэжээ. Шагжамуни Буддагийн зам мөрд орж дагасан шавь нар нь хэр чин сэтгэл, хичээл чармайлттай байгаагаасаа хамааран янз бүрийн ертөнцийг заримдаа, эсвэл үргэлж үзэж чаддаг байжээ.

Бид одоо Будда болон Есүсийн бясалган дадуулсан аргыг дамжуулан өгч байна. Арьяабалын бясалгалын аргаар бясалгагч хэн ч Есүс Христ, эсвэл Бурхан багшийн бясалгахдаа олж авсан сүнслэг хариултаудыг мөн адил олж авах боломжтой. Сүнслэг бясалгагч хүн энэ Дэлхийд амьдарч байхдаа ч Буддаг харж чадна, эсвэл тэр нойрон дундаа бусад ертөнцөөр зочилж ч магадгүй. Тэр хүн тэнгэрт халихаараа тэр дээр очиж амьдарч болох бөгөөд зовж зүдрэх гэж ийшээ буцаж ирэх албагүй.

Бид та бүхэнд энэ аргыг ямар нэг болзол нөхцөлгүй, ямар ч хөлс мөнгө, нийгмийн байр суурь, урьд өмнийн туршлага, эсвэл шашин шүтлэгийн шаардлага тавилгүйгээр санал болгож байна. Энэ аргаар бясалгах нь бидэнд өөртөө төдийгүй, гэр бүл, улс эх орондоо туслах, өвөг дээдсээ илүү сайхан гараг ертөнц өөд гэтэлгэн чөлөөлөх боломж өгч байна. Бид энэ дэлхийг орхихдоо, мэдээжээр, Бурхны оронд буюу Бурхны Хаант Улсад үүрд амьдрах болно! Хүсэж байгаа хэн бүхэн энэ аргад бидэнтэй хамт суралцаж болно.

Яриагаа үүгээр өндөрлөе. Та бүхний хайрын сэтгэлд болон ажралгүй анхааран сонссонд талархъя.

## Лекцийн дараах асуулт хариулт

А (Асуулт): Хойд төрөл байдаг гэж үнэн үү?

Б (Их Багш): Тийм, үнэн. Хойд төрөл байдгийг баталсан үйл явдлууд заримдаа сонинд нийтлэгдсэн байдаг. Энэтхэгт жишээлэхэд хэзээ ч гэрээсээ холдож үзээгүй найман настай хүү урьд насандаа амьдарч байсан орон гэрээ мэдэж таньж байсан; тэр тэндээс ирсэн юм байж л дээ. Тэр нөхөр, хүүхдүүд, орон гэр нь тэнд байсаар байгааг, мөн тэдний нэр ус, гэрийн хаягийг ч тун тодорхой хэлж чаджээ. Судлаад үзтэл тэр үнэн ярьсан байж. Иймэрхүү явдал олон тохиолддог.

Шагжамуни Будда сүнслэг нүдээрээ өнгөрсөн цагийг тольдон харж чаддаг байв. Арьяабалын аргаар бясалгахдаа бид ч бас заримдаа сүнслэг нүдээрээ өөрийнхөө урьд төрлүүдийг харж чаддаг. Манай зарим шинэ авшигтан анх удаагаа бясалгал хийж үзэж байна. Тэд ч бас үүнийг харж чадна. Энэ үнэн.

А: Арьяабалын аргыг хэрхэн дадуулдаг вэ?

Б: Та веган (ургамал хоолтон) болох хэрэгтэй. Ургамал хоолтон байх нь япончуудын хувьд тийм ч хэцүү бэрх биш, учир нь энд Японд веган давсалсан гахайн маягыг их амттай хийдэг юм байна. Түүнээс гадна Япончууд голдуу далайн байцаа иддэг бөгөөд махыг маш бага хэрэглэдэг. Япончуудын хоол хүнс энгийн атлаа олон биш. Япончууд хоолонд тэгтлээ хомхойрч шунадаггүй, хоол ундыг тэгтлээ их

чухалчилдаггүй. Тэд тун энгийн даруу, цэвэр цэмцгэр амьдардаг учраас Арьяабалын аргаар бясалгахад таарч тохирно.

А: Их Багшийн дүрслэн өгүүлсэн ертөнцүүдийг харах чадвартай болтлоо би хэр удаан бясалгах хэрэгтэй вэ?

Б: Өө! Заримдаа түүнийг авшиг хүртэх үедээ л харчихдаг. Хүн хүний байдлаас хамаардаг юм. Ихэнх бясалгагч, эсвэл тэдний хагас нь авшиг хүртсэний дараа нэг их удалгүй энэ ертөнцүүдийг харж чаддаг. Зарим тохиолдолд үүнд хэдэн долоо хоног, эсвэл хэдэн жил орно.

А: Хэрвээ бид сүнслэг бясалгалын зам мөрд орж авшиг хүртчихвэл хайртай нохой маань үхлээ гэхэд ач тус хүртэх болов уу?

Б: Пээ! Таны зүрх сэтгэл хайраар дүүрэн юм байна. Тийм ээ, хүртэнэ! Бидний хүч чадал төсөөлөхийн аргагүй хөгжих учраас тэгэх болно. Бидний хайрлаж, эсвэл бодож байгаа хэн ч бай, ямар ч төрөлтөн ач тусыг нь хүртэх болно.

## ҮНЭНИЙ ТУХАЙ ХҮҮРНЭЛ ЯРИА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1991 оны 6 дугаар сарын 2 (Дүрс бичлэг 175)  
Коста Рика (Эх нь Англи хэлээр)*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай болон түүний эртний анд найзын хооронд ийм нэгэн яриа өрнөсөн байдаг. Их Багш энэ найзтайгаа олон жилийн тэртээ аль алин нь үнэний эрэлчид байх үедээ анх Хималайн ууланд тааралджээ. Энэ найз нь дэлхийн янз бүрийн газар орноор явж, олон ч алдартай Их Багшаас суралцаж, олон янзын аргаар бясалгаж үзсэн байв. Харин одоо энэ эмэгтэй Арьяабалын аргаар бясалгадаг болжээ. Үнэнийг олох хүсэл эрмэлзэл, мэдлэгийн төлөөх тэмүүлэл нь сэтгэлийг нь хөдөлгөсөн учраас Их Багш Чин Хай түдгэлзэлгүй түүнтэй чөлөөтэй ярилцжээ. Энэхүү гайхалтай харилцаа яриа нь чухамдаа “Үнэний тухай хүүрнэл” байв.

Энэхүү бичвэрт “Б”-гээр Их Багш буюу Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хариултыг, “А”-гаар түүний найзын асуултыг, “Ш”-ээр асуулт тавьсан бусад авшигтан шавийн асуултыг тэмдэглэлээ.

### Гэгээрсэн Их Багшийн сэтгэл татам чанар

Ш (Шавь): Хэрвээ энэ дэлхийд байгаа хэн нэг хүн бие нь тун сайнгүй байлаа гэхэд сүнс нь өөр бие, өөр хүний махан биеийг авч болох уу, жишээлбэл биеийг нь шилжүүлэн суулгаж байгаа юм шиг?

Б (Их Багш): Яах гэж тэр вэ? Нэмж зовохын тулд уу?

Ш: Үгүй ээ. Тэр хүн магадгүй сайн сайхан яваа, бас чухал ажил эрхэлдэг тул хүмүүс түүнийг ажлаа үргэлжлүүлээсэй гэж хүсдэг байж болох юм.

Б: Хэн ч хэн нэгнээр тэгтлээ дутагдахгүй. Хэн ч тийм чухал биш. Тийм шүү. Тэр байтугай танд Их Багш байхгүй байлаа ч өөр нэгэн Их Багш хүрээд л ирнэ. Энэ ч харин танд л таалагдахгүй л болов уу. (Инээлдэв.) Та таньдаг зүс царайтай цуг байгаад дасчихсан, тэгээд өөр царай гараад ирэхлээр та “Үгүй ээ, энэ биш ээ!” гэдэг. (Инээлдэв.)

Пээ! Цорын ганц асуудал нь энэ шүү дээ. Хүмүүс Есүсийг эргэж ирэхийг хүлээгээд байдгийн учир нь энэ. Тэд өөр нэг Элч ирвэл яг л зураг дээрхтэйгээ адилхан төрхтэй харагдах ёстой гэж боддог. Хэрвээ хэн нэг хүн Чин Хай Их Багшийг танилцуулбал тэд “Үгүй ээ, энэ биш!” гэж хэлнэ.

Ш: Хүн хүний бие яагаад өөр өөр хэлбэртэй байдаг вэ? Жишээлбэл, нүүр царай нь өөр өөр байдаг. Нүүр царай ямар утга учиртай вэ? Хүний нүүр царай юу илэрхийлдэг юм бэ?

Б: Та хүн бүр адилхан харагдах ёстой гэж бодож байна уу? Тийм байвал дэндүү уйтгартай. Үгүй ядаж л та хэзээ ч хүнд дурлахгүй, хүүхэд ч төрөхгүй байхсан. Та бүхэн олон янзын нүүр царайтай байхын ядаж нэг шалтгаан нь энэ. За юу? Аав, ээж хоёр чинь яг адилхан харагддаг байсан бол та хэзээ ч төрөхгүй байх байсан.

Ш: Би сүнслэг амьдралд “нүүр царай” ямар утга учир агуулдгийг л мэдэх гэсэн юм л даа?

Б: Ямар ч биш. Ердөө л уур амьсгал төдий. Гэвч ихэнх хүнийг бясалгаж байх үед өнгө үзэмж нь их хурц тод болсон байдаг. Гэхдээ орчин нь чухал. Хүмүүс сайн бясалгадаг хүний ойр орчимд байх дуртай, гэхдээ энэ нь нүүр царайнаас нь болж байгаа юм биш. За юу? Яагаад гэвэл хэрэв та 1970 оны Дэлхийн Мисс бүсгүйг харах гэж ирсэн байлаа гэхэд жишээлбэл, хүмүүс танд түүнийг үргэлж ширтээд дэргэдээс нь битгий холдоорой гэвэл (Инээлдэв) та тэгэхгүй л байх даа. Та жаахан байзнаад уйдаж эхэлнэ. Хамгийн үзэсгэлэнтэй сайхан хүнийг ч хэсэг зуур нүд салгахгүй ширтэсний дараа их ядардаг юм байна гэдгийг та анзаарах болно. Ядраад явж амармаар санагдана. Гэхдээ би Их Багш гэгддэг зарим хүнийг таньдаг юм. Зарим нь тийм ч үзэсгэлэнтэй, эсвэл царайлаг харагддаггүй, гэтэл хүмүүс тэдэн лүү ширтээд салдаггүй, тэгсэн мөртлөө ядардаггүй. Заримдаа хүн тэр Их Багшийн барааг ганц л удаа зэрвэхэн, хальтхан л харчих санаатай өдөржин хүлээж, тэрүүгээр холхидог. Эсвэл Их Багшийг ердөө л харахын төлөө хичнээн бээр газрыг туулан очдог, тэгээд буцах цаг болоход сэтгэл нь тавгүйддэг. Ойлгож байна уу? Ердөө л энэ үү? Та яагаад ингэж асуув?

Ш: Яагаад гэвэл би заримдаа хүмүүст Таных шиг сайхан Гэрэл байгааг хардаг. Энэ нь тэр гэрэл Таны сүнснээс ирж байгааг илтгэдэг, бас Таны царайнаас Та надад амар лингуйг өгч байгааг би хардаг. Би Танд тун их талархаж байна, яагаад гэвэл би тийм ч сайн биш агал Та намайг маш их хайрладаг. Танд баярлалаа.

Б: Миний нүүр царай бусдынхаас ямар ялгаатай гэж? Төстэй биш гэж үү? Би мэдээжээр, авшигтан та нартай адилхан харагдаж чадахгүй, гэхдээ хүний нүүр царай ямар байх нь ямар нэг утга учир агуулдаггүй. Царай зүснээс биш, харин тухайн хүнээс цацарч байгаа хайранд л гол нь байгаа юм. За юу?

Ш: Би энийг л асуусан юм. Би үүнийг бүгд мэдээсэй л гэсэн юм.

Б: Аа тийм үү!

Ш: Та царай зүс хардаггүй. Та зөвхөн зүрх сэтгэлийг нь л хардаг.

Б: Өө, би хардаг шүү. Та миний зүрх сэтгэлийг хармаар байна уу? (Инээв, бас санаа алдав.) Өндөр настай Их Багш нар бий. Тэд үрчлээ, атираатай, нүүрээрээ дүүрэн үрчлээтэй, бие бялдарын хувьд сэтгэл татахааргүй болчихсон байдаг, гэтэл хүмүүс тэдний бясалгалын буян, өөртөө агуулж байгаа хайраас нь болоод тэдэнд дуртай байдаг. Тийм! Зарим хүн намайг аятайхан дуу хоолойтой, эсвэл царай зүс нь гоё сайхан, эсвэл нүд нь үзэсгэлэнтэй учраас таалагддаг гэж хэлдэг. Энэ үнэн биш, яагаад гэвэл надад бас хараагүй, сонсголгүй шавь нар бий. Тэд намайг тэнд байвал үргэлж ирдэг, бүр долоо хоногийн даяанд ч ирдэг. Тэд миний царай зүсийг хэзээ ч харж байгаагүй, гэхдээ тэд дотоод ертөнцдөө царайг минь хардаг, тэгээд та нар намайг одоо ямраар харж байгаатай яг адилхан дүрслэн хэлдэг. Мэдээж дотоод талд илүү үзэсгэлэнтэй, тийм биз? (Инээлдэв)

### Хараагүй хүн авшигтан шавь болж болох уу?

А: Их Багш Чаран Сингх аль хэдийн Маха-самади хүртсэн байсан. Тэр Энэтхэгийн Бийс хотын маш том Их Багш байжээ. Тэр хараагүй хүмүүсээс бусад бүх хүнд авшиг хүртээдэг байсан.

Б: Яагаад?

А: Би үүнийг л Танаас асуух гэсэн юм, яагаад гэвэл Танд хараагүй авшигтан шавь байдаг гэж Та хэлсэн шүү дээ.

Б: Надад хараагүй авшигтан шавь нар бий. Үүнийг бүгд мэднэ. Тийм. Их Багшаас авшиг хүртэхийн тулд тэр хүний таван мэдрэхүй нь төгс байх ёстой гэдэг нь ерөнхий дүрэм. Энэ бол бүр эрт дээр үеэс байсан ерөнхий дүрэм. Будда бас л ингэж хэлсэн. Гэхдээ хэн нэг нь тэдэнд авшиг хүртээх л ёстой биз дээ. Үгүй гэж үү?

А: Нэгэнтээ шавь нь нэг өдөр ээждээ авшиг хүртээлгэхийг хүсжээ, гэтэл эх нь хараагүй гэдгийг нь Их Багшдаа хэлээгүй байжээ. Тэр “Чаран Сингх Их Багш аа, ээж маань ирж авшиг хүртэж болох уу?” гэж асуухад Их Багш нь “Болно, болно, та аваад ир, би түүнд авшиг хүртээе” гэжээ. Гэтэл өнөөх шавь ээжийгээ дагуулаад ирэхэд Их Багш ээжийг нь хараагүйг нь үзээд “Хараагүй хүнд авшиг хүртээж чадахгүй гэж би хэлсэн шүү дээ, тиймээс би ээжид чинь авшиг хүртээж чадахгүй” гэжээ. Шавь нь ихэд гонсойсон ч “Их Багш аа, гуйя, ээж минь шүү дээ! Авшиг хүртээчих л дээ!” гэжээ. Тэгтэл, Их Багш ид шид бүтээв, юу гэхээр авшиг хүртээх үедээ ээжид нь хараа оруулж байгаад авшиг хүртээжээ. Тэгэх зуур ээж нь юм харж байжээ.

Б: За тийм, түр зуур л.

А: Зөвхөн авшигийн үеэр л.

Б: Дараа нь яасан?

А: Дараа нь буцаад юм харахаа больчихсон.

Б: Формосад намайг лекц хийх үеэр ирж суусан зарим хүн бас хараа орсон байсан, гэхдээ авшиг хүртэхийн төлөө ирээгүй. Тэд хараа орсныхоо дараа авшиг хүртэх гэж ирсэн. Тэгээд харин тэд лекцийн явцад хараа нь сэргэсэн тухай түүхээ ярьсан, бас захидал илгээсэн юм.

А: Тэгээд тэр хэвээрээ үлдсэн үү?

М: Тэр хэвээрээ үлдсэн. Нэгэн эмэгтэй бүр багаасаа хараагүй байсан гэсэн, хорь гаруй жил.

А: Гэхдээ хараагүй байсан ч та тэдэнд авшиг хүртээдэг гэж үү?

Б: Тийм! Тэд ялгаагүй л бясалгалын ахуй ойлголт үздэг. Тэд Их Багшийгаа дотооддоо харчихдаг. (Инээлдэв)

А: Тэд Их Багшийгаа эндээ харжээ.

Б: Тэр хараагүй хүн бас намайг өөрт нь ойртоход миний байгааг үргэлж мэдэрдэг, намайг ойр хавьд нь байвал дандаа мэдэрдэг. Тэр инээмсэглэхээр нь би мэддэг юм. Би мөрөн дээр нь зөөлөн алгадахад тэр мэддэг. Тэгээд бид их ойр дотно гэдгээ мэдэрдэг.

### Их Багш шавийнхаа үйлийн үрийг өөртөө авдаг

А: Их Багш нар авшиг өгөхгүй байх шалтгаан нь тэр хувь хүний үйлийн үрийн хэсгээс өөртөө авдаг учраас тэр үү?

Б: Тийм.

А: Тэр Их Багш хараагүй хүнд авшиг өгөөгүй шалтгаан нь хараагүй болох нь хүний хамгийн хүнд муу үйлийн үр гэж өөрөө ярьсан учраас тэр байх гэж би бодсон, тийм үү?

Б: Өө! Энэнээс ч долоон дор үйлийн үр байдаг!

А: Үүнээс долоон дор уу? Ямар?

Б: Бие эрхтний хувьд хараагүй байх нь сүнслэг талдаа хараагүй байхаас хавьгүй дээр. Их Багшийг хардаггүй ч аугаа чанараа нь ухааран мэдсэн хүн Их Багшийг нүдээрээ хардаг мөртлөө ухаарч мэдээгүй хүнээс хавьгүй дээр.

А: Гэхдээ Та хараагүй хүнд авшиг хүртээх үед тэр хүний үйлийн үрээс танд халддаг уу?

Б: Надад үргэлж л халдаж байдаг.

А: Үргэлж үү?

Б: Хүмүүс ердөө гэртээ залбирч байхад л надад үйлийн үр нь халдаж байдаг. Хүмүүс миний нэрийг олж мэдэхэд л надад үйлийн үр

нь халдаж байдаг. Хүмүүс миний үүх түүхийг сонсож мэдэхэд л надад үйлийн үр нь халдаж байдаг. Надад хаа сайгүй үйлийн үр халдаж байдаг. Хүмүүстэй уулзаж харах үед ч надад үйлийн үр халдаж байдаг.

А: Тэгвэл Та энэ үйлийн үрийг хэрхэн арилгадаг вэ?

Б: Энэ чинь миний ажил. (Инээлдэв) Та өөрөө Их Багш болох хүртлээ хүлээ, тэр үед би хэлж өгөмз. Одоохондоо үүнийг ойлгоход хэцүү. Би үүнийг сүнслэг дэг журам, өөрийн асар олон тэрбум, их наяд жилийн бясалгалынхаа буян, бие махбодын гайхалтай тэсвэр хатуужил, хязгааргүй хайраараа хийдэг юм. Ойлгов уу?

А: За, Танд баярлалаа.

Б: Буддизмын дэг ёсонд ч бас хэн нэг хүний таван мэдрэхүй нь, аль нэг мэдрэхүй нь хэвийн биш байвал тэр хүнийг Бурхны шашны ёсонд хүлээн авдаггүй. Бурхан Багшийг амьд сэрүүн байх үеийн авшиг хүртээх ёсонд өөр олон нөхцөл болзол тавьдаг байжээ. Харин би хамгийн мууг нь ч аврах андгай тавьчихсан, тийм болохоор хэн ч над дээр горьдлого найдлагагүйгээр ирдэггүй юм. Гагцхүү төсөөлж л болохоор хамгийн муу хүмүүс миний шавь нарын дунд байдаг. Арван зүгийн Будда нар ч тэднийг аварч чадаагүй юм.

А: Тийм. Бурхан Будда үл өршөөгдөх таван нүглийг бидэнд айлдсан байдаг. Жишээлбэл, хэрвээ бид Буддагийн амийг хөнөөвөл.

Б: Тийм ээ, хэрвээ Буддаг хөнөөвөл, эсвэл Буддагийн цусыг асгарахад хүргэсэн бол.

А: Яг тийм, хэрвээ Гэгээнтэн хүнийг, эсвэл аав, ээжийгээ хөнөөвөл, үгүй бол Сангха нарыг хагаралдуулбал (Сангха гэдэг нь хуврагийн чуулган хэмээх санскрит үг.)

Б: Эсвэл эцэг, эхээ хөнөөвөл. Тийм ээ, бид энэ тал дээр асуудал тарьдаг.

А: Будда эдгээрийг үл өршөөгдөх гэм нүгэл гэсэн.

Б: Тийм.

А: Тэгвэл Та ийм төрлийнхнийг ч бас хүлээн авдаг уу?

Б: Тэгнэ.

А: Яагаад?

Б: Өөр хэн тэднийг хүлээж авах юм бэ?

А: Тийм шүү, хэн ч тэгэхгүй л дээ.

Б: Тийм.

А: Гэхдээ тэдний нүглийг өршөөхгүй гэж Будда хэлсэн байхад энэ хүмүүс яаж аврагдаж чадах юм бэ?

Б: Би тэднийг хувирган өөрчлөхдөө өөрт байгаа хайраа ашигладаг.

А: Тэгвэл, энэ нь Таны Христийн талаас болдог байх, яагаад гэвэл Есүс Эзэн хамгийн адгийн нүгэлтэн, гэмт хэрэгтнүүдийг ч үргэлж уучилдаг байсан. Тэгэхлээр одоо Та тэр хүмүүсийн үйлийн үрийг авах ёстой юу?

Б: Тийм. Үйлийн үрийн Хуулийг хүндэтгэх ёстой. Гэхдээ Их Багш бусдын үйлийн үрийг авч байх нь авшигтан шавь нь өөртөө үйлийн үр авахтай адил биш. Жишээлбэл, Есүсийг хяхан хавчиж, загалмайд цовдолсон тэр үед олон шавь нар болон сүслэн дагагчдынх нь гэм нүгэл өршөөгдсөн. Гэтэл та гудамжнаас нэг хүн олж аваад түүнд “Одоо таныг бусдын гэм нүглийн өмнөөс цовдолно” гэж хэлбэл хэн ч уучлан өршөөгдөхгүй. Хэн ч ямар ч үр өгөөж хүртэхгүй. Их Багшийн бие махбод хэдий бусдынхтай адил харагддаг ч тэднийхээс ялгаатай. Жишээлбэл, бүх машин ижил төстэй харагддаг ч Мерседес юмуу, Вольво машин өөр бүтэц хийцтэй, бас эдэлгээний чанараар өөр.

Тэгэхлээр одоо та нар Их Багш авшгийн үед хэдэн зуу, эсвэл хэдэн мянган хүнд авшиг хүртээх ёстой байдгийг төсөөлж чадах уу? Их Багш, тооноос нь хамаараад хүн нэг бүрд, хэдэн зуу, хэдэн мянган хүнд авшиг хүртээхийн тулд наанадаж л хангалттай хүрэлцэхүйц адислагч хүчтэй байх ёстой байдаг. Гэтэл ердөө ганц хүн өөрт ноогдох хувиа авахад тэр хүний билгийн мэлмий нээгдэж, ахуй ойлголт, од гараг, тэнгэр диваажин, там гээд юм юмыг л харчихдаг.

Тэр Хүч нь ердөө тэр ганц хувь хүний хэдэн арван мянган жилийн үйлийн үрийг бүгдийг нь цэвэрлэж чадахаар хүчирхэг байх ёстой. Ердөө ганц хүний гэм нүгэл, ганц хүний үйлийн үр нь хэрвээ хэлбэртэй байсан бол түүнийг нь бүх орчлон ч багтаах аргагүй гэж Бурхан багш айлдсан байдаг билээ.

Ганц л хувь хүний, бас дээрээс нь багадаа л гэхэд таван үеийн удам угсааных нь хамаг гэм нүгэл, үйлийн үрийг шатаахын тулд хэр их хүч орохыг та мэдэж байна уу? Хэрвээ тэгэхгүй л бол тэр хүн Аялгуу сонсож, эсвэл Гэрэл харж чадахгүй, яагаад гэвэл тэр үйлийн үрдээ дарагдаж, бас түгжигдчихсэн байдаг. Энэ бүх хүч Их Багшийн бие махбодоор дамжиж л гадагшлах ёстой байдаг юм. Тэр эмэгтэй хэдэн мянган хүнд авшиг хүртээдэг гэхээр хүч нь нэн аугаа байж таарна. Жирийн хүн энэ Хүчийг өөртөө багтаан агуулж чадахгүй. Хэдийгээр сайн хүч байсан ч таныг муужирч унахад хүргэж магадгүй. Ойлгов уу?

Гэрэл гэрэлтэхийн тулд ихээхэн цахилгаан хүчдэл агуулж байх ёстой. Энэ чийдэн өөр чийдэнтэй төстэй байж болох ч өөр бүтэцтэй. Танд ийм хурц тод гэрэл гаргаж өгөхийн тулд тэр нь ихээхэн цахилгаан эрчим хүч агуулж байх хэрэгтэй. Тэр өөрөө ийм цахилгаан хүчдэлийг тэсвэрлэх чадалтай байх ёстой. Тийм учраас Их Багшийн бие махбод эргэлзээгүй ялгаатай, гэвч Их Багш нараас өөрөөс нь асуухгүй л бол тэд энэ тухай ихэнхдээ дурсдаггүй. Ихэнх Их Багш нэн даруу бөгөөд ярихад тохиромжтой цаг нь болоогүй л бол ярих шаардлагагүй байдаг. Бас зөв сонсогчид байж байх хэрэгтэй.

## Их Багш хүн бүрт өөр өөрөөр зааж сургадаг

А: Надад бас нэгэн зүйлийг тайлбарлаж өгнө үү. Бурхан Багш сонсогчид нь хэн байхаас хамаараад дөрвөн өөр төвшинд сургаалаа айлддаг байжээ. Харин Есүс Эзэн бол үргэлжид нэг л төвшинд айлдаж байжээ. Тэр өөрт нь хэзээ ч өөр өөр төрлийн сургаал бий гэж хэлж байгаагүй.

Б: Ямар дөрвөн төвшин билээ?

А: Лам нараас суралцаж байх үед нь дөрвөн хэв маягийн хүмүүс байсан гэж тэд бидэнд хэлсэн. Нилээн их хөгжсөн нэг төрөл байна. Дараа нь хүмүүсийн оюун ухаанд тааруулан Тэр сургаалаа зааж байжээ.

Б: Тийм, гэхдээ зөвхөн дотоод талд. Авшиг ч бас ижил. Дотоодын чинь Их Багш хүн бүрд өөр өөрөөр зааж сургадаг, бүр хамгийн сайн найз чинь ч үүнийг мэдэхгүй. Тэр байтугай эхнэр, нөхөр хоёрын дотоодод өөр өөр сургаал номлол байдаг. Дөрвөн төвшин төдий биш, бүр дөрвөн мянга, дөрвөн сая төвшин гэх мэт.

А: Тэгэхлээр, Есүс ч бас тэгж байсан уу?

Б: Тийм.

## Есүс болон Бурхан багшийн түүхэн цаг үе

Б: Есүст зааж сургаад яваад байх цаг тийм их байгаагүй. Түүнийг цовдлохоос өмнө Түүнд ердөө л гурван жил хагас л байсан. Үүнээс гадна Есүс сургаал номлолоо түгээж байхад энэ нь маш хүнд бэрх байсан гэдгийг та нар ойлгох хэрэгтэй. Тухайн цаг үеийн улс төр эмзэг хөндүүр байсан нь Түүнд болон шавь нарт нь ном сургаалаа чөлөөтэй түгээхэд саад болж байжээ. Тэр цагт Сүм хийд болон Эзэн хаант засаглал нь ямарваа нэг алдар нэр олж байгаа хүнд атаархан жөтөөрхдөг байв. Бас тэр цаг үеийн хүмүүсийн оюун санааны дэс төвшин нэн доогуур байсныг та нар мэдэж байх ёстой. Бүх сүм дуган нь ердөө тахил өргөхийн тулд л үргэлж амьтан нядалдаг байжээ. Утаа нь тэнгэрт хүрч, бүх сүм хийдийн хана харлаж, тахилчдынх нь гар цусанд будагдаж байлаа. Аймшигтай муухай үнэр нь Египет болон Палестины тэнгэрт хаа сайгүй ханхалж байлаа.

А: Харин Бурхан Багшийн тухайд ямар байсан бэ? Надад ярьж өгнө үү?

Б: Бурхан багш уу, тэр их азтай. Түүний мэндэлсэн Энэтхэг бол

оюун санааны дэг ёс хэдийн баг бэх төлөвшиж, ард түмний дийлэнх нь ургамал хоолтон байж, Гэгээнтнүүдээ бишрэн сүсэглэдэг улс орон байлаа. Тэр цаг үеийн улс төрийн өрсөлдөөн тэмцэл тийм ч аюултай хурц байсангүй. Үүнээс гадна Бурхан Багш ханхүү болж мэндэлсэн шүү дээ. Түүнийг Хаант Улсаа хэрхэн зольж орхисныг бүгд мэднэ. Тиймээс түүнийг хаан болохыг завдаж, атаа тэмцэл өрнүүлнэ гэж нэг ч хаан төсөөлж чадахгүй байсан. Гэтэл Есүсийг мэндлэхэд түүнд тийм язгууртан угсаа гарал байсангүй, бас тэр үед Еврей ард түмний хаан болох хэн нэг хүн мэндлэх тухай цуу яриа тарсан байв. Бүгд л Есүсийг хувьсгал хийгээд дараа нь Еврейчүүдийн хаан болчих вий гэж эмээж байсан тул Ромын хаант улсын төр засаг ихэд бухимдаж байлаа. Тэгэхлээр та нар Есүс ч, Будда ч тэр яагаад тус тусын байдлаар ялгаатайг, бас Христийн шашин яагаад ийм нэг замаар хөгжсөн, Буддизм өөр арга замаар дэлгэрэн түгсэн шалтгааныг ойлгохын тулд тухайн түүхэн нөхцөл байдлыг нь бас харгалзах хэрэгтэй болж байгааг харж байгаа биз дээ.

Энэ нь хорвоо дэлхийн л төвшин. Гэтэл зайлшгүй харгалзан үзвэл зохих өөр бусад төвшин ч бас бий, жишээлбэл тэнгэр диваажингийн бүтэц байгуулалт, тэр цаг үеийн хүмүүсийн сүнслэг ойлголт мэдлэг байна. Ийм л юм. Харин Есүс загалмайд цовдлуулахдаа азтай байжээ; Тэр нэр төртэй үхсэн. Тэр алдар хүндийнхээ оргил үед өөд болсон. Хэрвээ Тэр арай урт насалсан бол Түүний алдар хүндэд таарахгүй асар их зовлон зүдүүрийг амсах байсан байх.

А: Судар номд заасныг л гүйцэлдүүлж байна гэж Есүс дандаа хэлдэг байсан. Түүний хэлсэн, хийсэн бүхэн, үйлдэл бүхэн нь зөвхөн Судар номлолыг л даган биелүүлсэн л хэрэг байсан.

Б: “Би хуулийг устгах гэж биш биелүүлэх гэж л ирсэн.” За тийм, Их Багш бүхэн бас л ингэдэг. Тэд дэлхийд залрах үедээ хүмүүст Судар бичгийг тодруулан тайлбарлаж л өгдөг. Тийм шүү. Үнэнхүү гэгээрсэн Их Багш байхгүй бол Судар бичигт юун тухай өгүүлээд байгааг цөөхөн хүн л ойлгоно. Буруу ташаа ойлголт элбэг байдгийг та нар ч харж л байгаа. Ихэнх Судар бичигт мах идэхийг хориглосон байдгийг та нар мэднэ, гэхдээ бүхий л сүм хийд, хамгийн дээдэхээсээ доодохоо хүртэл, хамба лам нар, сүсэгтнүүд гээд бүгд мах идэж, архи дарс уудаг. Бурхан: “Надад тахил өргөхийн төлөө энэ бүх ямаа, үнээ, бухыг алж нядал гэж хэн та нарт хэлсэн юм? Гар чинь гэмгүй амьтдын цусаар будагджээ. Та нар энэ нүгэл хилэнцээ зогсоо, эс тэгвэл залбирах үед чинь би нүүр бууруулж, чамайг сонсохгүй. Наманчил, тэгээд энэ бүхнээ зогсоо, эс бөгөөс би та нарыг уучлахгүй” гэжээ. Тэгээгүй гэж үү? Хэрвээ Бурхан, тэр байтугай Өөрт нь өргөл өргөхийн тулд алж нядлахыг хориглосон байтал бид өөрсдөө идэж, өөртөө өргөж яаж зүрхэлж байна вэ? Үгүй юү? Ингэх нь учир зүйд нийцэхгүй.

Пап ламын бүхий л мяндаг тушаалтнуудаас ганцхан энэ л асуултад, ганц өгүүлдээрээр хариулж өгөхийг гуй. Библийг бүхлээр нь хэлэлцэх ч хэрэг бидэнд алга. Амьд сэрүүн Их Багш байхгүй бол хүн бүр сүнслэг байдлын хувьд сохор байдаг. Тийм учраас бие махбодын хувьд сохор байх нь ёстой юу ч биш. Би над дээр ирж байгаа, сохор чигээрээ ирж байгаа хүмүүсийг хараатай хэр нь харж чаддаггүй сая сая хүмүүсээс харин ч илүү дээр, бүр илүү их, маш их гэгээрсэн хүн гэж үздэг. Тийм учраас Библид хэлэхдээ: “Хараад л байдаг ч ухаардаггүй, сонсоод л байдаг ч ойлгодоггүй” гэжээ.

Авшиг хүртсэний дараа авшигтан бүрд бүх зүйл улам ойлгомжтой болж ирдэг; өмнө нь бол үүнийг мэдэхгүй л байх байсан. Үүнийг “гэрэлтүүлэх” буюу “гэгээрэл” гэж нэрлэдэг. Бид гэгээрчихсэн. Бид Үнэнийг мэднэ. Яагаад гэвэл Их Багш Библи болгонд, Судар болгонд байдаг илчлэгдээгүй Үнэн дээр гэрэл тусгаснаар бидэнд дотоодынхоо “Үнэн”-ийг мэдэх боломж олгосон.

Бүр ийм энгийн тохиолдолд гэхэд л түрүүхэн миний дурдсан Библийн жирийн өгүүлдэрийг хэр олон Христийн шашинтан мэдэх вэ? Ойлгох нь байг гэхэд мэдэж байгаа нь хэд байна вэ? Тэд Библийг өдөр бүр уншдаг, сүмийн номлогч нь Библийг цээжээр мэддэг. Тэд шалгалтандаа тэнцэхийн тулд үүнийг мэдсэн байх ёстой. Үгүй гэж үү? Гэвч тэд Библигтэй зөрчилдөх зүйлийг хийгээд байх юм бол диваажингийн шалгалтанд тэнцэхгүй унана. “Ходоодонд орсон мах, мах идсэн ходоод, Бурхан хоёуланг нь устгана.” (Инээлдэв)

### Эмэгтэйчүүдийн эсрэг харалган гадуурхалт

А: Их Багш аа, Та Библи судар болон Дармапада (Dhammapada) судрын тухайд юу хэлэхсэн бол? Аль алинд нь эмэгтэй хүний тухай өгүүлдэг. Та бид хоёр адилхан л эмэгтэй хүн, тиймээс энэ тун чухал сэдэв. Дармапада сударт Бурхан багш эмэгтэй хүнийг бүлгэмдээ оруулахыг хүсээгүй гэж дурджээ.

Б: Би Түүнийг буруушаахгүй. Эмэгтэй хүн аюултай. Хурсан олон хувраг нь бие махбодын хувьд сайхан, тэнхлүүн бие бялдартай, бэлгийн дур хүсэлтэй гоонь эрс гэдгийг та төсөөлж чадах уу. Тэгтэл гэнэт хэдэн бүсгүй ороод ирж. Та нар юу гэж бодож байна? Ганцаараа байх гэж ч ядаж байхад нь бас уруу татах зүйл нэмэгдчихлээ. Та юу гэж бодож байна? Улам л хэцүү болно. Гэсэн ч Бурхан Багш юутай ч гэсэн Энэтхэг улсын тухайн цаг үеийн нийгмийн зан заншлыг, бас хуврагуудын бэрхшээлийг харгалзан үзсэн; учир нь тэд байнга хүнд бэрх, хахир хатуу нөхцөл байдалд нүүж суух хэрэгтэй болж байжээ. Эмэгтэй хүн үүнийг тэсвэрлэхгүй байж мэднэ. Эмэгтэй хүн байтугай



бүр зарим эрчүүд ч тэсээгүй билээ.

Зарим хувраг намайг дагаж эхлэхдээ “Их Багшийг гүйцэж амжихгүй нь ээ! Дэндүү шаламгай. Бидэнд ахдаж байна!” гэдэг байсан. Тэд бүгд гомдоллодог ч тэгсхийгээд бүгд үүнд дасдаг. Заримдаа ч тун бэрх л дээ.

Намайг Филиппин улсад байхад надтай хамт хэдэн лам, бас хэдэн эгэл хүн байв. Тэдний дунд дөнгөж ирээд байсан шинэхэн бясалгагч эхнэр, нөхөр хоёр байсан. Эр нь өдөржин унтаад л, эмэгтэй нь арай чүү л гүйцэж байлаа. Тэр бүлэгт бас нэгэн авшигтан биш эр байв. Улс төрийн ажилттай хүн. Би тэр үед Ау Лакийн цагаачдын асуудлаар ажиллах хэрэгтэй болсон байлаа, тиймээс зарим нэг авшигтан биш улс төрчидтэй хамтран ажиллах хэрэгтэй болж байв. Тэр улс төрч миний хөдлөх байдлыг хараад айн сүрдсэн. (Түүний амьсгаа давчдан аахилсныг Их Багш аахилж харуулав) Тэр ингэж аахилж уухилж байсан.

Нэг өдөр би түүнээс өнөөх эмэгтэйн тухай сураглав. Би “Ийм нэг эмэгтэй хаана байна? Миний шавь эмэгтэй хаана байна?” гэлээ.

Тэр эр “Үхсэн!” гэв. (Инээлдэв.) “Тэр эмэгтэй үхлүүт байна.”

Би “Юу? Би явлаа шүү дээ, тэр намайг үдэж өгөхөөр нисэх буудал дээр ирэхгүй юм байх даа. Ямар гээч шавь вэ? Тэр юу хийгээд байгаа юм? Хийж гавих ажил байхгүй дээ.

Тэр эр өрөвдөлтэй гэгч санаа алдан, “Ээ Их Багш минь, тэр чинь жирийн л нэг эмэгтэй хүн шүү дээ” гэсэн. (Инээлдэв.)

Би “Жирийн л эмэгтэй гэдэг чинь юу гэж байгаа юм? Би ямар нь юм?” гэв. Би үнэндээ төвөг удах гээгүй юм; би зүгээр л бүр гайхаж орхисон. Би явахдаа тэр эмэгтэйдээ надад нэг зүйл хийж өгөөч гэж гуйх санаатай байсан юм л даа, гэтэл тэр хүрч ирээгүй тул сүйд майд болсон хэрэг.

Харин тэр эрэгтэй “Өө! Юмыг тань шиг хийж чадах хэн байх вэ дээ!” гэсэн. Шулуухан ингээд хэлчихдэг байгаа. (Инээлдэв) “Та эмэгтэй хүн биш ээ биш. Та энэ дэлхийнх биш. Таныг хэн ч гүйцэж чадахгүй” гэж яг өөдөөс минь харж байгаад шуудхан хэлсэн. Тэр “Эмэгтэй байтугай эрэгтэй хүн ч таны хурдыг гүйцэхгүй” гэсэн. Би тун их цочирдоод үүнийг бодож тунгаахад хүрэв. Бодож тунгаах хэрэгтэй учраас хариу хэлж чадаагүй. Энэ үнэн гэж үү гэж би тэр цагаас хойш бодсоор л байдаг.

А: Би нэгэн удаа Хималайн ууланд Жиотирмагад байж байлаа. Шанкарачарья тэнд байв. Тэр эрхэм бол Хиндүчүүдийн “Пап – Хамба лам” нь юм. Тэнд эмэгтэй хүн эмэгтэй бие янзаараа байхыг зөвшөөрдөггүйг та мэднэ. Би санньяси (хуврагийн) хувцастай, халзан байсан тул тэд намайг эрэгтэй хүн гээд бодчихож.

Б: Тэгэхлээр, тэд танд зөвшөөрчээ.

Ш: Тэд надад зөвшөөрсөн. Би харин тэдэнд юу ч хэлээгүй. Би тэдэнтэй зүгээр л тоглоом тоглож байлаа. Би бусад хуврагтай хамт амьдарсан. Үдийн хоолоо ч хамт иддэг. Би эрэгтэй хүн шиг дуу хоолойтой, бас тэдний нурууг алгадаж, яг л эрэгтэй хүн шиг аяглаж, тэдэнд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн. Би шүршүүрт орохдоо хаалгаа хөлөөрөө ингээд тээглэхидэг тул бусад гэлэн хаалга нээж ороод намайг гэлэн биш, харин гэлэнмаа гэдгийг мэдэж чадаагүй.

Нэгэн удаа оройн зургаан цаг болж байв. Бид Шанкарачарьягийн ном айлдахыг сонсоод хэдэн цаг суучихсан байж байлаа. Надад тэр тун их гэгээрсэн хүн шиг санагдсан. Тэр үед түүнийг их гэгээрсэн хүн гэдгийг нь би аяндаа л мэдэрсэн. Хиндү нарын тэргүүн “Пап-Хамба лам” нь шүү дээ. Гэтэл доод давхраас нэгэн эмэгтэйн дуу гарахыг сонслоо. Тэр үед бид бүгд Жиотирмат дахь мөргөлд сууж байсан бөгөөд тэнд хэдэн мянган мөргөлчин ирсэн байсан. Тэр гэлэнмаа Сарасвати Мат-ынх байв, энэ нь Шанкарачарьягийнх шиг ижилхэн Мат (бүлгэм) юм. Тэнд нилээн хэдэн эрэгтэй хүн байсан, харин тэр л ганцаараа эмэгтэй байв. Тэд түүн лүү довтолсон учраас эмэгтэй тэдэнд хариу өгч байв. Тэр мөргөлийн үед хөл нүцгэн алхаад байсан учраас тавхайнаас нь цус шүүрч байлаа. Хүмүүс түүнийг тэр газраас хөөж гаргах гээд байсан учраас эмэгтэй хариу өгч байсан аж. Тэд тэр эмэгтэйд маш харгис хандаж байсан.

Б: Маш буруу. Би мэднэ мэднэ. Тэд эмэгтэй хүнийг үнэхээр үзэн яддаг. Тэд эмэгтэй хүнийг аюултай гэж боддог, гэхдээ шалтгааныг нь мэддэггүй. Тэд учир зүйг дагадаггүй. Зүгээр л мухар сохроор дүрэм журмыг дагаж, тэнд очсон ямар ч эмэгтэйд жанчиж, хөөдөг. Тэд танд юу тохиолдохыг тоох ч үгүй, дүрэм журмаа л дагах ёстой байдаг. Ийм л юм. Тэд юу ч бодохгүйгээр, ойлгохгүйгээр сахилаа л мухар сохроор дагадаг.

А: Шанкарачарьягийн сургаалыг дагадаггүй, ямар ч ойлголт мэдлэггүй. Шанкарачарья эхлээд “Бид бүгд нэгэн цогц” гэж хэлсэн.

Б: Тэд тэнд эмэгтэй хүн ердөө байж байгаараа л өөрсдийг нь буртаглана, урсгалыг нь бохирлоно гэж боддог. Тэд эмэгтэй хүнийг эрэгтэй хүнээс доогуур гэж үздэг.

А: Тэд тэр эмэгтэйд чөтгөр шулам гэж бодсон. Тэд бүр ийм дээрээ тулчихсан.

М: Тийм.

А: Тийм учраас тэд түүнийг аяндаа л ингэж, басамжилж, ямар ч нигүүлсэлгүй харилцаж байсан, учир нь тэгэхэд аль хэдийн орой болчихсон, цастай, тун хүйтэн байсан. Гэлэнмаа цус алдаад бүр туйлдчихсан учраас алхаж ч чадахгүй болсон.

М: Ёстой хэнээтэй юм.

Ш: Хэнээтэй байгаа биз. Сарасвати Мат-ын бас нэгэн гэлэн түүнтэй хамт байсан ч юм хэлээгүй. Тэгээд тэр эмэгтэй хорин эр

хүний өөдөөс тулаад зогсож байсан. Би хуврагийн орон дээр тухлан шөнийг өнгөрөөж чадаагүй, бас ярьж тохирсон ёсоор өглөөний 9 цагт Шанкарачарьятай уулзах байсан. Би тэгж чадаагүй. Би бас эмэгтэй биетэй учраас түүнийг хамгаалах л хэрэгтэй болсон. Би гарч очсон юм.

Б: Та тэгэх гэж л тэнд байсан юм байна.

А: Ердөө үүний тулд.

Б: Тэдэнд сургамж өгөхийн төлөө.

А: Тэдэнд сургамж өгөхийн төлөө. Би бас тэд бүгд намайг эрэгтэй биетэй хувраг гэж бодож байгааг мэдэж байсан.

Б: Таныг тэнд байлгах зохицуулалт хийгдсэн байж.

А: Бурхны л таалал байсан байна, ойлгож байна уу.

Б: Түүнээс биш хэн ч таныг гэлэн гэж бодохуйц харалган байхгүй л дээ. Сармагчин л тэгж магадгүй.

А: Сармагчин л тэгнэ, гэтэл гэлэн! Тэд цөмөөрөө намайг гэлэн гэж бодсон, бүгдээрээ шүү. Бүгд намайг гэлэн, эрэгтэй гэж л итгэсэн. Намайг эмэгтэй хүн гэж ёстой төсөөлөөгүй. Юу гэхээр, би тэднийг хуурах гэсэн юм биш. Би зүгээр л тэдний надад өмсөгсөн зүйлсээр тоглож, тэгээд үүнийгээ үргэлжлүүлээд л байсан.

Тиймээс тэр эмэгтэй тусламж гуйн орилох үед би түүнийг хамгаалахаар очсон юм. Би тэр бүх гэлэнд эмэгтэй биеэс төрснийг нь сануулж хэлсэн. “Та нар эмэгтэй хүнээс төрсөн” гэж. Би бас үүнийг үнэхээр ойлгож бараагүй. Учир нь Хинду шашинд Эх хүнийг үнэхээр хүндлэн дээдэлдэг. Тэдний хувьд Тэнгэрлэг Эх нэн эрхэм байдаг.

Б: Тийм шүү, Тийм.

А: Гэтэл тэд түүнд ядаж л хамгаалалттай газарт ариун цэврийн өрөөнд ойр байрлах зай гаргаж өгөөгүй. Бид өндөр толгод дээр байсан. Тиймээс тэр эмэгтэй тавхайнаасаа цус шүүрүүлсээр тэр толгодоос, энэ бүх замын турш хагас үхлүүт байдал алхаж буух ёстой болжээ.

Б: Тэгсэн атлаа тэд Тэнгэр Эхийг шүтдэг.

А: Тэгдэг. Тэнгэр Эхийг шүтдэг. Гэвч тэд хөөрхий гэлэнмаагаас түүнийгээ олж хараагүй. Ингээд би тэр гэлэнмаад аяндаа л санаа тавьж, түүнийг хооллож, унтах газар хайх хэрэгтэй болсон. Тиймээс би эрэгтэй биегүй, харин эмэгтэй биетэй гэдэг үнэнээ тэдэнд хэлсэн.

Б: Сахил санваар бол бясалгагчийг хамгаалахын төлөө юм. Бид уян хатан бусаар үүндээ хүлэгдэж, улмаар бусдад гэм хор тарих ёсгүй. Тэгэхлээр та одоо сахилаа ядаж л мөрдсөн байна шүү дээ.

А: Үнэнийг хэлэхэд тийм. Тэгээд би тэр хөөрхий гэлэнмааг, бас Сарасвати Матын нэг гэлэнг өөр дээрээ байлгасан. Тэгтэл бусад эрчүүд “айдаст автсан” бөгөөд би Шанкарачарьятай уулзахгүй гэдгээ ч тэдэнд хэлсэн.

Б: Айж сүрджээ.

А: Тийм, айсан. Хэрвээ Шанкарачарья биднийг нэгэн цогц гэж

сургасан л юм бол бид үүнийг үйлдлээрээ харуулах хэрэгтэй гэж би тэдэнд хэлсэн. Ингээд өөр нэг гэлэн бид хоёр тэр өрөвдөлтэй гэлэнмааг өөр дээрээ авсан. Хэдэн мянган мөргөлчин тэр газрыг дүүргээд зайгүй болчихсон байсан юм. Бид энэ Хинду гэлэнмаад хаана байрлах газар гаргаж өгсөн гээч? Сикхүүдтэй хамт.

Б: Юу? Өө! За за, тийм.

А: Сикхүүд. Хинду болон Сикх нар хоорондоо дайтаж алалцаж байсан хүмүүс гэдгийг та бүхэн мэднэ.

Б: Сикхүүд очих газаргүй тэднийг хүлээн авчээ.

А: Зөвхөн Сикхүүд л Хинду гэлэнмааг тосож хаалгаа нээсэн юм. Ингэж л би шашны учир утгагүйг ойлгосон доо.

Б: Тийм ээ, зөвхөн хайр л чухал; шашин биш. Сикхүүд бол сайхан хүмүүс.

А: Тэд үзэсгэлэнтэй. Би тэдэнтэй цагийг өнгөрүүлж, Сикх Гэгээнтнүүдээс суралцсан.

Б: Тийм, миний л үзэж харснаар бол Хинду нар бас л сайн бие хүмүүс, гэсэн ч таны харсан шиг хэнээрхэл мэр сэр бий.

### **Бурханы Хаант Улсад эрэгтэй, эмэгтэй гэж байдаггүй**

А: Гэсэн ч эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд ялгаа гаргадаггүй өөр бусад Гэгээнтэн, Хинду гэгээнтнүүд ч байдаг. Гэхдээ эмэгтэй Гэгээнтэн олдох хэцүүг та мэднэ. Та бол миний амьдралдаа учирсан хоёр дахь хүн, учир нь өөр тийм хүмүүс алга. Гэгээнтнүүд үргэлж л эрэгтэй биеийг авдаг.

Б: Тэд чинь бяраа чадалтай тул бүх газрыг дүүргэчихдэг. Эмэгтэйчүүд тэдэнтэй үзэлцэж чадахгүй учраас буугаад өгчихдөг. Үүнээс гадна, эмэгтэйчүүдэд тийм том би гэх үзэл байдаггүй. Хэрвээ хэн нэг хүн тэмцэлдэж өрсөлдөж байвал эмэгтэй хүн “за яахав, сууж л байя” гэдэг. Эмэгтэйчүүд гэр бүлдээ хоёрт тавигдаад сурчихсан шигээ Гэгээнтнүүдийн Хаант улсад ч бас тэгдэг. Эрчүүд голдуу л маш түрэмгий, би гэх үзэлтэй, том би-үзэлтэй байдаг. Бүх суудлыг, тэр байтугай Гэгээнтнүүдийн суудлыг тэд эзэлчихсэн байгаа нь гайхах зүйл биш. Ийм л юм болдог.

Эмэгтэйчүүд бүгд хүн төрөлхтөнд аугаа ихээр үйлчлиж ирсэн. Эмэгтэй хүнгүйгээр эрэгтэй хүн төрөхгүй. Төрсөн хойноо тэд эмэгтэйчүүдэд халдаж, бас эмэгтэй хүн тэднийг өсгөн бойжуулж, хооллон ундааж, гэжээн тэтгэж, сургаж боловсруулсны хариуд дорд үзсээр байдаг. Ямартаа ч гэсэн энэ бол би гэх үзлийн тулаан юм. Бурхны Хаант Улсад эрэгтэй ч, эмэгтэй ч гэх юм байхгүй. За юу. Би өөрийгөө

эмэгтэй хүн гэж мэдэрсээр санагдсан үедээ эмэгтэй хүн шиг, эрэгтэй хүн шиг мэдрэхийг хүсвэл өөрийгөө эрэгтэй хүн шиг л санадаг.

А: Үнэн. Би ч бас тэгдэг.

Б: Нөхцөл байдалтайгаа уялдуулдаг.

А: Тийм.

Б: Тухайн агшны хэрэгцээ шаардлага гэж нэг юм бий. Бусад үед нь би эрэгтэй ч биш, эмэгтэй ч биш. Би хэрвээ эрэгтэй байсан бол Будда болж чадахгүй байх байсан. Хэрвээ би эмэгтэй бол бас л Будда болж чадахгүй байх байсан, яагаад гэвэл та өөрийгөө хайрцаглагчигвал Будда байж чадахгүй. Та уян хатан байх ёстой.

А: Гэхдээ маш олон Будда байсаар ирсэн нь бүгд эрэгтэй хүн гэж тэд хэлсэн байдгийг Та мэднэ дээ. Нэг ч эмэгтэй байгаагүй. Бүгд эрэгтэй Буддагийн нэр л байдаг.

Б: Та Бадамлянхуа судрыг уншсан уу? Буддизмын Бадамлянхуа Судар? Будда амьд байхад Манзушир нэртэй Бодьсадва байжээ. Бодьсадва нар цуглаад Манзушир Бодьсадвагаас: “За та хаа сайгүй явж ном айлдлаа. Таны сургаалыг сонсоод Будда болсон хүн ер нь байна уу?” гэж асуужээ.

Манзушир Бодьсадва: “Тийм, тийм, нэг бяцхан эм луу байсан л даа. Тэр л Будда болсон. Тэр дөнгөж л найман нас хүрч байсан” гэжээ. Энэ нь эрчүүдийн хувьд бол хараал юм. Ямар ч эрэгтэй хүн ийм бага залуудаа Будда болж байгаагүй, үүнд Шагжамуни Будда ч бас хамаарна.

Тэд гучаас дээш настай, эрэгтэй биетэй, хүний биетэй байх хэрэгтэй байдаг. Тэр найман настай бяцхан эм луу Будда болжээ. Тэд заримдаа наргиан болгож ярьдаг юм. Бяцхан эм луу Будда болж болдог юм бол би яагаад чадахгүй гэж? Би яагаад Будда болж чадахгүй юм? гээд л. Тийм. Тэр дөнгөж найман настай юм бол түүнд бясалгах хугацаа хэр их гарсан байх вэ? Хамгийн ихдээ л найман жил. Тэгсэн ч тэр Будда болж чадсан байна. Би гуч гарсан, дөчтэй. Би яагаад Будда болж чадахгүй гэж? Авцалдахгүй байна! Тэд ингээд л өөртэйгөө тэмцэлдээд байгааг харж байгаа биз дээ.

### Өөр өөр шавь нарт зориулсан өөр өөр сургаал

Б: Би Судруудыг нэг их ойшоодоггүй. Учир нь Бурхан Багш нэг мөчид, нэг удаад өөр өөр шавь нарт хандан ярьсан байдаг. Өөр нэг удаа бас л өөр бүлэг шавь нарт хандан ярьсан байдаг. Тэр маш олон зүйл ярьсан. Тэр байтугай Судрын зарим хэсгийг нь бүр энэ Дэлхий дээр ч айлдаагүй, тиймээс дэс төвшин нь ялгаатай. Жишээлбэл, “Буддын Газар дэлхийн хаалга, Бодьсадвагийн Газар дэлхийн хаалга” (Earthdoor

Buddha, the Earthdoor Bodhisattva) судрыг диваажинд айлдсан. Судрыг нээмэгц л Будда ийм тийм диваажинд залрав, бүх Бодьсадва нар тэнд хамт цуглав гэсэн тайлбар тэр даруй харагдана. Бас шавь нар, ахисан төвшний шавь нар тэнд залран бүх зүйлийг сонсож, тэмдэглэж авсан бөгөөд эргэж ирээд дахиад бичиж буулгажээ. Тиймээс тэдгээрийн ялгааг бид хэрхэн тайлбарлаж чадах билээ. Эсвэл заримдаа Судрууд хоорондоо утга авцалдахгүй зөрдөг. Үүний учир гэвэл Бурхан багш дэлхийн хүмүүст өөр байдлаар, диваажингийн хүмүүст бас нэг өөр байдлаар, Бодьсадва нарт бас өөрөөр ном номложээ. Энэ Дэлхий дээр айлтгаагүй олон Судар байдаг, тухайлбал “Flower Gannon Scripture” нь энэ Дэлхийн тухай биш юм.

А: Билгүүний Зүрхэн судар (The Heart Sutra.)

Б: За, энэ бол арай өөр нэг зүйл. Зүрхэн Судрыг Бурхан багш зөвхөн ганцхан шавьдаа, Шарипутра-д л айлдсан байдаг.

А: Өө, Шарипутра! Тэр л Бурхан багшийн хэлж буйг ойлгож чаддаг байсан учраас уу?

Б: За тийм ээ. Тэгэхээр бусад нь зүгээр л олж аваад ухаарч мэдсэн юмгүй өдөр бүр давтан уншдаг байсан. Хүмүүс Шарипутрагийн төвшинд хүрээгүй байжээ.

А: Би ч бас Зүрхэн судрыг судалж эхлэх үедээ түүнийг ер ойлгоогүй.

Б: Өө, амархан шүү дээ.

А: Хэцүү, хэцүү юм байна лээ.

Б: Одоо амархан болсон.

А: Тийм, Тийм, Тийм.

Б: Та ахиад уншаарай.

А: За, би хичээе ээ.

Б: Би Зүрхэн судрыг, ялангуяа Арьяабал Бодьсадвагийн тухай бүлгийг дандаа дурддаг юм.

А: Бидэнд ярьж өгөөч.

Б: Та Хятад хэлээр ойлгодог бол ойлгомжтой байх сан, танд илүү тодорхой ойлгогдох байсан. Би нэг юмыг давтаж хэлээд баймааргүй байна. Өөр хэлээр байна л даа.

А: За, та бидэнд ярьж өгнө үү.

Б: Үгүй ээ, яг одоо нэг л яримаргүй байна. Цагаа зөв олох ёстой юм. Хятад хэлээр бичигдсэн хуурцаг бий, ялангуяа даяан хийж байгаа энэ үеэр байгаа. Та Испани хэлээр тайлбарлаж өгөхийг хэн нэгнээс гуй л даа? Даяаны бичлэг, эсвэл хуурцаг бэлэн болж гарахаар та тэр хэсгийг нь тэдэнд тайлбарлаж өгөөрэй. (Их Багш нэгэн бясалгагчдаа заавар өгөв.)

За, та ойлгохгүй байгаа зүйлээ надаас асууж болно. Юу ойлгохгүй байгаагаа надаас асууж болно.

А: Жишээлбэл, Бурхан байдаг эсэхийг нэгэн удаа Бурханд итгэдэг нэгэн эр, мөн Бурханд итгэдэггүй өөр нэгэн эр Бурхан багшаас асуужээ, гэтэл тэнд нэгэн Бодьсадва бас хариултыг сонсох гээд сууж байлаа. Ингээд Бурхан багш...

Б: Гурван өөр хариулт хэлсэн.

А: Гурван өөр хариулт.

Б: Энэ зөв үү?

А: Яг зөв! Тэгэхлээр Бурхан багш толь шиг аяглажээ дээ, ер нь бол хэзээ ч хариулт өгөөгүй. Тайлбарлаж өгнө үү!

Б: Та аль хариултыг нь ойлгоогүй юм, хэл дээ. Асуу, би хариулъя.

А: Юу л даа, итгэдэг гээд байгаа эхний эрд Тэрээр итгэдэг зүйлийг нь л хариулт болгож хэлжээ. Тэр “Тийм ээ, Бурхан байдаг” гэжээ. Итгэдэггүй гээд байгаа эрд Тэр “Бурхан байдаггүй” гэж хариулжээ. Ингэхлээр Тэр эхний хариултаа үгүйсгэсэн. Бодьсадвад мэдээжээр, ерөөсөө огт юм хэлээгүй.

Б: Мөн ч нигүүлсэнгүй юм. Тэр түүнийг занчих ёстой байсан юм. Бодьсадвагийн зам мөрд аль хэдийн багтаж орчихоод байж ийм тэнэг юм асууж байх юм гээд бод доо. Бурханд итгэдэг эрийн тухайд гэвэл тэр тун баг бөх итгэл сүсэгтэй аж. Бурхан хэмээгдээд байгаа энэ зүйл нь түүний амьдралыг амар жимэр, сахилга багтай, эмх цэгцтэй болгожээ. Тийм учраас Бурхан багш түүнд Бурхны дүр төрхийг шинээр бүтээх цаг алга байхад нь түүний энэ төлөв байдлыг эвдэхийг хүссэнгүй. Жишээлбэл, би ч бас Бурхны тухай дандаа дурддаг. Хэрвээ хүмүүс Бурханд итгэдэг бол амьдралаа цэвэр ариун, дэг журамтай авч явдаг, бас Бурхныг бясалгадаг, тийм байхад нь би Бурхан байхгүй гэж ярьж яах юм? Ингэх нь тэдэнд тус болохгүй. Энэ нь тэднийг будилуулж, өдгөөг хүртэл нандигнаж, бүтээж босгосон бүх зүйлийг нь нураана; тэд үүн дээр л амьдралаа бүтээж босгодог юм шүү дээ. За юу.

Бурханд итгэдэггүй гэж хэлсэн тэр эрийн хувьд магадгүй тэр хүн гэгээрсэн байсан байх. Бидний Бурхан гэж төсөөлдөг шиг тийм Бурхан байдаггүй гэдгийг тэр мэддэг аж, ойлгож байна уу. Гэхдээ бид Бурхан бол Хүч чадал, Хайр, Билиг ухааны хүч юм гэдгийг мэдэхийн тулд гэгээрсэн байх хэрэгтэй. Энэ нь ихэнх хүний итгэдэг Бурхан хэмээгч нь биш юм. Хүмүүн төрөлтний төсөөлдөг маягийн тийм Бурхан байдаггүй. Тэр ийм л санаагаар хэлжээ.

Хоёрдох эр нь ийм Бурхан байхгүй гэсэн санааг өгүүлж л дээ. Гэсэн ч Бурхан Багш мэдээж түүний хэлсэн санааг ойлгосон, бас дэс төвшнийг нь ч ойлгосон хэрэг. Тиймээс Тэр үүнийг нь баталж “Тийм ээ, Бурхан байхгүй” хэмээн өгүүлсэн байна. Энэ хүн Бурхан ямар болохыг аль хэдийн ухаарсан аж. Энэ бол бие хүн, ямар нэг хүн, эсвэл таны хүсэлтээр танд ийм тийм юм хийж өгдөг гэх мэтээр танд төсөөлөгддөг хэн нэг хүн биш. Тэгэхээр Будда үүнийг нь л баталж хэлж л дээ. Тэр “За,

та сайн байна. Энэ сайн” гэжээ. Энэ нь Бурхан багш бурхангүй үзэлтэн гэсэн үг биш. Харин Тэрээр ердөө л Бурхан гэж юу вэ гэдгийг жинхэнэ ёсоор таньсан хэрэг юм. Зүгээр л ямар нэг хэм хэмжээг бус, жинхэнэ Бурхныг; “Бурхан” гэж хэлэх шаардлагагүй Бурхныг - Билиг ухаан, Хайрлагч, хамгийг нигүүлсэгч Хүчийг таньсан гэсэн үг.

А: Хэн нэг хүн, тусдаа ганц хүн биш, орчлон дахины юу?

Б: Тийм, ихэнх хүний боддог шиг Бурхныг биш.

А: Би үүнд итгэж байна.

Б: Харин гуравдах хүн буюу Бодьсадва, мэдээж тэр өөрийгөө Бодьсадва гэж нэрлэдэг юм бол ийм тэнэг асуулт тавих ёсгүй байсан юм!

А: Тэр Бодьсадва тэгж асуусан гэдэгт би итгэхгүй байна. Тэр зүгээр л Буддагийн дэргэд сууж байсан, тиймээс Будда инээмсэглэсэн.

Б: Тийм, Тийм, Тийм. Гурван удаа.

А: Тийм байна. За. Тэр асуух ёсгүй байжээ, тийм ээ?

Б: За, тэр Бодьсадва асуугаагүй биш: “Та яагаад эхний хүнд Тийм гэж хариулсан атлаа хоёрдох хүнд Үгүй гэж хариулав?” гэж асуужээ. Мэдээжээр тэнэг асуулт. Нэгдүгээрт, энэ түүнд ямар ч хамаагүй байсан. Бурхан багш тийм гэнэ үү, үгүй гэнэ үү, энэ түүний хэрэг биш. Тэр үүнийг ойлгох ёстой байсан юм. Өөр асуух зүйл байна уу?

### Их Багшийн бие золиослогдохын тулд байдаг

А: Тийм. Тэгвэл Есүсийг авч үзье. Есүс Еврейн эртний Судруудыг нэвтэрхий мэддэг, бас Өөрөө Бурхны Элчийн (Messiah) тэрхүү илгээлтийн хэсэг болсон гэж бид үздэг.

Б: За алив, асууж дуусав уу?

А: Тэгээд би өөрөө Есүс лүү харах үедээ асуулт тавьдаг. Есүс Эзэн тийм байдлаар амь үрэгдэхээ мэдэж байсан, учир нь Тэр нэгэнтээ Бурхан дээр очиж, Эзэн минь ээ, Та надаас энэ аягыг зайлуулж болохсон болов уу? гэж асуусан. Тэр тийм байдлаар үхэхийг хүсээгүй.

Б: Энэ гашуун аягыг Та надаас зайлуулж өгөөч? гэсэн утгатай – Тэр түүнийг уухыг хүсээгүй. Ай хөөрхий, энэ чинь аль ч Их Багшид байдаг хүмүүн шинж нь шүү дээ. Намайг цовдлох гэж байвал би бас л ингэж асууна. Бурхан надаас миний дургүй зүйлийг хий гэж шаардвал би мөн л ингэж асууна. Би эцсийн бүлэгт тэгэх л болно.

Их Багш супер-хүний төвшний олон зүйлийг хийдэг, нөхцөл байдал бүрийг гэсвэрлэж туулдаг, хязгааргүй тэвчээр болон хайр агуулдаг. Гэхдээ энэ нь Их Багш юм болгоныг тохиролцож байж хийх дуртай гэсэн үг биш. Тэд ч бас айж эмээдэг. Тэдэнд ингэх нь бас

таалагддаггүй, гэсэн ч тэд үүнийг хийх ёстой болдог. Хэрвээ тэд юм болгоныг хийх дуртай байх юм бол золиос гаргахын үнэ цэнэ гэж юу байх юм? Ойлгов уу?

А: Тийм ээ, би ойлгож байна.

Б: Жишээ нь, та нар мөнгөнд их дуртай. Та нар үүнд санаа тавьж, их мөнгө олдог. Яагаад гэвэл та мөнгөний төлөө шаргуу ажилладаг. Гэвч шаардлага гарвал та мөнгөө хэн нэгэнд өгдөг. Та мөнгөнд дургүй болчихсондоо тэгж байгаа юм биш. Мөнгөнд дургүй бол та тэгтлээ шаргуу ажиллана гэж үү? Харин бусад хүмүүсийн төлөө та мөнгө олох хэрэгтэй болдог. Тиймээс таны бусдад зориулсан мөнгө бүр ч үнэ цэнтэй, яагаад гэвэл тэгэх нь та нарт таалагддаг. Хэрвээ та өөрт таалагдаагүй, эсвэл салахын түүс болсон зүйлээ хүнд тарааж өгч байгаа бол энэ тухай ярих нь утга учиртай байх уу?

А: Гэхдээ Бурхан яагаад Есүсийг тийм байдлаар үхүүлэхийг хүссэн бэ?

М: Тэгэхгүй бол Түүний шавь нарын нүгэл хилэнц цэвэрлэгдэхгүй байсан. Их Багшийн махбод хоёр шалтгаанаар оршдог. Нэгдүгээрт, физик дэлхий дэх авшигтан шавь нар нь харах боломжтой байхын тулд; тэд Их Багшийн астрал биеийг харж чадахгүй. Хоёрдугаарт, Их Багшийн махбод нь золиослолд зориулагдах учиртай байдаг. Шавийнхаа салж ангижрах ёстой бүх зүйлийг хүлээн авах, шавь нарынхаа гэм нүглийг үүрэх, дараа нь цэвэрлэх ёстой байдаг юм.

Жишээлбэл, хог цэвэрлэдэг хүн эхлээд хог түүж цуглуулаад биеэрээ үүрч өргөх ёстой. Тийм биш үү? Тэд хогийн хувингаа гараараа зөөж машинд ачих хэрэгтэй болдог. Тэгсний дараа л хогийг хог хаягдлын талбай, эсвэл далай тэнгис рүү аваачиж асгадаг. Харин тэгэх зуур бие нь бохирдож, хог үнэртэж л таарна даа. Хог тэдэнтэй хамт үлдэхгүй, үнэр танар нь ч үүрд байгаад байхгүй, гэхдээ гэртээ харьж угаатлаа, угаах цаг гарах хүртэл тэд хүлээх болно. Наанадаж л хог цуглуулж байхдаа тэд таван минут, эсвэл таван хором ч бай хогтой хугталдсаар байдаг. Ойлгов уу?

А: Бурхан Багшид бас л шавь нар байсан, гэхдээ ийм байдлаар үхэх шаардлага Түүнд байгаагүй.

Б: Хэд хэдэн шалтгаан бий. Эхнийх нь, Бурхан багш Энэтхэгт байсан. Энэтхэг бол дээдийн номын орон. Ард түмэн нь хэдэн мянган жил ургамал хоолтон байж, Судар уншиж, Гэгээнтнүүдэд бишрэн мөргөж, бясалгасаар ирсэн байдаг. Тэд цэвэр ариун зүрх сэтгэлтэй. Хоёрт гэвэл, Бурхан багш бас л зовлон зүдгүүр амссан, гэхдээ өөр байдлаар буюу оюун сэтгэлгээгээрээ. Нэгэнтээ Түүний тэвчээр барагдаж, шавь нараа орхин ганцаараа ширэнгэн ой руу явж ороод гурван сар болсон. Мэдээжээр, Их Багш сэтгэл дотроо туулдаг зовлонгоо барагтай л дурсдаггүй, гэвч тийм зовлон байдаг. Аль ч Их Багш үүнийг

тойрч гардаггүй. Бас заримдаа тэр дотоодын зовлон нь өгүүлшгүй их байдаг. Тэр нь шалтгаангүй өвчин гэх мэт зүйл, эсвэл гадна талаас ирэх халдлага довтолгоо, муушаал шүүмжлэл байдлаар бие махбод дээр нь буудаг. Дотор талын зовлон гадна харагдах зовлонгоос ч дор шүү дээ. Заримдаа тамаас ч долоон дор байдаг.

Заримдаа, Их Багш бүр шавь нарынхаа дунд инээж, хошигнож, бүжиглэж, эсвэл хооллож байвч дотор талд нь юу болж буйг хэн ч гадарлахгүй. Их Багш ихэнхдээ хаалттай хаалганы цаана зовдог.

Та Мял богдыг санаж байна уу?

А: Өө, тэгэлгүй яахав, би мэднэ.

Б: Түүнд тийм ч олон шавь байгаагүй. Тэр тухайн цаг үедээ тийм ч алдартай байгаагүй, бас Хималайн ууланд агуйд нуугдаж байсан. Түүнд хотоор явж, олон түмэнд ном айлдах боломж ч гаргаагүй. Хэдхэн хүн л сураглаж явсаар түүн дээр ирсэн байдаг. Бас тэр бүү хэл, тэр цаг үед ч түүнтэй уулзахын тулд Хималайн уулыг зорих нь итгэхийн аргагүй зүйл байлаа, тиймээс ингэж чадсан хүн олон гараагүй. Хималайн уулын бүс нутаг руу нэвтрэхэд ямар бэрхийг та мэднэ биз дээ? Тиймээс түүнтэй уулзахаар очсон хүн тийм олон биш гэдгийг та ойлгох байх. Тэгсэн хэр нь л тэр хор хүртэж зовсон. Зарим хүн түүнд атаархан хор өгсөн шүү дээ. Түүний үхсэний учир нь энэ, бас тэр үүнийг мэдэж байсан ч хүлээн авсан.

Есүс өөрийгөө цовдлуулна гэдгээ мэдэж байсан ч үүнийг хүлээн зөвшөөрсөн. Сонголт байхгүй, сонголт байхгүй. Бурхан хүсэж байгаа үед танд сонголт байхгүй.

А: Бурханд ийм зүйл яагаад хэрэгтэй байдаг юм бол?

Б: Шавь нарын гэм нүглийг цэвэрлэхийн тулд.

А: Шавь нарын нүглийг цэвэрлэх эерэг нааштай арга замыг Бурхан сэдэж чадахгүй гэж үү?

Б: Үгүй, яагаад гэвэл энэ дэлхий эерэг биш байна. Энэ дэлхий бол сөрөг хүчнийх. Та энэ дэлхийд ирсэн л бол Үйлийн Үрийн Хуулийг дагаж зохицох хэрэгтэй болно. Эс тэгвээс та энэ физик дэлхийн хаанчлалыг гонсойлгож, дэлхий хөл толгойгоо алдан самуурч, бүгд дураараа дургиж, улмаар үүнийхээ шийтгэлээс ямагт бултана. Аллага, хулгай, бусармаг бүхнийг үйлдчихээд хэн ч шийтгэгдэхгүй болчихно.

А: Рамана Махарши хорт хавдраар өөд болсон, Свами Шивананда ч бас, та мэдэж байгаа. Тэд бас шавь нарынхаа үйлийн үрээс авсан уу?

Б: Тэгсэн. Энэ чинь “жүжгийн” ердөө төгсөл хэсэг нь. Амьд байхад нь бүр ч олон адармаатай үйл явдал болж байсан.

А: Свами Вивекананда ийм байдлаар үхээгүй, түүний тухай юу хэлэх вэ?

Б: Тэр яаж өөд болсон бэ?

А: Би мэдэхгүй. Түүнийг хорт хавдар, эсвэл уяман өвчин туслаа,

эсвэл иймэрхүү зүйл боллоо гэж би сонсоогүй.

Б: Гэхдээ түүнд өөр зүйл байсан. Бүгд хорт хавдар тусаад эсвэл цовдлуулж үхдэг юм биш. Үгүй гэж үү?

А: Шри Ауробиндо, бас ээж нь ч самади төлөвт орчихсон шиг.

Б: Дотоод шаналал, сэтгэлийн шаналгаа, мөн оюун сэтгэлгээний зовлон бол махбодын зовлон амсахаас дор. Гэхдээ бас Их Багш нарын өөр өөр дэс төвшин байдаг тухай би та нарт хэлж байсан. Хэрвээ шавь нартаа авшиг хүртээж, үйлийн үрийг нь авдаггүй бол танд зовж шаналах шаардлага байхгүй. Вивекананда бол тэдэнтэй адил дэсийн Их Багш биш байсан.

А: Шри Ауробиндо бас уу?

Б: Надаас битгий асуу. Тэгэхгүй бол бүгд намайг загнана. Их Багш нар бол сургагч багш нараас өөр.

А: Гэхдээ тэд бүгдээрээ бясалгалаар дамжих ёстой байдаг. Энэ нь их багшийн зэрэгт очих түлхүүр нь дандаа бясалгал байдаг гэсэн үг биз.

Б: Янз бүрийн л бясалгал байдаг.

### Есүс Христ Арьяабалын аргаар бясалгасан

А: Жишээлбэл, Есүс ямар төрлийн бясалгал хийсэн бэ?

Б: Гуан Инь (Арьяабал).

А: Та яаж мэдэж байгаа юм?

Б: Би мэднэ.

А: Тэгвэл Есүст бас л хаа сайгүй оршигч оюун санаа байжээ.

Б: Тийм ээ, тийм! Тэр тийм байсан.

А: Тэр тийм байсан гэж үү?

Б: Ээ, надаас битгий асуу. Би танд олон ч үнэнийг хэлж өгнө. За яахав зүгээр, та надаас асуу. Та ухаалаг асуултууд тавь, та үргэлжлүүл. Бусад хүмүүсийг би сонсмооргүй байна. Бусад нь аль хэдийн асуудгаа мянгантаа асуучихсан, намайг аль хэзээний мянгантаа доромжилсон, тэднийг дахиж ингэхийг би зөвшөөрөхгүй.

А: Жишээ нь, Есүс Эссеичүүдтэй<sup>4</sup> хамт байсан. Эссенүүд бол Сөнөсөн тэнгисийн эрэг дээр амьдардаг ариун шашинтан. Та энэ талаар мэдэх үү?

Б: Тийм. Тэр Эссений шашных байсан. Эссенүүд хэдэн мянган жил дамжин ургамал хоолтон байсан бөгөөд бас тэр цаг үедээ

<sup>4</sup>- Ессеи. Нарийн зохион байгуулалт бүхий бүлгэмээрээ амьдардаг, эд хөрөнгөө нийтээр эзэмдэг Палестин дахь НТӨШ – НТШ зуун үеийн эртний еврейчүүдийн даяан бясалгалын урсгалын гишүүн. Ессеичүүдийг Сөнөмөл тэнгисийн бичээсийн зохиогч гэж үздэг.

бясалгалын жүд дамжлагатай байсан.

А: Тэр үед үү?

Б: Тэд бол Гэрэл, Аялгууг уламжилж авсан “Цагаан Ахан дүүс” байсан. Тэр цаг үед энэ бүлгэмд нэгдэн ороход нэн бэрх хэцүү байжээ. Та гэр бүл болохгүй байх, сургаал номыг гадуур нээлттэй уламжлахгүй байх тангараг өргөх ёстой байв. Аливаа хүн энэ бүлгэмд нэгдэхийн тулд аль нэг настай гишүүнээр батлан даалгах, сүүлчийн зөвшөөрөл авч, авшиг хүртэхээс өмнө олон жилийн сорилт туршилтыг давж байж тэнцэх ёстой байжээ. Тэгсний дараа л тэд цагаан нөмрөг өмсөх эрхтэй болдог байв.

Энэ урсгалын хүмүүс ёстой гайхалтай. Тэд бол хайрын биелэл байв. Чимээгүй байх амлалтыг зөрчсөн нь ганцхан Есүс л юм, гэвч мэдээж Оройн Дээдийн тааллаар тэгсэн хэрэг. Тэр дотоод бясалгалдаа илгээлт хүлээн авсан. Түүний бүлгэмээс өөр хэн ч ингэж нээлттэйгээр ном тайлж байгаагүй, энэ нь нэгдүгээрт, тавьсан андгай тангараг, хоёрт гэвэл аюул осолтой учраас тэр.

Тийм учраас, Есүс нээлттэй номлож эхэлсний дараа, бас цовдлогдох хүртэл нь “Цагаан Ахан дүүс” бүлгэм Түүнийг сайтар ажиглаж, олон талаар хамгаалахыг ямагт хичээж байжээ. Гэвч тэд энэ талаар нэмэр болж чадаагүй. Тэд л түүнийг агуйгаас, эсвэл загалмай дээрээс салгаж авсан шүү дээ.

Ямартаа ч би дэндүү их ярьчихлаа. Би хэрэггүй зүйл их ярьдаг. Өөр асуулт асууна уу.

Ш: Тийм ээ, Египетчүүдийн тухай ярьж өгнө үү.

Б: Египетчүүд үү?

Ш: Тийм, Египетчүүд бас авшигтан байсан уу?

А: Тийм, учир нь тэр цаг үед тэдэнд жинхэнэ амьд сэрүүн Их Багш Моисей нь байсан. Моисейг тэнд байх үед тэд авшиг хүртсэн, тэдний зарим нь Түүнээс авшиг хүртсэн – нэг хэсэгтээ л дээдийн номын жүд дамжлагаа хадгалсан байдаг. Чухам ийм учраас л тэр цаг үед тэд өөрсдийгөө Бурхны хүүхдүүд гэж тооцож байсны учир нь энэ. Яг л та нар одоо Бурхны хүүхэд гэдэгтээ итгэж, авшиг хүртэсний дараа гэгээнтний хүрээлэлд нэгдэн орж байгаа шиг. Жинхэнэ амьд сэрүүн Их Багш байгаа цагт ямар ч хүн өндөр дээд авшигтан болдог; тэдэнгүйгээр Египет ч, Палестин ч, хэн ч өндөр дээд авшигтан болж чадахгүй. Энэ бол Их Багшаар дамжин нээгддэг дотоод Хүч. Энэ бол гадна талын Судар ном болон шашны зан үйл биш.

А: Тэгвэл Моисей яагаад тэр хоёр алдааг гаргасан гэдгийг тайлбарлаж өгнө үү? Нэг нь гэвэл Тэрээр тэр Египетчүүдийг хөнөөсөн, нөгөө нь Тэр дөчин жил цөлд хэрэн тэнүүчилсэн.

Б: Энэ явдал түүнийг гэгээрэхээс өмнө болсон юм.

А: Үүнээс гадна Тэр Эцэгт дуулгаваргүй хандсан. Эцэг Түүнд

усны тухай хэлэхэд итгэж үнэмшээгүй, Тэр үргэлжлүүлсэн...

Б: Тийм ээ, энэ бол Моисейд байгаа хүмүүн талын шинж нь юм.

А: Моисейгийн хүмүүн шинж нь байсан юм гэж үү?

Б: Тэнд шальдар булдар зүйл их бий. Жишээлбэл, та нар Бурхныг мэднэ. Ай хөөрхий, энэ Сударт утгагүй дэмий юмс их бий. Би энэ тухай яримааргүй байна. Зүгээр үү? Би ярьж болох юм уу?

А: Тийм.

Б: Жишээлбэл, Бурхан бүтээсэн гэж бид ярьдаг – хэрвээ та сонсохыг хүсэхгүй байвал гар! За юу? Бурхан дэлхийг зургаан өдрийн дотор, долоон өдрийн дотор бүтээжээ гэдэг. Гэхдээ дараа нь, арван сахилыг гаргах гэж Тэр дөчин өдөр зарцуулсан, тэр нь маш ариун, халдашгүй зүйл баймаар юм, өөрөөр хэлбэл би нандигнавал зохих зүйл гэж байна л даа. Гэтэл Моисей бууж ирээд харгал бүгд наргиж наадан цэнгэн зугаалж, ууж идэж, тэнэг үйлдэл хийж байхыг үзээд Тэр түүнийг нь бут ниргэсэн! Дөчин өдөр зарцуулж байж гаргасан Бурхны гэрээсийг Тэр зөрчсөн. Бурхны зарлиг гэрээсийг сийлсэн чулууг тэр хагалчихсан! Түүнийг Бурхан мутраараа бичсэн гэж үздэг байсан юм. Тийм биш гэж үү? За тийм. Гэтэл дараа нь хүмүүсийг гэмээ наманчилж байх үеэр Тэр ирээд тэдгээрийг дахин, энэ удаад харин маш хурдан бүтээсэн!

Хэрвээ та надаас ахиад асуувал бид асуудалд орох байх. Би яриад байж болно л доо, гэвч миний яриа Сүм хийд, эсвэл өөр хэн нэгэнд таатай санагдахгүй л байх. Заримдаа би хүмүүсийг гомдоохыг хүсдэггүй тул юм ярьдаггүй. Гомдохгүй биз?

А: Үгүй ээ, Та тэднийг гомдоодоггүй гэж тэд хэлдэг.

Б: За сайн, та нар бүгд Христийн шашинтан. Би яалтай билээ дээ?

А: Би аль алин нь. Би Буддын ч, бас Христийн ч шашинтан. Юу гээч! Харин сүүлд нь, Бурхан хилэгнэсэн - Бурхан яаж Өөрийнхөө хүмүүст уурлаж хилэгнэж чаддаг юм бэ?

Б: Хүмүүс л ингэж тайлбарласан хэрэг. Бид Бурхан хилэгнэж байна гэж хэлж байгаа нь Үйлийн үрийн Хууль үйлчилж байна гэсэн утгатай, Хамгийг чадагч биш, ядаж л Үйлийн үрийн бурхан, Эзэн бурхан хилэгнэдэг гэсэн утгаар.

А: Тэгэхлээр, Моисей зорьж тэмүүлсэн газар орон руугаа нэвтэрч чадаагүй, түүнийг зөвхөн харсны шалтгаан нь энэ мөн үү? Түүний өөрийнх нь үйлийн үр Түүнд дээр буусан. Тэгсэн үү?

Б: Энэ бол Еврей ард түмний, бүлгэмийн нэг төрлийн хамтын үйлийн үр. Яагаад гэвэл тэдний төгсгөл ирж байх үед Бурхан маш олон байгалийн гамшгаар дамжуулан тэдэнд тусалж, олон гайхамшгийг үзүүлсэн. Тэдэнд тусалж, тэднийг аварч, хоол ундаар хангаж, тэд юунд ч санаа зовох хэрэг гараагүй; гэтэл тэд Бурхны үгийг дагаагүй. Ойлгож байна уу? Тэд Бурхны зарлиг гэрээсийг дуулгавартай дагаагүй. Тийм

учраас тэд юунаас татгалзсан, түүнийгээ дахин авч чадахгүй болчихсон. Эсвэл наанадаж л нэлээн урт хугацааны дараа л үүнийг эргэж харахаар болсон.

Жишээлбэл, та эмнэлгийн яаралтай тусламж авахаар эмч дээр очтол эмч танд тэр даруй анхаарч, халамжлах гэж л дээ. Гэтэл эмчийг хартал танд таалагдаагүй, эсвэл та эдгэсэн ч талархах сэтгэлгүй, тэгээд та “Пээ, би таныг хармааргүй байна. Би тэр хүнээр эмчлүүлмээр байна. Би тэгмээр байна!” гэжээ. Эмч ч тантай мэдээжээр, удтал маргалдаад л байгаад байж чадахгүй; тэр өөр хүмүүст халамж анхаарал тавих ёстой. Харин сүүлд нь та харамсаад эмчийг дахиад гуйхад “Үгүй! Өөр хүний ээлж болсон байна, та хүлээх л болж дээ. Та түүнээс татгалзчихсан шүү дээ!” гэсэн хариу авна. Эмч одоо өөр хүнд мэс засал хийж байна. Тэр өвчтөнөө хагас дутуу, дэл сул үлдээж орхиод таныг халамжлахаар гүйж ирэх боломжгүй, учир нь та тэнд түрүүн байсан шүү дээ. Та товлосон хүлээн авах цагаас татгалзсан, дараа нь харин эмч надад уурлаж байна гэж хэлж байгаа чинь таарахгүй” гэнэ.

А: Тэгвэл Еврей болон арабчуудын хооронд өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа тэмцлийн талаар ярьж өгнө үү. Бурхан энэ хүмүүсийг Өөрийнх нь үгнээс зөрсөн тул шийтгэнэ гэж хэлсэн. Тэр энэ хүмүүсийг дэлхий даяар тарааж, тэгээд бас Арабчуудыг тэдэнтэй цаг үргэлж, ертөнцийн төгсгөл болтол байнга дайтуулна гэж хэлсэн.

Б: Тийм, учир нь тэд атаач жөтөөч Бурхныг шүтсэн хэрэг. Тэд Хоёрдугаар Ертөнцийг захирдаг Эзэн Бурхныг шүтсэн. Тэд Хоёрдугаар Ертөнцөд байдаг Үйлийн үрийн Бурханыг шүтсэнээс нь болж л Бурхан тэднийг шийтгэсэн. Хэрвээ тэд Хамгийг Чадагчийг шүтсэн, эсвэл өөрсдийнх нь Их Багш Моисей маш өндөр дэсийн Гэгээнтэн байсан юм бол тэд энэ бүхнийг амсаж туулахгүй байсан. Түүнчлэн, та завшаан боломжийг нэг л алдсан бол энэ тойрог хүрдийг төгсөн төгстөл, олон мянган жилийн турш, олон үе удам дамжин зовох хэрэгтэй болдог, ингээд та бүх зүйлээс үнэнхүү залхаж, чин сэтгэлээсээ наманчилна. Яг тэр цагт Их Багш ирж, өөрийг чинь авардаг.

Манай нэгэн бясалгагч намайг анх удаа харж, лекц сонсчихоод гэртээ харьжээ. Тэр авшиг хүртэхийг хүсээгүй аж. Тэр татгалзсан. Тэрээр ингэх хэрэг юу байна гэж бодсон аж. Өөрийгөө их сайн эр гэж бодож л дээ. Тэр бясалгал дадуулдаг, хааяа бясалгачихдаг, бас зөвхөн сайныг нь л үйлддэг, түүнд Их Багш – тэр тусмаа эмэгтэй Их Багш хэрэггүй! гэж санаж л дээ. Бас Буддын шашны судруудад эмэгтэй хүн Будда болох боломжгүй хэмээсэн гэж тэр эр хэлсэн ажээ.

Гэхдээ тэр урд төрлүүддээ сайн бясалгасан нэгэн байв. Түүнд Буддатай тааралдаж, бас гэгээрэл олох буян заяа байжээ. Түүний энэ том би гэх үзлийг эс тооцвол түүнд сайн тал ч бий аж. Тийм учраас л лекцэд ирээд сууж байхдаа ахуй ойлголт үзэж, мэдэж, бас тэнд олон

Будда, Гэрэл байхыг харж, мэдэрчээ. Чин Хай нэртэй Их Багш бол эгэл нэгэн биш гэдгийг тэр мэджээ. Тэр үүнийг мэдсэн байна. Тэр мэдээгүй хэрэг биш, мэдсэн гэдгээ зөвшөөрөхөөс татгалзаж л дээ. Тэр ганцаараа болгоод байдаг, энэ зүйл надад хэрэггүй гэж хэлжээ. Түүнд сайн буян байв. Тэр бас Буддын шашны сүм хийд болон буяны байгууллагад байнга хандив өргөдөг бөгөөд ганц өөрт нь бол болж бүтээд байдаг аж. Ингээд л тэр гэртээ харьж дээ. Гэтэл нэгэн авшигтан түүнийг жаахан шахамдуулж, “Чи яагаад авшиг хүртэхгүй байгаа юм бэ? Энэ тун сайхан боломж шүү. Авшиг хүртэлгүй үхчих ч юм билүү гэдгээ чи яаж мэдэж байгаа юм. Их Багш хэзээ эргэж ирэхийг чи ер мэдэхгүй. Юу ч тохиолдох юм билээ. Очоод авшиг хүртчих” гэх мэтээр учирлажээ. Харин дараа нь та нарын хэлдэгчлэн түүний итгэл үнэмшил дэнсэлж донслох болсон гэнэ.

### Янз бүрийн ертөнцийн Эзэн тэнгэр

А: Оройн Дээд Бурхан бие махбодод хувиран заларч болох уу?

Б: Тэр бие махбодод хувиран ирж чадна.

А: Тэр ямархуу бие махбодыг хүсдэг бол? Өөр өөр шашны шавь нар Бурханд залбирч байх үедээ мөн чин үнэн сэтгэлтэй байхдаа Эзэн тэнгэрийн жинхэнэ сүсэгтэн мөн юм, тэд бүгдээрээ. Тэд үнэхээр Тавдугаар төвшний Эзэнтэй харилцаж чадах уу?

Б: Тэд ихэнхдээ Үйлийн үрийн Эзэнтэй л харилцаа тогтоодог.

А: Үйлийн үрийн Эзэн бол Хоёрдугаар Төвшнийх. Еврейчүүд түүнийг Яхве (Jehovah) хэмээн дууддаг, гэвч энэ нь Үхлийн Эзэн Яма<sup>5</sup> (Yama the Lord of Death) хэмээгчтэй ижил юм биш үү?

Б: Үгүй. Үхлийн Эзэн бол Нэгдүгээр төвшний ертөнцөд, тамын мужид байдаг.

А: Ер нь бол Оройн Дээд Бурхан янз бүрийн төвшинд тэр ертөнцийг хариуцсан Эзэн бурхдыг томилдог бололтой юм уу даа?

Б: Яма бол Үйлийн үрийн Эзэн тэнгэртэй хамтарч ажилладаг. За юу?

А: Тэгвэл тэд зөвхөн бидний энэ Дэлхийд байх хоногийн тоо дуусах хүртэл л ажиллана гэсэн үг үү?

Б: Тийм. Тэд алба үүрэг нь дуусах хүртэл л ажиллана.

А: Та жишээлбэл Калпа (галав) гэх утгаар хэлж байна уу? Хиндү нарын хувьд 4 янзын галав байдаг, энэ утгаар уу?

Б: Тэдний үйлийн үр дуусч, Бурханд хүртэл.

<sup>5</sup> - Яма. Вед шашидир дахь анхны нас барсан хүн, дараа нь үхэгсдийн бурхан, эцэст нь үхэл болон тамын харгис бурхан болсон. (Мирча Элиаде. Ион Кулиаде. Словарь религий, обрядов и верований).

А: Энэ бол үйлчлэл, тэднийг ариусаж байгаа гэж хэлж байгаа юм уу?

Б: Энэ ярвигтай.

А: Ярвигтай юу.

Б: Гэхдээ тэд ийм албанд байх үедээ тэр ажлаа гүйцэтгэх Бурхны Хүч чадлыг өөртөө агуулж байдаг.

А: Тэгвэл Арш нар болон Гэгээнтнүүд энэ хуулиудыг өөрчилдөг хэрэг үү?

Б: Тийм. Их Багш нар энэ бүхнээс дээгүүр. Их Багш нар ер нь Их Багшийн байр сууриа тэднийг дарамтлахын тулд ашигладаггүй. Тэдэнтэй ердөө л хамтран ажиллаж, сүнснүүдийг тэдний хариуцсан муж нутгаар нь дамжуулан өнгөрүүлдэг болохоос биш, тэднийг дарамтлан шахдаггүй. Ерөнхийлөгчийн зөвлөх хүн шиг л юм. Түүнд бүх сайд, тэр байтугай үүдний харуулыг захирах эрх мэдэл бий. Гэсэн ч тэдэн дээр очоод “Хүүе, чи ердөө л үүдний харуул биз дээ” гэж хэзээ ч хэлэхгүй. Тэр тэгэхгүй дээ. Тэр харуулыг хүндэтгэн явж очоод нэвтрэх үнэмлэхээ үзүүлж, харуул хаалга нээж өөрийг нь ордонд оруулах хүртэл азнан хүлээнэ. Тэр хүн бүрийн ажил үүргийг хүндэтгэдэг. Харин ордонд ерөөсөө нэвтрэх зөвшөөрөлгүй хүнийг авч орьё гэвэл тэр бас чадна. Зөвлөх тэнд байгаа учраас, та нарын хэлдэгчлэн тэр баталгаа өгч байгаа тул харуул ерөнхийлөгчтэй уулзахаар хамт яваа хүнийг нь дотогш нэвтрүүлнэ. Тийм биш бол хэн ч ерөнхийлөгчийн ордонд нэвтрэх боломжгүй. Нөлөө бүхий хүнийг дагалдаж яваа бол жирийн хүн ч ерөнхийлөгчийн өргөөнд нэвгэрч болдог шүү дээ.

### Гэгээрсэн Их Багш хүмүүсийг учир зүйн туслалцаатайгаар авардаг

А: Бурхан багш нэгэн удаа “Хэрвээ би бүгдийг чинь энэ бүх зовлон, мунхаглалаас салгачихаж чадах байсан бол аль хэзээний тэгчих байсан, гэвч би чадахгүй” гэж хэлсэн байх юм.

Б: Тийм ээ, тэгж хэлсэн!

А: Тэгвэл ямар нэг утгаар, Тэр хаа сайгүй оршигч биш юм уу даа. Гэтэл Эзэн Тэнгэр (The Lord) бол бүхнийг чадагч мөн шүү дээ.

Б: Будда бол бүхнийг чадагч мөн, харин бид өөрийн дур зоргыг ашиглах ёстой.

А: Тэр яагаад биднийг бүгдийг нь зүгээр л гэтэлгэчихдэггүй юм бэ?

Б: Үгүй! Тэгвэл зугаатай биш болно.

А: Гэтэл энд зовлон нь зугаанаасаа их байгаа биш үү. (Инээлдэв)

Б: Хүмүүс зовж шаналах дуртай. Бурхан багш ч, Есүс ч өөрийг нь



дагахыг хүсэхгүй байвал хүмүүсийг албадаж хүчлэхгүй. Хүмүүст дур зорго-чөлөөт хүсэл гэгч зүйл байдаг. Энэ бол хэцүү бэрх хэсэг нь, бас энэ бол сөрөг дэлхий. Тэд энэ дэлхийн жам ёстой зохицож ажиллах ёстой. Тэд бүхнийг эвдлэн нурааж болохгүй. Энэ бол Үйлийн үрийн Эзний хаанчлал. Та энэ хаанчлалд нэгэнт нэвтэрсэн л бол түүнтэй зохицон ажиллах ёстой. Гэгээнтнүүд хүмүүстэй шүүн хэлэлцэх, тэдэнтэй учир зүйн дагуу ярилцах, тэднийг ид шидийн хүч, ховсдох чадвараар бус тэдний өөрийнх нь сонголт, билгүүн ухаан, дур зоргых нь дагуу татаж үгэндээ оруулна гэсний үндсэн дээр тэдэнд энд ирэхийг нь зөвшөөрдөг юм. Их Багшийн ажил нэн хүнд бэрх, бас зовлон шаналлаар дүүрэн байдгийн учир нь энэ. Тийм бишсэн бол хэн ч Их Багш болж чадна, тэгээд дэлхийг хоосортол нь бүгдийг нь дээш нь татаад гаргачихад ганц л Их Багш байхад хангалттай байхсан. Гэвч үүнийг зөвшөөрдөггүй, учир нь бусад Гэгээнтэн илрэн гарч ирээд диваажинтай холбоо тогтоохын тулд энд үргэлж зарим хүн үлдсэн байх хэрэгтэй болдог. Яагаад гэвэл энэ дэлхийд хүмүүс байж байвал л бусад төрөлтнүүд хувьсан хөгжиж чадна. Та Библийг, Хуучин гэрээг санаж байна уу?

А: Тийм.

### Ургамал, амьтан болон хүн

Б: Бурхан амьтдыг захирч, хаан нь байхыг хүн төрөлхтөнд даалгажээ. Энэ нь бид тэднийг асран халамжилж, зааж сургаж, тэднийг хувьсан хөгжих боломжтой байлгах хэрэгтэй гэсэн утгатай. Мөн зарим амьтан хүн болох тэр цагт энэ шинэхэн төрсөн хүмүүст зааж сургахын тулд энд аль хэзээний хөгжин дэвшсэн, илүү цэцэн мэргэн өөр хүмүүс байж байх ёстой юм. Хүн болж төртлөө хувьсан хөгжих ёстой мод, хад чулуу, эрдэс бодисууд байдаг. Хэрвээ тэднийг хүрээд ирэхэд нь тэдэнд зааж сургах хэн ч байхгүй бол тэд эрдэс бодис, модны хаант улс руугаа дахин буцна.

А: Ургамал, жишээлбэл, юу нь сайн, эсвэл муу гэдэгт хэрхэн суралцаж чаддаг юм бэ?

Б: Тэд орчны уур амьсгалын энергиэ ном сургаалыг шингээж авах байдлаар олон мянган жилийн туршлага хуримтлуулан алгуурхан суралцдаг. Гэхдээ тэдний мэдэх ойлгох болон хоол боловсруулах тогтолцоо нь удаан. Тэд эцсийн эцэст “Аан! Тийм! Ингээд л гүйцэх шив!” гэж ойлгож мэдэж, сэргэж сэхээрэх хүртлээ ийм уур амьсгалд олон мянган жил оршсон байх хэрэгтэй байдаг. Тэр цагт л тэдэнд хүний бие заяах хэрэгтэй болно. Тэд бол залуухан сүнснүүд.

Том ах, эгчдээ юу хүсэж буйгаа хэлж ойлгуулах нь танд амархан байдаг бол бага дүү нартаа тайлбарлах хэцүү байдаг шиг л юм. Тэд таныг ойлгодог болтол нилээн удна. Тэд коллежид элстэл нилээн цаг

хугацаа шаардлагатай, элсээд орчихсон үед бол тэдэнд зааж сургахын тулд ямар нэг профессор багш тэнд байж байх ёстой. Шинээр элсэгч, шинэ оюутнуудыг хүлээж авах хэн ч тэнд байхгүй байвал хэн төгсөгч болж, коллежийн цаана гарах билээ. Хүн болгон коллежийн багш болж чадахгүй. Гэтэл бага ангийн багш бас л чухал. Үгүй гэж үү?

Би дэндүү их ярьчихлаа. Одоо ингээд дуусгах уу даа? (Сонсогчид Их Багшийг үргэлжлүүлээч гэж гуйв.)

### Сүнс

А: “Атман” гэдэг онолын талаар ярина уу? Бурхан Багш хэлэхдээ бодит байдал дээр сүнс гэж байхгүй гэж хэлсэн байхад Есүс сүнс байдаг гэж хэлсэн аж.

Б: Энэ нь хэн нэг хүн Бурхан байдаг гэж хэлж байтал Тэр Бурхан байхгүй гэж хэлсэнтэй л адил. Энэ чинь тэдний л ажил. Бидэнд ер хамаагүй. Тэд янз бүрийн дэс төвшний янз бүрийн хүмүүст хэлж учирлаж байсан. Тэд ялгаатай нэр ашиглах ёстой байж л дээ.

А: Тэгэхлээр, Тэр бас сүнс байдаг гэж хэлсэн хэрэг үү? Өөр газруудад, Бурхан Багш сүнс байдаг гэж хэлсэн үү?

Б: Тийм. Энэ бол Аугаа Би, эсвэл Жинхэнэ Хүн, Жинхэнэ Чи гэж Тэр хэлсэн. Энэ бол сүнс. Үгүй гэж үү? Нэг л ижил зүйлийг ярьжээ. Тэр зүгээр л үгэнд уягддаг хүмүүсийн уяа хүлээсийг л таслах гэсэн хэрэг. Хүмүүс сүнсийг ийм тийм гэж төсөөлж, ямар нэг зүйлд хийж савладаг. Тиймээс Тэр үүнийг нь л таслах ёстой болсон тул Тийм зүйл байхгүй. Энэ бол ердөө л таны Би юм шүү дээ гэж хэлсэн.

А: Тэгвэл хойд төрөл аваад байгаа нь бие хүн гэгч нь үү?

Б: Энэ бол дадал зуршил, дадал зуршлын энерги; бид хэрхэн бодож сэтгэж, хэрхэн хийж үйлдэж, хэрхэн хүлээж горьдож байгаа байдал маань л юм. Энэ зүйлс хуримтлагдаад дахин төрөл авах энергийн цул болчихдог. Гэтэл энэ энергийн цулд сүнс, сэтгэгч энерги агуулагдаж байдаг учраас тэр нь түүнтэй хамт зовж зүдрэх ёстой болдог. Хэрвээ тэр сүнс тэрхүү агуулагдсан энергиэ суллагдаад гарчих юм бол дахиж зовохгүй!

А: Суллагдаад гарчих үед энэ нь Гэрэлтэхүй болох уу? Энэ нь цорын ганц арга зам уу?

Б: Тийм!

А: Яагаад? Тэр сүнс энэ дадал зуршилдаа уягдаж хүлэгдэхээ больсон учраас уу?

Б: Тийм. Бие даасан гэдгийг нь сүнсэнд хэн ч хэлж сургадаггүй. Сүнс өөртэйгөө хог новшоо үргэлж хамт чирч явахын хэрэг байхгүй. Түүнд энэ “хувцас”-ыг өөртөө өмсгөх шаардлага байхгүй. Тэрээр “хувцас”-аа урж тасчиж чадна. Бас “хувцас”-аа тайлаад чөлөөтэй байж

ч чадна. Энэ хог новшийг байнга биш, түр зуур л авч явах шаардлагатай байдаг.

Жишээлбэл, би үүнийг аль хэдийн ярьсан ч ахиад ярья. Далайн гүний усанд шумбахад бидэнд хүчилтөрөгчийн баг мэтийн балай хэрэгсэл, бас мэлхийнх шиг өмсгөл хэрэгтэй болдог. Гэтэл бид анхнаасаа ийм биш шүү дээ. Далайн гүн рүү шумбахын тулд энэ бүхэн бидэнд байх шаардлагатай. Тэр бол огт өөр ертөнц. Энэ муухай хэрэгсэлгүйгээр бид тэнд амьд байж тэсэхгүй. Тэгээд далайн гүнд шумбаж орсон бол хэсэг байзнаад та буцаад гадаргуу дээр гарч ирэх ёстой. Хэрвээ тэндээ үлдлээ гэхэд шумбах хэрэгсэл чинь асуудал үүсгэнэ. Та үүнийг өөрт тань тус болдог зүйл гэж боддог, гэвч хэрэв та усны гүнд дэндүү удаад бас энэ тоног хэрэгсэлдээ сэтгэл хүлэгдээд байвал, тэр чинь эвдрэх цагт та өөрөө асуудалд орно. Та үхнэ. Та тэр багаж хэрэгсэлдээ уягдаж хүлэгдсэнээсээ болж л үхнэ. Та дээшээ гарах ёстой, тэрнээс биш “Үгүй ээ! Үгүй! хэрвээ та намайг дээшээ гар гээд байвал, харин надад энэ хүчилтөрөгчийн баг байхгүй бол би яаж амьд байх болж байна? Надад үргэлж хүчилтөрөгчийн баг байсан, цаг ямагт байсан, харин одоо та нар надад дээшээ гараад үүнийгээ тайл гэж байна. Би яаж ингэж чадах юм бэ? Үгүй шүү! Үгүй! Тэгэхгүй! Би эндээ үлдэнэ. Үүнгүйгээр би яаж сэлж чадах юм бэ?” гэж хэлж болохгүй биз дээ.

Хуурай газар дээр гараад ирвэл ерөөсөө сэлэх ч шаардлагагүй болно гэдгийг та мэдэхгүй байна. Хүчилтөрөгчийн баг ч хэрэггүй. Танд бүх зүйл байх болно. Бас бүр ч илүү үзэсгэлэнтэй сайхан. Энэ бол ердөө л нэг муухан жишээ төдий, гэхдээ та тэнгис далайн ус руу шумбах нь зөвхөн түр зуурын явдал, бас бид дэлхийн амьдралаа санагалзана гэдгийг ойлгож байгаа байх.

Харин бид энэ физик оршихуйн далайд шумбаад орчих тэр цагт энд маш олон амьдралаа өнгөрөөж, энэ зовлонгийн далайн бүх “загас”-нд сэтгэл уягдчихдаг. Бидэнд далай тэнгисийн гоо үзэсгэлэн таалагдаж, газар дээр дахин гарч ирэхийг хүсдэггүй. Дараа нь, бидний уураг тархитай төстэй хүчилтөрөгчийн баг, эсвэл ердийн далай тэнгисийн усанд шумбахдаа өмсдөг мэлхийн хувцастай төстэй бидний бие махбод зэрэг энэ бүх багаж хэрэгсэл бидэнд хэрэгтэй гээд бодчихдог.

Ингээд Их Багш танд “Өө, сүнснийхээ төлөө бие цогцсоо орхи. Та үхэхээс айх хэрэггүй. Эд хөрөнгийн тухай мартаад намайг дага” гэж хэлэхэд та “Үгүй ээ! Үгүй! Бидэнд байгаа бүх зүйл бол эд хөрөнгө. Гэр бүл минь! Найзууд минь! Байшин минь! Хүүхдүүд минь! (Инээлдэв) Банкны данс минь! Зээлийн карт минь! гэдэг.” Биднийг диваажин луу явах цагт энэ бүхэн хэрэггүй.

Бид хуурай газар дээр гарахаараа энэ бүх хүчилтөрөгчийн багаа тайлах ёстой. Тэгэхгүй бол бид өөрийгөө хөнөөнө шүү дээ. Тийм. Харин бид одоо гэгээнтний эгнээнд элсээд орчихсон, өмнө нь шаардлагатай

байсан ч одоо хэрэггүй болсон энэ бүх “хүчилтөрөгчийн баг” гэх мэтийн юмаа яаралгүйхэн тайлах ёстой. Тийм юм, гэтэл зарим хүн “хувцас”-ндаа уягдаж хүлэгддэг. Тэд энэ хувцсаа дэндүү удаан өмссөн тул хувцас нь биетэй нь наалдчихаад дулаахан байдаг. Тэд “Өө! Зүгээр ээ, болж байна. Тайлж яах юм?” гэдэг. Гэтэл түүнийг цагт нь тайлахгүй бол тэд үхнэ. Хүчилтөрөгчийн багийг түр зуур хэрэглэх гэж л зүүдэг. Хэрвээ бид үүнээсээ салахгүй зууралдвал хуурай газар дээр гарч ирсэн хойноо хүчилтөрөгчөө хэвийн авч чадахгүй, ингээд энэ хэзээ нэг цагт хэрэг тус болсон зүйлээсээ болж үхэх болно.

А: Есүс “Үхэгсэд нь үхэгсдийгээ оршуулаг” гэж хэлсэн шиг л Та тэд үхнэ гэж хэлэх юм. Хүмүүс хувцас хунар, хогшил тавилга, унаа машин, мөнгө төгрөг зэрэг энэ бүх зүйлдээ уяж хүлэгдээд байдаг учраас энэ бие махбодод байх үедээ ийм хүмүүст хэзээ ч сүнслэг амьдрал байхгүй гэж та хэлж байна уу?

Б: Тийм! Тийм! Тийм! Тиймээс л Есүс “Үхэгсэд нь үхэгсдийгээ оршуулаг” гэж хэлсэн. Яагаад гэвэл бүр амьд нь ч үхдэл болчихсон хэрэг юм. Тэд сүнслэг талаараа үхмэл. Их Багшид итгэдэггүй, Их Багшаас авшиг хүртээгүй бол бид бүгд үхдэл, явдаг үхдэлүүд. Үүнийг юу гэмээр юм дээ? Хөдөлдөггүй үхдэл.

А: Хэрэв хүн аль хэдийн үхээд, бас сүнсгүй болсон бол үхэх үед нь зүгээр л эд эс нь задраад харин дадал зуршил нь үлдэж, дахин төрөл авах уу?

Б: Тийм! Тийм!

А: Бурхныг хайрлаж, биширч, судалж ойлгосон, Их Багшид үйлчилсэн хүмүүс сүнслэг зам мөр дээр байгаа; ийм хүмүүст сүнслэг Гэрэл, Гэрлийн бие байдаг аж. Тэгэхлээр тэднийг үхэхээр энэ Гэрлийн сүнслэг бие нь дадал зуршил болон сэтгэлийн хүлээсний зааг хязгаараас чанагш гардаг уу? Тэгээд, сүнслэг бие нь Их Багштай хамт дээд ертөнц рүү явах уу?

Б: Тийм ээ, тийм! Ердөө л энэ.

А: Тийм болоод л Их Багш нар хүмүүсийг энэ хүмүүний бие махбод хэмээх хогноос салгах гэж ингэглээ эрмэлзэн тэмүүлдэг байх нь ээ, яагаад гэвэл энэ чинь ердөө л задарч ялзарч байдаг цогцос юм биш үү?

Б: Тийм.

А: Тэгвэл Их Багш болон шавийн хооронд холбоос байдаг уу? Энэтхэгт хүмүүс надад бид Их Багштайгаа үүрд хамт байна гэж хэлж байсан.

Б: Тийм! Тийм учраас Есүс: “Дэлхий хөмөрсөн ч, Би та нарыг орхихгүй” гэж хэлсэн. Бурхан багшийг амьд сэрүүн байхад шавь нар нь янз бүрийн л дэс төвшинтэй байжээ. Энэ насандаа гэтэлчихсэн, хойд

насандaa гэтлэх, бас Бурхан багшаар гэтэлгүүлэх хүртлээ ахин дөрвөн удаа амьдрах, долоон удаа амьдрах шавь нар байжээ. Харин би буцаж ирэхийг хүсэхгүй байгаа учраас энэ амьдралдаа та нарыг бүгдийг нь аваад явмаар байна! (Алга ташиж, инээлдэв.)

### Бид бүгд нэгэн цогц

А: Буддист, Хиндү, Суфи, Сихк, Христэд итгэгчид гээд бид бүгд хэзээ хамтдаа гэтлэгдэх вэ, тэр үед бид бүгдээрээ хамт байх уу?

Б: Тийм ээ, лавтайяа. Шашин гэж байхгүй. Үнэндээ бол зөвхөн эртний Их Багш нарын ардаа үлдээсэн Их Багш нарын сургаал л байдаг.

А: Есүс шашин байдаггүй гэж хэлсэн, тэгвэл бид бие биеэ яаж таних вэ? Бид бүгд үхчихсэн хойно шашин шүтлэг, бие махбод ч байхаа болино, тэгээд тэр үед... ?

Б: Өө, үгүй. Та жирийн хүнийг хэлж байна уу эсвэл авшигтан хүнийг үү?

А: Авшигтан хүнийг.

Б: Авшигтнууд Их Багштай хамт явна. Яагаад өдий хүртэл энд суужихсан атлаа “Та Сихк үү, Христ үү?” гэж асуугаад байна аа? Ямар балай юм! Бид иймэрхүү асуулт ахиж асуух хэрэггүй. Та одоо битгий асуу, бас дараа нь ч асууж яах юм? Бид одоо нэгэн цогц гэдгээ аль хэдийн мэдчихсэн, тэгсэн мөртлөө үхсэнийхээ дараа бид яагаад энэ тухай асуух ёстой гэж?

А: Тийм тийм, Таны зөв. Тэгвэл бид ер нь өнө мөнхөд хамтдаа юу хийх билээ?

Б: Бид суралцана. Бид их багш болж, их багшийн чадварт хүртлээ суралцах ёстой зүйлдээ суралцсаар байх болно.

А: Өө, Та биднийг авшиг хүртсэн, гэхдээ хараахан гэгээрээгүй гэж хэлж байна уу?

Б: Бид гэгээрсэн, гэхдээ бид Их Багш шиг төгс гэгээрээгүй. Жишээлбэл, та коллежид оюутнаар элсэх үедээ коллежийн профессор, эсвэл төгсөгч биш. Та суралцах ёстой.

А: Тэгэхлээр энэ бие махбод үхсэний дараа л бид дээд боловсролтой болж чадна гэсэн үг үү?

Б: Яг одоо! Бид үүнийг яг одоо чадаж болно, хэрвээ та хангалттай бол – гэхдээ бүгдээрээ биш. Үүнийг нэг амьдралдаа хийж чадсан Будда, Есүс, Луу-охин, эсвэл Мьял богд шиг. Тийм ээ? Та тэдний нэг болж болохсон.

А: Би тэдний нэг болж чадах болов уу? Бид бүгд чадна. Суралцаж чадаагүй нэг нь яаж суралцах вэ? Тэнд ном бичиг байдаггүй, тийм биз?

Б: Үгүй. Тэднийг дэлхийг орхисны дараа Их Багш тэдний дэс

төвшинд нь тохируулан зааж сургана. Их Багш тэднийг Будда болтол нь орхихгүй. Би Их Багш болтол нь гэх гэсэн юм.

А: Энэ үнэхээр тийм гэж үү?

Б: Тийм!

А: Тэд хүүхдүүдээ хэзээ ч орхихгүй юу?

Б: Үгүй.

### Амьд Их Багштай байх нь чухал

А: Энэ чинь тэгвэл Есүс Өөрийн дагалдагчидтайгаа хэрхсэн шиг гэсэн үг үү? Жинхэнэ христийн шашинтан гэгдэх бүх христийн шашинтан цөмөөрөө Түүний хойноос явах уу?

Б: Үгүй, одоогийн байгаа шиг бүх Христийн шашинтнууд биш, харин амьд байхдаа Түүний зааж сургасан тэр хэд нь л. Түүнийг амьд сэрүүн байхад нь дагасан тэр хүмүүсийг Тэрээр их багшийн зэрэгт хүртэл нь халамжилна. Жинхэнэ Христийн шашинтнууд бол Түүнийг амьд сэрүүн байхад нь Христийг дагаж байсан тэр хүмүүс юм. Жинхэнэ Буддистууд бол Буддаг амьд сэрүүн байхад нь дагаж байсан тэр хүмүүс. Жинхэнэ Сикхүүд бол Сикхийн Их Багш нарыг амьд сэрүүн байхад дагаж байсан тэр хүмүүс. Тэд өөрсдийгөө Сикхүүд, Буддистууд, Христүүд гэж нэрлэдэг, яагаад гэвэл энэ нь тэдний Их Багшийнх нь нэр учраас тэр. Намайг үхсэний дараа хүмүүс өөрсдийгөө “Чин Хай-истүүд” гэх юмуу, эсвэл иймэрхүү маягаар нэрлэж магадгүй л юм. (Инээлдэв.)

А: Та өнөөдөр “Зөвхөн амьд байгаа Их Багш” гэж хэлж байгаа нь одоо Есүсгүй байгаа Христийн шашинтнууд амьд Христийг олох хэрэгтэй гэсэн санааг илэрхийлж байна уу?

Б: Тэд Христийн шашинтан биш.

А: Тэд Христийн шашинтан биш ээ?

Б: Тэд жинхэнэ Христийн шашинтан биш.

А: Тэгвэл энэ хөөрхий хүмүүст хэн туслах вэ? Маш олон байгаа.

Б: Тийм, чухам ийм учраас л дэлхий үргэлж пиг дүүрэн байгаа юм. Хэрвээ Есүст болон Христийн шашинд итгэдэг хүн бүр диваажинд оччихсон байсан бол дэлхий өдийд хоосон байх байсан. Хүн амын ядаж л тал хувь нь алга болчих байсан. Та тэгж бодохгүй байна уу?

А: Тийм. Яагаад гэвэл тэд ахин дахин буцаж ирсээр байна гэж та хэлж байна уу?

Б: Хүмүүсийн тал хувь нь Христийн шашинд итгэдэг гэж байгаа ч дэлхий үргэлж дүүрэн байна. Хүн ам нь цаг үргэлж ихсэж байна. Энэ нь нэг ч Христийн шашинтан диваажинд очоогүй гэсэн үг. Орчин үеийн Христийн шашинтнаас хэн нь ч диваажинд очоогүй гэсэн үг.

А: Тэгвэл эндээс явахын тулд тэдэнд Есүс, амьд Есүс хэрэгтэй

гэсэн үг үү?

Б: Тэгэлгүй яахав.

А: Тэгвэл Есүсгүйгээр Христийн шашин бүхэлдээ юутай адилхан болж таарч байна?

Б: Есүсийг мэндэлж байсан үеийн Иудей дэх еврейчүүд шиг. Тэд Мессиаг хүлээж байсан, гэтэл Мессиа (Элч) тэнд байж байсан. Тэд хэзээ ч ирэхгүй, гэхдээ ирнэ гэж амласан нэгнийг хүлээж байхдаа жинхэнэ, амьд Мессиагаас татгалзсан.

А: Хэн ч, хэзээ ч ирэхгүй гэж?

Б: Тийм.

А: Тэр ирж магадгүй.

Б: Тэр ирж магадгүй гэнэ ээ!?

А: Үүлэн дээр гэж л Зөнч Ионн<sup>6\*</sup> өгүүлсэн байдаг.

Б: Үүлэн дээр биш! Аа, за. Би үүлэн дээгүүр явдаг. Би үүлнээс ирсэн. Би дандаа л нисэх онгоцоор явдаг ч хэн ч надад итгэдэггүй. (Инээлдэв) Есүс “Би үүл хөлөглөн буцаж ирнэ” гэсэн. Үгүй гэж үү? (Алга ташилт)

А: Тэр үүлний тухай ярихдаа ямар нэг өөр зүйлийг хэлсэн байх.

Б: Үгүй.

А: Бэлгэ тэмдэг маягийн зүйлийг.

Б: Үүл л бол үүл! Үүлнээс бууж ирсэн.

А: Үүлнээс бууж ирж магадгүй гэж Тэр хэлсэн.

Б: Тийм. Би үргэлж л үүлнээс бууж ирдэг.

А: Та болон Есүс бол нэг юм гэсэн утгаар хэлж байна уу?

Б: Та юу гэж бодож байна?

А: За, би тийм л гэж бодож байна (Инээлдэв)

Б: Одоо, хэрэв та намайг ядаж л Есүстэй адил эсэхийг мэдэхийг хүсэж байвал амьд байхдаа Тэр юу гэж хэлсэн, амьд байхдаа Тэр юу хийснийг бодож үзээд дараа нь намайг Тэр хэрхэн хийж байсан шиг хийж байна гэдэг энэ нөхцөлийг би хангаж буй эсэхийг харгалзаж үзэх хэрэгтэй. Тэгж байж л та намайг Түүний төвшинд байгаа, эсвэл Түүнтэй нэгэн цогц эсэхийг мэднэ.

А: Өө, тийм. Та бол Түүнтэй нэгэн цогц, яагаад гэвэл Та ариун. Ариун хүн бүхэн Бурхныг хардаг. Есүс хэлэхдээ “Би Эцэгтэйгээ нэгэн цогц” гэсэн. Тиймээс Та ч Эцэгтэй нэгэн цогц.

Б: “Энэ дэлхий дээр байгаа цагтаа Би энэ дэлхийн Гэрэл нь” гэж Тэр хэлсэн. Хэн нэг хүн Гэрэл юм бол бусдыг гэрэлтүүлж, бусад хүнд

*6 - Ионн. Библийн номд гайхалтай адал явдлуудынх нь тухай өгүүлдэг (МЭӨ 4-р зуун) Бошиглогч. Их Эзний дур зоргоос хэн ч зугтаж чадахгүй бөгөөд Ниневе-д бошиглох үүргээсээ татгалзахдаа Ионн энэ хуулийн үнэн зөвд итгэж үнэмснэ. Түүнийг асар том загас залгиад дараа нь нулимж гаргасан бөгөөд үүний дараа Ниневегийн хүмүүс нүглээ наманчилсан ажээ.*

Гэрэл өгч чаддаг байх ёстой. Тэгэхлээр одоо ойлгомжтой байна уу?

А: Тийм ээ, би ойлгож байна. Бид ийм маягаар шашнаас чанагш оршин буй Үнэн рүү явж байгаа юм уу?

Б: Шашин зөвхөн Үнэн рүү заадаг, харин бид Их Багштай хамт түүнийг олох ёстой. Тэр байтугай жинхэнэ Их Багшгүйгээр бид шашныг ч ойлгож чадахгүй.

А: За тийм ээ, би үүнийг өөрийнхөө амьдралаас харж байна.

Б: Хар л даа, та өөрөө гэхэд л Хималай, Энэтхэг, гадаад улс оронд байгаа хамаг л Их Багш нартай, алдар суутай Их Багш нартай уулзсан хэр нь л Судар бичигт байдаг жижиг сажиг санааг ухааж ойлгоогүй л байж байна – та нэрлэ л дээ, танд тийм багш нар байсан шүү дээ. Тийм байтал та ямар ч Их Багшгүйгээр яаж чадах билээ, ойлгож байна уу?

А: Үнэн. Тийм, би чадаагүй.

Б: Та бас олон жил гэлэнмаа байж, янз бүрийн дэг сургуульд суралцсан, бас өөрөө нэн ариун гэгээлэг амьдарч иржээ. Та утгагүй дэмий юм хийгээд яваад байгаагүй, эсвэл гэм нүгэлтэй зүйл хийж байгаагүй. Тэгсэн хэр нь л энэ бүх золиос болон хатуу чанд амьдрал танд гэгээрлийг өгч чадсангүй. Ямар нэгэн байдлаар бидэнд сайн Их Багш хэрэгтэй. За юу? (Инээлдэж, алга ташив.)

## Гүрү Нанак

А: Тэгвэл Та Гүрү Нанакийг мэдэх үү?

Б: Мэднэ.

А: Тэр ном сургаалаа анх айлдаж эхэлж байхдаа, маш олон гэлэн, гэлэнмаа болон бусад хүн байна, тэд бүгд олон сая арга замаар бүгд л залбирч, Бурхныг шүтэн мөргөж байдаг. Хорин дөрвөн цагийн туршид энэ дэлхий дээр бүгд л Бурханыг шүтэн биширч байна. Гэсэн хэдий ч хичнээн цөөхөн Их Багш байгааг хар даа гэж хэлжээ.

Б: Тийм, тэднээс хэд нь бүрэн гэгээрсэн билээ дээ? Тийм шүү.

А: Тэгвэл яагаад ийм байдаг юм бэ? Сая сая сүсэгтнүүд мөргөж залбираад байсан атал яагаад ганцхан Гүрү Нанак байсан юм бэ?

Б: Чин үнэн сэтгэлээсээ бүхий л зүйлээ зольж, хатуужил хүлцэмжтэй амьдралаар амьдарсан учраас тэр.

А: Олон жилийн хатуу чанд амьдрал!

Б: Тийм, яг л Бурхан Багш шиг. Тэр цаг үед ердөө л ганц, эсвэл хамгийн ихдээ хоёр л байсан. Зөвхөн ганцхан Есүс. Хүн бүр Бурханд мөргөж, залбирдаг, бүгд л Бурхныг танин мэдэж, Бурханд хүрэхийн төлөө янз бүрийн золиос гаргасан байдаг; гэтэл хэн ч хүрч чадаагүй. Зөвхөн Есүс. Зөвхөн Будда. Зөвхөн Гүрү Нанак. Зөвхөн энэ хэдэн Их Багш л үүнийг чадсан.

А: Тэгэхлээр яагаад вэ? Энэ аль хэдийн урьдаас зурагдчихсан тавилан уу? Жишээлбэл, Гүрү Нанак гэгээрлийг олсон, тийм учраас Тэр Сикхизмийг үндэслэгч болсон гэх үү?

Б: Тийм.

А: Энэ нь тэгэхлээр төөрөг тавилан байх нь ээ?

Б: Тэр Диваажингаас сонгогдож, үүрэг даалгавар хүлээж авсан. Гүрү Нанак бүр хүүхэд байхдаа л огт өөр байсныг харахгүй юу.

А: Тэр үзэсгэлэнтэй, бас Гэгээнтэн байсан.

Б: Үгүй ээ, зөвхөн үзэсгэлэнтэй төдий биш. Түүнийг модон доор унтаж байхад нь нар шилжин хөдөлсөн ч сүүдэр нь хөдлөөгүй, яагаад гэвэл тэр мод нойрсож буй Түүнийг хамгаалахыг хүсчээ. Есүс бүр бага залуугаасаа л нигүүлсэнгүй байсан. Тэр ээжийгээ ядууст хувцсаа тарааж өг гэж хэлсэн байдаг. Ээж нь сүүлчийн хувцсаа өгөх эсэхээ бодоод байж байхад нь Тэр “Энэ эмэгтэйд өг” гэж хэлсэн. Тэгэхэд тэр бүр хүүхдээрээ байсан. Будда ч бас гоц гойд байсан.

А: Тэр бас бяцхан шувууны амийг аварсан.

Б: Бас Тэр энэрэнгүй нигүүлсэнгүй байсан. Тэр бяцхан шувуухайн амийг болон бусад элдэв зүйлийг аварсан. Тэд өөр. Мөн Буддаг Төгс баясгалант тэнгэрийн орноос бууж ирсэн Бодьсадва байсан гэсэн байдаг. Тэр эгэл жирийн хүн биш байсан. Тэрээр жирийн төрөлтнүүдийг Гэр лүү нь буцаан залахын тулд эгэл жирийн хүн болж төрсөн. Тийм ч учраас Есүс бол тэнгэрийн хүү, Будда бол Төгс баясгалант тэнгэрийн орноос ирсэн Бодьсадва, Гүрү Нанак бол диваажинд мэндэлсэн хэмээн өгүүлдэг. Тэр залуу байхдаа ч гэгээнтний шинж тэмдгүүдийг харуулсан. Энэ бас цуу яриа төдий юм биш, үнэний талтай.

А: Гүрү Нанакийг Меккад очиж, хар чулуу руу хөлөөрөө заасан гэж надад ярьсан.

Б: Тийм, энэ нь Бурхны ариун дүр байх ёстой байсан.

А: Тэр чулуунд хуруугаа хүргээгүй. Хөлөө жийн тавхайгаа хар чулуун дээр тавьсан.

Б: Уг нь их л... байх учиртай даа...

А: Их ариун чулуу.

Б: Тийм, хэн ч ингэх учиргүй.

А: Яг тийм. Тэгтэл өөр нэг эрэгтэй хүрч ирээд “Та энэ хар чулуу руу хөлөө жийж болохгүй!” гэжээ. Гүрү Нанак хариуд нь “За, тэгвэл миний хоёр хөлийг авч яваад Бурхан байхгүй газар тавьчих” гэжээ.

Б: Тийм, яагаад гэхээр чулуу тэнд байж байна, тэгэхлээр Бурхан тэнд байх ёстой байв. Тийм учраас Тэр “Тэгвэл би хөлөө тавьчихаж болохоор Бурхан байхгүй байгаа газрыг надад харуулаад аль” гэж хэлсэн гэдэг. Тэгтэл тэр хүмүүс нөгөө тал руу нь заажээ. Гүрү Нанак заасан зүг рүү нь хөлөө тавьтал чулуу босоод иржээ.

А: Чулуу хөдлөөд нүүчихсэн үү?

Б: Тийм, чулуу хөдөлж, Түүний хөлийг дагаад хөдөлсөн. Та тэгэхлээр юу мэдэхийг хүсээ вэ?

А: Түүнийг бас ниссэн гэж ярьдаг. Тэр нэгэн удаа Саудын Араб ч юмуу хаа нэгтгэх иймэрхүү газар байж байхдаа Мекка руу ниссэн гэдэг. Энэ үнэн үү? Шавьтайгаа цугтаа шүү. Энэ шавийг нь Мардана гэх бөгөөд үргэлж Түүнтэй тоглож наадаж, хамт хөгжим зохиож, Бурханд дуулж өгдөг байжээ.

Б: Энэ үнэн, эсвэл үгүй ч байж магад. Нисэхийг та ч сурч болно шүү дээ.

А: Агаарт хөвөх чадвар уу?

### Хувилгаан хүчний гайхамшигт ертөнц

Б: Тийм. Гэхдээ та дэндүү их юм мэдчихвэл дараа нь, яагаа вэ өнөөх Александрын номыг уншихад гардаг шиг...

А: Македоны Александр уу? Энэтхэгийг зорьсон Аугаа Александрыг хэлж байна уу?

Б: Үгүй, үгүй, Төвөд рүү явсан нь. Франц эмэгтэй.

А: Өө мэдэлгүй яахав. Александра Ниэль.

Б: Ниэль

А: Би мэднэ. Тийм, номыг нь уншсан.

Б: Тэр Төвөд рүү явахдаа...

А: Эрэгтэй хүн шиг, үгээгүй гуйлгачин шиг хувцасласан.

Б: Тэр эмэгтэй Хималайн ууланд олон эр хүн, нүцгэн эрстэй тааралдсан. Жишээлбэл, бүх биедээ гинжтэй, биеэ төмөр гинжээр ороосон Төвөд хүмүүс. Тэгээд тэд хаашаа ч ниссэн гинжээ авч явах хэрэгтэй байдаг, учир нь тэд их удаан хугацаагаар нисэх дасгал хийсний дараа бие нь дэндүү хөнгөн болдог байна. Тэд ийм гинжгүй бол цаг үргэлжид нисэж байх болно. Тиймээс тэд биеийн жингээ хянаж, заримдаа хоол хүнс авахаар газарт буух хэрэгтэй тул гинж ашиглах хэрэгтэй болжээ. Тэр эмэгтэйд заримдаа “Тар, няр!” гэх хяхтнаан сонсогдож байжээ. Тэр хүнийг газардах үед гинж нь ийм чимээ гаргаж байж л дээ, ойлгож байна уу. (Инээлдэв)

Тийм учраас та хүсвэл Төвдөд очиж нисэх дасгал хийж болно. Нисэх чадвар эзэмшихэд маш олон жил шаардагддаг.

А: Хэсэг лам намайг “Дүмэ” (хүйсний хүрдний бясалгал) хийх гурван жилийн даяанд урьсан юм. Энэ нь дулаанаа хадгалахыг хэлж байгаа юм. Би тэдэнд “Үгүй ээ, юунд хэрэгтэй юм бэ?” гэсэн. Энэ нь надад утга учиртай зүйл шиг санагдаагүй л дээ.

Б: Бидэнд халаагуур байдаг. Төвлөрсөн халаалт.

А: Бидэнд төвлөрсөн халаалт байна, бас дээр нь би Бурхныг, Бурхныг л таньж мэдэхийг сонирхож байна.

Б: Халаалтыг сонирхсон ч юм биш, тийм ээ? Гэхдээ юу гээч, та тэрийг сурах байж дээ.

А: Яах гэж тэр билээ?

Б: Хувцас хатаах маш олон машиныг хэмнэнэ. Та хэдхэн хормын дотор хувцсаа хатаачихна. Усаар угаах, эсвэл хуурай цэвэрлэгээ хийх шаардлагагүй, хатаагчид хийхгүй гэсэн үг. Хатаагч авах мөнгөө хэмнэнэ. Маш хэмнэлттэй.

А: Гэхдээ би наранд хагаачихна л даа.

Б: Төвдөд нар эдэггүй тул тэдэнд ийм зүйл хэрэгтэйг мэдэж байна уу.

А: За тэр ч тийм шүү. Тэсгим хүйтэн.

Б: Осгом хүйтэн. Тий тий! Та өөрийгөө дүмэ (tumo) дулаантай, бас гэр бүлтэй байгаагаар төсөөл дөө. Гэрийнхэн чинь бүгд хувцсаа, гэрийнхээ бүх хувцсыг таны бие дээр хатаавал маш олон доллар хэмнэнэ. Гэрийнхэн чинь бүгдээрээ хувцсаа угааж дуусаад ердөө л “Алив, үүнийг биен дээрээ тавьчих” гэнэ. Тэгэнгүүт бүгд хэдхэн хормын дотор хатчихна.

А: Гэхдээ би Хималайд бүтэн гурван жил даарч хөлдөх байсан. Гурван жил даарч жиндэхийн зовлон амсахын ач тус гэж ч юу байхав!

Б: Та дүмэ дулааныг сураагүй учраас тэгжээ. Хималайн цастай ууланд маш олон йогч шалдан, хөл нүцгэн, гуталгүй, юу ч үгүй явж байхыг би харсан! Тэдний бие яв ягаан, бас халуун байсан.

### Иднэ, унтана, эсвэл үгүй

А: Шиваратри-д хоёр йогч байсан, тэд өөрсдийгөө хүмүүст харуулдаг юм. Тэд хэзээ ч иддэггүй, хэзээ ч унтдаггүй, ердөө л жижиг урцандаа байж байдаг. Тэд хүмүүст жилийн нэг л өдөр Шиваратри-д өөрсөд дээр нь ирэхийг зөвшөөрдөг. Йогчид гадаанаа сууж байдаг, бас том гүзээтэй. Яагаад юм бол? Би үүнийг огт ойлгодоггүй. Мөн хүзүү нь маш бадриун, үс нь их урт. Тэд хэзээ ч иддэггүй, унтдаггүй.

Б: Тэд агаараар хооллодог! Тэд чинь “агаар хоолтон.” Та үүнийг ч бас сурч болно.

А: Яаж?

Б: Яахав дээ, тэдэн дээр явж очоод хамт суралц!

А: Гэхдээ тэд зааж өгдөггүй. Тэд өнөөх хоёр урцандаа үргэлж нуугдчихдаг. Тэдэнтэй хэн ч уулзах, эсвэл ярилцах боломжгүй.

Б: Хэрвээ тэд хүмүүстэй дэндүү удаан ярилцвал үхчихнэ.

А: Тэд юм ярьдаггүй. Тэд гадаалсан өдрөө ч бас ярьдаггүй. Зүгээр

л тэнд гадаа сууж байдаг. Хүмүүс тэднийг арван хоёр цагийн турш үзэж ширтэж болно, харин тэд дуугардаггүй.

Б: Формосад нэг хүн байсан, эмэгтэй хүн, гэлэнмаа. Тэр өөд болтлоо хориод жил юм идээгүй. Германы Бавариас ирсэн Тереза Гэгээнтэн бас юм иддэггүй байсан.

А: Тэр зөвхөн ариун ёслолын зоог хүртдэг үү (Эвхаристын өргөлийн жигнэмэг)?

Б: Тийм бага зэрэг. Бид идэх дадал зуршлаа хаях талаар дасгалжиж болно. Энэхэгт нэг эрийн түүхийг надад ярьж өгсөн. Тэр маш эгэл нэгэн байжээ, ямар нэг төрлийн бясалгагч байгаагүй, гэхдээ өдөр бүр багахан давстай ус л уудаг. Ингээд л боллоо. Тэр юу ч иддэггүй. Энэ нь ямар ч байлаа гэсэн сүнслэг зүйл биш. Бидний бие махбод уян хатан тул түүнийгээ ямар ч чиглэлээр дасгалжуулж болдог.

Би ч бас нэг удаа идэх зуршлаасаа бараг л татгалзсан, гэтэл Бурхан үүнийг хүсээгүй. Тэр “Болохгүй” гэж хэлсэн тул би юм иддэг хэвээрээ үлдэх хэрэгтэй болсон.

А: Харин Та тун бага иддэг!

Б: Тухайн үед бол би хоол хүнснээс... их сүрддэг байлаа. Юу ч идлээ гэсэн тийм нэг.. зангирсан, бас бөөлжис хүрэм мэдрэмж төрөөд дахиж юм идмээргүй болчихдог. Би нилээн удаан хугацаагаар юм идэхээ больсон байсан. Гэтэл Бурхан “Болохгүй. Та жирийн байдлаараа бай. Тэгэхгүй бол хүмүүс ердөө л юм иддэггүй гэдгээ тань болоод л тан дээр ирдэг болно” гэж хэлсэн. Тэгэх юм бол тэд гэгээрлийн талаар тас мартаж болно. Тэд ердөө л ходоодоо яаж цагтах тухай л асууна.

Формосад суудаг, мацаг барьдаг нэг гэлэнмаа юм иддэггүй, бас юу ч ярьдаггүй байсан. Гэтэл Энэтхэгт мөн өөр нэг эмэгтэй байсан, бас их алдартай. Тэр юм иддэггүй боловч ярьдаг байсан.

А:Тийм, би түүний тухай сонссон. Түүнтэй уулзахыг завдаж байсан.

Б:Тэр одоо байхгүй л болов уу даа.

А:Тийм, одоо өөд болчихсон байх аа.

Б:Түүний хувьд сайн хэрэг байна.

А:Тэгэхлээр, Бурхныг эрэлхийлдэг хүмүүст Их Багш нь юм иддэг, эсвэл хувцас өмсдөг үү, үгүй юу гэдэг нь ер хамаагүй. Энэ нь ерөөсөө чухал биш гэж би хэлэх гэсэн юм.

Б: Тийм. Тэд үүнд санаа зовох хэрэг байхгүй.

А: Тэгэхлээр хоол хүнс хэрэгцээтэй байдаг нь махбодын дүрэм үү?

Б: Дүрэм ч бас биш юм аа. Ерийн л хэрэг явдал юм даа, гэсэн ч бид өөрийгөө сургаж бэлтгэж чадвал, бас хэрвээ юм идэхгүй байх хувь төөрөг байвал идэхгүй байж болно. Хэрвээ урд насандаа юм идэх буянаа дуусгачихсан бол бид энэ насандаа төрлөө ч гэсэн ч дахиад юм

идэх ёсгүй. Бидний “сан хөмрөг”-т юм идэх буян байхгүй тул бид юм идэх ёсгүй. Хэрэв байгаа бол бид идэх ёстой. Тэгэхгүй бол бид дахин буцаж ирж, дараагийн амьдралдаа бүгдийг нь идэж барах хэрэгтэй болно. Тиймээс зүгээр л жирийн байгаарай. За юу.

А: Нойрны хувьд ч бас ийм байдаг уу? Яагаад гэвэл ихэнх Их Багш унтдаггүйг би анзаарсан.

Б: Өө! Унтах уу, эс унтах уу. Зөвхөн бие махбод л унтдаг юм, сүнс хэзээ ч унтдаггүй. Би унтаж ч чадна, унтахгүй байж ч чадна. Энэ нь ямар ч ач холбогдолгүй. Хэрвээ би унтахгүй байвал яаж цаг нөхцөөх вэ? Би унтаж чадаж байгаадаа дандаа талархаж байдаг, тэгвэл цаг хурдан өнгөрдөг. Самадигийн тухайд бол би унтсан ч, сэрүүн байсан ч үргэлж дотор нь оршиж байдаг. Тэгэхээр ямар ялгаа байна аа?

### Ийшээ зөвхөн “Солиотой” нь л бууж ирэхээр шийддэг

А: Жишээлбэл, Бодьсадва гэхэд л тэр буцаж ирэх ёстой, тэгээд ахин дахин бие махбод авдаг. Тэгэхлээр унтах нь бусдын зовлонг харахаас түр зуур зугтах арга зам юм уу?

Б: Яагаад? Бодьсадва яагаад ахин дахин буцаж ирэх ёстой болдог билээ?

А: Яахав, тэд надад тэгж л хэлсэн. Их Хөлгөний дэг сургуульд хүн бүрийг Будда болох хүртэл Бодьсадва ахин дахин буцаж ирдэг гэсэн байдаг.

Б: Тийм, гэхдээ бүгд биш. Ер нь бол Бодьсадва нар ээлжилж ирдэг. Зарим нь диваажинг хэзээ ч орхиж үзээгүй байдаг.

А: Тэгвэл өөрсдийнх нь сонголт уу? Тэд зүгээр л тэндээ үлдэж болох уу?

Б: Тийм! Зөвхөн “солиотой” нь л энд ирэх сонголт хийдэг юм. (Инээлдэв)

А: Зүгээр л тэндээ амар тайван үлдэж, Судар уншин жаргаад сууж байвал болох нь ээ?

Б: Тийм. Гэхдээ тэгвэл... Их Багшгүй байх болно.

А: Их Багш нартай байх ёстой юу, яагаад? Их Багштай хамт бол бид хэзээ ч зовж зүдрэхгүй!

Б: Үгүй! Хэрвээ бүх Их Багш диваажиндаа үлдэн жаргалтай байвал та нар энд зовно.

А: Өө! Тийм юм байна, хэрвээ Их Багш байхгүй байвал. Ай, үнэн үнэн!

Б: Тийм. Их Багш байхгүй бол та нар энд зовно.

А: Энэ ч гарцаагүй л дээ.

Б: Тиймээс зарим нэг “солиотой” Их Багш бууж ирэх ёстой юм.

А: Тэгэхлээр Их Багш бууж ирэх үедээ аль хэдийнээ гэгээрчихсэн байдаг уу, Тан шиг, өөрөө?

Б: Тэгэлгүй яахав. Түүнийг мухар сохроор буугаад ирсэн, эсвэл андуураад үсэрчихсэн гэж та бодож байна уу? Эсвэл, автобусаа андуурчихсан байдаг ч юм уу? (Инээлдэв)

А: Гэтэл дараа нь, жишээлбэл, Сикхүүдийн аравдугаар Гүрү хэмээдэг Гүрү Говинда Сикх хүүхдүүдийг нь хана руу шахаж, амьдаар нь булшлахыг харсан. Их Багш ирээдүйг мэддэг учраас Тэр ийм явдал болохыг мэдэж байсан. Тэгвэл тэр яагаад хүлээн зөвшөөрсөн юм бэ? Тэднийг ингэж үхүүлэхгүйн тулд Тэр энэ нөхцөл байдлыг өөрчилж чадахгүй байсан гэж үү?

Б: Үгүй, Тэр тэгж чадаагүй. Тэр чадна л даа, гэвч Тэр ингэхийг хүсэхгүй. Бид яагаад Бурхны тааллыг зөрчих ёстой гэж? Бид яагаад сүнснээс илүүгээр бие махбодод санаа тавих ёстой юм? Бурхан таны биеийг, эсвэл өөр хэн нэгний биеийг цаашид ашиглахыг хүсэхээ больвол ямар нэг аргаар буцаагаад авчихна. Үхсэнээр нь үү, эсвэл амьдаар нь оршуулсан уу алин нь ч ялгаагүй. Үхсэн ч бай, амьд ч бай биднийг эрт, орой тэртээ тэргүй л оршуулна. Их Багш нарын хувьд эртхэн буцаж явах тусмаа л тэдэнд сайн. Зовлон нь бага. Энэ бие махбодод амьдрах нь юу нь тийм сайхан юм бэ? Энэ физик ертөнц Их Багшид юу өгч чадах юм бэ?

### Нэг хувраг нь унтаж байхад нөгөө нь бясалгаж байдаг

А Буэно! Гэгээнтнүүд байдаг, бас Бурхан байдаг гэж ухамсар маань мэдэж байдаг, ингэж бодож байхдаа тэр үргэлж жаргалтай байж чадах уу?

Б: Нэг талаар бол тийм. Гэвч нөгөө талаар бол тэр өөрийгөө үргэлж тэр төвшиндөө байлгаад байж чадахгүй. Хүмүүсийн гэм нүглийн төлөө тэр бас зовох ёстой. Буддагийн нэг маш өндөр дээд дэсийн шавийн нэг нь, түүнийг хэн гэдэг билээ дээ...?

А: Ананд уу?

Б: Үгүй ээ, биш, биш! Жирийн хүн.

А: Кашьяпа юу?

Б: Үгүй. Кашьяпа бол гэлэн. Буддагийн маш алдартай шавь, жирийн нэг хүн байсан даа. За хамаагүй. Би уул нь мэднэ л дээ, ердөө л мартчихаж, за юу? (Их Багш Вималакирти-г хэлж байна) Тэр өвчтэй байсан. Тэр өвдсөн байж. Тэр бүү хэл, тэрээр бүх гэлэнгээс ч дээгүүр байсан. Маш ухаалаг, гэгээрсэн хүн байсан. Гэлэнгүүд бүгд түүнээс эмээдэг байв. Тэгээд хэн нэг нь түүнээс нэгэнтээ: “Чи яагаад өвдөөд байгаа юм бэ? Та бол гэгээнтэн. Танд үйлийн үр байхгүй. Чи яаж өвдөж

чадаж байна аа?” гэж асуужээ.

Тэр “Хамаг амьтан өвчтэй байна, тиймээс би ч өвчтэй байгаа юм” гэжээ.

Яагаад гэвэл Гэгээнтнүүд маш мэдрэмтгий, тэд хамаг төрөлтөнтэй нэгдмэл. Тийм учраас тэд төрөлтөн бүрийн зовлонг мэдэрч чадна, тиймээс бага сага өвддөг, хүн бүрийн, төрөлтөн бүрийн зовлонгоор жаахан жаахан өвддөг. Шархалсан зүрх анир чимээгүй байдаг. Үүнийг хэн ч сонсож чадахгүй, гэтэл Гэгээнтэн хүн л сонсож чаддаг.

Хятадад байсан хоёр гэлэнгийн тухай хөгжөөнтэй түүх бий. Байнга бясалгал хийж, ууланд суудаг нэгэн лам байжээ. Тэр маш цэвэр ариун, дээдийн номын амьдралаар амьдарсан. Бас нэг үргэлж нааш цааш явж байдаг, хэзээ ч бясалгал хийдэггүй бололтой өөр нэг лам байжээ. Нэгэнтээ огт бясалгал хийдэггүй лам нь нэг өдөр ууланд суудаг бясалгагч гэлэнгийн овооход очиж, тэндээ нэг шөнө хоногложээ. Эхний лам нь үргэлжид нэн ариун байсан бөгөөд хэнтэй ч харилцахыг хүсдэггүй, хэнийг ч хүлээж авахыг хүсдэггүй байжээ. Гэтэл хоёр дахь лам зүгээр л тэнд хэвтээд унтчихжээ. Тэгэхлээр тэр юу хийж чадах билээ? Шөнөжин хурхирч гэнэ. Өглөө нь ариун Гэгээнтэн түүн дээр ирэн загнаж, “Чи шөнөжин хурхирлаа! Миний бясалгалд саад боллоо! Муухай, шуугиантай лам гуай! Өөрөө бясалгадаггүй мөртлөө миний бясалгалыг үймүүлчихлээ!” гэжээ.

Тэгэхлээр нь унтаахай лам хариуд нь загнажээ. Тэр: “Чи бол муу хөгийн гэлэн! Чи бясалгаж байхдаа самадид ч орж чаддаггүй. Чи эргэхдээ нэг шоргоолжийг алж, өөр нэг шоргоолжны хөлийг хугалсан. Тэр шөнөжингөө уйлсан! Тэгээд би унтаж чадсангүй!” гэжээ. (Инээлдэв)

А: Энэ тун дажгүй түүх байна.

Б: Өөр өөр дэс төвшин. Ердөө л энэ. Харин чи бас гэртээ харихдаа шоргоолжны хөл гэмтээж надад төвөг удуузай.

А: Энэ нь бясалгал харилцан адилгүй гэдгийг харуулж байна уу?

Б: Тийм. Хятадын Лин Чи хэмээх Их Багшийн тухай ч түүх бас байдаг. Их Багш Лин Чи шавь байхдаа үргэлж унтаж байдаг байжээ. Тэр хаана ч хамаагүй унтчихдаг. За одоо та дуурайчихав даа! За? Би таны тухай биш, Их Багш Лин Чигийн тухай ярьж байна. Нэгэн өдөр тэр бясалгалын өргөөний нэг буланд унтаж хэвтсэнээ Их Багш нь орж ирж байгааг хармагцаа айсан дүр эсгэж, уутан хөнжил, дэрээ аваад нуугдах гэж өөр нэг буланд очоод дахиад л унтчихжээ – үргэлжлүүлсэн хэрэг! Их Багш нь Лин Чи-г мэддэг байсан. За, тэр хоёр бие биеэ сайн мэддэг байж. Тэгээд Их Багш бясалгалын өргөө рүү шууд зүглэж очин тэнд суугаад бясалгаж буй нэгэн ламыг харснаа түүнийг өшиглөн “Хөөе, унтаахай лам аа! Юу хийж байгаа дүр эсгээд байгаа юм бэ? Чи тэнд байгаа Лин Чи шиг бясалгаж сураач” гэжээ. (Инээлдэв)

Лам үүнд итгэж чадсангүй. Гэтэл харин тэр лам яаж сууж

байсныг мэдэх үү? Орхимжоо нөмрөөд Буддагийн баримлын өмнө нэр төртэй нь аргагүй сууж байсан ч бөгс лүүгээ өшиглүүлжээ. (Инээлдэв) Урдаа нэг хүж уугиулаад тавьчихсан - хүж уугиж дуустал суудлаасаа огт хөдлөөгүй. Гэвч тэр дотооддоо хөдөлж байж. Тийм учраас л Их Багш хөнжлөөрөө толгойгоо бүтээчихсэн Лин Чи-г бясалгаж байна гэсэн атлаа сууж байгаа ламыг унтаж байна гэж хэлсэн байна. Ойлгож байна уу? Энэ бол өөр өөр дэс төвшин.

Тийм, Лин Чи унтаж байсан, гэхдээ хэзээ ч унтдаггүй байж. Тэр зөвхөн бие махбодоо унтуулсан. Оюун санаа нь үргэлж гэрэлтэж байсан. Тэр юу ч хийж байлаа гэсэн үргэлж Жинхэнэ-Би дотроо төвлөрдөг. Тэрээр төвөөсөө огт хазайдаггүй байж. Гэтэл тайрсан мод шиг сууж байсан тэр ламын бодол санаа тал тал тийшээ үсчээд юу ч хийж чадсангүй. Тиймээс анхаарлаа төвлөрүүлэхийг хичээгээрэй, бусад хүний гадна төрх байдлыг битгий шүүмжил.

Бясалгагч шавь нар гэхэд л зарим нь гаднаа харагддаг шигээ биш байдаг. Хэн нэг хүн надаас “Нүүр царайны хоорондох ялгаа юунд оршдог вэ, хүмүүст ямаршуу өөр өөр царай зүс байж болох вэ?” гэж асууж байгаа юм шиг. Энэ нь ямар ч ач холбогдолгүй. Хэрэв зарим хүн намайг өдөржин дагаж явах юм бол “Өө, Их Багш юу хийдэг вэ? Хоол идээд, унтаад л юу ч хийдэггүй” гэж бодно. Гэтэл бусад шавь нар маань Их Багш дэлхийн өнцөг булан бүрт хоногийн хорин дөрвөн цагийн турш ямар завгүй байдаг тухай янз бүрийн түүхийг өгүүлж ярина.

Тэгэхлээр, Их Багш ямар харагддаг, Их Багш юу хийдэг гэдэг нь өөр өөр зүйл. Их Багш ямар харагддаг нь бидний дэс төвшнөөс хамаарна. Бид өөрсдөө Их Багшийн дэс төвшинд хүрчихвэл, эсвэл хаа нэгтээ нь зэрэгцэж очсон үедээ л Их Багшийг ойлгоно.

## Үзэгдэх байдал хуурмаг

А: Зэн буддизмын хоёр хувраг салхилж яваад нэг хувраг нь нэгэн эмэгтэйд олж харсан тухай бас нэгэн түүх бий.

Б: Өө тийм! Алдартай түүх.

А: Тэр эмэгтэй нэг хүүхэдтэй байсан бөгөөд гол гатлахад бэлэн байв. Гэвч тэр гаталж чадахгүй болов уу гэж айжээ. Ийнхүү аргаа барж буйг нь хараад нэг лам нь даруй явж очоод түүнийг мөрөн дээрээ өргөн нялх хүүхэдтэй нь хамт голын нөгөө эрэгт гаргаж өгч, тэнд үлдээгээд нөгөө лам руугаа буцаж иржээ. Тэд Зэн буддист учраас ярих нь бага. Гэтэл хоёр цагийн дараа нөгөө лам түүнээс “Чи эмэгтэй хүний биед хүрч яаж зүрхэлж байна аа?” гэжээ.

Б: Тэр байтугай тэврээд гол гаргаж өгсөн!

А: Бүр тэврээд гол гаргаж өгсөн! Тэгтэл хоёр цагийн дараа эхний



лам нь “Би түүнийг тэврээд гол гаргаж өгчихөөд тэнд нь үлдээсэн. Харин та түүнийг тэвэрсэн чигээрээ л байгаа бус уу!” гэж хариулсан байдаг.

Б: Тийм. “Чи түүнийг энд ч тэвэрсэн чигээрээ л байна.” Сэтгэлийн хүлээс.

А: Сэтгэлийн хүлээс үү?

Б: Гадна талын сахил, бас дотор талын сахил. Гэгээнтнүүд болон Их Багш нар юм хийхдээ тухайн зүйлдээ сэтгэл хүлэгдэхгүй хийдэг. Тэд зүгээр л хийх ёстой зүйлээ л хийдэг. Тэр бүү хэл, гадна талдаа адилхан харагдаж байлаа ч гэсэн, өөр хүмүүс юу ч юм хийж л байдаг, учир нь дадал зуршил юмуу, хүсэл шунал нь үүнийг хийхэд хүргэдэг.

Хятадад их алдартай нэгэн Их Багш байжээ, хаантан түүнд их хайртай тул тэр Их Багшид арван гурван эхнэр хишиг болгож өгчээ. Хаад өөрт таалагдсан хүндээ сайхан бүсгүйчүүдийг бэлэглэдэг заншил байдгийг мэднэ биз дээ. Хэрэв хааны хишгээс татгалзвал цаазлуулна. (Инээлдэв) Цаазын дүүжлүүр хүлээж авна. Тиймээс Их Багш мэдээжээр бүсгүйчүүдийг хүлээж авчээ. Тэр үед бүх шавийнх нь сэтгэл догдолжээ, шавь нар нь мэдээж бүгд эрэгтэй шүү дээ. Тэд “Багш аа, та арван гурван эхнэртэй байж чадаж байгаа юм чинь бид ядаж ганц хоёртой байж болох биш үү. Бидэнд хоёр, гурав байсан ч болох юм байна” гэжээ.

Тэгэхээр нь Их Багш атга дүүрэн сүлбээр зүү аваад залгичихаж, тэгснээ “Та нар хэрвээ ингэж чадвал бүр гучийг ч авсан болно” гэж хэлэв. Шавь нар нь бүгд хэлээ гаргаад амаа хамхижээ.

Гэхдээ энэ бол мэдээж дэндүү туйлширдаг Их Багш байна. Тэр хувилгаан хүчээ гайхуулахын төлөө ингэх хэрэггүй байсан юм. Тэр учир зүйн ухааныг ашиглаж болох байсан. Энэ л хангалттай шүү дээ.

Их Багш болон шавь нарынх нь хооронд ялгаа бий. Их Багш маш даруу, үүнийгээ хэзээ ч мэдэрдэггүй, эсвэл үзүүлдэггүй ч гэсэн ийм байх ёстой юм. Гэхдээ бид Их Багш нар юу хийж чадах, харин бид юу хийж чадахгүйгээ ажиглалт, зөн совингоороо мэдэж, харах ёстой. Харин энэ их багш шавь нартаа сэтгэгдэл төрүүлэх гэж ид шид, шууд увдис шид хэрэглэхэд дулдуйдаж байгаа бол олиггүй л их багш байж таарлаа. Тийм биш бол түүнд ингэх хэрэг байхгүй. Тэгэхгүй. Хэдхэн авшиг хүртээлтэй дараа шавь нар нь Их Багшийн хүчийг мэдчихсэн байх ёстой доо. Бусад шавийн цөөн хэдэн сэтгэгдлээ ярьсны дараа л тэд хэдий өөрсдөө хувийн туршлагагүй байсан ч, их туршлагагүй ч их багшийн хүчийг мэддэг болчихдог.

## Мөнгө, бэлэг сэлт, цэвэр ариун байдлаа хадгалах тухай асуулт

Б: Өөр бас нэгэн түүх байдаг. Энэтхэгт нэг Их Багш таван зуун шавьтай байжээ. Үнэндээ тийм ч өндөр дэстэй Их Багш биш, жирийн л багш, гэхдээ тэр ирээдүйг харж чаддаг байж. Хоёрдугаар төвшний багш байх. Хэрвээ хэн нэг хүн түүнд өргөл өргөхөөр урьвал, үдэшлэг уулзалтанд явахдаа тэр ерөөсөө шавь нараа хэзээ ч дагуулж явдаггүй байжээ. Тэгтэл нэгэн өдөр шавь нар нь тэвчээрээ барж, “Их Багш аа, та үдэшлэгт явах болгондоо ганцаараа явдаг. Бид ажиллаад л ажиллаад л байдаг, харин та бидэнд хэзээ ч ийм таашаал эдлүүлсэнгүй. Тийм болохоор энэ удаад та биднийг дагуулж явахгүй бол бид таныг орхиж одно” гэжээ.

Ингээд Их Багш тэднийг дагуулаад явжээ, тэр цагаас хойш үргэлж авч явдаг болов. Энэ амьдралынхаа дараа Их Багш дахин дээд, илүү өндөр дээд бүлгийн, нэр алдартай лам болон дахин төржээ. Тэр хаашаа ч явсан түүний хойноос таван зуун фламинго шувуу нисэж явдаг болжээ. Энэ бол түүний урд төрлийнх нь таван зуун шавь нь бөгөөд олон түмний өргөлийн буяныг шингээж чадаагүй ажээ. Яагаад гэвэл тэдэнд үүнийг эдлэн жаргах хангалттай адислал, хангалттай цэвэр ариун байдал, хангалттай бясалгалын буян байгаагүй ажээ.

Зөвхөн Их Багш, шавь хоёрын хооронд гэлтгүй бас хүмүүсийн хооронд ч ялгаа байдаг. Тиймээс л би та нарт ариг гамтай бай, харин битгий шунахайр, өөрт оногдох хувиа хэтрүүлэхгүй бай гэж заадаг. Байгаагаасаа илүүг бүү зарцуул. Хэрэгцээ шаардлагатай үед л ав, ашигла. Тийм биш бол ингэхгүйг хичээ. Эс бөгөөс бид асуудалд орж мэднэ. Заримдаа бид өвдөж, эсвэл эдгэршгүй өвчин тусаж ч мэднэ.

Бясалгал дадуулдаг нэг хүнийг би таньдаг байлаа. Тэр дандаа л бусдын орлогоор амь зуух гэж оролддог, бас үргэлж гэдэс нь гүйлгэдэг байсан. Ариун бус өргөлөөс болж тэр! Заримдаа бид ариун бус хүнээс бэлэг авбал тэр нь бидэнд нөлөөлдөг. Тэр бүү хэл, энэ нь бидэнд нөлөөлж байна гэдгийг нь заримдаа бид анзаарч мэддэг ч үгүй. Гэтэл энэ нь бид энэ хүнд, эсвэл энэ хүмүүст ямар нэг өртэй юм шиг болгочихдог. Бид тэднээс хамааралтай ч юм шиг санагдахыг мэдэрдэг ч яагаад үүнээс салж чадахгүй байгаагаа мэддэггүй. Заримдаа ийм зүйл болдог. Ердөө л тэдний бэлгийг хүлээн авснаас болж байгаа юм.

А: Гүрү Нанак болон түүнд мөнгө өгсөн баян, ядуу хоёр хүний тухай түүх байдаг. Гэвч Тэр зөвхөн ядуугийнх нь мөнгийг л авсан. Тэгэхлээр нь баян эр ихэд бухимдаж, Гүрү Нанакаас “Та яагаад миний мөнгийг авсангүй вэ, үүгээр та их зүйл амжуулна шүү дээ?” гэжээ.

Б: Цус!

А: Гүрү Нанак тэр хоёрт тус бүрд нь чапати-бин өгчээ. Дараа нь баян хүнээс чапатиыг нь аваад шахтал түүнээс нь тэр баянд дарлуулж мөлжүүлсэн хүмүүсийн хүнд бэрх хөдөлмөрөөс үүдэлтэй цус гарч иржээ. Тэгээд Гүрү Нанак ядуу хүнээс чапатиыг нь аваад шахахад түүнээс нь сүү гарчээ.

Тэгээд л, жишээлбэл, Их Багш Чаран Сингх болон шавь нар нь хүмүүсээс огт бэлэг хүлээж авдаггүй байсан нь тэд үүнийг бохир гэдгийг нь мэдэж байсан учраас уу?

Б: Тэгэлгүй яахав!

А: Тэгээд бас зөвхөн ажлынхаа л төлөө юм авдаг байж. Хэрвээ олон түмэнд хоол хүнс өглөө гэхэд өлсгөлөн хүмүүст өгөхийн тулд л авдаг гэх юмуу даа. Гэхдээ тэр хэзээ ч хувьдаа бэлэг авдаггүй, эсвэл ашрамд зориулсан бэлгийг хүлээж авдаггүй. Бас зарим нэг хүнээс бол ерөөс юу ч хүлээж авдаггүй.

Б: Тэр идсэн хоол, эсвэл шавь нараасаа авсан зүйлийнхээ төлбөрийг үргэлж төлдөг байсан. Тэр өөрийнхөө хувийн үйлийн үрд санаа зовдог. Маш их санаа зовдог.

А: Хөөх! Тэр үүнд санаа зовдог гэж үү!?

Б: Тийм, мэдээж шүү дээ. Түүнээс биш ядаж л шавь нараасаа авч болох л байсан. Тэр аль ч айлын, бүр шавийнхаа гэрээс ирсэн хоолыг идсэн ч хоол бүрийн төлөө төлбөр төлдөг байсан.

А: Өө, бүр шавийнхаа гэрээс үү! Үүнийг би мэдээгүй юм байна.

Б: Түүний буян хишиг нь хангалттай их биш учраас тэр байх л даа, өөрөө ч үүнийг мэдэж байсан. Шавь нартаа үлгэр дуурайл үзүүлэхийг хүссэн ч байж магад. Бүр ийм нэгэн Их Багш хүртэл бусдын өргөлийг хүлээж авч зүрхлээгүй байтал бид хэрхэн зүрхлэх юм бэ? Тийм ч учраас би бүх гэлэн нартаа бусдаас хэзээ ч, юу ч авахгүй байхыг сургадгийн учир нь энэ.

А: Хувраг биш, амьдралдаа байнга бэлэг солилцдог бусад хүн яавал зохих вэ?

Б: Шаардлага гараагүй бол бусдаас юм авахгүй байхыг хичээ, танд хүн юм өгвөл, хамаатан садан чинь байсан ч ялгаагүй та хариуд нь ямар нэг зүйл өгөхийг хичээгээрэй гэж би та нарт заасан. Нөгөө ном, жижиг номд би та нарт үүнийг заасан байгаа. Авшигийн дараа би та нарт бяцхан ном өгсөн шүү дээ.

А: Би тэрийг уншиж амжаагүй л байна, гэхдээ үүнийг мэдсэн маань сайн хэрэг боллоо. Та надад сая хэлж өглөө.

Б: Та тэрийг унших ёстой!

А: За, би уншина аа.

Б: Авшиг хүртэхээсээ өмнө таны авсан зүйл бол зүгээр ээ, болно, та мэдээгүй байсан шүү дээ. Харин авшиг хүртсэний дараа та юу идэж, юу авч, бүр хэнтэй шүргэлцэхээ ч анхаарч сэрэмжтэй байх ёстой шүү.

А: Өө! Тэд өнөөдөр намайг цай уухыг урьсан. Энэ чухал биш, тийм үү? Би алтан товч цэцгийн цай уусан.

Б: Тэр бүү хэл, таны хажууд сууж байгаа, эсвэл шүргэлцсэн хүн ч танд маш хүчтэй нөлөөлнө. Хэрвээ та сайн бясалгадаг, бас үргэлж Бурхан дээр төвлөрдөг бол танд хэн, юу өгөх нь хамаагүй – аар саар зүйл, ингээд л боллоо. Энэ тийм ч их ач холбогдолгүй. Хэн нэгэн танд хүрч, эсвэл тэврэх нь тийм ч үр нөлөөтэй биш. Харин хэрвээ та сайн бясалгадаггүй, бас энэ замд дөнгөж шинээр ороод байгаа, юм бүхэнд зүгээр л тоомжир болгоомжгүй байдаг, юуг ч хамаагүй идэж, хэнийг ч хамаагүй тэвэрч, хүрч шүргэлцэж байдаг бол та үргэлж асуудалд орно. Мэдээж, хэрвээ та адислал болон хүч чадлаар нэн аугаа бол таны гараа хүргэсэн бүхэн хувиран өөрчлөгдөнө. Харин та тийм ч сайн төлөвшөөгүй байгаа бол тэд таныг өөрчилнө.

Тийм учраас та сүнслэг биш хүмүүсийн дунд байх үед илүү хүнд мэдрэмж төрж, таны төвшин унана, та нүд ирмэх зуур бараг тэдэн шиг болно! Энэ яг үнэн гэдгийг та мэдэж байна уу.

А: Тийм, яг үнэн. Би үүнийг амсаж туулсан. Би мэднэ!

Б: Тийм, та өөрөө үзэж мэджээ. Тийм! Тийм! Би та нарт худал юм хэлэхгүй. Тэр байтугай Их Багш ч түр зуур бохирддог. Тэгвэл жирийн хүмүүст энэ нь ямар байх вэ? Гэхдээ насанд хүрсэн хүн, хүүхэд хоёрын хооронд мэдээж ялгаа бий. Хэрвээ хүүхэд шавартай цөөрөмд уначихвал тэр өөрийгөө цэвэрлэж чадахгүй. Гэтэл том хүн уначихвал өөрөө гарч ирээд даруй цэвэрлэх хэж чадна. Үүнд л ялгаа нь байгаа юм. Ойлгож байна уу?

А: Би ойлгож байна.

Б: Тиймээс би хуврагууддаа жолоо барих, мөнгө авах, эсвэл хүмүүст хүрэх үедээ бээлий өмсөх ёстой шүү гэж заадаг.

А: Бээлий юу?

Б: Бээлий. Тийм. Тийм ч учраас эртний лам нар, тэр байтугай орчин үеийн лам нар таны биед ер хүрдэггүй. Энэтхэгчүүд хүнд адистай хоол хүнс өгөхдөө түүнийгээ хоёр километрийн цаанаас гар дээр чинь унагадаг.

А: Тийм, тийм, үнэн шүү.

Б: Тэд зөвхөн жирийн хүмүүс гэлтгүй гэлэн, гэлэнмаа нарт ч бас ингэдэг. Надад бас л ингэсэн. Тэд надад адистай хүнсээ тэнгэрээс өгсөн! Таазнаас! Хэн нь хэнийгээ адисалсан юм бүү мэд. Би тэр адистай хоолыг дараа нь үнээтэй хуваалцсан.

Энэтхэгт “хүний биед хүрэхгүй байх” заншил ингэж л үүссэн аж. Үүнд муу юм байхгүй. Авшиг хүртээгүй хүмүүсээс авах бохирдлыг маш багасгах, зайлсхийх гэсэн авшигтан хүмүүсийн оролдлогоос л үүсжээ. Гэтэл одоо тэд үүнийг утга агуулгагүй зан заншил болгочихсон. Тэд бүгдээрээ хамт бохирддог. Хүний биед их, бага шүргэлцэхэд юу нь

муу гэж? Аль алин нь, “шүргэсэн” болон “шүргүүлсэн” нь хоёулаа л ижил. Жинхэнэ бярманууд бол эрт дээр үед амьд сэрүүн Их Багштай байх үедээ авшиг хүртсэн хүмүүс юм. Тэгээд Их Багш нь тэнгэрт халиад бас хойч үеүд нь үхээд тэр удам угсаа байхгүй болсон. Эдгээр Бярман гэр бүлээс төрсөн хүүхдүүд өөрийн гэх Их Багшгүй, авшиггүй, ариун байдалгүй, юу ч үгүй. Аль алин нь бохирдож, бузартсан хэр нь энэ ёс заншлаасаа болоод тэд бусдад гараа хүргэж ч зүрхэлдэггүй.

Сүнслэг өв соёлоос маш олон ёс заншил үлдсэн байдаг. Тийм ч муу юм биш л дээ, зүгээр л утга агуулгаа алдчихсан, тэгээд л тэр. Жишээ нь, Гэгээн Иоанн шиг, тэр агуу гэгээнтэн байсан. Тэр хүмүүст усаар загалмайж авшиг (баптизм) хүмүүсийг цэнэглэх Хүч чадал өөрт нь оршиж байсан. Харин өдгөө цагт Сүмд байгаа тэд ямар ч Хүч чадал агуулаагүй атлаа хүн рүү зүгээр л ус цацаж байдаг.

### Жинхэнэ загалмайлах ёс нь Гэрэл, Аялгуутай байдаг

А: Есүс яагаад та ус болон Сүнсээр, хоёулангаар нь баптизм хүртэх ёстой гэж хэлсэн юм бэ?

Б: Үгүй ээ, Тэр тэгж хэлээгүй.

А: Сүм хийд санаанаасаа зохиож ярьсан гэж Та хэлж байна уу?

Б: Тэр тэгж хэлээгүй. Тэр хэзээ ч тэгж хэлээгүй.

А: Та ус болон Сүнсээр, хоёулангаар нь баптизм хүртэх хэрэгтэй гэж Тэр хэлсэн.

Б: Үгүй! Түүнийг баптизм хүртэх үед Иоанн “Үгүй ээ. Би яагаад Танд баптизм хүртээх гэж, Их Багш аа? Та надаас дээгүүр шүү дээ” гэж хэлсэн.

Харин Есүс “Хууль ёсоор болог” гэж хэлсэн, энэ нь заншсан ёсоороо л байг гэсэн утгатай.

А: Баптист Иоанн: “Миний араас өөр хүн ирж танд баптизм хүртээнэ” гэж хэлсэн.

Б: Тийм, Сүнсээр, Ариун Сүнсээр. “Би усаар баптизм хүртээдэг, гэхдээ миний араас ирэх хүн надаас илүү хүчирхэг, надаас агуу. Тэр танд Ариун Сүнсээр баптизм хүртээх болно” гэжээ. Энэ нь та дотоод дамжуулалтыг ашигла гэсэн утгатай. Ариун Сүнсээр.

А: Тэгэхлээр зөвхөн галаар гэсэн санааг Тэр хэлжээ дээ. Христийн шашинтнууд үнэхээр галаар баптизм хүртэх ёстой юу?

Б: Тийм, гал бас Ариун Сүнс. Энэ нь Гэрэл гэсэн утгатай.

А: Өө, энэ нь Гэрэл юм уу?

Б: Тийм, гал.

А: Харин хэлээр ярина гэсэн нь?

Б: Тэр бол Аялгуу.

А: Аа, Аялгуу байх нь!

Б: Тийм, тэд “Хэлээр ярина, Ариун Сүнс хэлээр ярина” гэж хэлдэг. Ойлгож байна уу? Дотооддоо ярина гэдэг нь энэ бол Аялгуу юм, бас гал нь Гэрэл гэсэн утгатай. Тэр цагт хүмүүс үргэлж Бурхан том гал шиг хүрч ирсэн гэж ярьдаг байжээ. Та ойлгож байна уу? Энэ нь тэр цагийн хэл байжээ. Тэгэхлээр, Есүс Арьяабалын аргаар бясалгаж байсныг би яагаад мэдээд байгааг та одоо мэдэж авлаа. Ингээд одоо, эцэст нь би танд хариулт өгчихлөө.

Эрт цагт Хятадад хүмүүс “Дэнлүү дамжуулах” гэж хэлдэг байсан шиг л юм. Дэнлүү нь дотоод дэнлүү. Дэнлүү гэдэг нь Гэрэл гэсэн утгатай. Гэрлийг төлөөлж байгаа юм. Тэр цагт хүмүүс Гэрэл уламжлахыг бэлгэдэхдээ энэ үгээр илэрхийлжээ. Харин хэдэн үе удам өнгөрсний дараа хүмүүс дэнлүүг сүмд тавьж, бие биедээ дэнлүү өгөөд “Та дэнлүү рүү хараарай, тэгвэл гэгээрнэ” гэж хэлдэг болжээ. Тэр байтугай өдгөө ч бас зарим хүн гэгээрэл хүртэнэ гэж горьдон лаа ширтэж бйгаа харагддаг. (Инээлдэв) Хэрвээ тэд дэндүү удаан ширтвэл сохорно.

Би бас саяхан өөд болсон өнөө цагийн нэг алдартай Их Багшийг мэднэ, тэр их олон санал зөрөлдөөн өдөөсөн. Тэр хүмүүст авшиг хүртээхдээ тольдуур гэрэлтүүлэгчэй жижиг гар чийдэн ашигладаг байсан. Тэр үүнийгээ чиний дух руу ингэж чиглүүлдэг (Их Багш хийж үзүүлэв), “гэгээрэл” нь энэ л юм байж. Та ийм жижигхэн гэрлийг мэднэ дээ? Бамбар! Тийм нэг жижигхэн гар чийдэн. Тэр түүгээрээ таны билгийн мэлмий рүү тусган гялбуулна – таны нүдийг аниулаад гялбуулна. Энэ нь “гэгээрэл” юм гэнэ!

А: Гэхдээ та наргиж байгаа байлгүй, Үгүй юү?

Б: Үгүй ээ, наргиан биш.

А: Та үүнийг үнэн гэж байна уу?

Б: Би үүнийг намтраас нь уншсан юм. Наргиа байх боломжгүй. Наргиа гэж үү? Үгүй шүү, та тэднээс асуу, тэд хэлээд өгнө. Энэ наргиа биш.

### Хурьцал болон бага сага гэгээрсэн нэгэн Их Багшийн сургаал номлол

А: Түүнд их олон ухаалаг шавь, баян шавь, мэргэжилтэн хүмүүс байсан.

Б: Тэд сэхээтэн учраас түүний оюунлаг номын уншлага, яриа нь тэдэнд таалагддаг байж л дээ.

А: Тэр гэгээрсэн Их Багш уу?

Б: Тийм, ямар нэг хэмжээнд.

А: Би түүний “Эзотерик сэтгэл зүй” номыг уншиж байгаа, тэр энэ номдоо “Гэгээрэл зүгээр л тохиолддог. Бид гэгээрэлд хүрэхийн тулд ямар нэг зүйлд санаа тавих, эсвэл ямар нэг юм хийх гээд байх хэрэггүй” гэсэн байна.

Б: За яахав дээ, бүгд л тэгж хэлдэг. Тэр маш олон ном уншсан, тэгээд түүнийхээ хагасыг нь, дөрөвний гурвыг нь давтаж ярьсан. Нэг л ижил зүйлийг яриад байдаг үй олон номыг та олж үзэж болно. Харин үүний цаана нь хүч байна уу, өөрийн ухаарал нь ямар байгаа эсэх нь өөр хэрэг. Би зарим нэг номыг нь уншиж үзсэн.

А: Танд ямар сэтгэгдэл төрөв?

Б: Тэр аахар шаахар зүйлийг дэндүү их ярьсан байна лээ. Тэр эмэгтэй хүн шиг, ердийн нэг гэрийн эзэгтэй шиг зүгээр л ярихын тулд л ярьдаг.

А: Тэр их юм ярьсан уу?

Б: Туж л нэг юмаа ярьжээ. Дандаа хурьцлын тухай. Яахав дээ, хурьцал муу юм биш, гэхдээ яагаад үүнийг үргэлж онцлоод байдаг юм бэ? Өөр ярих зүйл байхгүй юу? Юу ч байхгүй юу? Энэ чинь унтлагын өрөөндөө хийчихээд л мартчихдаг тийм л зүйл. Үүнийг үргэлж ном, сонин хэвлэлд бичээд байх хэрэг байхгүй, яагаад гэвэл энэ чинь унтах, хооллохтой л адилхан ердийн зүйл.

Та өдөр болгон хоол иддэг тухайгаа сүржигнэн ярихын хэрэг бий юу? Бид хурьцлыг яагаад үргэлж сүрхий чухалчилж байх ёстой гэж? Яахав, танд хурьцал таалагддаг бол хийнэ л биз. Энэ таны хувийн явдал, хэн ч таныг болиулах гэхгүй. Түүнийг үргэлж магтан дуулаад л тийм зүйлд дургүй хүмүүсийг шоглоод байхын хэрэг алга шүү дээ. Ингэвэл шударга биш. Энэ бол хувь хүний дур сонирхлын чанартай зүйл.

Харин амьтад хурьцлыг хүнээс дээр хийдэг! Хурьцалд юу нь тийм чухал гэж? Үнэн хэрэгтээ хурьцлын хичээл сургамжийн ихэнхийг хүмүүс амьгнаас л суралцсан. Тэгэхээр үүнд онцгой юм юу байна? Тийм биз. Би үүнийг л буруу гэж боддог.

А: Дэлхийн даяар хурьцлаас болж маш олон хүн дарамтлуулж байгаа учраас тэр үүнийг Фройд шиг л онцолж ярьсан хэрэг байх гэж яагаад ч юм би бодож байна л даа. Тэр ч байтугай олон лам, олон авшигтан шавь (свами), олон ижил хүйстэн байдаг. Олон хүн эмэгтэй хүнийг хүсдэг ч тэдэнд хэзээ ч боломж олдож байгаагүй байдаг. Тиймээс л тэд өөрсдийгөө дарамтад оруулдаг, Тэр ч бас ингэж л Их Багш болсон гэж би бодож байна. Магадгүй л юм. Үүнийг хүмүүсийн оюун ухаанд ойлгуулахын тулд Бурхан түүнийг унаа хөсгөө болгон ашигласан байж магадгүй юм.

Б: Магадгүй л юм, гэхдээ тэр хэтрүүлчихсэн.

А: Тэр Фройд шиг л арай дэндүүлчихсэн. Тэд туйлширсан гэж би хэлэх гэсэн юм. Доктор Кинси хүний бэлгийн харилцааны талаар хоёр илтгэл тавьсан байдаг. Ихэнх гэр бүл, эхнэр, нөхөр бүгд бэлгийн

амьдралдаа аз жаргалгүй байдаг гэж тэр илтгэлд дурджээ. Тиймээс л бидэнд ийм олон асуудалтай, бохир бузар энэ нийхэм байна.

Б: Тэдэнд зааж сургаад өгөх өчнөөн ном байж байна. Их Багшийн хэрэг алга. Ном, кино, сонин сэтгүүл, цээжээ нүцгэлэх үзүүлбэр гээд л бүх зүйл байна. Та хаана ч очоод сурч болохоор байна. Та нар ердөө үүнийг сурахын төлөөнөө Их Багшийн хөлд сөхөрч яах нь вэ? Ямар ч зөвтгөх юм алга. Гэтэл та нар надад энэ нь илүү хүчтэй, бас бүх хувраг, бусад хүн түүнийг сонсох учраас Их Багш зөвхөн энэ тухай л ярьдаг гэж хэлж байгаа юм гэж үү. Гэтэл одоо түүнийг бүх лам хувраг сонссон уу гэвэл үгүй, лам хуврагууд түүнийг үгүйсгэсэн. Тиймээс түүний хичээлүүд тэд дарамтлуулсан уу, үгүй юу гэдгээс нь үл хамааран ямар ч тохиолдолд лам нарт хүрэхгүй. Хурьцалд дургүй хүнд энэ нь тус болохгүй. Хэрвээ тэдэнд хурьцал хэзээ ч таалагдаж байгаагүй бол тэд түүн лүү хэзээ ч очихгүй. Тэгэхлээр тэр хэнд туслах вэ? Хэнд ч биш! Зөвхөн хурьцалд дуртай хүмүүс, аль хэдийн мэддэг хүмүүс түүн дээр очдог. Ингэхээр үүнд ямар ач тус байна? Эхийнхээ сүүгээр хооллодог, цагталан нялх хүүхдэд сүү өгөх хэр нь бусад өлсөж буй хүүхдүүдэд өгдөггүй. Харах уу, лам нар бүгд түүнийг үгүйсгэсэн байна.

А: Тэд тэгсэн, тийм. Тэр бас бүх дүрэм журмын тэнгэлүүдийг дэлгэжээ. Тэр дундад зууны үеийн талаар, сүм хийдүүдэд болж байсан зүйлсийн талаар өгүүлсэн байна. Тэгэхлээр, түүнийг би шинэ эрин үед олон үнэнийг түүчээлэв үү дээ гэж хэлэх гэсэн юм.

Б: Гэхдээ ийм зүйлсийг бид номоос уншчихаж болно. Бүлгэм болгонд авлига байж байдаг нь мэдээж. Гэхдээ ингэтлээ туйлшруулах нь утгагүй хэрэг.

А: Гэхдээ би түүнийг унаа хөсөг гэж хардаг. Хамгийн дээдийнх нь унаа хөсөг болж яваа хүн.

Б: Хүмүүсийг ямар байгаа яг ийм болгодог цорын ганц зүйл нь хурьцал биш шүү дээ!

А: Тийм. Мэдээж, бие хүний түгээмэл чанарын ердөө л нэг жижигхэн хэсэг.

Б: Нэг жижигхэн хэсэг. Тийм. Тийм ээ, тийм. Хурьцал үйлддэггүй олон хүн бий, тэд маш цэвэр ариун, бас нэн жаргалтай байдаг. Хурьцлыг их үйлддэг олон хүн бий, гэсэн ч түүн шигээ аз жаргалтай биш, тэнэг байдаг.

Шалтаг хайх хэрэггүй. Энэ чинь утгагүй зүйл! Би хурьцлын эсрэг, эсвэл иймэрхүү зүйлийн эсрэг байгаа юм биш. Зүгээр л маш жирийн, өчүүхэн зүйлийг хүмүүс сүр бадруулан өдөр тутмын номлол болгочихдог нь надад таалагддаггүй. Хэвийн, жам ёсоороо байгаа юм бүхэн зүгээр.

А: Тийм, би үүнд итгэж байна.

Б: Хэн ч хэнд ч хурьцлын талаар заах ёсгүй. Би та нарт үнэнийг л хэлдэг. Эрт дээр цагт гэрлэх үедээ хүмүүс маш залуугаараа л байдаг

байсан, хэн ч тэдэнд юу хийхийг нь заадаггүй байж. Тэд өсөж бойжоод арван хүүхэдтэй болсон байдаг. Бас хэрхэн хурьцахыг амьтанд хэн заадаг гэж? Тэдэнд ном, киноны ч хэрэг гардаггүй. Тэд биднээс тэнэг байх ёстой юу. Үгүй юу? Амьтад бүгд л хурьцдаг, хэнтэйгээ ч хамаагүй хурьцаж, элдэв янзын эмх замбараагүй хурьцал үйлддэг. Гэгээрсэн юм алга!

Бурхан багш агь байсан учраас олон зуун эмэгтэйтэй хурьцсан, Түүнд гэргийгээс нь гадна багадаа л таван зуун үзэсгэлэнт эмэгтэй байсан. Тэгсэн ч Тэр гэгээрэлд хүрээгүй. Гэхдээ Тэр ингэж их хурьцсан ч хожим нь гэгээрсэн. Энэ нь Түүнийг зогсоож дөнгөөгүй. Гэгээрэлд нь ч нөлөөлөөгүй. Тэрээр гэгээрлийг хүртэх хэрэгтэй болох цагт Тэр түүнийгээ хүртсэн. Хар багаасаа эхлээд өтөл хөгшин болтлоо өдөржин бясалгаж, ургамал хоолыг өдөрт нэг идэж байсан бүх хүн тэглээ гээд төгс гэгээрсэн төрөлтөн болчихдоггүй. Иймээс та ерөөсөө ямар нэг дүрэм журам тогтоож огт чадахгүй. Үгүй! Үгүй!

А: Энэ үнээн.

Б: Буддад олон зуун эхнэр байсан, гэсэн ч тэр гэгээрэлд хүрсэн. Есүст хэн ч байгаагүй, гэсэн ч Тэр бас л гэгээрсэн. Тэгээд юу гэж? Бид учир зүйтэй байх ёстой. За юу? Ямар ч хэнээрхэл улангасал байхгүй. За юу. Дундад буюу Төв зам мөр.

А: Тэр хэт туйлширсан байх, түүгээр ч барахгүй авто машины хувьд ч гэсэн тэр. Түүнд ганц нь л хэрэг болох байтал маш олон Роллс Ройс машинтай байсан. Тэгэхлээр, түүний зан байдал ч бас туйлширсан байсан байх. Тэр хурьцлыг маш их онцгойлон ярьсан. Түүнд гучин зургаан Роллс Ройс машин байсан, энэ бас л жаахан туйлшрал. Их Багшид байгаа шиг, хэрвээ танд машин байгаа бол энэ л хангалттай. Хэрэв та нэг газраас нөгөө рүү очих хэрэгтэй бол...

Б: Яахав дээ, зарим хүнд зүгээр л хүмүүсийн анхааралд өртөж, цочирдуулахын тулд туйлширсан юм хийх дуртай. Магадгүй тэр хангалттай татаагүй байх.

А:Тэгвэл Их Багш юутай ч гэсэн бас гэгээрсэн байж болох нь, гэхдээ үүнийхээ зэрэгцээ бас зан байдал нь тун хачин жигтэй байж болох нь ээ?

Б: Тэгэлгүй яахав! Хэрвээ гэгээрчихсэн бол тэд хүссэн бүхнээ хийж чадна. Энэ нь тэдэнд нөлөөлж чадахгүй.

А: Тэд цаашид ямар ч үйлийн үр үүрэхгүй юу? Тэдний Крия-мана (бие, хэл, сэтгэлээр үйлдэх) үйлийн үр шатаагдсан, тэдний Санчита (урьд наснуудын бүх хуримтлагдсан) үйлийн үр шатаагдсан, тэгэхээр тэд чөлөөтэй болсон гэсэн үг үү?

Б:Тийм. Гэхдээ та гэгээрсэн байх ёстой!

А: Та гэгээрсэн байх ёстой аж. Гэгээрээгүй бол та хийсэн үйлдлийнхээ үр дагаврыг хүртэх үү?

Б: Тэгнэ, гэхдээ би түүнийг гэгээрсэн гэж бодохгүй байна.

А: Тэр бүрэн гэгээрээгүй байсан уу?

Б: Бүрэн гэгээрэл бол биш. Сайндаа л хоёрдугаар төвшнийх.

А:Тэгвэл тэр шавь нь гэгдэх Энэтхэг бүсгүй урьд төрлийн үйлийн үрээсээ болоод түүнийг хордуулахаар завдсан уу?

Б: Би мэдэхгүй байна. Солиотой хүмүүс элдэв солиотой зүйл хийхийг алийг тэр гэхэв.

А: Ерөөсөө ямар ч харилцаагүй байсан байж болох уу?

### Жинхэнэ Их Багш хаа сайгүй оршдог нэгэн байх ёстой

Б: Юу гэхээр, жинхэнэ, үнэнхүү Их Багш, Төгс Гэгээрсэн Их Багш мөн л бол хаа сайгүй оршигч байх ёстой, энэ бол цорын ганц нотолгоо. Тэр нэгэн зэрэг олон янзын газар илрэн гарах чадвартай байх ёстой гэсэн утгатай.

А: Та нарийн биеэрээ гэх утгаар хэлж байна уу?

Б: Авшиг хүртээх үеэр тэр ядаж л цөөн хэдэн хувилгаан биеэ үзүүлэх чадалтай байх ёстой. Багадаа гэхэд тав, эсвэл арван шавь нь ядаж л дотоод Их Багшаа, эсвэл нэг иймэрхүү зүйл харсан байх ёстой, Наад зах нь л хоёр, эсвэл гурав. Авшиг хүртээх болгонд ийм зүйл болсон байх ёстой, эсвэл зарим цөөн хэдэн хүн, эсвэл тавин хувь нь. Энэ хаа сайгүй оршигч Хүч байхгүй бол та Их Багш биш, яагаад гэвэл та Бурхантай нэгдмэл биш байна. Бурхан бол хаа сайгүй оршигч.

А: Энэ Хүч нь тэр Их Багшийн хэлж байгаачлан өөрөө л хүрээд ирдэг үү, эсвэл дасгал сургуулилт, эсвэл бэлтгэл дадуулалтын үр дүнд ирдэг үү?

Б: Тийм, бас үгүй. Та юунаас ч бай Хүч авч чадна. Хэрэв та хэсэг хугацаанд галзуу мэт бүжиглэвэл танд хүчилтөрөгч дутагдана, гэсэн ч та бага сага Хүчийг мэдрэх болно.

А: Ямар нэг зүйл хийх хэрэгтэй байдаг уу?

Б: Хэрэв та гэгээрэлд хүрэхийн тулд ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй болж байвал энэ нь жинхэнэ гэгээрэл биш.

А: Тэгэхлээр, хэрэв та дасгал сургуулилт хийлээ ч гэсэн үр дүн гарахгүй гэсэн хэрэг үү?

Б: Та Будда болон Есүс гэгээрлийг хүртэх гээд хаа сайгүй, цөлд, Бодь модны доор ингээд чичрээд сууж байхыг төсөөлж чадах уу? Тэд зүгээр л хөдөлгөөнгүй сууж байсан, гэгээрэл хүрээд л ирсэн.

А: Гэгээрэл тэдэн дээр бууж ирдэг үү?

Б: Тийм.

А: Шри Ауробиндо болон түүний Эх хоёр наад зүйл дээр чинь ажиллаад байсан юм. Хэрвээ хүмүүс зүгээр л сууж байх юм бол тэд

ямар ч дасгал хийхийн хэрэггүй. Хэрэв амгалан тайван сууж байх юм бол Гэрэл зүгээр л Титэм хүрдээр (Sahasrara) дамжаад ороод ирнэ гэж тэд хэлсэн.

Б: Тийм, тийм юм болдог.

А: Гэхдээ бид эндээ харах ёстой юу? (Зулай руугаа заав)

Б: Үгүй, энэ ч ижил.

А: Адилхан юм уу?

Б: Үгүй, бид Гэрэл олж үзэхийн тулд хардаг. Бид билгийн мэлмийгээрээ харна. Бид эндээ харж чадахгүй. Энд нүд байхгүй.

А: Гэхдээ энд бас нүд нээгддэг, бас Гэрэл ирдэг. Энэ юу юм бэ?

Б: Тэр чинь мэлмий, билгийн мэлмий. (Их Багш духныхаа төв рүү хуруугаараа заав) За юу?

А: Өө, энэ нь билгийн мэлмий юм байна. Тэгвэл тэр юун Гэрэл билээ? Ямар төрлийн Гэрэл билээ? Би нэг Их Багштай байхдаа харсан.

Б: Энэ бол Бурхан!

А: Бурхан юм уу?

Б: Би авшиг хүртээхдээ танд хэлээд өгчихсөн шүү дээ. Янз бүрийн төрлийн Гэрэл нь өөр өөр төвшнийг төлөөлдөг. Хэрвээ та мартчихсан бол Гуан Инь элчээс дахиад асуух ёстой шүү.

А: Тэгвэл би Бурхантай яг л хүнтэй ярьж байгаа шиг ярилцаж болох уу? Яг Тангай ярьж байгаа шигээ Түүнтэй хамт суугаад ярьж болох уу?

Б: Тийм, та Бурхны дэс төвшинд хүрч чадсан үедээ тэгж чадна. Гэхдээ Бурхан гэдэг чинь хүн биш. Нэг хүн хүрч ирээд тангай нүүр тулан ярина гэж хүлээх хэрэггүй.

А: Бурхан аав шиг нэгэн байж чадахгүй юу, аавтай адилхан байж чадахгүй гэж үү?

Б: Тэр чадна. Тэр тийм байдалтай биежиж чадна. За юу. Гэхдээ одоо та улам дордож байна гэж би бодож байна. Таны дэс доошлоод байна. Тиймээс явж унт, өөрийгөө цэнэглэ, тэгээд дараа ахиж асуугаарай. За юу? За, боллоо. Маргааш хоолой минь сөөчих нь ээ.

А: Энэ миний буруу. Би залбирна аа.

Б: Би маргааш Америк руу явна, тэгээд удахгүй буцаад ирнэ. Миний төлөө залбираарай.

А: Та хэзээ буцаж ирэх вэ?

Б: Би хоёр хоногийн дараа ирэх байх аа, та миний төлөө залбираарай.

А: Бид залбирна аа.

Б: Миний амжилтын төлөө залбираарай. Энэ бол Бурхны таалал. За юу. Сайхан нойрсоорой.

А: Та амжилт олно оо. Танд амжилт ерөөж байна.

Б: Баярлалаа.

## ЧАНАГУУХИ ЕРТӨНЦИЙН НУУЦ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*

*1992 оны 6-сарын 26-ны өдөр*

*Нью-Йорк хотноо НҮБ-д уншсан лекц*

Нэгдсэн Үндэстний Байгууллагад тавтай морилцгооно уу? Одоо хүн бүр өөр өөрийн шүтлэг бишрэлээрээ, өөртөө байгаа бүхний төлөө, энэ бүхнийг бидэнд өгснийх нь төлөө Бурханд талархан хамтдаа жаахан залбиран даатгая. Мөн гачигдаж дутагдаж буй хүмүүс бидний адилаар хүссэн бүхнээ олох болтугай; даян дэлхийн дүрвэгсэд, дайн дажны хөлд нэрвэгдэгсэд, цэрэг дайчид, төр засгийн тэргүүн нар, түүнчлэн НҮБ-ын удирдагчид санаж бодсон бүхнээ эцэст нь хүргэж чадаад бие биетэйгээ эв найртай амьдрах болтугай гэж сэтгэл зүрхнийхээ угаас хүсэн ерөөж, итгэж найдъя. Хүсч гуйсан бүхэн маань биелнэ гэдэгт бид итгэж байна. Яагаад гэвэл Библид ингэж өгүүлсэн байдаг билээ.

Баярлалаа! Та бүхний мэдэж байгаачлан өнөөдрийн лекцийн сэдэв бол “Чанагуухи ертөнцийн нууц”. Учир нь би өөрийгөө та бүхэнд та нарын мэдэх энэ ертөнцийн тухай нэмж илүү юм ярихыг хүсэж байна гэж бодохгүй байна. Харин энэ ертөнцийн чанадад бол огт өөр зүйл байдаг. Энд ирсэн бүх хүн энэ тухай мэдэж авах сонирхолтой байгаа гэж би бодож байна. Энэ бүхэн нь манай нэг бясалгагчийн сая ярьсан шиг итгэхүйеэ бэрх уран сэтгэмж юмуу ид шидийн зүйл биш. Энэ бол нэн шинжлэх ухаанлаг, учир зүйд бүрэн нийцэх атлаа маш чухал зүйл юм.

Шашны янз бүрийн бичиг зохиол хийгээд Ариун судруудад тэнгэрийн долоон орон, ухамсрын өөр өөр төвшин, бидний дотоодод байх Бурхны орон, Бурхан чанар... зэрэг нь оршин байдаг тухай дурдсан байдгийг бид цөм сонсож байсан билээ. Эд бүхэн бол энэ ертөнцийн чанадад л байдаг хэмээх зүйл юм. Гэвч эдгээр Ариун сударт амласан зүйлст тийм ч олон хүн хүрч чаддаггүй юм. Олон биш шүү. Ер хэн ч чаддаггүй гэж хэлж болохгүй боловч тийм олон хүн хүрдэггүй. Дэлхийн хүн амын тоотой харьцуулбал дотоодынхоо Бурхны оронд буюу “Чанагуухи ертөнц” гэгддэг зүйлд хүрсэн хүн үнэндээ маш цөөхөн. Хэрвээ та Америкт амьдардаг бол та бүхэнд чанагуухи ертөнцөд байдаг зүйлсийг дүрсэлсэн олон ном унших боломж байдаг биз. Мөн америкчуудын хийсэн киноны зарим нь бүхэлдээ ургуулан

бодсон зохиомол зүйл ч биш. Япончуудын хийсэн кино ч тэр чигээрээ уран зохиол биш. Учир нь тэдгээр найруулагч чанагуухи ертөнцөд байж үзсэн хүний бичсэн номыг уншсан, эсвэл тэд өөрсдөө Бурхны гэрэл гэгээнд нэвтэрсэн байж ч магад.

За, тэгэхээр, Бурхны оронд юу байдаг хэрэг вэ? Бидэнд энэ ертөнцөд өчнөөн хэрэг явдал, ажил төрөл, тав тухтай гэр орон, элгэмсүү дотно хүмүүс байсаар байтал юунд Бурхны орны тухай санаагаа зовоох ёстой вэ? Чухамдаа гэвэл бидэнд энэ бүхэн хэдийнээ байгаа учраас л бид Бурхны орны тухай бодох хэрэгтэй байгаа юм. “Бурхны орон” гэж ярихаар – энэ үг дэндүү шашин суртахууны шинжтэй сонсогддог. Гэтэл энэ бол үнэн хэрэгтээ дээд ухамсрын нэг төвшин төдий юм. Эрт цагт хүмүүс үүнийг диваажин гэдэг байв. Шинжлэх ухааны нэр томъёогоор бол үүнийг өөрөөр-мэдлэгийн дээгүүр төвшин, билиг ухааны дээгүүр шат гэж тодорхойлж болно. Тийм болохоор арга замыг нь мэдчих юм бол бид ч гэсэн үүнд хүрч чадна.

Саяхан Америкт нэгэн шинэ бүтээл гарч, хүнийг самади-д оруулж чадах машин хүртэл бий болж гэж бид бүгд сонссон. Та бүхэн хэрэглэж үзэв үү? Энэ нь Америкт маш хямдхан, та самацийн аль төвшинд орохыг хүсч буйгаас хамаараад дөрвөн зуугаас долоон зуун долларын үнэтэй. Хүмүүсийн ярьж байгаагаар бол энэ машиныг бясалгал хийх дургүй мөртлөө нэн түргэн самади агуулах санаатай залуу хүмүүст зориулсан аж. Энэ тухай та нар мэдэхгүй байгаа бол би товчхон ярьж өгье.

Энэ машин хүнийг тайвшруулан сулруулж, уураг тархийг амрааж чаддаг, тэгээд I.Q (оюуны итгэлцүүр) нь өндөр төвшинд хүрдэг гэж ярьдаг. Энэ нь хүнд дээд зэргийн эрдэм мэдлэг, дээд зэргийн билиг ухаан өгдөг, тэгээд тэр хүн өөрийгөө гайхалтай сайхан байгааг мэдэрдэг гэнэ. Энэ машинд тусгайлан сонгосон хөгжим, гадна талын хөгжим ашигладаг болохоор та заавал чихэвч зүүх хэрэгтэй болно. Тэгээд тэд ямар нэг өөрийг чинь өдөөдөг цахилгаан, гүйдэл маягийн юм өгч, тэгмэгц та гэрэл гялбаа мэт ямар нэг зүйл үзнэ. Тийм учраас та нүдээ заавал уяж боох шаардлагатай аж. Самади агуульа гэвэл нүдний боолт, чихэвч зүүчихвэл гүйцэх нь тэр. Энэ чинь маш сайхан хэрэг, тэгээд бас дөрвөн зуун доллар төдийхөн, маш хямдхан биш үү. Гэтэл бидний самади бол үүнээс ч хямд, сохор зоос ч хэрэглэхгүй, тэгээд бас үүрд мөнхийнх байдаг. Түүнчлэн цахилгаан зайнаас цэнэглэх, залгуурт залгах, салгах хэрэг үгүй, эсвэл машин эвдэрчих тохиол гардаг бол биднийхийг засах ч шаардлага байхгүй билээ.

Тэгэхлээр зохиомол гэрэл гялбаа, дуу аялгуу хүнийг амирлуулан тайвшруулж, билиг ухааныг нь нээгдүүлж чаддаг - ингэх ёстой гэх авч би энэ тухай сониноос уншсанаас биш өөрөө хэрэглэж үзээгүй. Тийм учраас энэ юм маш их дэлгэрч байгаа бөгөөд бас борлуулалт сайн байгаа

гэж дууддаг байна. Ийм хиймэл зүйлс хүртэл сэтгэлийн амар тайвныг өгч, оюуны итгэлцүүрийг маань дээшлүүлж чадаж байхад жинхэнэ үнэн бодит зүйл бидний билиг ухаанд хичнээн их тус болж чадахыг төсөөлөөд үз! Жинхэнэ үнэн зүйлс нь энэ ертөнцийн чанадад байдаг ч хэрэв түүнтэй холбогдохыг хүсвэл хэн ч хүрч болохуйц зүйл юм. Энэ бол дотоодын тэнгэрлэг хөгжим, дотоодын тэнгэрлэг аялгуу. Энэ хөгжим, дотоодын гэрэл гэгээ болон дотоодын дуу аялгууны хүчний төвшнөөсөө хамааран бид өөрийгөө энэ ертөнцийн зааг хязгаараас түлхэн гаргаж, үлэмжийн гүн гүнзгий ухамсрын төвшинд хүрч чадна.

Энэ нь физикийн хуультай адилхан гэж би боддог. Газрын татах хүчний эсрэг пуужин хөөргөө гэвэл пуужинг асар их хүчээр түлхэх хэрэгтэй бөгөөд түүний хурд нэн их болох үед пуужин гэрэл цацруулна. Тэгэхлээр чанагуухи ертөнц рүү маш их хурдтай нисэх үедээ бид ч бас гэрэл цацруулна, мөн түүнчлэн бид дуу аялгуу ч сонсож чадна.

Энэ аялгуу бол биднийг дээд төвшин рүү түлхэж буй хэлбэлзлийн хүчний нэг төрөл. Гэхдээ ингэхдээ ямар ч дуу чимээ гаргалгүй, нэг их түвэг удалгүй, тохь тух алдуулалгүй, зардал мөнгө ч шаардалгүй хийдэг. Энэ бол чанагуухи ертөнцөд хүрэх арга юм.

Чанагуухи ертөнцийн юу нь манай ертөнцийнхөөс илүү байдаг вэ? Бидний төсөөлж чадах болон эс чадах юм бүхэн нь илүү. Үүнийг нэгэнтээ үзчихвэл дараа нь бид мэддэг болно. Өөр хэн ч бидэнд үнэн бодтой дүрслэн хэлж чадахгүй. Гэхдээ бид үүндээ чин сэтгэлтэй, мөн цөхрөлгүй шургуу байх ёстой, эс бөгөөс бидний өмнөөс өөр хэн ч үүнийг хийж өгч чадахгүй. Энэ нь таны НҮБ дахь ажлыг хэн нэгэн хүн таны өмнөөс хийгээд харин цалин хөлсөө та өөрөө аваад байдаггүйтэй адилхан юм. Хэн нэгэн хүн бидний өмнөөс хоол идэж туслахад бид цаддаггүйтэй адил. Тийм учраас энэ аргыг туршиж үзэх хэрэгтэй. Бидэнд хэлэх ахуй ойлголттой хүмүүсийн яриаг сонсож болох ч түүнээс бид ихээхэн туршлага олж авч чадахгүй. Магадгүй бид Бурхны ахуй ойлголттой болсон хүний хүчээр нэг удаа, хэдэн удаа, эсвэл хэдэн өдрийн турш ахуй ойлголт авч болно. Цаашилбал нэг их хүч зарцуулалгүй зүгээр байж байгаад гэрэл гялбаа үзэж, дуу аялгуу сонсож болно, гэвч ихэнх тохиолдолд энэ нь төдий л удаан үргэлжилдэггүй. Тийм болохоор бид өөрсдөө бясалгаж, өөрсдөө л хийх ёстой юм.

Манай ертөнцийн чанадад өөр олон ертөнц бий. Манай ертөнцөөс арай дээгүүр оршдог нэг ертөнцөөр жишээлье. Барууны нэр томъёогоор түүнийг “Одот ертөнц” (Асури-Astral world) гэдэг. Одот ертөнц нь 100 гаруй ялгаатай төвшинтэй бөгөөд төвшин бүр нь дангаараа нэгэн ертөнц болно. Энэ ертөнц бүр нь бидний ойлголтын төвшинг харуулж байдаг. Их сургуульд сурахтай эгээ ижил, сурах явцад дамжаа бүр нь бидний их сургуулийн эрдмийг хэрхэн ойлгосныг илтгэн харуулж, бид тийнхүү аажимхан ахисаар сургуулиа төгсдөг шиг юм.

Асурийн ертөнцөд бид увдис шид гэж нэрлэдэг олон гайхалтай зүйлийг үзнэ. Биднийг мөн ид шидээрээ гайхуулан татаж ч мэднэ, бид ч өөрсдөө бас ид шид үйлдэж чадах ч магадлалтай. Бид өвчтэй хүнийг эмчилж, бусад хүний нүдэнд харагдахгүй зүйлийг олж үзэж чадна. Наад зах нь зургаан төрлийн ид шидийн хүчтэй болж, ердийн саад хоригийг даван далдыг харж, орон зайнаас үл хамааран юмыг сонсож чадна. Бидний хувьд хол ойрын ялгаа үгүй болох бөгөөд үүнийг бид тэнгэрлэг үзэхүй, тэнгэрлэг сонсохуйгаар онох хэмээн нэрлэдэг юм. Тэр цагт бид хүний бодлыг нэвт харж, заримдаа хүний санаа сэтгэлд юу байгааг үзэж чадна. Бурхны орны нэгдүгээр төвшинд хүрэхэд бидэнд дээрх боломж чадвар нээгдэж болдог.

Миний саяын ярьсан нэгдүгээр төвшний цаад талд өөр олон төвшин байх бөгөөд тэдгээр нь үг хэлний дүрслэн өгүүлэх бололцоо чадамжаас хэгийдсэн байдаг. Авшиг хүртсэний дараа үргэлжлэн бясалгасаар бидний зэрэг дэс нэгдүгээр төвшинд хүрвэл бид илүү олон чадвартай болно. Тэгэхэд урьд нь бидэнд огт байгаагүй уран зохиолын авьяас билиг хүртэл бий болно. Түүнчлэн бид бусад хүний мэддэггүй өдий төдий юмыг мэддэг болж, Бурхан тэнгэрээс заяаж өгөв үү гэмээр олон зүйл бидэнд олдох болно. Тэр нь зарим үед санхүүгийн амжилт, зарим үед албан тушаал ч байх юмуу, өөр бусад зүйл байж болдог. Мөн бид шүлэг найраг бичих чадвартай болох юмуу, уран зураг зурж, урьд өмнө хийх нь байтугай хийж чадна гэж төсөөлж ч чадахгүй байсан олон зүйлийг хийж чаддаг болно. Энэ бол нэгдүгээр төвшин. Бид гайхалтай найруулгатай ном бичиж, шүлэг зохиож болох юм. Урьд өмнө нь мэргэжлийн төвшинд зохиол бичиж чадахгүй байсан бол одоо харин чадах жишээтэй. Эдгээр зүйл бол бид ухамсрын нэгдүгээр төвшинд хүрэхэд бидэнд олддог материаллаг ач тус нь юм. Үнэн хэрэгтээ бол эдгээр нь Бурхны бэлэг биш. Эд бүгд нь бидний доторх тэнгэрлэг ертөнцөд оршиж байдаг бөгөөд бид тэднийг урин дуудсаны улмаас тэдгээр нь сэрэмж дүүрэн болжээ. Тэгээд бид тэр бүгдийн ашиг тусыг хүртэх боломжтой болно. Нэгдүгээр ертөнцийн тухай товчхон өгүүлэхэд ийм байна.

Ингээд бид илүү өндөр дээд төвшинд хүрэх юм бол бид шинэ шинэ зүйлийг нээж, нэн их зүйлийг хүртэж эзэмшинэ. Бүгдийнх нь тухай би та нарт ярих аргагүй нь мэдээжийн хэрэг. Тэгээд ч өөрөө хэзээ ч идэж үзээгүй хэрнээ чихэр, бялууны тухай өчнөөн сайхан юм сонсох шаардлагагүй. Тийм учраас би одоохондоо та бүхний хорхойг жаахан хүргэж байгаа төдий. Харин та нар идэж үзье гэж хүсч байвал ч өөр хэрэг шүү. Жинхэнэ амтлах идээг би жаахан байзнасхийж байгаад гаргаж өгнө. Тийм шүү! Гагцхүү та үүнийг идэж амтлахыг хүсч буй бол шүү дээ.

Одоо харин энэ төвшнөөс жаахан дээшилж, хялбарчлахын

тулд “хоёрдугаар ертөнц” гэж нэрлэсэн хоёрдугаар төвшинд очъё. Хоёрдугаар ертөнцөд бид нэгдүгээр ертөнцийнхөөс ч илүү нэн их авьяас чадвар, түүний дотор ид шидийн хүчтэй болж болно. Гэхдээ хоёрдугаар ертөнцөд хүрээд олж авдаг авьяас чадваруудын дотроос хамгийн гайхамшигтай нь – уран илтгэх урлаг болон маргах чадвар юм. Хоёрдугаар ертөнцөд хүрсэн хүний оюун ухааны хүч чадал оргилдоо хүрч, гайхалтай уран илтгэх чадалтай болсон байдаг тул хэн ч түүнийг давж дийлэхийн аргагүй мэт санагдана.

Ердийн оюуны чадвартай юмуу, дундаж I.Q тэй хүмүүсийн олонх нь I.Q нь ер бусын өндөр төвшинд хүрсэн ийм хүнтэй өрсөлдөж чадахгүй. Гэхдээ энэ нь зөвхөн бие махбодын уураг тархи илүү хөгжсөнд биш, бидний дотоодод угаас байдаг нууцлагдмал хүч, төрөлхийн билгүүн ухаан, тэнгэрлэг хүч чадалд оршиж байгаа юм. Одоо тэр нь нээгдэж эхэлсэн хэрэг. Энэтхэгт энэ төвшинг “Буддхи” гэж нэрлэх бөгөөд энэ нь “оюун ухаанлаг төвшин”-г илтгэдэг. “Буддхи”-д хүрвэл та Будда болно. “Будда” гэдэг үг нь эндээс гаралтай юм. Тэгэхээр Будда гэдэг нь чухамдаа үүнийг илэрхийлдэг байх нь. Гэхдээ энэ бол эцэс төгсгөл нь биш ээ. Би та бүхэнд зөвхөн Буддаг танилцуулаад зогсчихгүй, үүнээс цааш юм бас бий. Ихэнх хүн гэгээрсэн хүнийг Будда гэдэг. Хэрвээ тэр хүн хоёрдугаар ертөнцөөс дээш оршихуйг мэддэггүй бол үүгээрээ их бахархана. Өөрийгөө үнэнээсээ амьд Бурхан гэж бодохын зэрэгцээ шавь нар нь ч түүнийг Бурхан хэмээн өргөмжилж бахархана. Үнэн хэрэгтээ зөвхөн хоёрдугаар ертөнцөд хүрч аль дуртай хүнийхээ өнгөрсөн, одоо, ирээдүйг нэвт үзэж, дээд зэргийн уран илтгэх чадвартай болсон нь Бурхны оронд хүрэх зам мөрийн эцэс төгсгөл биш.

Хэн нэгэн хүн өнгөрсөн, одоо, ирээдүйг үзэж мэдэх чадвартай бол түүндээ онгирч бардамнах ёсгүй, учир нь энэ бол Барууныхны ярьдаг Акашийн мэдээллийн сан (“Akashic record”) юм. Та нарын дотроос йог юмуу бясалгалын аль нэг төрлөөр хичээллэдэг хэн нь ч гэсэн Акашийн гэмдэглэл гэдэг нь хажуугийн танхимд байгаа НҮБ-ын номын сантай адил янз бүрийн төрлийн хэлний номын сан маягийн зүйл гэдгийг ойлгоно. Хажууд байгаа номын сандаа та нар араб, орос, хятад, англи, франц, герман хэл зэрэг элдэв төрлийн хэлний ном байхыг харж болно. Хэрэв та энэ бүх хэлээр уншиж чаддаг бол тухайн оронд юу болж буйг мэднэ. Үүнтэй адилаар, хоёрдугаар төвшинд хүрсэн хүн бол өөрийнхөө намтрыг мэддэгийн адилаар бусад хүний төрх байдлыг ойлгож, тов тодорхой тайлж чадна.

Ухамсрын хоёрдугаар төвшнээс олж авах зүйл үүнээс хавьгүй их бий. Гэхдээ “Буддхи” буюу оюун ухаанаа нээчихсэн учраас хэн нэгэн хүн хоёрдугаар ертөнцөд хүрэх нь хэдийнээ гайхамшигтай явдал, амьд Бурхан болсон хэрэг мөн билээ. Энэ үед бид олон олон юм, нэрлэж ч чадахгүй олон зүйлийг мэддэг юм. Оюун ухаан маань нээгдэж, амьдралаа



амар амгалан, илүү сайн сайхан болгохын тулд эмчлэн анагаах, эвсэн зохицохуйн дээд эх сурвалжтай яаж холбогдохоо бид мэдчихсэн байдаг тул хүссэн ч, хүсээгүй ч ид шид хэмээгч тэр бүхэн бидэнд тохиолддог юм. Бидний урьд өмнө буруу хийсэн зарим зүйлийг засч залруулж, дахин гаргуулахгүй байхад зайлшгүй хэрэгтэй өнгөрсөн үеийн хийгээд одоогийн мэдээлэл рүү нэвтрэх гэж бидний оюун ухаан буюу “Буддхи” нээгддэг юм. Энэ бол бид алдаа дутагдлаа засч амьдралаа улам сайн сайхан болгохын тулд билээ.

Жишээлбэл, бид хөршөө ямар нэг санамсаргүй явдлын улмаас гомдоосноо өөрсдөө мэдэхгүй байж болно. Харин одоо бол энэ бүхэн бидэнд тов тодорхой болно. Маш хялбархан! Үл ойлголцлоос болоод юмуу, эсвэл бид хөршдөө ямар нэг буруу юм хийснээс болж хөрш маань бидний эсрэг санаа өвөрлөж, ар хударгаар маань хорлохыг хичээдэг байсныг бид мэддэггүй бол харин одоо яагаад ийм зүйл тохиолдсон нь бидэнд тодорхой болно. Тиймээс энэ нь амархан. Бид хөршийндөө очих юмуу, утсаар ярих, үдэшлэг зохиогоод түүндээ урьж залан үл ойлголцол бүхнээ арилгаж болох юм.

Бид энэ оюун ухааны төвшинд хүрэх үед, иймэрхүү зүйлсийг аяндаа, өөрөөр хэлбэл чимээгүйхэн ойлгож, зохицуулах юмуу, эсвэл юмыг зохицуулахад тусалж чадах, амьдралын маань хэлбэр маяг, зам мөрийг улам сайн сайхан болгох тэр хүчний эх ундаргатай холбогддог юм. Ингэж бид амьдралаас үүсдэг таагүй, хүсмээргүй нөхцөл байдал, элдэв зовлон гамшгийг багасгаж чадна. Тийм шүү! Тийм учраас бид хоёрдугаар ертөнцөд хүрэх нь хэдийнээ гайхалтай явдал юм.

Та бүхэнд тайлбарлах гэж хичээсэн энэ зүйл бол шинжлэх ухаан болон учир зүйд бүрэн нийцэх бөгөөд йог юмуу бясалгал хийдэг хүн гэдэг нь ямар нэг нууц далдын юмуу харь гарагийн хүн гэж бодох хэрэггүй. Тэд бол бидний л нэг адил газар дэлхийн хүмүүс бөгөөд гагцхүү хэрхэх арга замыг мэдсэнийхээ ачаар өөрсдийгөө хөгжүүлж чадсан улс юм.

Америкт хэрхэн яаж гэдгийг мэдсэн эсэхээс бүх зүйл шалтгаалдаг гэж бид ярьдаг. Тийм болохоор бид юуг ч сурч чадна. Тийм үү? Бид юуг ч сурч чадна. Тэгэхлээр энэ бол бас бид тэнд сурч болохуйц, чанагуухи ертөнцийн шинжлэх ухаан гэмээр зүйл юм. Хэдийгээр хачин сонин санагдаж болох ч судалж буй зүйл маань хэчнээн дээд зэргийнх байна, төдий чинээ хялбар дөхөм байдаг юм шүү. Энэ ухаан нь дунд болон дээд сургуулийн математикийн нарийн түвэгтэй асуулт, бодлогоос ч амархан байдаг юм.

Хоёрдугаар төвшин мөн олон дэд төвшинтэй. Орчлон ертөнцийн хамаг нууцыг нэгд нэгэнгүй тайлбарлах аргагүй учраас би ердөө л товч төдийхэн танилцуулахыг хичээе. Тэгээд ч та бүхэн энэ зам мөрийг

нэгэнт туулчихсан Багштай хамт аялбал энэ бүхнийг өөрсдөө үзэж мэдэх болно. Тийм болохоор нууц гэмээр юм юу ч байхгүй. Гэвч энэ бол дэндүү удаан, хэрэв бид төвшин нэг бүрт хүрээд зогсож, доторх дэд төвшин бүрийг нь судлан шинжлэхэд хүрвэл хэтэрхий их цаг зарцуулах болно. Тийм учраас заримдаа Багш нь төвшин бүрт удаж төдөлгүй дараа дараагаар нь танилцуулж байгаа юм. Нэн хурдан, сүн, сүн, сүн гээд л. Хэрэв та нарт бусдыг сургах хэрэг байхгүй бол их юм сурах шаардлага байхгүй, толгой чинь өвдөнө. Яасан байлаа ч маш их цаг хугацаа шаарддаг учраас та нарыг дагуулж яваад гэрт тань хүргэж өгснөөр л зогсдог юм. Заримдаа үүнд бүх амьдрал шаардагдана. Гэхдээ гэгээрэл бол агшин зуур ирдэг юм. Тийм боловч энэ бол зөвхөн эхлэл юм, яг л элсэлт шиг. Их сургуульд элссэн анхны өдрөөсөө л тэр даруй их сургуулийн оюутан болдог. Гэхдээ энэ нь докторын эрдмийн зэрэгтэй огт хамаагүй. Таныг сургуулиа төгстөл зургаа, дөрөв, арванхоёр жил ч өнгөрч мэднэ. Хэрвээ та их сургуулийн оюутан болохыг үнэн сэтгэлээс, жинхэнээсээ нухацтай хүсээд бүртгүүлбэл, тэгээд тэр сургууль чинь үнэхээр их сургууль мөн юм бол та тэр дорхноо оюутан болчихно. Тиймээс хоёр талаасаа хамтран ажиллах ёстой юм. Бидэнд Нью-Йоркт өөр явах газар байхгүй гэж бодоод жишээлбэл, зүгээр л нэг наргиа болгож, энэ ертөнцийн чанадад гаръя гэж бодъё л доо. Бид Манхеттен, Лонг-Биич, “Шорт-Биич” болон өөр Биич-үүдийг (далайн эрэг) мэднэ. Одоо бид харь гарагт хаа нэгтээ очиж, тэнд юу болж байгааг үзэхийг хүсчээ гэж төсөөлье. Болох уу? Яагаад болохгүй гэж? Бид зөвхөн тэнгисийн усанд орохын тулд л Майами, Флорида руу их мөнгө төлөн явдаг биш үү, гэтэл яагаад хөрш гараг маань ямар болохыг, түүн дээр хүмүүс хэрхэн аж төрдөгийг үзэхийн тулд энэ ертөнцөөс цаанах өөр өөр ертөнц рүү явж болохгүй байх билээ. Би ингэхийг ямар нэг этгээд юм гэж бодохгүй байна. Үгүй гэж үү? Энэ нь ердөө л арай алсхан аялах, энэ биеэрээ аялахын оронд сүнсээрээ, оюун санаагаараа аялах төдий л зүйл.

Ер нь бол хоёр төрлийн аялал байдаг. Энэ бол нэн зүй ёсны төдийгүй ойлгоход маш хялбар зүйл.

Тэгэхлээр бид одоо хоёрдугаар төвшинд байна. Би өөр юуг та нарт хэлж өгөх ёстой билээ? Ийм замаар бид энэ ертөнцөд аж төрөхийнхээ сацуу өөр бусад ертөнцийн тухай мэддэг болдог юм. Бид аялан жуулчилж байдаг учраас тэр. Америк болон бусад орны иргэд та нар ч хөрш орнуудаа ямар болохыг нь үзэхийн тулд л нэг улсаас нөгөө улс руу аялаж байдагтай адил. Одоо энд НҮБ-д сууж байгаа та нарын ихэнх нь уугуул Америкчууд биш гэж би бодож байна. Тийм биш үү? Тийм ээ. Тийм болохоор та нар үүнтэй адил юмыг мэдэж авлаа. Ухаж ойлгохын тулд бид өөр гараг эрхэс юмуу, эсвэл амьдралын дээгүүр төвшин лүү аялж болох юм. Гэвч эндхийн орон зай нь явганаар ч, пуужингаар ч, тэр

бүү хэл нисдэг тавгаар ч туулахын аргагүй уудам.

ҮМНБ-ээр нисээд ч туулан гарах аргагүй тийм аварга том ертөнцүүд ч байдаг. Үл Мэдэгдэх Нисдэг Биет! Үл мэдэгдэх объект, тийм ээ, нисдэг биет. Тийм. Бидэнд аль нэг ҮМНБ-ээс ч хурдан нисэж чадах чадвар байдаг. Энэ чадвар бол бидний дотоод сэтгэл. Бид үүнийгээ бас сүнс гэдэг. Сүнсээ түшиглэж нисвэл шатахуун хэрэглэхгүй, замд саад тотгор тохиохгүй, цагдаа ч тааралдахгүй. Аль нэг өдөр Арабууд газрын тосоо бидэнд худалдахаа больчихно гэж сэтгэл зовох ч хэрэггүй (Инээлдэв). Сүнс хэрэгцээгээ өөрөө хангадаг тул өөр юуны ч хэрэг үгүй. Бид өөрсдөө л ертөнцийн хуулийг зөрчиж, тэнгэр газрын зохицлыг эвдэх тохиолдлуудыг эс тооцвол сүнс маань хэзээ ч гэмтдэггүй юм. Гэхдээ үүнээс сэрэмжлэхэд тийм ч хэцүү биш. Та нарыг хүсвэл би яаж ингэхийг зааж өгч болно. Жишээ болгож би товчхон ярья. Тэгэх үү? Би номлогч биш, бүү санаа зов, та нарыг сүм рүү аваачихгүй. Зүгээр л жишээ болгож байна.

Машин жолоодоход замын хөдөлгөөний дүрмийг мэдэж байх ёстойн адилаар бидний мэдэж байвал зохих ертөнцийн хууль гэж байдаг юм. Ногоон гэрлээр явна, улаан гэрлээр зогсоно. Баруун, зүүн тийшээ эргэх, хурдны замаар хэр хурдан явах г.м. Тиймээс манай ертөнцөд, биет ертөнцөд зарим тун энгийн хуулиуд байдаг. Энэ ертөнцийн гадна, биет ертөнцийн чанадад бол ямар ч хууль байдаггүй. Бид чөлөөтэй, эрх чөлөөт иргэд, гэвч энэ эрх чөлөөг олж авахын тулд чанагуухи ертөнцөд хүрэх ёстой шүү. Гэхдээ бид энэ дэлхийд, энэ бие махбодоороо амьдарсаар байгаа болохоор асуудал зовлонд орчихгүйн тулд энэхүү ертөнцийн хуулийн хүрээнд орших хэрэгтэй. Ингэж чадвал бид нисэх төхөөрөмжөө гэмтээлгүй нэн түргэнээр, нэн өндөрт саадгүй хүрч чадах юм.

Хинду, Буддын болон Христийн шашны ариун судруудад энэ хуулийг бичсэн байдаг. Эдгээр нь маш энгийн бөгөөд бид хөршдөө гай учруулж болохгүй, амь хороож болохгүй: "амь тасалж болохгүй", "садар самуун байж болохгүй", "хулгай хийж болохгүй" гэх мэтээр өгүүлдэг. Мөн мансууруулах бодистой зүйл хэрэглэж болохгүй гэсэн бөгөөд үүнд хар тамхийг багтаажээ. Будда ХХ зуунд хүмүүс кокаин гэх мэт зүйлийг зохиож гаргахыг мэдсэн бололтой. Тиймээс аливаа мансууруулагчийг хориглосон байдаг. Бүх төрлийн мөрийтэй тоглоом, дэнчин тавих гэх мэт оюун санааг маань бие махбодын цэнгэлд татаж, оюунлагийг эрэлхийлэх сүнсний аяллаа мартуулахад хүргэдэг юм болгоныг мансууруулагчид хамааруулна. Хэрэв бид аюулгүй бөгөөд хурднаар өндөрт нисэхийг хүсч байгаа бол пуужин хөөргөхөд физикийн хуулийг дагаж мөрддөгийн адилаар биет ертөнцийн хуулийг дагаж мөрдөх ёстой. Пуужин нисгэхийн тулд эрдэмтэд тодорхой хуулийг мөрддөг. Ердөө л энэ. Бид үүнээс хол, пуужингаас ч хол, ҮМНБ-ээс ч хурдан

нисэхийг хүсч байгаа болохоор хичнээн их анхаарал болгоомжтой байх ёстой билээ. Гэвч та нарын сонирхвол, тайлбарлаж ойлгуулах ёстой зарим нарийн ширийн зүйл байдаг. Гэхдээ үүнийг авшиг хүртэх үед чинь хэлж өгье. Харин одоо бол та нарын "Би аль хэдийн мэднэ", "Би үүнийг мэднэ. Би үүнийг Библээс уншсан. Арван гэрээс л биз дээ? Арван сахил" гэж хэлдэг тэр бүх сахилаар чинь та нарыг залхаахыг хүсэхгүй байна.

Чухамдаа бол бидний олонх нь эдгээр сахилыг уншсан байдаг боловч түүний гүн далд утгыг нь сайтар эргэцүүлэн ухаараагүй юмуу, эсвэл сайн ойлгоогүй байдаг. Магадгүй бид өөрсдийнхөөрөө ойлгоод яг ямар утгатай болохыг нь ойлгодоггүй байж болох юм. Тиймээс үүнийг өөрсдөдөө дахин сануулж, гүн утгыг нь бага боловч сонсоход нь гай болохгүй. Жишээлбэл, Библид болон Хуучин Гэрээний эхний хуудсан дээр Бурхан Би газар дэлхийн хамаг амьтныг та нарын анд нөхөр байг гэж, та нарт туслаг гэж бүтээлээ, тануус тэднийг эзэгнэн жолоодогтун гэсэн билээ. Мөн тэр амьтдад тус бүрт нь өөр өөр хоол хүнс бүтээж өглөө гэж хэлжээ. Харин Бурхан биднийг амьтныг идээрэй гэж ер хэлээгүй билээ. Үгүй, Үгүй! Харин тэр Би газар дэлхий дээр байгаа ургамал ногоо бүхнийг, харахад сайхан, хазахад амттай жимс жимсгэнэ бүтээлээ, тэр бүхэн бол та нарын хоол хүнс болог гэжээ. Гэтэл тун ч цөөхөн хүн үүнд анхаарлаа хандуулдаг биш үү. Тийм болохоор Библийг баримталдаг маш олон хүн Бурхан үнэндээ чухам юу хэлснийг ухаарахгүй мах идээр л байгааг та нар мэднэ.

Хэрэв шинжлэх ухааны дорвитой судалгааг анхаарч үзвэл бид мах идэх ёсгүй юм гэдэгт итгэж үнэмших болно. Бидний бие цогцос, ходоод, гэдэс, шүд зэрэг нь цөм зөвхөн ургамал хоол хэрэглэхэд зохицсон байдаг. Бид төрөхөөсөө л оюун санааны гайхам чадамжтай байдаг боловч олонх маань хурдан хөгширч, өвчин тусч, үлбэгэр дорой, хойрго залхуу болдогт гайхаад байх юм алга. Өдрөөс өдөрт дордсоор нас ахих тусмаа улам мууддаг. Энэ нь бид өөрсдийн нисэх хэрэгсэл болсон бие, ҮМНБ-ээ гэмтээснээс болдог юм. Хэрэв бид энэ унаагаа удаан хугацаагаар аюулгүй ашиглая гэвэл, түүнийгээ зөв арчлан хямгадах хэрэгтэй. Жишээ нь, бид машинтай байлаа гэж бодъё. Мэдээжээр та нар бүгд машин барьдаг. Хэрэв машиндаа тохирохгүй шатахуун хийчихвэл юу болох вэ? Яах вэ? Машин чинь хэдхэн алхам газар яваад л зогсчих байх. Үүнд машинаа буруутгах хэрэггүй. Энэ бол бидний л алдаа, бид андуурч будлиад тохирохгүй шатахуун хийчихсэн шүү дээ. Эсвэл шатахуунд ус орчихсон байлаа гэхэд машин чинь жаахан явж магадгүй ч яршиг түвэг чирэх л байх. Эсвэл тос нь хэт бохирдсоныг бид солиогүй бол жаахан яваад л дахиад асуудал гарна. Заримдаа бас машинаа зохих ёсоор арчлаагүйгээс болж тэр нь дэлбэрч ч мэднэ.

Үүнтэй адилаар, бие цогцос маань бол бид эндээс шинжлэх

ухаанлаг билиг билгүүний нэн өндөр төвшин болох мөнхийн ертөнцөд нисэн хүрэхдээ хэрэглэх унаа хөсөг юм. Гэтэл бид заримдаа түүнийгээ гэмтээж, зүй зохисоор нь хэрэглэж чаддаггүй билээ. Жишээлбэл, машин маань биднийг найз нөхөд, ажил руугаа болон янз бүрийн үзэсгэлэнт газар луу аялахад олон бээр зам туулах болдог. Хэрэв бид машинаа арчлахгүй, тохирохгүй шатахуун, тос хийгээд мөн ус энэ тэр бүгдийг нь анхаарахгүй байвал машин маань их хурдан явж чадахгүй, их хол ч явж чадахгүй. Тэгээд бид арын хашаандаа юмуу, гэрийнхээ ойр орчмоор л эргэлдэнэ. Ингээд байж ч болно л доо. Гэхдээ бид машин авсныхаа хэргийг гаргаж чадахгүй. Зөвхөн мөнгө төгрөг, цаг хүчээ дэмий үрэгдэхээс цаашгүй. Ердөө л энэ. Үүнд хэнийг ч буруутгах аргагүй. Ингэлээ гэж цагдаа таныг торгохгүй. Харин та холын хол газар явж, байгалийн үзэсгэлэнт сайханд цэнгэж, олон сонирхолтой зүйл үзэж харж болохоор байтал машин, мөнгө хөрөнгөө дэмий гарздаж байгаа хэрэг юм.

Бидний бие махбод ч үүнтэй адил. Бид материаллаг ертөнцөд амьдарч байгаа, тиймээс ч энэ бодит бие махбод доторх, өөрсдийг маань чанагуухи ертөнцөд хүргэж чадах зэмсгээ хайрлаж хамгаалах ёстой. Пуужинд суугаад нисдэг сансрын нисэгчтэй адил. Пуужин бол түүний зэмсэг нь билээ. Тэрээр пуужингаар аюул осолгүй, хурдан түргэн нисгэхийн тулд физикийн хуулийг чанд баримтлах ёстой. Харин пуужингаас доторх хүн нь чухал. Пуужин түүнийг зорьсон газарт нь хүргэнэ. Гэвч пуужин гол юм нь биш - гол нь сансрын нисэгч болон хүрэх газар нь л юм. Тэр энэ пуужингаараа зөвхөн Лонг-Айлендыг тойроод байх юм бол бас л цагаа дэмий үрж байгаа хэрэг болно. Улс үндэстнийхээ мөнгө хөрөнгийг үргүй зарж буй хэрэг.

Тийм ч учраас бие цогцос маань дотроо бидний Багш (Дотоодын эзэн)-ийг агуулдаг тул асар их үнэ цэнэтэй зүйл. Библийн сударт “Та бол Бурхны оршдог сүм, бүхнийг чадагч Бурхан дотор тань оршиж байдаг гэдгийг та мэдэх үү?” гэсэн байдаг. Хэрэв бид Ариун сүнс, Бүтээгч Бурхныг агуулагч орон нь юм бол энэ чинь юутай их хариуцлага, ямар их учир утга вэ гэдгийг та ойлгож байна уу! Гэвч ихэнх хүн энэ өгүүлбэрийн цаад агуу их сургаалыг ухааралгүй, гүнд нь нэвтрэлгүй, гүйлгэн уншчихаад ойлгохыг оролдох ч үгүй өнгөрдөг. Шавь нар маань өдөр тутмын мөнгө олох, ажил хаях зэрэг зөрчил тэмцлээр дүүрэн энэ бодит ертөнцийн гадна чанадад юу байдаг тухай, өөрсдийнхөө нь дотоодод хэн оршиж байдаг тухай олж мэдэж чаддаг тул миний сургаалыг дагах дуртай байдаг юм.

Бидний дотоод талд илүү гоо сайхан, илүү эрх чөлөө, илүү эрдэм мэдлэг оршиж байдаг билээ. Бид түүнтэй нэвтрэлцэх үнэн зөв арга замыг мэдэж чадвал энэ бүхэн дотоодод маань оршиж байдаг болохоор цөм биднийх юм. Бид харин түлхүүр нь хаана байгааг мэддэггүй,

“байшингаа” удаан хугацааны турш цоожлоод орхичихсон болохоор дотор нь бидний үнэлж баршгүй эрдэнэс буйг мартчихсан хэрэг. Ердөө л энэ.

Харин Төгс Гэгээрсэн Багш гэдэг бол тэр хаалгыг нээхэд бидэнд тусалж, угаасаа биднийх байсан тэр бүхнийг харуулж өгдөг нэгэн билээ. Бид харин цаг зав гарган тийшээгээ орж, өөртөө байгаа юмсыг нэг бүрчлэн шалгаж үзэх хэрэгтэй.

Тэгэхлээр бид ямар ч атугай хоёрдугаар ертөнцөд байлаа. Та нар цаашаа явмаар байна уу? Үзэгчид Тийм, Тийм! гэв. Та нар өөрсдөө юу ч хийхгүйгээр бүгдийг мэдэхийг хүсч байна уу? (Багш инээв). За яахав. Өөр улсад байж үзсэн хүн бол тэнд та очиж үзээгүй байсан ч тэр улс орон ямар гэдгийг танд ядахдаа ярьж өгч чадна. Тийм биз? Та ямар ч гэсэн сонирхож байгаа болохоор тэнд очиж үзэхийг хүсэж ч магадгүй. Зүгээр дээ. Тэгэхээр хоёрдугаар ертөнцийн цаана юу байдаг вэ. Хоёрдугаар ертөнцийн тухайд бүгдийг нь ярьсангүй, гэхдээ бид энд бүхэл өдөржингөө суугаад байж болохгүйг та бүхэн ойлгож байгаа биз дээ. Ингээд хоёрдугаар ертөнцийг давбал та нар илүү их чадалтай болох нь магадтай. Та нар зориг шулуудан чармайн бясалгавал гуравдугаар төвшинд хүрч чадна. Гуравдугаар ертөнц гэдэг бол ахисан дээд шат мөн.

Гуравдугаар ертөнцөд хүрье гэсэн хүн наад зах нь энэ ертөнцийнхөө өр төлөөсөөс бүрэн салсан байх ёстой болдог. Ойлгож байна уу? Хэрэв бид энэхүү материаллаг ертөнцийн эзэнд ямар нэг өр төлөөстэй бол дээш дэвшихийн аргагүй. Хэрэв та аль нэг улсын хууль ёсыг зөрчсөн, нэр төр цэвэр биш бол өөр улс орны хилийг давж чадахгүйтэй адилхан. Энэ ертөнцийн өр төлөөс нь бид бие махбодын амьдралын өнгөрсөн болон одоогийн төрөлд хийсэн үйлээс бүрддэг бөгөөд мөн ирээдүйд хийх үйлийг ч багтааж мэднэ. Гаалиар байцагдан нэвтэрдгийн адил чанагуухи ертөнцөд очихын өмнө тэр бүхнийг төлж барагдуулах хэрэгтэй болно.

Хоёрдугаар төвшинд байх үеэсээ л урьд төрлийнхөө болон энэ төрлийнхөө үйлийн үрийг төлж эхлэх хэрэгтэй. Урьдын амьдралын үйлийн үр гэж үгүй байсансан бол бид энэ төрөлдөө амьдрах ёсгүй билээ.

Хоёр янзын Багш байдаг. Нэг нь ерөөс үйлийн үр огт байхгүй бөгөөд манай энд бууж ирэхийн тулд бусдаас үйлийн үр зээлддэг. Нөгөө нь бидэнтэй адил, ертөнцийн жирийн хүн бөгөөд үйлийн үрээ цэвэрлэсэн байдаг. Тийм учраас хүн бүр Багш болох буюу, ирээдүйн Багшийн үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэн горилж болно. Зарим үед Багш нар бусдаас үйл үр зээлдэж, дээд ертөнцөөс энд бууж ирдэг. “Үйл үр зээлдэх” гэхлээр ямар сонсогдож байна? (Багш инээв). Гэхдээ энэ бол бүрэн боломжтой, үнэхээр бололцоотой зүйл шүү. Жишээлбэл: та урьд

өмнө энд бууж ирээд саатаж байжээ. Олон зуу, мянган жилийн туршид өдий төдий хүмүүстэй өгөө аваатай байжээ. Дараа нь та тэнгэр лүү буюу өөрийн гэр орон байдаг ямар ч гэсэн тавдугаар төвшин хүртэлх нэн алсын ертөнцүүдийн нэг рүү буцсан байж. Тавдугаар төвшин бол Багш нарын оршин суудаг газар. Гэтэл бас түүний дээр өөр олон төвшин байдаг юм.

Хэрэв бид Дээд Тэнгэрийн бошиг зарлиг юмуу нигүүлсэнгүй сэтгэлийн улмаас жишээлбэл, буцаж ирэхийг хүсвэл доош бууж ирэх хэрэг гарна. Өнгөрсөн үедээ хүмүүстэй холбоотой байсан учир тэдний данснаас, та нарын мэдэх үйлийн үрийг зээлдэж болно. Хүмүүст зөвхөн өр төлөөс л байдаг, өөр ямар ч өөдтэй юм байхгүй. Бид хэсэг өр төлөөсийг нь зээлэн авч, энэ ертөнцөд ирсэн үүрэг зорилгоо бүрэн биелүүлэх хүртлээ бясалгалын хүчээрээ эргүүлэн төлж, барагдуулна. Иймд энэ бол өөр маягийн Багш юм. Мөн энэ ертөнцөөс гаралтай, дээд сургууль төгсөхтэй адил бясалгал хийснээр дороо Багш болсон хүмүүс байна. Тийм ээ. Их сургуульд багш нар байдаг, сургуулиа төгсөөд дараа нь багш болдог оюутнууд ч байдагтай яг адилхан. Маш олон жил ажилласан багш нар, бас дөнгөж төгссөн багш нар гэх мэт байдаг. Үүнтэй адилаар Гэгээрсэн Багш нар ч ийм янз бүр байна.

Ингэхлээр, хэрвээ бид гуравдугаар ертөнцөд дэвшье гэвэл байгаа бүх үйл түйтгэрээ ул мөргүй арилгах хэрэгтэй. Үйлийн үр гэдэг нь “Юу тарина, түүнийгээ л хурааж авах” хууль юм. Бид жүржийн үр тарьсан бол жүрж хурааж авдаг, алимын үр суулгасан бол алим л хурааж авдагтай адил, үүнийг л үйл үр гээд байгаа юм. Самгарьд хэлний энэ нэр томъёо нь шалтгаан ба түүний үр дагаврыг илэрхийлдэг. Библи сударт карма (үйлийн үр)-ын тухай өгүүлээгүй боловч түүн дотор яг үүнтэй адил утга бүхий “Юу тарина, түүнийгээ л хурааж авна” гэсэн үг байдаг.

Библи судар бол гэгээн Багшийн сургаал номлолын товч хэлбэр бөгөөд Түүний амьдрал ч бас товчхон байдаг. Тийм болохоор Библи нэг их зүйлийг тайлбарлаж өгсөнгүй. Библийн хувилбаруудын ихэнхийг нь шашны энэ хөдөлгөөний удирдагчдын шаардлагад нийцүүлж хасаж танасан байна. Гэтэл тэр хүмүүсийг бүгдийг нь Билгүүн ухаантнууд байсан гэхэд хэцүү. Хаашаа ч харлаа гэсэн, хүмүүс юм бүрийг зарж, худалдан авч байдгийг та бүхэн мэднэ шүү дээ. Амьдралын аль тал руу харлаа гэсэн хаа сайгүй борлуулагч - худалдаачдыг харж болно. Бидний ойлгож байгаагаар жинхэнэ үнэн Библи бол үнэн хэрэгтээ арай өөр, илүү урт, оновчтой, ойлгоход хялбархан байсан. Ямар ч атугай, бид үүний ихэнхийг баталж нотлох аргагүй учраас тэр ариун шүтээнийг бузарлаж байна гэж зэмлүүлэхгүйн тулд энэ тухай ярилцсаны хэрэггүй. Бид нотолж чадах зүйлээ л ярьж чадна.

“Та энэ хоёр, гурав, дөрөвдүгээр ертөнцийн тухай ярих юм. Үүнийгээ яаж нотлох юм бэ?” гэж та нар асууж болох юм. Би үүнийг

нотолж чадна. Хэрэв та нар надтай хамт чухам яг тэр замаар явбал миний үзсэн тэр зүйлийг олж үзнэ. Хэрвээ надтай хамт явахгүй бол би танд юуг ч нотолж чадахгүй нь мэдээжийн хэрэг. Нотолгоо байгаа учраас л би ямар нэг эргэлзээгүйгээр энэ зүйлсийн тухай ярихаар зориглосон хэрэг. Дэлхий даяарх зуу зуун мянган шавь нар маань үүний нотолгоо билээ. Тиймээс бид мэдэж байгаа зүйлээ ярьж чадаж байгаа юм. Үүгээр та харин надтай хамт явах ёстой, та явах ёстой шүү. Та “миний өмнөөс яваад дараа нь тэр бүгдийн тухай надад ярьж, үзүүлж өг” гэж болохгүй. Би ингэж чадахгүй.

Жишээлбэл, би НҮБ-ийн энэ хурлын танхимд биеэрээ ирж байгаагүй бол бусад хүн надад яаж дүрслэн ярьсан ч би энэ танхимын талаар бодит ойлголттой болж чадахгүй нь мэдээж. Тийм биз? Тийм болохоор бид замд гарахдаа ямар нэг туршлагатай замчинтай хамт явах хэрэгтэй. Энэ танхимд байгаа янз бүрийн орны шавь нар маань миний та нарт ярьсан зүйлийг бүгдийг, эсвэл заримыг нь биеэрээ амсчихсан байгаа.

Гуравдугаар ертөнцийн цаадах юмс миний өгүүлснээр хязгаарлагдахгүй. Би юмсын зөвхөн хагас заримыг нь л өгүүллээ. Энэ бол гол зүйлийг нь тойм төдий товчхон өгүүлсэн жуулчлалын тухай яриатай адилхан. Ямар нэг улс орны тухай ном уншлаа ч тэр нь жинхэнээсээ тухайн орон нь биш. Тийм биз? Бид далайн чанадын улс орнууд, аялал жуулчлалын тухай ном хичнээн уншлаа ч гэсэн өөрсдөө биеэрээ тэнд очихыг хүснэ. Испани, Генерифийн арлууд, Грекийн тухай бид зөвхөн ном, киноноос мэддэг байж. Бид номоос уншаад амсаж мэдэх аргагүй тэр нутгийн аж төрлийн амьсгал бүхнийг, найрсаг зочломтгой хүмүүсийг нь, цаг агаарын сайхныг нь, далайн гайхамшигтай усанд нь умбаж шумбахыг, тэдний дайлж цайлдаг хоол ундыг нь амсаж, баяр цэнгэлийг нь мэдрэхийн тулд тэнд очих ёстой.

Одоо та бүхэн юутай ч гэсэн гуравдугаар ертөнцтэй танилцлаа гэж бодье. Ингээд дараагийнх нь юу вэ? Мэдээж та нар дараагийн бүр өндөр дээд дөрөвдүгээр ертөнц рүү явна биз. Энэ бол дөрөвдүгээр ертөнц, тэр нь ер бусын гайхамшигтай гэдгээр ч хязгаарлагдахгүй. Энэ ертөнцийн тухай энгийн хүмүүст эгэл жирийн үг хэлээр өгүүлэх нь тэр ертөнцийн эзнийг гомдоох байх гэж зүрхшээж байна. Учир нь энэхүү ертөнц нь маш үзэсгэлэнтэй, харин зарим газраа харанхуй байдаг. Нью-Йорк хотын цахилгаан тасарсан шөнөөс ч илүүтэй харанхуй. Та нар бүхэл бүтэн хот шөнийн цагт гэрэлгүй байхыг үзсэн үү? Тийм ээ! Тэнд түүнээс ч илүү харанхуй. Гэрэл гэгээнд хүрэхийн өмнө түүнээс ч их харанхуй байдаг. Ямар нэг хориотой хот мэт. Бурхныг таньж хүрэхээс өмнө биднийг тэнд зогсооно. Гэвч Багштай, туршлагатай Багштай хамт яваа бол бид түүнийг нэвтрэн гарч чадна. Эс бөгөөс бид тиймэрхүү ертөнцөд төөрөх болно.

Оршихуйн янз бүрийн давхарга, төвшинг туулан гарах үедээ бидний зөвхөн оюун санаа өөрчлөгддөг төдийгүй бие махбод, ухаан санаа, амьдралын бүх зүйл хувирч өөрчлөгддөг. Бид ертөнцийг өөрөөр харж, өөрөөр алхаж, өөрөөр ажиллаж эхэлдэг. Өдөр тутмын ажил төрөл маань хүртэл шинэ утга учиртай болж, бид ямар нэг зүйлийг яагаад ингэж хийдэг, чухам яг энэ ажлыг яагаад хийх ёстой болов, эсвэл яагаад тэр ажлаа солих ёстой вэ гэдгээ ойлгож авна. Амьдралынхаа учир зорилгыг ойлгож мэдээд цаашдаа хий дэмий бухимдаж шаналахаа болино. Тийм шүү! Харин амьдарч байх хугацаандаа бид дараа нь хаа очихоо үргэлж мэдэж байх тул газар дэлхий дээр ирсэн томилолтоо дуусахыг тэвчээртэй, эв найртай хүлээх болно. Үүнийг “Эдүгээх төрөлдөө туулан тонилох” гэдэг. Тийм, тийм! Та нарын зарим нь ийм нэр томъёог урьд өмнө сонсож байсан байх гэж би бодож байна. Харин энэ дотоодод орших баяр жаргалыг бид биеэр мэдрэх ёстой гэдгээс өөр зүйл ярих Багшийг би мэдэхгүй юм. (Багш инээв). Жишээ нь, Мерседес Бенц машиныг хэн өөрөөр тодорхойлон хэлж чадах юм бэ. Тийм үү. Тэр машин яг хэвээрээ л байх болно. Бенц машинтай, Бенц машиныг мэддэг хүн болгон адилхан зүйлийг дүрслэн хэлнэ гэдэг нь мэдээж юм. Гэвч тэр нь зөвхөн дүрслэл төдий болохоос биш Бенц машин өөрөө биш.

Би та нартай тун энгийн үгээр ярьж буй ч эдгээр нь ер бусын зүйлс бөгөөд чин сэтгэлээсээ итгэж, Багшийн дэмжлэг дор хичээнгүйлэн бясалгаж, өөрийн биеэр мэдрэх ёстой зүйл юм. Багштай бол аюул осолгүй байх болно. Бие даан энэ замаар явж бясалган амжилт олох нь сая сая хүний нэгэнд нь л таарч магадгүй аз боловч энэ нь аюул эрсдэлтэй, тэгээд ч амжилт олох баталгаагүй, үр дүн нь найдваргүй. Эрт цагт зарим хүн жишээ нь, Сведенборг өөрөө үүнийг хийсэн гэх, бас Гуржиев ч үүнийг хийж бүх замыг ганцаараа туулж чадсан гэдэг. Гэхдээ энэ хүмүүсийн заримын тухай уншихад иймэрхүү зүйл хийх нь гай гамшиг, аюул осолгүй эд биш байжээ. Тэгээд бас тэд бүгд хамгийн дээд төвшинд хүрч чадсан байх ч албагүй.

Ингээд, дараа нь та бүр дээшээгээ явна. Дөрөвдүгээр ертөнцийн дараа илүү өндөр төвшин болох Тавдугаар ертөнц буюу гэгээрсэн Багшийн оршдог нутагт очно. Гэгээрсэн Багш бүхэн тэндээс ирдэг. Тэдний зэрэг дэс нь Тавдугаар ертөнцөөс өндөр байсан ч тэд тэндээ л суудаг. Энэ нь гэгээрсэн Багш нарын гэр юм. Түүнээс гадна тэнд Бурхны ухааж ойлгоход хэцүү маш олон талын чанар илэрнэ. Би та бүхнийг эндүүрч төөрөлдүүлэхээс сэрэмжилж байгаа учраас өөр удаад ч юм уу, та нар эсвэл авшиг хүртсэнийхээ дараа бага зэрэг бэлтгэлтэй болсон үед ярьж өгье; би та нарт өөрсдийн тань төсөөллийн талаар асар хачирхалтай зарим юмсыг ярьж өгөмз. Төсөөлөл заримдаа хэрхэн Бурхны талаар олон буруу ойлголт өгдгийг ярьж өгнө.

## Лекцийн дараахь асуулт хариултын цаг

А: Гэгээрсэн Багш бусад хүний үйлийн үрийг зээлдэж чадна гэж та ярьсан. Энэ тохиолдолд тэр хүмүүсийн үйлийн үр нь арилж алга болох уу? Энэ нь тэр хүмүүсийнхээ хувьд ямар үр дагаварт хүргэх вэ?

Б: Тийм, тийм. Хэрэв Гэгээн Багш ийм замыг сонгож авсан л бол ямар ч хүний үйл түйтгэрийг арилгаж чадна. Үнэн хэрэгтээ авшиг хүртэх үед бүх шавь нарынхаа урьд төрлийн үйл түйтгэрийг цөмийг нь арилгадаг. Энэ амьдралаа үргэлжлүүлэх боломжтой байлгахын тулд би зөвхөн одоогийн энэ төрлийн чинь үйлийн үрийг л та нарт үлдээдэг. Тэгэхгүй бол бид тэр даруйдаа нөгчиж ангижирчихна шүү дээ. Хэрвээ үйлийн үр байхгүй бол энэ ертөнцөд амьдарч чадахгүй. Тийм учраас гэгээрсэн Багш тухайн хүнийг ариусгахын тулд зөвхөн урьд төрлүүдэд хуримтлагдсан үйлийн үрийг л арилгаж, харин тэр хүн энэ амьдралаа үргэлжлүүлэн энэ ертөнцөд хийх зүйлсээ хийхэд нь зориулж бага сага үйлийн үрийг үлдээж өгдөг. Үүгээр багшийн ажил дуусна. Ингэж байж л тэр хүн цаашаа явдаг юм, тэгэхгүй бол яаж явах вэ? Хэдийгээр шавь нь энэ төрөлдөө үйл түйтгэргүй ариун байвч тэр нь хэр зэрэг цэвэр ариун байдал вэ? Урьд насандаа ямар байсан байх вэ? Ойлгож байна уу?

А: Бясалгал хийхийн зорилго юу вэ?

Б: Ямар зорилготой вэ? Зорилго нь юу болохыг би та нарт хэлээгүй гэж үү? Энэ ертөнцийн чанадад хүрч, Бурхны оронд буцаж очно, билиг ухаанаа танин мэдэж энэ төрөлдөө ч илүү төгс төгөлдөр хүн болно.

А: Ертөнц бүхэнд үйлийн үр байдаг уу?

Б: Үгүй, бүгдэд нь биш. Зөвхөн хоёрдугаар ертөнц хүртэл л байдаг. Учир нь бидний ухаан бодол, уураг тархи болох энэ компьютер нь хоёрдугаар ертөнцийн бүтээл юм. Бид ямар нэгэн ажил үйл хийх гэж өндөр дээд төвшнөөс доош бодит юмсын (материйн) төвшинд уруудан бууж ирсэн байг. Жишээлбэл, Төгс Гэгээрсэн Багш хүртэл мөн тавдугаар ертөнцөөс материаллаг ертөнцөд бууж ирдэг. Ингэхдээ тэрээр хоёрдугаар ертөнцийг дайран өнгөрч, манай энэ ертөнцөд ажиллахын тулд тэндээс компьютер авч угсруулах хэрэгтэй болно. Усанд шумбагч далай тэнгист шумбахад мөн ингэж усны хувцас, хүчилтөрөгчийн сав болон бас бус хэрэгсэл өмсөж зүүх хэрэгтэй болдогтой адил. Уг нь тэр тийм хөгийн дүртэй биш боловч усны хувцас, хүчилтөрөгчийн хэрэгслийг өмсөж зүүмэгцээ яг л мэлхий шиг харагддагийг та нар мэднэ. Яршиг түвэгтэй материаллаг бие махбод, компьютер мэтийг хэрэглэсэн бид ч заримдаа бас ингэж харагддаг юм. Түүнээс биш бид үнэнхүү үзэсгэлэн гоо юм шүү дээ. Хэдийгээр өөрсдийгөө гоо сайхан гэж боддог ч жинхэнэ дүртэйгээ харьцуулбал та нар үнэндээ хичнээн эрэмдэг зэрэмдэг гэдгээ мэдэх үү. Энэ ертөнцийн гүнд шумбан орж,

ажиллаж хөдөлмөрлөхийн тулд тэр бүхнийг өмсөж зүүх хэрэгтэй болдгоос л ийм болсон хэрэг.

Тийм учраас хоёрдугаар төвшнийг туулаад дээш гарах үед бид компьютерээ тэнд үлдээх ёстой. Үүнээс цааш бидэнд түүний хэрэг байхгүй. Шумбагч эрэгт хүрмэгцээ далайд шумбахад хэрэг болсон хүчилтөрөгчийн сав, усны багаа тайлж, өөрийн уг дүр байдалд ордогтой адил юм. Тийм биз? Ойлогж байна уу?

А: Та Хоёрдугаар ертөнцийн төгсгөлд цаашид ахихын өмнө үйлийн үрээ цөмийг ардаа орхих, өөрөөр хэлбэл хамаг үйл түйтгэрээ төлж арилгах ёстой гэж ярилаа. Одоогийн энэ төрлийг олох үед бидэнтэй хамт ирсэн урьд төрлүүдийн бүх үйл түйтгэр үүнд хамаарах уу.

Б: Тийм. Учир нь үүнээс цааш бидэнд энэ компьютер-тархи, юуг ч тогтоон санах хэрэгсэл байхгүй болно. Биет ертөнцийн амьдралын дадал туршлага бүхнийг маань бүртгэн санаж, тогтоох зориулалттай уураг тархи, ой ухаан, энэ компьютер байгаа болохоор л бидэнд үйл үр байгаа хэрэг. Тиймээс л бидэнд үйл түйтгэр байгаа юм. Сайн, муу ямар ч мэдээллийг бид тархиндаа бүртгэчихдэг. Бид үүнийг үйлийн үр гээд байгаа юм. Үйлийн үр гэж юу юм бэ? Бидний төрөл төрөлдөө хуримтлуулсан сайн, муу туршлага мэдлэг, хариу үйлдэл, сурах дадал төдий л юм шүү дээ. Бидэнд ухамсар гэгч юм байдаг болохоор бид сайн хүн байх ёстой гэдгээ мэддэг, гэвч бас заримдаа муу юм ч хийчихдэг. Тэгээд түүнийг үйлийн үр гэдэг. Харин муу муухай үйлдэл маань хүнд ачаа, хэрэггүй хог мэт дарамт болж, газрын татах хүчний хуулиар биднийг доош татан уул өөд авирья гэвч нэн хэцүү байдаг билээ. Энэ ертөнцөд байх ёс суртахууны нэн олон хэв журам, янз янзын үндэстэн угсаатны өчнөөн их дэг жаяг, зан заншил, дадал зуршил нь биднийг сайн муу, гэмтэй гэмгүйн үзэл бодлын хүлээсэнд оруулдаг. Тиймээс бид энэ ертөнцөд хүмүүстэй харилцахдаа тухайн үндэстний зан заншил, өв уламжлал, хууль дүрмийн дагуу сайн, муу, нүгэл, буяны тухай ойлголт туршлага олдог. Тэгээд л тэр маягаар бодож тунгаах нь бидний зуршил болж, би үүнийг хийсэн, би гэм буруутай, би тэгсэн, би муу хүн гэж боддог дадал тогтчихдог. Эд бүгд энд л бичигдэж тэмдэглэгддэг. Биднийг биет болон түүнээс арай дээхнэ орших, хангалттай өндөр биш төвшний ертөнцөд хүлж уяад, янз бүрийн төрөл авахуулаад байдаг зүйл бол энэ. Энэ бүх үзэл бодол, урьдаас тогтчихсон итгэл үнэмшлийн улмаас бид хангалттай эрх чөлөөтэй биш, дээшээ өөдөө хөөрөн гарчихаар хөнгөхөн биш байдаг.

А: Төрөл авах болгонд ямар төвшинд хүрэх нь урьдаас тодорхойлогдчихсон байдаг уу?

Б: Үгүй, бидэнд түргэн юмуу удаан явахаа сонгох эрх чөлөө бий. Жишээлбэл, та машиндаа зуун литр бензин хийсэн бол, та түүгээр хурдан давхиж хүрэх газраа очиж болно. Эсвэл удаан явж ч болно. Энэ нь танаас л хамаарна.

А: Би зүгээр л...сахиулсан тэнгэрийн зэрэг дэвийг мэдэх гэсэн юм.

Б: Ямар зэрэг дэв гэнэ ээ? Өө, ямар сахиулсан тэнгэрийн тухай ярьж байгаагаас л хамаарна.

А: Хамгаалагч - сахиулсан тэнгэр.

Б: Хамгаалагч - сахиулсан тэнгэрүүдийн зэрэг хоёрдугаар ертөнц хүрдэг. Сахиулсан тэнгэрүүдийн зэрэг дэс хүнийхээс доогуур байдаг, доогуур зиндааных. Тэд бидэнд үйлчлэхийн тулд л байдаг юм.

А: Тэд тэгээд хэзээ ч дээш гарч чадахгүй юу?

Б: Үгүй. Хүний төрөл олж төрөхийг нь эс тооцвол шүү дээ. Бурхан хүмүүсийн дотоодод оршдог учраас тэд хүмүүст их атаархдаг. Бурхантай нэг адил зиндаанд байх бүхий л боломж нөхцөл бидэнд байдаг, харин сахиулсан тэнгэрт байхгүй. Энэ нь их нарийн төвөгтэй зүйл учраас дараа нэг тухтай ярья.

Сахиулсан тэнгэрүүд бидэнд үйлчлэхийн тулд бүтээгдсэн. Та нар өөр өөр сахиулсан тэнгэр байдгийг бас мэдэж байгаа биз дээ. Жишээлбэл, хэрэв Бурхан түүнийг бүтээсэн бол тэр нь бидний төлөө л бүтээгдсэн хэрэг. Харин тэд дээшээ гарах ёсгүй...хэрэг ч үгүй. Уг нь тэд дээш гарч болох байсан л даа. Зарим үед төгөлдөржих аятай боллоцоогоор хангагдаагүй зүйлс бүтээгдсэн байдаг юм. Тухайлбал, гэр оронд ая тухыг тань хангахын тулд хийгдсэн зарим юмс байдаг. Жишээлбэл, та энд сууж байхдаа цэцэрлэг юмуу гэрийнхээ бүх гэрлийг асааж унтрааж, зориулалтын хэрэгслээр зурагтаа асааж унтрааж чадна. Хичнээн гайхалтай зүйл байлаа ч гэсэн тэр хэрэгсэл бол зөвхөн таны хэрэгцээг гүйцэлдүүлэх л зориулалттай. Тиймээс хэдийгээр тэр зүйл нь зарим нэг шинж чанараараа танаас илүү, бүр хамаг юмыг хянаж жолооддог, хүний хийж чадахгүйг чаддаг байлаа ч танаас илүү дээр гэсэн хэрэг биш. Тэр бол танд үйлчлэх цорын ганц зорилгоор л бүтээгдсэн. Тэр танаас илүү төгөлдөр сайн байлаа ч тийм биш юм. За юу! Тэр, компьютер хэзээ ч хүн болж чадахгүй.

А: Чин Хай Багш аа, бид одоо бие махбодтой - урьд нь энэ махбодоос чөлөөлөгдсөнөө доошоо унасан байж болох уу гэдгийг мэдэх гэсэн юм. Урьд нь бид үргэлж энэ дэсэнд байсан уу, эсвэл илүү дээд зэрэг дэсэнд байсан юмуу, үгүй бол зөвхөн энэ дэсэндээ л байсан уу? Түргэн урагшилж гэтлэхэд ямар хандлага, байр суурийг баримтлах вэ?

Б: Бие цогцсоо орхиод урагшлах уу? Тийм ээ, хэрвээ яаж гэдгийг нь мэдчихвэл бид тэгж чадна. Бие цогцсоо энд орхичихоод энэ ертөнцийн чанадад очиж болдог олон янзын арга байдаг. Зарим нь хол газарт хүргэдэг, зарим нь бүр холын холд хүргэнэ, зарим нэг нь эцэс төгсгөлд нь хүргэдэг. Залуу цагаасаа өөрийн биеэр үзсэн олон янзын туршлагынхаа үр дүнг харьцуулсны үндсэн дээр би энэ талаар шүүн дүгнэж чадах юм. Би одоо залуу харагдаж байгаа ч тэр үед би залуу

байлаа л даа. Эдгээр бүх аргаас манай бясалгалын арга хамгийн илүү нь юм шүү, тийм ээ! Энэ арга бүхнээс хол, бүгдээс алсад, хамгийн эцэс хязгаарт нь хүргэж чадна.

Өөр бусад олон бясалгалын арга бий, хэрэв та туршиж үзье гэж шийдсэн бол сонгох бололцоо бий. Гадуур олон аргыг санал болгож байна; зарим нь Асурийн ертөнц, зарим нь бүр алс холын гурав, дөрөвдүгээр ертөнцөд хүргэнэ, гэвч тавдугаар ертөнц хүргэж чадах нь тун ховор. Харин манай бясалгалын арга, энэ аргаар хичээллэх нь таныг чөлөөлж явуулахаас өмнө тавдугаар ертөнцөд хүргэх зорилготой юм. Тэндээс та ганцаараа явж болно.

Түүнээс цаашилбал, тавдугаар ертөнцийн цаадах Бурхны өөр чанарт хүрч чадах хэдий ч энэ нь тэр бүр тааламжтай сайхан байдаггүй юм. Бид хичнээн өндөр бол төчнөөн сайн гэж дандаа боддог. Гэтэл тэр нь үргэлж үнэн байдаггүй. Жишээлбэл, заримдаа бид нэгэн сайхан ордонд орох завшаан гарч, гэрийн эзэн зочдын өрөөндөө биднийг урьж суулгаад сэрүүн ундаа, амтат хоол, юм бүхнээр дайллаа гэе. Гэтэл дараа нь бидэнд ордны дотуур жаахан явж үзье гэсэн бодол төржээ. Энэ эрсдэлтэй алхам таныг хог хаядаг газарт аваачиж болно, бас байшингийн бусад олон юмсыг та мэддэг болно. Энэ нь дандаа тийм чухал байдаггүй. Тийм биз? Хэрэв бид цаад ар талын эрчим хүчний байшин, цахилгаан хуваарилах газар очихвол, тогонд цохиулж ч мэднэ, тэгэх юм бол үхнэ шүү дээ. Тийм учраас адал явдалд дурлаж л хийхгүй юм бол юмны гүнд нэвтрэх нь тэр бүр тийм зөвлөмөөр, зайлшгүй хэрэггүй зүйл биш байдаг.

А: Чин Хай Багш аа, надад хоёр асуулт байна. Эхнийх нь, хэрэв урьд төрлөө дурсан саналаа гэхэд урьд төрлийн тухай дуртгал аль ертөнцөөс ирдэг вэ? Хоёрдугаарт нь, урьд төрөл нь одоогийн үйлийн үртэй болон хүний энэ насны ойлголт, ухааралтай ямар хамааралтай вэ? Эдгээр нь “илүү ачаа” мөн үү?

Б: Тийм, тийм. Тэдгээр нь маш их холбоотой. Нэгдүгээр асуулт, урьд төрлийн үйлийн үр хаанаас ирдэг? Та ямар ч эргэлзээгүйгээр урьд төрлийн тэмдэглэлээ уншиж чадна. Урьд төрлийн тэмдэглэл миний өмнө ярьсанчлан Акашийн бичээст хадгалагдаж байдаг юм. Энэ бол хоёрдугаар ертөнцөд байх номын сан шиг зүйл бөгөөд тэнд хүрч чадвал хэн ч өөрийн өнгөрсөн амьдралаа уншиж чадна. НҮБ-ын номын санд хэн хүн хамаагүй нэвтэрч, ашиглаж чадахгүй. Гэхдээ намайг, жишээлбэл, лекц уншаач гэж НҮБ-ээс урьсан учраас би өнөөдөр орж болно. Тийм биз? Хүн бүр орж чадахгүй ч та нар энд үргэлж байдаг юм чинь орж болно. Яг үүнтэй адилаар хоёрдугаар ертөнцөд нэвтэрч чадмагцаа бид урьд төрлөө уншиж чадна. Түүнчлэн нэгдүгээр ертөнцөд нэвтрэхэд тэндхийн зарим нэг хэсэгт бид бас хүний урьд төрлийг зэрвэсхэн харж чадна. Гэвч энэ нь тийм өндөр зэрэглэлийн, бүрэн гүйцэд тэмдэглэл биш.

Урьд төрлийн ойлголт, туршлага одоогийн үйлийн үртэй ямар

хамааралтай вэ? Одоогийн амьдралаа жолоодохын тулд бид тэр ойлголт, туршлагауудыг сурсан юм гэж хэлж болно. Ойлгож байна уу? Урьд төрөлдөө ухаарч мэдсэн бүхнээ та одоогийнхоо амьдралд хэрэглэнэ. Үүнтэй адилаар, та урьд төрлийг тань тун ихээр санагдуулсан ямар нэг бэлгэ тэмдгийг олж үзвэл урьдны дэндүү олон таагүй явдлууд тань танд айдас төрүүлнэ. Жишээ нь, урьд төрөлд тань хэрэв гай тохиолдон харанхуйд шатнаас унаж, түүнээсээ хүнд гэмтэж, туслах хүн ойр хавьд байгаагүй бол одоо та шатаар буух болбол нэг л эвгүйцнэ; ялангуяа шат их өндөр, доор их харанхуй бол буух уу, болих уу гэсэн ямар нэг дотоод эргэлзээ, тэмцэл шиг юм төрнө. Эсвэл урьд төрөлдөө та шинжлэх ухааны ямар нэг салбарыг гүнзгий судлаж, шинжилж байсан бол одоогийн энэ төрөлдөө урьдынх шигээ түүнийг сонирхсон хэвээр байх болно. Тэгэхээр, та эрдэмтэн биш ч шинжлэх ухааны судалгаанд урьдын адил тэмүүлэн татагдана. Ямар ч зүйл ийм л байдаг.

Моцарт дөрөвхөн настайдаа тийм агуу суут болсны учир нь энэ. Тэр төгөлдөр хуураар тоглонгуугаа л алдаршаад одоо хүртэл нэр алдартай хэвээр байна. Моцарт урьдын төрөл төрөлдөө маш их дасгал сургууль хийж, төгс эзэмшсэн учраас л суутан болсон юм. Гэвч үүнийхээ дараа насан эцэслэжээ. Төгс төгөлдөрийн оргилд хүрэхээсээ өмнө нас нөгчиж. Гэвч хөгжимд нэн дуртай байсан болохоор алдар хүндийн оргилд хүрэлгүй мэргэжлээ зүгээр ингээд орхиод явчих ёстой болсонд сэтгэл ханамжгүй байв. Тэр үхэх үедээ цааш үргэлжлүүлэх хүсэл тэмүүлэл нь маш их байсан болохоор эргэж ирж, урьд төрлийн хөгжмийн авьяас билгийн хуримталсан туршлага нь ч эргэж заяажээ.

Энэ хүмүүсийн зарим нь энэ ертөнцөд дахин төрөхөөсөө өмнө Асурийн юмуу хоёрдугаар ертөнцөөс ихээхэн зүйл сурдаг. Тийм учраас тэд бусад хүний мэддэггүй шинжлэх ухааны, эсвэл хөгжмийн, уран зохиолын эсвэл ямарваа нэг шинэ бүтээл туурвилын санаанд багтамгүй авьяас чадвартай байдаг. Бусад хүмүүс зөвхөн ойлгохын аргагүй төдийгүй бүтээе гэж санаанд нь ч орж ирэхээргүй тийм ер бусын шинэлэг бүтээл гээд бод л доо. Яагаад гэвэл тийм зүйлийг тэд үзэж харж, сурч судалсан хэрэг.

Эндээс, аливаа зүйлийг хоёр янзаар; нэг бол энэ ертөнцөд, үгүй бол чанагуухи ертөнцөд сурч мэддэг гэж хэлж болно. Авьяас төгөлдөр хүмүүс болон агуу суутан мэт гарамгай сод хүмүүс бол чанагуухи ертөнцийн мэргэжилтнүүд; тэд Асурийн ертөнц, хоёрдугаар ертөнц, хэрэв эргэж ирэхээр шийдсэн бол зарим үед гуравдугаар ертөнцөөс ч ирдэг. Тэд бол онцгой. Тэд бол – суут хүмүүс.

А: Таны авшиг чухам юу агуулдаг вэ? Мөн авшиг хүртсэний дараахь өдөр тутмын бясалгал дасгалын бүрэлдэхүүнд юу багтдаг вэ?

Б: Юуны өмнө энэ бүхэн нь үнэ төлбөргүй, тэгээд бас та цаашид ахиж дэвшихийг хүсвэл өөрийгөө өөрөө хариуцахаас биш өөр ямар ч

уяа хүлээсэнд баригдахгүй. Нөхцөл нь гэвэл ямар ч дадал туршлага шаардлагагүй. Аль нэг йог юмуу бясалгалын тухай өмнөх мэдлэг хэрэггүй. Гэхдээ та насан туршдаа махгүй хоол хэрэглэхээ амлах ёстой. Өндөг идэж болохгүй. Сүү болно, бяслаг болно. Амь хороогоогүй ямар ч юм болно.

Учир нь өндөг үр тогтоогүй ч гэсэн хагас амь хороосон идээнд ордог. Үүнээс гадна түүний нэг чанар нь сөрөг энергийг татах хандлагатай байдаг. Та бүхний мэдэж байгаагаар чухам ийм учраас хар, цагаан дом хийдэг хүмүүс, эсвэл вүүдүү гэж нэрлэгддэг хүмүүс ад дон шүглэж, галзуурсан хүнээс адыг нь соруулж авахад өндөг хэрэглэдэг. Та нар үүнийг мэдэх үү? (зарим хүн мэднэ гэв) Та мэддэг үү? Ай, энэ чинь гайхалтай хэрэг. Ядаж л надад та бүхэнд зориулах агшин зуурын гэгээрэл үгүй юм аа гэхэд агшин зуурын нотолгоо байна. (инээлдэв)

Ингээд авшиг хүртэх үед та бүхэн Бурхны гэрэл, аялгууг мэдэрнэ. За? Сүнсний дуу аялгуу та бүхнийг ухамсрын өндөр дээд төвшин руу татаж аваачна. Та нар самадийн амт, гүн гүнзгий амар амарлингуй, баяр баяслыг ойлгож мэдрэх болно. Тийм ээ.

Үүний дараа хэрэв та буурьтайхан шийдсэн бол бясалгалаа гэртээ хийж болно. Хэрвээ та үгүй гэвэл би таныг цаашид албадаж, зовоож залхаах аргагүй юм. Та үргэлжлүүлэн хийж, миний тусламж танд эцсийг хүртэл хэрэгтэй бол би тусалсаар л байх болно. Хэрэв үгүй бол энэ бол танаас хамаарна гэдгийг та харж байгаа. Гэхдээ өдөрт хоёр цаг хагас бясалгана. Өглөө эрт босох болон унтахаасаа өмнө хоёр цаг, өдрийн хоолны үеэр хагас цаг бясалга. Би энд яриа хийгээгүй үед та нарт үдийн хоолны бүтэн цаг байдаг. Та нар хаа нэгтээ ганцаараа сэмхэн суугаад бясалгаж болно. Ингээд л бүтэн цаг гараад ирлээ шүү дээ. Тийм биз. Орой бол дахиад нэг юмуу, хагас цаг бясалгана. Өглөө ердийнхөөсөө нэг цагийн өмнө бос.

Ажил амьдралаа эмх цэгцтэй болго, телевиз бага үз, хов живээ багасга, утсаар бага ярь, сонин бага унш, ингэвэл та бүхэнд чөлөөт цаг маш их гарна. Үнэндээ бидэнд цаг их байдаг ч бид түүнийгээ дэмий хоосон үрдэг. Лонг-Айленд явахын оронд машинаараа арын хашаан дотроо давхиж байгаагаас ялгаагүй. Миний хариулт санаанд тань нийцэж байна уу? (Асуугч тийм гэв.) Насан турш бясалгал хийнэ гэсэн сайн дурын хариуцлагаас өөр ямар ч нөхцөл болзол байхгүй. Ингээд таны хүссэн хүсээгүй амьдралд тань өдөр бүр янз бүрийн сайн сайхан өөрчлөлт хувирал гарч, янз бүрийн гайхамшиг тохиолдоно. Ийм зүйл яаж ийгээд л тохиолдох болно. Хэрвээ та үүнд үнэнээсээ буурьтай хандвал газар дэлхий дээр байхдаа диваажин гэж юу болохыг жинхэнээр нь амсаж мэдэрнэ. Чин сэтгэлээсээ, тогтвортой хичээллэж, улам улам сайхныг олж мэдэрсээр байгаа учраас олон зуун мянган шавь нар маань удаан жилийн турш намайг ийнхүү дагаж итгэсээр байгаа юм.

А: Ухамсрын уг чанарыг тайлбарлаж өгнө үү?

Б: Ухамсрын мөн чанар, за. Үүнийг тайлбарлах амаргүй ч та оюун ухаанаа ашиглан төсөөлж болно. Энэ бол билгүүн ухааны нэг төрөл, та ямар нэг зүйлийг урьд өмнө хэзээ нэг цагт мэдэж байснаасаа илүү мэдэж байгаа юм шиг. Тийм ээ, та энэ ертөнцийн зааг хязгаарын гаднах ямар нэг зүйлийг мэддэг, бас урьд өмнө мэддэггүй байсан энэ ертөнцийн ямар нэг зүйлийг мэддэг. Мөн урьд өмнө нь ойлгодоггүй байсан, эсвэл ойлгож чаддаггүй байсан олон зүйлийг ойлгож мэддэг. Энэ бол ухамсар.

Тэгээд энэ ухамсар, эсвэл билгүүн ухаан гэж нэрлэдэг зүйлээ нээнгүүт та хэн юм бэ, яагаад энд байгаа юм, энэ ертөнцийн чанадад өөр юу байдаг юм, газар дэлхийн хүний зэрэгцээ өөр хэн оршин байдаг юм гэдгийг үнэхээр ойлгох болно. Олон зүйл байдаг. Тэгэхлээр ухамсрын төвшин нь яг л коллеж төгсөхтэй адил, ойлголтын янз бүрийн дэсийн нэг нь л юм. Төгсөх хүртлээ хичнээн их юм сурна төчнөөн их юм мэднэ.

Ийм хийсвэр ойлголтыг тайлбарлах амаргүй л дээ, гэхдээ би чадлаараа хичээлээ. Ухамсар бол сэхээрэл гэж хэлж болох юм. Сэхээрэл гэж юу болохыг тайлбарлах хэцүү. Та ухамсрын өөр, илүү өндөр төвшинд хүрэхэд таны сэхээрэл өөрчлөгдөнө. Та юмсыг өөр янзаар ойлгож, өөр байдлаар мэдрэх болно. Та туйлын амгаланг мэдэрч, нэн амар амарлингуй, аз жаргалтай болно. Таны санааг зовоох юм үгүй болж, өдөр тутмын амьдралын тань юм бүхэн тов тодорхой болно. Элдэв зүйлийг хэрхэн эмхлэн төвхнүүлэх, төвөг бэрхшээлийг яаж амар хялбар зохицуулахаа мэддэг болно. Энэ нь тэр байтугай материаллаг төвшинд ч хэдийнээ ач тусгаа өгнө. Харин та дотоод талдаа юу мэдэрч буйг зөвхөн та өөрөө л мэдэж байх болно. Яг л хайртай бүсгүйтэйгээ гэрлэснээс өөрцгүй, таны юу мэдэрч байгааг та л мэднэ. Өөр хэн ч таны өмнөөс үүнийг мэдэрч чадахгүй.

А: Эрхэм Багш аа, нэвтэрхий ухаанаа бидэнтэй хуваалцсанд тань баярлалаа. Та миний ухаан санаанд байгаа нэгэн зүйлд анхаарлаа хандуулж болохсон болов уу гэж би гайхширч байна. Яагаад урьд цагт их хэцүү байсан байтал өнөө үед ийм олон багш газар дэлхийд ирж бидэнд аливаа зүйлийг хурдан түргэн хийж сурах бололцоо олгож байна вэ? Та үүнд анхаарлаа хандуулж тусална уу?

Б: Тийм ээ, бололгүй яахав. Яагаад гэвэл манай эрин үед холбоо харилцаа сайжирсан байна. Тийм учраас бид багш нарын тухайд илүү их мэддэг болжээ. Гэхдээ энэ нь урьд цагт багш нар байгаагүй юмуу, эсвэл тэдэнтэй уулзаж учрах аргагүй байсан гэсэн үг биш. Мэдээжээр зарим багш бусдыгаа бодохноо олж уулзахад хялбар байдаг нь үнэн л дээ. Энэ нь түүний өөрийнх нь сонголт, бусдад өөрийгөө зориулах хүсэл, бас хүмүүстэй хэр ойр дотно байдгаас ихээхэн хамаардаг. Гэлээ ч гэсэн тухайн цаг үе, эрин зуун бүхэнд нэг, хоёр, гурав, дөрөв, таван



багш хэзээд байдаг юм. Цаг үеийн шаардлагаас л хамаарна. Манай үед аз болж олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевиз, радио өргөн нэвтрүүлэг, богино хугацаанд сая сая хувь, сая сая ширхэгээр хэвлэгддэг ном зохиол байгаа учраас л бид янз бүрийн төвшний болоод олон янзын багш одоо оршиж байна гэдэг талаар илүү сайн мэдэж сэхээрсэн хэрэг.

Урьд цагт ном хэвлэхийн тулд эхлээд бүхэл бүтэн мод унагаж, түүнийгээ дорхноо “ямбий” болж дахин хэрэглэхийн аргагүй болдог болхи сүхээр хагалж, дараа нь өө сэвийг нь арилгах гэж чулуу болон элдэв бус юмаар зүлгэж өнгөлөх хэрэгтэй болно. Тэгсний дараа үг бүрийг нь сийлдэг байжээ. Библийг бүтнээр нь тээвэрлэхэд бүхэл бүтэн жингийн цуваа шаардагддаг байв. Ойлгож байна уу? Хэрэв тэр үед машин байсан бол асар том ачааны машин хэрэгтэй болох байв. Бидэнд ийм олон багш мэдэгдэж байдгийн учир нь энэ.

Тийм шүү, энэ нь маш азтай хэрэг. Энэ бол бидэнд л төдий чинээ сайн - та харж байгаад аль хүссэнийгээ сонгон авч болно. Ингэснээр хэн ч таныг хуурч мэхлэн “Би хамгийн сайн нь” гэж чадахгүй. Тийм ээ, та харьцуулан үзэж, билиг ухаан, эрдэм ухаанаа ашиглан, шүүн тунгааж “Өө, энэ нь хамгийн сайн нь”, эсвэл “Тэр нь надад илүү таалагдаж байна”, “Аймаар царай зүстэй”, “Өө, тэр нь царай муутай” гэх болно. (инээлдэв).

А: Та сонголт хийх тухай ярьсан болохоор өөр багшаас авшиг хүртсэн хүнд та авшиг хүртээх үү?

Б: Хэрвээ тухайн хүн намайг өөрийг нь илүү өндөр дээд төвшинд илүү хурднаар хүргэх чадвартай гэж чин үнэнээсээ итгэж байвал л авшиг хүртээж болно. Түүнээс биш, хэрвээ тэр хүн багшдаа ихэд итгэж, хүчтэй татагдаж буйгаа мэдэрсээр байгаа бол тэр багштайгаа байсан нь илүү сайн. Хэрвээ та багш тань хэдийнээ хамгийн сайн нь гэж итгэж байгаа бол түүнийгээ бүү солиорой. Хэрэв та эргэлзсээр байгаа бол, миний дээр дурьдсан гэрлийг үзэж, аялгуу сонсоогүй байгаа бол туршаад үзэж болох юм. Тийм шүү. Гэрэл болон аялгуу бол жинхэнэ Багшийн хэмжүүр. Танд агшин зуур гэрэл, аялгуу үзүүлж чадахгүй байгаа хэн нэгэн бол жинхэнэ багш биш. Ийм юм хэлсэнд өршөөгөөрэй. Тэнгэрт хүрэх зам гэрэл, аялгуугаар тоноглогдсон байдаг. Хэрэв та далай тэнгист шумбах гэвэл хүчилтөрөгчийн баг зэрэг бүх юмыг өмсөж зүүх хэрэгтэй болдогтой яг адил. Янз бүрийн юманд зориулагдсан зүйлс байдаг. Тийм ч учраас та бүхэн гэгээнтнүүдийн хөрөг дээр тэргүүн тушаа нь цагираг байхыг хардаг. Энэ бол гэрэл. Хэрвээ та энэ аргаар бясалгал хийх юм бол Бурхны хөрөгт Есүсийг дүрслэн зурсантай яг ижил гэрэл цацруулах бөгөөд хүмүүс түүнийг чинь харах болно. Хэрвээ тэр хүмүүс үзмэрч (онцгой чадвартан) бол таны гэрлийг олж үзнэ. Есүсийг гэрлийн цагирагтай, Буддаг туяаран цацарсан гэрэлтэй зурдгийн учир нь энэ.

Хэрвээ та нээлттэй бол өндөр төвшний бясалгагч нар гэрэлтэйг олж үзнэ. (Багш дух руугаа заав). Олон хүн үүнийг олж үзэж чаддаг. Энд байгаа хүмүүсээс олж үзсэн хүн байна уу? Та юу? Та юу үзсэн бэ?

А: Би биеийн гэрлийн бүрхүүд, гэрлийн бүрхүүд (аура) харж чаддаг...

Б: Тийм үү, гэхдээ аура бол гэрэлтэй адилгүй. Аура янз бүрийн өнгөтэй байдаг. Заримдаа хар, заримдаа кофе, кофений өнгөтэй, заримдаа бол шар юмуу улаан байдаг. Тухайн үед тэр хүн ямар зантай байхаас хамаардаг. Хэрэв та оюунлаг сүнсний хүчтэй гэрлийн биетэй хүнийг харах юм бол ялгааг нь мэдэх болно. Тийм ээ?

А: Надад үнэндээ асуух зүйл алга. Би зүгээр л ... Би Ража-Йогоор хэсэг зуур хичээллэж байсан юм.Тэгээд би бас аура харсан байх гэж бодож байна. Би тэр үед нэг их юм ойлгож мэддэггүй байсан гэх гэсэн юм.

Б: Та одоо түүнийгээ харахгүй байна уу? Зөвхөн хааяа л хардаг уу?

А: Үгүй, би одоо бясалгал хийхээ больсон.

Б: Өө, тийм учраас та авъяас чадвараа алдсан байна. Бясалгалаа дахиад хийх хэрэгтэй. Хэрвээ та зөв зам сонгосон гэдэгтээ итгэсээр байгаа бол дахин бясалгал хийх хэрэгтэй. Ингэх нь танд ямар нэг хэмжээгээр тус болно. Хор болохгүй, тийм үү?

А: Таны танилцуулах хуудсан дээр таван сахил байдаг талаар уншлаа. Авшиг хүртэсний дараа амьдралдаа энэ сахилыг баримтлах хэрэгтэй юу?

Б: Тийм, тийм, тийм. Энэ бол энэ ертөнцийн хууль.

А: Садар самуун - бэлгийн харилцааны дур зоргоороо байдал гэдгийг би сайн ойлгохгүй байна.

Б: Энэ бол хэрэв танд нөхөр байгаа бол хоёр дахь нөхрийн тухай битгий бодоорой гэсэн үг. (инээлдэв) Маш энгийн. Амьдралаа бэрхшээл зовлонгүй эгэл жирийн болго. Хэрүүл маргаан, сэтгэлийн түгшүүр үүсгэх шалтаг бүү эр. Тийм шүү. Энэ нь бусад хүнийг зовоох болно. Бид бусдад хор хөнөөл болох учиргүй, сэтгэл санаанд нь ч хүртэл хор хөнөөл учруулах ёсгүй. Үүнийг л хэлж байгаа юм. Бид зөрчлөөс зайлсхийж, сэтгэл санаа, бие махбод, оюун ухааны талаар хэнийг ч ялангуяа ойр дотныхноо зовоохгүй байхыг хичээх ёстой. Ердөө л энэ. Хэрэв танд хэн нэг өөр хүн байдаг бол хайртай хүндээ битгий хэлээрэй. Таны хэлснээс болоод улам их зовох болно. Өөрөө энэ асуудлаа яаралгүй, чимээгүйхэн шийдвэрлэ, тэр хүндээ хэлэхгүй байсан нь дээр. Заримдаа хүмүүс хэрэв тэд амрагийн холбоотой бол гэртээ ирээд бүгдийг нь эхнэр юмуу, нөхөртөө илчлэн хэлдэг. Тэгээд ингэх нь үнэнч шударга, ухаалаг хэрэг гэж үздэг. Энэ бол утгагүй явдал. Увайгүй хэрэг. Та нэгэнт

алдаа хийчихээд тэр хог новшоо гэртээ чирч ирж, бусдыг үүгээрээ бас “гялайлгах” хэрэг юу байна. Хэрвээ хүн энэ тухай мэдэхгүй бол тэгтлээ зовж шаналахгүй шүү дээ. Мэдэж байна гэдэг нь л хүнийг шаналгадаг. Тэгэхлээр бид өөрийнхөө асуудлыг өөрөө шийдвэрлэх, түүнийг дахин давтахгүй байхыг хичээх хэрэгтэй. Ингэх л ёстой. Энэ талаар амраг хүндээ хэлэхгүй байх нь дээр. Учир нь түүнд зовлон шаналал авчирна. Амрагийг тань зовоож шаналгана.

А: Ихэнх оюуны Багш нар хошин шогийн асар их мэдрэмжтэй байдгийг би ажигласан. Хошин шог болон оюун санааны бясалгал дасгал хоёр ямар холбоотой вэ?

Б: Өө, тийм үү? Тэд өөрсдийгөө амар амгалан, аз жаргалтайгаар мэдэрдэг, аливаа бүхэнд санаа зовнихгүй ханддаг гэж би бодож байна. Бас бусад хүн аливаа зүйлийг ноцтой байдлаар хүлээж аваад салж ядан зууралдаж байхад тэд энэ амьдралд тохиолдох ямар ч утгагүй хөгийн зүйлс, бусад хүн хийгээд өөрсдийгөө шоолон инээж чаддаг.

Бид бясалгаж эхэлсний дараа ямар нэг байдлаар сул чөлөөтэй болж, тийм сүрхий чухал улс байхаа больдог юм. Хэрвээ маргааш үхэх л бол үхнэ, амьдрах л бол амьдарна. Хамаг юмаа алдчихсан бол алдаа л биз, хэрэв бидэнд бүх юм байгаа бол тэр л биз. Гэгээрсний дараа бид ямар ч нөхцөлд өөрийгөө аваад явчих хангалттай билиг ухаантай, авъяас чадвартай болно. Тэгээд бид юунаас ч айж эмээдэггүй. Бид айдас хүйдэс, зовлон түгшүүрээ хаячихсан. Тийм ч учраас бид амар амгалан байдаг хэрэг. Бид энэ ертөнцөд татагдан хоргоддоггүй. Олж авсан, алдаж гээсэн зүйлс маань бидэнд нэг их юм байхаа больдог. Хэрэв бид ихээхэн олз ашиг олбол түүнийгээ гагцхүү бусад хүний тусын тулд мөн ойр дотныхныхоо ашиг тусын төлөө өргөчихдөг. Түүнээс биш бид өөрсдийнхөө бие болон амьдралаа тэр их тэмцэл зөрчил, зовлон бэрхшээлийг туулан байж хадгалж хямгадаад байх тийм чухал зүйл гэж үздэггүй. Хадгалж хямгадаж байгаа бол болж л байна. Энэ нь бид өдөржингөө орон дээр, битүү арзайсан хадаастай йогийн дэвсгэр дээр суугаад л бясалгаад л байж байдаг гэсэн үг биш. Бид харин хөдөлмөрлөдөг.

Жишээлбэл, би ажилласаар л байна. Би зураг зурж, гар урлалын бүтээлээрээ амьдралаа залгуулдаг. Би хэнээс ч мөнгө төгрөгийн өглөг авахыг хүсдэггүй. Тэр байтугай миний олж байгаа мөнгө бусад хүнд туслахад минь ч хүрэлцдэг юм. Би дүрвэгсэд, байгалийн гамшигт нэрвэгдэгсэн хүмүүст тусалж чаддаг. Бид яагаад ажиллах ёсгүй билээ. Гэхдээ бидэнд ийм их авъяас чадвар байна, тэгээд ч гэгээрсний дараа амьдрал нэн амар хөнгөн болдог учир бидэнд санаа зовоод байх шаардлага огт үгүй гэдгийг мэдэрдэг. Бид зүгээр цаанаасаа л нэг санаа амар байдаг юм. Үүнээс л хошин зан гарч ирдэг юм даа. Ингэдэг гэж би бодож байна.

Таны бодлоор надад хошигнох чадвар байна уу? (Хүмүүс:

Байна) (Инээлдэж алга ташив). Тийм үү. (Багш инээв). Тэгвэл би ямар ч гэсэн Багш мөн бололтой, тийм ээ. (инээлдэв) За за. (Багш инээв) Та нарын төлөө би Багш мөн байна гэж найдъя, та нар хоёр цагийн турш гэгээрээгүй багшийг сонсож цаг заваа хоосон үрээгүй юм байх гэж найдъя.

А: Энэ бол үнэнийг эрэн хайгч хүмүүс бидний үргэж л асуудаг, тэгээд хариуд нь онол болон домог олж сонсдог тийм асуултууд. Би зүгээр л таныг энэ тухайд юу хэлэх бол гэдгийг л сонсох гэсэн юм. Эхнийх нь “Бид хэн бэ? Би хэн бэ? Би гэртээ яаж харихаа мэдэх аргагүй энэ хүнд хүчир байдалд хэрхэн орчихсон юм бэ?” Би гэрээ хэрхэн орхисон, гэртээ буцаж харих нь яагаад тийм чухал юм бэ? Тэгээд бас та тавдугаар ертөнцөд эргэж очих тухай, түүнээс цааш явах шаардлага байхгүй тухай ярилаа. Гэхдээ хэрэв түүнээс цааш ямар нэг юм байдаг бол түүний оршиж байгаагийн утга учир нь юу вэ? Хэрвээ би тийшээ заавал буцаж очих шаардлагагүй бол энэ нь надад ямар хамаа байна? Иймэрхүү асуултууд байна.

Б: Одоо л байдал нэг хошин тийшээгээ хандах нь шиг байна. (инээлдэж, алга ташив). За тэгэхээр, “Би хэн бэ?” гэдэг асуултын хувьд бол Та Нью-Йорк муж улсаар дүүрэн байгаа Зен багш нарын нэгнээс очиж асуу. Та шар хуудаснаас (лавлах номыг нэрлэдэг) хайвал түүнийг олж чадна. (Инээлдэв). Би энэ чиглэлээр мэргэшээгүй.

Хоёр дахь нь “Та яагаад энд байгаа юм бэ?” Танд энд байх нь таалагддагаас ч болсон байж магадгүй биш үү? Түүнээс биш Бурхны хүүхэд биднийг хэн энд албадан байлгаж чадах юм бэ? Бурхны хүүхдүүд хэмээгдэгсэд нь Бурхантай өөртэй нь адилхан, үгүй гэж үү? Ханхүү бол аль нэг юмаараа хаантай төстэй, ямар нэг хэмжээгээр хаантай адил, эсвэл ирээдүйн хаан мөн. Тийм учраас хэрэв түүнд хаа нэг газар байх нь таалагдаж байвал тэр тэнд л байх болно. Ямар ч атугай, бид өөрийгөө сорьж турших гэж диваажинд юмуу, өөр хаа нэг газар байхаа чөлөөтэй сонгодог. Та хамгийн анх, эрин галавын тэртээд ямар нэг адал явдалтай, айдас төрүүлсэн юмыг таньж мэдэх гэж энд байхаар шийдсэн байх. Зарим хүмүүст хурц осолтой мэдрэмж таалагддагийг мэднэ биз дээ.

Жишээ нь, ханхүү ордондоо байж болно, эсвэл байгалийг нээн судлах сонирхолтойн улмаас ой ширэнгээр тэнүүчилж болно. Ийм байж болох юм. Ордны маань үүдэнд хамаг юмыг маань бэлдээд тавьчихдаг учраас бидэнд их уйтгартай, диваажин уйтгартай байсан байж мэднэ. Тиймээс бид өөрийнхөө төлөө өөрөө юм хийхийг хүсчээ. Хааны гэр бүлийнхэн заримдаа өөрсдөө хоолоо хийж, зарц шивигчингээ хажуудаа байлгахгүйг хүсдэгтэй л адил юм. Тэд тос, сүмсээр өөрсдийгөө болон орчноо хаа сайгүй будаж завааруулчихдаг боловч энэ нь тэдэнд сайхан санагддаг. Хаад ноёдод нэг их тохирмоор зүйл биш харагдавч тэд үүндээ дуртай байдаг юм.

Жишээ нь, надад жолоо барьж өгөх хүмүүс байна, хаашаа ч явлаа

гэсэн хүмүүс миний жолооч байх дуртай байдаг. Гэхдээ зарим үед би өөрөө жолоодож давхимаар санагддаг. Би өөрийнхөө утаагүй, цагт 10 км/цагийн хурдтай, цахилгаанаар тэжээгддэг бяцхан гурван дугуйтыг унадаг. Би ингэж ийшээ тийшээ давхих дуртай. Тийм шүү. Учир нь би хаана ч очсон хүмүүс намайг шууд анзаарч таньдаг учраас заримдаа хүмүүс нь намайг таньж мэдэхгүй хаа нэг газар луу явмаар санагддаг юм. Намайг хайж олоод нэрд гаргасан тэр цагаас миний хувьд үүрэг хариуцлага болсон лекцээ унших ёстойгоос бусад үед би их ичимхий нэрэлхүү хүн. Байн байн зугтаагаад явчихаж чаддаггүй ч зарим үед би хоёр, гурван сараар хол явчихдаг юм. Яг л нэг нөхрөөсөө оргож зугтдаг эрх эхнэр шиг. Энэ бол миний сонголт.

Магадгүй та энд хэсэг хугацаагаар байхыг сонгосон байж мэдэх юм. Одоо бол та энэ ертөнцийн тухай хангалттай мэдлэгтэй болж, сурч мэдмээр өөр юм үгүй мэт санагдаж, аяллаас залхсан тул явахыг хүсэх цаг тань ирсэн байж магадгүй. Та амрахыг хүсч байгаа биз. Эхлээд гэртээ хариад амар. Дараа нь аюул осолтой аялалд дахин гарахыг хүсч байна уу, үгүй юу гэдгээ хараарай. Энэ хүртэл миний хэлж чадах юм ердөө ийм байна.

Та яагаад гэртээ буцаж очих ёстой вэ? Бас яагаад зургаад биш, тавд очих ёстой гэж? Энэ нь танаас л хамаарна. Тавд очсоны дараа та дуртай тийшээ явж болно. Дээшээ тун олон төвшин бий. Та ойлгож байна уу? Гагцхүү тэнд байхад илүү тохиромжтой, илүү ая тухтай байдаг юм. Түүнээс цааш дээшээ бол хэт хүчирхэг төвшин байдаг гэж хэлмээр юмуу даа. Та түр хугацаагаар очиж болох ч танд тэнд үлдэж амрах хүсэл төрөхгүй байх.

Жишээлбэл, таны орон байр их сайхан, бие засах газар нь хэдийгээр байшингаас тань цаана байдаг ч та тэнд үүрд үлдэж амрахгүй. Энэ нь уул өөдөө илүү өндөрлөг, үзэсгэлэнтэй газар санагдавч амрах зориулалттай газар биш. Эсвэл байрны тань цахилгаан хүчдэлийн хэсэгт цахилгаан үүсгүүр дуу шуугиантай, дүнгэнэж хүнгэнээд халуун бөгчим, бас аюултай байдгийг та мэдэж байгаа. Энэ хэсэг таны орон байшинд хичнээн их хэрэгтэй ч гэсэн та тэнд байгаад байхыг хүсэхгүй байх биз. Ийм л юм.

Бидний төсөөлж ч чадахааргүй тийм олон янзын шинж чанар Бурханд байдаг. Бид үргэлж л хэдий чинээ дээш гарна, төдий их хайр энэрэл байдаг гэж боддог. Гэвч хайр олон янз байдаг. Маш хүч түрэмгий, хатуу хайр ч бий, эелдэг зөөлөн хайр ч бий, алагчлал үгүй хайр ч байдаг. Бидний хүлээн авах савны хэмжээнээс л хамаарна. Бурхан бидэнд янз бүрийн хэмжээний хайр өгдөг. Тийм биз? Ертөнц бүр Бурхны хайрыг янз бүрийн хэмжээнд агуулж байдаг юм. Гэвч заримдаа тэр нь дэндүү хүчтэй, биднийг хэсэг хэсэг болгон цуулан тасчиж байх шиг санагддаг.

А: Амар сайн байна уу? Миний эргэн тойрон өдий төдий их

эвдрэл сүйтгэл, байгалийг сүйтгэн талхлах явдал ажиглагдаж байна. Амьтанд харгис хэрцгий хандах явдал. Та үүнийг яаж ойлгож мэдэрдэг бол, бас энэ ертөнцөөс оюун санааны зам мөрөөр чөлөөлөгдөхийг хүсч буй хүмүүст орчинтойгоо яаж зохицох, эргэн тойронд нь болж буй үгүйрэл сүйрлийн дунд учраа яаж олоход нь туслахын тулд та юу гэж зөвлөж чадах бол гэж би гайхширч байна л даа. Мөн юуг ардаа орхин үлдээж байгаагаа ухамсарлахын тулд энэ ертөнцийн чанадад гарах нь бидэнд хангалттай гэж та бодож байна уу, эсвэл ухамсрын энэ төвшинд бид зовлон зүдгүүрийг хөнгөлөхийг оролдох үүрэгтэй гэж боддог уу? Энэ нь ямар нэг тус болж чадах уу?

Б: Тус болно. Яриангүй тус болно. Бусад хүмүүсийнхээ зовлон зүдгүүрийг багасгахын тулд чадлаараа хичээж, ямар нэг юм хийж байгаагаа мэдрэх нь наад зах нь бидэнд болоод бидний хүн чанарт тустай. Би ч бас ийм ажил хийдэг. Та бүгд юуг л хүсч гуйна, түүнийг би хийдэг. Би хийж байсан, хийсээр байгаа, хийх ч болно. Бид заримдаа хөрөнгө мөнгөө янз бүрийн байгууллага, гамшиг зовлонд нэрвэгдсэн янз янзын улс оронд хувааж өгдөг гэж би түрүүн хэлсэн билээ. Би уг нь энэ тухай нэг их сайрхмааргүй л байна. Гэхдээ нэгэнт асуусан болохоор жишээ нь өнгөрсөн жил Пинатуба галт уулаас үүдсэн гамшгийг арилгахад Филиппинд санхүүгийн туслалцаа үзүүлсэн. Мөн Ау-Лакын болон Хятадын үерт нэрвэгдэгсэн хүмүүст тусалсан. НҮБ бидний туслалцааг хүсч байвал НҮБ-ын ачааллыг багасгахын тулд Ау-Лакын дүрвэгсдэд туслахыг одоогийн байдлаар чармайж байна. Бид хичээсээр л байна. Бид тэдэнд санхүүгийн туслалцаа үзүүлж байгаа бөгөөд хэрэв НҮБ зөвшөөрвөл бид тэднийг шилжин суурьшуулж чадахсан.

Тийм ээ, та бүгдийн гуйж хүссэн болгоныг бид хийдэг, тэгээд ч бид энд байгаагийнхаа хувьд энэ хүрээлэн байгаа орчноо ч бас аль болох сайн цэвэрлэж байх нь зүйтэй. Ийнхүү бид зовлон шаналалыг хөнгөрүүлж, дэлхий ертөнцийнхөө ёс суртахууны байдлыг төлөвшин тогтоход нь тусалдаг юм. Оюун санааны болоод материаллаг аль аль талаар. Тийм. Яагаад гэвэл зарим хүн надаас оюун санааны дэмжлэг авдаггүй. Тэд зөвхөн биет тусламжийг хүсдэг. Тиймээс тэдэнд материаллаг зүйлээр тусалдаг. Бидний хийдэг зүйл энэ бөгөөд би яагаад ажиллаж, мөнгө олох ёстой байдгийн учир нь энэ юм. Би өргөл барьц авч амьдрахыг хүсдэггүйн учир нь энэ.

Миний шавь хуврагууд цөм яг та бүхэн шиг л ажиллах ёстой. Тэгээд үүнээс гадна, бид оюун санааны талаар тусалж, энэ ертөнцийн бэрхшээл саад, зовлон шаналалыг хөнгөрүүлэхэд нэмэр болдог юм. Бид үүнийг хийж байх ёстой. Бид гар хумхин бүхэл өдөржин самадид автан өөрсдийгөө баясган сууна гэсэн үг биш. Ингэвэл дэндүү амиа хичээсэн Будда /гэгээнтэн/ болохсон. Энд бидэнд тийм хүн хэрэггүй.(Инээлдэв).

А: Хүн өөрийн сэхээллээс бий болсон хүч чадалтайгаа ухаардаг

тийм төвшний тухай та ярьж байсан. Хэрэв та тэр боломж чадвараа ухааравч тийм чадвартайгаа мэдэхгүй, гэхдээ л ухаараад байгаа бол яах вэ? Бүр та өөртөө тийм чадвар байгаа мэт мэдэрч байж болно. Түүнийгээ хэрхэн ашиглах, эсвэл ашиглахгүй байх вэ? Хэрэв тэдгээрийг ашиглахгүй бол хэрхэн яаж орчин тойрондоо болж байгаа үйл явцад тэсвэр хүлээцгүй хандахгүй байх вэ? Жишээ нь, та ямар нэг үйл явц дэлхий ертөнцийн жамаар удаан явж байхыг харжээ. Түүний зэрэгцээ та зүгээр залбирах, эсвэл тэнд болж буй бүхнийг хурдан түргэн шийдвэрлэх ямар нэг юм хийх боломжтой. Энэ юу гэсэн үг вэ? Сайн үр дүнд хүрэх адис хамгаалалттайгаар чадвараа яаж ашиглах вэ? Намайг юу гэж байгааг та ойлгож байна уу?

Б: Ойлгож байна, ойлгож байна. Та, бид амьдралыг өөрчлөх чадвартай байтал харин эргэн тойрны юмс хүнд сурталтай, залхуу наазгай маягаар явж байхад энэ бүхнийг тэсч гарах тэвчээр хүлцэмжийг хаанаас олох вэ гэж байна. Тийм үү? Ердөө л залбирч мөргөх юмуу, эсвэл домнож шивших, эсвэл хуруугаа чиглүүлж байгаад түлхэц өгөх үү гэж байна. Тийм үү? Үгүй, энэ ертөнцийг эмх замбараагүй байдалд оруулахгүйн тулд бид түүний эрч хурдтай тохируулж ажиллах ёстой учраас би тэвчээртэй байдаг юм. Тиймээ, жишээ нь хүүхэд гүйж сураагүй байхад та хичнээн яарч, гүймээр байлаа гээд хүүхдийг бүдэрч унагаахгүй шүү дээ. Тийм учраас бид тэсвэр тэвчээртэй байх ёстой. Бидэнд гүйх чадал байсан ч хүүхэдтэйгээ алхах хэрэгтэй болно, тийм ээ. Ийм байдаг болохоор би заримдаа цөхөрч, тэсвэр тэвчээргүй байдаг ч гэсэн өөрөө тэвчээртэй байхыг сурах хэрэгтэй болдог. Бид санхүүгийн бүх дэмжлэгээр нэмэр болох гэж байгаа атлаа би дүрвэгсдийн тусын тулд нэг ерөнхийлөгчөөс нөгөөд очин бөхөлзөж явдгийн учир нь энэ. Бид өөртөө байгаа бүхнээ, долларыг саяар нь, тэрбайтугай тэрбумаар нь өгмөөр байдаг. Гэлээ ч гэсэн бүхий л хүнд суртлын тогтолцоог туулан гарах хэрэгтэй болно. Ёс ёмбогор, төр төмбөгөр гэдэг.

Би НҮБ-ыг албадахын тулд өөрийн боломжоо ашиглах юмуу, эсвэл хуруугаараа чичлэхгүй. Үгүй, үгүй. Хэрэв бид шид увдис, бодит материаллаг хүчийг хэрэглэх юм бол энэ ертөнцөд сүйрэл гамшиг авчрах болно. Бүх юм жамаараа л явах ёстой. Гэхдээ бид оюун санааны эмчилгээ, билиг билгүүн, мэдлэг ойлголтоороо хүмүүсийн ухамсрыг дээшлүүлж чадна. Үүнийг сайн дураараа хийж, хамтран ажиллахыг хүсэх мэдлэг ухааныг бид тэдэнд өгч чадна. Ид шидийн хүчийг ашиглах биш, ингэх нь хамгийн сайн арга зам юм. Би аж амьдралын ямар ч нөхцөлд зориудаар хэзээ ч шид увдисын хүч хэрэглэж байгаагүй. Гэхдээ бясалгагчдын эргэн тойронд ер бусын гайхамшиг зүгээр л болж байдаг юм. Энэ бол санаатайгаар бус аяндаа болдог эд. Хэрэг явдлыг яаруулж, түлхэхийг оролдох явдал биш. Тийм ээ, ингэх нь сайн зүйл биш. Хүүхэд гүйж сураагүй байна. Тийм биз. Хариулт маань та нарын

сэтгэлд нийцэв үү?

Аль нэг нь хангалтгүй санагдаж байвал надад хэлээрэй, би гүйцээн тайлбарлаж өгье. Гэхдээ улс үндэстнүүдийн хамгийн шилмэл, оюун ухаанлаг хүмүүсийн хувьд та нарыг би маш сэргэлэн улс гэж бодож байна. Тийм болохоор би нэг их дэлгэрэнгүй ярихгүй байгаа.

Дашрамд нь НҮБ байдаг нь сайн хэрэг гэдгийг би тэмдэглэн хэлэх ёстой. Тийм тийм. Хэдийгээр бүрмөсөн арилгаж чадахгүй байгаа ч бид дэлхийн олон олон зөрчил мөргөлдөөн, дайн дажныг багасгаж чадсан. Би НҮБ-ын тухай танай номыг уншсан. НҮБ-д хүн болгон хамаардаг. Би ч бас НҮБ-ын үйл ажиллагаанд оролцдог. Бусад хүн болоод дэлхийн аль ч засаг төр аварч хүчрэхгүй байх тэр үед НҮБ-ын нэгэн тусгай бүрэн эрхт элч гарч ирэн барьцааны хүмүүсийг аварсны төлөө би НҮБ-ын хүчин зүтгэл, чадварлаг үйл ажиллагааг сайшаан магтах ёстой. Тийм ээ, тусламж хэрэгтэй болдог байгалийн гамшигийн асуудал, дүрвэгсдийн асуудал зэрэг өөр олон жишээ байна.

Та бүхэн арван хоёр сая дүрвэгсдийн төлөөх хариуцлагыг өөртөө авсан гэж би дуулсан. Үгүй гэж үү? Энэ бол тун их ажил, тэгээд бас дайн дажин бусад бүх юм байна. Тийм учраас бидэнд НҮБ байдаг нь сайн хэрэг. Тийм шүү. Энэ тун сайн хэрэг.

А: Цэцэн мэргэн ухаанаа бидэнтэй хуваалцаж байгаа танд баярлалаа. Чин Хай багш аа, надад нэг асуулт байна. Энэ нь дэлхийн хүн амын өсөлт, үүнтэй холбогдон хүрээлэн буй орчин хойшид улам бохирдох, хүнс тэжээлийн хэрэгцээ цаашид улам ихээр өсөх асуудалд хамаарах юм. Та дэлхийн хүн амын энэ өсөлтийг тайлбарлаж өгч чадахсан болов уу? Энэ нь манай ертөнцийн үйлийн үр мөн үү? Эсвэл энэ нь ирээдүйд ямар нэг тодорхой үйлийн үрийг бий болгох уу?

Б: За, энэ ертөнцөд улам олон хүн байх нь бас сайн хэрэг шүү. Яагаад үгүй гэж. Чихцэлдэж шахцалдаад хөгжөөн шуугиантай. Үгүй гэж үү. (Инээлдэв) Үнэн хэрэгтээ хүн ам хэт өсөөд байгаа юм биш. Ердөө л тархалт суурьшил нь тэнцвэргүй байна. Хүмүүс дэлхийн тодорхой нэг газар нутагт нягтарч суурьшаад өөр газар руу шилжихийг хүсэхгүй байна. Ердөө л энэ. Бидэнд ашигладаагүй асар их зэлүүд газар бий. Өдий төдий эзэмшээгүй арал, ногоорох ой шугуйнаас өөр юу ч үгүй өргөн уудам тэгш өндөрлөг байна. Хүмүүст ердөө л Нью-Йоркт шахцалдаж байх нь таалагддаг, жишээ нь, (инээлдэв) энд илүү хөгжөөнтэй болохоор. Тэгээд ч, засгийн газар болон өөр бусад удирдлагаас янз бүрийн газар оронд үйлдвэр, төрөл бүрийн ажлын байр, боломж бий болгодог бол хүмүүс тийшээ ажиллахаар очно шүү дээ. Ажил олоход амар хялбар, эсвэл аюулгүй байдгаас хүмүүс тодорхой зарим газарт бөөгнөрч байна. Хэрэв өөр газарт ажил олох боломж, аюулгүй байдал, хамгаалалт байх юм бол хүмүүс тийшээ ч бас явах байсан. Хүмүүс амь зуулга, аюулгүй байдлынхаа төлөө явах л болно. Энэ бол зүй ёсны юм.

Тийм учраас бид хүн ам өсч буйд түгшиж зовох ёстой биш юм.

Энэ дэлхийн хүмүүсийг орон байр, аюулгүй байдал, ажлын байраар хангахын тулд бид илүү сайн зохион байгуулалттай байх учиртай. Тэгвэл хаана ч гэсэн адилхан болно. Хүн ам хэт олшрох явдал хэзээ ч гарахгүй болохсон.

Хүнс тэжээлд хамаатай асуултын тань хувьд гэвэл үүнийг та надаас илүү мэдэх ёстой доо. Яагаад гэвэл энд, Америкт дэлхийг хэрхэн хадгалж хамгаалах тухай маш их мэдээлэл байдаг. Дэлхийн байгалийн нөөцийг хадгалах, дэлхийн бүх хүн амыг хүнсээр хангахад ургамал хоол бол хамгийн илүү нийцэх зүйлийн нэг. Учир нь бид амьтныг тэжээж бордохын тулд асар их хэмжээний хүнсний ургамал, эрчим хүч, цахилгаан, эмийг үрэн таран хийж байна. Гэтэл энэ бүхнээр бид хүмүүсийг шууд хооллож болохсон. Дэлхийн гуравдагч орнууд уургаар баяжуулсан ургамлын гаралтай хоол хүнсийг нэн хямд үнээр борлуулж байна. Гэтэл энэ нь бусад улс оронд тус болж чадахгүй байна. Бид хоол хүнсээ тэнцүү хуваавал, ургамал хоол ингэхэд тус болно, зөвхөн хүмүүс бидэнд биш, зөвхөн амьтдад ч биш, бүх дэлхий дахинд тус болж чадна даа. Нэгэн судалгааны сэтгүүлд аль хэдийн бичсэнчлэн хэрвээ хүн бүхэн ургамлын гаралтай хүнс хэрэглэвэл дэлхий хэзээ ч өлсгөлөнд автахгүй. Бид зохион байгуулалттай байх хэрэгтэй. Цагаан будааны хивгээр тэжээллэг хүнсний зүйл, тэр байтугай сүү хийж чаддаг нэг хүнийг би мэднэ. Энэ тухай бид түрүүн уулзахдаа ярьсан шүү дээ. Тэрээр гурван зуун мянган доллар зарцуулаад Цейлонд ядуу зүдүү, хоол хүнсгүй эхчүүд болон бусад хүн гээд зургаан зуун мянган хүнийг хүнс тэжээлээр хангасан гэж ярьж байсан. Энэ бол гайхалтай зүйл байсан шүү. Дэлхийн хаа сайгүй хийж үйлдэж байгаа байдлаас маань болоод л байгалийн нөөц үрэгдэж байгаа болохоос биш бидэнд нөөц баялаг хүрэлцэхгүй болж байгаа гэсэн хэрэг биш. Бурхан биднийг өлсгөх гэж энд орхиогүй байх. Үнэн хэрэгтээ бид л өөрсдийгөө өлсгөн тамирдуулж байна.

Тийм учраас бид өөрөөр бодох, шинээр сэтгэх, бүхнийг өөрчлөн зохион байгуулах хэрэгтэй, үүний тулд орон орны засгийн газрын дэмжлэг шаардлагатай. Засгийн газрууд өөртөө үйлчлэх бус, харин олон түмэнд үйлчлэх эрмэлзлээрээ, туйлын үнэнч шударга ариун байдал, эрхэм чанараараа биднийг ивээн дэмжих ёстой. Хэрвээ бид дэлхийн улс орон бүхний засгийн газраас ийм ивээл хүртэх юм бол бидэнд үнэндээ ямар ч асуудал байхгүй. Ямар ч асуудалгүй. Бид сайн удирдагчид, эдийн засгийн сайн зохион байгуулалт, удирдах авьяас билигтнүүд, мөн чин шударга засгийн газартай байх хэрэгтэй. Хэрвээ олон хүн, хүмүүсийн ихэнх нь, эсвэл бүр бүх хүн оюунлагийг эрхэмлэдэг болчихвол энэ бүхэн илүү хурдан биелнэ. Тэгвэл тэд дэг журам, сахилга гэдгийг мэддэг болно. Тэд хэрхэн үнэнч шударга, цэвэр ариун байхыг мэддэг болно. Тэгээд билиг ухаанаа яаж хэрэглэхээ мэддэг болно. Тэр цагт тэд хэчнээн

их зүйл хийх ёстойгоо ухаарч, амьдралаа өөрчлөн байгуулж чадна.

А: Энэ хэрэгжихэд тун хэцүү санагдаж байна, учир нь миний ойлгож байгаагаар бол орчин үед хүрээлэн буй орчныг буруугаар ашиглах нь ихэнхдээ хорьдугаар зуунд амьдрах жишгийг мэддэг, тэгээд тийм байхыг хүсдэг хүмүүсийн амьдрах орон зай, гэр байраа тэлэх хэрэгцээ өсөж байгаагаас болж байгаа санагдаж байна.

Бразилийн ширэнгэ ой, тэндхийн байгаль орчныг зүй бусаар ашиглаж буйг аваад үзье. Халуун орны чийглэг ойг нь устган сүйтгэсэн. Газар ногоон хөрсөн бүрхүүлгүй болж, энэ нь үер болоход хүргэж байна. Эдгээр нь хүн ам олшрох асуудалд хамаагүй зүйл биш шүү дээ.

Б: Тийм ээ, энэ ертөнцөд байгаа бүхэн хоорондоо холбоотой нь эргэлзээгүй. Тийм болохоор цорын ганц боломжтой шийдвэр гэвэл асуудлыг мөчир салбараас нь бус үндэс, язгуураас нь эхлэн шийдвэрлэх явдал. Үндэс язгуур нь бол сүнсний (оюунлагийн) тогтвортой байдал юм. Ойлгож байна уу?(Алга ташив).

Тийм болохоор бидний хийх ёстой зүйл бол ердөө л, мэдэж байгаа оюун санааны сургаалаа түгээн дэлгэрүүлэхийг эрмэлзэж, бясалгалын ёс журмыг баримтлах явдал юм. Хүмүүст дутагдаж байгаа зүйл нь энэ. Өөрийгөө цахилгаан машинд залгаад бага сага гэрэл үзэж, хөгжмийн эгшиг сонсох самади-д орох нь болох л хэрэг. Гэтэл танд ёс суртахууны сахилга байхгүй бол та энергийг зөвхөн муу зүйлд ашиглаж болох юм. Түүнийгээ хянаж жолоодож чадахгүй. Тийм учраас бид энэ бүлэгт, хүмүүст эхлээд сахил санваар сахихыг зааж сургадаг юм. Сахил санваар маш чухал. Бид хаашаа явж байгаага, мөн Хүч чадлаа хааш нь чиглүүлэхээ мэддэг байх ёстой. Хайр энэрэлгүй, нигүүлсэнгүй сэтгэлгүй, ёс суртахууны үнэт чанарын зохих ойлголтгүй хүч чадал бол ашиг тусгүй. Тэр нь хар дом, муу муухай зүйл болж хувирна. Тийм шүү. Хар увдис шид эндээс гардаг юм шүү дээ. Тэгэхлээр гэгээрэлд хүрэх нь амархан, харин түүнийг хадгалж хямгадах л хэцүү. Та манай энэ зам мөрөөр явах тэр цагтаа жинхэнэ ёсоор сахилга журамтай, ёс суртахуунтай байж чадахгүй бол таныг хүчээ муугаар ашиглаж, нийгэмд хор хөнөөл учруулахгүйн тул багш энергийн чинь зарим хэсгийг буцаагаад авчихна. Ялгаа нь үүнд байгаа юм. Багш хянаж харгалзаж чадна. Багшийн хүч, багшийн хүч. Ойлгов уу?

Та нарын энэ бүх ухаалаг асуулт намайг баярлуулж байна. Тун ухаалаг асуултууд байна. Хүмүүс хангалттай ухаалаг биш учраас таны хэлсэнчлэн газар дэлхийг буруу ашиглах мэт зүйл хийдэг, эсвэл зарим зүйлийг мэргэн ухаан дутсанаас болж хийдэг юм. Тийм шүү. Тэгэхлээр үндэс суурь нь билиг ухаан, бясалгал дасгал юм. Гэгээрэлд хүр.

Та бүхнийг анхааран сонссонд баярлалаа. Хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

## БИД АЛЬ ХЭДИЙНЭЭ ГЭТЛЭГДЧИХСЭН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1992 оны 11 дүгээр сарын 8 (Дүрс бичлэг 287)  
Малайз улс, Пенанг (Эх нь Англи хэлээр)*

Танд “Нугасны муухай дэгдээхэй” гэдэг хүүхэлдэйн киног үзсэний дараа ямар санагдсан бэ? Заримдаа хүн биднийг бусадтай адилгүй, дэндүү этгээд сонин гэж боддог тул хорвоо дэлхийн хүмүүс биднийг өөчилж гоочилдог. Гэтэл үнэн хэрэгтээ бид маш эрхэм нандин хүмүүс нь байж ч магад! Тэр дэгдээхэй нугас ч биш, харин хун байсан. Хун бол хамгийн эрхэм нандин амьтан.

Хун шувуу өндөр ууланд амьдарч, уулын хамгийн өндөр оргилын бохирдоогүй, нэн цэвэр цэнгэг нуурын усаар, эсвэл шүүдрийн ариун дуслуар ундаалдаг. Тэднийг сувд иддэг гэж би сонсож байсан юм байна. Тийм учраас л Энэтхэгт аугаа их сүнслэг бясалгагчид өөрийгөө хунтай зүйрлэн ярих нь бий. Хэрвээ хун шувуу нугасны сүрэг дунд орж холилдол мэдээжээр, нугасанд хун эрэмдэг муухай санагдана. Тиймээс заримдаа сүнслэг бясалгагчид болон энгийн хүмүүсийн ойлголт ухагдахуун ялгаатай байдаг, тийм биз дээ?

Бид өөргэйгөө адилгүй хүмүүстэй харилцахаараа өөрийгөө хэнтэй ч адилгүй мэтээр мэдэрч, тэгээд хүмүүс бидэнд дургүй гэх мэтийн гунигтай бодол төрдөг. Гэтэл чухамдаа бол бид ердөө л бусдаас ихээхэн давуу болохоороо л тэдэнд таалагддаггүй байж мэднэ.

Тэр нугаснууд хун шувууг таалахгүй байсан нь өөрсдөд нь бас сайн хэрэг болсон, тийм биш үү? Хэрвээ тэд түүнийг маш халуун байдаг урд зүгт дагуулж аваачаад өдөр бүр хэрэлдээд байвал энэ нь юун сайн байх вэ дээ? Бусад хунгийн адилаар цаснаас айдаггүй учраас түүнийг үлдээсэн нь үнэндээ тэр хунд сайн явдал болсон байх. Цастай ууландаа амьдарч, сайхан цэнгэг усаар ундаалах нь түүнд хэрэгтэй байв. Тэд маш цэмцгэр, үзэсгэлэнтэй болохоор нугаснуудтай холилдож тэнд амьдрах ёсгүй. Нугаснуудтай холилдоо гэхэд мэдээж нугаснуудад энэ нь таалагдахгүй, бас таатай сайн юм бодох ч үгүй. Ингэсэн бол хун ч тухтай байж чадахгүй, нугас ч тухтай байж чадахгүй. Ингэлээ гээд нугаснуудыг буруушаах аргагүй, учир нь тэд харсан, хараагүй хун өөрсөдтэй нь адилгүйг мэдэж л байгаа. Хун уртаа гэгчийн хүзүүтэй, шовх хошуутай гэхчилэн тэдэнтэй адилгүй.

Би ууланд байхдаа доош бууж очих дургүй байсан. Учир нь тэр доор маш олон хүнтэй, хөл үймээн ихтэй, уйтгартай байдаг; мөн хүмүүст зааж сургах, шавь нараа сургах нь хэцүү гэх мэт. Би уулнаас бууж ер нь яах юм? Тэр дээрээ л байж байх нь үнэхээр аятайхан шүү дээ! Өдөр бүр чапати хайрч, халуун усанд орох ус халааж, хүүхэлдэйн кино үзэх сайхан санагддаг. Энэ бол маш тухлаг амьдралын хэв маяг билээ.

Түүрүүчийн долоо хоногт Шихү Төвд бага сага өөрчлөлт гарсан. Бясалгалын өргөөг буулгасныг та нар мэдэж байгаа. Энэ юу ч биш! Гэтэл үүнд зарим хүний сэтгэл эмзэглэжээ. Би үүнийг ойлгоно л доо. Ийм учиртай тул би та нартай утсаар ярьсан юм; бас та нар сэтгэл уяраасан учраас би Тайбэйд очно гээд амлачихсан. Та нарыг “Төв байхгүй болсон, бас Их Багш буцаж ирэхгүй. Тэр биднийг орхих биз!” гэж хэлэх вий гэхээс би эмээсэн.

Та нар яагаад уйлна вэ? Бясалгалын өргөөг буулгалаа гээд ямар ялгаа гарах гэж? Би үүнийг аль эрт мэдэж байсан. Өргөөний шалны доод талыг цементлээгүй байсныг та нар харсан даа, хэрэв тэгсэн бол одоо хэцүүдэх байлаа. Бид мод тарьж болно. Бясалгалын өргөөгүй нь илүү дээр юм. Одоо байгаа шиг муу юм биш. Би юунд ч хүлэгдэх ёсгүй.

Би гэрээс гарсан хувраг шавь нартаа хуврагийн орхимж өмсөхөө боль гэж хэлье гэж сүүлийн хэд хоног бодлоо. Яагаад? Учир нь энэ тусгай хувцас тэднийг өөрийгөө онцгой хүн мэт бодоход хүргээд байна. Би тэднийг илүү төлөв даруу байж сураасай гэж бодож байна. Та нар тэднийг дэндүү өндөрт тавьсаар ирлээ. Ямар янзаар гэж үү? Жишээлбэл, “Зөвхөн тэд л Гуан Инь элч, харин бид бол “дагалдагчид” гэж бодож байна. Энэ бол утгагүй зүйл. Үүнийг сонсохоор сэтгэл минь өвддөг. Хэн ч бусдаас ялгаатай биш. Гадна талдаа бүгд л ижил шүү дээ. Гол ялгаа бидний дотоодод л байдаг.

Зарим хувраг шавь нар үнэ хүндтэй биш байна; чухамдаа бол хэн ч үнэ хүндтэй биш, гэхдээ хүн бүр үнэ хүндтэй. Хэрвээ бид зөвхөн угийн Бурхан Чанараа, жинхэнэ Би-гээ авч үзвэл хүн бүр үнэ хүндтэй. Зөв, буруу бүхнийг бичиж аваад буцаан тоглуулж байдаг энэ чимээ шуугиантай тархиа авч үзэх юм бол хэн ч үнэ хүндтэй биш. Гэхдээ үүнийг зүрх сэтгэлийнхээ гүнд ухаарна гэдэг тун бэрх. Өөрийнхөө дотоодтойгоо харилцаж, өөртөө итгэлтэй байж, өөрийгөө уг чанараараа маш цэвэр гэдгээ таньж мэдэх нь бидэнд тун бэрх байдаг. Үнэхээр нэн хэцүү бэрх! Тийм учраас үнэ хүндгүй гэдэг үгийг би хэлж байгаа юм. Их Багшийн байр сууринаас харах юм бол тэд үнэ хүндтэй; бусад зарим хүний байр сууринаас бол үгүй. Тэгэхээр хэн ч юм гэрээс гарч, хуврагийн орхимж нөмрөөд өөрийгөө аугаа гэж бодох юм бол энэ зөв биш! Тэгэх юм бол тэдэнд олон саад тотгор учирна. Хэрвээ бид өөрийгөө “даяанч” гэж үздэг юм бол бид дууссан гэсэн үг. Бид гэрээс гарахад болохгүй юм

үгүй; уг нь энэ маш сайн хэрэг, гэхдээ гэрээс гарсан, гараагүй нь ямар ч ялгаагүй гэдгийг бид мэдэх ёстой.

Ийм учраас л би тэдэнд хувцсаа сольж, эгэл хүмүүс шиг хувцаслаарай гэж хэлмээр байгаа юм. Хамтдаа холилдоод ирэхээр хүн бүр ижил шүү дээ. Дотооддоо өөрийгөө сүнслэг талаараа хөгжүүлж байгаагаар мэдэж байхад л хангалттай. Ямар нэг зүйлээр гайхуулах гэхийн хэрэг юун, ингэснээрээ өөртөө л саад тоггор тарина. Яагаад? Яагаад гэвэл бид жаазанд баригдчихлаар төөрөгдөл маань ч улам ноцтой болж лавширдаг. Хэн ч даяанч юмуу, эгэл хүн гэж байдаг гэж бодоод байж болохгүй. Сүм хийдийн зарим хувраг шавь нар тусгай хувцас өмсөхөд болохгүй гэх юмгүй, учир нь тэдэнд өөрт нь бол хувраг, эсвэл эгэл бясалгагч хүн байх нь ялгаагүй адилхан санагддаг. Хуврагийн орхимж нөмрөгийг тэд аяндаа л өмсөх болдог юм. Зарим хүн ийм биш байдаг. Тэд гайхуулах санаатай л орхимж нөмөрдөг.

Их Багшийн зарим хувраг шавь нар ч бас тийм сайн биш байдаг; тэдэнд зөв ойлголт ухагдахуун байдаггүй. Байгаа газраа цэвэрлэж эхлэх нь бидний хувьд хамгийн сайн зүйл. Ингэвэл биднийг гэрээ хэр сайн шүүрдсэнийг харсан хөрш маань ч бас гэрээ цэвэрлэж магадгүй. Тэгвэл бид түүнд бага сага тусалж чадна. Үүнийг хүлээн зөвшөөрч болно. Бид эхлээд өөрийнхөө гэрийг цэвэрлээгүй байж бусдын гэрийн хогийг шүүрдэж өгөх гэж чинь болохгүй.

Уг нь анхандаа энэ дэлхийд ганц ч хүн байгаагүй. Та нар үүнийг мэднэ биз дээ? Энэ бие гал, ус, мод, төмөр, шорооноос бүрдсэн (Хятадаар таван махбод гэдэг). Эрт орой нэгэн цагт энэ бие буцаад л бүрэлдсэн материал руугаа хувирна. Тэгэхлээр, “хүн” гээч бид чинь юу юм бэ? Бидний бодол өдөржин ар араасаа хөвөрч ундарч байдаг. Энэ нь л “хүн” гээч нь үү? Үгүй! Одоо “Би” жаргалтай байснаа дараа нь “Би” гунигтай байна гэдэг; тэгснээ дахиад “Би” жаргалтай байна гэнэ, бас “Би” гунигтай байна гэдэг. Энэ нь “би” гээч нь үү? Үгүй, энэ чинь ердөө л бодлууд шүү дээ, ар араасаа давалгаалагч далайн долгио шиг. Энэ бол “хүн” гээч бид биш! Давалгаа мэдээжээр далайгаас ирж байгаа ч далай өөрөө биш шүү дээ. Далай дээгүүр үлээх салхинаас долгион үүсдэг. Тийм учраас хэрэв ийм ойлголттой зууралдаад байвал бид дуусна. Бид хувцас битгий хэл өөр юунаас ч зууралдах ёсгүй!

Уг нь анхандаа бол энэ дэлхийд нэг ч “хүн” байгаагүй билээ. “Тэр” бол үүрдийн Үзэгч гэдгээ “Тэр” мэдэж байдаг. Жишээлбэл, “Тэр” тэнд нөхцөл байдлыг ажиглаад л байж байдаг. Нэгэн мөчид “Тэр” баярлах мэдрэмжийг мэдэрчээ, дараа нь өөр нэг мөчид уйтгарлах мэдрэмжийг мэдэрчээ. “Тэр” энэ бүхнийг мэддэг, “Тэр” бол үүрдийнх. “Тэр” бол уйтгар гуниг ч, биш аз жаргал ч биш гэдгээ “Тэр” мэдэж байгаа. Харин бидний хувьд энэ юу билээ? Хэрвээ бид өдөр тутамд бясалгаж, өөрийгөө эс шалгаваас, бид гэдэг бол уйтгарт хүн гэж бодох болно.

Жишээлбэл, би энэ алимыг идэж байхдаа чихэрлэг амттай

гэдгийг нь мэдэж авна. Чихэрлэг амт гэдгийг би мэднэ, гэхдээ чихэрлэг амт бол “Би” биш гэдгийг би мэдэж байгаа. Эсвэл исгэлэн амт бол “Би” биш. “Би” тэр чихэрлэг-исгэлэн амтыг ердөө л таашааж байгаа хэрэг. Гэвч бид үүнийг мартаж бүртгээ өөрийгөө алим гэж боддог. Ингэх нь инээдтэй биш үү?

Тиймээс, ямар ч хүн гэж байгаагүй учраас бид хий хуурмаг үзэгдлийг жаазанд хийж тавьчихаад түүнийг улам амь бөхтэй болгоод байх хэрэггүй. Тийм болохоор та ямар ч хувцас өмсөж болно. Энэ чинь асуудал биш. Байнга хувцсаа солих нь миний хувьд залхмаар байдаг, тиймээс би одоо тэгэхээ больсон. Би иймээрээ л үлдэнэ.

Бид “хүн” гэх юм байхгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Хичнээн аугаа их, авьяас билигтэй байлаа ч энэ “хүн” гээч нь ердөө л үзэгдэл төдий. Энэ бол түүний эзэмшсэн чанар, эсвэл тэр хүн түүнд иймэрхүү чанар бий, дараа нь түүнийгээ ашиглаж хэрэглэнэ гэдгээ мэддэг төдий л юм. Тэр бол тэрхүү “хүн” биш. Тийм учраас бидэнд үхэх, төрөхийн алин ч байхгүй. Ердөө л бодлууд бүтээгдэж, алга болж байдаг. Хэрвээ бид энэ бодлуудаасаа салахын оронд үхэх төрөх, өтлөх, өвдөх, жаргах цэнгэх, уурлах гуниглах, баярлаж хөөрөх гэх мэтээр үргэлжлүүлээд бас энэ мэдрэмжээ өөрийгөө гэж бодоод л байх юм бол мэдээж дахин төрөл авна. Бид алим идсэн хүнийг алимаас нь ялгахгүй, өөрөө алимд сэтгэл хүлэгддэг. Бид нэгээс нөгөө газар очин үргэлж л алим хайж байна. Бид тасралтгүй хайгаад л байдаг, ингээд л бид ахин дахин төрөл авсаар байдаг. Заримдаа дуртай зүйлийнхээ төлөө, заримдаа дургүй зүйлээсээ зайлсхийхийн төлөө ингэдэг нь бидэнд яришг төвөг тарьж, улмаар бид дахин төрөл авдаг. Тэгдэггүй бол анхдагч Би чинь төрөл авдаггүй. “Тэр” бол гэрч, үүрд үхэхгүй, бас төрөхгүй, өнө мөнхөд үзэгч төдий л юм.

Энэ чинь кино үзэхтэй л адилхан! Одоо ч би зарим киног үзэхээрээ уйлдаг. Би олон сайхан гүн ухааны түүхтэй “Оддын ханхүү” киног үзсэн. Жишээлбэл, лимбэ тоглох дуртай бяцхан хүү байсан. Гэвч аав нь тоглохыг зөвшөөрөөгүй тул тэр уйлж, гэрээсээ зугтахыг хүсдэг. Тэгтэл Оддын ханхүү түүнд, “Чи лимбээ зүрх сэтгэлдээ агуулчихвал бүх зүйл сайхан болно” гэж хэлдэг. Хүү энэ санааг ойлгоод лимбээ хойш тавьдаг. Хожим нь хүү лимбээ тоглох боломжтой болсон, учир нь лимбэ тоглолоо гээд мөнгө төгрөг, хоол хүнс олж чадахгүй ч хүмүүсийг тайтгаруулдгийг аав нь ойлгожээ. Энэ тайтгарал бол маш чухал зүйл. Бяцхан хүү лимбэ тоглохоо болиход бүх хүн сандран бажгаджээ. Харин тоглож чаддаггүй Оддын ханхүү лимбэ үлээхэд хүмүүс муудалцаж, тахиа нугаснууд бие биеэ тоншиж хазаж, тосгон даяар эмх замбараагаа алджээ. Гэтэл харин бяцхан хүүг лимбэ тоглоход хүн бүр амар амгалан, тохь тухтай болдог.

Ийм зүйл үнэхээр болдог. Заримдаа бид намуухан хөгжим сонсохоороо аз жаргалыг мэдэрч, тайтгардаг. Муухай хөгжим

сонсвол тавгүйтэж, солиорч, хийрхэлд автмаар болдог. Зарим зүйлийг материаллаг байдлаар хэмжих боломжгүй байдаг нь үнэн шүү, яагаад гэвэл тэр нь өөрийн гэсэн сүнслэг үнэ цэнэтэй байдаг.

Яг үүн шиг, заримдаа хүмүүс биднээс та нар яагаад бясалгадаг юм бэ? гэж асуудаг. Тэд биднийг тэнд суугаад л байвал өдөр тутмынхаа талхны мөнгийг олж чадахгүй гэж боддог. Гэтэл бид хэдий чинээ их бясалгана, бидэнд мөнгө олох боломж төдий чинээ их гарна. Энэ тийм биш гэж үү? Урьд нь бид мөнгө олох гээд тун завгүй байдаг байсан. Бид сэргэг ухаанаар бодож чаддаггүй байсан тул тийм ч их зүйл хийж чаддаггүй байсан. Гэвч бясалгасны дараа бид олон ач тус хүртдэг. Энэтхэгт хүмүүс “Сүнслэг бясалгал дадуулдаг нэг хүн зуу зуун, эсвэл мянга мянган хүнд материаллаг ач тус хүргэж чадна” гэж хэлдэг. Түүний билиг ухаан илрэн гарч, олон хүнд өгөөжтэй их зүйлийг гүйцэлдүүлэх боломж өгдөг.

Тиймээс мөнгө олох гээд л борви бохис хийлгүй ажиллаад байх нь сайн гэсэн үг биш. Бид мөнгөний төлөө явдаггүй гэсэн ч үг биш. Бид бүгд л мөнгө олж чадна, өдгөө цагт бол бүр өмнөхөөсөө ч ихийг олно. Таны бизнес амжилттай явж байгаа нь илт байна. Урьд нь тийм ч сайн байгаагүй, тийм ээ?

Нэгэн өдөр бид ууланд зугаалж шорлог хийж идсэн юм. Хэдэн хувраг шавь маань намайг дагаж явлаа. Тиймээс би тэдэнд тус бүрд нь аяга, майхан, шорлог хийх зай талбай гаргаж өглөө. Бүгд дор бүрнээ л зэрэг хөдлөөд орчноо цэвэрлэж, хуурай түлээ мод цуглуулав. Бидэнд шорлог, буцалсан ус, чанасан хоол хүнс бүгд байсан. Ийм амьдрал л хамгийн сайн гэж би хэлж байгаа юм биш. Бусад арга маяг ч бас сайн. Үнэхээр тийм байдаг! Бид хэрвээ тийм нөхцөл байдалд байвал зугаатай байж чадна гэж хэлэх гэсэн юм. Жишээ нь, бид хот газар амьдарвал бас л таатай сайхан байж болно. Би хэрвээ ууландаа үлдвэл уулнаас буумааргүй байдаг. Амар жимэр, аз жаргалтай, санаа зовох зүйлгүй амьдралаар жаргаж цэнгэхийг би хүсдэг.

Бид байгаа газартаа дасаад энэ тухай боддоггүй. Та нар шиг хотод амьдрах муугүй гэж би бодож байна. Бүх зүйл нь тав тухтай. Номын худалдааны төвд зориулан Тайбэйгийн хүмүүс та нарын худалдан авсан долоон давхар байшинд би байрлаж байлаа. Надад тун ч төгс зохицсон газар байна гэж би бодсон. Компьютер тавьчихсан жижигхэн газар амьдрахад л яг болчихно гэж би бодсон. Хол алхахын ч хэрэг байхгүй, автобусны буудал яг доор нь байдаг тул маш тухтай байлаа! Тиймээс газар бүр өөрийн сайн талтай.

Та нарыг хотод ингэтлээ сэтгэл татагдаад, ууланд очиж шорлог хийх гэж явмааргүй байгаад гайхах зүйл алга. Та нараас хэн ч ууланд гарч, бие дааж, зэлүүд буйд хэв маягаар амьдрахыг хүсэхгүй байгаа, тийм үү? (Сонсогчид: Тийм.) За зүгээр дээ, та хаа байгаа газраа байж

болно. Би ч бас тийм. Би ууланд байхдаа уулнаас буумааргүй, гэндээ байж байх дуртай, харин уулнаас бууж ирсэн хойноо тийшээ буцмааргүй байдаг. Надад хаана ч байх сайхан санагддаг. Зүгээр л нэг газар очихоосоо өмнө бид жаахан эмээдэг. Харин тэнд оччихсон хойноо бол айхаа больчихдог. Тийм биз? Магадгүй та бид адилхан, ямар ч ялгаагүй юм болов уу? Урьд нь би өөрийгөө их л онцгой гэж боддог байлаа, гэтэл үнэндээ бид бүгд адилхан, бид хаана ч байлаа гэсэн нэг газар нь нөгөө газартайгаа адилхан сайхан санагдаж, хаана ч аз жаргалтай байдаг. Энэ чинь л сайхан хэрэг шүү дээ!

Одоо би хувраг шавь нартаа гэртээ буцаж, чөлөөтэй амьдар гэж хэлнэ гэж бодож байгаа. Ямар нэг төрх байдлаар өөрийгөө жаазлаад яах юм? Гэхдээ тэдний зарим нь үргэлжлүүлэхийг хүсэж байгаа, бас тэгээд тэд бол ингэж болохоор хүмүүс. Бололгүй яах вэ, зүгээр! Гагцхүү өөрийгөө албадах ёсгүй юм. Бидний хувьд аль ч газар сайн байж чадна. Загас усандаа, бар ууландаа л байдаг, тийм ээ? Заан ширэнгэн ойд амьдардаг, бич жимс идэх гэж дээш доош модонд авирдаг. Бид хүн бүрийг өөр шигээ байхыг албадах боломжгүй. Үгүй! Жишээ нь, “Нугасны муухай дэгдээхэй” шиг л юм. Өөрийгөө нугасны гэр бүлд хамааралгүй гэдгийг мэдээд тэр тун ч аз жаргалгүй байсан нь эргэн тойрны найз нөхөд, хамаатан садныг нь мөн адил аз жаргалгүй болгочихсон. Түүний өөр дүр төрх нь эргэн тойрныхонд нь дарамт болсон. Яг үүнтэй адилаар, бидэнд ээлтэй л байгаа бол хаана ч амьдрахад болно.

Өдөр бүр хичээнгүйлэн бясалгаж, ууланд ганцаараа амьдрах нь заавал сайн байх албагүй. Илэрхийлэн гаргахад хэцүү. Надад таалагддаг учраас л ингэх нь надад сайн хэрэг байгаагаас биш, би тийм аугаа учраас биш юм. Үүнээс болж намайг магтах хэрэггүй, эсвэл үүн шиг зүйл хийж, өөрийгөө агуу гэж боддог, бүх зүйлээ орхисон хэн нэгнийг магтахын хэрэг байхгүй. Тэр энэ хорвоод дургүй болсон байна, тэгвэл тэр юуг огоорч орхисон юм бэ?

Жишээлбэл, танд энэ эмэгтэй таалагддаггүй гэж бодъё. Тэр эмэгтэй хичнээн үзэсгэлэнтэй байсан ч танд таалагддаггүй гэе! Чамд зөвхөн эхнэр чинь л таалагддаг. Тэгвэл та юугаараа аугаа юм бэ? Та гоо үзэсгэлэнд тэмүүлэх хүслээ дарчихсандаа ч биш, та ердөө л тэр эмэгтэйд таалагддаггүй хэрэг. Танд зөвхөн эхнэр чинь л таалагддаг. Яагаад гэвэл та хамт амьдарсаар байгаад дасчихсан, түүнгүйгээр амьдарч чадахгүй. Өөр бусад гоо бүсгүй үгүйгээр цаашид амьдрах нь танд тийм ч чухал зүйл биш. Тийм учраас, хэн нь хэнээс илүү вэ гэдэгт биш, зүгээр л хүмүүс өөр өөрийн таашаах зүйлтэй, өөр өөрийн арга замтай гэдэгт л хамаг учир байгаа юм. Тиймээс бид бусдыг дуурайх албагүй.

Бид сэтгэлийнхээ гүнд өөрийгөө ямаршуу хүн бэ гэдгээ мэдэж байдаг. Мэдээжээр, хэрэв бидэнд ямар нэг алдаа дутагдал, эсвэл өөрт таалагддаггүй зан чанар байгаа бол бид түүнийгээ хасаж танаж, арай



богино, арай бага болгох хэрэгтэй. Тэгвэл бид болчихлоо гэсэн үг. Тийм биз! Түүнээс биш, нэг их чухал зүйл юу ч байхгүй! Та өөрийн гэсэн амьдралтай, тэр чинь тав тухтай, аз жаргалтай байгаа л бол сайн. Царайлаг нөхөртэй байх нь сайхан мэдрэмж болохоос биш бусдад ямар ч хамаагүй хэрэг.

Заримдаа бидэнд хүсэж байгаа шигээ зугтаад явчих боломж байдаггүй. Жишээлбэл, хэрвээ хэн нэгэнтэй ханилах хувь төөрөгтэй бол урд насандаа тавьсан өр учраас л тэр, тэгтэл одоо бид үүнийг яршиг төвөг хэмээн үзэж, тавьсан өрөө төлөхийг хүсэхгүй байгаа хэрэг. Авах сайхан ч буцааж төлөх нь мэдээж тийм биш. Тэгээд л бид түүнийг хүсэхгүй байна, өр төлбөрөө төлмөөргүй байна гэдэг. Тийм учраас бид энд заяагдсан өр ширээ цэгцлэх хэрэгтэй, тэгснийхээ дараа хожим нь дээрх диваажингийн ертөнцийн төлбөр тооцоогоо үргэлжлүүлэн барагдуулна.

Бид дээд ертөнцүүдэд байх үед төлбөр тооцоогоо шийдвэрлэх нь өөр шүү. Тэр мөчид энэ нь хэн илүү хичээнгүй бясалгаж, ямар төвшний гэгээрэлд хүрсэн байхаас хамаарна. Бидний жинхэнэ Би хамаарах тэр газарт эрэгтэй, эмэгтэй гэсэн хүйсийн ялгаа, эсвэл дурлал хайрын холбоо байдаггүй гэдгийг бид ойлгох ёстой. Энэ нь Оройн Дээдийн орныхтой адилхан.

Энэ хорвоод бид кино үзэхээр ирсэн үзэгчид л юм шүү дээ. Тэгээд заримдаа бид сэтгэл хөдлөн догдолдог, киногоо үзээд сэтгэл хөдөлж, догдолж, бас уйлдаг. Кинондоо автсан бид “Түүнийг цохиоч, цохиод ав! Алчихаач наадахыгаа! Араас нь яв, араас нь!” гэж хашхирч халагладаг. Тэр үедээ бид кинон дахь жүжигчинтэй холбоогдчихсон байдаг биз дээ? Гэвч кино дуусахад бид бүх зүйл бодит бишийг санадаг. Зарим кино маш сайн, тун бодитой, эсвэл маш сайн жүжиглэсэн байдаг тул бид үзэж байхдаа сэтгэл хөдлөлөө өөрчилдөг.

Яг үүн шиг, бид нэг төрлөөс нөгөөд дамжих бүрдээ хүн төрөлтний дүрд жүжиглэж дасчихаад үүнийг орхиж чаддаггүй. Энэ жүжиг бол бид биш гэдгээ төсөөлж чаддаггүй. Ийм л энгийн. Энэ жүжиг бидний ой тойноос гарахгүй маш их уддаг. Кино үзсэний дараа харгис хэрцгий, сэтгэл хөдөлгөсөн, шударга бус хэсгүүд нь сэтгэлд үлдчихээд бидэнд удтал нөлөөлсөөр байдгийг та мэднэ. Заримдаа кино, жүжиг үзсэний дараа бидний амьдрал хэсэгхэн зуур өөрчлөгддөг. Тийм учраас, хэрвээ бид энэ удаад, энэ амьдралдаа ухаарч сэхээрэхгүй, харин үргэлжлүүлэн жүжиг тоглож, сэтгэл хөдлөл, аз жаргал, уур хилэн, уй гуниг, баяр хөөртэй амьдралын хойноос хөөцөлдсөөр байвал бид дахин төрөл авах ёстой гэж бид хэлдэг. Үгүй! Хэн ч дахин төрөл авах албагүй.

Үнэндээ хэн ч гэтлэгдээгүй. Үнэндээ хэн ч чөлөөлөгдөөгүй байна. Чухам ийм учраас өнөөдөр ийм, маргааш тийм, өнөөдөр сайн, маргааш муу өдөр гээд л бид тэр сэтгэл хөдлөл, тэр үзэгдлийн араас

мөшгөн хөөцөлдөөд байдаг бөгөөд үүнийгээ бид дахин төрөл авдаг гэж ярьдаг юм.

Хойд төрөл авах нь хэрхэн тохиолддог вэ? Хойд төрөл авдаг нь тэр бодлууд л юм! Дахин төрөл авдаг нь тэр үзэгдлүүд л юм! Тэр сэтгэл хөдлөлүүд л дахин төрөл авдаг юм! Тэд байнга өөрчлөгдсөөр, дахин төрөл авсаар байдаг. Бид, бие хүн маань хойд төрөл авдаггүй; тэр гэрч дахин төрдөггүй. Гэхдээ энэхүү “хүн” гэгч нь “хүн” биш учраас “Түүнд”-д юу ч нөлөөлдөггүй. Хэрэв та түүнийг цавчвал “Тэр” үхэхгүй. “Түүнийг” шатааж, живүүлэх боломжгүй. Тэгвэл үхэж төрөхийн мөчлөгт ямар “хүн” нь дахин төрөх ёстой вэ? Үнэн хэрэгтээ нэг ч хүн гэж байхгүй! Энэ бие махбод л дахин төрж байгаа болохоос бид биш юм.

Гэсэн хэдий ч, хэрвээ бид сүнслэг бясалгал сайтар дадуулдаггүй, үүнийгээ нухацтай анхаарч боддоггүй, ойлгохын тулд тайвширдаггүй байх юм бол, намайг энэ бүхнийг хэлж өгсөөр байтал та зөвхөн ийм зүйл болдог л гэдгийг мэднэ. Төрж, үхдэг, дахин төрөл авдаг мэдрэмжээс та тусгаарлагдаагүй хэвээрээ л байх болно. Ингэвэл та өөрийгөө гэтлэгдэж чадаагүй гэж л хэлнэ. Үнэн хэрэгтээ бол бид аль хэдийн гэтлэгдчихсэн!

## БУРХАНЫ БҮХ БҮТЭЭЛ НЭГДМЭЛ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1992 оны 11 дүгээр сарын 22 (Дүрс бичлэг 287)  
Формоса, Шихү төв (Эх нь хятад хэлээр)*

Та бүхний өдрийн амгаланг айлтгая! (Сонсогчид: Өдрийн мэнд, Их Багш аа.) Ян Мин ууланд эрс хүйтэрсэн тул би буцаад ирлээ. Худалдаж авч амжаагүй учраас би бэлтгэлийн хувцасгүй байна. Надаас бусад нь өөрийн гэсэн бэлтгэлийн хувцастай. Надад нэгийг худалдаад авчихаарай гэж би захисан ч тэд аваагүй байгаа тул би өмсөөгүй байна. За үүнийг марг даа! Юутай ч би хувраг гэж тооцогдсон хэвээрээ байна. (Инээлдэв)

Хувраг болох эсэхээ шийдэж ядан буй буй тэр хүн чухамдаа хэн юм бэ? Энэ хүн хэн гэдгийг та мэдэх үү? Энэ хүн хувраг болохын тулд гэрээ хэзээ ч орхиогүй, тэглээ ч гэсэн үсээ хусаагүй ч бас л хувраг мөн. Хэзээ ч төрдөггүй, хэзээ ч үхдэггүй, тэр хүн бол бидний өөрийн жинхэнэ Би юм – тэр үүрд жаргалтай, үүрд гэгээрсэн, бас үүрд тэнэг. Бид тэнэг, ухаалаг, утгагүй, бас үүнийхээ хамт чухал утга учиртай. Энэ бол бидний жинхэнэ Би юм. Бид хэн бэ гэдгийг та ойлгож байна уу? (Хэн нэг нь: Ухаант амьтан! гэв) Бурхан минь! Та огт ойлгоогүй байна. Та нар бол Бурхан!

Энэ цахилгааны утсыг хар даа. Дотуур нь цахилгаан гүйдэл гүйж, янз бүрийн залгуур луу очдог. Бүх залгуур адилхан, тийм биз? Гэтэл харин энэ хүн тэр хүнд мөргөж шүтдэг. Энэ чийдэн нь тэр чийдэнг шүтдэг, учир нь илүү тод гэрэлтэй, бас арай дээр гэнэ. Та өөрийнхөө хэр ухаалагийг өөрөө хардаггүй; гэрэл гэгээтэйгээ хардаггүй, тэгсэн атлаа бусдын гэрэл гэгээтэйг анзаарч “Энэ овоо тод гэрэлтэй юм! Хөөх! Та гайхалтай. Та яаж ийм тод гэрэлтэй байж чадаж байна аа? Та надад арга замаа үзүүлж болох уу?” гэдэг. Тэгээд л хүн болгон арай их гэрэл гэгээтэй хэн нэгэнд өдөр бүр мөргөж биширнэ. Цахилгааны утас хүн бүхэнд өөрийг нь бас ийм ухаалаг байж чадна гэж итгүүлэхийг хичээдэг. Гэтэл хэн ч түүнд итгэдэггүй. Тэд “Яалаа гэж дээ, бид бүгдээрээ харанхуй, бүүдгэр. Гагцхүү та л ийм гэрэлтэй байж чадна. Та бидэнд яаж ингээд байгаагаа үзүүлэх ёстой” гэдэг. Тэд тод гэрэлтдэг тэр хүнээсээ өдөр шөнөгүй зууралдан яаж илүү тод гэрэлтэхийг зааж өг гэж түүнийг шална. Үнэн хэрэгтээ бүгдээрээ л ижилхэн ухаалаг. Ийм л

энгийн. Бид бүгдээрээ адилхан.

Та зүгээр л бодоод үз дээ, бид энэ биесийг олж хүн болж төрөхөөсөө өмнө өөрийнхөө оршин байгааг анзаарсан уу? Бид хүн болж төрсөн хойноо ч оршин буйгаа анзаарахгүй хэвээрээ л байдаг. Үнэхээр ийм байдаг. Хүн болж мэндэлсэн мөчөө санадаг хүн ер нь байна уу? Зөв! Тэгтэл хэн нэгэн бидэнд “Чи төрчихсөн байна. Энэ бол бие махбод чинь, энэ бол чи” гэж хэлэх ёстой байдаг. Аажмаар бид энэ баримтыг ухаарч: “За за! Энэ бол “би” юм байна. “Би” одоохондоо жаахан хүүхэд. “Би” одоо том болсон” гэдэг. Тэгээд дараа нь “Би” үүнийг ч хүсэж байна, “би” түүнийг ч хүсэж байна.” “Би” бол хувраг хүн. “Би” бол энгийн хүн. “Би” бол өндөр албан тушаалт түшмэл, “Би” бол хэн ч биш” гэгцгээдэг. Үнэн хэрэгтээ та ерөөсөө эдгээрийн аль нь ч биш!

Жишээлбэл, бид төрөхөөсөө өмнө оршин буйга(а бараг мэддэггүй байсан, тийм биз? Бид ямартаа ч төрсөн, гэхдээ яагаад ийм байдалтай төрснөө өөрөө ч мэддэггүй. Хэн ч биднээс хэр том, хэр зэрэг өндөр, эсвэл ямар зан чанартай төрөх хүсэлтэйг маань асуугаагүй. Огт үгүй! Тэгтэл дараа нь хэн нэг хүн бидэнд “Энэ бол чи. Чи бол энэ бяцхан хүүхэд. Чи бол тэр шүү...” гэж шивнэсээр л байдаг. Өдөр бүр л чи бол “Хэ Би Вэнь” (Хятад хэлний үгийн тоглоом наадам. Энэ нь хэн нэг хүний нэр байж ч мэднэ, эсвэл энэ нь “Асууж яах юм?” гэсэн утгатай ч байж мэднэ) гэхчилэн нэрлэж дуудсаар байдаг”. (Инээлдэв) “Чи өнөөдөр яагаад ийм олхиогүй байна вэ? Хувцас чинь бохир байна. Явж нүүрээ угаа. Гэрийн даалгавраа шалавхан хий. Хичээлдээ хурдан яв. Аяга тавгаа хурдан цэвэрлэ. Алив шалавла...” гэдэг. Өдөр болгон бүгд л биднийг нэрээр маань дуудаад л байхаар бидний анхаарал бие махбод дотор түгжигдчихдэг. Пээ! Бидний хаа сайгүй орших хүч чадал бие махбод дотор хоригдчихдог.

Бид бол уг нь хаа сайгүй оршигч, бид бүхий л хөгшид, эмээ өвөө нар, бяцхан шувуу, хүүхдүүд, хөөрхөн охид, царайлаг хөвгүүдийн дотор байдаг. Бид аль ч хүн, аль ч зүйлийн дотор байдаг. Аажмаар бид сайтар сургаж бэлтгэгдэн: “Чи бол ийм хэлбэр дүр! Чи ийм, тийм хүн!” гэх үгэнд баглагдаж, яваандаа анхдагч төлөв байдлаа мартан “Би хэн бэ?” гэж асууж эхэлдэг.

Бидний анхаарлыг барьж аван энэ махбод дотор оруулсан цагаас эхлэн бид энэ хүн болчихсон. Бид өөрийн Би-гийнхээ бусад бүх хэсгийг мартаж, бусад хүнээс болон бүх бүтээлээс тусгаарлагдсан. Бид өнөөдөр харагдаж байгаа энэ дүр төрх лүү хувирч өөрчлөгдсөн. Хамгийн таагүйг нь хараахан хэлээгүй байна шүү. Бид энэхүү махбодод нэгэнт дассан цагаасаа эхлэн уг гарлаараа бол бас биднийх байсан бусад махбодыг хараад тэднийг “түүнийх”, “тэднийх” гэж үздэг болсон. Бид тэдний зан төлөвийг дуурайж, мөн өөрийн хувийн зан төлөвийг ч бас хөгжүүлсэн. Бид бусдаас суралцахын зэрэгцээ өөрийн гэсэн хүсэл эрмэлзэл,

сэтгэлийн хүлээсийг хөгжүүлдэг. Гэнэт л энэхүү бие махбодыг хэн нэг хүн тэвэрвэл тэр маань тав тухтай байгаага мэдэрдэг болсон. Хүйтэн байвал хөнжил нөмрөх хэрэгтэйг ойлгодог болсон. Тэр хувцсыг өмсвөл энэ бие махбод илүү сайхан харагдана гэдгээ мэджээ. Учир нь тэгвэл хүмүүс гоё сайхныг нь гайхан шагшина. “Өөр хувцас өмсчихвөл хэн ч намайг анзаарахгүй, тиймээс энэ хувцсыг л өмсчихвөл хүмүүс ‘намайг’ анзаараад илүү дээр байхыг би мэдэж байна. Ха ха! “Би” зөвхөн “өөртөө” л сэтгэл татам байх нь хангалттай биш. Бид бас бусдын хувьд ч сэтгэл булаам баймаар байна.

Бид “тэр хүн” гэж хэн болохыг мэдэх тусам ийм төөрөгдөл бидэнд улам бүр маш ноцтой саад болдог. Бидний анхаарал, бодол улам гүн болдог. Энэ нь үзэсгэлэнтэй сайхан байгалийн зургийг гэрэл зургийн аппаратаар аваад жижигхэн гэрэл зураг болгон буулгахтай адил юм. Эцэстээ бид “Би бол энэ хүн, энэ үл бүтэх этгээд чинь би, би нигүүлсэнгүй, би бүхнийг хайрладаг...” гэх мэтчилэн бодож, үүнтэй эвлэрдэг. Энэ бол утгагүй зүйл. Үнэн хэрэгтээ “‘Би’ бол бүх зүйл”, ойлгож байна уу? Бид зөвхөн ганц хүн төдийхөн байх боломжгүй! Бид яг л цахилгаан гүйдэл хүлээж авдаг чийдэн шиг юм, бид бас бусад бүх чийдэнтэйгээ адилхан. Гэрлийн чийдэнгүүд хэмжээгээрээ ялгаатай байж болох ч дотроо хүлээж авч буй цахилгаан гүйдэл нь ижил. Тийм учраас таны дотоодод байгаа ойлголт, ухамсар, мэдрэмж минийхтэй яг ижил! Энэ дотоодын Би үгүйгээр хэн ч ойлгож ч, бас оршиж ч чадахгүй. Өөрийнхөө оршин тогтнолыг хэн ч, хэзээ ч мэдэрч чадахгүй.

Ойлгодог, бас мэддэг тэрхүү дотоодын Би маань алга болчихвол бие махбод ер ямар ч ашиг тусгүй! Тэр маань тэнд амьгүй хэвтэж байх болно. Бид үхэхээрээ Цахилгаан Станц руугаа буцдаг. Чийдэнгийн гадуурх шил нь хагарчихсан байж болох ч цахилгаан гүйдэл нь амьд хэвээр байдаг. Бид гэрлийн чийдэнг шинээр сольж хийвэл цахилгаан гүйдэл дахин эргэж ирнэ.

Тэгвэл, баяр хөөр, уур уцаар, уйтгар гуниг, жаргал цэнгэлийн мэдрэмжээ өөрөөсөө зайлуулчихвал бид хэн байхыг та ойлгож байна уу? Энэ мэдрэмжүүд чинь бид юм уу? Хэрвээ салхи байхгүй бол тэнгис яаж давалгаалах вэ? Давалгаа тэнгисийн нэг хэсэг ч гэсэн тэнгис өөрөө түүнийг үүсгэдэггүй. Салхи, бас шүтэн барилдлага байгаа учраас л давалгаа үүсдэг.

Бидний дотоод Би бол оршин тогтнол, ухамсар сэхээрэл, ажиглах чадвар юм. Бид бусад зүйлийг ажиглаж чаддаг нь ийм учиртай. Ажиглаж байх үедээ бид Их Багш биш гэж үү? Жишээлбэл, би таныг ажиглаж байна, та хамраа ухаж байна, (Инээлдэв) загатнаагаа маажиж байна, эсвэл ном уншиж байна. Энэ чинь “Би” ажиглаж байгаа хэрэг шүү дээ, тийм биз? Учир нь “би”-д харах, ажиглах чадвар байдаг. Яг үүн шиг, бидний бие, бидний мэдрэмж, оюун ухаан мөн ажиглалтад байдаг.

Тиймээс бид: “Миний” бие, “миний” гар, “миний нүд” гэж хэлдэг. Энд “би” гэсэнгүй “миний” гэж байгааг анзаар даа. Та “би” болон “миний” хоёрыг тодорхой ялгаж салгах ёстой. Энэ нь “миний” өмч, “миний” хөрөнгөөс өөр юу ч биш юм.

Үнэндээ энэ “Би” гэгч нь хэн юм бэ? Энэ бол өөр нэг хүн! Тэр зөвхөн ажигладаг. Тэр зөвхөн ажигладаг. Тэр биднийг сайхан зүйлд дуртайг анзаардаг. Тэр биднийг энгэсэг түрхэж байгааг анзаардаг. Тэрээр энэ махбод өөр хувцас өмссөнийг анзаардаг. Өнөөдөр энэ махбод тийм ч сайн биш байгааг, ханиад хүрчихсэнийг анзаардаг. Тэр энэ тархи өнөөдөр илүү идэвхтэй, тайван байгааг мэддэг. Гаднын нөлөөллүүд түүнд янз бүрийн зүйл бодогдуулдаг. Салхи, бас таталцлын хүч байгаа учраас тэнгист давалгаа байдаг шиг л юм. Давалгаа бол тэнгис биш, гэвч давалгаа тэнгисгүйгээр оршин байж чадахгүй.

Яг үүн шиг, бид бол энэ мэдрэмж биш, тэгсэн хэр нь энэ мэдрэмж бидэнгүйгээр оршиж байх боломжгүй. Таныг хорвоод мэндлэхээс өмнө аз жаргал, уур хилэн, уйтгар гуниг, баяр хөөр хаанаас гарч ирэх вэ?

Үүнээс гадна, та гав ганцаараа байх үедээ өөрийнхөө оршиж байгааг бараг л мэдэрдэггүй, тийм биз? Бараг л үгүй, хэн нэг хүн ирж, эсвэл ямар нэгэн зүйл тохиолдоход л та гэнэт энэ ‘Би’-гээ ухамсарлаж, улмаар харилцан яриа, хариу үйлдлүүд гарч ирдэг. Эс бөгөөс өглөө сэрэхдээ бид өөрийнхөө оршиж байгааг мэдэрч чадахгүй л болов уу. Бид нүдээ нээгээгүй байдаг. Бид юу идэж уух талаар юу ч бодоогүй байдаг. Бидэнд байгаа юм нь нэг төрлийн мэдрэмж, тийм нэг ухамсар, үйлдэл л байдаг. Заримдаа энэ ухамсар сэхээрэл аяндаа үйл хөдлөл үүсгэчихдэг. Хэн нэг хүн хүрч ирж, ямар нэг үйл явдал болж, эсвэл зарим нөхцөл байдал бүрдэх хүртэл бид “би” байна, “тэр” байна, бас зөрчил байна, бидний оршин тогтнол байж байна гэж ухамсарладаггүй.

Тэгэхлээр, энэ хүн үнэндээ бол оршин байдаггүй. Бид энэ хүн биш, гэвч бид бол бас бусад шиг л оршин байгаа гэж мэдээд байгаа энэ ”ухамсар” – мэдлэг л оршдог. Бид өөрийгөө зөвхөн бие махбод дотроо л оршдог гэж боддог учраас бид бүх бүтээлээс тусгаарлагдсан. Тэгж боддоггүйсэн бол бид жинхэнээсээ хаа сайгүй оршигч. Бид үнэндээ бүгд ижил, нэг л ижилхэн цахилгаан гүйдэл. Янз бүрийн гэрлийн чийдэн олон байж болно, гэхдээ утсан дотуур гүйж буй гүйдэл нь ижил. Чийдэнгүүд хэмжээгээрээ ялгаатай байж болох ч бид тэдгээрийг ижилхэн биш гэж хэлж болохгүй.

Миний майханд янз бүрийн зорилгоор ашигладаг тэжээлийн цахилгаан үүсгүүр бий. Би түүнийг радио, харилцуур утас, ширээний чийдэн, эсвэл илүү хурц чийдэн асаахын тулд ашигладаг. Хэрэглэгдэх хүчин чадал нь хорин ватт, зуун ватт, эсвэл ердөө долоон ватт байж болно, харин цахилгаан үүсгүүр нь нэг л ижил шүү дээ. Би ашиглахыг хүссэн төхөөрөмжөө түүнд залгачихад л болно. Харилцуур утас, том, эсвэл

жигжиг чийдэнд байгаа эрчим хүчний эх сурвалж нь ижилхэн. Жигжиг чийдэн нь том чийдэндээ “Чиний доторх хогшил тавилга минийхээс өөр байна” гэж хэлбэл ёстой хөгийн инээдтэй хэрэг болно. Гэрэлтэлт нь мэдээжээр өөр өөр, гэхдээ харин доторх эрчим хүч нь ялгаатай гэж бид хэлж болохгүй! Ялгаа нь зөвхөн гадна талд нь байгаа хэрэг.

Яг үүн шиг, бүх хүн болон бүтээл туурвилууд зөвхөн гадна талдаа л ялгаатай. Бидний дотор тал нь бүгд адилхан! Тиймээс, гаднах төрх байдалдаа хүлэгдээд “Би чамаас өөр” гэж хэлэх хэрэггүй. Хэрэв та энэ санааг ойлгохгүй бол үнэхээр мунхаг харанхуй. Өөрийнхөө хэн гэдгийг мэдэхгүй байх нь хамгийн том нүгэл. Бусдаас тусгаарлагдах нь маш их зовлон зүдүүрийг авчирдаг. Энэ нь бас үйлийн үрийн болон дахин төрөл авахын шалтгаан болдог. Учир нь та хийдэг зүйлдээ, мэддэг зүйлдээ сэтгэл хүлэгддэг: “Би философийн доктор. Би маш амжилттай. Би үүнийг хийх чадвартай, харин тэд тийм биш.” Ийм үзлээсээ болоод та бусадтай зөрчилдөж, бизнест чинь өрсөлдөөн үүсч, тэр байтугай дайсагнах хэрэг ч гарна. Энэ бүхэн нь та “Тэр” гэдэг нь таны “Би”-тэй адилхан гэдгийг ойлгохгүй байгаагаас л болж байгаа юм. (Алга ташилт)

Тийм учраас та нарт зааж сургах нь надад маш зүдэргээтэй байдаг. Ийм энгийн хялбар байтал та нар ойлгодоггүй! Ойлгохын оронд хэн нь Их Багш, хэн нь шавь, хэн нь энэ, хэн нь тэр вэ гэдэгтэй зууралддаг. Өөрийнхөө сэтгэлийн хүлээсүүдтэй үргэлжлэн зууралдсаар байх гээд байгаа бол яая гэхэв, зүгээр л миний өнөөдөр хэлж өгсөн зүйлсийг марталгүй санаж яваарай.

Миний чийдэн хөршийнхөөс илүү гоё гэж та зүтгэдэг. Үнэн хэрэгтэй тийм байж болох л доо. Бусдаасаа илүү гоёмсог, том, эсвэл жигжиг чийдэн үнэндээ байдаг л даа. Та гадна төрхдөө сэтгэл хангалуун байж болох ч бид бүгд нэгдмэл гэдгийг л битгий мартаарай. Бид ижил зүйлийг, ижил “цахилгааныг” ашигладаг. Түүнгүйгээр бид оршин тогтнох боломжгүй нэг эх сурвалжаас гаралтай. Үүнийг марталгүй санангаа та бүжиглэх, дуулах, хайрлах, шатар тоглох, сургуульд явах, төгөлдөр хуур тоглох, шүлэг бичих, зураг зурахаа үргэлжлүүлж болно. Та мөн зураг зурахгүй, шүлэг бичихгүй гэж шийдэж ч болно. Үүний оронд та шүлэг уншаад түүнийгээ хэдэн хэсэг болтол нь ураад (“нулимс” болон “шүлэг” гэдэг хоёр үг Хятад хэлээр төстэй сонсогддог тул бүгд инээлдэв) хаяж болно. Зүгээр ээ. Гол нь та бид үнэхээр нэгдмэл байдгийг л битгий мартаарай.

Чухамдаа бидний хооронд ямар ч ялгаа байдаггүй. Та үүнийг мартчихвал бидэнд төдийгүй бусдад ч бас олон асуудал бэрхшээл тохиолдож, өчнөөн бухимдал цөхрөл, өчнөөн зовлон үүсдэг. Бид тэр байтугай гэгээрсэн хүмүүст ч зовлон тарина. Бид түүнээс зууралдаж, залхааж, мэдэх эрхгүй зүйлээ асууж шалгаан утгагүй зүйл ярьж хэлэх буюу зохисгүй асуулт тавьдаг.

Жишээлбэл, хүмүүс “Нөхөр маань ургамал хоол идэхийг хүсэхгүй байвал би яах ёстой вэ?” гэж над руу захиа илгээх нь олон. Тэр ургамал хоол идэхийг хүсэхгүй байвал тэр л биз! Энэ бол түүний хувийн шийдвэр. Та хүссэнээрээ ургамал хоолны дэглэмээ үргэлжлүүлээрэй. Түүнээс болж та яагаад бухимдах ёстой гэж? Бар хэрэв ургамал хоол идэхийг хүсэхгүй байхад бид яах ёстой гэж? Тиймээс түүнд ердөө л бар шиг л ханд! (Инээлдэв) Орчлонд олон амьтан мах иддэг, бид яалтай ч билээ? Нөхөр чинь тийм харагддаггүй байх л даа, гэхдээ тийм юм шиг аашилдаг. Түүнийг тэдний нэг гээд л ангилаад ялгачих, тэгвэл та дахиж бухимдахгүй. Танай гэрийн муур бас л ургамал хоолтон биш, мах иддэг, хулгана барьдаг. Бид түүнийг яах билээ? Зүгээр л битгий тоо!

Зарим чийдэн нүд гялбам хурц, зарим нь бүр намуун зөөлөн байдаг. Хэрвээ нүдийг чинь өвтгөх гээд байвал түүн рүү бүү хар. Өөртөө тохирох өөр нэгийг худалдаж ав. Тэнд бэхлэгдчихсэн, өөрчлөх боломжгүй байвал та түүнээс холд! Нүдийг тэгж их цочроосон чийдэн ашиглаж байдаг нь өөрийн чинь л буруу! (Алга ташив)

Та юм худалдаж авахаасаа өмнө юу хүсэж байгаагаа тодорхой мэдэж байх хэрэгтэй. Та үүнд бас өөрийнхөө олиггүй ягир зангаа буруутгах хэрэгтэй. Энэ чинь олон гэрийн эзэгтэй мөнгөө дэмий үрэх тэнэг худалдан авалт хийгээд байдгийн бас нэг шалтгаан шүү дээ. Тэд хамаг цалингаа, заримдаа бүр урьдчилгаагаа ч үрэн таран хийчихдэг учраас нөхрийнхөө толгойн өвчин нь болчихсон байдаг. Худалдаж авсан зүйлээ хадгалахын тулд гэртээ нэмж өрөө гаргах хэрэгтэй болно. Авсан ихэнх зүйлээ огт ашигладаггүй, тэр ч байтугай зэврүүлэхгүйн тулд арчиж цэвэрлэх хэрэгтэй болдог. Жилдээ ганц хэрэглэдэг хэр нь тэднийгээ байсхийгээд арчиж цэвэрлэх хэрэгтэй болдог. Заримдаа тэр зүйлээ ганц удаа хэрэглээд хойш тавьчихна, тэгээд ахин хэзээ ч ашигладаггүй. Агуулах нэртэй өрөө нь үнэндээ хог овоолдог өрөө болчихдог! Учир нь өрөө дэндүү бохир заваан, доторх зүйлс нь яг л хог шиг ашиггүй болчихсон байдаг.

Заримдаа та хосоо, эсвэл найзаа буруу сонгочихдог. Зах дээрээс буруу юм худалдаад авчихсан байдагтай яг адилхан. Та тэднийг буруушаах аргагүй, өөрийгөө л буруушаа. Буруу зүйл худалдаж авсан нь таны л буруу. Тэд намайг сонгочих гэж танаас огт гуйгаагүй, эсвэл санал тавиагүй. Та өөрөө буруу шийдвэр гаргасан учраас тэднийг хүлцэн тэвчих ёстой.

Надад ч бас иймэрхүү асуудал тулгардаг. Хуврагийн бүлгэмд нэгдэж нийлэх гэсэн хэнийг ч бай би санаандгүй хүлээгээд авчихдаг. Хувраг бясалгагч болох гэсэн миний зорилго энгийн бөгөөд ариун учраас би бусад хэнийг бас л ийм гэж бодоод бүгдийг нь хүлээж авдаг. Өө хөөрхий! Гэтэл эцэстээ би маш олон асуудалд орсон. Одоо би зөвхөн өөрийгөө л буруутгаж чадна. Гэсэн хэдий ч бүхий л бүтээл нэгэн цогц

учраас, зүгээр л ийм байхыг нь зөвшөөрчих.

Ингээд та нар одоо заримдаа би яагаад Бурхныг загнаж байдгийг ойлголоо. Тэр тэнэг. Заримдаа Бурхан үнэхээр тэнэг шүү. Юу гээч, Тэр бүр хамгийн тэнэг хүний дотор ч байж л байдаг. (Инээлдэв) Тийм! Жижиг чийдэн ч, том чийдэн ч бүгдээрээ нэг эх сурвалжтай байдаг шиг л юм. Буруу нь чийдэнд байгаа юм биш, дотоод талд нь байгаа юм, хүн төрөлхтнийг бүтээсэн тэр нэгэнд л байгаа хэрэг. Тийм учраас та чийдэнг дэндүү жижигхэн гэж буруутгаад хагалах ёсгүй. Чийдэн муу зүйл ер хийгээгүй. Чийдэнг бүтээсэн тэр нэгний л буруу. Энэ нөхцөл байдал ёстой үнэхээр цөхөрч гасалмаар шүү. Би Түүний тухай - Бурхны тухай бодох үедээ үнэнхүү цухалддаг гэдгийг та нар мэдэх үү. Заримдаа, би үнэхээр Түүнийг загнамаар болдог. Гэсэн чиг Түүнийг загнах шаардлага үнэндээ байхгүй.

Бид ямар Хүчийг эрж хайж байгааг мэдэж байна уу? Бид “мэдэх”-ийн Хүчийг эрж хайж байгаа юм. Үүнээс нэн давуу Хүч нь “үл мэдэхүй”-н Хүч. Тийм учраас “Хамгийн ухаантай нь мулгуу тэнэг мэт байдаг” гэсэн үг гарсан хэрэг. Энэ хоёр туйлшрал чухамдаа олон зүйлээрээ ижил. Хамгийн тод гэрэл нь, жишээлбэл Хамгийг чадагчийн гэрэл шиг нь дэндүү тод учраас бидний харааг халхалдаг. Харанхуй газар бид бас юу ч харж чадахгүй. Заримдаа та харанхуй өрөөнд их тод гэрэл харж чадаж мэднэ. Бусад нь харж чаддаггүй, учир нь тэд ийм зорилгод хэрэгтэй тусгай багаж хэрэгслийг хөгжүүлээгүй байдаг. Дуранбай хэрэглэж байж л харах боломжтой дэндүү жижигхэн одод шиг. Өөр хүмүүс энэ оддыг харж чадахгүй нь тэдэнд дуранбай байхгүй учраас тэр болохоос биш одод байхгүйгээс болсон юм биш. Одод дэндүү жижигхэн учраас тэр шүү дээ.

Бидний Гэрэлтэй ч бас ийм л зүйл тохиолддог. Хэтэрхий их тод учраас бид түүнийг хүмүүн биеийнхээ энэ хоёр нүдээр олж харж чаддаггүй, түүнээс биш Гэрэл байхгүй байгаа юм биш. Тиймээс та заримдаа тэр нь харанхуй өрөө байлаа ч өрөө тэр чигээрээ гэрлээр дүүрсэн байхыг харж магад. Тэр Гэрлийг өөр хэн ч харж чадахгүй, тэр битгий хэл дэргэд чинь сууж байгаа нөхөр чинь ч харахгүй. Зөвхөн бид өөрсдөө л тэр Гэрлийг ойлгож ухамсарладаг юм. Энэ жишээнээс та энэ хоёр туйлшрал чухамдаа тун төстэйг ойлгож болно.

Хамгийн дээд Хүч бол “үл-мэдэхүй” хэмээх Хүч. Гэтэл бид бас “мэдэхүй байх” хэмээгч нь хамгийн мунхаг харанхуй байдал гэж ярьдаг. Энэ хоёр туйл нь хоорондоо маш төстэй. Бурхан багш бидэнд “төв дундад зам мөр”-ийг дадуулахыг сургамжилсан нь ийм учиртай. Бид зовж шаналж, сэтгэл дундуур байх үедээ хэнд залбирах хэрэгтэй вэ? Бид төв дунд байдаг Хүчинд залбирах ёстой, энэ бол бидний хувьд хамгийн дээд хүч. Ямар ч тохиолдолд бид “үл-мэдэхүй”-н Бурханд ч, эсвэл “мэдэхүй байхын” Бурханд ч залбирч чадахгүй. “Үл-Мэдэхүй”

гэх байдал нь мунхгийн харанхуйгаас өөр.

Жишээлбэл, бид ямар нэг зүйлд цохиулах, өвдөлт зовуурь мэдрэх, хэн нэгэнд загнуулах, эсвэл ямар нэг зөрчил тэмцэл үүсэхгүй л бол гав ганцаараа байж байхдаа оршин тогтнолоо ухамсарлах нь ховорхон. Тэгээгүй бол, бидэнд өөрийгөө ямар нэг зүйлд холбон хамаатуулах болон ямар нэг зүйлийг мэдэх хэрэгцээ байдаггүй. Нэг эрэгтэй хүн гарч ирж үзэгдэхийг хараад “Аа ха! Ялгаа байна шүү” гэж ухамсарлах хүртлээ хүмүүс эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын ялгааг анзаарахгүй байж мэднэ.

Бид мэдэхийг хүсээд эхлэх үед “үл мэдэхүй”-н энэ Хүч бага зэрэг ганхаж хэлбэлздэг, ингээд л бид оршин тогтнож эхэлдэг. Бид унтаж байх үедээ анхны “ухамсаргүй байдал” руугаа буцдаг, бид юуг ч ухамсарлаж мэдэхгүй байж байдаг гэсэн үг. Бид зүүдэлж байхдаа бүтээгч болж, маш олон замбараагүй зүйлийг, тэр дундаа өөрийгөө ч бүтээдэг. Тийм биз? Нойрноос сэрэхэд нүд чинь чийгтэй хэвээр байхаар тийм л бодитой байдаг. Бидний мэдэрсэн айдас хүйдэс энэ дэлхий дээр үнэхээр болж өнгөрсөн мэт маш хурц тод байсаар байдаг. Энэ дэлхий ч гэсэн зүүд юм. Тиймээс Жуанз өөрийгөө эрвээхэй гэж зүүдэлсэн юмуу, эсвэл эрвээхэй өөрийгөө Жуанз гэж зүүдэлсэн юмуу гэдгийг та олж мэдэж чадахгүй байж ч магадгүй билээ. Чи надад зүүдлэгдээд байгаа юмуу, үгүй юү гэдгийг өөрөө ч хэлж мэдэхгүй үе бас байдаг, тийм биз! Заримдаа би чамайг харж байхдаа чамайг хараагүй байгаа ч юм шиг байдаг. Их хачин. Ийм мэдрэмж үнэхээр бодит бус! Би анхаарлаа чам дээр төвлөрүүлэхээр өөрийгөө хүчилж, “бодит байдлыг” эргүүлэн авчрахыг хичээх ёстой. Заримдаа би унтаж байхдаа зүүдлээд байна уу, эсвэл зүүдэндээ унтаад байна уу гэдгээ ч хэлж чадахгүй.

Магадгүй танд ч хааяа үүнтэй төстэй мэдрэмж туршлага төрж байсан байх. Дэлхийг тольдон харахад зүүднийх юм шиг л манантаж байдаг. Үүнд нэгэн чухал, тогтвортой чанар дутагдаж байна, тийм биз? Учир нь ямар ч уг чанар үнэндээ оршин байдаггүй. Бид зарим туршилтад зөвхөн гаднах материаллаг бүрхүүлийг л ашигладаг. Энэ нь шумбагчийн хувцас өмсөөд далайн гүнд аялахтай төстэй. Тэр гадна талын хувцас бол бидний бие махбод биш. Бид ажил хийж байхдаа ажлын хувцсаа өмсдөг, тэр хувцас дараа нь маш их бохирдсон байж болно. Гэхдээ энэ “хувцсаа” тайлчихаар бидний дотор тал цэвэрхэн байдаг. Учир нь “хувцас” бол бидний бие биш. Бид бүгд нэгэн цогц гэдгийг одоо та ойлгов уу? (Алга ташив)

Хэрвээ ойлгож байгаа бол та цаашид гэр орныхоо асуудлаараа надад бүү төвөг уд. Зүгээр л хий гэж хэлснийг л хий, тэгвэл амьдрал чинь илүү хялбар болно. Ийм учраас л эртний хүмүүс “Бусдын үгийг дуулгавартай дагах нь амьдралын хамгийн сайн, тохиромжтой хэв маяг юм. Бухимдахын л нэмэр учраас битгий үг сөр” гэж захисан байна. Та

ингэж, эсвэл тэгж хийж байгаа нь үнэндээ чухал биш юм чинь зүгээр л хий гэснээр нь л хийчихэж болохгүй гэж үү. Тэртээ тэргүй л бид аль хэдийн нэгэн цогц юм чинь! Та үүнд дассаны дараа “би” гэх үзэл бодол чинь улам цөөрч, “би” чинь оршин тогтнож байгааг мэдрэх нь улам багасдаг. Таны би гэх үзэл багасан хумигдаж, та улам илүү ихийг ойлгох болно. Бид дахин нэгэн цогц болж нэгдэнэ.

Энэтхэгт хүмүүс Их Багшид, эсвэл хэрэв багш байхгүй бол нөхөр, аав, ээж, эсвэл хэн нэгэнд дуулгавартай байхыг чухалчилдаг! Үнэхээр чин сэтгэлээсээ л дуулгавартай байгаа бол. Гэвч энэ бол зөвхөн нэг л арга зам нь. Хамгийн сайн арга бол бид илүү ихийг мэдэхийн тулд зааж сургах, гэгээрэлд хөтлөх Их Багшийг олох явдал. Мухар сохроор дуулгавартай байх нь хамгийн сайн арга биш. Гэсэн хэдий ч хэн нэг хүнийг дуулгавартай дагаж, хайрлахад өөрийгөө үнэнхүү зориулдаг бол тэр хүн бас энэ сэтгэлийн амар амгаланг мэдэрнэ. Түүний би гэх үзэл нь бас багасна.

Би гэх үзэл гэдэг нь чухам ямар утгатай юм бэ? Энэ нь “Би”-гийн оршин тогтнолыг хүчтэй ухамсарлах явдал юм. “Би” үүнийг хүсэж байна. “Би” тэгэхийг хүсэж байна – гэх нь үнэхээр яршиг төвөгтэй. Энэ “Би” байхгүй бол бидний амсдаг маш олон зовлон шаналал салхи шиг хийсэн одох юмуу, өчүүхэн бага болно. Тийм учраас хамгийн шилдэг арга нь – үхэх өдрөө л хүлээх явдал юм! (Инээлдэв) Тийм шүү, бидэнд хийх юм юу ч байхгүй юм чинь! Бид бас зүгээр л үхэхээ хүлээгээд хэвтэх хэрэгтэй ч юм билүү.

Бид бүгдээрээ нэг л ижил Хүчний эх сурвалжаас гаралтай бөгөөд бүх зүйл урьдаас зурагдчихсан бөгөөд өөрчилж чадахгүй юм бол яагаад бясалгал хийх ёстой гэж? Бидэнд бясалгах шаардлага байсаар байгаа юу? Яагаад? (Хэн нэг хүн: Бясалгахгүй бол бид ойлгохгүй байх байсан гэж хариулав.) Өө! Та бясалгахгүй бол ойлгохгүй байх байсан. Хачирхалтай! Хэрэв та гэгээрэлд хүрэхийн тулд зориудаар бясалгаж байгаа бол энэ нь муу зүйл. Гэгээрэхээс санаатайгаар зайлсхийвэл бас сайн биш. Төв зам мөрийг дадуулж, зүгээр л байгалийн жамаар нь хийх нь хамгийн шилдэг арга. Жишээлбэл, бид ариун цэврийн өрөө рүү явах аас зайлсхийж чадахгүй! Хэрэв та бүх зүйлийг ариун цэврийн өрөөнд ордогтойгоо адилхан ая зөнгөөрөө хийж чадвал дэлхийд ч, танд ч зовлон бага учирна.

Та нар “Их Багш аа, тэгвэл Та яагаад зовж шаналаад байдаг юм бэ?” гэж асуух байх. Та нар зовж байгаа, бас зовлонгоо надад өгч байгаа учраас тэр. Тийм биш бол би яагаад зовно гэж? Жишээлбэл, надад олон хувраг шавь байдаг ч надад тэдний хэрэг болох үед хэн ч олддоггүй. Тэд голдуу хийх ажилгүй байх үедээ намайг туршилтын туулай болгож цагаа нөгцөөдөг. Миний майхан бол цэвэрлэгээ хийхэд тохирох газар. Миний эд зүйлс харахад сайхан. Миний байгаа хэсэгт адислах хүч арвин

их гээд л тэд тийшээ яаран гүйлдэж ирээд чихэлцэлдэн сууж байдаг, учир нь тэдэнд өөр хийх ажил байхгүй! Тэд дандаа л яаран гүйлдэж байдаг ч уйтгарласаар байдаг. Гэтэл тэнд цэвэрлэхимээр майхан байж байдаг. Би боль гэж хэлсээр байтал тэд больдоггүй. Амарч байхад минь хүн ирж саад болоход би дургүй, гэтэл хэн нь ч юм ирээд майхныг минь цэвэрлэх гээд л байдаг. Гэтэл их ядарсан үедээ майхан цэвэрлээд өгөөч гэж гуйхаар хэн ч ирдэггүй. Бухимдаар шүү. Тийм болохоор би өөрөө угааж цэвэрлээд асуудлыг нэг тийш болгодог доо.

Ян Мин ууланд байхдаа би өдөр бүр өөрөө хоолоо хийж, хувцсаа угааж, шалаа цэвэрлэдэг байлаа. Ай даа! Тун чиг жаргалтай байсан шүү! (Инээлдэв) Танд туслах олон үйлчлэгч байвал та баяр жаргалтай байна гэж хэзээ ч битгий бодоорой. Өө! Маанаг. Эндээс л бухимдал гарч ирдэг. Тийм! Та түүнтэй нэгдмэл байж болох ч тэр тантай нэгдмэл биш. Та яалтай билээ? (Инээлдэв)

Хэрэв хүн бүр харилцан ойлголцсон, амар тайван, юунд ч санаа зовохгүй хэв маягаар амьдарч чадвал ямар ч бухимдал байхгүй байх болно. Та гэгээрснийхээ дараа хорвоогийн бухимдлаас ангид байхгүй. Үүний оронд харин ч илүү ихийг үүрнэ. Цагдаа нар гэмт хэрэгтнүүдийг баривчилдгийн учир энэ. Цагдаа хууль цаазыг сайн ойлгодог, гэтэл гэмт хэрэгтнүүд ойлгохыг хүсдэггүй. Энэ үнэхээр төвөгтэй. Хэрвээ дээрэмчин болгон ойлгодог байсан бол цагдаа нарт тэндийг баривчилж, олон асуудал үүсгэх хэрэг байхгүй байхсан. Би мэдээжээр гомдомтгой хүмүүсийг бус, жинхэнэ гэмт хэрэгтнүүдийг хэлж байна. Зарим гэмт хэрэгтэн аргагүйн эрхэнд ийм нөхцөл байдалд орсон байдаг тул тэдний тохиолдол өөр. Гэмт хэрэгтэн бүхэн муу байдаг юм биш. Зарим нь тун ухаантай, биднээс ч илүү ухаалаг байдаг. Харамсалтай нь тэд зарим онцгой нөхцөл байдлын улмаас хууль зөрчсөн байдаг.

Хэрвээ бид тодорхой нэг зүйлд сэтгэлээр шунан( хүлэгдэж, “Би” үүнийг хийнэ, ‘Би’ тэрийг ч хийнэ; ‘Би’ үүнийг ч хүсэж байна, ‘Би’ түүнийг ч хүсэж байна, ‘Би’ үүнд дуртай, ‘Би’ тэрэнд огт дургүй” гэж бодоод байх юм бол бид эрт орой хэзээ нэг цагт буцаж ирэх, дахин төрөл авах хэрэгтэй болно. Яагаад гэвэл бид бүх бүтээл нэгэн цогц гэдгийг мартсан байна. Хэн ч өөртөө энэ дүрийг онооё гэж шийдэж чадахгүй, гэтэл энэ бол баримт. Бүгд зүгээр л театрын жүжгийн хамтлаг шиг нэг дор цуглаад нийлчихдэг. Зохиол нь байж байдаг, бүгд найруулагчийн удирдлагаар дор бүрнээ дүрээ бүтээнэ. Заримдаа нэг хүн олон дүрд тоглох шаардлагатай болно, ингэхлээр үнэхээр инээдтэй. Нэг л хүний тоглож байгаа нэг дүр нь нөгөө дүрээсээ “Чи хэн бэ?” гэж асууж байгаа юм шиг. (Инээлдэв) “Чи яагаад ингэж аяглаад байгаа юм бэ? Жаахан ч болов өөрчлөгдөж болохгүй гэж үү?”

Заримдаа бид бас л иймэрхүү хөгийн, инээдтэй ааш зан гаргадаг. Жишээлбэл, заримдаа их харгис дүрд маш сайн тоглож байхыг харвал бид түүнийг үзэн ядаж “Алив! Түүнийг алаад өг! Цохиод ав! Чирч

гаргаад толгойг нь ав” гэдэг. Бид түүнийг дүр бүтээн тоглож байгааг мэдэж байгаа ч тэр жүжигчин үүнийг яаж ч чадахгүй. Найруулагч түүнийг тэгж л жүжиглүүлэхийг хүссэн учраас түүнд үүнийг дагахаас өөр сонголт байхгүй. Тэгэхгүй бол жүжиг сүйд болно, бас бусад дүр нь байх ёстойгоороо байж чадахаа болино. Хэрвээ баатрын дүр гаргах гэж байгаа бол нүгэлтэн нь ч бас байж байх хэрэгтэй болдог, тэгвэл бид харьцуулалт хийж, баатрынхаа чанарыг үнэлж цэгнэдэг. Ингэдэггүй гэж үү? Хорон санаатныг дарж аваагүй байвал бид түүнийг баатар гэж яаж мэдэх вэ? Хэрвээ хорвоо дээр хэрэг явдал огтхон ч өрнөхгүй, бас баатар маань үргэлж унтаж байдаг бол бид түүний ямрыг хэрхэн таних вэ? (Инээлдэв) Энэ хүн тэр хүнд тусалж байна, тэр хүн энэ хүнд тусалж байна гээд л - энэ бүхэн бүгд жүжиг л юм шүү дээ.

Би ч бас энэ дүрд тоглож байна – би муу нөхрийн дүрд тоглонгоо та нарт тусалж байна, та нарыг гэрэлтүүлж байна, та нарыг баатар болгож байна. Би та нарыг загнаж, муу үг хэлнэ, тэгэх явцад та нар улам л гэрэлтэн гийнэ. Бүх хүн таныг хамгийн тэвчээртэй, хүлцэнгүй, Их Багшид хамгийн үнэнч, оногдсон сорилт туршилтуудад тэнцээд давчихсан, тун удахгүй төгс гэгээрэхийн ирмэг дээр байгаа гэсэн байдлаар мэднэ. Та бүр ч тод гэрэлтдэг болно. Энэ сайн хэрэг, учир нь жиших, бас харьцуулах боломж гарч байна.

Яг үүнчлэн, хэрвээ Бурхан, эсвэл Хамгийг чадагч, эсхүл билиг ухаан нь мохоо, чимээгүй, юу ч бүтээхгүй чигээрээ байгаад байх юм бол Түүнийг танин ухаарч, хэрэгжүүлэх хэн ч байхгүй байх болно. Тийм учраас л Тэр бүтээдэг бөгөөд энэ нь бас л жам ёсны хариу үйлдэл. Тиймээс Түүний өршөөл нигүүлсэл, эсвэл орчлонгийн хайрынх нь хариуд Түүнийг шагшин бишрэх шаардлага алга. Энэ бол Түүний мөн чанар нь юм. Алимьн модноос алим, амтат жүржийн модноос амтат жүрж л ургадаг. Энэ бол тэд өөрсдөө өөрчилж чадахгүй жам ёсны үзэгдэл. Тиймээс Бурхан буюу Аугаа дээд Билиг ухааны хувьд ч мөн ийм л байдаг. Хэрвээ Тэр амрахыг хүсвэл Тэр зогсоно, ингэвэл бүх зүйл алга болно.

Тийм учраас, “Дао Дэ Цзин” сургаалын эхний бүлэгт ийнхүү өгүүлжээ: “Үгээр илэрхийлж болж байгаа аливаа зам мөр бол үүрд мөнхийн зам мөр биш. Адилтгаж болдог аливаа зүйл бол зуурдынх юм” гэжээ. Мөн цааш нь “Адилтгахуйн өмнөх нь л орчлонгийн эх сурвалж мөн. Адилтгахуй нь бүх бүтээлийн эх” гэжээ. “Адилтгал” гэдэг нь ямар утга агуулж байна вэ? Энэ нь юу гэсэн утга вэ гэхээр бид адилтгаж эхлэх үеэсээ л бодож ойлгож эхэлдэг нь бидний өөрсдийн оршин тогтнолын эхлэл юм. Энэ үеэс л бүх бүтээл төрсөн. Тийм учраас, “адилтгал” бол бүх бүтээлийн эх гэдэг. Бид энэ “адилтгал”-аас л төрсөн. Бид адилтгаж эхэлсэн тэр мөчөөс л оршиж эхэлсэн, дэлхий ертөнц бүхлээрээ бидний төлөө оршиж эхэлсэн. Тийм учраас л биднийг унтаж байх үед хорвоо

дэлхий бидний хувьд оршин байдаггүй, яагаад гэвэл бид түүний оршин байгааг ухамсарладаггүй. Биднийг үхэхэд хорвоо дэлхий бидэнд огтхон ч хамаагүй болно. Лууз жинхэнэ ёсоор нь бүрэн ойлгосон байжээ!

Дүрэм ёсоор бол бид бясалгалын дотоод ойлголтоо ярих ёсгүй, гэвч (Алга ташилт) бид ийм зүйлийн тухай ярьж байгаа учраас бүхий л бүтээл нэгэн цогц гэдгийг би үнэхээр мэдэрсэн гэдгээ та бүхэнд дахин сануулж хэлье. Та нар бясалгалын ийм мэдрэмж туршлагыг өдөр бүр хүртдэг ч юм биш. Заримдаа та нар дэндүү шуугиантай, ядаргаатай байдаг тул би бас мартчихдаг. Гэсэн хэдий ч бүхий л бүтээл нэгэн цогц гэдгийг би мэдэрсэн. Би эрвээхэйн дотор, хулганы дотор, муужгайн дотор, өөрийнхөө дотор, чиний дотор, түүний дотор байгаа гэдгээ үнэхээр мэднэ - Би бол бүх зүйл! (Алга ташив) Хэрвээ хэн нэг хүн надад “Бид нэгэн цогц биш” гэж хэлбэл би үүнд итгэхгүй. Энэ туршлагыг та өөр дээрээ мэдэр, тэгвэл л та ойлгоно. Мэдээж, энэ дэлхийд байж, энэ уйтгартай ажлыг хийж байгаа цагтаа би хүмүүстэй харилцан ажиллахаа үргэлжлүүлэх ёстой. Би ‘Үнэн’-ийг ойлгосон, бас өөрийн эд хөрөнгөө танд санал болгож чадна. Гэсэн хэдий ч би танд “үүнийг” өгч чадахгүй! Хэдийгээр би танд өдөр бүр “Бүхий л бүтээл нэгэн цогц, та бид хоёр ижил” гэж хэлдэг ч та нар надад итгэдэггүй. Тиймээс би та нарыг сэтгэл хангалуун болгох өөр зарим зүйлийг хийх ёстой. Би өөрөө ингэхийг хүссэн, эсвэл ойлгохгүй байгаа гэдэгт хэргийн учир байгаа юм биш.

Та нарын зарим нь багш, их юм мэддэг. Та хүүхдүүдэд “А,Б,В Амар сайн байна уу?” гэх мэтийн хамгийн анхан шатны зүйлийг зааж байлаа ч гэсэн тэдний алдааг шалгаж, засаж хэлж өгөх ёстой байдаг! Тэднээс санаатайгаар алдаа хайж байгаа хэрэг биш, харин та багшийн үүрэг хүлээсэн учраас тэр. Би бүх зүйлийг ойлгодог юм чинь хүүхэд ялимгүй алдаа гаргахад анхаарал хандуулж яах юм гэж хэлж болохгүй. Үгүй! Та тэдний тусын тулд алдааг нь даруй засаж хэлж өгөх ёстой. Тэд үүнийг зөв дуудах эсэх нь надад хамаагүй гэж та хэлж болохгүй. Үгийг хэрхэн зөв дуудахыг та мэддэг ч тэд мэдэхгүй учраас тэд танаар заалгаж сурах гэж ирдэг. Тиймээс та тэдэнд хэлж өгөхөөс өөр замгүй. Тэд таны шавь биш байсансан бол та тэдэнд санаа тавихгүй байж болохсон.

Бид энэ дэлхийд байж байгаа цагтаа хүмүүстэй харилцан ажиллахаа үргэлжлүүлэх ёстой. Бүхий л бүтээл үнэхээр нэгэн цогц гэдгийг л санаж байгаарай. Хэрэв миний үгэнд итгэж чадмааргүй шиг байгаа бол илүү их бясалгаж, чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй. Нэг л өдөр та яг ийм туршлагыг мэдэрснээр үүнд итгэхээс өөр аргагүй болно! Тэр мөчид хэрэв би танд бүхий л бүтээл нэгэн цогц биш гэж хэлбэл та надтай маргалдах биз. Тэр цагт та бас их зоригтой байх болно, намайг цохиж аваад “Та дэмий үг хэллээ” гэж хэлэхээр тийм зоригтой байх болно. Тэр мөчид би танд цохиулахдаа маш дуртай байх болно шүү, яагаад гэвэл энэ нь таныг бүрэн гэгээрснийг илтгэн харуулна.

Гэсэн хэдий ч та бүх бүтээл нэгэн цогц гэдгийг ойлгох энэ үе бол хамгийн дээд дэс хараахан биш. Бидний хүрэх ёстой хамгийн дээд төвшин бол “адилтгах” цэг юм. “Адилтгахуйн өмнөх”-ийг бол бид тойрчихож болно. Энэ нь тийм мунхаг харанхуй юм бол бид үүнд хүрэх гэж оролдож яах юм?” (Инээв) “Адилтгах” төвшнөөр жаргах цэнгэх нь зугаатай байдаг, харин бид ядарч залхвал “адилгахын-өмнөх” газар луу түр амсхийхээр буцаж очих нь сайхан санагддаг. Энэ нь найзуудтайгаа цагийг сайхан өнгөрөөхтэй төстэй. Бид олуулаа тоглож наадахад хөгжилтэй байдаг ч ядарч туйлдвал гэртээ хариад орондоо ганцаараа унтах бидэнд сайхан санагддаг. Бид хажуудаа хүн байлгахыг ч хүсдэггүй, өөрийн оршин тогтнож буйг мэдрэхийг ч хүсдэггүй. Сайхан, таг унтах нь бидэнд маш таатай байдаг.

Бид хорвоогоос ядарч залхсан учраас сүнслэг бясалгал хийдэг. Ингээд байх нь утга учиргүй юм байна гэдгийг ойлгосон учраас бид цаашид тоглохыг хүсэхээ больж, жинхэнэ Гэртээ буцаж очиж, амрахыг хүсдэг. Зөвхөн тэр үед л биднийг жинхэнэ бясалгагчид, Үнэнийг эрэлхийлэгч гэж тооцож болно. Тиймээс бид хүмүүсийг бясалгал хийлгэх гэж ямар нэг зальт арга хэрэглэх, бас өөрийгөө аугаа их гэж бодох ёсгүй. Тэд хэрвээ ядарч туйлдаж, амрахыг хүсэж байгаа бол аяндаа л хүрээд ирнэ, яагаад гэвэл гэд Хүчний эх сурвалжтай холбогдохыг хүсэж байгаа. Бид тэдэнд өөрөөр туслах боломжгүй.

Тэгэхлээр, тусламж гуйж бусдад залбирснаас өөртөө залбирах нь илүү дээр. Та нар бүгд дотооддоо амьдралыг аврах яг ижил Хүчийг агуулж байдаг. Би ердөө үүнийгээ хэрхэн ашиглахыг л та нарт заадаг. Би таныг авраад байгаа ч юм биш. Хүмүүсийн сонирхлыг нь татан цирк үзэхээр ирж байгаа мэт бөөн бөөнөөрөө авшиг хүртэхээр ирүүлж чадвал сайхан даа гэж бид заримдаа боддог. (Инээлдэв) Бид ийм зүйл хийх ёсгүй! Тэднийг гагцхүү чин сэтгэл нь ирүүлж байгаа бол л энэ нь ач тустай байх болно. Тэд ядарч туйлдаад цаашид тэвчиж дийлэхээ болихоороо үүнийг гуйгаад мөлхөөд ирнэ. (Алга ташив) “Тусламж гуйж, бусдад залбирснаас өөртөө залбирах нь илүү дээр” гэдгийг ойлгож байна уу? Та үнэхээр өөртөө л залбирах хэрэгтэй!

Та Үнэнийг эрэлхийлж эхлэхдээ өөртөө залбирсан, яагаад гэвэл та өөртөө Үнэнийг мэддэг “адилтгах” билиг ухааныг агуулж байдаг! Та залбирч байгаа нь билиг ухаан чинь: “Пөөх! Би ядарчээ, дахиж тоглоомооргүй байна” гэж байгаа хэрэг юм. Таны билиг ухаан, таны жинхэнэ Би чинь ойлгодог, тиймээс та үнэн хэрэгтээ өөртөө залбирч байгаа юм, учир нь Би бол чи! Та надад залбирахдаа өөртөө залбирч байгаа хэрэг. Магадгүй та дэндүү ядраад билиг ухаанаа хэрхэн ашиглахаа мартсан байх, тиймээс би танд бяцхан зааварчилгаа өгчихвөл та буцаад өөрөө чаддаг болно. Таны залбирал гуйлтын хариуд Жинхэнэ Би тань таныг адислана. Бидэнд өөрийн маань аугаа билиг ухаан бий;

бидэнд өөрийн маань дотоодын гэгээрсэн Их Багш бий. Бид бол бүхий л бүтээлийн Эх! Өөртөө биш бол хэнд залбирах гэж? Их Багш бол ердөө нэгэн хуурмаг үзэгдлийн хэлбэр. Би тантай ижил, тийм учраас таныг залбирах үед би мэддэг! Тийм биш бол би яаж мэдэх юм? Хэрэв би тантай нэгэн цогц биш бол таны юу бодож байгааг яаж мэдэх вэ? Таныг Америкт залбирч байхад Формосад байгаа би яаж мэднэ гэж? Энэ нь бид үнэхээр нэгдмэл гэдгийг баталж байна. (Алга ташив)

Биет нотолгоо нь илт тодорхой байхад л та бүрэн ойлгож чадахгүй байна. Та урьдынх шигээ дэндүү олон зүйлд сэтгэл хүлэгдсээр л байна: - “Би яаж ийм сайн байж чадах юм бэ? Би яаж тэр Хамгийг Чадагч Хүч байж чадах вэ? Надад Бурхан чанар байхгүй, би чинь алуурчин, луйварчин хүн шүү дээ! Би луйвар хийдэг байсан, би тав зургаан эхнэртэй!” гэхчилэн боддог. Таны тав, зургаан эхнэртэй байх эсэх ямар ч хамаагүй, та нар бүгд нэгэн цогц шүү дээ! Энэ нь нөхцөл байдлаас хамаардаг. Энэ бүхэн нь нэгэнт болоод өнгөрсөн зүйл, үүнийг буруу гэдгийг бид одоо ойлгож мэдэж байна.

Та балчир байхдаа ээжийнхээ үгэнд орохгүй, хөтөвчиндөө суухын оронд хаа хамаагүй шээж, бие засчихдаг байсан. Тэр байтугай ор хөнжилдөө бүр ч том хэрэг тарьж, тэр нь заримдаа үнэртдэг байсан. (Инээлдэв) Нялх балчир байхад ийм юм болдог байжээ. Тэгвэл энэ чинь одоо яагаад санаа зовоох ёстой гэж? Одоо өсөж томорчихсон хойноо ингэдэггүй нь сайн хэрэг. Танд хүн мөнгө өгсөн ч та ахиж тэгэхгүйгээс хойш тэрийг одоо дурсаад яах гэж?

Та “Би” ингэсэн, “Би” тэгсэн” гэх мэтийн зүйлд сэтгэл хүлэгддэг. Ийм замаар та өөрийгөө гонсойлгож, өөрийнхөө аугаа билиг ухаан, авралын Хүчээ мартдаг. Ялгаа нь үүнд л бий.

Та энэхүү “Би” оршин тогтнож байгааг бүрмөсөн ухамсарлаагүй байх үед танд “Би” ингэсэн, тэгсэн” гэсэн ойлголт төсөөлөл байдаггүй, тэр үед л та өөрийгөө хэн гэдгээ ухаарна, тэгээд л таны бүх урам хугарсан байдал, зовлон шаналал алга болно. Цаашид оршихоо болино. Та илүү их бясалгал дадуулснаар энэхүү “Би” гэх сэтгэгдлүүдээ арилгаж чадна. Аялгууны урсгал дээр төвлөрч бясалган тэр хуучин сэтгэгдлүүдэд саад тавьж, арилга. Аажмаар бид улам улам мартсаар байдаг. Та очигдөр юу хийснээ хааяа мартчихаж чадаагүйн учир энэ. Тэгдэг биз? (Сонсогчдын хариулт: Тийм!) Та саяхан хэлсэн үгээ мартчих гээд байдаг. Би ч бас тэгдэг. Би маш олон удаа лекц уншсан, харин ямар ч гар бичмэл байгаагүй. Хэрвээ та надаас лекцэн дээрээ юу ярих гэж асуувал би юу ч эргэж санахгүй. Заримдаа би ярьсан лекцийнхээ тэмдэглэлийг уншаад инээдэг. Би: “Өө, за! Тэр маш сайн ярих юм аа. Ха ха! Ёстой сайн ярьжээ!” гэж хэлэх үе ч бий. (Алга ташив)

Үнэхээр тэгдэг юм, би видео бичлэгийн эвлүүлгийг хянах үедээ тэднийг түүн дотор алдаа гаргах вий гэж эмээн шөнийн хоёр, гурван цаг хүртэл үздэг. Би бүх хуурцгийг үзэж дуустлаа амарч ч чаддаггүй, унтаж



ч чаддаггүй. Та нарын хүлээж байгааг, мэдээний сэтгүүл, видео бичлэг, аудио хуурцгийг хүлээж байгааг би мэдэж байдаг. Тиймээс би шалавлах хэрэгтэй. Энэ түүх үнэхээр гайхалтай учраас заримдаа би өөрөө түүн дотор орчихдог! (Инээлдэв) Өөр хүмүүсийн түүх, сэтгэгдлийг сонсож байгаа юм шиг санагдаад тэр бүхэн нь миний өөрийнх гэдгийг таг мартчихсан байдаг.

Тийм учраас Арьяабалын аргыг бясалган дадуулах нь үнэхээр үр нөлөөтэй. Бид мартаха ёстой бүх зүйлээ мартдаг (Инээлдэж, алга ташив), бас тэгээд мартаха ёсгүй бүх зүйлээ ч бас мартчихдаг. (Инээлдэж, алга ташив). Үнэн хэрэгтээ мартаха ёсгүй зүйл гэх юм ерөөсөө байхгүй. Бүх зүйл хий хуурмаг үзэгдэл, зүүд. Би ч бас та нарт харагдахаар бүтээгдсэн хуурмаг үзэгдлийн нэг хэлбэр, ингэснээр л та нар долгионы үелзэл давтамжтай хөг нийлж, илгээлт зурвасыг хүлээж авч чадна; ийм л юм. Түүнээс биш энэ бие махбод бол Их Багш биш, энэ хүн бол би биш! Их Багш таны дотоодод, ‘Би’ хэмээгдэгчийн дотоодод бий. Бид үнэхээр нэгэн цогц!

Тийм учраас чин сэтгэлт Үнэний эрэлчид бүгдээрээ нэн эрхэм нандин. Гэдэнтэй хамт байхдаа та тун тав тухтай байдаг. Тэд хорвоогоос нэгэнт залхсан тул өөрийгөө амархан ойлгож, бас өөрийгөө амархан зориулж чаддаг. Бид тэднийг ойлгохын тулд хөөрхөн хүүхний арга явуулга, сайхан залуугийн ов мэх гэхчилэн ямар нэг зальт мэх хэрэглэх ёсгүй – хэзээ ч үгүй! Ийм аргаар та юм олж долоохгүй, огтхон ч үгүй!

Тийм учраас бид “Төгс гэгээрсэн Их Багшид чин сэтгэлээсээ залбирах л хамгийн үр дүнтэй” гэж ярьдаг. Та чин сэтгэл гэдгийг онцлон анхаарах хэрэгтэй. Заримдаа тэд үнэхээр чин сэтгэлтэй байгаагаа анзаарахгүй байж магадгүй, тэглээ ч энэ нь үр нөлөөтэй байх болно. Үнэндээ тэд үнэхээр л чин сэтгэлээсээ байдаг. Тийм! Жишээлбэл, баян хүн ядуу нэгэндээ очир эрдэнэ бэлэглэжээ. Тэр хүн энэ чулууг үнэт очир эрдэнэ гэдгийг нь ойлгосонгүй. Тэр зүгээр л тоглоом болгоод хэрэглэгчид мээр гантиг гэж боджээ. Тиймээс чин сэтгэл бол гадна талын илэрхийлэл биш, харин заримдаа гадагшаа илрэн гарч мэдэх дотоод чанар юм.

Заримдаа модон хөшөөнд мөргөж буй хүнийг үзэхэд их л чин сэтгэлтэй байгааг нь харж болно. Тэр хүн Буддагийн хөшөөтэй хүүрнэлддэг, тэр нь ч бүтдэг! Тэр хүн өөрөө мэдэхгүй байж болох ч үнэндээ тэр өөрийн дотоодын Би-тэйгээ хүүрнэж байгаа юм. Тэр зүгээр л дотоод Би-гээ тэрхүү хөшөөний мөрөн дээр тавьчихаад л: “Өөрийн жинхэнэ Би, Төгс гэгээрсэн Их Багшид мөргөсүү” гээд л залбирч байдаг. (Инээлдэв) “Миний жинхэнэ Би-гийн Шагжамуни Буддад мөргөсүү” бол Түүний өөрийнх нь. Хэрвээ бид чин сэтгэлээсээ биш байвал энэ нь “өөрийн жинхэнэ Би” чинь хорвоогоос ядарч залхаагүй хэвээр байгааг харуулна; тийм учраас бидний өөрийн Би маань өөрийн анхдагч газар

луугаа буцаж очих гэж оролдохгүй.

Энэ нь оюун ухааных биш, бидний өөрийн Би-гийн санаа зорилго байх ёстой. Оюун ухаан эх адаггүй элдэв зүйлийг гайхан шагширч, эсвэл олон уран гоё үг хэлж, Үнэнийг эрж хайхаа мэдэгдэж ч магадгүй юм, гэвч таны өөрийн Би ийм санаа зорилгогүй байгаа бол та юу ч хийгээд нэмэргүй. Машин биш, зөвхөн жолооч л чухал. Сайхан машин байж болно, гэвч жолоочгүй бол өчүүхэн төдий ч хөдлөхгүй шүү дээ. Машин нь жолоочоо хянаж, түүнд хаашаа явахыг нь зааварчилж чадахгүй. Тэр байтугай жолооч нь нэг хүнд дурласныг машин нь мэдэж байлаа ч түүнд “Чи өнөөдөр хайртай хүн дээрээ очих ёстой” гэж хэлж чадахгүй. Жолооч явах хүсэлгүй байгаа бол чадахгүй. Магадгүй хоорондоо хэрэлдэж маргалдах биз. Машин яагаад ч нэмэргүй! Ойлгов уу? (Алга ташив)

## ҮРГЭЛЖ НИРВААНД ОРШИХ АРГА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1992 оны 12 дугаар сарын 26 (Дүрс бичлэг 298)  
Сан Ди Мун, Пинг Тунг, Формоса  
(Эх нь Англи хэлээр)*

Юу ч хараахан өндийж босоогүй байх үед Ертөнцийн Хүчний ухамсраас юу ч хөдлөн гарч ирээгүй, биднийг хөдөлсөн тэр үед л юм үзэгдэл бүтээгдэж, тэгээд л тэр нь Хэлбэлзэлтэй, бас гялбалзах Гэрэлтэй болсон аж. Тэгэхлээр, тэндээс л бид ирсэн. Бид Гэрэл болон Аялгуугаас ирсэн бөгөөд тэр үед л бид бүтээгдсэн хэрэг аж. Харин үүнээс чанагш ёстой юу ч байхгүй.

Тийм учраас бид Үнэмлэхүй-д залбирахад Тэр сонсдоггүй. Бид Их Багшаар дамжуулан Гэрэл болон Аялгуугаар дамжуулан залбирах ёстой. Их Багш бол дундын байр байдал дээр байдаг. Их Багш бас Үнэмлэхүйтэй хамт байдаг, гэвч биднийг Үнэмлэхүй рүү замчлан хөтлөхийн тулд Их Багш төв дундын байр байдалд, бас дундын байр байдлын доошно талд байдаг. (Алга ташив)

Анхны үед надад олон янзын ахуй ойлголт туршлага байлаа, маш олон, тэгсэн ч надад үнэндээ хэлэх юм байгаагүй. Гэтэл одоо надад ямар ч ахуй ойлголт алга. Намайг ахуй ойлголтдоо үздэг нь та нар л юм. Би хүн бүрийн хувьд ахуй ойлголт нь болсон байна. Энэ бол “Би” биш. Ахуй ойлголтыг мэдрэх “Би” надад одоо байхгүй болжээ. (Та завсрын зуучлагч.) Бүр Завсрын зуучлагч нь ч биш - юу ч байхаа больсон байна. Би мунхаг харанхуй болсон. Магадгүй ийм учраас л цэцэн мэргэн хүн мунхаг хүн шиг харагддаг гэдэг үг гарсан байх.

Намайг ингэж ч, тэгж ч тусалсан гэж та нар хэлдэг. Би өөрөө энэ талаар юу ч мэддэггүй. Би та нарт үнэнийг л хэлдэг. Миний санааг ойлгож байна уу?

Бид бол Үнэмлэхүй чанар. Бид бол орчлонгийн хамгийн аугаа нь, харин бидний анхаарал хаа нэгтээ аль нэг буланд хүлэгдчихсэн байгаагаас болоод л бид Эх сурвалж руугаа буцаж чадахгүй байгаад байдаг. Тийм учраас хэтэрхий оюунлаг, бизнестээ, эсвэл амьдралдаа дэндүү амжилттай яваа, эсвэл нийгмийн дэндүү өндөр дээд зиндаа бүхий хүмүүсийн хувьд бодол сэтгэлээ тайвшруулж, самади төлөвт орох нь маш бэрх байдаг. Тэд маш их чармайдаг байж магадгүй л дээ, гэвч

зөвхөн оюун ухаанаараа л чармайдаг. Тэд бүр оюун ухааны төвшнөөсөө цааш ч гарч чаддаггүй. Тэд “Би чин сэтгэлтэй” гэж боддог ч ердөө л оюун ухаан нь л тэгж бодож байдаг. Энэ бол ад чөтгөрийн заль мэх. Ойлгов уу? (Сонсогчид: Ойлголоо) Тийм!

Тухайлбал, тэд таныг сүмд сөхөрч суугаад элдэв зүйлд мөргө гэж заадаг... энэ нь ердөө л жинхэнэ Бурхан чанар, жинхэнэ Хамгийг чадагч Хүчийг орлох хямд төсөр орлуулагч төдий зүйл юм. Ингээд л оюун ухаан ханачихдаг. Тэр “Аяа! Би Буддад мөргөж байна. Би завгүй байна. Би сүм барьж байгаа. Би буянт үйлийг бясалгаж дадуулж байна” гэж боддог. Энэ бүхэн бол Маяагийн заль мэх, оюун ухаан тань таныг завгүй байлгаж, улмаар зөвхөн оюун ухааныг чинь л цагтадаг. Та энүүхнээс цааш яваагүй л байдаг. Ухаан санаанаас цааш бол тэр байтугай ямар нэг сэтгэлийн ханамж ч байдаггүй. Та юу ч мэдрэхгүй. Та сэтгэл ханамж гэгч ийм зүйл байдаг гэдгийг огт мэдэхгүй болтлоо сэтгэл тань төгс төгөлдөр ханана.

Зөвхөн бодож сэтгэж, эсвэл хооронд нь харьцуулах үедээ л та тийм, үгүй, сайн, муу гэх хоёрдмол ертөнцөд оршиж, улмаар та сэтгэл ханасан, эсвэл сэтгэл ханаагүй байгаага мэддэг. Та сэтгэл ханамжтай нэгдмэл байх үедээ та сэтгэл ханасан байна гэдгээ мэднэ гэж үү? Үгүй, нүд өөрөө өөрийгөө харж чадахгүй. Нар өөрийгөө халуун, эсвэл хурц тод байна гэдгээ мэдэж чадахгүй шүү дээ. Энэ нь нарны шинж чанар. Тэгэхлээр, Үнэмлэхүй бол Үнэмлэхүй л юм. (Алга ташив)

Үнэмлэхүй гэдэг нь жишиж харьцуулахгүй гэсэн үг. Та нар Үнэмлэхүй бол сайн, эсвэл Үнэмлэхүй бол төгс дээд гэж ч хэлж ч чадахгүй. Та Үнэмлэхүй гэж хэлэхэд л аль хэдийн харьцангуй болчихож байна. Аль хэдийн харьцуулалт хийчихсэн байна. Гэвч бид хүний хэлээр харилцахдаа үргэлж л дэл сул, дэмий зүйл ярьдаг учраас бүх зүйлийн талаар ямар нэг зүйл үргэлж чалчих хэрэгтэй болоод байдаг. Бид бүх зүйлийг харьцуулах, үнэлэмж өгөх, адилтгах, нэр өгөх хэрэгтэй болдог. Харин Үнэмлэхүй чинь жинхэнэ Үнэмлэхүй мөн л бол та түүний тухай ам нээх ч боломжгүй. Энэ тухай бүү ярь. Тэр байтугай түүний тухай бүр бодож ч чадахгүй. Төсөөлөх ч боломжгүй. Юу ч байхгүй.

Энэ бол миний өөрийн туршлага. Тэгэхлээр, намайг амьд сэрүүн Будда (бүрэн ухамсарласан оршихуй) хэмээн хэлэхэд би яагаад бахархаж бардамнадаггүйг та нар одоо ойлголоо. Намайг Төгс Гэгээрсэн Их Багш гэдэг нэр алдрыг хүлээн авах үед хүмүүс намайг амиа хичээгч, эсвэл дүүрэн Би гэх үзэлтэй гэж хэлэх эсэхийг би ойшоогоогүй. Надад энэ бүхэн ёстой юу ч биш. Би энэ бүхнээс хэтийдсэн. (Алга ташив) Энэ бүх нэр алдар бол ердөө л хог новш. Гэтэл энэ дэлхийд бидэнд өөр илүү дээр зүйл байхгүй учраас бид үүнийг хүлээн зөвшөөрдөг. Бид үүнийг хүлээн зөвшөөрөх эсэх нь ямар ч ач холбогдолгүй. Нар өөрийг нь магтах, эсвэл буруушаахын алийг нь ч огт тоохгүй. Нар өөрийгөө аугаа

их, эсвэл эрхэмсэг тансаг гэж сайрхан бардамнадаг ч үгүй. Зүгээр л ийм л байж байдаг. Тийм биз дээ? (Сонсогчид: Тийм.) Тиймээс бид нарыг магтсан ч, буруутгасан ч тэр байрнаасаа ямх ч хөдлөхгүй. Асуух зүйл байхгүй. Нар илүү хурц, эсвэл арай бага гэрэлтэж туяарна гэж байхгүй. Та буруушаал, магтаалаараа наранд нөлөөлж чадахгүй.

Яг үүн шиг та бид Их Багшийг шүүн хэлэлцэж, эсвэл Их Багшийг магтан сайшаах боломжгүй. Бид өөр өөрийнхөө ондоо ондоо төвшинд зөвхөн өөрийнхөөрөө л танин ухаарах л боломжтой, ингээд аажимдаа Би хийгээд Их Багш нэгдмэл юм байна гэдгийг ухаарна. Би болон Их Багш хоёр ялгаагүй юм байна гэдгээ ойлгоно. Бид чинь нэг ижил эх сурвалжаас ирсэн, нэг ижил эх сурвалж дотор байж байдаг. Бидэнд нэг ижил эрдэнэс бий. Зүгээр л одоохондоо эрдэнэсээ ашиглах бидний чадвар ялгаатай байгаа юм. Түүнийг хэрхэн илүү сайн ашиглах вэ гэдгийг бид хожим мэдэх байх.

Үүнийг нэгэн чинээлэг гэр бүлд төрсөн хүүхэдтэй зүйрлэж үзье. Тэр бусад ах, эгчтэйгээ адил эрхтэй, адил өв хөрөнгө залгамжилж авсан. Гэвч одоохондоо дэндүү балчир байна. Тэр мэдэхгүй байгаа. Нэг л гэр бүлтэй, нэг ижил эрхтэй, нэг ижил эрдэнэстэй боловч том болсон ах, эгч нар нь илүү сайн мэднэ - том болсон нь илүү сайн мэддэг, түүнийг хэрхэн илүү сайн ашиглахаа мэднэ. Ердөө л энэ. Тийм биз. (Сонсогчид: Тийм.) Энэ бол хоёр хүүхдийн хоорондох ялгаа л юм, өөр зүйлгүй.

Тэгэхлээр, би мэдэж байгаа, харин та хараахан мэдээгүй байгаа л хэрэг. Та мэддэг хэр нь мэдэхгүй байгаа гэж боддог ч байж магадгүй. Эсвэл дэндүү даруугаасаа болоод өөрийгөө аугаа гэж хүлээн зөвшөөрөхгүй байгаад байдаг. За хамаагүй. Та хүссэн бүхнээ л хий. Та түүнийг хүлээн зөвшөөрнө үү, үгүй юу, ашиглана уу, үгүй юу, эрдэнэсээрээ бахархах уу, эсвэл тоохгүй байх уу, энэ бол таны эрх.

Тийм учраас л би эргэн тойрон явж, хүмүүст ном тавьж, эсвэл бүх дэлхийг энэ “ажил хэрэг”-т татан оруулах гэж хэзээ ч яаравчилдаггүй. Учир нь энэ бүхэн тэдний эрх. Хэрвээ тэдэнд үүнийг эрж хайх тэмүүлэл байгаа л бол хайх арга замаа өөрсдөө олчихно. Тэд ингэхийн төлөө хамаг чадлаараа хичээнэ. Хэрвээ тэдэнд энэ юу ч биш санагдаж байгаа бол яая гэхэв. Энэ нь өөрсдийнх нь л эрдэнэс шүү дээ. Ойлгов уу? (Сонсогчид: Ойлоголоо.) Ямар ч тохиолдолд бүх зүйл зүгээр.

Тиймээс заримдаа та нар, зарим нэг чинь ирээд надтай ярилцахдаа “Тантай харьцуулахад бид тун ч доогуур байна даа” гэдэг.

Би тэдэнд “Энэ бол ердөө л чиний мэдрэмж” гэж л хэлдэг. Та өөрийгөө хуурч байна. Гэхдээ одоохондоо танд энэ хууран мэхлэх тоглоом чинь зугаатай байгаа бол би танд юу ч хэлэх билээ дээ. Харин үнэхээр л өөрийнхөө аугаа чанар, билиг ухаанаа мэдэхийг хүсэж байгаа бол дотоод талаа чагна. Зөн билгээ чагна. Хэрэгтэй цагт юу хийх ёстойгоо чагна. Өөрийн урьдаас тогтсон үзэл, эсвэл нийгмийн ёс заншил, санал

бодолд бүү хуурт, бүү булингарт. Доторхоо чагна. Үргэлж дотооддоо байж, тэгээд юу болж байгааг, юу хийх ёстойгоо мэдэж авахыг хичээ.

Яагаад гэвэл та мэдэж байгаа атлаа юмыг урвуугаар нь хийчих нь олон тохиолддог. Тэгчихээд л “Ээ, ингэхих минь яав даа!” гэдэг. Тийм биз? (Сонсогчид: Тийм шүү.) Та бодит байдлаас, дотоодынхоо Үнэнээс, юу хийхийг чинь хэлж өгдөг чимээгүй Дуу хоолойноос жаахан хөндийрчих үед ийм зүйл л болдог.

Тиймээс та чимээ аниргүй байх тусмаа, улам дотогшоо хандах тусмаа улам их цэцэн мэргэн болдог, учир нь та юу хийхээ мэдчихдэг. Харин үүнийг мэдэхгүй байгаа бол та болхи толхи байна. Та эцсийн эцэст үүнийг тэртээ тэргүй хийх л болно, гэхдээ амжилттай хийж чадахгүй. Ингээд л та хойд төрөл авч, үүнийг дахин хийх хэрэгтэй болно. Өөрийгөө ойлгох болон ойлгохгүй байх хоёрын ялгаа энэ л юм. Тийм учраас л бид хойд төрөл авдаг. Тийм учраас л бид ахин дахин төрөх хэрэгтэй болдог. Учир нь бид юу хийх ёстойгоо сонсоогүй, бас суралцахаар, эсвэл хийхээр ирсэн ажил үүргээ биелүүлээгүй байж байдаг. Тэгэхлээр дахин төрөл авах гэдэг нь эндээс л үүсдэг. Сүнс ч бас суралцахын тулд үүнтэй хамт хойд төрөл авах хэрэгтэй болдог.

Та нар бүгдийг ойлгосон байх гэж би бодож байна. Эсвэл би бүгдийг ойлгосон ч юм уу. Та нартай ярьж байхдаа би нэн цэцэн цэлмэг байдаг. Ойлгосон уу? (Сонсогчид: Тийм.) Үүнд маргах зүйл ёстой юу ч байхгүй.

Гэхдээ энэ аяндаа л ирдэг, яагаад гэвэл энэ нь таны ойлголтын төвшинд таарч тохирч ирдэг. Заримдаа би чадна; би та нарт ийм байдлаар ярьж чадна, энэ нь маш тодорхой. Өөр үед би чадахгүй, яагаад гэвэл тухайн мөчид та үүнийг хүлээн авч чадахааргүй байдаг. Тийм учраас та бас миний урсгалд хаалт тавьчихдаг. Тиймээс би ч бас та нарт ярих хүсэлгүй болчихдог. Тэр мөчид би энэ мэтээр ярьж чадахгүй гэж байгаа юм биш. Та өсөж том болсон хүүхдэдээ элдэв гоёлын чимэг зүүлт, амттай сайхан хоол өгдөг, харин хар нялхаараа бол сүү л өгдөгтэй энэ төстэй.

Тийм учраас та даяан бясалгалд, эсвэл надтай уулзахаар ирсэн бол зөвхөн суухаасаа гадна, бас жигнэмэг, амттан, чихэр, үзэм, үлгэр түүх, дуу хуур, гээд элдэв төрлийн тав тух, амттанаар хангагддаг. Хүүхдүүд ээжтэйгээ уулзахаар ирсэн үедээ бие биеэ хайрлахын дашрамд ээжээсээ бас гоё сайхан юм хүртдэг шиг л юм. Ийм зүйл дашрамд нь л болж байдаг, харин ийм зүйл байх үгүй нь хамаагүй, гэд бие биеэ хайрласан хэвээр л байдаг. Энэ бол үнэн. Ойлгож байна уу? (Сонсогчид: Тийм.) Ийм л юм.

Тэгэхлээр, ахуй ойлголт хүртсэн ч, үгүй ч энэ хэд хоногийн турш та баяр хөөртэй байсан; та бүхэн Нирваанд байлаа, энэ чинь л зорилго нь. Хэрвээ та энэ дурсамжаа амьдралынхаа сүүлийн мөч хүртэл

ямагт тээж явах аваас та ямагт Нирваанд, эсвэл ядаж л үхэх мөчдөө Нирваанд байх болно. Бидний сүүлчийн мөчийн бодол ямар байх нь нэн чухал. Хэрвээ та зовлон шаналлын тухай л бодож байвал та там руу явна. (Инээлдэв.) Хэрвээ та Их Багшийгаа, Их Багштай хамт байсан мөчийнхөө аз жаргал, баяр цэнгэлийг л бодож байвал Та тэр даруйдаа Нирваанд очсон байх болно. Тэгэхээр нууц нь энэ л юм, ойлгов уу? (Сонсогчид: Тийм.) Гаднаа, эсвэл дотооддоо, бие махбодоороо, эсвэл сэтгэл санаагаараа аль нь ч бай, Их Багштайгаа хамт байхын давуу тал нь энэ юм.

Тиймээс, цаг үргэлж Их Багшийгаа өөртөө тээж яваарай, өөртөө даяан бясалгалаа ямагт тээж яваарай, ингэвэл та ямар ч асуудалд орохгүй. Та бүхнээс дээш гарч, тэр цагт бүх асуудал бэрхшээл танд шалихгүй зүйл гэж санагдана. Бүх асуудал бэрхшээлийг давсныхаа дараа тэдгээрийг яг л тоглоом шиг харна. Та бүхнээс дээгүүр ниснэ. Та энэ аз жаргалаа санан дурссаар байгаа учраас амьдралын бүх сорилт шалгуурыг ажрахгүй давна. Энэ нь магадгүй маш урт хугацаанд, үүрд үргэлжилнэ.

## ЛУУЗ, ЖУАНЗ БОЛОН ТЭНГЭРИЙН ХӨГЖИМ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1993 оны 2 дугаар сарын 28 (Дүрс бичлэг 320)  
Сан Йен Сен Хүндэтгэлийн танхим, Тайбэй хот  
(Эх нь Хятад хэлээр)*

Хүн бүрт хязгааргүй адислал бий. Хэрвээ та намайг хязгааргүй адислалтай гэж хэлж байгаа бол танд ч бас адилхан байгаа л гэсэн үг. Та түүнийгээ ашиглахаа л мартчихсан хэрэг, тийм учраас л Их Багш болон шавь гэж байгаа юм. Бусдаараа бол та бид эн тэнцүү – ялгаа байхгүй. Тийм учраас л бид бясалгах, бас дадуулах хэрэгтэй байдаг. Бясалгах олон арга бий. Бид чухам яагаад Гуан Инь (монголоор: Арьяабалын арга) аргыг санал болгож байна вэ? Яагаад гэвэл бүр эрт дээр үеэс улбаатай, биднийг хамгийн дээд төвшинд хүргэж чадах, бас бидний хамгийн аугаа Хүчийг ойлгуулж чадах цорын ганц энэ арга байсаар ирсэн. Бусад арга бол ердөө л тав тухын төлөө л байдаг юм гэж Шагжамуни Будда нэгэнтээ айлдсан нь тэр аргууд түр зуурын буюу байнгын бус гэсэн утгатай.

Сүүлийн хэд хоног би Жуанз, Күнз зэрэг Даогийн тухай зохиолуудыг уншиж байна. Би залуудаа энэ бүхнийг уншдаг л байсан, харин одоо өөр мэдрэмж төрж байна. Тэдгээрт бас л Дотоодын Гэрэл болон Аялгууг дурджээ. Урьд шөнөжингөө л ном уншлаа. Би мартчих вий гэж эмээж байсан юм. Би та нарт зах зухаас нь эш татан уншиж өгье. Та нар сонсмоор байна уу? (Алга ташив.)

Арьяабалын арга бол шинэ юм биш. Аль эртний цаг үеэс л Арьяабалын аргаар бясалгадаг Их Багш нар болон жирийн хүмүүс дэлхий даяар байсан. Бид Формоса хэмээх хятад газар байна, би эрт цагт зарим хятадын бясалгагч оршин амьдарч байсны баталгаа нотолгоог мэдүүлэх гэсэн л хэрэг.

Жишээлбэл, Жуанзын бичсэн номд Ниэ-гэй хэмээх хүн “Дао гэж юу вэ?” гэж Пэй-и хэмээх нэртэй нэгнээс асуусан тухай өгүүлжээ.

Пэй-и: “Та биеэ үнэхээр зөв байрлалаар суулгаад сэтгэл оюунаа “нэгдмэл” дээр буюу диваажин, эсвэл Дао дээр төвлөрүүлэх аваас өөр дээр чинь диваажингаас амар амгалан бууж ирнэ. Тэр үест та Дао-тай нэгдмэл болохын тулд төвлөрлөө сарниулахгүй барих ёстой, тэгвэл

Бурхан таны дотор байх болно. Бурхан таны дотор амьдарч буйг, бас та өөрөө Дао дотор буйгаа мэдэх болно. Энэ нь бид Дао-тай нэгдмэл болсон гэсэн үг. Та энэ дэс төвшинд хүрэхээр таны дотоодод жаргал цэнгэл бялхаж, нэн аз жаргалтай болно. Та яг л дөнгөж төрчихсөн, юу ч нэхэж шаардалгүй, ойр хавиа сонжин харж байгаа гэм хоргүй бяцхан тугал шиг л байх болно” гэж хэлжээ. Үүгээрээ бидэнд бясалгалын тухай хэлж өгч байна. Бид ч бас авшиг хүртээх үедээ ингэж бясалгахыг хүмүүст заадаг.

Гэхдээ ном унших нь таныг гэгээрүүлж чадахгүй, яагаад гэвэл үүнд гэгээрлийг уламжлах жүд дамжлагынх нь хүч байхгүй. Та нар бүгд мэдэж байгаа. Эхийн хайрын тухай ном ээжийнхээ хайрыг үгүйлж буй балчир хүүхдийн сэтгэлийг хангаж чадахгүй, яагаад гэвэл номоос ээжийн хайрыг хүртэх боломжгүй. Тэрхүү шүүрээд авчих, эсвэл номд бичих боломжгүй зүйлийг мэдрэхийн тулд биднийг хайрлах жинхэнэ бодит ээж, эсвэл ээжийг орлох нэгэн бидэнд хэрэгтэй. Та нар ойлгож байна уу? (Алга ташив.)

Жуанзын тухай яриагаа үргэлжлүүлэе. Жуанз: “Нэн хичээнгүйлэн бясалгаваас Бурхнаас буюу диваажингаас Гэрэл ирж үзэгдэнэ” гэжээ. Хэн нэгэнд энэ Гэрэл байгаа бол, та энэ Гэрлийг харах үе бол та дотоодын Би-гээ харж буй хэрэг юм. Жинхэнэ Мөн чанарыг дотооддоо төгөлдөржүүлж буй хэн ч хамгийн дээд Хүчийг олно. Хамгийн дээд дотоод Хүчийг олж авснаар хүмүүн чанарууд нь тэр хүнийг орхиж, харин Диваажингийн чанар түүн дээр бууж, түүнд хүмүүн чанаруудаа солиход нь тусална” гэжээ.

Жуанз нэгэнтээ Луузыг луу шиг гэж тодорхойлсныг би саналаа. Тэгсэн байх аа? Тэр: “Лууз тэнд үхдэл мэт хөдлөх ч үгүй, зүгээр л сууж байлаа, гэвч бидэнд Тэр яг л луу мэт санагдаж байв; тэгтэл диваажин болон амарлингуйн төвшинд аянга мэт нүсэр Аялгуу чимээ нижигнэж байлаа. Тэр Аялгууны чимээ диваажингаас, эсвэл газрын гүнээс, эсвэл аль алинаас нь хослон гарч буй мэт байлаа” гэжээ.

Арьяабалын аргаар бясалгадаг хүн бол Тэр юуны тухай яриад байгааг мэдэж байгаа. Тийм биз? (Шавь нар: Тийм.) Энэ нь дотоодын Гэрэл, диваажингийн Аялгууг хэлж байгаа юм. Жуанз бас диваажингийн хөгжмийн тухай ярьжээ. Хэрвээ бид Арьяабалын аргаар бясалгадаггүй бол бидэнд тийм хувийн туршлага байхгүй учраас Тэр чухам ямар утга санаатай юм ярьсныг ойлгоход бэрх байсан биз.

Юуг “Диваажингийн Хөгжим” гэж нэрлэж байна вэ? Арьяабалын аргаар бясалгагч нарт ямар нэг ном унших хэрэг байдаггүй, бид өөрийн биеэрээ Диваажингийн Хөгжмийг сонсож, тэр нь диваажингийн Гэрэл шиг үнэхээр байдаг юм байна гэдгийг мэдэж авдаг. Диваажинд бол бид түүнийг үзэх гэж тэр дээшээ гарах гэхийн хэрэг байхгүй. Харин бид бясалгаж байх үедээ түүнийг хаа сайгүй харж болно, учир нь бид

уг сурвалжаараа бол бүх бүтээлтэй нэгдмэл нэг, Дао-тай нэгдмэл нэг билээ. Хэрвээ бид дотоодын Аялгууг өөрөө биечлэн сонсохгүй, дотоод Гэрлийг хардаггүй бол бид үнэхээр Дао-тай нэгдмэл гэдгээ ойлгож мэдэхгүй.

Нэгэн хүн Цу-чи-гээс “Диваажингийн Хөгжим гэж юу юм бэ?” гэж асуусан тухай нэгэн бүлэгт нь байна.

Тэр: “Тэнд ямар ч бодитой хөгжмийн зэмсэг ашигладаггүй хэр нь Диваажингийн Хөгжмийг арван мянган хөгжмийн зэмсгээр тоглож, арван мянган зүгээс ирж сонсогдох мэт байдаг” гэж хариулжээ.

Энэ тайлбарыг сонсоод бид эргэлзэж тэвдэж магадгүй. Бид ямар ч зэмсэггүйгээр яаж хөгжим тоглох юм бэ гэж. Хэрвээ бид Арьяабалын аргыг бясалган дадуулах аваас эргэлзэж тэвдэхгүй, бас хэн ч, ямар ч хөгжмийн зэмсэгээр тоглоогүй ч тэнгэрийн Хөгжмийг байнга сонсоно.

Тэрээр диваажингийн Хөгжмийн тухай дурдсан өөр олон хэсэг байна. Та гэртээ хариад тэр тухай уншаарай. Эртний сүнслэг бясалгагчдын үлдээсэн тэмдэглэлүүд байдгийг та нарыг мэдэж аваг гэж л би үүнийг дурдаж байгаа юм.

Жуанзтай нэгэн цаг үед амьдарч байсан Ли Зы гэж хүний тухай жишээ байна. Тэрбээр Жуанзтай ижил дэс төвшинд гэгээрсэн бас нэгэн Их Багш байж магадгүй. Тэр: “Есөн жил бясалгал дадуулсны эцэст бие махбод болон сүнс маань бүрэн чөлөөтэй болжээ. Хэрвээ надад хэлэх үг байсан бол би ямар ч саадгүй чөлөөтэй хэлэх байсан. Юу сайн, юу нь муу, амжилт гэж юу юм, эсвэл бүтэлгүйтэл гэж юу юм, минийх, эсвэл түүнийх гэж юу юм гэдгийг би мэдэхгүй” гэж хэлжээ.

Түүнд ямар ч алагчлах үзэл байхгүй гэсэн утгаар хэлсэн байна. Тэр аль хэдийн гэтлэхүйн дэс төвшинд хүрчихсэн аж. Тэр мөн дотооддоо болон гаднаа өөрчлөгдөж, урьдынхтай адилгүй болсноо хэлжээ. Нүд нь чих болж, бас юмыг сонсож чаддаг, аялгууг сонсож чаддаг болсон нь хачирхалтай. Чих нь хамар нь болчихжээ. Чих нь үнэрлэж чадна. Хамар нь ам шиг нь болжээ. Түүний эдгээр чадварт ялгаа байхгүй болжээ. Яс, булчин минь оргүй алга болчихсон гэж тэр хэлжээ, өөрөөр хэлбэл бие нь цаашид оршин байхгүй болсныг тэр мэдэрчээ. Тэр бас яаж нэг юм яваад байгаагаа, юугаар яваад байгаагаа; салхи өөрийг нь хийсгээд байгаа юмуу, үгүй бол өөрөө салхинд хийсгээд ч байгаа юмуу гэдгээ мэдэхгүй байсан гэж хэлжээ.

Тэр ямар төлөв байдал байгаа нь энэ вэ? Арьяабалын бясалгагч нарт ийм зүйл олон тохиолддог, энэ үед бид бие махбодынхоо оршиж байгааг мэдэрдэггүй. Бид илүү сайн бясалгах тусмаа ийм зүйлтэй байн байн тохиолдоно. Тэр байтугай хэрэв бид сайтар бясалгаж хараахан амжаагүй байсан ч ийм зүйлтэй авшиг хүртэх үедээ учирдаг. Хүн болгон өөр өөр ухамсартай байдаг, гэхдээ зарим нь Ли Зы-гийн дүрсэлсэн шиг ойлголт туршлагыг мэдэрдэг.

Тийм учраас хэрвээ бид бясалгадаггүй, дадуулдаггүй, өөрийн мэдэрсэн туршлагагүй бол энэ номууд бидэнд харь элгийн байх болно. Тийм биз? Энэ номууд Хятад хэлээр байгаа, бас бид Хятад хүмүүс, бүр багаасаа, коллежид байхаасаа эдгээрийг сурч судалсан ч одоо хүртэл жинхэнэ утгыг нь ойлгоогүй л байгаад байна. Ташаа ойлгосон олон хүн байдаг. Тэд тэнд хаанаасаа дотоодын Хөгжим, Гэрэл, бас диваажингийн Хөгжим гэх мэт зүйл байж болох билээ гэж эргэлздэг. Тэд үүнийг гаднах хөгжим мэтээр ойлгодог байж магадгүй, тийм бол тэд түүнийгээ сонсохоор караоке мэтийг зорих байх. Гэхдээ гаднах хөгжимд ч бас сайн тал гэж бий. Би өөрөө ч бас хааяа төгөлдөр хуур, босоо ятга тоглох дуртай. Би бас үүнээс таагай сайхныг мэдэрдэг. Хэрвээ ажил дээрээ ядарч туйлдсан, эсвэл дэндүү ачаалал дарамттай байгаа бол төгөлдөр хуур тоглодог, тэгмэгц сэтгэл санаа хавьгүй дээрдэг. Мэдээж үүнийг дотоодын Хөгжимтэй харьцуулшгүй, гэхдээ бидэнд дотоодын диваажин маань байгаа юм чинь гээд гаднах хорвоо дэлхийг хаяж орхичих хэрэггүй. Бид урьдынхаараа эгэл жирийн амьдралаар амьдарсаар л байна. Ингээд та нар Арьяабалын аргыг бүр эрт дээр үеэс бясалгаж иржээ гэдэгт одоо итгэв үү? За яахав, хэрэв нэг л итгэж чадахгүй санагдаж байвал би өөр нэгийг уншиж өгье.

Цэ-квэй хэмээх нэгэн эр Ну-юй хэмээх хүнээс ингэж асуужээ: “Та их урт насалжээ. Яагаад арьс тань хүүхдийнх мэт тун сайхан байна вэ? Яагаад ийм байгаа юм бол?” гэжээ.

Ну-юй хариуд нь: “Би Дао-д хүрсэн учраас тэр” гэжээ.

Тэр тун бардам ихэрхүү ч юм шиг аж. Дао-д хүрсэн хүн ийм байдлаар ярих уу? (Сонсогчид: Үгүй.) Үгүй ээ? Танаас Дао-д хүрсэн эсэхийг асуувал та юу гэхсэн бол? Хүн танаас ингэж асуувал үнэнээ л өчих ёстой. Асуухгүй бол та юу ч хэлэх хэрэггүй. Хэрэв нэгэнт асуусан бол хариулахгүй байх нь эелдэг бус явдал болно. Тийм биз? Хэрэв хэн нэг хүн асуухад нь та “үгүй” гэвэл худлаа хэлсэн болчихно. Зүгээр л ердийнхөөрөө шуудхан л хариул. Бид ихэрхэж бардамнадаггүй. Бид ердөө л үнэнээ л хэлдэг, Үнэнээс өөр юу ч хэлдэггүй.

За тэгэхлээр, Ну-юй өөрийгөө Дао-д хүрсэн гэж хэлсэн байна. Энгийн бөгөөд шулуухан хариулт өгчээ. Ингээд тэр Цэ-квэйд цааш нь: “Пу Лян И гэдэг хүн байжээ. Тэр үнэхээр гоц ухаантан байв. Гэвч тэр Дао-д хүрээгүй учраас төгс төгөлдөрт хүрч чадаагүй, яалаа ч төгс хүн болж чадахгүй байжээ. Би түүнд нэг арга зааж өгсөн юм. Энэ аргын ачаар тэр төгс хүн болж чадсан. Би түүнд зааж өгснөөс хойш гурван өдрийн дараа тэр энэ хорвоог огоороход бэлэн болжээ. Ахиад долоо хоног өнгөрөхөд тэр гаднах хорвоод сатаарахгүй болсон байв. Гаднах бүх санаа зовнил, хөндлөнгийн оролцооноос тэр хэтийдэн давжээ. Ахиад ес хоноход тэр өөрийнхөө оршин тогтнолыг мэдрэхгүй болсон байв. Тэр мөчдөө тэр нарны дэс төвшинг харсан байна” гэж тайлбарлаж

өгчээ. Ойлгож байна уу, тэр нарыг харжээ.

Арьяабалын бясалгагч шавь нар минь, та бүхэн нарны дэсийг мэдэх үү? (Шавь нар: Тийм ээ, бид мэднэ.) Хаана билээ, мэдэж байна уу? (Шавь нар: Бид үүнийг дотооддоо хардаг.) Та дотооддоо хардаг! Энэ зөв! Зөв! Хэрвээ та түүнийг хардаг бол та “Цан Гун Ан” хэмээхийг (Зэнгийн асуултыг бясалгах) хийх шаардлага байхгүй.

“Тэрээр нарны дэсэд хүрснийхээ дараа үргэлжлүүлэн бясалгасаар, улмаар хамаг орчлонтой нэгдэх төвшинд очсон байна. Тэгснээр өнгөрсөн, одоо, ирээдүй гэх ялгаа байхгүй болов. Дараа нь тэр үхэхгүй, төрөхгүй дэсэд хүрчээ. Тэр мөчид тэрбээр энэ бие махбод үнэндээ үхдэг юм биш, бидний амьдрал үнэн хэрэгтээ замхран арилдаг юм биш гэдгийг ухаарчээ. Түүнчлэн хүн болж төрсөн үедээ жинхэнэ ёсоор амьдардаг юм биш байна гэж ухаарчээ. Өөрөөр хэлбэл амьдрах нь үнэхээр амьдарч буй хэрэг биш, үхэх нь үнэхээр үхэж буй хэрэг биш гэсэн үг. Энэ мөчөөсөө тэр бүх зүйлд эгэл жирийнээр хандах болжээ. Өөрт нь зориулж Бурханаас бэлтгэж зохицуулсан бүхнийг тэр жам ёсны дагуу хүлээн авчээ. Бүх бүтээлд төгсгөл ирнэ, тэгснээр л шинэ нь төрж чаддаг аж. Энэ нь эмх замбараагүйн дунд амарлингуй амьдарна гэсэн үг. Хорвоогийн үймээн самуун дунд амар амгалан амьдарч байвал бид Дао-д хүрсэн хэрэг юм” гэжээ.

Түүний хэлж байгаа нь хорвоо дэлхий санагдаж байгаа шигээ эмх замбараагүй биш, дэлхий дээрх зовлон зүдүүр, сүйрэл мөхөл нь санагдаж байгаа шигээ бодитой биш гэсэн санаа юм.

Би юм ярихдаа ер нь ноорог бичдэггүй л дээ, гэтэл урьд шөнө ер унтаж чадсангүй, танайхны зарим номыг уншиж судалсан юм. Хятад хүмүүс та нар ном унших дуртай, бас намайг гадаад хүн ярьж байна гээд итгэхгүй байх вий гэж би эмээсэн. Тиймээс би эртний хятад хүмүүсийн номоос хэдийг зээлдэхэд хүрсэн хэрэг. Арьяабалын аргаар бясалгадаг өөр хүмүүс бас байжээ гэдэгт та нар одоо итгэв үү? (Сонсогчид: Тийм.) Сайн байна, та нар ядаж л бясалгах, дадуулахын сайн талд итгэж байна. Танай Жуанз, Лууз нар бүгд энэ аргыг бясалгасан.

За боллоо, бид гэхдээ бясалгал дадуулж байсан эртний Зэн Их Багш нарын тухай ярилцаагүй байгаа. Бясалгал гэж юу вэ? Өчигдөр би асуулт тавсан та нарын заримын чинь хэлбэлзлийг хүлээж авсан юм шиг байна, тиймээс маш их зүйл бичсэн. Бясалгал гэхдээ бид ямар санааг хэлж байна вэ? Энэ нь зүгээр л нэг тэнд сууж байх тухай юм биш. Бид дотоод билиг ухаанаа нээх аргыг мэдэх ёстой. Ер нь бол жирийн хүмүүс бид бүгд л хэрхэн бясалгахыг мэдэж байдаг. Танд бясалгачихсан юм шиг санагддаггүй гэж үү? Тийм биз? (Сонсогчид: Тийм.) Бид өдөр бүр бясалгадаг! Бясалгал гэдэг нь зүгээр л нэг сууж байх төдийг хэлдэггүй, энэ бол бид бодол санаагаа ямар нэг зүйл дээр, эсвэл ямар нэг шийдэх асуудал дээрээ төвлөрүүлэхийг хэлнэ.

Зарим хүн хамаг анхаарлаа нэг цэг дээр төвлөрүүлж, үүнийхээ тусыг хүргэхийн тулд “Зэнгийн асуултыг бясалгах” дадлага хийдэг нь ийм учиртай. Та бясалгах үедээ - би үүнийг бясалгах гэж хэлмээргүй байна, харин “судлан шинжлэх”, ямар нэг зүйлийг сурч судлах гэж хэлмээр байна. Бид судалж байгаа үедээ анхаарлаа тэр зүйлдээ төвлөрүүлдэг. Бид өдөр тутын амьдралд асуудал бэрхшээл тулгарвал түүнийгээ шийдэхийн тулд хамаг анхаарлаа энэ асуудал дээрээ төвлөрүүлдэг. Тэр үеийг бид бясалгал гэж бас нэрлэж болно. Бид ямар нэг зүйлийг гүн гүнзгий судлан шинжилж байхдаа гэнэт шийдлийг нь олдог.

Тийм учраас бид өөр бусад олон асуудлыг ар араас нь шийдэхийн тулд эрэл хайгуулаа цааш нь үргэлжлүүлсээр байдаг. Өч төчнөөн асуудлыг судалж шинжлэх гэж элдэв янзын арга хэрэглэсээр нэгэн насаа элээхийн наагуур байдаг. Бид үүнийг ч бас бясалгал гэж нэрлэж болно. Бид нэг л цэг дээр бясалгаж байхдаа нэг нэгээр нь дараалуулан бясалгадаг. Бид гол цэг нь аль билээ гэдгийг эргэцүүлэн бодохгүй байна. Хэрэв бид төв цэг дээрээ бясалгавал олон цэгийг хяналтандаа байлгаж чадна. Цэг тус бүрийг тус тусад нь авч үзэх шаардлага байхгүй.

Хорвоогийн ихэнх хүн нэг удаадаа зөвхөн нэг л зүйлийг, эсвэл нэг л асуудлыг судлах юмуу бясалгадаг. Тиймээс ч тэдний амжилт нэг л зүйлээр, эсвэл нэг л асуудлыг шийдвэрлэх төдийхнөөр хязгаарлагддаг. Одоо харин бид бүх анхаарлаа өөрийн билиг ухааны төв дээр төвлөрүүлбэл бүх асуултынхаа хариултыг амархан авчир боломжтой. Бүх асуудал бэрхшээлийн шийдэл нь өөрөө хүрээд ирдэг. Үүнээс өмнө нь бид анхаарлаа зөвхөн нэг л асуудал бэрхшээл дээр л төвлөрүүлдэг байсан. Тиймээс бид нэг л асуудалд шийдэл олдог, эсвэл буруу цэгээ зассан учраас хариулт, шийдэл огт олохгүй байж ч магадгүй. Бид ургамал услах бол үндсийг нь усалдаг, ингэж үндэс нь услагдчихаар мод нь ургаж томордог. Үндэс нь усыг аяндаа шингээж, улмаар навч мөчрүүддээ тараадаг. Харин навч бүрийг нэг нэгээр нь усалбал ашигтай юу? (Сонсогчид: Үгүй.) За тийм, тийм. Та нар одоо ойлгожээ.

Яг үүнчлэн, бид яагаад бясалгал дадуулах ёстой вэ? Учир нь бид арван зүгээс ирсэн хорвоогийн асуудал бэрхшээлээ шийдвэрлэхдээ уг үндэснээс нь эхлэх ёстой юм. Бидний бие махбод, эсвэл аж амьдрал маань мод шиг л юм. Модны үндсийг нь усалбал мод бүхэлдээ эрүүл байх болно. Нэг мөчир, нэг навч гэх байдлаар услах хэрэггүй, энэ чинь сайн үр дүн авчрахгүй, цагийн гарз.

Эрт дээр үеэс л энэ дэлхийн хүмүүс өдөрт арваас хорин цаг ажиллаж, маш завгүй байсаар ирсэн гэдгийг та бүгд мэднэ, заримдаа нойр хоолоо ч умаргддаг. Гэтэл манай энэ дэлхий бас яг ийм байна. За яахав, шинжлэх ухаан, технологийн хувьд өмнөхөөсөө дээрджээ, гэтэл зарим салбар нь тийм ч сайн биш байна. Нэг тал нь сайн байхад

нөгөө нь муу байна. Техник технологи хөгжин дэвшсэн ч ёс суртахуун дутагдаж байна. Ёс суртахууны тал нь болж байгаа юм шиг байлаа ч бүр ухарчихжээ. Нэг улс орон сайн байхад нөгөө нь сайнгүй байна. Энэ улс амар амгалан байхад өөр нэг нь дайтаж байлдаж байна.

Дэлхий маань бидний сэтгэлд нийцэх хэм хэмжээнд очоогүй байна. Бүр амар амгалан болчихоогүй байна. Энэ дэлхий зол жаргалгүй хүмүүс, хулгай дээрэм, хүчирхийлэл болон аз жаргалгүй, зовуурь шаналалтай зүйлээр дүүрсэн байна. Үүний учир нь ихэнх хүн үндсийг нь биш, харин навчийг нь усалж байгаагаас тэр. Бид бясалгал дадуулах хэрэгтэй учир нь энэ юм.

Хүн нэг бүрийн дотоодод билиг ухааны төв бий. Яг тэндээс бид энэ дэлхийг хянан удирдах, амьдралаа хянах, эргэн тойрны асуудал бэрхшээлээ зохицуулах ямар ч тушаалыг илгээх боломжтой. Тэр төв хаана байдгийг олж мэдээд түүн дээр анхаарлаа төвлөрүүлбэл бид төв станцаас харж байгаа юм шиг л аль ч газрыг нэвт харж чадна. Байшин доторх ерөнхий төв унтраалга шиг л юм; хэрвээ түүнийг асаавал байшин бүхэлдээ цахилгаанаар хангагдана. Хэрвээ төв унтраалгаа асаалгүй, бусад жижиг унтраалгаа нэг нэгээр асаавал энэ бас л ашигтай. Учир нь аль нэг өдөр энэ хоёрдугаар зэргийн жижиг унтраалга эвдэрвэл бид шинийг худалдаж авна, тэгэхлээр унтраалга үйлдвэрлэдэг үйлдвэр жаахан мөнгө олно. Ингэвэл л ашиг тустай, өөрөөр бол үгүй. Яг үүн шиг, бидний дотоодод “ерөнхий унтраалга” байдаг. Хэрвээ бид “ерөнхий унтраалгаа” асаачихвал бусад “унтраалгыг” удирдахад улам хялбар болно.

Нэг хүн надаас, хэрвээ бид өдөржин ингэж бясалгаж суувал, хорвоо дэлхийг хайхрахгүй болчих юм биш үү, тэгээд энэ нь хэвийн зүйл мөн үү гэж асуусан? (Сонсогчид: Үгүй.) Зүгээр, яагаад болохгүй гэж! Тийм! Шагжамуни Будда тэнд зүгээр л сууж байдаг байсан. Тэр ямар нэгэн зүйл хийсэн гэж үү? Тэр уг нь хаан болох ёстой байсан! Улс орноо тэр чигт нь эрхшээж байсан, гэтэл юуг ч хайхрахаа болиод Бодь модон доор удтал суусан. Та үүнийг зүгээр биш гэж хэлэх үү? Та Буддаг гүтгэж байна уу? Ха, ха! Яасан их зориг вэ! Тийм үү, үгүй юу? (Сонсогчид: Тийм.) Үгүй! (Их Багш болон бүгд инээлдэв) Үгүй. Түүн шиг тэгээд сууж байх нь зүгээр сайн биш. Тухайн үед гэгээрээгүй байсан тул Тэр тэгсэн байна. Бид тэнд өдөржин суугаад байх ёсгүй. Бид дундад зам мөрийг бясалгах нь илүү дээр, ойлгов уу? Тэгэхгүй бол бүгдээрээ хорвоог умарган ажил төрлөө хаяад Бодь модны дор суучихвал хорвоо дэлхий ч бас бүхэлдээ амар тайван болно, (Инээлдэв) өөрөөр хэлбэл эрт орой ч бүх хүн үхнэ - өлсөж үхнэ, шинээр нэг ч хүүхэд мэндлэхгүй, бид бүгд төгсгөж, амар жимэр болно. Тулалдаж зодолдох хэн ч байхгүй болно. Энэ бас болж л байна! Гэвч ийм арга зам эрхэм дээд зам биш гэж би хэлж байна.

Хорвоо дэлхий маань аль хэдийнээ оршиж байна, бас хөрст дэлхий маань үзэсгэлэнтэй, гайхалтай сайхан. Ийм баян тансаг ургамлын аймагтай гарагийг олоход хэдэн зуун сая галавын хугацаа шаардагдана. Өвс ургамал нь тасралтгүй ургаж байдаг, хүн төрөлхтөн амьдран суух боломжтой газар болсон байна. Ийм үзэсгэлэнтэй гараг болж бүрэлдэх нь асар урт удаан үйл явцын үр дүн билээ. Бид энд аль хэдийнээс суурьшин амьдарсаар ирсэн тул амиа егүүтгэх гэхийн хэрэг алга шүү дээ. Бид харин дэлхийгээ улам үзэсгэлэнтэй болгож болно. Бид ажил хөдөлмөр эрхэлж, бас бясалгал дадуулж болно.

Бид чухам яагаад бясалгах хэрэгтэй юм бэ? Учир нь хэрэв бясалгал хийхгүй, “үндсэн ерөнхий унтраалга”-аа олохгүй бол бид олон асуудлыг хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй, эсвэл дутуу хагас шийдвэрлэх болно.

Дэлхий маань одоо өмнөхөөсөө дээрдсэн. Энэ нь эрин цаг үе бүрт олон сүнслэг бясалгагч байсан учраас тэр. Хэрвээ бидэнд Хятад улсад жинхэнэ Их Багш байхгүй байлаа гэхэд Энэтхэг, Герман, Грек зэрэг оронд жинхэнэ Их Багш байж л байх байсан. Тэр үед дэлхийн өнцөг булан бүхэнд ямар нэг хэмжээгээр диваажингийн Гэрэл гэрэлтэх л байсан. Иймээс л манай дэлхийг пад харанхуй нөмөрчихөөгүй байна. Гэхдээ бас дэлхий маань ер нь төгс төгөлдөр болчихоогүй л байна. Энэ нь сүнслэг бясалгалыг хүн нэг бүр нь дор дороо дадуулахгүй байгаа учраас тэр юм. Бясалгалыг ердөө нэг хэсэг нь дадуулж, үлдсэн хэсэг нь тэгэхгүй байна. Бясалгал дадуулдаг хүмүүс бусдадаа маш их тус нэмэртэй байж чадна. Бясалгал дадуулдаггүй нь өөртөө ч тус нэмэр болж чаддаггүй! Тэгсэн атлаа бүр бусдыгаа үймүүлж, дэлхийд яршиг төвөг тарьдаг. Энэ хорвоо бол хуурмаг үзэгдэл гэдгийг бид мэддэг, гэхдээ хуурмаг үзэгдлээсээ сэрэхээсээ өмнө үүнийг ойлгож ухаарах л хэрэгтэй, тэгэхгүй бол бид маш их зовлон шаналалтай тулгарна гэж би боддог. Хэн нэг хүн биднийг бясалга гэж албадаж шахаад байгаа, эсвэл бид хэн нэгний төлөө бясалгаад байгаа ч юм биш.

Энэ дэлхийд авьяаслаг хүмүүс олон байгааг бүгд мэддэг. Янз бүрийн салбарт мэргэшсэн олон хүн байдаг ч заримдаа тэд амжилт олдоггүй. Тэгээд л заримдаа нисэх онгоц дэлбэрч, эсвэл галт тэрэг эвдэрч, машин нь муудах гэх мэтийн зүйл болж байгаа харагддаг. Яагаад гэвэл бид хичнээн сайн, суут ухаантай, авьяас чадвартай байгаагаас үл хамааран билиг ухааныхаа ердөө нэгэхэн хэсгийг нь л ашигладаг. Хэрвээ бид “төв өрөө”-нөөсөө билиг ухаанаа ашиглавал, билиг ухаанаа бүрэн өөрийн болгосон бол бидний хийсэн бүхэн сайн болох болно.

Надад өөрт минь энэ туршлага бий. Бага залуу байхад минь оюуны чадвар гээч юм нь их сайн байсан. Багш нар маань намайг оюуны чадвар сайтай, маш ухаалаг гэхийг сонсож л байлаа. Би сар бүхэн гэртээ нэг, хоёрдугаар байрын шагнал авчирдаг байлаа. Хэрвээ гутгаар

байрны шагнал авсан байвал намайг гутгаар шагналт нэгэн байх ёсгүй гэж үздэг аав маань хөмсөг зангидах байсан биз. Гэхдээ үүнээс болоод миний хийсэн юм бүхэн сайн байсан биш л дээ. Бага залуудаа оюуны чадамж сайтай гэгддэг байсан хэдий ч би юмыг тийм ч сайн хийдэггүй л байсан мэт санагддаг.

Арьяабалын аргаар бясалгах болсны дараа юу ч хийсэн маш сайн, хавьгүй дээр, ихээхэн ойлгоцтой, нэн сайн ойлголттой – илүү түргэн, маш шийдэмгий, бас юу хийх ёстойгоо үнэнхүү ойлгож хийдэг болсон байсан. Бүх зүйлийг нэн шаламгай, ухаалаг хийдэг болсон. Их Багшийн шавь нар ч мөн адил. Өндөр дэс төвшинд бясалгадаг хүн бол ямарваа ажлыг миний таашаалд илүү нийцэхүйцээр, олон нийтэд маш үр өгөөжтэйгээр хийнэ л дээ. Хэрвээ бясалгал сайн дадуулаагүй, оюун санааны дэс төвшин нь доогуур, энергийн хэлбэлзлийн хурд багатай хүн бол юмыг ихэнхдээ хор хохиролтой хийдэг. Тэр туслах чин сэтгэлтэй байсан ч олон нийтийн чухал ажил хэрэгт гарцаагүй хохирол учруулдаг, эсвэл Их Багшийн ажилд саад тотгор болдог.

Хэн нэг хүн ямар нэг ажлыг заримдаа сайн хийгээд заримдаа тааруухан хийчих нь бидэнд харагддаг даа. Энэ нь тэр хүн урд насандаа ямар нэг хугацаагаар бясалгаж байсан, эсвэл төгс төгөлдөр болтлоо бясалгаагүйгээс болж байгаа юм. Тиймээс л түүнд билиг ухаан нь байж байх үед юмыг сайн хийдэг. Харин хорвоо дэлхий рүү, эсвэл доод ертөнц рүү уначихсан үедээ юмыг сайн хийж чаддаггүй. Үүний учир нь тэр хүний билиг ухаан тогтворжоогүй, бас тэр өөрийн дотоодод байгаа “үндсэн унтраалга” бүрэн дүүрэн өөрийн болгоогүй байгаа хэрэг. Эсвэл, тэр заримдаа тохиолдлоор “үндсэн унтраалга”-таа хүрээд өөрийн мэдэлгүй асаачихдаг. Хожим нь тэр яаж асаахаа мэддэггүй. Тэгээд л тэр хүн заримдаа сайн, заримдаа тийм ч сайн биш байгаа юм.

Шавь нар маань ч бас үүнтэй адил байдаг. Надад ч ийм туршлага бий. Хэрэв тэр нэг хэсэг бясалгасны дараа зарим зүйлийг гэнэтхэн маш ойлгоц мэдрэмжтэй, сайн гэгч нь хийчихдэг, тэгэхээр нь та түүнд маш их итгээд өөр ажил даалгачихлаар тэр гэнэтхэн сайн хийхээ больчихдог. Түүнд билиг ухаан дутаад байгаа учраас л ингэдэг. Бид үүнийг түүний анхаарлын төвлөрөл нь тогтворжоогүйгээс заримдаа сайн, заримдаа сайнгүй байна гэж хэлдэг. Тиймээс бясалгагчид бид бясалгал дадуулахаа таслахгүй үргэлжлүүлсээр байх хэрэгтэй. Бид билиг ухаандаа бүрэн эзэн болох тэр үед л юмыг үргэлж сайн хийдэг болно - ямар ч асуудалгүйгээр өдөр бүр, бас цаг ямагт сайн хийнэ.

Тэгсэн ч гэсэн асуудал бэрхшээл байсаар л байдаг. Нэн сайн бясалган дадуулагч хүнд асуудал бэрхшээл тулгарах уу? Тэгэх үү? Алив хэл дээ! Тийм үү, үгүй юу? (Сонсогчид: Тийм) Яагаад тийм гэж? Хэл дээ? (Нэгэн хүний хариулт: Бусад хүний нөлөөгөөр.) Зөв! Иймээс л, Шагжамуни Буддаг амьд сэрүүндээ ном айлдаад явж байхад нь хүмүүс



үймүүлж, аминд нь халдаж байсан. Есүс Христ гэхэд л цовдлогдсон. Үүнээс гадна, өөр олон Их Багшийг хорвоо дэлхий үймүүлснээс болж зовж зүдэрч байсан. Бясалгагчид нь цөөхөн, харин бясалгадаггүй нь олон. Бясалгадаггүй хүмүүсийг би сайн биш гэж хэлж байгаа юм биш. Үгүй, үгүй. Таныг сайн биш гэж би хэлж байгаа юм биш. Би ердөө л, хэрвээ бясалгал дадуулахгүй бол бид бүр их зовж шанална, бас яагаад ингэж зовж байгаагаа ойлгохгүй. Тэгэхлээр та зовуурь шаналгаатай нөхцөл байдлыг багасгаж намжаая гэвэл бясалгах нь зүйтэй гэж би санал болгож байгаа юм. Ердөө л энэ. Та зовлон шаналлаа тэсвэрлэж чадна гэж боддог бол бясалгах хэрэггүй. Гол ялгаа нь яг үүнд л байгаа юм.

Хэргийн учир нь бясалгасны дараа бид өөрсдийгөө аугаа их гэж мэдрэхэд байгаа юм биш. Энэ нь ердөө л бясалгахаас өмнө бид маш их тэмцэл тулаан, асуудал бэрхшээл, зовуурь шаналал амсан туулж, шийдлийг нь олж чаддаггүй байсан. Ингээд л бид эдгээр асуудалдаа шийдэл олох аргыг эрж хайсан. Улмаар ингэж бясалгах боломж өгөх аргыг олж, тэгээд байдал сайжирч дээрдсээр байна. Иймээс бид энэ аргыг бусдад санал болгохыг хүссэн. Бид урьд нь шаналж зовж, тэмцэж тулалдан амьдарч байсантай адил тэгж амьдарч байгаа олон хүн энэ дэлхийд байгаа нь лавтай. Ийм л юм.

Гэвч бясалгах хүсэлгүй хүмүүс одоо ч байсаар л байна. Мэдээж, түүнд амьдрал урьдынхаараа хангалуун сайхан, бага сага тэмцэлдэх нь асуудал биш, бас энэ хорвоод ахиад хэдэн мянган жил үлдэхэд болохгүй юмгүй шиг санагдаж байгаа. Үнэн хэрэгтээ, ер нь бид бясалгаж байна уу, үгүй юү гэдгээс үл хамааран бидний дотоодод Дао болон төгс дээд Хүч байж л байдаг.

Их Багшийн буян хариулал цаглашгүй гэж та нар хэлдэг. Тэгвэл та нарын буян хариулал бүр ч илүү цаглашгүй, яагаад гэвэл та бидний дотоодод яг л ижилхэн эрдэнэ байдаг. Би үүнийг танд яаж итгүүлье дээ, гэхдээ ийм байдгийг нь би өөрөө мэдэж, ухаарсан юм. Гэхдээ бид үүнийг өөр өөрөөр ашигладаг учраас хүн хүний байдал өөр. Бидэнд Арьяабалын аргыг сурталчлах санаа алга. Зүгээр л манай бясалгагч нөхөд үүнээс гайхалтай үр өгөөж хүртсэн байдаг, тэгээд л бид үүнийг бусад хүнд ч бас таалагдаж юуны магад хэмээн бодож байгаа хэрэг. Тиймээс бид та бүхэнд энэ аргыг өгч байна. Түүнээс биш, эрт дээр цагт энэ аргыг олж авахыг хүссэн хүн маш олон саад бэрхшээлийг туулах ёстой болдог байсан: гол ус гатлан уул нуруунд мацаж, жинхэнэ Их Багшийн дэргэд хүнд хүчир хар ажил албадан хийх хэрэгтэй болдог байсан, тэгж байж л түүнд энэ аргыг зааж өгдөг байжээ. Бидний цаг үе өөр учраас ингэх нь зөв биш.

Тийм учраас л Шагжамуни Будда шиг бясалгах нь сайн биш гэж би түрүүхэн хэлсэн. Зөвхөн гагц Түүний хувьд бол энэ сайн л хэрэг.

Гэтэл бид өөр, бид Түүний замаар явах аргагүй. Бид эхнэр хүүхдүүдээ орхиж явах боломжгүй. Харин Түүнийг явахад ард үлдсэн гэр бүлд нь санаа тавих бүхэл бүтэн улс орон байсан. Тэр хунтайж байсан! Хэрвээ бид гэр бүлээ орхивол тэднийг хэн халамжлах вэ? Тиймээс л ингэх нь зүгээр биш хэвээрээ байгаа хэрэг. Бид Түүний жишгийг дагах боломжгүй.

Бид билиг ухаанаараа л ижил бусыг үл тооцвол дэлхийн бусад хүмүүстэй л нэг адил. Энэ нь ч дээр. Хэрвээ бид хачин этгээд байдлаар бясалгаж, хүмүүст өөрсдийгөө огт өөр юм шиг санагдуулбал хүмүүс айж эмээнэ шүү дээ.

Өнөө цаг үед хэнд бүх зүйлээ орхин Бодь модон доор суух боломж байх билээ дээ? Тэгээд ч Формосад Бодь мод тун цөөхөн байдаг. (Инээлдэв) Хүн бүр Бодь мод эрж хайгаад явбал дайн дэгдэх биз. За яахав, тийм юм бол бид Бодь модон доор суух албагүй. Бид зүгээр л гэр орныхоо дээвэр доор л сууя - бид гарцаагүй гэгээрнэ, үүнийг манай шавь нар батлан хэлж чадна.

Шавь нарын маань ихэнх нь энгийн хүмүүс, бас цөөн хэдэн гэлэн ч бий. Гэвч би лам нарыг нэг их чухалд тооцдоггүй. Миний хувьд хувраг, энгийн шавилагчийн алин ч ялгаагүй адилхан. Хамгийн гол нь дотоодын дэс төвшин. Бид ямар дэс төвшинд хүрсэн нь л чухал. Таныг бусдаас ялгаатай болгож байгаа гадна талын хувцас чинь биш. Бясалгал дадуулах нь өөрийн буян хариулал, зүтгэл чармайлт, билиг ухаанаас хамаарна. Гадна талдаа ямар байхаас хамаардаггүй.

Эрт дээр цагаас л олон жинхэнэ Их Багш энэ тухай аль хэдийн дурдсан байна. Хэрэв та Бадамлянхуа Судрыг (Lotus Sutra) уншвал Арьяабалын аргыг дурдсан байгаа. Энэ сударт Брахманы Аялгуу, далайн давлагааны Чимээ, ер бусын ертөнцүүдийн Чимээ, аянгын Чимээ, Хөгжим болон өөр бусад Чимээ гэж дурдсан байдаг. Мөн олон янзын Гэрлийн тухай: алтлаг өнгөт алтан Гэрэл, шаргалдуу өнгийн шар Гэрэл, цайвар өнгөт цагаан Гэрэл гэж дурджээ. Аль хэдийн хэлчихсэн байгаа биз? Жуанз бас зарим хэдийг нь дурдсан байсан. Библи сударт ч бас Бурхны Дуу хоолой нь аянгын нүргээн, тэнгисийн усных мэт гэх зэргээр дурдсан байдаг. Бурхан илрэн үзэгдэхдээ асар том, хурц тод гал байсан гэх мэт. Аль хэдийн хэлчихжээ, тийм ээ?

Тиймээс хамгийн чухал санаа бол миний түрүүн хэлсэнчлэн; бид энэхүү Арьяабалын аргаар бясалгал дадуулвал үнэхээр ач тусыг нь хүртэж чадна. Энэ нь зөвхөн тухайн хүнд өөрт нь өгөөжтэй төдийгүй бүхэл бүтэн улс оронд нь тусалж, бүх дэлхийг ариусгадаг. Өнөө цагийнх шиг ийм олон хүн урьд нь хэзээ ч Арьяабалын аргаар бясалгаж байгаагүй. Тиймээс манай дэлхий улам бүр сайжирч байгаа нь та бүхэнд илхэн харагдаж байгаа байх. Хэт туйлширсан, маш хатуу харгис олон үзэл суртал нуран унасан. Бид дайтаж байлдах шаардлагагүй болсон.

Урьд нь бид эдгээр үзэл суртал бие биетэйгээ мөргөлдөхөөс хамгийн их айдаг байсан. Өөр өөр үзэл сурталтай хүчирхэг улс орнууд харилцан бие биеэ болон манай дэлхийг сөнөөнө; төв тусгай албад нь хэдхэн товч дарах төдийд дэлхий бүхэлдээ арилна гээд л. Бид маш их айж эмээдэг байсан, тийм биз? Хэдхэн жилийн тэртээ л бид их айж эмээдэг байлаа. Харин одоо бидэнд илүү аюулгүй болсон шиг санагддаг, тийм биз? Дэлхий маань энх тайвны шугам руу улам л ойртож буй мэт байдаг. Бид их холыг харах хэрэггүй болжээ. (Алга ташив)

Формосаг харцгаая л даа. Намайг анх ирж байсан үеэс хавьгүй тав тухтай, илүү дээр болсон байна! Надад ингэж л санагдаж байна. Тийм биш гэж үү? (Сонсогчид:Тийм) Би сонин уншдаггүй, зурагт ч үздэггүй, гэхдээ надад ийм мэдрэмж төрсөн. Тийм биз? Тийм бол сайн байна. Эх газрын Хятад улсын байдал ч бас улам бүр дээрдсэн, тийм үү? (Сонсогчид:Тийм.) Хүссэн хэмжээгээр сайжраагүй ч гэсэн өмнөхөөсөө илүү дээрдсэн байгаа нь тун сайн хэрэг.

Энэ дэлхийн хурд маш удаан байдаг учраас л та бүхэн заримдаа тэвчээр алддаг. Энэ үнэн. Таны ааш муутайгаас болсон юм биш. Энэ дэлхий дэндүү амар тайван биш учраас тэр. Бид юу ч хийлээ гэсэн ямагт олон бүтэлгүйтэл, таагүй мөч гарах л болно. Мөн үр дүн гарах нь тун удаан. Одоо хавьгүй хурдан болсон, гэсэн ч их удаан хэвээрээ л байна.

Заримдаа бид ухаалаг дарга, эсвэл менежер хэр нь тийм ч ухаалаг биш, эсвэл хамтач биш ажилтан, эсвэл доод тушаалтнуудтайгаа нүүр тулахад өдөр бүр толгой өвддөг. Гэтэл хүмүүс ааш муутай гэж ярьдаг. Үнэн хэрэгтээ тийм биш. Тэр арай илүү ухаалаг сэргэлэн, эсвэл юмыг илүү шийдэмгий, хурдан хийчихдэг хүн байж болно, гэтэл эргэн тойрны бүх хүн нь түүнтэй харьцуулахын аргагүй, түүнийг гүйцэж чадахааргүй байдаг. Ингээд л түүнд ихээхэн цаг хугацаа үрж, эрч хүчээ барж, ялагдаж дийлдсэн мэт санагддаг. Алдсан цаг хугацаагаа өөр зүйл хийхэд зарцуулж болох байсан. Дэмий үрэгдсэн эрч хүчээ өөр газар тус хүргэхэд зориулж болох байсан. Тиймээс энэ дэлхийд амьдралынхаа төлөө зүтгэнэ гэдэг үнэхээр их эр зориг, тэсвэр тэвчээр шаардагддаг. Тиймээс би та нарын санаа сэтгэлийг бас ойлгодог. Хэрвээ та дарга, эсвэл өөр дээрээ зарим нэг нийгмийн үүрэг хүлээх ёстой алба тушаалтан л биш бол та маш их бүтэлгүйтэлтэй тулгарна.

Урьд нэгэн удаа Формосад байдаг нэгэн алба тушаалтан эмэгтэй надтай уулзахаар ирээд нулимс дуслуулан сууж байлаа. Тэр нилээн өндөр алба тушаалтай. Нэрийг нь дурдаад яах вэ. “Их Багш аа, ямар учиртай юм бэ? Би урьд насандаа ямар алдаа гаргаснаа мэдэхгүй юм. Одоо энэ амьдралдаа юу ч хийлээ гэсэн надад дандаа саад тотгор учирч, хүмүүс үймүүлж байх юм. Ямар нэг ажил хийнэ гэдэг дандаа маш хэцүү байх юм” гэсэн.

Би түүнд: “Нэн хэцүү бэрх ч гэсэн чи үүнийг хийх хэрэгтэй.

Хэрвээ энэ маш амархан ажил байсан бол хэн ч үүнийг хийчихэж чадна шүү дээ” гэж хэлсэн. Тэр ойлгосон байх аа.

Тэр төр засаг болон ард иргэдийн итгэл хүлээж чадсан маш авьяаслаг, бас ёс журамтай хүн хэдий ч нэн их зовлон зүдгүүр туулсан. Сайн юманд садаа мундахгүй гэдэг. Харахад гял цял болсон алба хашдаг өндөр тушаалын түшмэл байх нь тэр бүр харагддаг шигээ сайхан байдаггүй. Хөшигний ард маш олон зовлон зүдгүүр өрнөж байдаг. Ийм байдгийг хүмүүс ойлгодоггүй.

Хэрвээ бид жирийн хүмүүс бол, өөрийгөө болон гэр бүлээ тэтгэх хангалттай орлого олчихдог л бол их дарамт шахалтыг төдийлөн амсдаггүй. Гэвч энэ замд ч бас аюул эрсдэл бий. Бидэнд тийм их дарамт шахалт, их зовлон шаналал байхгүй бол бид бясалгах талаар боддоггүй, илүү дээд ертөнцийн тухай мэдэхийг хүсдэггүй – “дэлхий маань нэн амгалан, амьдрал маань дэндүү эгэл жирийн” гэдэг. Бид одоо байгаа стандарт хэм хэмжээгээ дээшлүүлэх талаар боддоггүй; тиймээс л энэ нь аюултай. Зарим хүн маш баян чинээлэг, тэдний амьдрал тав тухтай, амар жимэр амьдардаг. Гэд илүү дээр ертөнц байдаг талаар боддоггүй; иймээс энэ хоёр хэв маяг хоёулаа тийм ч сайн биш.

Хэдийгээр бидэнд маш их буян хариулал байгаа мэт санагддаг ч энэ нь өнө мөнхийн цаг хугацаанд бол бидэнд хүрэлцэхгүй. Хэрвээ бид баян байгаад хажуугаар нь бас бясалгах тухай боддог байж болно, тэгвэл үүнийг бид урьд өмнө нь билиг ухаанаа их хөгжүүлсэн байжээ гэж үздэг. Яагаад гэвэл бид урт удаан аялалд гарах тухай бодож байлаа гэхэд мөнгө төгрөг нь үргэлж байж байдаг юм биш. Хичнээн тав тухтай, хичнээн баян тансаг байлаа ч нэгэн өдөр бид буцах хэрэгтэй болно, эсвэл энэ эд хөрөнгө, тав тухтай амьдралын хэв маяг биднийг орхино. Ийм өдөр хэзээ тохиохыг бид мэдэхгүй.

Арьяабалын арга буюу бясалгалын арга нь бидний дотор ямар гайхалтай өөр бусад хүч оршдог; бидний ашиглаж амжаагүй ямар авьяас чадвар байдаг; орчлон ертөнцөд их үзэсгэлэнтэй, илүү тав тухтай, эсвэл бүр үүрд мөнхийн ямар төвшин байдгийг танин мэдэх боломж өгнө; тиймээс бид бясалгах л хэрэгтэй.

Энэ дэлхийд дуртай, энэ дэлхий хангалттай сайн сайхан гэж боддог хүмүүс үүнийг сонирхохгүй. Гэхдээ Их Багш та нарт энэ дэлхий мөнх биш гэдгийг сануулж хэлэх ёстой. Ямар ч дайнгүй, байгалийн гамшиггүй, бусад зовлон зүдгүүргүй, өвчин эмгэггүй байлаа ч гэсэн бид хэзээ нэг өдөр үхэх нь гарцаагүй.

Түрүүхэн бидний уншсан Ли Зы (эртний Хятадын Их Багш) амьдрал-үгүй, үхэл-үгүй ертөнцийн тухай ярьжээ. Тэгвэл бид бясалгаж яах юм бэ? гэхэд Тэрээр “Амьдрах нь амьдарч байгаа юм биш, үхэх нь үхэл биш” гэжээ. Тэгвэл бид яагаад бясалгах ёстой юм? Энэ нь түүний дэс төвшин, түүний туршлага. Бид тэр дэс төвшинд хүрээгүй байна.

Бидний хувьд бол амьдрал бол амьдрал, үхэл бол үхэл л юм, тэгсэн ч бид бас зовсоор л байдаг. Хэрвээ бид Арьяабалын аргаар бясалгаж, өөрийгөө гэтэлгэх аваас тэр цагт бидэнд амьдрал, үхэл ялгаагүй болно. Хэрвээ бид амьдрахыг хүсвэл амьд байна. Хэрвээ үхэхийг хүсвэл бид үхнэ. Ертөнцийн аль нэг буланд үлдэхийг хүсвэл бид тэндээ үлдэнэ. Хэрвээ тэнд үлдэх бодолгүй байвал өөр тийш явчихна. Бид арай эрх чөлөөтэй.

Тэр байтугай энэ дэлхийд үлдлээ ч бид хангалттай чөлөөтэй байж чадахгүй. АНУ ч юмуу, нэг тийш явахыг хүслээ гэхэд амаргүй байх болно. Жишээ нь, би Формосад үлдэх санаатай байлаа ч энэ нь бас тийм ч амаргүй. Би маргааш эндээс явах гэж байна. Тиймээс энэ хэдэн жил надад үнэнхүү сайн сайхнаар хандаж ирсэн хүн бүхэнд талархаж байна. Надад сайн сайхнаар хандсан хүн бүхэнд би талархаж байна. Намайг эндүү ташаа ойлгосон, эсвэл таагүй сэтгэгдэлтэй үлдсэн хүмүүс надад харамсалтай байна. Яагаад гэвэл энэ дэлхий дээрх харилцаа маш хэцүү шүү.

Би Формосагаас явах бүртээ буцаж ирэх эсэхээ мэддэггүй. Түүнчлэн сүнслэг бясалгалын энэ асуудлаар олон түмэнд ярих боломж хэзээ гарахыг мэддэггүй. Тиймээс би та нарт бүгдэд тань талархаж байна. (Алга ташив)

Би Формосад үлдэх санаатай байгаа юм биш. Зүгээр л би Формосатай барилдлагатай бололтой. Гэхдээ би Формосагийн хүмүүст үнэхээр, маш их хайртай! (Алга ташив) Яагаад гэвэл та бүхэн тун ариун сэтгэлтэй, бас нэн шаргуу, хичээнгүй хөдөлмөрлөдөг. Бид дотоод билиг ухаанаа жаахан ахиулчихад л хэний ч дор орохгүй болно, хэн ч таныг, Формосагийн ард түмнийг ялан дийлж чадахгүй болно гэж би бодож байна.

Тиймээс бид Арьяабалын аргыг дадуулдаг нь зөвхөн өөрийгөө гэтэлгэхийн төлөө биш билээ. Бид энэ дэлхийд байгаа цагтаа гараг дэлхийгээ сайхан болгоход бага ч болов нэмэр болохын төлөө энэхүү билиг ухаанаа ашиглаж чадна. Хэрвээ Формосагийн ард олон бясалгал дадуулах аваас юутай гайхамшигтай вэ, бүр ч гайхамшигтай болно. Би тэр тусмаа Формосаг тийм болоосой гэж хүсэж байна. Гэхдээ бүр ч төвөгтэй болчих юм болов уу – байн байн ирж байх хэрэг гарах юм байна. (Алга ташив)

## ӨӨРИЙГӨӨ УУЧИЛ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
1993 оны 11 дүгээр сарын 25 (DVD 396)  
АНУ-ын Калифорни, Хинду шашины  
Фремоннт сүм (Эх нь Англи хэлээр)*

Бидэнд ингэж уулзалдах, мөн түүнчлэн Оройн Дээд Бурхныг ямар нэр, хэлбэрээр дууддагаас үл хамааран Бурханд зориулах өдөр олдсонд баярлан талархаж байна. Намайг ийшээ ирүүлэхээр чармайлт гаргасан та нарт болон бусад бүх хүнд талархъя, эс бөгөөс би юу ч хийж чадахгүй байсан байх. Надад лекц унших, эсвэл хурал цуглаанд очих завшаан боломж гарах бүрийд би ахин дахин талархах болно, яагаад гэвэл тийм үед би ямар нэг зөв зүйл хийх гэж байгаагаа мэддэг. Хэн ч намайг ийм ажил хий гэж шахаж шаардахгүй, гуйж хүсэхгүй, эсвэл түлхэж шавдуулахгүй бол би юу ч хийхгүй л байсан байх. Тийм шүү. Тэгээд бас энэ талаар юу ч бодохгүй. Би харамсахгүй, эсвэл энэ ажлыг хийгээгүйдээ дотоод сэтгэлдээ гэмшихгүй байх байсан гэж байгаа юм л даа.

Би ийм сайхан ажил хийхийг ер нь яагаад хүсдэггүй юм бол, мэдэхгүй юм. Би учрыг нь мэдэхгүй байна. Гэхдээ энэ ажлыг хийх болгондоо энэ бол сайн хэрэг гэж боддог. Би үүнийг хийх ёстой байдаг нь сайн хэрэг, гэлээ гэхдээ би үүнийг дахиж хийхсэн гэж хүсдэггүй. Тэгтэл дараа нь хэн нэгэн хүн намайг гарч лекц унш гэж шавдуулдаг, тэр үед л би энэ ажлыг хийж байгаадаа дахин талархдаг. Энэ ямар учиртайг та нар мэдэх үү? Залхуурал л байх гэж бодож байна. (Инээлдэв) Би үнэхээр өөрийгөө ойлгодоггүй. Хүмүүс юу гэж хэлдэг вэ гэхээр “Та чинь гэгээрчихсэн хүн; та бол Их Багш, та өөрийгөө мэддэг л баймаар юм” гэдэг. Гэхдээ би мэддэггүй гэдгээ хүлээх ёстой!. Мэдэхгүй юм даа. Би гэртээ унтаад л байж байвал ялгаагүй жаргалтай байж чадна. Тиймээс би үнэхээр мэдэхгүй. Харин энд ирчихсэн хойноо бол энд байгаадаа талархаж, бас их жаргалтай байдаг. Би орондоо ороод унтаж байхдаа жаргалтай байж, унтаж байгаадаа талархана. Харин та бүхэн намайг ийшээ шавдуулан ирүүлсэнд би үнэхээр талархаж байна, юу гэхээр би хүнд өчүүхэн ч атугай хэрэг тустай байгаа минь маш сайн хэрэг учраас надад ерөөсөө тун сайхан байгааг та бүхэн мэдэж байгаа байх.

Сүм хийд ч бас ач тустай, бид тэнд цуглаад Оройн Дээд Бурханд даатгал өргөн өдрийг сайхан өнгөрүүлдэг. Эсвэл та зөвхөн үдийн хоол

идэх гэж л ирсэн юм уу? (Инээлдэв) Үгүй байлгүй дээ? Би эндүүрээгүй, тийм биз? Та нар Бурхны л төлөө ирсэн, тийм биз? (Сонсогчид: Тийм.) За, сайн, ингээд та үдийн хоол идэх эрхтэй боллоо. (Инээлдэв.)

Бидэнд сүнсээ тэтгэх хоол байхгүй бол ер нь юу идлээ ч тэр нь үнэндээ тийм чухал биш; тэр бүхэн сэтгэл санаа, бие махбодын хувьд биднийг хэзээ ч бүрэн цагтахгүй. Тийм учраас бид улам л өлссөөр, ахин дахин өлсөөр байдаг. Тэр байтугай олон сайхан хоол хүнс, амин дэмийг ахиухан идэж хэрэглэсэн ч өвчин туссаар байдаг, заримдаа ходоод гэдэс хямарч, хоолоо шингээж чадахаа больдог.

Эхлээд Бурханд өргөл тахил болгохын тулд хоол хүнс бэлтгээд дараа нь өөрсдөө түүнийг идвэл нэн шим тэжээлтэй төдийгүй бидэнд ирэх адислал нь ч их байдаг тухай Бхагавад Гита сударт дурджээ. Хэрвээ бид зөвхөн өөрийн сэтгэлийг хангах үүднээс бэлтгэвэл үнэндээ алдаа гаргаж байгаа хэрэг. Ингэвэл маш их сэтгэл дундуур болж, заримдаа хоол шингэхгүй байх гэх мэтийн таагүй явдал болдог. Чухамдаа Бхагавад Гита сударт үүнээс ч хатуу, маш хүчтэй. Тухайлбал: “Хэрвээ урьдаар Бурханд өргөөгүй бол та гэм нүгэлт юм идэж байгаа хэрэг” гэжээ. Би ингэж хэлж байгаа юм биш; Кришна бурхан хэлсэн байна.

Тэгэхлээр одоо энэ нь зөвхөн хоолны тухайд ч биш, бүх зүйлд ийм аж. Бхагавад Гита-г та нар бүгд мэдэх үү, үгүй юу? Энэ бол эртний Энэтхэгийн билиг ухааны судар. Бараг таван мянган жилийн настай. Үүнийг тухайн цаг үеийн Төгс Гэгээрсэн Их Багш буюу Кришна, хайрлан дурлагч, хар үзэсгэлэн гоо айлджээ. Олон Энэтхэг хүний адил түүний царайны өнгө нь бараан байсан ч Тэр нэн үзэсгэлэнтэй, царайлаг тул түүнийг “зүрх шархлуулагч” гэж нэрлэдэг байжээ. Энэ нь бас Түүнийг явж одоход хүн бүхний зүрх шархалдаг байсан учраас тэгж ярьдаг хэрэг аж. Түүнийг хаана ч очлоо гэсэн хүмүүс Түүнийг хайрладаг, Түүнд мөргөдөг, Түүнд өргөл өргөдөг, ерөөсөө л Түүний хойноос өөрийн ухаангүй дагадаг байжээ.

Түүнийг бараг л арван зургаан мянган гэргийтэй байсан гэж ярьдаг юм байна лээ. За яахав, Энэтхэгчүүд заримдаа дэгсдүүлдэг л дээ, гэхдээ Түүнд маш олон дагалдагч байсан байж таарна. Тэр бүхэн нь үнэндээ эхнэр нь биш, шавь нар нь юм. Магадгүй дийлэнх нь эмэгтэй хүн байсан, яагаад гэвэл – миний сонссоноор бол, Тэр маш царайлаг учраас тэр байх! Би тэнд байгаагүй. Эсвэл байсан байж болох ч би мартжээ.

За тэгэхлээр, Бхагавад Гита бол Их Багш Кришнагийн сургаал. Та энэ номоос чамгүй удирдамж, бас билиг ухаан олж авна. Би өнөө ч үе үе үзэж уншиж байдаг юм. Би одоо ч гэсэн лавлаж хардаг, яагаад гэвэл энэ нь маш сайхан, төвлөрөлтэй, бас цэцэн мэргэн. Заримдаа та энэ номыг уншиж байхдаа тайтгарч, тайвширна. Та үүнийг үнэхээр ойлгож, шингээж авах юм бол энэ нь билиг ухааны гайхамшигтай бүтээл билээ.

Урьд үеийн олон Их Багш Энэтхэгийн хуультай холбоо барилдлагатай байдаг учраас бид Энэтхэгийн тухай, мөн Бхагавад Гита-г дурдахгүй байж чадахгүй. Тэр бүү хэл Мьял Богд, та мэдэх үү? Төвөдийн аугаа йогч. Тэр байтугай, Төвөдийн энэ аугаа йогчийн хамаг өмч хөрөнгө нь хоолны тогоо, Бахагавад Гита судар хоёр л байжээ.

Тэгэхлээр, энэ номд дурдсанаар бол зөвхөн хоолоо зооглохоосоо өмнө төдийгүй ерөөсөө эхлээд Бурхан өргөх сэтгэлээр бэлтгэж, амьдралдаа хийдэг бүх зүйлээ Бурханд, Оройн Дээд Сүнсэнд өргөл болгох ёстой, золиослон зориулах ёстой гэж дурджээ. Ингэвэл л бид үүнээсээ сайн, эсвэл муу үр дүнг хэзээ ч хураахгүй, яагаад гэвэл сайн, эсвэл муу үр дүн биднийг энэхүү материаллаг хорвоод уяж хүлдэг.

Тэр байтугай, хэрвээ бид заримдаа өөртөө тусалж чадахгүй байх үедээ муухай аашилж; уурлан хорсдог, тэгсэн ч ингэх ёсгүйгээ мэдэж л байдаг. Тэгчихсэний дараа, заримдаа уур хилэн аль хэдийн дарагдсан хойно бид удтал ихэд харамсаж явдаг. Гэхдээ би та нарт өөрийгөө уучил гэж захиж хэлбэ. Ямар ч үед өөрийгөө уучил. Юу ч хийсэн бай, түүнийгээ Бурханд өргөл болго. Үр дүн нь ямар ч байлаа гэсэн тийм л болог, яагаад гэвэл бид тэртээ тэргүй бие махбод биш. Бид үйлдэл биш. Бид энэ дэлхийд юу ч хийдэггүй. Тэр бүү хэл, хэрэв бид үйлдэгч нь мөн гэж бодсон ч өөрийгөө уучлах л ёстой болно. Алдаа гаргасан үедээ, эсвэл уур хилэн, үгүй бол хааяа гаргадаг харамч хариг ааш зан, мөн зарим үеийн тачаангуй санаа бодол гэх мэтийн дадал зуршлаа орхиж гэж чадахгүй байх үедээ ч өөрийгөө уучилж бай, яагаад гэвэл энэ бүхэн нь орчны нөхцөл байдлаас л үүсэж бий болдог. Энэ бол Жинхэнэ Би биш; үнэн хэрэгтээ сүнс маань энэ бүхнийг хүсдэг юм биш.

Тэгэхлээр, бид ахин дахин хичээн оролдох ёстой, бас эцсийн эцэст өөрийгөө уучлах хэрэгтэй гэж би юун түүрүүнд хэлэх гэсэн юм. Яагаад гэвэл дотоодод маань Бурхан, Оройн Дээд Билгүүн ухаан байж байдаг, түүнийг бид загнаж болохгүй, үүнийг буруугаар ашиглаж болохгүй, түүнд бүдүүлэг хандаж болохгүй. Тийм учраас, хэрвээ бид өөртөө уурлана гэвэл зөвхөн зуршилдаа, хуримтлагдсан зуршилдаа л уурлах ёстой. Эсхүл бид бас нөхцөл байдлыг буруутгах ёстой, түүнээс биш, Оройн Дээд Билгүүн ухаан, жинхэнэ Би-гээ буруутгах учиргүй, яагаад гэвэл жинхэнэ Би маань хэзээ ч алдаа гаргадаггүй, хэзээ ч андуурч эндүүрдэггүй.

Бид ийм нийхэмд байгаа, бас хийж бүтээдэг хүмүүс юм гэж бодъё, заримдаа бидний уур хүрдэг. Энэ нь дандаа бидний буруу байдаггүй. Ихэнхдээ бидний буруу биш байдаг. Зарим үед юм бүхэн биднийг уурлуулчихдаг. Жишээлбэл, та нэгэн компанид ажиллаж байхдаа буруу хүний дэргэд байж болно. Та юу хэлсэн ч тэр ерөөсөө ойлгодоггүй. Эсвэл ойлгосон ч эсрэгээр нь хийчихдэг. Тэр ер нь таныг дандаа л уурлуулж байдаг. Тэр битгий хэл, та түүнийг ахин дахин

уучлавч, тэр үүнийгээ ахин дахин давтаад л байдаг. Маш жижигхэн, бүр шалихгүй зүйл ч биднийг ундууцуулж, сэтгэл шаналгадаг. Тэгэхлээр сэтгэлээс дээш, бие махбодоос дээш өөр ямар нэгэн зүйл байгааг бид мэдэж байгаа нь сайн хэрэг.

Бие махбод бол ус, шороо, төмөр гэх мэт зөвхөн материаллаг зүйлээс бүрддэг. За яахав, хэдэн хадаас хийхэд хангалттай хүрэлцэх төмөр бидний бие дотор байж байгаа. Та нар мэдэх үү? Бас ус, шороо, магадгүй бас, бие махбодыг дулаацуулахын тулд гал, амьдралын гал ч байгаа юм байж.

Оюун ухаан юунаас бүтдэг вэ? Энэ бол ердөө л – сайн болон муу гэсэн мэдээллийн цуглуулга л юм. Яг л компьютер шиг – та түүнд ямар программ суулгасан байна, товчлуур дарахад тэр чинь л яг гарч ирнэ. Манай нэг авшигтан цахилгаан бадралт баг бишгүүр хөгжимтэй, түүндээ янз янзын айзам хэмнэлтэй программ суулгачихаад тэгээд хуурцаг хийгээд буцаагаад тоглуулчихдаг. Бидний тархи ч бас үүнтэй л ижил. Тархи уг нь хоосон байдаг, биднийг түүн дээр заримдаа сайн, заримдаа муу гэх мэтийн зүйл, мэдээлэл бичиж эхлэх хүртэл үнэхээр хов хоосон, яг цоо шинэ компьютер шиг л байж байдаг. Хэрвээ бид аз болж сайн мэдээлэл хураачихсан байгаад түүнийгээ ашиглахыг хүсвэл тэндээс сайн мэдээлэл л гарч ирнэ. Муу мэдээлэл биччихсэн байх юм бол мэдээж муу мэдээлэл л буцаж гарч ирнэ.

Тиймээс одоо бясалгах, Бурханд залбирах, Ариун Судруудыг судлах нь ердөө л бодол сэтгэлгээгээ, амьдрах хэв маягаа дахин программчилж байгаа арга зам л юм. Бид түүнийг гайгүй сайн зохирол нийцэл дээр дахин программчилбал, буцаж гарч ирэх үр дүн нь ямагт сайн байх болно, эсвэл ядаж л өмнөх шигээ муу байхгүй, эсвэл ядахнаа л бүгдээрээ муу байхгүй. Хэдийгээр өдөр болгон илүү их муу мэдээлэл тархиндаа бичиж авахгүй байж чадахгүйг эс тооцвол тоо хэмжээ нь өмнөхөөсөө улам л цөөрнө. Үүний учир нь бид сайн зүйлсийг бүртгэж авахаа үргэлжлүүлж байгаа, Бурхны нэрийг бясалгадаг, бид Бурхны Хүч дээр бясалгадаг, тэгээд биднийг баяр баясгалан, буянт үйл, адис ерөөлөөр дүүргэн биднээр дамжиж байдаг Бурхны хүчийг авдаг. Ингэснээр муу мэдээлэл орж ирлээ ч түүнд зай олдохгүй, магадгүй бүр багасдаг. Өдөр тутмын бясалгалаар дамжуулан Бурхнаас хүртсэн хүчирхэг энерги болон буян хишгийн ачаар бидний оюун ухаан, сүнсэнд маань хор хөнөөлтэй ямарваа мэдээллийг сулруулж, эсвэл бүрэн шингээн боловсруулж чадна. Ийм учраас л бид бясалгахгүй байж болохгүй! Бид Ариун Судруудыг судлахгүй байж болохгүй.

Ихэнх хүн Ариун Судруудыг судлах дуртай байдаггүй. Яагаад тэр вэ? Ойлгодоггүй учраас тэр. Залуучууд, орчин цагийн хүмүүс Судар бичиг, Ариун Судрыг судлах сонирхолгүй байна гэж сүм хийдийн гэгээн хүмүүс гомдоллож байхыг би сонсдог. Үүний учир нь ихэнх

ариун Судар хэтэрхий гүнзгий утгатай, дэндүү уран тансаг, хэтэрхий гүн гүнзгий, заримдаа орчин үеийн хүмүүс, жирийн хүмүүс ойлгоход арай л хүнд бэрх байгаад оршдог.

Гэсэн ч бидэнд нэг шийдэл бий. Бид эхлээд ойлгохуйн хүчээ нээх хэрэгтэй, тэгсэн цагт л Библи, эсвэл Ариун Судруудыг ойлгож чадна. Та ямар ч номыг, юуг ч шүүрээд авлаа гэсэн ойлгож чадна. Библи, Бхагават Гита, Буддын судрууд, эсвэл Күнз, Луузын сургаал ном зэргээс уншаад ихэнхэд нь юу өгүүлснийг нь би ч бас сайн ойлгодоггүй байсан. Би Күнз, Луузын сургаалын номуудыг уншдаг л байсан. Өнгөцхөн нь л гэхээс биш одооны шиг гүн гүнзгий ойлгож чаддаггүй байлаа. Бидний ойлгохуйн хүч нээгдчихлээр билиг ухаан маань дахин ашиг тустай байж чаддаг болчихдог, ингэнгүүт л бид олон зүйлийг ойлгож чадна. Тиймээс хэрвээ Судар номыг ойлгохгүй байгаа бол гэгээрлээс эхлэх нь хамгийн сайн. Гэгээрэл гэдэг нь бид ойлгож мэдэхүйн хүчээ нээнэ гэсэн үг, тэгвэл диваажингийн Гэрэл, Бурханлаг Гэрэл бидний судлахыг хүсэж байгаа аль ч зүйл дээр бүхий л ойлголтыг тусган гийгүүлж өгнө.

Одоо ч гэсэн коллежийн оюутнуудад ядаж л үймэрсэн сэтгэлийг нь тайвшруулахын тулд олон төрлийн бясалгал зааж байгаагийн учир нь энэ. Хэрвээ тэдэнд илүү сайн бясалгал, тэр байтугай билиг ухааны үүд хаалга, ойлгохуйн хүч чадлыг нь нээж өгч чадах хамгийн сайн бясалгал байх юм бол тэдэнд нэн тустай. Тиймээс коллежид суралцахынхаа хажуугаар бас бясалгадаг оюутнуудын ихэнх нь судлахыг хүссэн аль ч хичээлээ эзэмшихэд улам хялбар дөхөм болох билээ. Тийм оюутнууд сургуульдаа ямагт маш сайн сурдаг. Энэ бол одоо хэн бүхний мэдэх баримт.

Яагаад хойд төрөл байдаг вэ? Энэ нь бид жинхэнэ Би-гээ мэддэггүй, харин Би-г агуулагч савны хойноос хөөцөлдөж байгаа учраас тэр. Тиймээс бид нэг бүрийх нь араас хөөцөлддөг. Жишээ нь, далай доторх ус бүхэлдээ нэг. Хэрэв усыг аягалчихвал, эсвэл аягыг ингэж битүүмжлээд далайд тавьчих юм бол аяган доторх ус далайгаас тусгаарлагдана. Харин аяга хагармагц ус буцаад далайтай нэгдэн нэг бүхэл зүйл болно. Хэрэв доторх ус нь аягандаа хүлэгдээд байгаа бол энэ савыг хагалчихвал тэр ус өөр аяга хайхаар явна, ингээд л далайгаас үүрд тусгаарлагдах болно.

Яг үүнчлэн, бидний жинхэнэ Би хэзээ ч энэ бие махбод дотор агуулагддаггүй! Учир нь тэр бол хаа сайгүй түгэн нэвтрэгч, мөн олон станцын нэг нь, ердөө л бидний ялимгүй хэсгийг агуулсан олон зүйлийн нэг нь. Тийм учраас бид энэ хязгаарлалтыг л эвдчих юм бол бүхэлтэйгээ нэгдчихнэ. Гарахын тулд энэ бие махбодыг эвдлэж хэмхлэхийн хэрэг байхгүй; тэндээс гарч явах арга зам байдаг юм. Жишээлбэл, бид аяган дахь усыг чөлөөлөхийн тулд аягыг нь хагалах шаардлагагүй; бид харин хаагуураа шүүрч гоождог, эсвэл хаана нь нүх сүв байгааг л мэдчихэд

л болно; тэгэхээр аяга ч эндээ байж л байна, ус нь ч дотроо байж л байна, гэхдээ үүний зэрэгцээ ус үргэлж орж гараад л бүх далайтайгаа холбоотой байж байдаг.

Үүн шиг бидний энэ аяга буюу биед нэгэн нүх бий, гэхдээ тэр нүх бөглөрчихсөн. Дотор нь сүнс, амьдралын усыг хадгалахын тулд түүнийг бөглөчихсөн байдаг юм, гэхдээ бид түүнийг нээж болно. Зарим аягыг иймэрхүү байдлаар хийсэн байдаг (Их Багш нэг аягийг гартаа барив), гэхдээ ёроолдоо нүхтэй тул тэд хуванцар тагаар тагладаг. Эсвэл бас эмийг савласан лонх байна. Бид ердөө л жижигхэн таг, хуванцар тагийг нь ч юмуу, иймэрхүү юмыг нь авчихад л доторх зүйлтэй нь холбогдчихно. Тэгэхээр бид бие махбод гэдэг энэ багаж хэрэгслэлээ хадгалсан хэвээр байхын сацуу хамаг ертөнцтэй холбогдож болох тийм газар гэж бас бий. Энэ бол гуравдагч нүдний төв, билгүүн ухаан орших газар, сүнсний суудал юм. Хэрвээ энэ нь ямар нэг аргаар, өөрийн тэсвэр тэвчээрээр, гэтлэгдэх хүсэл тэмүүллийн хүчээр, эсвэл Их Багшаар дамжин нээгдчихвэл бид хамаг орчлонтой, хаа сайгүй оршигч Оройн Дээдтэй тэр даруй холбогдчихно.

Оройн Дээдийн Хүч чадал зөвхөн энэ бие махбод дотор л хадгалагддаг юм биш, яг одоо энэ агаарт ч байгаа. Хаа сайгүй байдаг. Ширхэг өвс, модны навч болгонд, бүхий л бүтээлд шингээстэй байж байдаг. Хамаг ертөнцийн Хүчтэй аль хэдийнээ холбогдчихсон нэгэн туршлагатай хөтөч бидэнд байвал түүнийг бүр ч амархан нээчихнэ. Тэгвэл тэр маш хүчирхэг болно, яагаад гэвэл тэр хувь хүний хүч чадлыг ашиглахаа больчихдог. Тэр хүн хамаг орчлонгийн Хүчийг ашиглана, яагаад гэвэл тэр аль хэдийн холбогдчихсон байгаа. Аяган доторх ус шиг, хэдийгээр энэ ус аяган дотроо л байж байгаа ч гэсэн нүхээр дамжин үргэлжид далайтай холбоотой хэвээрээ байна; бас аяган дотроо агуулагдсаар байгаа ч цэнгэг ус ямагт орж гарч сэлбэж байдаг. Тийм учраас Их Багш, эсвэл гэгээрсэн хүн үүнтэй л адил. Авшиг хүртсэн хүн гэдэг нь ийм холбоостой, “товчлуур нь нээгдчихсэн” хүн юм. Харин Их Багш бол орчлонгийн Хүч чадлыг хэрэгжүүлэн боджуулагч нэгэн юм.

Энэ Хүч чадал бидэнд бүгдэд нь байдаг хэдий ч Их Багш бол үүнийгээ ухамсарласан хүн. Энэ нь яг л хэрвээ хоёр хүн эцгээсээ ижил хөрөнгө мөнгө өвлөж авчээ гэж бодвол нэг хүн нь үүнийгээ мэддэг, хаана байгааг нь мэддэг, ашиглаж чаддаг. Харин нөгөөд нь өв хөрөнгө байгаа ч гэсэн хаа ч юм хийгээд орхичихсон, эсвэл хаана байгааг нь ерөөсөө мэдээгүй байж гэе, тэгвэл тэр ашиглаж чадах уу? Чадахгүй! Бид ч яг үүнтэй адил, гэхдээ бид орчлонгийн Хүч чадлаа хаана ашиглахыгаа мэдчихвэл бид өөрсдийнхөө эзэн нь болно, өөрийнхөө хувь тавилангийн эзэн нь болно. Мөн түүнчлэн бид бусад олон хүнийг хувь заяаныхаа эзэн болоход нь залж чиглүүлж чадна. Эс бөгөөс, бид эн тэнцүүхэн аугаа хэдий ч аугаа чанартайгаа мэдэхгүй, тэгээд энэ нь цагаа

дэмий үрсэн хэрэг л болдог. Тиймээс бид энэ эрдэнэсийг олох хүртлээ ахин дахин эргэж төрөх ёстой болдог, олж чадсан тэр үед л бидний аялал дуусна. Их энгийн!

Бид энэ мартагдсан эрдэнэсийг эрж хайх гэж л энд байгаа, бид түүнийг олон олноо хэзээ ч бууж өгөхгүй. Амьдралдаа хэзээ ч бүрэн дүүрэн сэтгэл ханадаггүйн учир нь энэ, яагаад гэвэл бид өөр ямар нэгэн зүйл байгаа гэдгийг үргэлжид мэдэж байдаг, бидэнд яг одоо байгаагаас илүү аугаа ямар нэгэн зүйл байгааг ямагт мэдэж байдаг. Бид ямар нэг байдлаар өөрсдийгөө энэ сав буюу бие цогцос биш гэдгээ үргэлж мэдэж байдаг, учир нь үхэх гэгч зүйл болсны дараа бие цогцос байж байдаг ч бид хөдөлж чадахгүй; бид юу ч хийж чадахгүй; бид хэнийг ч хайрлаж чадахгүй; бид амаа нээж ч чадахгүй; бид ерөөсөө юу ч хийж чадахгүй! Энэ нь бид бол бие махбод биш гэсэн үг. Биднийг амьд байх үед биеийг хөдөлгөж, ажиллуулж байдаг ямар нэг зүйл бие махбодод байдаг. Үхэх цагт биед байдаг ямар нэгэн зүйл орхин оддог, тиймээс бид биеийнхээ ямар ч хэрэгслийг хөдөлгөж чадахгүй. Тэгэхлээр, бид ямар нэг байдлаар мэдэж байдаг; зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэж байдаг. Би бол харин мэддэг! Таныг мэдэж байгаа эсэхийг би мэдэхгүй байна. Та мэдэх үү? Та мэдэж байх ёстой.

Ийм учиртай болоод л та цаг завтай бол, ялангуяа зовлон бэрхшээлтэй тулгарсан үедээ суучихаад л хэнтэй ч хамт биш, ердөө гав ганцаараа байхыг л хүсдэг. Тэр үед та юм бодож тунгаадаг, тэр үед сэтгэл санаа тань ч илүү дээрддэг, яагаад гэвэл та тэнд ямар нэг юм байгаа гэж, заримдаа чимээ аниргүй үед биднийг тайтгаруулдаг ямар нэг зүйл байгаа гэж боддог. Би Арьяабалын аргыг мэддэг болохоосоо өмнө тийм л байсан. Би урьд өмнө маш их залбирч мөргөдөг байсан. Бурхан багшид залбирдаг байлаа, бас Есүст залбирдаг байлаа. Би тэдний аль нэг нь сонсохгүй үлдчих вий гэж эмээдэг байв, тиймээс би өөрийн мэддэг бүхэндээ залбирдаг байсан. Заримдаа Хиндү шашны Бурхан Кришнад залбирч байсан.

Үнэндээ зөвхөн Бурхан гэж л байдаг болохоос Хиндү Бурхан гэж байдаггүй. Бурхан ердөө л заримдаа Энэтхэг, эсвэл Хятадын хэлбэр дүрс авдаг, тийм болохоор л бид энэ бол Хиндү Бурхан, эсвэл Хятад Бурхан гэх мэтээр нэрлэн дууддаг - гэвч ийм зүйл үнэндээ байдаггүй.

Тиймээс Арьяабалын аргыг мэддэг болохоосоо өмнө би ихэд гуниглаж харамсах үедээ зүгээр л ганцаараа байхын тулд гүн гүнзгий гэгч нь залбирдаг байсан; нэг их чанга дуугарч залбирдаггүй, дотоод сэтгэлдээ чин сэтгэлийн угаас энэлэн шаналдаг байлаа. Ингэсний дараа ямар нэг зүйл намайг өөд нь өргөсөн мэт санагдаж, дотор уужирч, сэтгэл ихэд хөнгөрч, санаа зовох юу ч үгүй мэт болдог. Тэр мөчид л бид энэ амьдралаас илүү аугаа юу ч юм нэг зүйл, биднийг ямагт сонсдог ямар нэг зүйл байдаг юм байна гэж ухаардаг юм.

Ихэнх хүн залбираад ямар ч хариулт хүлээж аваагүй гэж ярьдаг.

Энэ нь тэд хангалттай гүн залбираагүй учраас л тэгсэн хэрэг. Бид маш гүн гүнзгий гуниглах үедээ илүүхэн хариулт авдаг, учир нь тэр мөчид та үнэхээр чин сэтгэлтэй байдаг. Бид энэхүү дүр эсгэж, бялдуучилдаг зангийнхаа бүх давхаргыг, өөрийн хуурмаг би-гээ нэвтлэн гараад ямар боловч, түр зуурхан ч гэлээ жинхэнэ Би-дээ хандан харилцдаг юм. Чухамхүү тэр үед л бид хариулт авдаг. Гэвч та бүхэнд зөвлөхөд хариулт авахын тулд гүн гүнзгий гуниг харуусал амстлаа хүлээх албагүй. Энэ нь сэтгэлд дэндүү зовиуртай. Бидэнд үүнийг хийх илүү дээр арга зам байна. Бид бүр харамсаж гуниглаагүй үедээ ч энэ аргыг дадуулна: ингэх нь хамаагүй дээр. Бид үхэхээсээ өмнө амжиж дадуулна; ингэх нь илүү дээр. Тийм учраас бид үхэх мөчид, энэ нь ердөө л нэг өрөөнөөс гараад нөгөө рүү орохтой адилхан байх болно. Асуудалгүй! Бид бас үүрд явчихаж ч чадна. Бид хамаг аягаа хагалаад бүх далайтайгаа нэгдэж болно, эсвэл бид хадгалаад үлдэж болно; өөр хэн нэгний хүсэл эрмэлзлэлийг хангаж өгөх, эсвэл хэн нэгэнд туслахын тулд өөр нэг аяга хайж болно.

Энэ нь Их Багш шиг л юм, заримдаа Их Багш хүн төрөлхтөнд туслахын тулд өөр өөр биед ахин дахин төрөл авдаг. Зарим Их Багш диваажиндаа, Нирваандаа л жарган баясахыг л хүсдэг, тэд хэзээ ч буцаж ирэхийг хүсдэггүй. Зарим Их Багш энэ Дэлхийд хэзээ ч хойд төрөл авдаггүй, тэд тийм санаа зорилго агуулдаггүй. Зарим Их Багш зовж зүдэрч буй хүүхдүүддээ, аугаа эрдэнэстэй хэр нь ач тусыг нь хүртэх аргаа мэддэггүй, түүнээсээ болж тун ядуу зүдүү, аз жаргалгүй байгаа хүүхдүүддээ туслахын тулд ахин дахин эргэж төрсөөр байдаг.

Энэтхэгт хүмүүс Их Багш нарт нэн бишрэл хүндэтгэлтэй ханддаг. Энэ шалтгааны улмаас Их Багшийг бүр Бурхнаас ч илүү шүтдэг. Тэд: “Өө, Их Багш болон Бурхан хоёр яг одоо үзэгдвэл би зөвхөн Их Багшид л биширч мөргөнө. Бурхан надад хамаагүй” гэдэг. Энэ нь Их Багшид талархаж, биширч буй нэг өвөрмөц хэлбэр юм. Үнэн хэрэгтээ тэд Бурхны төлөө л Их Багшийг биширдэг; Их Багшийн төлөө Бурхныг биширдэг. Жинхэнэ Бурхан байдаг эсэхийг тэд Их Багшгүйгээр мэдэх боломжгүй. Тийм шүү. Бурхны Хүч Чадалгүйгээр Их Багш ч бас юу ч биш.

Тэгэхлээр Их Багш мөн, бишээс үл хамааран бид бүгдээрээ Бурханаас ирсэн. Их Багш бол Бурхныг мэддэг нэгэн, мөн “Их Багш биш” нь Бурхныг хараахан танин мэдээгүй байгаа нэгэн, тэгсэн ч тэдэнд Бурхан байгаа; тэд угаасаа ижил эх сурвалжаас ирсэн.

Би та нарт аяганы тухай, аяганд хийсэн далайн усны тухай түүхийг ярьж өгсөн. Тэгэхлээр, авшиг хүртээх үед “говчлуур”-ыг дардаг, та нар мэдэж байгаа, ингэснээр бид ямар нэг хэмжээгээр Бурхантай, ядаж л тэрхэн мөчдөө ч болов холбоо барьж харилцдаг. Ингээд Бурхантай нэгдмэл гэдгээ, тусгаарлагдаагүй гэдгээ бүрэн дүүрэн танин ухаарах

хүртлээ бид энэхүү дадлыг өдөр бүр давтан үргэлжлүүлсээр байдаг.

Авшиг хүртсэн хүн олон зүйлийг ойлгож мэдсэн байдаг ч түүнийгээ үгээр илэрхийлэхэд хэцүү. Би ч мөн адил. Хэрвээ надаас хэн ч, юу ч нэхэж шаардахгүй байвал би Бурхны тухай бүр бодох ч үгүй. Миний юу гэж хэлж байгааг мэдэж байна уу? Тэр ердөө л миний ойр хавьд ямагт зогсож байдаг, эсвэл Тэр миний дотор байж байдаг. Тиймээс би Түүний тухай боддог ч үгүй. Би Түүний тухай ярьдаггүй. Би Түүнийг санаж үгүйлдэггүй. Би Түүнийг эрж хайхаа больсон. Ердөө л бусдад хэрэгтэйг нь бодож л би Бурхны тухай ярьдаг, энэ зүйлсийн талаар ярьдаг юм. Заримдаа надад Бурхны тухай ярих нь амаргүй байдаг. Магадгүй тийм учраас л надад ном тайлах гэх мэтийн зүйл хийхээр явах хүсэл төрдөггүй байх, яагаад гэвэл би зүгээр л хаа байгаа газартаа, хийж буй зүйлдээ сэтгэл ханачихсан байдаг.

Авшигтан хүмүүс голдуу тийм байдаг. Тэдний олонх нь ийм сэтгэл ханамжийг авшиг хүртэх үедээ тэр дорхноо авдаг бөгөөд энэ нь үүрд үргэлжилдэг. Зарим нь эрдэнэсээ олсон гэдгээ ухаартлаа хэсэг хүлээх хэрэгтэй болдог. Яагаад ийм байдаг вэ? Учир гэвэл зарим хүний “хөшиг” нь бусдынхаасаа илүү зузаан байдаг, тэдний амьдралынхаа туршид хуримтлуулсан маш их мэдлэг болон оюун ухааны төвшний ойлголтууд нь саад хаалт болж, тэд үүгээрээ бахархаж, үүнтэйгээ зууралддаг. Тийм учраас бид өөрсдийгөө энэ мэдлэгээсээ илүү, докторын зэргийн гэрчилгээнээсээ ч илүү аугаа гэдгээ мартсан. Доктор, ийм тийм алба тушаалтан гэх мэт бахархах дуртай нэр цолоосоо ч илүү аугаа гэдгээ мартсан. Бид үүнээс ч аугаа, энэ дэлхий дээрх ямар ч хаанаас аугаа шүү.

Заримдаа бид өөрт маань ийм аминч үзэл байгааг, энэ Би гэх үзэл биднийг Маяа-гийн урхи торонд оруулсныг ухаардаггүй. Бид үүнийг маш их бясалгаж ойлгож мэдэх хүртлээ ерөөсөө ухаардаггүй. Тэгээд бид маш их бясалгах тусмаа өөрийн дадал зуршил, өөрийн цуглуулсан хог новш, утгагүй дэмий бодлууд өөрт маань эргээд саад хаалт болж байдгийг улам сайн таньж мэддэг.

Үүний адилаар, бид өдөр тутмын ажлаасаа болоод завгүй, энэ хорвоогийн мэдлэгээсээ болоод завгүй байдаг, өч төчнөөн юм мэддэг гэж боддог, ингээд л бид хамгийн аугаа нь гэдгээ мартчихдаг. Бид үүнээс ч ихийг мэднэ. Бид энэ зүйлсийг мэдэхийн сацуу энэ бүх зүйлээс ч бүр дээгүүр зүйлсийг мэднэ. Тэгэхлээр, хамгийн аугаа Хүч чадал, аугаа билиг ухаан бол, жишээлбэл; нэн аугаа, нэн түгээмэл байдалтай, тийм аугаа их байдаг, харин дараа нь бид ийм аугаа билгүүн ухаанаа эгэл хорвоогийн мэдлэгээс ялихгүй жаахныг ойлгоход л ашигладаг. Жишээлбэл, анагаах ухааны мэдлэг, хууль зүйн мэдлэг, эсвэл нэг тиймэрхүү зүйлд суралцчихаад түүнээсээ зууралддаг. Бүхэл бүтэн билиг ухааныг бид танин мэдэхүйн ердөө энүүхэн буланд анхаарлаа

хандуулахад л ашигладаг. Тийм учраас бид бүхэл бүтэнг мартдаг. Миний хэлж байгаа санааг ойлгож байна уу? Ийм л байна. Ийм байтлаа бид өөрийгөө их мундаг болчихлоо, бид бол ийм ч эмч доктор, тийм ч эрдэмтэн доктор цолтон гэх мэтээр боддог. Би таны тухай яриад байгаа юм биш. Би энд “бид” гэж хэлэхдээ өөрийгөө ч бас багтааж байгаа шүү. Оршөөнө үү!

Тэгэхлээр, одоо бид өөрсдийгөө маш их юм мэддэг гэж бодож байна. Бид бол үзэсгэлэнтэй сайхан, бидэнд энэ ч, тэр ч гэрчилгээ байгаа гэж боддог. Яг үнэндээ хорвоогийн иймхэн мэдлэгийн төлөө аугаа билгүүн ухааныхаа бүхэл бүтэн 99.9999 хувийг нь гээчихсэн байна. Эцсийн эцэст бид юу ч үгүй үлдэнэ, яагаад гэвэл энэ мөнхийн бус; энэ мэдлэг өөрчлөгддөг. Анагаах ухааны олон тодорхойлолт дүгнэлт, эсвэл олон эм хоцрогдож хуучирсан нь батлагдан, өөр нэгнээр солигдсоныг бид мэднэ. Эсвэл шинжлэх ухааны баримт сэлт үргэлж өөрчлөгдөж, хаягдаж, өөр нэг санаагаар солигддог. Цаашдаа хүн төрөлхтөний ухамсар өндөрт дэвшин хөгжих явцад ч ахин дахин солигдсоор байх болно.

Тийм учраас, бид энэ дэлхийгээс, судлан шинжлэх тархины хүчээрээ хичнээн их мэдлэг олж авсан байлаа ч тус нэмэргүй; бидэнд бүхэл бүтэн зүйл нь буюу орчлон дахь ердөө ганц жижиг цэг нь байхгүй хэвээрээ л байх болно. Энэ нь аяганы доторх ус өөрийгөө асар том хэмээн бахархах аглаа өөрийгөө бүхэл бүтэн далай гэдгээ мэдэхгүй байхтай адил юм. Бүхэл бүтэн далайтайгаа холбогдох тэр цагт тэр өөрөө далай болно. Та бүхэн миний хэлж буй санааг ойлгосон болов уу гэж би найдаж байна.

### Лекцийн дараах асуулт, хариулт

А: Их Багш аа, яагаад Кришнамурти “Гүрү нар хийгээд шашин бол таяг юм” гэж хэлсэн юм бэ? Тийм учраас тэр шавь нарынхаа түшиг тулгуур байхаас татгалзсан.

Б: Та өөрөөс нь асуухгүй яасан юм? Би бусдын номлол айлдварыг хариуцахгүй. Хүн бүхэнд өөрөө мөрдөн баримталдаг, өөрийн гэсэн бие даасан сэтгэлгээ, гүн ухаан байдаг.

Магадгүй, түүний хэлэх гэсэн санаа нь хэрвээ шашны ягшмал үзэлд, эсвэл ерөөс аль нэг багшид хэт их хүлэгдэх юм бол та эрэмдэг болно гэсэн санаа байх. Энэ утгаараа бол тэр зөв. Багш хүн, эсвэл Их Багш гэдэг нь та түшиг тулгуурт нь дулдуйдах төдий тийм нэг хүн биш, харин та цаашдаа өөрөө алхахын тулд туршлага, билиг ухаанаас нь суралцах ёстой тийм нэгэн юм. Ихэнх тохиолдолд хэрвээ ажлаа сайн хийдэг багш бол шавьдаа ийм л арга замаар зааж сургавал зохино.

Гэхдээ санаа зовох хэрэггүй! Тэр бүү хэл, хэрвээ шавь нь өөрөө

бие даан хөгжих чадвар хараахан суугаагүй байгаа бол сүнслэг бясалгал дадуулж байгаа эхэн үе шатандаа Их Багшдаа залбирч болно. Хожим шавь өсөж хөгжөөд ирэхээрээ Их Багшийг аяндаа л орхино.

Хүн шиг л юм шүү дээ; цэх шулуун алхаж чаддаггүй хүн байдаг. Заримдаа хөл минь салганачихдаг тул явган алхахын тулд надад шүхэр хэрэгтэй болдог. Харин хөл зүгээр байвал хэрэглэхгүй. Заримдаа хүмүүс тохиолдлоор эрэмдэг болдог, эсвэл анхнаасаа эрэмдэг төрдөг тул тэдэнд таяг хэрэгтэй. Тэдний хувьд энэ нь хэвийн зүйл. Та түүнийг зүгээр л хөөж туугаад “Чамд суга таяг хэрэггүй. Энэ чамайг хараат болгочихно!” гэж хэлж чадахгүй, ойлгож байна уу? (Хариулт: Тийм.)

Тиймээс, бид “Их Багш, Гүрү, эсвэл шашин хүмүүст ямар ч ашиггүй” гээд шуудхан хэлчихэж болохгүй. Хэн нэгэнд ашиг тустай л байгаа. Хэрэв өөрт чинь хэрэггүй бол тэр л биз. Хэрэгтэй байвал танд хэрэггүй болох хүртэл нь нэг хэсэгтээ үлдээнэ л биз.

Тиймээс би ямарваа туйлшрах зүйлийг огт заадаггүй. Миний бодоход, шашин олон хүний хувьд бас л тустай зүйл. Тэд наанадаж л ёс журамтай амьдрах арга замыг сурна. Тэд Бурхнаас эмээнэ; тэд үйлийн үрийн хуулиас эмээнэ, улмаар олон хүн сайн хүн болно. Би та бүхэнд үнэнийг л хэлж байна. Гэхдээ бид үүнийг эцсийнх нь биш гэдгийг мэдэж байгаа. Жишээлбэл, энэ физик махбодод байгаа Их Багш бол эцсийн үнэмлэхүй нь биш. Үнэмлэхүй нь Их Багшийн дотор буй, бас таны дотор буй! Их Багшаар дамжуулан та үнэмлэхүй дээдийг олно. Энэ бол хэвийн зүйл! Хэрвээ та үүнийг хараахан олоогүй байгаа бол танд тусалж, таныг нэг хэсэгтээ өргөөд явах Их Багшийг найдан түшиглэ, улмаар та алхаж чаддаг болно. Энэ сайн хэрэг. Гэхдээ ерөөсөө юм бүхнийг нэг дор хаячих тийм туйлшрал гэж байхгүй. Тийм биш үү? (Алга ташив)

А: Их Багш аа, хүн төрөлтөн энэ газар Дэлхий дээр оршоод хэр удаж байгаа вэ?

Б: Пээ! Би хуруугаараа тоолж үзэх болж байна уу. (Ин(ээлдэв.) Хэр удаж байгааг нь та нар мэдэх үү? Хэр удаж буйг нь мэдээд бид яах гэж? Өдөр бүр ажлаа хийж байвал их юм! Энэ бол асар их, үлэмжийн их урт хугацаа шүү дээ. Зарим нь дахин төрсөөр байгаа. Зарим нь гэтлэгдчихсэн. Зарим нь ахин дахин буцаж ирсээр байдаг. Тэгэхлээр, хэрвээ та үүнийг тоолох гэвэл маш хэцүү. Олон галав өнгөрсөн гэж л та хэлж болох юм.

А: Чин Хай Их Багшаас авшиг хүртсэнээр тухайн хүн бусад Гүрү, ном айлдвараас татгалзах хэрэгтэй юу? Хэрэв хүн авшиг хүртээгүй ч гэсэн урьдынх шигээ Чин Хай Их Багшид залбирч, тэгээд бас адислалыг нь хүртэж болох уу?

Б: Та өөрийнхөө дагадаг сургаал номлолыг, багшаа орхих албагүй; би үүнийг аль хэдийн хэлсэн; шашнаасаа ч бас татгалзах



албагүй. Жишээлбэл, би авшигтан; тэгсэн ч би Бхагавад Гита-г дурдан ярьсаар л байдаг. Библи, Буддизм болон бусад бүх зүйлийн тухай, бусад Их Багш нарын тухай, бүр эрг цагийн Их Багш нарын талаар ч ярьдаг. Тэгэхлээр би юунаас ч татгалзаагүй байна! Би харин ч урьд, одоо цагийн, магадгүй бас ирээдүй цагийн Их Багш нараас суралцаж, билиг ухаан болон мэдлэгээ улам баяжуулсан.

Та ирээдүйн Их Багш нартай орчлонгийн илүү дээд төвшинд уулзах боломжтой, яагаад гэвэл тэд энэ Дэлхийд хараахан залраагүй байна. Гэхдээ та бясалгаж байх үедээ ирээдүйн Их Багш нартай уулзаж, тэднээс суралцаж болдог. Тэгснээрээ та юу ч алдахгүй; зөвхөн хожно.

Хэрвээ та авшиг хүртээгүй атлаа Чин Хай гэдэг Их Багшид залбирах юм бол Тэр танд туслах эсэхийг би мэдэхгүй. Та Түүнээс тэр мөчдөө асуух хэрэгтэй. Магадгүй тэр мэдэх байх, эсвэл мэдэхгүй байж ч магад. Энэ нь та өөрөө хэр чин сэтгэлтэй гэдгээс, мөн үйлийн үрээс тань хамаарна.

А: Их Багш аа, би бясалгахдаа ухаан бодлоо эндээ төвлөрүүлж чадахгүй байна. Бодол санаа үсчиж, элдэв бодол үймэлдсээр байдаг. Би явал илүү сайн төвлөрч бясалгах вэ?

Б: Энэ хүн авшиг хүртсэн үү, үгүй юу? (Хөтлөгч: Та авшигтан уу?) Яагаад гэвэл би өөр өөрөөр хариулна. Энэ асуултыг хэн асуусан бэ? (Нэгэн хүн: Тийм.) Бид хамтын бясалгалд очиж байх хэрэгтэй байдгийн учир нь энэ. Яагаад гэвэл төвлөрсөн хүч бидэнд тусалдаг, бас бидэнд цаг хугацаа хэрэгтэй. Зарим хүн тэр дорхноо төвлөрч чаддаг; зарим хүн илүү урт хугацаа зарцуулдаг. Би урьд нь лекцэн дээрээ хэлж өгч байсан даа. Бас өөрийгөө уучил. Энэ дэлхий дээрх нөхцөл байдал бидэнд амар жимэр бясалгах, амгалан тайван сэтгэхэд таатай байдаггүй ч ахин дахин хичээгээрэй. Энэ дэлхий бидний хувьд нэн хэцүү бэрх учраас Бурхан биднийг олон дахин, ахиухан адисладаг нь бидэнд давуу тал болдог. Тиймээс биднийг ганц алхахад аугаа их Хүч бидэнд туслах гэж зуун алхам хийдэг юм.

Бид хэрвээ диваажинд байх үед бясалгавал тийм ч ашиг тустай биш. Тийм учраас, диваажинд хэрвээ бясалгахыг хүсвэл бүр урт хугацаа зарцуулдаг. Жишээлбэл, бид энд зөвхөн ганц хоног бясалгах нь диваажингийн зуун өдөртэй дүйцнэ. Тиймээс олон охин тэнгэр, тэнгэрийн оршихуйнууд илүү түргэн бясалгахын тулд хүний биеийг авч төрөх дуртай байдаг. Үүний учир нь энд бидэнд үйлийн үр, нөхцөл байдал, байгалийн гамшиг, дайн байлдаан, жаргал зовлон гэхчлэн холилдож хугалдсан элдэв янзын “үрэн таран хийгч” хүч байдаг. Нэг ёсны биднийг хатуужуулах шатам халуун гал юм. Энэ бүх гал биднийг хүчирхэг, өөрсдөд маань болон дэлхийд хэрэгтэй багаж хэрэгсэл болгон хувиргадаг.

Бид энд хамтаараа бясалгал дадуулж байхдаа ойр дотныхондоо

туслах боломж олддог, тиймээс бид бас илүүхэн буян хишиг хураадаг. Жишээлбэл, та гэртээ ганцаараа бясалгавал танд зөвхөн өөрийн тань л буян ирнэ. Харин зүтгэл чармайлт, эсвэл уран цэцэн үгээрээ өөрийнхөө байрыг жишээлбэл, зуун хүний бясалгалд зориулж санал болгон өгвөл өөрийнхөө хувийн буян дээрээ ахиад зуун буян нэмнэ. Тиймээс та ахиад зуу дахин хурдан түргэн болно. Эсвэл та ахиад зуун хүнийг авшиг хүртэхээр ирэхэд хүргэвэл энэ буян ч бас таных юм. Учир нь бид нэгдмэл нэг; бид хичнээн олон хүнтэй харилцахын хэрээр буяны талаасаа улам тэлж, улам аугаа болдог. Тооны ухааны үүднээс бол ийм байна.

Тиймээс диваажинд байхаас илүү дээр. Диваажинд бүгд цагийг сайхан өнгөрүүлдэг тул тэд сэтгэл амар байдаг. Тэдэнд төвлөрүүлэх гэж түлхэж сэрээгээд өгөх сэдэл байдаггүй. Тийм учраас та гүн гүнзгий гуниг харуусалд автсан, эсвэл цөхрөнгөө барсан үедээ илүү сайн залбирдаг, бас заримдаа арай дээр бясалгадаг гэж би хэлдэг юм. Тэр мөчдөө та Их Багшийг дурсан санах нь илүүтэй байдаг; та “Ээ, Их Багш минь гуйя, гуйя, гуйя...” гэдэг. (Инээлдэв.) Тэгэхлээрээ л тэр өдөртөө ахуй ойлголт тань дээрдэж – илүү их Гэрэл, илүү хүчтэй Аялгуу хүртэж, эсвэл сэтгэл санаа тань улам дээрдэж, Бурханд илүү ойртсон байдаг. Тэгэхээр хэцүү бэрх хэдий ч энэ дэлхийд бясалгал дадуулах нь сайн хэрэг.

Манай олон авшигтан маш хичээнгүй бясалгадагт би талархдаг. Зарим нь зүгээр л сониучирхаж харах санаатай бясалгалын Төвд ирдэг, харин бүгд нүдээ аниад суучихдаг тул сүүлдээ тэд удгал сониучирхаж харах юмгүй болдог доо. Тэгээд хэсэг байзнаад эвгүйцэж ичээд бас л нүдээ аньдаг. Ингээд тэд гадаа хөөрхөн охидыг харахын оронд өөрийнхөө дотор талд ямар нэг зүйл хардаг. Тийм учраас хүмүүс цуглаад нэг ижил зүйл хийх буюу төвлөрч, Бурхныг нэгэн үзүүрт сэтгэлээр дурсах газар, сүм хийд, эсвэл бясалгалын Төвтэй байх нь маш сайн давуу тал юм. Энэ маш их тустай.

Тиймээс та яарах хэрэг юун. Та хэсэг зуур хараа бэлчээнэ л биз, тэгээд уйдахаараа нүдээ аниад бусадтай хамт бясалгаарай. Оюун ухааныг жолоодох амаргүй, бид өдөр бүр бясалгах хэрэгтэйн учир нь энэ. Тийм биш байсан бол би та нарт “Авшиг хүрт, тэгээд л та Будда. Өөр хийх юм байхгүй!” гэж хэлэх байсан. Тийм биз? Бидний дадал зуршил урт настай байдаг учраас тэр. Маш олон мянган жил, бүр үүнээс ч урт хугацаа өнгөрсөн байх! Тиймээс энэ бүхнийг бүрэн цэвэрлэхэд бүх насаа зориулах нь хүнд бэрх хөдөлмөр хэдий ч үнэ цэнэтэй байх болно. Эсвэл та үүнийгээ үргэлжлүүлэх гэж эндээ ахиад мянган жил үлдэх юм уу? Яая гэхэв, зугаатай л юм!

Тийм учраас би танд уртхан цагаар, хоёр цаг гучин минут, эсвэл гурван цаг бясалгах хэрэгтэй гэж хэлдэг, учир нь эхний хорин минутад та зүдэрнэ. Зүгээр л үргэлжлүүлээд бай, эхний хорин минутын дараа

та тайвшран зүгширч эхэлнэ. Хагас цаг өнгөрөхөд танд таатай сайхан болж эхэлнэ; дөчин минутын дараа та тасарчихна. (Инээлдэв.)

А: Хүн төрөлхтөн ямар зорилгоор ийм хэв маягаар амьдрах гэж бүтээгдсэн бэ? Хүмүүн хэлбэртэй амьдрал Ертөнцийн өөр гараг дээр байдаг уу?

Б: Тийм ээ, бусад ертөнцөд, бусад гарагт хүний амьдрал байдаг. Ямар зорилготой вэ гэж үү? Би мэдэхгүй. Үүнийг та дээш очихоороо Бүтээгчээс өөрөөс нь асуух хэрэгтэй. Би нэг их асуулт тавьдаггүй учраас Түүнээс хэзээ ч асууж байгаагүй. Би чимээгүй талдаа хүн.

А: Эргэн тойрны нөхцөл байдал, амьдралыг огоорохыг нэн хүчтэй хүсэмжлэх үедээ зовлон зүдүүр, эмзэг хөндүүр сэтгэл хөдлөлөөс хэрхэн ангижрахаа бид яг зөв цагтаа хэрхэн мэдэх вэ? Гэхдээ бас энэ амьдралд орхичиж чадамгүй хэн нэгнийг гэсэн хайр, бидний холбоо барилдлагатай байдаг хүмүүсээс шалтгаалаад үүнийг ойлгоход, бас зөвхөн өөрсдөөс минь гадна ямар нэг бүр илүү зүйл байдаг гэдгийг ойлгоход төвөгтэй байдаг.

Б: Би зүгээр л өөрийгөө уучлаад дахин чармай гэж хэлсэн шүү дээ. Хааяа бид зарим нэг нөхцөл байдалд өөрийгөө захирч чаддаг ч маш их хүчин чармайлт гаргадаг, бусад тохиолдолд бид өөрийгөө хянахыг хүсдэггүй, эсвэл чаддаггүй. Аль ч тохиолдолд та яг тухайн мөчид өөрт хэрэгтэй зүйлээ л хий. Сэтгэл хөдлөлийн тухайд тэгж их санаа зовох хэрэггүй. Энэ нь ердөө л далайн гадаргуу дээрх давалгаа л юм. Энэ чинь далай тэнгисийн буруу биш. Салхинаас л болсон хэрэг. Чухамдаа бол дэлхийн бөмбөрцгийн эргэлт л давалгаа үүсгэдэг. Тиймээс далай өөрийгөө давалгаа үүсгэн завь, бас хүмүүст төвөг удлаа гэхчилэн үргэлж буруутгаж чадахгүй. Далай өөрөө өөртөө тусалж чадахгүй. Далай өөртөө гэдэг нь эр, эм аль хүйсээр хэлэгдэх үг билээ? (Хөглөгч: Хүссэнээрээ нэрлэ.) Бид хэзээ ч мэдэхгүй. За яахав, тэр эмэгтэй болог л дээ, яагаад гэвэл би Чин Хай учраас. “Чин Хай” гэдэг нь ариун далай гэсэн утгатай.

Үнэндээ үүнийг Энэтхэгт хүмүүс Вишудананда гэж нэрлэдэг. Би олон америкчуудын анхаарлыг татахын тулд нэрээ Энэтхэг нэрээр солимоор ч юм уу. Нэгэн америк авшигтан нэг өдөр надад “Америкчууд чинь зөвхөн Энэтхэг багш нарт л дургтай байдаг юм, тийм болоод л та тэднийг олноор нь татаж чадахгүй байгаа хэрэг. Та зөвхөн Ау Лак, бас Ази хүмүүсийг л өөртөө татаж байна” гэж хэлж билээ.

Би “Тийм байх нь! Нэрээ өөрчилмөөр ч юм уу?” гэв.

Тэр “Танд ингэхэд Энэтхэг нэр байдаг уу?” гэв.

Би “Байлгүй яахав – Вишудананда гэдэг” гэж хариулсан. (Их Багш болон бүгд инээлдэв.)

Энэ нь миний нэрийн орчуулга. Ямар нэг “Ананда”, “Да, Да, Да” байхад л болчихно. (Инээлдэв) Энэтхэгжүү сонсогдоно. (Алга ташив)

Одоо та нар намайг Ананда, Вишудананда гэж дуудаж болно. Тун Энэтхэгжүү сонсогдож байна, тийм ээ?

А: Бид өдөр тутмын амьдралдаа сэтгэлийн амар амгалан, эсвэл аз жаргалд хэрхэн хүрэх вэ?

Б: Аажмаар. Авшиг хүртсэний дараа бид Бурханаас улам их мэргэн ухаан, амар амгалан, ивээл хүлээн авах тусам амьдрал маань төдий чинээ амар амгалан болно, гэхдээ гагцхүү та Их Багш болохгүй л бол тэр шүү. Хэрэв та Их Багш болохыг хүсэж байгаа бол би танд амар амгалан амьдралыг амлаж чадахгүй. Гэхдээ та шавь бол бүх зүйл төгс байх болно. (Алга ташилт)

А: Эрхэм Их Багш аа, би үргэлж л нэг л янзын, хүсдэггүй алдаагаа давтаад байдаг. Миний дотор сайн, муу гэсэн хоёр тал байх шиг санагддаг. Би үүнийг яаж зогсоох вэ?

Б: Яахав, энэ нь таны амьдралд байгаа суралцвал зохих тэнцвэрийн харьцаа байх. Үнэнийг хэлэхэд бид цаг үргэлж дэндүү сайн байх боломжгүй. Та эвдэрч хэмхэрнэ шүү! Циркчин олсон дээгүүр явахдаа нэг энэ тал руу, бас дараа нь нөгөө тал руугаа явах хэрэгтэй болдог. Нэг удаадаа энэ тал руугаа, нөгөө удаад нь тэр тал руугаа хазайдаг. Харин ингээд л чигээрээ алхаад байвал тэр унана. Энэ амьдрал гэдэг чинь юутай ч хоёр талтай: нэг нь эерэг, нөгөө нь сөрөг; нэг нь жаргал, нөгөө нь зовлон. Заримдаа бид нэг талаас нөгөө тал руу хазайхад өөртөө тусалж чадаггүй. Зүгээр дээ! Өөрийгөө уучил. Боломжтой бол ахиад оролдоод үз; чадахгүй бол өөрийгөө уучил.

Хэрэв муу гэж бодож байгаа бол тэр зуршилдаа эсрэгцэх, өөр няцаах зүйлийг хий. Жишээлбэл, ер нь бол та харамч, хүнд юм хялайлгах дургүй бол одоо бусдад өглөг өгөхийн төлөө өөрийгөө дайчил. Бусдаас авах хүсэл төрөх болгонд оронд нь бусдад өг! Ингээд дараагийн удаа дахин авах хүсэл тээж зүрхлэхгүй, учир нь та авахыг хүсэх болгондоо бизнесээ алдана. (Инээлдэв.)

Жишээлбэл, хэрвээ та нэг доллар авах хүсэлтэй байвал хоёр доллар өгөх гэж өөрийгөө хүчил. Эсвэл та ер нь эхнэрээсээ өөр эмэгтэйг харах дургүй байгаад байдаг юм бол ингэж хүсэх бүртээ гэртээ хариад гэргийгээ л хар. Тэгсээр байгаад дараагийн удаад та залхаж, дахиж хүсэхээ болино. Та үүнийг туршаад үзэж болно шүү дээ. (Алга ташив.)

А: Зарим шашин дэлхийн төгсгөл ирж байна гэж ярих боллоо. Энэ үгийн жинхэнэ утга нь юу вэ?

Б: Нэг ч шашин хэзээ ч ингэж хэлээгүй!

А: Зөвхөн Христийн шашин, тийм үү?

Б: Юу? Христийн шашин тэгж хэлдэг юм уу?

А: Би Библийг хэлж байна.

Б: Библид биднийг 2000 онд мөхнө гэж хэлээгүй. Библид ердөө л дэлхийн ямар нэгэн сүйрлийн тухай илчлэлт л байдаг, гэхдээ энэ нь

зөвхөн нэг хүний л бясалгалын ойлголт юм. Бас бид, зарим хүн хааяа нэг ийм ойлголтыг бясалгалдаа үздэг. Та ямар нэг сүйрэл амссан өнгөрсөн үе рүү нэвтрээд орчихдог, эсвэл урьд нь өмнөх амьдралдаа үзсэнийгээ одоо үзэж харчихаад харин яг энэ мөчид энэ Дэлхийд болох гэж байгаа зүйл гээд бодчихдог. Энэ үнэн биш. Магадгүй өөр одны орд, эсвэл өөр гарагийн төгсгөлийг харчихаад энэ дэлхийнх мэт бодож эндүүрсэн байх. Эсвэл та урьдын цаг үед болж өнгөрснийг харчихаад энэ цаг үеийнх гэж андуурдаг. Заримдаа та бүр хаа холын ирээдүйг харчихаад цаг хугацааг нь алдаж тооцоолж, одоогийн энэ цаг үе гэж боддог. Олон бошго зөгнөл хэзээ ч биелдэггүйн учир нь энэ.

Тун саяхан Китийн нэгэн хүн дэлхийн төгсгөлийг зөгнөж, тэгсэн атлаа хугацааг нь гурав дөрвөн удаа шилжүүлэн өөрчилсөн. Уул нь баасан гарагт болох байтал амралтын өдөр байсан тул Ням гараг болгосон, тэгтэл Ням гарагт тийм юм болоогүй. (Алга ташилт)

Гэхдээ энэ хамаагүй ээ, ямар ч байлаа гэсэн биднийг үхэх үед дэлхийн төгсгөл ирдэг, тиймээс тэр өдөрт л бэлтгэ. Энэ дэлхийгээс явахдаа үхлийн сахиулсан тэнгэртэй бус, Бурхантай хамт явахад бэлтгээрэй. Энэ чинь л манай дэлхийн төгсгөл болох болно.

А: Энэрэн нигүүлсэхүй болон яг одоо дээрээ анхаарал сэрэмжтэй байх хэмээхийн хооронд ямар хамаарал байдаг вэ?

Б: Яг одоо дээрээ анхаарал сэрэмжтэй байх гэдэг нь сайтар төвлөрнө гэсэн үг. Энэрэн нигүүлсэхүй бол та бусад хүмүүсийг хайрлана гэсэн үг. Энэрэн нигүүлсэхүй гэдэг бол та өршөөх сэтгэлтэй, бусад оршихуйг хайрладаг, амьтдыг хайрладаг, хүмүүсийг хайрладаг байх явдал юм. Та тэдэнд гэм хор хүргэхийг хүсэхгүй. Тэднийг гачигдаж байхад нь та туслахыг хүснэ. Энэ бол энэрэл нигүүлсэхүй. Яг одоо дээрээ анхаарал сэрэмжтэй байх гэдэг нь та бясалгах үедээ хүрсэн төвлөрлийн дэс төвшин юм.

А: Таны түрүүн хэлснээр бол хэрвээ оюун ухаанаа орчлон руу нээн тэлбэл билиг ухаан, эрдэм мэдлэг олж аваад ямар ч номыг ойлгох чадвартай болох юм байна. Танаас асуух зүйл гэвэл: Хэрэв та оюун ухааны хувьд тийм ч гялалзсан биш төрсөн бол яах вэ? Оюун ухаанаа нэгэнт нээчихсэн бол орчлон ертөнцөөс мэдлэгийг хэрхэн олж авч чадах вэ?" Шинэ мэдлэгийг судлахад цаг хугацаа, шаргуу хөдөлмөр шаардана. Миний хувьд урьд өмнө нь мэргэжилтэн болохыг хичээсэн. Гэсэн ч ухаан муутай учраас бүтэлгүйтсэн. Та надад арга зам зааж өгч болох уу?

Б: Сургуульд юм сурах боломжгүй байх нь тэнэг гэсэн утга биш. Танд эр зориг дутагдсан байж болно, сайн багш, сайн найз нөхөд, сайн орчин байгаагүй, эсвэл таны тэвчээр дутагдсан байх. Зарим хүн хурдан суралцдаг ч зарим нь энэ бүхнийг удаан сурч эзэмшдэг, гэхдээ энэ нь ухаан муутай гэсэн үг биш; та тэнэг гэсэн үг биш. Өөрийнхөө аугаа

билиг ухааныг мэдэхгүй байх чинь л жинхэнэ тэнэглэл. (Алга ташилт.)

Тиймээс би таныг авшиг хүртээрэй гэж урьж байна, тэгээд өөрийнхөө аугаа чанарыг мэдэж ав, тэгвэл л та олон зүйлийг ойлгоно. Учир нь миний хэлж байгаа бүхэн ердөө л хоосон үг, чалчаа яриа. Ямарваа туршлагаар батлаагүй бүх зүйл бол ердөө л зар сурталчилгаа. Би аягандаа байгаа амтат жүржийн шүүсийг их сайхан, шим тэжээлтэй, танд ач тустай, С амин дэмээр баялаг, уувал цангаа тайлна гэж хичнээн ч хэлж болно. Харин та хүрч ирээд үүнийг ууж үзэхгүй л юм бол би хичнээн ярьсан ч нэмэргүй, бүгд чалчаа яриа. Дэмийрэл! Чалчаа үг. Тэгэхлээр, зүгээр л уучих нь л хамгийн зөв. Гэгээрэлд хүр! (Алга ташилт)

А: Би нэг л төөрөлдчихлөө. Би эрж хайсаар байгаа ч Гэрээ олоогүй байна; би хэн байх ёстой, юу хийх ёстойгоо олоогүй гэсэн үг л дээ. Дэлхий дээр, яг энд Гэрээ яаж олох вэ?

Б: Гэгээрлийг олж ав. Гэр маань маш ойрхон байгаа. Дэргэд чинь. Таны арьснаас ч илүү ойрхон байгаа. Гэхдээ хэрвээ танд Гэрэл байхгүй бол та түүнийг харж чадахгүй. Та харанхуйд юм хардаггүй тул хичнээн ойрхон байлаа ч нэмэргүй. Энэ нь юу юм гэдгийг та мэдэрч байсан байж болох ч та үүнийг харахгүй – та Гэрэлтэй байх ёстой. Бурхны гэрэл таны эрж хайхыг хүссэн бүх зүйл дээр, тэр дундаа Гэр дээр чинь тусаж гийгүүлдэг. Гэвч энэ бүхэн нь хийсвэр эргэцүүлэл бодол, үнэн хэрэгтээ бол танд туршлага хэрэгтэй, харин энэ нь гагцхүү авшиг хүртэж, хичээнгүй бясалгаснаар л танд ирнэ. Та хэрхэн бясалгахаа мэдэж ав, тэгээд бясалга, ингэж байж л та өдөр ирэх тутам ухаарч ойлгох болно.

А: Шашны ном сургаалтай, бас эртний Их Багш нартай байсаар ирсэн атлаа ийм олон жилийн хойно ч дэлхий яагаад дээрдээгүй, харин ч бүр дордсон байна вэ?

Б: Учир нь эртний Их Багш танд зааж сургах боломжгүйгээс тэр. Та асуултад тань хариулж, эргэлзэхэд чинь тусалж, таныг гар дээрээ өргөөд Бурхны Оронд аваачиж чадах, өнөө цагийн Их Багшийг эрж олох ёстой. Бидэнд урьд өмнөх амьдралын биш, харин амьд хүмүүсийн харилцаа хэрэгтэй. Үүн шиг, эрт цагийн сайхан бүсгүйчүүд хичнээн аугаа байлаа ч та түүнтэй гэрлэж чадахгүй! Тэр бүсгүй танд хүүхэд төрүүлж өгч чадахгүй; амьд гэргийгээс амсдаг хайрын мэдрэмжийг танд өгч чадахгүй.

А: Манай Христийн гол сүм надад Есүст ч биш, ариун Мария-д ч биш, тэнгэр элч нарт ч биш, хэнд ч, юунд ч биш, зөвхөн Бурханд, Есүсийн Эцэг, ертөнцийн Бүтээгчид л залбирах ёстой гэж заасан. Хүмүүс тэгвэл яагаад Их Багшийн хувьд Танд, эсвэл аль нэг Их Багшид залбирдаг юм бэ?

Б: Мэдэхгүй юм даа. Энэ нь тэдний өөрсдийнх нь хэрэг. Үүний өмнөхөн нэг хүн авшиг хүртэхийг хүсэхгүй байна гэсэн, энэ нь тэр

Бурхантай шууд холбоо тогтоохыг хүсэхгүй байна гэсэн үг. Тэгсэн атлаа Чин Хай Их Багшид мөргөж болох уу гэж асуусан. Би үүнийг яах билээ? За яахав, тэр эмэгтэй залбирвал хариултаа хүлээж авна, тэгээд залбирлаа үргэлжлүүлнэ. Харин би бол та нарт явж авшиг хүртээд Бурхантай шууд холбогд, тэгээд шуудхан л Бурханд өөрт нь залбир гэж дандаа зөвлөдөг. Энэ бол хамгийн шилдэг арга. Гэвч хэрвээ хэн нэг хүн энэ замыг сонгохыг хүсэхгүй, харин хоёрдогч арга замыг, илүү гялбар замыг сонгохыг хүсээд – ургамал хоолтон болохгүй, хоёр цаг хүчин минут бясалгахгүй, зарчим дүрэмгүй, юу ч хийхгүй, зүгээр л ач тус хүртэх хүсэлтэй байна гэж байгаа бол тэр эмэгтэй өөрт нь ямар нэг юм өгдөг хэнд ч хамаагүй залбирна л биз. Тэр Есүст, Бурхан багшид залбираад тусыг эс олж л дээ, тийм учраас л тэр Чин Хайд залбирчээ. Тус хүртчихвэл тэр үргэлжлүүлэн залбирсаар байх аж. Хүмүүс ийм л байдаг, тэд ашиг хүртэх л дуртай. (Алга ташилт.)

Мэдэж байна уу, аливаа амьд сэрүүн Их Багш бидний залбиралд хариу өгдөг нь үнэн шүү. Гэтэл тэр Их Багш жанч халчихсан хойно ч хүмүүс бас л түүнд залбирсаар байдаг, яагаад гэвэл тэд эцэг эхээсээ, өвөг дээдсээсээ үүнийг сурчихсан хэрэг. Тэд залбирахаа үргэлжлүүлсээр байдаг, яагаад гэвэл амьд сэрүүн Их Багш болон эртний Их Багшийн ялгааг мартчихдаг. Тийм учраас л урьд цагийн Их Багш нарт үргэлжлүүлэн залбирдаг, заримдаа өөрт нь тусалсангүй гэж тэднийг буруутгадаг.

Гэвч үнэн хэрэгтээ бол аль нэг Их Багшид залбирах үедээ та тэртээ тэргүй Бурханд л залбирч байгаа гэсэн үг. Их Багш бол Бурхантай холбогдохсон байдаг учраас, та зүгээр Бурханд л залбир. Тэр дотор чинь Бурхнаас өөр юу байгаа гэж? Та Чин Хайд залбирдаг гэж боддог уу? Чин Хай гэдэг чинь хэн юм бэ? Та Түүнийг бодох үед Тэр эмэгтэй хэн юм бэ? Энэ юу юм бол? Тэр эмэгтэйн биед зөвхөн Бурхан л оршиж буй; тэнд үүнээс өөр юу ч байхгүй! Тэгэхлээр, та Бурхантай холбогдохсон Тэр эмэгтэйд залбирлаа гэхэд таны залбирч байгаа чинь Бурхан л юм. (Алга ташилт.)

Хөтлөгч: Эцэг, эхийнх нь нэг нь нөгөөдөө бясалгахыг зөвшөөрдөггүй гэж байгаа нэг хүн хүндэтгэх шалтгааны улмаас эцэг, эхээ салгах нь буруу эсэх, энэ үйлдэл нь үйлийн үрд хамаарах уу, үгүй юу гэдгийг мэдэж болох уу? гэж асуужээ. Хэрэв тэр энэ бясалгалыг дадуулбал тэднийг салгасан буруу үйлдлийг нь засах уу?

Б: Зүгээр дээ, та цаг хугацаанд даатгаад орхичих. Эцэг, эхийнхээ асуудалд бүгч санаа зов. Та санаа зовох хэрэггүй, яагаад гэвэл цаг нь ирэхээр юм бүхэн өөрчлөгддөг. Цаг нь болоогүй байхад асуудлыг хүчлэх юм бол та асуудалд орно, заримдаа та мэдээжээр, үйлийн үр тарьчихна.

А: Аяганд байгаа ус бол далайдаа байгаа устай ижил ч бид би гэх үзлийнхээ улмаас аяган дахь усыг далайгаас тусгаарлачихдаг гэж Их

Багш хэллээ. Бясалгал нь усыг далайтай нийлүүлдэг нэг нүхийг аяганы ёроолд гаргаж өгдөг гэсэн үг гэж ойлгох нь зөв үү?

Б: Авшиг тийм утгатай. Тийм! Нийлүүлэн нэгтгэдэг нүхийг нээдэг, тиймээс ус байнга орж гарч чадна. Тиймээс, аяганд байгаа ус бол далайд байгаа ус гэсэн үг, далайд байгаа ус бол аяганд байгаа ус гэсэн үг. Та өдөр бүр бясалгаж байх үед ус ямагт орж гаран шинээр сэлбэгдэх тул аягатай ус муудахгүй.

А: Хэрхэн бясалгавал зохих вэ?

Б: Та хүссэнээрээ л бясалга. Хэрвээ та мэдэхгүй байгаа бол ирээд авшиг хүрт, бид танд тусална. Үнэн хэрэгтээ надаас ямар ч асуулт асуухын хэрэг огт байхгүй! Учир нь та хэр олон хариулт авах нь чухал биш, юунд хэрэгтэй гэж? Хамгийн шилдэг арга зам бол гэгээрлийг хүртээд бүх хариултыг мэдчих эсвэл ерөөсөө ямар ч хариултыг сонирхохоо болих тийм төлөв байдалд хүрэх явдал юм. Тэгсэн цагт бид ямарваа сониучирхал, юмыг мэдэж авах гэсэн хүсэл шуналаас өөрийгөө үүрд бүрэн чөлөөлнө. Ингэсэн цагт л бид юм бүхнийг мэдэгч байдаг юм. Бид мэдэх хэрэгтэй гэсэн бүхнээ тэр дорхноо мэдчихнэ, мэдэх шаардлагагүй зүйлийг харин дотооддоо бас л мэдэж байдаг, бид үүнийг ашиглаж хэрэглэхгүй.

А: Нөхөр маань арьсны тун айхтар өвчин тусаад найман жил болж байна. Би түүндээ үнэхээр их хайртай болохоор эмч домч, шашин, бясалгал, өвчнийг эдгээчих итгэл найдвар гээд бүх л арга чаргаа дайчиллаа. Одоо түүнийгээ харах бүрд нулимс урсдаг. Одоо бүр дордоод би их гуниглахаараа өөр эр хүнийг зүүдэлж эхэлсэн. Би их муу, үнэнч биш юм уу даа? Би явал оюун ухаанаа засаж, уйтгар гунигаа давж чадах вэ?

Б: Үгүй! Та муу биш. Ердөө л нөхцөл байдал муу байгаа юм. Ингэхэд, өвчин туссан хүн бүхэн эхлээд түүнийгээ хүлээн зөвшөөрөхийг хичээнэ, хоёрт анагааж эдгээх арга зам хайна. Анагааж эдгээдэг ямарваа арга зам байж л таарна. Юуны түрүүнд бид туслаач гэж Оройн Дээд Хүчинд залбирах хэрэгтэй. Бид залбирдаг л даа, гэхдээ гүн гүнзгий залбир. Заримдаа өвчин нь урьд насны үйлийн үр, урьдын хариу үйлдлүүд, урьдын өр төлөөс байдаг. Ямар нэг буруу зүйл хийсэн, эсвэл бусдын гадаад төрх байдалд гэм хор учруулсан учраас одоо ийм үр дүнг амсах болсон байдаг. Гэвч хэсэг хугацааны дараа, энэ үйлийн үр барагдвал байдал сайжирч эхэлдэг. Арьсны өвчнийг анагаах олон арга зам бий, тун муухай арьстай олон хүнийг би харж байсан, гэхдээ тэдэнд эдгээх эм тан байж л байдаг. Тэгэхлээр та хангалттай сайн эрж хайгаагүй байх. Та ингэхийн тулд олон арга замаар сураглах хэрэгтэй, эсвэл нөхөртөө өөрөө залбир, үгүй бол бясалга гэж хэлээрэй.

Авшиг хүртэх нь таны, эсвэл нөхрийн тань өвчнийг эдгээнэ гэсэн баталгааг би өгч чадахгүй. Учир нь хүмүүс ердөө л бие махбодынхоо

байдлаас болж манай бүлгэмд татагдахыг би хүсдэггүй. Энэ нь таныг гэтэлгэхэд хүрэлцэхгүй, яагаад гэвэл бид Бурхныг, газар дэлхийд бүхнийг өгөгчийг хүсэхийн оронд материаллаг зүйлээс зууралдсаар байдаг. Бид Бурхныг жинхэнэ ёсоор хүсэх цагт Бурхан өгнө. Хэрвээ бид ердөө л элдэв эд юм хүсвэл, юу гэж байгааг минь ойлгож байна уу, Бурхан заримдаа өгнө, заримдаа өгөхгүй. Энэ л төвөгтэй.

Энэтхэгийн нэгэн хаан харьяат албатууддаа хамаг юмаа өгөх дуртай байсан тухай нэгэн үлгэр байдаг. Тиймээс тэр хамаг эрдэнэсээ тойруулж тавиад хүмүүсийг хүрч ирээд аль дуртайгаа ав гэж хэлжээ. Хүмүүс очир эрдэнэ, алт, үнэт эрдэнэс, эртний аяга сэлтийг авч, машид баярлан гэртээ харьж гэнэ. Гэтэл ганцхан охин л юу ч авахыг хүссэнгүй. Охин шуудхан л хаанд дөхөж очоод “Та ч бас бэлэг мөн үү? (Инээлдэв.) Би энэ бэлгийг л авмаар байна” гэжээ. Ингэхэд нь, хаан мэдээжээр нэн гайхаж, бас өгч буй зүйлийг нь биш, өөрийнх нь төлөө өөрийг нь авахыг хүссэнд баярлажээ. Мэдээжийн хэрэг, хаан бүсгүйтэй гэрлэж, тэгэнгүүт бүсгүйд ч түүний бүх зүйл очжээ. Тэгэхгүй гэж үү? (Алга ташилт.) Ийм түүх байна. Та нар энэ үлгэр түүх мэддэг үү? Үүнийг батлах бас нэг өөр үлгэр ч байна.

Шивагийн тухай үлгэр. Шиваг мэдэх үү? Шива Бурхныг, ингэхэд тэр энд байна уу? (Их Багш ардаа байгаа тахилын ширээ рүү эргэж харав.) За, энэ байна, алман сар болон сэрээт таягтай. Шива бол эртний Их Багш нарын нэг. Түүнийг эвдлэн устгагч бурхан гэж үздэг байжээ. Тэр чухамдаа хүмүүсийг бус, нүгэл хилэнцийг л устгадаг. Зарим хүн үүнийг эндүүрч ойлгосон учраас Түүнийг өөрсдийг устгах вий гэж санаа зовнин Түүнийг элдвийн жимс, бялуугаар үргэлж хахуульдаж байдаг. (Инээв.) Тэр эрт дээр цагт Хималайн ууланд гүн төвлөрөн бясалгаж байжээ. Тэр бясалгалаасаа хэзээ ч сэрээгүй, огт үгүй. Түүнийг юу ч хөдөлгөж дөнгөөгүй. Энэ бол Энэтхэгээс гаралтай домог. Үнэн эсэхийг нь би мэдэхгүй. Би зүгээр л Бурхны хүчийн тухай та нарт хэлж өгч байна.

Тэр үргэлж Хималайн ууланд бясалгадаг байсан, маш гүн бясалгалд ороод огтхон ч хөдөлдөггүй байжээ. Гэтэл тэнгэрийн зарим бурхан тэнгэр түүнд эхнэр байхгүй, тиймээс хойчийн өөр үеийнхэнд ариун гэгээн үр, эсхүл ариун удам судар гэгчхмээр зүйлийг залгамжлуулан үлдээхгүй нь ээ хэмээн эмээжээ. Тиймээс тэд машид санаа зовжээ, яагаад гэвэл Тэр нэн ариун гэгээн байсан тул тэд ийм угсаа сурвалжтай өөр нэг хойч үеийг хүсэж байсан ажээ. Ингээд түүн лүү нэгэн маш гоо үзэсгэлэнт дагиныг илгээжээ. Түүнийг Парвати гэдэг. Тэр бол нэн үзэсгэлэн төгс, түүний уран гоолиг биеийг харсан эр хүн хөлд нь сөгдөж унамаар нэгэн аж. Гэвч бүсгүй түүнийг байрнаас нь хөдөлгөж дөнгөсөнгүй. Тэр түүнийг тойрч бүжиглэхээс авахуулаад хамаг л арга чаргаа барсан ч тэр бясалгалаасаа огт ангижирсангүй.

Ингээд тэр бүсгүй сүүлдээ залхсан учраас уулын нөгөө тал руу арай холхон явж, нэгэн уулын нурууг сонгож аваад бясалган суужээ. Тэр “Энэ бүхэн ямар дэмий балай хэрэг вэ! Би одоо Бурхныг бясалган гэтлэгдэж, мөнхийн цэнгэл жаргалд хүрэх минь. Ингэх нь мэдрэмжгүй, юу ч үгүй, чулуу шиг эрийн хойноос хөөцөлдсөнөөс хамаагүй дээр! (Инээв.) Би ийм үзэсгэлэнтэй байтал тэр огт хөдөлсөнгүй!” гэжээ.

Тэр бүр залхаж, уурлаж, гонсойсон учраас өөр уул буюу Энэтхэгчүүдийн сүсэг бишрэл ёсоор хамгийн алдартай, хамгийн ариун дагшин уул гэгддэг Кайлас руу явсан байж. Энэ уул маш өндөр бөгөөд хажууханд нь үзэсгэлэнтэй сайхан Мансаруар нуур бий. Ийнхүү тэрбээр тэнд үлдэн бясалгаж, хэсэг хугацааны дараа амарлин ахуйд хүрчээ.

Тэгтэл Шива гүн бясалгалынхаа үед гэнэт ямар нэг зүйл өөрийг нь өдөөн хөдөлгөөд байгааг мэдэрчээ. Ямар нэгэн маш хүчтэй, хүчирхэг эмэгтэйлэг энерги байлаа. Түүнийг тавгүйтүүлэх янзтай байв. Тавгүйтэхгүй гэтэл бас тавгүйцээд байж, гэхдээ тэр нь түүнд сайхан мэдрэмж төрүүлж, ямартаа ч догдлуулжээ. Тэгэхлээр нь, билгийн мэлмийгээ нээгээд харснаа “Пээ! Юу гээчийн үзэсгэлэн гоо вэ” гэжээ. Ингээд л дурлалын адал явдал эхэлж дээ. Цаашихыг нь та нар мэдэж байгаа.

Бясалгалын хүч, Бурхны Хүч ийм юм. Энэ хүч бүр бурхадыг ч шилгээдэг. Миний санааг ойлгож байна уу? Энэ хүч хамгийн хатуужилтай даяанч йогчийг хүртэл догдлуулсан аж. За яахав, хэрвээ та нөхөрт гарахыг хүсээд байгаа бол энэ нь сайн зөвлөгөө ч байж магадгүй. (Инээлдэв) Үнэндээ бол та хүсэхгүй байх үедээ л хүссэнээ хүртдэг.

Парвати түүний сэтгэлийг татах гэж хамаг чадлаараа хичээсэн ч чадаагүй, яагаад гэвэл тэр би гэх үзлээрээ, өөртөө өмчлөх гэсэн мөхөс хүчээрээ, хорвоогийн эгэл доорд сэтгэлгээгээрээ ингэх гэж оролдсон байна. Гэтэл бүсгүй өөрөө ариусан гэгээрэхэд сэтгэл татам байдал нь ч өөр болжээ. Яагаад тэр вэ? Шивагийн энергийн хэлбэлзэл нэн ариун, түүний стандарт хэм хэмжээ их өндөр байж л дээ. Хэрвээ бүсгүй түүнийг татахын тулд хорвоогийн жирийн хэлбэлзэл, энергиэ ашигласан бол тэр эр хүн яаж бууж ирэх вэ дээ? Өрсөлдөгчөө өөртөө татъя гэвэл та ядаж л түүнтэй эн тэнцүү болох хэрэгтэй.

Үнэндээ ийм л байдаг юм. Олон хүн бусдын сэтгэл татах юмгүй байснаа авшиг хүртээд хэсэг бясалгасны дараа хүмүүсийг өөртөө татаж эхэлдэг. Заавал бие махбодоороо татах албагүй, зүгээр л хүмүүсийг өөртөө татдаг. Хүмүүс зүгээр л тэдэнд дуртай болж, дэргэд нь байхыг хүсдэг. Энэ нь таны хэлбэлзэл, таны Хайрлагч Бурханлаг энергиэс болдог. Та үүнийг нууж дарж чадахгүй. Энэ нь зүгээр л гадагшаа цацарч, хүмүүсийг соронз адил татдаг, яагаад гэвэл тэдний дотор буй сүнс нь бас л бурханлаг. Тиймээс тэд танд зүгээр л татагддаг. Хүмүүс Их Багшид сэтгэл татагддаг шиг л танд татагдаад байгаагаа мэдэрдэг, гэхдээ

энэ нь ямар ч тохиолдолд таяг биш. Энэ бол ердөө л жинхэнэ Би чинь аугаа их Би рүү татагдаж байгаа хэрэг. Тиймээс хэсэг хугацааны дараа тэд хоёулаа нэгдмэл нэг гэдгээ ухаардаг. Тиймээс суга таяг авъя гэх хүн хэн л байгаа аж? Хэн нь хэндээ найдах гээд байгаа гэж? Тэгэхлээр энэ нь үнэн хэрэгтэй бас Их Багш болон шашныг таяг гэж үзэх үү хэмээх асуултын хариулт болж байна. Байдлаас шалтгаална. За юу? За, одоо үдийн хоолоо зооглоцгооё! (Алга ташилт)

## АМЬДРАЛДАА ӨНГӨ НЭМЖ СОЛОНГОРУУЛЪЯ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1994 оны 9 дүгээр сарын 29, (Дүрс бичлэг 446)  
Сингапур (Эх нь Англи хэлээр)

Зуун жилийн тэртээ хүмүүсийн амьдрал ямар аймшигтай байсан талаар би өнөөдөр сониноос уншлаа. Тэдний амьдрал өнөөдрийнх нь шиг ийм цэвэрхэн, ийм тав тухтай байсангүй, үнэн биз! Тэр үеийн хүмүүс машинаа моринд хөллөдөг байсан байх гэж бодож байна. Заримдаа өвлийн улирал маш хүйтэн тул адуугаа байшингийнхаа нөмөрт, эсвэл өөр жүчээнд байлгадаг байсан. Тэд үнэр танараар нь амьсгалахаас аргагүй болдог байжээ. Үйлдвэрийн газруудын утаа, орчны бохирдол хүмүүсийн эрүүл мэндэд аюул учруулж байжээ. Дээхэн үеийнхэн одооны хүмүүсийг бодвол арай залуугаараа нас бардаг байсан байна. Учир нь хүрээлэн буй орчин нь нэн бохир заваан, үйлдвэрийн янз бүрийн аюултай бодис, том компаниудын химийн хог хаягдлаар бохирдож байжээ.

Үнэндээ ердөө ганцхан зууны дотор л хүн төрөлхтөн бид бүх салбарт маш том алхам хийж, ахиц дэвшил гаргасан байна. Гэхдээ авто машинтай болсон одоо үеийнхээс ч илүү их зам тээврийн осол гарч байсан гэж гэд өгүүлжээ. Үүнд итгэхэд бэрх ч үнэн байж магадгүй, учир нь тэдний өгүүлснээр бол заримдаа морьд уяанаасаа алдуурч давхиснаас болж олон мянган хүн энддэг байжээ. Морьд заримдаа зам дээгүүр давхиж, хүмүүсийг өшиглөж тангардаг байжээ. Өнөөдөр ч бидэнд авто машины осол гэдэг зүйл байна, харин тэр цаг үед хүмүүс адуунаас болж осолд өртдөг байсан ажээ. Энэ бол үндсэн шалтгааны нэг нь.

Гэтэл бүр өдгөө цагт ч маш олон янзын өвчин хүмүүсийн амь насыг авч одсоор байна, жилд арван найман сая гаруй хүн янз бүрийн өвчнөөр үхэж байна. Яагаад гэвэл зарим хүн Дэлхийд ямар нэг зорилгоор, ямар нэг эрхэм чухал даалгавар гүйцэтгэх, түүнчлэн Хамгийг Чадагч Хүч чадлаа танин хэрэгжүүлэхэд зориулан Бурханаас заяасан үнэ цэнэтэй бие махбодоо хамгаалахын төлөө урьдчилан сэргийлэхгүй байна. Зарим зүйл, жишээлбэл, дэндүү их тамхи татаж, тэндүү их архи ууж, мөн мал амьтны махыг дэндүү их идэх болсноороо маханд байгаа

янз янзын нягт өөрийн эрхтэн системийн тогтолцоо руугаа оруулж байна. Энэхүү үхэлд хүргэгч бүх хүчин зүйл бидний амьдралыг, цаг үеийг маань аз жаргалгүй болгож байна.

Үнэндээ хэрвээ бид арай эмх цэгцтэй, журамтай байж, бие махбодоо үнэлж эрхэмлэдэгсэн бол улам сайхан амьдрах боломжтой. Хэрвээ бие махбодод маань шим тэжээлтэй хоол унд хүртэж, амттай болохоор нь биш, харин зохистой хэмжээгээр идэж ууж байх аваас бидний эрүүл мэндэд ноцтой хор хохирол учрахгүйсэн. Ихэнх ургамал (веган) хоолтон хүн улам л эрүүлждэгийг та нар харж байгаа. Тийм биш гэж үү? (Сонсогчид: Тийм) Та нарын ихэнх нь авшиг хүртэн ургамал хоол хүнсэнд шилжсэний дараа улам эрүүл болсон. Тийм биш гэж үү? (Сонсогчид: Тийм) Үнэн хэрэгтээ мах иддэг хүмүүс л эмнэлгээр дүүрэн байна шүү дээ. (Инээлдэв.)

Бид эндээс нотолгоо олоод харчихад асуудал алга. Ургамал хоол зөвхөн эрүүл хоол төдийгүй, энергийн хэлбэлзэл нь бие махбодод маш нийцтэй байдаг. Гэтэл амьтны хэлбэлзэл тийм ч нийцтэй биш, тийм ч амар амгалан биш. Үнэндээ эгэл жирийн, эрүүл амьдрах тийм хэцүү биш, харин ч маш амархан. Дэндүү их эм тан, дэндүү их тариа хэрэггүй. Олон хүн бие рүүгээ хортой бодис оруулснаас болж, өөртөө хор хөнөөл учруулж байна. Тэгдэггүйсэн бол, хэрвээ бид эгэл жирийн, шим тэжээлтэй, эрүүл амьдрах арга замаа мэддэг байх юм бол бидэнд эмчийн хэрэг үнэндээ алга. Эмч нар ч олон хоног амарчихна, аль аль талдаа эрүүл байх болно.

Тухайлбал, би маш их ажилладаг, бас жижигхэн хүн, тэгсэн ч гэлээ би хоол хүнс нэг их хэрэглэдэггүй, эсвэл тэгж их анхаарах цаг надад байдаггүй. Харин ургамал хоол хэрэглэдэг хэвээрээ байдаг нь намайг маш олон өвчнөөс аварч, эмчид зарцуулах асар их мөнгийг хэмнэж байна. Тийм бишсэн бол, үргэлж эмч рүү гүйгээд байдаг бол надад яршиг төвөгтэй. Би хааяа л аар саар зүйлийн улмаас эмчид үзүүлдэг. Та нарыг бодвол эмчид үзүүлэх минь ховорхон. Гадуурх хүмүүстэй миний биеийн хэмжээг харьцуулах юм бол. (Инээлдэв) Та бас миний биеийн хэмжээг бодолцох ёстой. Тийм, өөрийнхөө ажлыг хийлгэхийн тулд Бурхан болон Будда ерөөн адисалжээ.

Харин заримдаа, би ажлаа хийхгүй бол бас өвддөг, яагаад гэвэл дотоодод маань энерги нөөцлөгдсөн байтал гадагшлах боломж өгөөгүй учраас тэр. Тийм учраас та нар хүнд бэрх ажлаас битгий халшир. Та ажиллаж, энергийг зарцуулж байх ёстой, яагаад гэвэл хүний бие организм дотор ертөнцөөс энерги татаж авдаг долоон хүрд байдаг. Тэр хүрд бол ертөнцийн түгээмэл Хүчнээс аяндаа цэнэглэгддэг зай хураагуур шиг л юм. Тийм учраас л бид “машинаа” үргэлж ажиллуулж чаддаг хэрэг шүү дээ. Биднийг бясалгаж байх үед энэ Хүч бүр ихээр арвиждаг. Тиймээс бид хэдий чинээ их өгнө, төдий чинээ их орж ирдэг. Хэзээ ч зогсдоггүй.

Тиймээс бидэнд санаа зовох юм алга. Хүмүүст туслах болон үйлийн үрийн тухайд, эсвэл үйлийн үр тарьчихна гэх мэтээр тавгүйтэх хэрэггүй. Хэрвээ хүмүүст тус дэм хэрэгтэй байвал тусал.

Гол нь зөвхөн бусдын ухамсарт саад учруулах, жишээлбэл тэднийг хянаж цагдахыг завдах, эсвэл хувиа хичээх сэдлээр өөрийн хүссэн үйлдлийг хийлгэхээр тэдэнд хэлж заахыг оролдох үед л бид үйлийн үр тарьдаг. Тэгэхгүй бол, хэрвээ бид хүмүүсийг хайрлаж, бас хүнд хэцүү үед нь тэдэнд туслахыг хүсэж байгаа бол, бүр үйлийн үрээс нь үнэхээр авсан байлаа ч энэ нь нэг их ач холбогдолгүй. Энэ нь огтхон ч асуудал биш, яагаад гэвэл бид бие биеийнхээ төлөө өөрийгөө золиослох ёстой. Бид нэг нэгийгээ хайрлаж амьдрах ёстой, үйлийн үрийг бүү анхаар.

Бид заримдаа өнөөдрийнх шиг ийм зуушны газар зоогоор дайлуулдаг, энэ бас л маш сайхан. Та янз бүрийн хоол идэж, ямар амттай байгааг нь мэдэж болох төдийгүй бас хийх аргыг нь тэднээс асууж болох байх. Эсвэл хоолны, нарийн боовны хэдэн ном худалдаж аваарай. Энэтхэг, Хятад хоолны ном, ургамал хоолны ном олж аваад гэр бүлдээ амттай хоол хийж өгч, эрүүл байлгаарай, тэгээд тэднийг ургамал хоолтон болгоорой.

Ихэнх хүн ургамал хоол идэх дуртай. Гол нь тэдэнд амттай хоол олддоггүй учраас идэх боломжгүй байдаг. Тэд өдөр бүр салат, буурцгийн сүмс идээд байвал амьд байж тэсэхгүй. (Инээлдэв.) Тэгэхлээр, гэр бүл чинь ургамал хоол идэх дуртай биш бол хоол хийх авьяасаа хоцрогдсон эсэхийг шалгах хэрэгтэй. Хэрвээ хоол хийх арга барилд маань ямар нэг асуудал байвал хөршөөсөө асуу, том зоогийн газруудаас суралц, хоолны дамжааны багш нараас суралцах зэргээр түүнийгээ сайжруулж болно. Энэ маш амархан.

Үргэлж сэтгэл хангалуун байлгахуйц үр ашигтай хөтөлбөрөөр амьдрахыг хичээ. Амьдралаа хэзээ ч хий хоосон бүү өнгөрөө. Зүгээр л хүссэн бүхнээ хий. Шинэ зүйл сурахыг хичээ. Нээлттэй бай. Нийтэч бай. Найрсаг бай, хүн бүрд хайртай бай, бүх зүйлд нэг нэгнээсээ харилцан суралц. Хөдлөхгүй суучихаад л амьдралдаа, аз хийморьгүйдээ гаслаад байх хэрэггүй. Энэ амьдралд тийм золгүй явдал гэж байхгүй. Бид ямагт эерэг өөдрөг эрч хүчийг тээж явах ёстой, яагаад гэвэл хэрэв та эерэг сэтгэлгээтэй байвал, ердөө эерэг зүйл бодох төдийд л, хэрэв та бие махбодоо харж чаддагсан бол, эерэг бодол болгон таны гэрлийн бүрхүүлийн хэв бүтэц, таны үзэл бодол, санаа сэтгэл, дотоод энергийг өөрчилж байдгийг харах болно. Гэрлийн бүрхүүл тань бүрэн бүтэн, эрүүл саруул болдог. Гэхдээ хэрэв та сөрөг муу юм бодоод байх юм бол, ердөө л ямар нэг сөрөг, муу муухай, эсвэл зовлон зүдгүүртэй зүйлийн тухай бодох төдийд л таны гэрлийн бүрхүүлийн бүтэц тэр дорхноо өөрчлөгддөг. Үүнийг зөн билгийн чадвартай ямар ч хүн харж чадна.

Зарим хүн таны бодол санааг уншиж чаддагийн учир нь энэ,

яагаад гэвэл таныг орж ирэхэд л тэд таны гэрлийн биеийг харж чаддаг. Таны бие махбодын энергийн ижлийн өрөөсний бүтцэд өөрчлөлт гарсныг тэд харж чадна. Энергийн ижлийн өрөөсөн гэдэг нь таны биеийн жинхэнэ эрхтний хэлбэр дүрс шиг харагддаг энергийн хэлбэр дүрс юм. Жишээлбэл, та ийм зүрхтэй. Хэн нэгэн зүрхийг чинь авчихжээ гэж төсөөлбөл зүрхний тэр хэсэг зай хоосон болно. Гэлээ ч гэсэн таны зүрхний хэлбэр дүрс – ямар нэг юм тэнд байж л байдаг. Энэ бол зүрхний энергийн ижлийн өрөөсөн нь юм. Заримдаа жинхэнэ зүрх чинь бус, харин зүрхний энергийн ижлийн өрөөсөн нь асуудалтай болчихдог; тиймээс үүнийгээ засах хэрэгтэй болно. Тиймээс хэрэв эергээр бодож байх юм бол та өөрийнхөө хамгийн сайн эмч нь болно.

Эрүүл саруул, эгэл жирийн амьдар. Энгийн амьдрал, эрхэм дээд сэтгэлгээ чухал. Үргэлж сайн сайхныг бодож бай. Тэр бүү хэл, эгэл жирийн бодол сэтгэлгээ маань аж амьдралын хэв маяг, өдөр хоног, хувь заяаг чинь өөрчилдөг. Тийм учраас үргэлж эерэг байдлаа хадгалахыг хичээ. Тэгвэл маш олон золгүй явдал, өвчин эмгэгээс зайлсхийж чадна.

Хэрэв та эмч, сувилагч, эсвэл заримдаа нийгмийн ажил хийдэг бол үргэлж эерэг байна гэдэг бэрх, яагаад гэвэл тан дээр өвчтэй, асуудалтай, маш дорой бодолтой, сэтгэл гутарсан энергитэй хүмүүс ирдэг. Харин энгийн хүмүүсийн хувьд бол эерэг энерги үргэлж хадгалаад байх боломжтой. Бурхныг хажууд тань байна, арван зүгийн Их Багш нар үргэлж хамгаалж байна гэж цаг ямагт бод. Яагаад гэвэл энэ үнэн шүү. Энэ үнэн.

Бид энэ хорвоод бүх зүйлийг өөрөө хийхээр орь ганцаар орхигдчихсон юм биш. Биднийг тэнгэр элчис хамгаалж байдаг, хэдийгээр бид тэднийг олж хардаггүй ч гэсэн хүн нэг бүрийг Их Багшийн оюун санаа цаг ямагт хамгаалж байдаг. Та тэнгэр элчис, оюун санаа гэх мэтийн зүйлд итгэдэггүй байлаа ч Бурхан байдаг гэдэгт итгэх ёстой. Тийм биш байсансан бол бид оршин байхгүй байх байсан. Бид энэ Бурханаас зугтаж чадахгүй. Тиймээс бүү санаа зов. Асуудал бэрхшээл цагийн аясаар өөрөө шийдэгддэг. Тэгэхгүй байлаа ч бид энэ хорвоод түр зуурхан амьдарна, бид үүнийг тэвчиж чадна. За юу? Учир нь бид хожим буцаж очих диваажиндаа жинхэнэ найдлага тавьдаг. Бидний хэн нь ч энэ хорвоог орхих цагтаа, эрт, орой алин боловч нөгөө тийшээ эргэнэ. Энэ бол үнэндээ жинхэнэ асуудал биш.

Ихэнх асуудал бэрхшээлийг бид өөрсдөө л бүтээдэг, учир нь бид сөргөөр бодож, сөрөг үйлдэл хийж, хүмүүсийн сөрөг нөлөөнд автсан байдаг. Хааяа, эмчид үзүүлэхээр очиход тань эмч зарим өвчин нь аяндаа өөрөө үүсчээ гэж хэлдэг. Та ердөө л өвчин эмгэг хүсээд тэгчихсэн юм биш, харин таны эсэргүүцэх чадвар буурчихсан хэрэг. Жишээлбэл, харшил гэх мэт. Заримдаа та хэзээ ч харшил тусдаггүй. Харин та тамираа барж, сэтгэл хямарч, хэт ачаалалтай ажиллаж, туйлдаж ядарсан үед л

харшил тусна. Та өдөр бүр нэг л ижил хоол хүнс идсэн ч гэсэн харшил тусаагүй л байдаг. Гэтэл нэг өдөр л харшил тусчихдаг. Учир нь тэр үед л таны эсэргүүцэх чадвар маш бага байсных байх. Таны хамгаалах тогтолцоо түр зуур доройтсон гэх мэт зүйл болсон байх. Харин эерэг бодол сэтгэлтэй байвал өвчин бас хурдан арилна. Учир нь дархлааны тогтолцоо тань аль хэдийн алга болчихсон, эвдэрч хэмхэрсэн мэт болжээ, түүнийг засварлах маш бэрх. Тэр мөчид дэндүү муудаж, үхэх сэхэх дээрээ тулдаг.

Тийм учраас та өөрийнхөө эрхтэн тогтолцоонд санаа тавихыг хичээ, эвдэрч доройтоход бүү хүргэ. Эерэг үйлдэл, эерэг сэтгэлгээ, эерэг яриагаар тогтолцоондоо санаа тавихыг хичээгээрэй. Энэ маш энгийн. Ердөө л эергээр бодож сэтгэх нь л танд асар их тустай. Зарим хүн та ердөө л бодсон, үүнийгээ үйлдэж хийгээгүй бол яах ч үгүй, зүгээр гэж боддог. Гэтэл үнэн хэрэгтээ энэ тийм биш. Та хэн нэгнийг хөнөөх тухай бодож байхдаа үнэн хэрэгтээ түүнийгээ бас хийж байдаг.

Үүнийг туршиж үзсэн нэгэн хаан Энэтхэгт байжээ. Тэр нэгэн өдөр гадагш гараад гудамжинд байгаа нэг эр дээр явж очжээ. Хаан мань эрийг алах гэж завдаж байгаагаар боджээ. Тэр энэ тухай ердөө л бодсон юм байж. Тэгээд тэр эрийг хүрч ирээд энэ агшинд хааны тухай юу бодсоноо хаанд хэлнэ үү гэж гуйжээ. Тэр түүнд илэн далангүй шударгаар хэлж болно гэв, яагаад гэвэл энэ нь зөвхөн туршилт л байсан хэрэг. Түүнчлэн мэдэрсэн зүйлээ чин үнэнээр шударгаар хэлчихвэл хаан өөрийг тань хөнөөчихнө гэж айх хэрэггүй гэжээ. Ингээд хаан тэр эрд хааныг анх хараад юу бодсон тухайгаа хэлээч хэмээн шамдуулав. Тэр үед хаан тэр хүнийг алчих юмсан гэж бодож байсан учраас нөгөө эр “би чамайг зүгээр л боомилчихмоор байсан” гэж хэлжээ. Тийм ээ, хаан тэр эрийг алахыг хүссэн яг тэр мөчид нөгөө эр бас л очоод хааныг боомилохыг хүсэж буйгаа мэдэрчээ. Магадгүй өөрийгөө хамгаалах тогтолцоо байх.

Учир нь хүний сүнс бол хаа сайгүй оршигч. Сүнс бол Бурхны хэсэг бөгөөд хаа сайгүй орших чанартай. Тийм учраас, хэрвээ бид хэн нэгний тухай бодвол тэд мэдчихдэг; бид хэн нэгний тухай яривал өөрөө дэргэд байж байх үгүй хамгаагүй, тэд үүнийг мэддэг. Тийм учраас бид бусдыг араар нь муучлах ёсгүй; бид хэнийг ч нүднээс далдуур шүүмжлэх ёсгүй; хэний ч ар хударгаар муу зүйл хийх ёсгүй, яагаад гэвэл тэд мэдчихнэ. Хүмүүс ер нь Бурхан мэдэж байгаа гэж ярьдаг, гэхдээ тэр хүн ч гэсэн та түүнд энэ тухайгаа хэлээгүй байсан ч бас л мэдчихнэ. Олон гэмт хэрэг заримдаа харанхуйд үйлдэгдсэн байдаг ч эрт, орой нэгэн цагт ил гараад ирдэг. Сүнс хаа сайгүй оршигч чанартай учраас ингэдэг юм. Хэдийгээр тэр хүн мэдээгүй байлаа ч үл үзэгдэгч төрөлтнүүд мэдэх болно. Заримдаа хий үзэгдлүүд ч мэдчихээд хэлдэг үе ч бий.



Хий үзэгдлүүд тохиолдлоор хааяа биежиж гай тарьдаг талаар сонин хэвлэл, эсвэл зурагтаар та заримдаа үзсэн байх. Үүний учир нь тэд ямар нэг зүйл харсан, тэд бидний мэддэггүй, хардаггүй ямар нэг зүйлийг мэдэж байгаа явдал юм. Хэрвээ тэдэнд бие махбод байхгүй бол илүү их оюун ухаантай, илүү эрх чөлөөтэй болдог. Бид бие махбодтой байгаа нь энэ бие биднийг олон сөрөг нөлөөллөөс, бас олон сөрөг мэдлэгээс хамгаалдаг давуу тал болдог. Хэрэв бидэнд энэ бие махбод байхгүй байх юм бол бид хэтэрхий их зүйл мэдэж авна, уураг тархиараа дамжуулан дэндүү их зүйл мэдэж авна, жишээ нь хэн биднийг хөнөөхөөр завдаж байгааг мэддэг шиг; энэ хүн бидний тухай муугаар бодож байна, энэ хүн бидэнд ямар нэг муу зүйл хийх гэж байна гэхчилэн мэдэх болно. Бид өдөржин дэндүү их зүйл мэдэж авсаар байх тул бидний оюун ухаан янз бүрийн сөрөг мэдрэмж, үзэж харсан сөрөг зүйлс, хорвоогийн мэдлэгээр бөмбөгдүүлнэ. Хэдийгээр бидний сүнс мэдэж байлаа ч хэрвээ тархи маань мэдэхгүй л бол бид дэндүү их зовохгүй. Тийм учраас л энэ дэлхийн сөрөг уур амьсгалаас хамгаалахын тулд бидэнд энэ бие байгаа юм. Гэхдээ бидэнд энэ бие махбод байгаа нь тэнгэр элчисийн мэддэг, бас бие махбодгүй оршихуйнуудын мэддэг өчнөөн зүйлийг бид мэддэггүй байх сул тал болдог юм. Тэгэхлээр, бидэнд сайн, муу хоёулаа байна.

Гэсэн ч бид аль алиныг нь байлгаж болно. Бид сөрөг нөлөөллөөс өөрийгөө хамгаалахдаа энэ бие махбодоо ашиглаж болж байна. Гэхдээ бид бясалгалын арга техник хэрэглэн хүссэн үедээ биеэ орхиж сурч бас болно. Бид энэхүү биет “шоронгоос” гарч яваад байгалиас давсан эрдэм чадлыг сурч чадна; жишээ нь диваажинд очдог шигээ; дээд билиг ухаанд суралцахын тулд янз бүрийн төвшин хэмжээст оршдог ертөнцүүд рүү очиж гэх мэтийг чадна. Тэгээд буцаж ирээд үүнийгээ өөртөө, гэр бүлдээ, улс орондоо, дэлхийдээ тустай үйлс бүтээхэд ашиглаж болно. Тиймээс бие махбодгүй хүмүүсийн давуу тал биднийхээс бага. Гэхдээ гагцхүү хэрэв бид энэ амьдралаа ач тустай ашиглаж, энэ биет хэмжээс болон “биетээс чанагших” хэмжээс хоёрын аль алиныг ач тустай хэрэглэж чадвал л бидэнд хоёр давуу тал хоёулаа байх болно.

Бид сахиулсан тэнгэрсээс ч дээгүүр, тэр бүх биед хувилаагүй сүнснүүдээс ч илүү дээгүүр билээ. Бидэнд бүр ч олон давуу тал бий. Тиймээс амьдралаа анхаарч санаа тавихыг хичээ. Бие махбодын аугаа талыг ашигла. Энэ бие махбод нэн ярвигтай хэрэгсэл хэдий ч бас нэн сайн. Төгөлдөр сайн. Ер нь та маш шаргуу бясалгасан үедээ заримдаа биеэ мэдрэхгүй болно. Тэгдэггүй гэж үү? Танд ийм туршлагатай бий юу? Тийм ээ, бие тань маш хөнгөхөн болчихсон мэт санагдсан биз? Тийм. Та машин барьж байгаа ч та биш өөр хүн барьж байгаа юм шиг санагддаг. Ямар ч мэрийлт чармайлт байхгүй. Ингэж л бид физик биет хэмжээс дэх зүдрэл чармайлтгүй байдалд хүрнэ. Тэр цагт бид олон

зүйлийг хялбар дөхөм аргаар хөнгөхөн хийж чадна, бас учиргүй ядарч туйлдахаа ч больдог. Бид хэдий чинээ их бясалгана, сэтгэл санаа төдий чинээ дээрдэж, төдий чинээ шуурхай ажиллаж, асуудал бэрхшээлгүй болдог.

Та мөн элэг нэгтнүүдээ зовлон зүдүүрээс аврахын тулд мэдээ дамжуулахыг хичээх ёстой. Тэднийг тайтгаруулахыг хичээ. Мөн хэрвээ эртний билиг ухааныг бясалгаж, өөрийнхөө дотоодын Бурханы оронтой, Будда чанартайгаа холбоо тогтоон харилцаж чадвал илүү гэгээлэг, илүү агуу, аз жаргалтай амьдарч чадах тухай буянт сайн мэдээг тэдэнд уламжлаарай. Ингэвээс тэдэнд энэ дэлхийд тийм ч аз жаргалгүй, ядарч туйлдсан, түгжигдсэн, ганцаардмал мэт санагдахгүй. Энэ бол хүн төрөлхтний цорын ганц эм юм. Эс бөгөөс хүн бүхэн дэлхийн төгсгөл ирж байна гэж танд хэлэх болно. (Инээлдэв) Тэгээд юу гэж? Дэлхийн төгсгөл ирлээ ч, бид аюулгүй байдалд байгаа. Бид хаашаа явахаа аль хэдийнээ мэднэ, тиймээс айж эмээхгүй. Бидэнд амьдарч болох өөр олон ертөнц байх болно.

Дэлхийд маш олон байгалийн гамшиг айсуу боллоотой. Гэвч би дэлхий тийм хурдан сөнөчихнө гэж бодохгүй байна. Магадгүй зарим хэсэгт нь төгсгөл ирж мэднэ, өөр өөр хүмүүсийн заримд нь маш их сүйрэл ирэх байх. Харин буянтай хүмүүс, гэм зэмгүй хүмүүсийг хойч үед нь зориулан хамгаалж үлдэх болно. Таны бясалгалын явцад, хамтын цугларалтын явцад, та нарын анир чимээгүй залбирч байх мөчүүдэд үүсэх эерэг энергийн ач тусаар дэлхий маань бидний найдаж чадаж байгаагаас ч илүү далайцтайгаар хамгаалагдаж үлдэх болно. Тийм ч учраас таныг сайн мэдээг хүмүүст илүү ихээр түгээнэ байх гэж би найдаж байна. Олон хүнд сэлэх боломж өгөхийн тулд усан санд ус нэмнэ.

Хувийн дур таашаалаа жаахан золиосолж, эсвэл ургамал хоолтон гэргий чинь олиггүй хоол хийсэн байсан ч хамаагүй, хүн төрөлхтний төлөө гэж бодоод залгичихыг хичээ. (Инээлдэв.) Гэхдээ эхнэр нь хоолоо хийх чадвараа сайжруулах хэрэгтэй, эсвэл магадгүй нөхөр нь ч юмуу. Яагаад болохгүй гэж? Яагаад эхнэр нь л үргэлж хоол хийх ёстой гэж? Хоол хийхдээ эрэгтэй нь эмэгтэйгээсээ илүү авьяаслаг байдгийг та мэддэггүй юм уу? (Инээлдэв.) (Сонсогчид: Тийм.) Тийм шүү, тэд гагцхүү оролдож үздэггүй л болохоос биш. (Алга ташилт) Би эрэгтэйчүүдийн гарын хоолыг олон удаа идэж үзсэн. Тэд маш сайн хийдэг. Хамгийн том зочид буудлуудын хамаг сайн тогооч нь дандаа л эрчүүд байдгийг та мэдэх үү? Тийм биз? (Сонсогчид: Тийм ээ.) Гарамгай эмэгтэй тогооч байсан гэж бид маш ховорхон сонссон.

Тиймээс эрчүүд оролдоод үзвэл зүгээр дээ. Эхнэрээ гайхшируул л даа, тэрнээс биш “Эхнэр надад хоол хийж өгч чаддаггүй юм чинь би бясалгаж чадахгүй” гэж надад битгий гомдолло. (Инээлдэв.) Энэ чинь

дэмий балай үг. Бидэнд хийж чадахгүй гэж хэлчихээр зүйл огт байхгүй. Тийм биш гэж үү? Хэрэв энэ нь ноцтой зүйл бол танд өөрийгөө зөвтгөх юм байж болох билээ. Харин хоол хийж, юм угаах зэрэгхэнийг бол та оролд, суралц, бас түүнээсээ таашаал хүрт.

Бид мөн амьдралынхаа хором бүрийг үнэ цэнэтэй, эерэг сайхан, аз жаргалтай байж, сурч боловсроход ашиглах нь зүйтэй. Үнэндээ энэ амьдралд уйтгартай зүйл ер байхгүй. Юу ч уйтгарлаж залхмаар биш. Та ном эрж сурагла. Таны уншиж болох олон ном бий. Сүнс сүлдийг тань хорлож гэмтээхгүй, зөв зам мөрөөс тань хазайлгахгүй, ёс зүйтэй амьдралаас хөндийрүүлэхгүй, гэм нүгэлтэн болгохгүй л бол дуртай бүхнээ унш. Тийм байх юм бол ном болгоныг уншиж болно. Сониноос авахуулаад бүх зүйл мэдээлэл өгч чадна. Юу уншихаа мэдээж та сонгоно. Хорвоогийн мэдлэгээ баяжуулахын тулд юуг ч уншиж болно. Тэгээд дараа нь диваажингийн мэдлэгээ гүнзгийрүүлэхийн тулд бясалгаарай, ингэвэл та энэ дэлхий болон диваажингийн аль алиных нь мэдлэгтэй болох болно. Яалаа гэж уйтгарлаж суух юм бэ?

Надад заримдаа цаг зав ч хомс байдаг. Мэдээж сүнслэг ажлаа хийгээд завгүй байдаг. Тэгсэн ч бас хандив буяны ажлаа хийгээд завгүй байдаг. Ингээд л би тун завгүй болчихдог. Гэхдээ л би цаг гаргадаг. Би ном унших гэх мэтийн зүйл хийдэг. Яаж уйдаж амжих юм? Энэ дэлхийд өөрийгөө зугацуулж болох өчнөөн зүйл бий, би оюунлаг талыг нь хэлж байна л даа.

Бас шаардлагатай бол спортоор хичээллэж болно. Усанд сэлэх ч юмуу, өөр юу ч юм сур. Амьдралаа жаргалтай, эрүүл саруул, бас ашиг тустай болго. “Миний амьдрал уйтгартай, аз жаргалгүй байна” гээд л суугаад байх хэрэггүй. Энэ бол утгагүй зүйл. Та өөрийнхөө төлөө ингэ. Энэ зөв үү? (Сонсогчид: Тийм.)

Би энд ирэхээсээ өмнө юм уншиж байсан юм, хором бүрт тэвдсэн. Би эцсийн хором хүртэл уншмаар байсан учраас үргэлжлүүлэн уншаад л, тэгэх зуураа цаг руу хяламхийж байлаа. (Инээв.) Мэдээжээр, би үүргээ биелүүлэх ёстой. Би багшийн хувьд, сайн найзын хувьд үүргээ биелүүлэх ёстой. Гэхдээ би зөвхөн ажиллаад зогсохгүй, бас амьдралаа жаргалтай болгодог. Бас завтай бол хааяа усанд сэлдэг. Үүнд хагас цаг ч хүрэхгүй хугацаа орно. Та гараа хумхиад сөрөг муу болгоныг бодоод байхын оронд явж усанд сэл. Мөн түүнчлэн агаар салхинд зугаал, хүүхдүүдээ дагуулж гараад тогло, тэгвэл таны ажилд сайн шүү дээ. Тэдэнд усанд сэлэхийг заа, эсвэл өөрийнхөө дуртай зүйлийг зааж өг. Тэдэнтэй амьдралаа хуваалцаж, ухаалаг байхыг зааж өг.

Хүүхдүүдийн тухайд гэвэл та тэднийг өөр хүүхдүүдтэй тоглуулаад орхичих ёсгүй. Хүүхдүүд томчуудтай хамт байж суралцах ёстой. Тэгж байж л өсөж том болдог. Үнэндээ бол бид хэрвээ биечлэн анхаарч халамжилж чадахгүй бол дэндүү олон хүүхэдтэй байхын хэрэг юун. Та амьдралаа хүүхдүүддээ зориулах нь зүйтэй, нэг удаад нэг

хүүхэд. Та үргэлж тэдний хажуу дэргэд нь хамт байх ёстой. Тэгвэл л тэд хурдан өсөж өндийн тун ухаалаг, нийгэм дэх хүмүүст ач тустай хүн болно. Ингэсэн цагт л тэд таныг нилээн олон толгойн өвчнөөс аварна. Тэд маш сайн, зоримог болно. Тэгэхлээр, мэдээж хүүхдүүдтэй тоглох тун ядармаар хэдий ч та тэдэнтэй тоглож сурна. Тэд бас танаас суралцана. Та тэднээс тэвчээр, хайрыг - нөхцөл болзолгүй хайрыг суралцана. Тэр цагт л тэд таны билиг ухаанаас, оюун ухаанаас, амьдралын хэв маягаас суралцана.

Тиймээс өөрийгөө судлангаа өөрийгөө шилдэг үлгэр жишээ болго. Ном унш, шинэ сонирхдог зүйл (хобби)-тэй бол, эрүүл бай, спортоор хичээллэ; эгэл жирийн амьдарч, шударга үнэнч, буянтай хүн бай. Тэгвэл хүүхдүүд тань тантай адилхан болж өсөж бойжно.

Тиймээс энэ дэлхийд хийх зүйл үнэхээр их байна. Бас сонирхдог зүйлийн хувьд ч тэр. Над дээр ирээд уйтгарлаж, зовж зүдэрч байгаагаа хэлэх гэхийн хэрэг алга. Би хүлээж авахгүй. Би үүнийг хүлээж авахгүйг ч мэдэж байгаа. Та уурлаж цухалдах ёсгүй. Та зовлонтой өрөвдөлтэй байх ёсгүй. Та уйдах ёсгүй. Бясалгагчдын толь бичигт ийм зүйл байдаггүй. Яагаад гэвэл та илүү ухаалаг, илүү их эрч хүчтэй байх ёстой, тэгвэл илүү олон санаа төрнө. Та харин ч бүр илүү идэвхтэй, улам эрч хүчтэй байх ёстой. Тийм биш гэж үү? Ингэсний дараа сэтгэл санаа тань хөнгөрөхгүй гэж үү? (Сонсогчид: Тийм.)

Тэгэхлээр, хэрэв хэн нэг хүн тан дээр ирээд зовж шаналж буйгаа хэлж байвал тэр хүн бясалгадаггүй нь илэрхий, яг тийм шүү. Та “Явж ахиухан суу, тэгвэл та дээрдэнэ” гэж хэлж болно. Ахиухан бясалга, тэгвэл та бид гаднаа илүү нийтэч болж чадна. Хүн бүрээс, бас бүх хүнээс суралц.

Хааяа таны оюун ухаан дотроо асуусан асуултад хөрш, эсвэл дэргэд тань байгаа хэн нэгэн хариулчихдаг. Та мэдрэх ёстой. Зарим үед та асуулт тавь, хэрэв Их Багш дотоодод чинь хариулсан эсэхэд эргэлзэж байвал хааяа хариултаа гаднаас хайх хэрэгтэй болдог. Заримдаа хөрш тань тантай ярилцахыг хүсэж байгааг гэнэт мэдэрдэг. Хэрвээ энэ нь тов тодорхой байвал энэ бол та сонсох ёстой шүү гэсэн дохио тэмдэг юм. Мөн түүнчлэн энэ бол танд зориулсан хариулт юм. Эсвэл заримдаа гарт тааралдсан номоо сөхөнгүүтээ л хариултаа олдог. Эсвэл заримдаа хуурцаг сонсож байтал танд зориулсан өгүүлбэр гараад ирдэг. Хэрвээ та зөн совингоороо Их Багш таны дотоодод хариу өгснийг тодорхой сайн ойлгоогүй бол хариултаа гаднаас хайхыг оролд. Гэхдээ та алдсан байлаа гэхэд зүгээр дээ. Зүгээр зүгээр. Дараагийн удаа л алдаагаа бүү давт. Санаа зоволтгүй. Тийм биз?

За, та нарт хоол таалагдсан гэж найдаж байна. Энэ амтыг нь бас марталгүй санаж, гэртээ хариад гэргийдээ, нөхөртөө, хүүхдүүддээ яг

ийм хоол хийж өгөөрэй. Ингэвэл тэд ургамал хоолны дэглэм их хэцүү гэж гомдоллохгүй. Өнөөдрийнх шиг хоолыг хэрэв хүн бүр идээд үзчихвэл хэзээ ч гомдоллохгүй. Тийм биш гэж үү? (Сонсогчид: Тийм ээ.)

Намайг Герман эмч нөхөртэй байсан тэр үед хөршүүд маань бүгд ургамал хоол идэх гэж зочилдог байсныг би та нарт ярьж байсан даа. Нэг өдөр хуучин нөхөр маань намайг үргэлж ургамал хоол хийх юм гээд хөршүүдээ өрөвдлөө. Тиймээс тэр өдөр нөхөр маань чанаж болгосон хүйтэн загас худалдаж авчээ. Тэр бас хүйтэн мах гэх мэтийн тиймэрхүү зүйлс худалдаж авсан тул түүнийгээ ширээний нөгөө талд нь олноор нь тавьсан юм. Тэгтэл би ердийнхөөрөө, өөртөө болон Герман эмч нөхөртөө, хоёр биедээ ургамал хоол бэлтгэсэн байлаа. Гэтэл хүмүүс бүгд ургамал хоол идэх гэж, тэр тал руу хошуурсан. Би ургамал хоолоо ахиухан хийгээгүй байснаас болж бид бүгдээрээ өлссөн шүү. Би хоёр хүнд л зориулж хоол хийсэн байсан юм.

Би Герман эмчийн зөв гэдэгт итгэж байсан хэрэг, (Инээв) тиймээс хөршүүд маань ирээд түүний авсан хамаг хоолыг идэх байх гэж бодсон хэрэг. Тиймээс хоёр хүний багахан хоол хийсэн. Гэтэл бүгд ургамал хоол идэх гэж иржээ, яагаад гэвэл маш амттай учраас тэр. Тэр хүмүүс бол инженер, хуульч, эмч нар. Учир нь хөршүүд маань бидэнтэй төстэй хүмүүс байсан. Бид зөвхөн баячууд гэгддэг, иймэрхүү баян хүмүүс л суудаг чинээлэг дүүрэгт амьдарч байсан юм. Тэд энгийн иргэд шиг биш, арай дээгүүр зиндааных. Тийм учраас, тэд надад “Хөөх, ургамал хоол ийм сайхан юм бол өдөр бүр идсэн ч яах вэ” гэж хүртэл хэлсэн. Тэд мах хүсээгүйн учир нь энэ.

Би “Та очоод загас, махаа ид л дээ? Эмч та нарт зориулж худалдаж авсан шүү дээ” гэж хэлсэн.

Тэд “Үгүй ээ, бид мах, загасны төлөө ирээгүй. Бид үүнийг өдөр бүр л иддэг шүү дээ. Бидэнд таны ургамал хоол л хэрэгтэй байлаа” гэсэн.

Тэр цагаас хойш би хөршүүдээ урих болгондоо зөвхөн ургамал хоол л бэлтгэдэг болсон. Тэд ч намайг урихдаа ургамал хоолоор дайлдаг болсон. Бид ингээд л ургамал хоол идээд байсан учраас хөршүүд маань бүгд ургамал хоолтон болсон. Ядаж л хааяа ч гэсэн. Хадмууд дээрээ очиход тэд бас л ургамал хоол хийж өгдөг нь янз бүрийн хоол идэж үзэх боломж олгосон. Тэдэнд ч тийм хоол бас маш амттай санагдсан гэсэн.

Тиймээс ганц хүн ч маш ихийг шийдвэрлэж чадна. Та өөрийнхөө сайхан сэтгэлд, хийж буй зүйлдээ үнэнхүү итгэдэг л бол бусад хүмүүст нөлөөлөх болно. Харин итгэдэггүй бол тэд танд нөлөөлнө. Тэд таныг хүчирхэг хүн болгохыг хичээнэ. Та юуг сайн гэж итгэнэ, түүнийгээ тууштай баримталж, бусад хүмүүсээс болж шантрах шалтаг бүү гарга, учир нь энэ дэлхийд сайн үлгэр жишээ ховор байна.

Тиймээс та өөрөө сайн үлгэр жишээ нь бай. Таныг бясалгалын ач тусаар улам сайжраад байгааг хүмүүст мэдүүлэхийн тулд аливаа зүйлд хамаг чадлаараа хичээгээрэй. Ингэвэл та үнэхээр ач тус хүргэж, нийгэмдээ ач тустай байна. Та ингэж л нотолно. Ингэж л та бусад хүмүүст тусална. Ингэж л бид дэлхийг тохиож магадгүй их сүйрлээс аварна.

Миний бодлоор бол би эш бошго үзүүлэгч байх шаардлагагүй. Би зөгнөл айлдах шаардлагагүй. Би ирээдүйг харахын тулд зөн билигтэн байх шаардлагагүй. Бидний хэн нь ч ийм байх албагүй. Өөрсдийгөө хөнөөх маш олон мансуурах бодис, зэр зэвсэгээсээ болж, амьдарч буй хэв маяг, бие биедээ хэрхэн халдвар тарааж байгаагаа харахад л манай дэлхий асар их сүйрэлд өртөж болохыг бид бэлэхэн харж байна. Энэ нь дэлхийн төгсгөл болж ч мэднэ. Үүнд эргэлзэх зүйл алга. Эсвэл бид ойр дотныхондоо, тэдний амьдралд хэрхэн нөлөөлж байгаагаа, ДОХ-оор өвчилсөн ганц хүн ердөө л хэн нэг хүнтэй хурьцвал, эсвэл хаа нэгтээ хайхрамж болгоомжгүй үйлдэл хийчихвэл хэдэн зуун мянган хүнд хэрхэн нөлөөлж болохыг хараад л мэдэж болно.

Францад нэгэн эмч нэг өвчтөнд халдвартай цус сэлбэсэн. Хэдэн зуун хүн яагаа ч үгүй, гэм зэмгүй байтлаа энэ өвчинд нэрвэгдсэн. Бүгдээрээ л сэрэмжтэй байж, хаашаа ч яваагүй, өөрсдөө гэм хийгээгүй, гэтэл өвчний халдвар авсан. Энэ бол шударга бус явдал. Тиймээс ийм тохиолдолд энэ нь аймшигтай. Бас тэр зуун хүн дахиад зуун хүнд халдааж магадгүй. Тэгээд зуу нь мянга болж, мянга нь сая болдог. Жил бүр сая сая хүн элдэв дэмий зүйлээс болж үхэж байна. Тиймээс бид эш бошго үзүүлэгч нараас ертөнцийн төгсгөлийг асуухын хэрэг байхгүй. Хэрэв өнөөгийн ихэнх хүний амьдралын хэв маягийг үргэлжлүүлээд байх юм бол дэлхий сөнөнө гэдэгт бид итгэх хэрэгтэй болж магадгүй.

Тиймээс, хэрэв бид энэ гараг дэлхийгээ хайрлаж, үнэхээр үзэсгэлэнтэй газар гэж бодож л байгаа юм бол хүмүүсийг аврах нь бидний үүрэг, яг тийм шүү. Өнөөдрийнх шиг ийм үзэсгэлэнтэй сайхан гараг болгоход хэдэн тэрбум, их наяд жил шаардагдана, тиймээс л ийм үзэсгэлэнтэй байгаа хэрэг. Тиймээс бид ч бас хувь нэмрээ оруулах ёстой. Хэрэв чадахаар бол, засаж сэлбэнэ. Мэдээжээр, хамаг чадлаараа хичээсэн ч дэлхийн төгсгөл ирэх юм бол тэр л биз. Гэхдээ засаж залруулж чадахаар бол бид засаж сэлбэнэ. Тийм биз?

Тиймээс, хүмүүст буянт сайн мэдээ түгээж, амьдралын жам ёсны хэв маяг, буянтай сайн хэв маяг руугаа буцах боломж олго; энэ нь ургамал хоолтон байх, ёс суртахуунтай байх, сахил санваараа сахих, энгийн амьдрах, эерэг сэтгэлгээтэй байхыг хэлж байгаа юм. Тэгвэл манай дэлхий ямар ч асуудалгүй болж, бид магадгүй улам сайн сайхан нөхцөлд дахиад хэдэн мянган жил амьдрах болно.

Одоо хоёр гарц байна: нэг нь бүрмөсөн сүйрэх, нөгөө нь амьдралын бүхий л хэв маяг, тэр дундаа оюун санааны хувьд ахиц

дэвшил гаргах. Тэгээд ч үнэн хэрэг дээрээ ирээдүй бидний гарт байгаа. Энэ талаар ямар нэг юм хийж чадах харь гарагийнхан байхгүй. Биднийг шийтгэдэг Бурхан гэж байдаггүй. Биднийг адислах Будда гэж байдаггүй. Энэ нь гагцхүү бид өөрсдөө л юм. Бид сонголтоо хийх ёстой, учир нь бид чухам зөв сонголт хийснээрээ л өсөж өндийдөг.

Ер нь ирээдүйд бид энэхүү 2000 оны сүйрлийн хямралыг давчихвал цаашдаа хөгжих боломжтой болно. Түүнчлэн 2000 оноос хойших ирээдүйн хүмүүс дэндүү хүнд бэрх хөдөлмөр эрхлэх шаардлагагүй болохыг би төсөөлж чадаж ч магадгүй. Бид өөр тогтолцоотой болно, илүү ухаалаг тогтолцоотой болно, хүмүүс зөвхөн сонирхлынхоо дагуу хөдөлмөрлөх байх. Бидэнд мөнгө ч хэрэггүй болж магадгүй. Хүн бүр өөрт байгаа зүйлээ үйлдвэрлэж, дараа нь бие биетэйгээ хуваалцана. Улам дээр болно. Гэхдээ энэ миний төсөөлөл. Биелнэ гэж найдаж байна. Би ингэж магадгүй гэж бодож байна.

Одоохондоо бид дэмий юмны төлөө хэт их ажиллаж байна. Бид махран ажилласны эцэст өчүүхэн бага орлого олдог, ингээд илүү ухаалаг дасгалд зориулж болох маш их цагийг дэмий үрдэг. Учир нь чухамдаа хүнд арай илүүхэн цаг хугацаа байвал тэр хүн илүү их хувь нэмэр оруулж чадна. Чөлөөт цагтаа хүн бүтээж, суралцаж, өөр төрлийн ажилд өөрийгөө сургаж, сонирхдог зүйлээ хөгжүүлэхэд оюун ухаанаа ашиглаж чаддаг. Заримдаа хүн сонирхдог зүйлдээ эрч хүчээ түлхүү зарцуулдаг бөгөөд энэ нь илүү сайн үр дүнд хүргэдэг.

Хүн бүхэн хагас өдөр л ажиллах ёстой гэж би боддог. Ингэхэд л хангалттай. Өдрийн үлдсэн хагасыг сонирхдог зүйлдээ - өөрийн хөгжүүлэх дуртай зүйл, эсвэл хувийн бүтээл туурвил, судалгаа шинжилгээ гэх мэтдээ зориулах хэрэгтэй. Сонирхдог зүйл гэхлээр заавал дэмий чалчих, хөл бөмбөг хөөх гэх мэтийн зүйл байх албагүй. Өөрөө сайн дураараа, хүсэл зоргоороо, оюун ухаанаа дайчлан хийсэн аливаа зүйлийг хобби буюу сонирхдог зүйл гэдэг. Гэхдээ хобби нь нийгэмд маш их үр өгөөжтэй, ач тустай байх нь бий.

Ирээдүйд бид үүн лүү явж чадаж ч магадгүй.

## АСАР ИХ ШУНАЛ ХҮСЭЛТЭЙ ХААН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1995 оны 7 дугаар сарын 11 (Дүрс бичлэг 488)  
Формоса, Шихү төв (Эх нь Англи хэлээр)*

Энэ үлгэрийг “Асар их шунал хүсэлтэй хаан” гэдэг. Эртээ урьдын цагт, дивангарын үед, бүр маш эрт, элэн галавын үед Энэтхэгт нэгэн том гүрнийг өнө удаан, маш удаан жолоодсон аугаа хаан байжээ. Тухайн цаг үедээ тэр үргэлж л ялалт байгуулж байж. Тэр хэзээ ч ялагдаж байсангүй. Тэр ямагт ялдаг байжээ. Түүний хийсэн бүхэн нь түүнд ялалт авч ирж байсан учраас тэр улам л сувдаг шунахай, ихэрхэг дээрэлхүү болсоор байлаа. Энэ хаан нэг ёсондоо бол бясалгагч учраас ид шидийн хүчтэй байжээ. Дээр үед “Алтан Хүрдний Гэгээн Хаан” гэх мэтийн нэр алдартай хаад олон байжээ, учир нь түүнд хүссэн газар нь хүргэж өгч чадах алтан сүйх тэрэг байжээ. Энэ нь магадгүй Үл Мэдэгдэх Нисдэг Биет байх. Рама гэх мэт Энэтхэгийн олон үлгэр туулийг уншиж үзэхэд дээр үед хүмүүс тэнгэрт сүйх тэрэг хөлөглөн нисдэг харь гарагийн хүмүүс, ҮМНБ-үүдтэй харилцаа тогтоодог байсан бололтой байдаг. Өөр юу байсан байж таарах вэ? Тэр цаг үед тэдэнд нисэх онгоц байгаагүй, тийм биш үү? Би байсан гэж бодохгүй л байна.

Эсвэл тэд хийж бүтээсэн байж ч мэднэ. Үүнээс гадна, янз бүрийн ид шидийн хүчтэй байсан юм чинь тэд харь гарагийнхантай учирсан нь гарцаагүй – Рама болон түүний хатан, бараа бологсодыг мэднэ биз дээ.

Мэдээж, хаанд маш олон сайхан, эрхэм нандин зүйл байжээ. Эхнийх нь маш сайхан, хүчирхэг, ид шидтэй, түүнийг цагт мянган бээрийн газарт хүргэж өгч чадах морь юм. Энэ тэгэхлээр нисэх онгоц байж таарах нь ээ. Ямар морь гэхээрээ ийм байсан байх вэ? Гэхдээ улаан зүсмийн морь. Дараагийнх нь цасан цагаан зүстэй маш сайхан заан. Түүнд бас орой болохоор сарны туяа мэт үзэсгэлэнтэй гэрэл цацаргадаг эрдэнийн чулуу байв. Тэдэнд цахилгаан эрчим хүч байгаагүй, түүний хэрэг ч байгаагүй. Түүнд бас алтан өнгөтэй, сүйх тэрэгтэй төстэй “машин” байжээ. Энэ нь түүнийг тэнгэрт хүргэж чаддаг байв. Энэ юу байсан байж болох вэ? Нисэх онгоц уу, эсвэл ҮТНБ үү? Ингэхэд бидэнд цагт мянган бээр давхидаг машин байдаг билүү? Өө, өдөрт, өдөрт гэж байна, өдөрт мянган бээр. Энэ ч машин байж таарлаа. Түүнд машин, бас нисэх онгоц байжээ.

Түүнд бас хатан байсан нь нэн гоо, маш гоо үзэсгэлэнтэй, бас

маш үнэнч, нэн үнэнч аж. Тэгэхлээр түүнд өөр хүсэх юу байх билээ? Түүнд тусалдаг маш сайн ерөнхий сайд ч байв, тэр бас хүчирхэг, маш хүчирхэг армийн генералтай. Тэгэхлээр түүнд юм юм л байж, тийм биз? Тэр дандаа ялалт байгуулж байсанд гайхах юм алга. Тэгээд ч бас түүнд биерхүү том, өндөр, хүчтэй, ухаантай, боловсролтой, эр зоригтой, бүгдээрээ л аугаа их хаан шиг мянга мянган ноён байжээ.

Энэ бүх зүйл нь түүнийг чухамдаа туйлын жаргалтай, сэтгэл хангалуун болгочихсон байх ёстой байв. Гэвч тэгсэнгүй. Түүнд өдөр бүр хоосон оргиж, ямар нэг юмаар дутагдаад байх мэт санагддаг байв.

Нэгэнтээ тэр залхжээ. Түүнд (энэ бүхэн байсаар байтал мөнгө нь хүрэлцэмгүй санагджээ, тиймээс тэр суугаад мөнгөн дээр бясалгажээ. Тэр мөнгө бясалгаж, мөнгөний тарни уншив. Тэр “Доллар, доллар, доллар... Америк доллар, Франц доллар, Итали доллар, харин тайваний мөнгө биш шүү, германых, германы”... гээд л тарнидаж гарчээ. (Инээлдэв) Тэр энэ бүх тарнийг унштал тэр бүх мөнгө унаад ирж, Герман марк, Америк доллар, Францын франк гээд л бүгд; яагаа вэ, та нар маш сайн мэдэж байгаа – өө, иен, Японы иен. “Зэн Зэн” гэхийн оронд тэр “Иен иен” гэж хэлжээ. (Их Багш болон бүгд инээлдэв.)

За юутай ч түүний бясалгал хүчтэй болжээ. Тэр маш их, үлэмж их төвлөрч, асар их чин сэтгэл гаргаж; мөнгөнд сэтгэлээ ихэд зориулав. Тиймээс мөнгөний Бурхан сэтгэл догдолж, түүнд мөнгөөр бороо оруулжээ. Тэгээд тэр ордон нь бүхэлдээ, бас гадаа, модны орой гээд хаа сайгүй мөнгө байгааг харав. Бүр бие засах газрынх нь тэнд ч мөнгө байж гэнэ. Хаан энэ бүхнийг хараад албатууддаа тэднийг түүж аваад тоолоод өг гэж тушаав. Тэр “Хангалттай биш байна” гэв.

Тэр ахиад л бясалгав. Энэ удаа тэр арай өөр зүйл хүсэж, өөр тарни уншив. Би яг одоо та нарт заагаад өгч чадна шүү (Инээлдэв.) “Алт, алт, алт, алт, мөнгө, мөнгө, алт, алт, мөнгө...” гээд л (Инээлдэв.) Тэр ахиад л бас зуун хувь сэтгэлээ зориулсан учраас алт, мөнгөний Бурхны сэтгэл хөдөлж, түүний хүссэн ёсоор алт, мөнгөөр бороо оруулав. Энэ удаад Миаоли болон энэ хавь бүхэлдээ алт мөнгөөр хучигджээ. Тэгээд тэр ердөө л хүмүүстээ очиж түүж авчраад санд хураа гэж хэлэх л үлджээ.

Түүний сэтгэл нэг хэсэгтээ ханав. Хэдэн өдөр юмуу, хэдэн сар л байх. Үнэндээ эрт цагт хүмүүс маш удаан, их удаан амьдардаг байж л дээ. Тийм болохоор л түүнд их уйтгартай байсан биз. Тийм учраас та нар дэндүү удаан амьдарч байна уу даа гэдгээ анзаарах хэрэгтэй шүү.

Алт, мөнгөтэй холбоотой будлиант явдлаас хойш олон олон жил өнгөрчээ. Хаан ахиад л уйдаж, амьдралдаа сэтгэл ханамжгүй болжээ. Ингээд тэр өмнө зүгт хараа бэлчээх үест маш баян тансаг, өргөн уудам, үзэсгэлэнтэй нэгэн улс орон харагджээ. Тэгэхлээр нь тэр “Хөөх, би энэ өмнө зүгийн хаант улсыг ч бас захирах юм бол аз жаргалтай, сэтгэл хангалуун болох бус уу” хэмээв. Гэнэтхэн, түүнийг ийнхүү хүсэв үү,

үгүй юу сүйх тэрэг нь тэнгэр өөд нисэж, түүнийг өмнөдийн хаант улсад аваачжээ. Тэр даруй ялалт байгуулав, учир нь хүн бүр түүнийг тэнгэрээс ийм гэрэл цацарсан, гоё сайхан алтан сүйх тэрэгтэй бууж ирэхийг хараад газар сөгдөн “Амар байна уу” хэмээн угтжээ. Тэд түүнд ямар ч асуудалгүй бууж өгчээ. Тэд түүнд маш сайнаар хандаж, нэн ихэд хүндэтгэн хүссэн бүхнийг нь гүйцэлдүүлэв.

Тэгээд тэр дахин мянган жил тэнд амьдарчээ. Тэгтэл дахиад л залхсан тул өндөр цамхаг дээр гараад дахин алсад хараа бэлчээв. Магадгүй, хойд зүг рүү харсан байх, хойд зүгт нэн сайхан хаант улс байв - машинд цэцэглэн хөгжсөн, хүн ард нь царай зүс сайтай юм гэнэ. “Би одоо энэ хаант улсыг авмаар байна! Тэгвэл л би аз жаргалтай, сэтгэл хангалуун болно” гэж тэр уулга алдав. Түүнийг хэлэв үү, үгүй юу л, яагаад гэвэл тэр хүчтэй, тэр нь ид шидийн хүч биз, юу л хүснэ бүгд биелдэг байв. Магадгүй түүнд аль эрт хураасан буян байсан, тэгээд түүнийгээ үрэн таран хийгээгүй байсан байх.

Ингээд түүнийг хүсэмгц сүйх тэрэг нь түүнийг тэнгэрт нисгэн хойд нутагт авчрав. Түүнийг очмогц л хойд нутгийн хаант улсын ард иргэд бас л гудамжинд өвдөг сөгдөж, түүнд хүж, жимс, цэцэг, бялуу, чихэр, рашаан, шар айраг гээд л юм юм л өргөжжээ; дээр нь бас хаант улсаа өргөжжээ, ингээд ямар ч асуудалгүй бууж өгөв. Тэр дусал цус ч урсгалгүй энэ хаант улсыг өөрийн болгожээ. Яг одоо байлдаж байгаа хүмүүс хүний амь нас үрэлгүй, цус урсгалгүй хэрхэн өөр улс орныг эзлэх энэ стратегийг сураасай гэж би бодож байна.

Ингээд тэр ахиад л мянган жил аз жаргалтай, сэтгэл хангалуун болов. Түүний хувьд сэтгэл хангалуун болоход олон жил шаардагдахгүй байгаа биз!!! Ай хөөрхий, ингээд мянган жил өнгөрөв, сэтгэл ханамжгүй хаан ийш тийшээ, зүүн зүг харсан байх, тэнд өөр нэг хаант улс байв. Тэр магадгүй дурангаар харсан байх. Тэр тийшээ хараад ингэж хэлжээ: “Өө, энэ чинь юу вэ, тэнд миний мэдэхгүй хаант улс байж яаж болдог юм бэ? Энэ бас маш үзэсгэлэнтэй, хөгжин цэцэглэсэн улс байна – дуриан жимсээр баян юм. Эндээс би тэндхийн дуриан жимсний үнэрийг мэдэрч байна” гэв. (Их Багш болон бүгд инээлдэв.)

Тиймээс тэр “Би энэ хаант улсыг авах ёстой. Би энэ хаант улсыг ч бас захирах ёстой, тэгвэл л би сэтгэл хангалуун болно” гэв. Хэлсэн ёсоор нь л болов. Тэр цус урсгалгүй, эсэргүүцэл үзэлгүй ялав. Магадгүй Бурхан түүнийг ивээж тусалжээ. Урьд төрөлдөө тэр маш их буян хураасан учраас тэр байх. Магадгүй тэр хойд, өмнөд, зүүн зүгт маш амар амгалан, хайр энэрэлтэй хүмүүс байсан байх. Хаант улсыг нь хэн захирах нь тэдэнд ялгаагүй аж. Тэд цус урсахыг хүсдэггүй; зүгээр л бууж өгдөг. Энэ хамгийн сайн арга зам юм болов уу. Мэдэхгүй юм даа. Магадгүй бүх тохиолдолд энэ хамгийн зөв арга зам байх, учир нь эсэргүүцэхгүй бол тулалдах аргагүй. Бид ер нь хаана ч байлдаж

тулалдах хэрэггүй л болов уу даа.

Үнэхээр шүү, хэрвээ бид Бурхны Хаант Улс бидний дотоодод байгааг ойлгож мэдээд Бурхны Хаант Улсын бал бурмыг амтлаад үзчихсэн л бол бид юуг ч эсэргүүцэхийг хүсэхгүй. Хэрэв бид Бурхан болон хамаг амьтны тусыг бүтээхийн тулд энд илүү удаан амьдарч болохоор бол тийм л болог. Хэрвээ бидний хорвоогоос буцах цаг нэгэнт ирсэн, эсвэл бидний амийг хөнөөхөөр хэн нэг нь хүсэж байгаа бол тэр л биз, учир нь бидэнд амьдралаа үргэлжлүүлэх өөр хаант улс бий. Магадгүй, тиймээс, Бурхны таалалд даатгах нь хамгийн сайн. Эрт, орой нэгэн цагт бидний хэн нь ч тэртээ тэргүй энэ хорвоог орхихоос л хойш юмыг төвөгтэй болгох хэрэг байна уу?

Янз бүрийн улс оронд эсэргүүцэл тэмцэл өрнөж байгаа харагдах юм. Заримдаа ямар нэг тодорхой, төгс үр дүнгүй атлаа улам л их цус урсгадаг. Маш олон амь нас, цаг хугацаа, барилга бүтээн байгуулалтын хүч, санхүүгийн ашиг тусыг үрэн таран хийдэг - хүмүүсээр маш их төлөөс төлүүлдэг. Үүнээс гадна, та нарын харж байгаачлан аливаа тогтолцоо өөрөө нуран унадаг. Зүүн Европын коммунистууд шиг. Тэд өөрсдөө нуран унасан. Бурхны төлөвлөгөөнд нийцээгүй л бол юу ч мөнх оршдоггүй.

Тэгэхлээр, энэ бүх биетэй бодитой эсэргүүцлүүд үнэндээ сайн уу, үгүй юү гэдгийг би мэдэхгүй. Би үүнийг бодсоор л байдаг, бас олон юм хэлж зүрхлэдэггүй. Хүмүүс намайг гутранги, идэвхгүй, нэг тиймэрхүү хүн гэж бодох байх. Гэхдээ бүх зүйл өөрөө шийдэгдэнэ гэж би болдог. Заримдаа та амьдрал туулах явцдаа үүнийг өөрөө амсаж мэдэрсэн байдаг. Хааяа та элдэв зүйл нэхэж шаардах гэж оролддог ч эцэстээ нөгөө л хэвээрээ үлддэг, эсвэл өмнөхөөсөө бүр дорддог.

За ингээд, дахиад мянган жил өнгөрөхөд тэр аз жаргалтай байв. Тэр бас өөр нэгэн улс үндэстнийг залгиад маш жаргалтай байв. Дахиад нэг мянган жил болоход тэр дахиад л уйдан залхаж, уулын оройд гарч, дуран ч юмуу, дуранбай ч ч юмуу, ямар нэг зүйлээр баруун тийш харав. Энэ удаа тэр “Америк” гэж хэлэв. Магадгүй, Колумбыг нээхээс нь өмнө тэр үүнийг харчихсан байж л дээ. Тэгээд “Энэ газар маш том, үзэсгэлэнтэй аж - Калифорнийн эрэг” гэв. Өө, үгүй, үгүй. “Майамийн эрэг, Калифорнийн газар хөдлөлт.” Өө үгүй ээ. (Инээлдэв) “Цаг агаар сайхан байна. Баруун Виржиниад цас орж байна. Ай даа, юм юм л байна. Би энэ газрыг авдаг хэрэг ээ” гэжээ. За ингээд л хэллээ, хүслээ, мөн л урьд өмнө олон удаа болсон шигээ хүссэнчлэн биелжээ. Дахиад мянган жил өнгөрөхөд тэр дахин уйдаж, жаргалгүй болов.

Түүнийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай руу явуулах хэрэгтэй гэж би та нарт хэлээ биз дээ. Тэгсэн бол Тэр түүнд энэ хорвоод юу ч түүний сэтгэлийг хангахгүй гэж хэлэх байсан! (Их Багш болон бүгд инээв) Их Багшгүй байхын асуудал бэрхшээлийг харж байна уу? Танд амьд их багш байхгүй бол маш хэцүү. Гүрү бүхэн танд ингэж хэлнэ.

Хүний амьдралын мөнх бус чанарыг хэлж өгөх Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шиг тийм Багш түүнд байгаагүй аж.

Хэдэн мянган жил амьдрах байлаа ч нэг л өдөр та үхэх л ёстой болно, та бас эндээс юу ч авч явж чадахгүй. Таныг ямар ч физик биет зүйл амьдралын чинь өдөр бүр үүрд сэтгэл хангалуун байлгаж хэзээ ч чадахгүй. Сэтгэл ханамжаас өөр зүйлийг хайвал та эцэстээ үргэлж урам хугарч, зовж шаналах болно. Та оролдож хичээх болгондоо хана нүдэж байгаа мэт болж, дахин эргэж буцах, үйлдлээ ахин өөрчлөх хэрэг гарна. Бүр хайр дурлал, үр хүүхэд, нөхөр, эхнэр, хүний амьдралын хамгийн сайхан мэдрэмж авчирдаг гэж бодож байгаа бүхэн ч хэзээ ч удаан үргэлжилдэггүй. Өнөөдөр сайхан байх ч маргааш тэр нь сэтгэлийн зовлон, асуудал бэрхшээл, үр дагавар, элдэв янзын уй гашуу, санаа зовнилыг араасаа дагуулдаг.

Хайрладаг хэн нэгнийг авч үлдэхийн тулд та маш их хүчин чармайлт гаргах хэрэгтэй болдог. Түүнчлэн өөрийг тань хайрладаг хэн нэгнийг авч үлдэхийн тулд маш их хүчин чармайлт гаргах хэрэгтэй болдог. Ямарваа нэг буруу, ухаангүй алхам гэгддэг зүйл чинь харилцааг тэр даруйд нь сүйрүүлж, заримдаа засах боломжгүй болгодог. Тийм учраас Дэлхий дээр Хаант улсаа байгуулахын тулд, нөхөрсөг харилцаагаа сэргээн босгохын тулд бидний энэ хорвоод зориулж байгаа чармайлт бүхэн, хэдийгээр бид эцэс сүүлд нь, эсвэл хааяа нэг завсар хооронд нь амжилт олдог ч гэсэн цаг үргэлж төвөг чирэгдэл дагуулдаг. Түүгээр барахгүй, үүнийгээ хадгалахын тулд бид хамаг энерги, цаг хугацаа, залуу нас, анхаарлаа зарцуулах шаардлагатай болдог. Тэр нь ямар харилцаа, эсвэл ямар эрдэнэс байх нь чухал биш. Танд ийм зүйл тохиолдож байсан уу? Тохиолдож байгаагүй бол, та туршаад үзэж болно. Явж хаа нэгтээ очоод хайрлаж дурла, тэгээд юу болсныг надад яриарай.

За, Энэтхэг, шуналт хааны тухай яриандаа эргэн орё. За ингээд, хорвоог тойрон тэнүүчилсний эцэст тэр уйджээ. Дөрвөн мянган жил дэлхийн дөрвөн хязгаарыг эзлэн суусны эцэст хаан уйтгарлаж эхлэв. Одоо түүнд тоглож наадах зүйл үлдээгүй тул уйдаж үхэх гэж байлаа. Тэр бүх зүйлийг, бүх эзэлсэн улсаа нэр усаар нь мэднэ. Улс орныхоо бүх тоглоом, уулзсан бүх үзэсгэлэнт бүсгүй, юм бүхнийг тэр мэднэ. Харин одоо тэр Дэлхийгээс уйдаж, хийх зүйлгүй болсон байв. Нэгэнтээ тэр нэг газар сууж байж. Тэр бүр цадаж ханасан тул мөнгөн дээр ч бясалгаж чадахаа болив. Түүнд мөнгө хангалттай бий. Дэлхий дээрх бүх зүйл түүний мэдэлд ирсэн учраас тэр өөр юу ч бясалгаж чадахгүй байв. Тэгээд л тэр тэрүүхэнд нэг газар сууж байв. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг хайж олохоор Хималай уулыг зорихын оронд тэр зүгээр л Бурхны тухай бодож, Бурхан дээр бясалгав.

Аа, ха ха, ашгүй дээ, Бурхан минь. Та нар үүнд итгэх үү? Тэр эцэстээ нэг юм Бурхныг л бясалгасан байна. Тэгээд тэр ийнхүү боджээ. “Аяа, Бурхныг хардаг ч болоосой. Бурхныг харахыг хичнээн их хүснэ вэ! Хэрвээ Бурхны барааг нь ч болтугай харчихвал тун сайн, үнэхээр сайхан байхсан. Ээ, Бурхан минь! Би Бурхан таныг яавал харах вэ?” (Инээлдэв) Тэр ингэж хүстэл хүсэл нь биелчихэж гэнэ. Түүний чин сэтгэлийн хүсэл Бурхны сэтгэлийг хөдөлгөжээ, энэ нь магадгүй материаллаг хүсэл байсан байх. Ингээд Бурхан түүнийг Хаант улсдаа урьжээ. Тэр нь магадгүй Асурийн ертөнцийн бурхан, Вишнү бурхан, эсвэл Шива бурхан байх. Аль бурхан тэнгэр нь байсныг бид мэдэхгүй.

Яахав, тэр үнэхээр материаллаг үзэлтэй болохоор Асурийн хаант улсад очсон гэж бодсон байх. Тэр зүрх сэтгэлдээ сүслэн биширч, тэсгэлгүй хүсэн тэмүүлсэндээ Бурхныг харах гэсэн биш, харин Бурхны Хаант улсыг л үзэхийг хүссэн учраас л Бурхныг харахыг хүссэн юмсанж. Бурхны Хаант улс өөрийнх нь хаант улсаас ялгаатай байна уу, үгүй юу, түүнд сурах, харах, тоглогчихмоор өөр зүйл байна уу л гэсэндээ харахыг хүссэн хэрэг. Энэ нь угтаа цэвэр материаллаг сониуч зан байжээ.

Бурхан маш өгөөмөр, хайрлагч нэгэн байлаа. Юутай ч гэсэн түүнийг бясалгасан хэн нэгэн анхаарлыг нь татжээ. Бурхан ийм л байдаг. Хэдийгээр тэр ердөө л Асурийн ертөнцийн бурхан хэдий ч энэрэл нигүүлслэлтэй, хайрын сэтгэлтэй ажээ. Асурийн бурхан ч бас л хамгийн дээд Бурхны төлөөлөл юм. Бүхнийг чадагчийн зарим чанар түүнд байдаг.

Тэгээд нөгөө хааныг Бурхны хаант улсад зочлохыг болгоомжтойгоор, хайрлан зочломтгой гэгч нь урьжээ. Тэгээд түүний ҮМНБ, нисэх онгоц өөр юу нь ч юм, сүйх тэрэг нь түүнийг дээш нь, бурхад залардаг Хаант улс руу аваачив. Ингээд Бурхан, Асурийн, оюун ухааных, акашийн Будда бурхан гээд аль хаант улсынх нь юм, би мэдэхгүй, түүнийг хажуудаа суухыг урьжээ. Тэр Бурханд өглөөний нар мэт гялалзах үнэт чулуу, очир эрдэнийн чимэгтэй алтаар хийсэн урт гэгчийн зөөлөн буйдан байх юм гэнэ. Ингээд тэр түүнийг бүр дэргэдээ сууна уу гэж урьжээ – маш болгоомжтой Бурхан шүү дээ. Бурхан нэн найрсаг, зочломтгой, эелдэг гэгч нь янз бүрийн жигнэмэг, чихэр, усан үзэм, алимаар дайлав. Бурхны Хаант Улсад байдаг бүхнээр түүнийг, бас дээрээс нь дагалдан яваа морь, заан, хатан, сүйх тэргэний хөтөч, цэрэг, генерал, сайд гээд бүгдийг нь дайджээ. Ингээд Бурхан түүнтэй маш нөхөрсгөөр хүүрнэн ярилцав.

Хэзээ ч ханаж цаддаггүй хаан тэнд суугаад Бурхантай ярилцаж байхдаа бас эргэн тойрноо ажиж байв. Гайхалтай! Очир эрдэнийн дэнлүү! (Инээлдэв) Пөөх! Тэр дэнлүүг нь бадмаараг эрдэнээр хийжээ, нөгөөх нь сувдан юм байна. Энд байгаа бүхэн манай Дэлхий дээр байгаа бүхнээс илүү үнэтэй, үзэсгэлэнтэй юм байна. Бүр очир эрдэнэ

нь ч өөр юм; алт нь өөр, мөнгө нь ч өөр юм гэх мэт. Энэ бүхэн нь хааны нүдэнд, бас мэдээжээр, зүрх сэтгэлд нь ч мянга дахин сайхан, бүр илүү үнэ цэнэтэй, бодитой, тааламжтай санагджээ.

Тэгээд тэр тэнд суугаад (Чимээгүй инээв) боджээ. Тэр харж байхдаа тавхайгаараа боджээ. Дараа нь өвдгөөрөө бодов, тэгээд наран сүлжээгээрээ бодох гэж оролдов, харин сүүлд нь зүрхээрээ бодохыг оролдов. Энэ нь бас л болж өгсөнгүй. Дараа нь тэр хоолойгоороо бодож үзэхийг хичээв. Түүний бодож чадсан нь ердөө энд л хүрсэн ажээ. Энэ нь ч мөн болж өгсөнгүй, учир нь тэр бүгдийг нь залгичихмаар байжээ. Тиймээс түүний хамгийн төвлөрсөн хүрд нь хоолойных нь төв байжээ. Тэр харсан бүхнээ идчихмээр байжээ. Тэрээр нүдэнд туссан юу л байна, тэр бүгдийг эзэмдэж, залгичих юмсан гэж хүсжээ.

Тэр бодсоор хоолойн дээрээ ирэх үест Бурхны Хаант улсыг залгичих хүсэл төржээ. Тэгээд ийнхүү хэлжээ. “Гайхалтай! Ямар сайхан юм бэ. Энэ хөгшнийг зайлуулчихаад (Их Багш болон бүгд инээлдэв) би өөрөө хаан болчихвол яасан юм?” гэжээ. Аяа яа яа! Тэр ийнхүү тэндээ суусан чигтээ хоолойгоороо бодсоор байв.

Тэнгэрийн орны хаан бол бас л бурхан. Дээд, доод аль зэрэглэлийнх байх нь чухал биш, ямар ч атугай бурхан мөнөөс мөн. Хааныг өөрийн хоолойн төвөөр бодож байхад нь төвөнх нь дээш доош хөдлөөд байхыг бурхан харжээ. (Их Багш болон бүгд инээлдэв.) Түүний хоолойн төв идэвхжээд байхыг хараад тэр ойлгочихож. Бурхан билгийн нүдээрээ хоолойн төв рүү нь хараад л байв. Тэгээд тэнд болж буй хар захын наймаа, (Их Багш болон бүгд инээлдэв.) тэндэх мафийн бүлгийг, тэнд бичигдсэн хамаг гэмт хэргийн бичлэгийг харжээ. Ингээд бурхан тэр хааны ухаан санаанд юу болж байгааг мэдсэн хэр нь мэдээгүй царайлжээ. Тэр юу ч хэлсэнгүй. Харин ч бүр найрсаг, нөхөрсөг байхыг хичээж, улам олон зүйлээр дайлав.

Үүний дараа бурхан уулын өвөрт байж байхдаа хаанд ойлгуулахыг хичээж: “Өө, би зав муутай байна. Уулын гүнд авшиг хүртээх ёслолтой. Гадаадаас ирсэн таван зуун шавь бясалгалын өргөөнд байж байгаа, тав зургаан барилга барьж байгаа, тиймээс та намайг өршөөнө үү?” (Их Багш болон бүгд инээлдэв.) Тэгээд “Баяртай” гэв.

Тэр хаан энэ Бурхны Хаант Улсад үлдэхийг маш их хүсэж байв. Гэтэл тэндхийн бурхан-хаан түүнд явах ёстойг нь ойлгуулжээ. Тэр тэндээ үлдэж, арай удаан байхыг оролдтол нар шиг томоо нүдтэй, бас атомын бөмбөг шиг гялалзаж гэрэлтсэн Бурхны сахиулсан тэнгэрс, олон “хуфа” (ном хамгаалагч) нар түүн лүү гөлрөн ширтээд байсан ч юу ч хэлсэнгүй. Тэгтэл бурхан түүнд: “Та нэг бол сайн дураараа эндээс даруйхан яв, эс бөгөөс таныг хүчлэн даруйхан явууламц” гэв. (Их Багш болон бүгд инээлдэв.) Тэгээд хаан өөрт нь хэдхэн генерал, цэрэг, жижиг сүйх тэрэг л байгаа; тэгтэл тэнд нөгөө хүчирхэг нүд, гартай, томоо шүхэртэй хамгаалагч сахиулсан тэнгэрс байхыг хараад явсан нь

дээр гэдгийг ойлгов. Ингээд тэр хөдлөхөөс аргагүй болжээ. Тэр дахин Дэлхийдээ эргэн иржээ.

Энэ өдрөөс хойш бурхан түүнийг дахин ивээсэнгүй. Тэгээд тэр өвдөж, маш их зовсон бөгөөд тэгээд үхэх гэж байлаа. Үхэхээсээ өмнө тэр сайд, албатуудаа орныхоо дэргэд дуудаж ирүүлээд их харамсаж байгаагаа хэлэв. Үхэж байгаа шалтгаанаа мэдэж байгаа учраас маш ихэд харамсаж байв. Бурхан түүнийг шийтгэж байна гэдгийг мэджээ. Бурхан түүнээс мөнхийн жаргал, мөнх амьдралын хүчийг нь буцааж аваад харин одоо түүнд асар их өршөөл хайр бэлэглэсэн нь үхэх ял ажээ. Тэр маш ихээр харамсаж, нэн ихээр гэмшиж байлаа. Тэр сайд нараа дуудаад “Намайг үхсэний дараа хүмүүс намайг яагаад үхсэнийг асуувал шуналаасаа болсон гэж хэлээрэй” гэжээ. Энэ ч аргагүй тийм юм. Тэгээд нүдээ аниад булшиндаа үүрд оржээ. Баяртай. Төгсөв! (Алга ташив).

Харав уу, бид бас материалист бясалгагч байж мэдэх нь. Хэдийгээр бид сүнслэг бясалгал гэгдэх зам мөрийг дагаж байгаа ч өөрийгөө ямагт шалган нягталж байх ёстойг энэ үлгэрээр бидэнд сануулахыг зорьжээ. Материалист сүнслэг бясалгалыг дагаагүй гэдгээ байнга магадалж, шалгаж байх ёстой. Хэдий ингэж нэрлэдэг ч гэсэн. Учир нь бид илүү эрх мэдэлтэй болох гэж аливаа нэг зам мөрийг дагавал улмаар өөрөө огт мэдэлгүйгээр бусдыг хяналтдаа авч чадна, эсвэл орчлонгоос, хүмүүсээс юм авна. Заримдаа та өөрөө ч мэдэлгүйгээр материалист сүнслэг бясалгал хөөцөлдөж байдаг. Жишээлбэл, та энд ирэхдээ, эсвэл Их Багшийн байгаа газар очихдоо түүнийг өвчнийг тань эдгээж өгнө гэж горьддог, учир нь та эмчид очихыг хүсдэггүй. Та өөрийгөө ийм юм шаардах эрхтэй гэж боддог. Та энд маш хүнд өвчтэй ирээд өөрийгөө, бас хариуцлагаа ашрамд үүрүүлж, нэг шөнийн дотор эдгэрэхийг хүсдэг; эсвэл ямар нэгэн байдлаар улам баян, илүү хүчирхэг болохыг хүсэхдээ Их Багш хүслийг тань тэр ёсоор нь гүйцэлдүүлчихнэ гэж горьдон хүлээдэг. Энэ бол сайн юм биш.

Та хэдийгээр Арьяабалын аргаар бясалгаж, сахил санваар баримталж, бас дадуулж байгаа ч, ухаан санаа чинь материаллаг хэрэгцээнээс цэвэрлэгдээгүй байх юм бол энэ нь ашиг тусгүй. Мэдээж, та гай зовлонд өртсөн үедээ тусламж гуйх нь аргагүй зүйл. “Би одоо ажилгүй байна, түрээсээ төлөх хэрэгтэй байдаг. Их Багш аа, ажил олоход минь туслаач” гэх жишээтэй. Энэ бол өөр хэрэг. Хэрэгцээ тулбал гуйж болно, гэхдээ шаардлага гараагүй байхад...

Хэрэв хүмүүс авшиг хүртэхээр ирэхдээ үүний дараа энэ эмэгтэй ийм тийм материаллаг олз ашиг, эсвэл нийгэмд өндөр байр суурьтай болно гэж горьдох юм бол жигшүүртэй юм болно. Бид аль нэг Их Багш дээр ийм юм горьдож очих ёсгүй, учир нь маш ихээр урам хугарах нь дамжиггүй. Эсвэл урам хугараагүй байлаа ч Их Багш таны хүслийг биелүүлж ч магадгүй. Гэсэн ч бид хэдий чинээ их хүснэ, төдий чинээ

сэтгэл хангалуун биш болно, тэгэнгүүт улам хүсээд л байдаг, эцэс төгсгөлгүй хүсээд л байдаг. Тэгээд анхаарал, энерги чинь дандаа материаллаг зорилго дээр төвлөрөөд байвал дотоодын Хамгийг Чадагч Хүчээ мартаж болно.

Бид Хамгийг Чадагч Хүч чадалдаа хүрсний дараа бидэнд бүх зүйл хэрэгтэй цагтаа гуйлгалгүйгээр хүрээд ирнэ. Гэхдээ бид үүний төлөө энд ирдэггүй, бид материаллаг таашаал ханамж, эсвэл бусад ид шидийн хүчний төлөө ч ирдэг юм биш. Энэ бүхэн нь асурийн ертөнцийн хүсэл. Зөвхөн мөнгө хүсэх төдийхөн биш, өөр утгаараа ч бусад бүх зүйл материаллаг, тиймээс тэр бүхэн нь бас л биежиж биелнэ, гэхдээ ид шидийн хүч, эсвэл бусад хүмүүсийг, цаг агаар, эргэн тойрноо хянахыг хүсэх нь мөн л материаллаг хүсэл. Энэ нь бүр ч дор. Ажил хэрэгч хүмүүсийн адилаар бид бизнес хийхээр явахдаа мөнгө олох энэ тэр гээд иймэрхүү зүйлтэй болохыг хүсдэг. Бид зөвхөн билиг ухааны л төлөө, өөрийгөө таньж мэдэхийн төлөө, Гэр минь хаана байгааг мэдэхийн төлөө, бүхнийг хайрлагч, аз жаргалтай, эрх чөлөөтэй байхын төлөө л бясалгах ёстой. Ердөө л энэ. Өөр бусад зүйл ирэх, ирэхгүй нь зүгээр л дашрамд болох хэрэг.

Би та нарт бүгдийг хэлж өгсөн, мэдэж байгаа юу, үгүй юу? Та нар хийх үү? Гэхдээ та заримдаа мэдэж байдаг ч бясалган дадуулах чинь өөр байдаг. Хөгжилтэй шүү. Тиймээс бид үргэлж шалган нягталж байх ёстой. Бид алдаа гаргах нь дамжиггүй, гэхдээ бид үүнийгээ шалган нягталж, засах ёстой.



## ГЭГЭЭН ХААНЫ НИГҮҮЛСЭЛ

*Төгс гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
1995 оны 7 дугаар сарын 12 (Дүрс бичлэг 489)  
Формоса, Шихү төв. (Эх нь Англи хэлээр)*

Эртээ урьдын цагт, зүйрлэшгүй сайн нэгэн хаан байжээ. Маш нигүүлсэнгүй, асар хайр энэрэлтэй байсан тул түүнийг эрт цагт Шагжамуни Буддагийн хувилгаан дүрүүдийн нэг байсан байх ёстой гэцгээж байв. Тэр улсын ард олон бүгд л түүнийг Бодьсадва гэж үздэг тул гэгээн хаан хэмээн дууддаг байв. Энэтхэгт олон Махаража байдаг; тэд ч бас гэгээн хаад юм. Асуудал бэрхшээлтэй, эсвэл тусламж хэрэгтэй байгаа хэн хүн бүгд л түүн дээр очиход тэр хаан үргэлж хамаг чадлаараа туслахыг хичээдэг байлаа. Тиймээс ч түүний улс оронд хүн ард нь сайхан амьдарч, маш их аз жаргалтай, цэцэглэн хөгжиж байлаа; хэн ч, юугаар ч дутагдаж гачигдаж байсангүй. Сайд түшмэд нь ч бас ард олондоо сайхан сэтгэлээр ханддаг байв. Тиймээс ард түмэн нь хэзээ ч ямар нэгэн байдлаар дарлагдан зовж үзээгүй аж.

Тэгэхлээр одоо, энэ хаан юу хийсэн болоод гэгээн хаан хэмээх алдрыг хүртэх гавьяатай болсныг харцгаая. Улс орныхоо бүх албат иргэдээ баярлуулахаас гадна өөр юу хийсэн юм бол? Тэрээр хааны ордонд хэзээ ч ямар нэг зардал үрлэг ихтэй, төвөг чирэгдэлтэй баяр наадам зохиож байсангүй. Хаанд зориулдаг нэг тийм хааны ордны ёслол байдаг шүү дээ, мэднэ биз дээ. Ер нь эрт цагт ард олонтойгоо мэндчилэхээр хаан гарч ирээд ямар нэг ёс заншил гүйцэтгэх үеэр маш олон асуудал гардаг байжээ: өдий төдий хүж, цэцэг, харуул хамгаалалт, магадгүй их буугаар буудаж - “галт бөмбөг гарздах” гэх мэтийн зүйл болдог. Их буугаар хэдэнтээ буудахад “галт бөмбөг” хэрэгтэй, олон ч галт бөмбөг үрж гарзаддаг бөгөөтөл тэр хаан хэзээ ч ийм зүйл хийж байгаагүй ажээ. Олсон бүх мөнгөө, эсвэл хаант улсынхаа орлогыг эмнэлэг, сургууль, зам гэхчилэн ард түмнийхээ хэрэгцээт зүйлд л зарцуулдаг байжээ. Түүнд олон сайд байсан нь нэн язгуур сурвалжит тогтолцоотой болохыг хүссэндээ биш, харин гачигдаж дутагдсан хүмүүст илүү хурдан, үр дүнтэй туслахад нь тийм олон сайд хэрэгтэй байсных юм.

Аливаа нэг ёслол нь маш энгийн байв. Өөр бусад хаанд хэрэв сайд түшмэл нь бараалхвал “Өө болно, тааваараа бай” гэж тэр хааныг

хэлэх хүртэл магадгүй гурвантаа, эсвэл ядаж нэг удаа шалан дээр сөгдөн хаанд мөргөдөг байх жишээтэй. Харин энэ хаан ийм дэмий зүйл хийдэггүй. Та түүнд бараалхвал “Надад хэлж мэдээлэх зүйл байна” гээд л явж очоод суучихна. Эсвэл та түүн рүү утасдах юмуу, радио утас ашиглаад (Их Багш болон бүгд инээв) “Хаантан, амар байна уу. Та гэртээ байна уу? Надад мэдээлэх зүйл байна” гэж хэлнэ. Иймэрхүү янзтай байдаг аж.

Мөнгөнийхөө дийлэнхийг ард түмнийхээ эн тэргүүний хэрэгцээт зүйлд зарцуулна. Тэгээд өөрөө их даруухан амьдарч байжээ. Ердөө нэр төр, тав тухаа хадгалах төдийхөнд зарцуулаад харин дэмий үрлэг зарлага гаргадаггүй байв. Үүгээр зогсохгүй хаан өөрөө ч бас бага сага мөнгө олохын тулд гарч ажил хийдэг байжээ. Тэр хувцас хунар, гоёл чимэглэл мэтийн загвар бүтээж арилждаг байлаа. Энэ улс оронд хүн бүр нэн сэтгэл хангалуун аж төрж байжээ.

Тиймээс олон хөрш улс орныхон нь амар амгалан, цэцэглэн хөгжсөн, аз жаргалтай тэр улс руу ард түмнээ цагаачлуулахыг хүсэхгүй байсан тул хилээ хаажээ. Ха ха. Юу болж байгааг харж байна уу? Энэ улс хаалга үүдээ хааж барьсангүй. Харин хөрш улсууд нь өөрсдөө хаалгаа хаажээ. Энэ инээдтэй биш гэж үү? Яагаад гэвэл хилээ хаагаагүй бол нэн өгөөмөр хаантай, маш үр бүтээмжтэй, хайраар дүүрэн сайд түшмэдтэй, ард олон нь аз жаргалтай, сэтгэл хангалуун тэр газар нутаг руу хүн ард нь дүрвэн одсоор байх байсан.

Тэгтэл хөрш улсуудын нэгнийх нь хаан маш муу нэгэн байжээ. Будда хаана ч дахин төрсөн байсан хажууд нь гай тарьдаг муу этгээд байдаг байсан. Инь ба Ян, эерэг ба сөрөг тал үргэлж байдаг. Ингэхэд энэ хөрш улсын хаан тэр нэн сайн гэгээн хаанд маш их бухимдаж, нэн их атаархан жөтөөрдөг болсон байж, учир нь хүмүүс гэгээн хааныг асар их магтан шагшиж, тун ч дээдлэн хүндэтгэж байсан бөгөөд түүний хичнээн энэрэнгүй, нинжин сэтгэлтэй, ямар их мэргэн ухаан, анхаарал халамжтай тухай олон сайхан түүхийг ярьдаг байж л дээ. Тиймээс тэр атаархсандаа галзуурах шахаж байлаа. Түүнээс гадна олон хүн сайн хааны үйлдлийг түүний өөрийнхтэй нь үргэлж харьцуулдаг байсан бөгөөд ингэхэд үргэлж асар их ялгаатай байдаг байв. Тиймээс тэр тэвчиж чадсангүй.

Хэрэв энэ хүн та байсан бол мөн л тэвчиж чадахгүй байх. Хэрэв би байсан бол бас л тэвчихгүй байх. За, би наргисан юм. Ер нь бид хаант улсыг хүсэх үү? Үгүй. Таны зөв. Тун ухаалаг юм.

Тийм учраас тэр тун их гомджээ; түүний бардам зан хөндөгджээ. Хожим нь хөршийнхөө атаархлаас болж сайн хаан маш их зовлон зүдүүрийг амсаж тэвчих болсон шалтгаан нь энэ. Үүнийг бид дараа сонсомз. Энэ хөрш улсын муу хаан дэндүү их атаархлаасаа болж учир зүй, ухаж ойлгох чадвараа алдаж, улмаар сайн хаантай дайтахаар

шийджээ.

Нэгэн өдөр муу хаан дайтах гэж буйгаа мэдэгдэхээр сайн гэгээн хаан луу дайны элч илгээжээ. Гэгээнтэн хаан дайны мэдэгдлийг хүлээн аваад маш их цочирдов. Тэрээр “Гэвч танай хаан бидэнтэй дайтах гэсний шалтгаан юу юм бол? Хэрэв бид ямар нэг буруутай бол уучлалт гуйя, хүлээн авна уу. Танай эрхэм дээд хааны дайтах уур хилэнг өдөөж, өөртөө гай удахгүйн тулд зам мөрөө хэрхэн засахыг бидэнд хэлж ажаамуу” хэмээн ахин дахин асууж учирлав гэнэ.

Гэтэл элч “Үгүй ээ. Бид уучлалт гуйхыг яасан ч хүлээж авахгүй. (Их Багш болон бүгд инээлдэв) Бид зөвхөн дайныг хүсэж байна. Гүйцээ” гэжээ.

Ингээд удалгүй хөрш орноос нь хүчирхэг том арми улс оронд нь нэвтрэн орж ирэв. Зүгээр л ороод ирж. Ямар ч шалтгаангүй. Ямар ч зөвтгөх шалтаггүй. Тэр ингэх хэрэггүй л байсан шүү дээ. Магадгүй түүнд олон зөвтгөх шалтаг байсан байх. “Чи надаас илүү юм.” Энэ нь л зөвтгөх шалтаг нь байж. “Хүмүүс чамайг магтдаг, намайг магтдаггүй”, энэ ч мөн сайн зөвтгөх шалтаг юм гээч.

Йогийн болон бусад шинжлэх ухааны олон салбарын багш гэгдэгчид ч мөн л адил. Хэрэв тэр хүн маш алдартай, ухаантай, олон хүн түүнтэй санал нийлдэг бол ихэнх тохиолдолд энэ хүн ямар нэг таагүй зүйлд орооцолддог.

Ингээд гэгээн хаан өөрийг нь дайн тулаан хийхэд тулган шахамдуулж байгааг мэдэрчээ. Тэр хүсэхгүй байлаа, тэгээд сайд түшмэд, бусдаасаа “Бид тэдэнтэй тулалдах ёстой юу? Дайтах хүсэлтэй хүн байна уу?” гэхэд хэн ч дайтахыг хүссэнгүй. Тэр ч байтугай улс орных нь ард иргэд ч хүссэнгүй. Бусдыг хөнөөх энэ дайнд ямар нэг шударга үндэслэл, учир шалтгаан байхгүй гэдгийг тэд мэдэрч байсан тул тулалдах дуртай хүн олдсонгүй. Тэдэнд ингэх ямар ч зөв зүйтэй учир шалтгаан харагдсангүй.

Ингээд муу хаан ямар ч эсэргүүцэлтэй тулгаралгүйгээр нийслэлд нь ирээд тэдэнд бүгд зэвсгээ хаяж, бууж өгөх ёстой гэж шаардав. Тэгэхгүй бол тэр хүн болгоныг алж, хүүхдийг ч амьд үлдээхгүй. Тэр ингэж хэлжээ.

Энэ хаан ордон луу дахин зарлиг илгээж, хэрэв тэд бууж өгөхгүй бол, сайн хаан нь ч бууж өгөхгүй бол бүгдийг хядна гэж тулгажээ. Энэ мөчид бүх хүн ихэд эмзэглэв. Улс үндэсний бахархлыг нь хөндсөн тул тэд хаандаа “Бид гарч, эцсийн хүнээ дуустал тулалдах ёстой” гэжээ.

Юутай ч эндээ, билгийн нүдэн дээрээ төвлөрч нилээн эргэцүүлэн бодсоны эцэст гэгээн хаан босож зогсоод: “Намайг бууж өглөө гэж хаандаа хэлнэ үү. Түүнийг хүрч ирээд миний хаант улсыг, хаан ширээг минь эрх мэдэлдээ ав гэж хэлнэ үү. Хоёр үндэстний ард иргэд зөвхөн миний энэ алтан сэнтийн төлөө цусаа урсгаж, амь насаа золихыг би

хүсэхгүй” гэжээ. Юутай ч ийм явдал болов.

Тэгээд сайн хаан хүмүүстээ зэр зэвсгээ хураалга гэж хэлэв. Хэрэв тэд шинэ хаантай хамт үлдэхийг хүсвэл үлдэж болно. Хэрэв тэтгэвэртээ гарч гэртээ харихыг хүсвэл бас л болно, зүгээр гэв. Тэгээд тэр: “Шинэ хаан буян хишиг, мэргэн ухаанаараа надаас ч илүү дээр байж, энэ улс үндэстнийг захирах болтугай гэж залбирья” гэж хэлэв. Ингээд тэр зүгээр л хааны хувцас, жанч өмсгөлөө тайлж, титмээ ширээн дээр тавиад гарч одов.

Адууны жүчээний дэргэдүүр өнгөрөх үест морь нь түүн лүү харжээ. Морь нь их л баярлан жаргаж, нэг ёсондоо бараг “ий хо хо, ий хо хо” гээд янцгааж гэнэ. (Инээлдэв) Морь яаж янцгаадгийг та нар мэднэ дээ. Магадгүй би морь шиг сайн янцгааж чадахгүй байх, гэвч морь үнэхээр хаанд дуулж өгсөн бөгөөд “Өө, намайг аваад яваач дээ” гэх шиг түүн рүү харжээ.

Гэвч хаан толгой сэгсэрч, “Үгүй ээ, чи минийх байхаа больсон. Би бүх зүйлээ шинэ эзэнд өгчихсөн тул одоо чи ч бас түүнийх. Надад чамайг авах эрх байхгүй. Чи эндээ үлдэж, шинэ эзэндээ үйлчил. Баяртай” гэжээ.

Ингээд тэр ямар ч эд хөрөнгөгүй жирийн хүн шиг алхаж оджээ. Энэ явдлыг мэдсэн улс орных нь ард олон бүгд сэтгэл хөдөлсөн тул гудамжны хоёр талаар сөхрөн суугаад уйлж байж. Гэгээн хаан нэн сайхан сэтгэлтэй хүн байжээ. Ард түмнийхээ хайр сэтгэл, сайн санаа, эв нөхөрлөлийг харсан тэр маш шаналж байсан ч яаж ч чадсангүй. Тэр цааш алхсаар бас өөрөө уйлсаар байв.

Тэр үеэр муу хаан орж ирээд хаант улс болон хаан ширээг нь эзэгнэв. Гадаа зам дээр сайн хаан ард олныхоо хамт үлдээч гэх гуйлтыг сонсож тэвчилгүй зугтаахын наагуур гүйх аядан алхаж байв. Тэр их хурдан алхсаар байв. Эрх мэдэл, хаан ширээ, сүр жавхлангаа алдсандаа тэр тэтгэлээ харамссангүй. Түүний зөв шийдвэр олон хүний амь насыг, ялангуяа өөрийн ард иргэдээ аварсанд тэр харин ч нэн баяртай байв. Дайнд ялсан, эсвэл ялагдсанаас үл хамааран олон хүний амь нас хохирч, улмаар гар хөл, нүд ам, магадгүй оюун ухааны чадвараа алдсан эрэмдэг зэрэмдэг хүмүүс, бэлэвсэн эхнэр, өнчид олширч; гэр орон, итгэл найдвар, ирээдүй гээд хамаг бүхнээ алдсан байх болно гэдгийг тэр мэдэж байлаа.

Тэр зам даган явж байтал гэнэт нэгэн хүн түүнийг зогсоож, зам дээр сөхрөн суугаад гэр бүлийг нь болон өөрийг нь хамгаалахыг гуйж, тусламж хүсэв. Гэгээн хаан шаналангүй инээмсэглэн түүнд “Таны гуйлт даанч цагаа олсонгүй дээ” гэжээ.

Тэгтэл тэр хүн “Яагаад тэр вэ?” гэв.

Гэгээн хаан “Би бүх хаант улс, хаан ширээ, хамаг бүхнээсээ аль хэдийн татгалзчихсан, одоо тэр бүхэн шинэ эзэнтэй болсон” гэж хэлэв.

Тэр хүн “Гэхдээ таны эд хөрөнгө яасан бэ? Таны эд хөрөнгө юу болов, одоо ч тэндээ байгаа юу?” гэв.

Хаан “Юу ч үлдээгүй. Юу ч байхгүй. Бүгд өөр хүнийх болсон” гэв.

Тэгтэл тэр хүн “Та хаана байрлаж байгаа вэ? Та хаана амьдрах вэ?” гэв.

Хаан “Яахав, энэ хавьд хаа нэгтээ газар олно” гэв. Тэгээд тэр: “Чи зоригтой бай, дахиж битгий уйл. Нөхцөл байдалтай эвлэрч, сайжруулахыг хичээх хэрэгтэй” гэв. Тэр хүн уйлсаар л байв. Хаан түүнээс “Яав? Чи яагаад уйлаад байгаа юм? Одоо бид хоёр хоёулаа адилхан болсон. Та аз жаргалтай байх ёстой. Надад чамаас дээрдэх юм алга” гэв.

Тэгтэл өнөөх хүн: “За, та бүх зүйлээ орхижээ; та үүнийг л хүссэн. Та орон гэргүй, гар хоосон хүн болоход дуртайяа бэлэн байна. Харин би баян байхыг хүсэж байна. Би мөнгөтэй болмоор байна. Танаас тусламж гуйсан ч түүнийгээ хүртсэнгүй. Тийм учраас би зовж байна” гэв. (Инээлдэв.)

Хоёулаа өөр өөр зүйл хүсжээ. Яахав, тэр илүү хялбар арга замыг сонгох хэрэгтэй байж л дээ. Хэрвээ тэр хаан шиг бодож сэтгэхийг хүссэнсэн бол түүнийгээ аль хэдийн тэнд хүртчих байсан, гэхдээ тэр ямар нэг өөр зүйл хүсжээ. Тийм учраас л энэ нь төвөгтэй хэцүү байсан хэрэг.

Тэр хүн хувь заяандаа гомдон гашуудсаар л байв. Тэгээд хаантанд найдаж байсан ч тэр хаан одоо ямар ч нэмэргүй хүн болжээ, яагаад гэвэл байгалийн гамшиг гэх мэтийн зүйлээс болоод хамаг байр сууриа алдсан тул өөрт нь юугаар ч тусалж чадахгүй нь дээ гэжээ. Ингээд тэр уйлаад л байв, чин зүрхнээсээ уйлж байв. Тэр яахаа мэдэхгүй байна гэж бодон толгойгоо доош нь ингэж тавиад (Их Багш дуурайж үзүүлэв), хэн лүү ч харсангүй.

Тэгснээ тэр хүн гэнэт ихэд уурлав. Тэрээр: “Чи чинь хаан биз дээ, тэгсэн хэр нь юу ч хийж чадахгүй юу! Хэрэггүй амьтан! Чамд надад татгалзах эрх байхгүй. Би албат иргэн чинь шүү. Би чамаас тусламж шаардах эрхтэй, гэтэл чи юу ч хийхгүй байна. Аа, хэрэв чи хаан ширээндээ байж байсан бол би ийм аймшигтай байдалд орохгүй байсан! Үгүй гэж үү? Үгүй юу?” гэж уурлав.

Хаан ихэд аягүйрхэж, “За, анд минь, намайг яагаад хаан ширээг орхих ёстой болсныг чи мэдэх үү? Олон хүний амь наснаас болсон юм. Гэхдээ би үүнийг Бурхны тааллын дагуу хийсэн, учир нь Бурхан хүмүүсийг үргэлж хамгаалахыг хүсдэг, хэзээ ч, хэнийг ч хорлохыг хүсдэггүй. Тиймээс би ертөнцийн энэрэл нигүүлслэлийн хуулийн дагуу ингэсэн юм” гэжээ.

Тэр хүн маш зөрүүд нэгэн аж. Тэр “Та энэ нутгийн бүх хүнд

тусалдаг биз дээ, гэтэл одоо надад туслахгүй байна. Би үүнийг чинь л мэдэж байна” гэв.

Ийм хүн байдаг эсэхийг би мэдэхгүй. Та хэзээ нэгэн цагт ийм хүнтэй тааралдаж байсан уу? Тийм үү, та учирч байсан уу? Ямар ч учир зүй, шалтгаан, үндэслэлтэй тайлбарыг хүлээн авдаггүй. За, би иймэрхүү хэдэн хүн мэднэ ээ, тийм. Ингээд энэ хүн зол заяагүй, ядуу хоосон, юу ч үгүй тул хааныг буруутгасаар л байв.

Хаан жаахан гайхаж, “Энэ миний буруу ч байж магадгүй. Би ард түмний өмнө хүлээсэн үүрэг, засаглалдаа алдаа гаргасан юм болов уу? За, миний алдаа байсан ч одоо хэтэрхий оройтсон. Тиймээс намайг уучлаарай. Та зоригтой байж, шинэ амьдрал эхлүүлэхийг хичээгээрэй” гэв.

Тэр үглэж яншихаа больсонгүй, “Үгүй ээ, би зоригтой байж чадахгүй. Би амьдралаа тэвчиж чадахгүй. Би чамд бүх итгэл найдвараа тавьж байсан. Хэрэв чи надад туслахгүй бол одоо би яахаа мэдэхгүй байна. Хэрэв чи надад туслахгүй бол би үхнэ. Гүйцээ” гэв.

Хаан “Хэрвээ миний буруу бол, хэрэв урмыг чинь хугалсан бол намайг уучлаарай” гэх мэтийн үг хэлж уучлалт гуйв.

Өнөөх эр түүнийг дахиад л буруутгаж, “Сонсож бай, одоо чи зүгээр л ганцаараа явж байна, чамд санаа зовох зүйл алга, тиймээс чи жаргалтай байна. Харин би зол заяагүй, ядуу хоосон, үүрд хэн ч биш хэвээр үлдэнэ. Чамд намайг өрөвдөх сэтгэл алга боллолтой. Чи намайг ер нь хүн гэж тоохгүй байна. Чи зүгээр л эрх чөлөөтэй алхаж явна. Чи маш шударга бус юм” гэжээ.

Тэр үргэлжлүүлэн хааныг буруутгасаар л байв. Гэнэт хаан өгүүллрүүн: “За, надад нэг санаа төрлөө. Би чамд тусалж чадах байх. Би буруу боджээ. Надад чамд өгөх юм байхгүй гэж бодож байсан чинь байгаа юм байна. Надад эрх чөлөө минь байж байна. Энэ эрх чөлөөгөө би чамд мөнгө болгоод өгч чадах юм байна. Учир нь намайг барьж аваад шинэ хаанд аваачиж тушаасан хүн өгөөмөр шан харамж хүртэх болно. Тиймээс намайг олзолж аваад шинэ хаандаа аваачиж тушаа, ингэвэл чи хэрэгтэй бүх зүйлээ авах болно” гэв.

Гэтэл гэнэт өнөөх муу хүн маань сайн болж, “Үгүй, үгүй, үгүй, би тэгж чадахгүй. Чамайг аваад очвол тэд чамайг ячих ч юм билээ. Чамайг шоронд хийчихээд муугаар хандаж, тарчлаан зовоож, эцэст нь алж ч юуны магад. Би чамайг ингэж зүрхлэхгүй” гэв.

Гэгээн хаан маш шийдэмгий байсан тул “Үгүй ээ, чи үүнийг хийх ёстой. Чи олс дээсээр гарыг минь хүлээд намайг тийш нь аваач. Би одоо чиний олзны хүн. Чи надад итгэх ёстой. Ингэвэл шинэ хаан маш өгөөмөр загнах болно. Хэрвээ чи намайг түүнд аваачиж тушаавал хүссэн бүх зүйлээ авна. Бүр илүү ихийг ч хүртэж магад. Хааны ордны албат ч болох юм бил үү. Хааны ерөнхий сайд болох ч юм билүү. Та

хэзээ нэгэн цагт хүсэж байсан бүх зүйлээ авч, баян, эрхэмсэг байр суурьтай болох болно. Би танд талархана, учир нь би таны шаардсан ёсоор үүргээ биелүүлж, таны хүссэнээр таны төлөө ямар нэгэн зүйл хийсэн гэдгээ мэдрээд тун их баяртай байх болно” гэв.

Зөвхөн Буддагийн хувилгаан л ийм зүйл хийж чадна. Тэр Будда болчихсон нь гайхах зүйл биш.

Энэ нь тэр хүний сэтгэлийг маш их хөдөлгөжээ. Уй гашууд автсан өнөөх хүн хааны өмнө сөгдөн хөлийг нь тэвэрч, үнсээд: “Түүрүүн хэлсэн үгийг минь өршөө. Би танд гэм хүргэхгүй, танаас дахиж юу ч шаардахгүй. Та одоо явж, өөрийгөө бод” гэв.

Гэвч хэтэрхий оройтсон байлаа. Хаан тэр хүний төлөө өөрийгөө төлбөр болгон өгөхөөр хэдийнээ шийдчихсэн байж. Ингээд, удтал өөд уруугүй маргалдсаны эцэст тэр хүн гэгээн хааныг шинэ хааны ордонд аваачихаас өөр аргагүй болжээ.

Мэдээж, шинэ хаан маш их баярлажээ. Тэрээр “Аа, ха, ха. Сайн байна. Маш сайн. Ёстой сайн байна. Би чамаас тун ч, маш хатуу чангаар өшөө авах болно. Өнөөдрөөс эхлэн хэн ч чамайг ямар сайн, ямар сайн байсан, цаашдаа ямар сайн байх талаар чинь магтан сайшаахгүй. Чамайг хэн барьсан нь хамаагүй, би түүнд олон тэрбум доллар өгнө – Америк доллар. Ингэхэд чи манай талын хүн үү?” гэж гэгээн хааныг авч ирж тушаасан хүнээс асуув. “Чи манайхны нэг үү?” гэжээ.

Тэгтэл тэр хүн сөхрөн унаж: “Үгүй ээ. Би бол түүний харьяатуудын нэг. Би түүний албатуудын нэг нь. Тэр доор байгаа хааныг хэлж байгааг минь та мэдэж байгаа шүү дээ” гэв.

Шинэ хаан бухимдах янзтай болов. Урьд нь өөрөө харьяат нь байсан атлаа гэгээн хаанаа олзлон авч ирсэн гэдгийг сонсоод шинэ хаан хөмсгөө зангидав. Тэр цэвэр ариун дүр эсгэгч шиг байхыг хичээх аядан: “Юу? Урвагч уу? Та эзнээсээ урваа юу? Тэр маш сайн, нэн ёс суртахуунтай хаан байсан шиг санагддаг. Хэдийгээр чи урвагч ч гэлээ би амласан ёсоороо чамайг шагнана. Ер нь энэ хамаагүй. Чи миний энэ дайсныг барьж ирсэн тул болох нь тэр. Одоо зэвсгээ тавиад тийшээ яв. Би чамд нэг сая доллар өгье” гэж хэлжээ.

Өнөөх эр аяархан гэгч нь: “Эрхэм дээдэс ээ, надад зэвсэг байхгүй” гэж хэлэв.

Шинэ хаан ихэд гайхаж, “Юу!? Чамд ямар ч зэвсэг байхгүй гэж үү? Нээрээ юу? Тэгвэл чи яаж энэ хааныг барьсан юм? Чи түүнийг яаж барьсан юм бэ?” гэж асуув.

Гэгээн хаантныг барьж ирсэн хүн аягүйрхэж, юу гэж тайлбарлахаа мэдэхгүй байсан учраас гэгээн хаан хөндлөнгөөс оролцож, “Өө, энэ талаар асуугаад юу хийх вэ. Тэр намайг тан дээр аваад ирлээ, би одоо таны олзны хүн; та зүгээр л түүнд шагналаа өгчих. Ингэвэл болох нь тэр” хэмээв. Тэр хүнийг дэндүү их чалчаад байвал хаан шагналаа

өгөхөө больчих вий гэж түүний санаа зовжээ. Тэгээд л “Түүнд шагналаа л өгчих. Ингээд л болоо шүү дээ. Тэгэх үү?” гэжээ.

Шинэ хаан хуучин хаан луу нэг хараад, түүнийг барьж ирсэн хүн лүү бас нэг хараад ямар нэг хачирхалтай зүйл байх шиг санагджээ. Тэгээд тэр хааныг олзолж ирсэн хүнээс “Чи түүнийг яаж барьсан юм бэ?” гэв.

Тэгтэл хааныг барьж ирсэн хүн: “Өө, үгүй ээ, би биш, би түүнийг бариагүй. Энэ... нөгөө юу... тэр, тэр... аа... тэр надад хэлсэн... гэхдээ би хүсээгүй... тэр, тэр л... тэр...” гэж ээрч муурав. Миний юу хэлэх гээд байгааг ойлгож байна уу?

Тиймээс гэгээн хаан түүнд “Чишш. Ариун нэрсээ унш. Битгий юм ярь” гэв. (Их Багш болон бүгд инээв)

Гэтэл муу хаан түүнийг шахсаар: “Тэгэхээр байна аа, чи надад үнэнээ хэлэх ёстой. Эсвэл шан харамжгүй хоосон үлд” гэв.

Нөгөө хүн мэгшин уйлсаар байв, тэгээд нулимс дуслуулан өвдөг сөгдөж, шалан дээр мөлхөж, хааны ордонд ирэхээс өмнө хээр талд гэгээнтэн хаан тэр хоёрын хооронд болсон явдлыг шинэ хаанд өчив.

Энэ явдлыг сонсоод хөрш хаан бүр цочирдож орхив. Тэр нүдээ томоос том бүлтийлгэв - билгийн нүд биш, ердийн нүдээ шүү. Билгийн нүд нь хараахан нээгдээгүй байгаа. Зүгээр л ердийн нүдээ бүлтийлгэн амаа ангайлгаад (Их Багш дуурайн харуулж, бүгд инээв) нэг хэсэгтээ л хөшчихөв. Учир нь энэ ертөнцөд ийм сайхан сэтгэлтэй, хариу нэхдэггүй, ийм нигүүлсэнгүй, ийм аминч бус хүн, гэгээн хаан шиг хүн байдаг гэдэгт итгэх чадахгүй байв. Хэсэгхэн зуур ийм хувиа хичээсэн, шунаг сувдаг, харгис хэрцгий, зэрлэг догшин, атаархуу жетөөрхүү өөрийгөө түүнтэй харьцуулан бодов. Энэ гэгээн хаантай зүйрлэхийгээр юм өөрт нь юу ч байсангүй. Ингээд хэсэг зуур дуугаа хураан чимээгүй суусны эцэст тэр гэгээрсэн ч байж мэднэ.

Тэр босч, гэгээн хаан дээр бууж очоод түүнийг түшин босгож, улмаар хувцас хунар, хаан титмээ тайлж, гэгээн Хаанд өмсүүлээд: “Намайг уучлаарай. Одоо бүх зүйл таных. Та надаас илүү эрхэмсэг сайн юм байна” гэжээ. Түүнд тун ч харамсалтай байлаа. (Алга ташилт.)

Маш сайхан үлгэр байна. Та нар өдөр бүр ийм нэг үлгэр түүх уншаад байвал өөрчлөгдөх байх аа. Гэртээ ийм номтой юу? Үгүй юу? Хэдийг олж авахыг хичээ. Буддын шашны судар, бас эрдэнэс баялагийн тухай үлгэр түүхэнд энэ мэт зүйл олон гардаг. Тиймээс, хэрэв та ийм гэгээнтэн, Буддагийн хойд дүр болохыг хүсэж байвал өдөр бүр уншиж болно - заримыг нь хэрэгтэй үедээ уншиж болно. Ингэх нь ач тустай шүү. Тус болж магадгүй. Ийм муу хаанд хүртэл тус болсон байхад бидний хувьд бүр ярилтгүй биз? Бид тун сайн хүмүүс, тиймээс бүр ч их тус болох ёстой.

Тэгэхлээр ойлгож байна уу, ихэнх Их Багш нар бидэнд: “Бүхнийг

орхисон цагтаа л чи бүх зүйлтэй болно” гэж үргэлж захидаг. Библид ч бас: “Амьдралд хэт хүлэгдвэл та түүнийг алдана; харин орхиж огоорсон нь мөнх амьдралд хүрнэ” гэж дурдсан байдаг. Үүн лүгээ адил, хэрэв бид үнэнээсээ сэтгэл хүлэгддэггүй, эсвэл энэ дэлхий дээрх ямар ч эд хөрөнгө, алдар хүнд, нэр цол гэх мэтийн зүйлд өөрийгөө хүлж зууралддаггүй бол бүх зүйл бидэнд үнэхээр хүрээд ирнэ. Гэтэл бид энэ хорвоогийн ямар нэг зүйлд нэгэнт боолчлогдчихсон бол түүнийхээ араас үүрд гүйх болно; ядарч туйлдаж, оюун ухааны чадвараа үрэн таран хийнэ; бидний замд элдэв янзын таагүй зүйл тохиолдоно, тэглээ ч гэсэн ч ямар нэг амжилтад хүрэх баталгаа байхгүй. Үнэхээр ийм л байдаг. Би ч бас туршлагаа үндэслэн ярьж байна. Бид зөвхөн Бурхны Орныг эрж хайгаад эхэлмэгц л бидэнд бүх зүйл үнэхээр байж байх болно. Тэр байтугай бид үүнийг хүсээгүй байтал хаанаас ч юм хүрээд ирдэг; биднийг нэвтлэн гараад ирдэг. Заримдаа бид үүнийг хүсээгүй мөртлөө зүгээр л хүлээж авах ёстой болдог. Ингэх нь бас маш хэцүү, заримдаа харин татгалзах нь бэрх байдаг.

Заримдаа, та бүхний мэдэж байгаачлан, энд бидэнд маш хатуу чанга байдаг. Ийм байх нь миний хувьд бол сайн хэрэг. Эс бөгөөс бэлэг сэлт мэтийн зүйлс хаа сайгүй хөглөрч байх байсан. Урьд нь би бэлэг авдаггүй гэдэг байсан. тэгэнгүүт хүмүүс ийш нь шидчихээд зугтчихдаг. Ингэдэг юм. Хөөрхий би. Би түүнийг нь цуглуулаад өөр хэн нэгэн хүнд өгөх хэрэгтэй болдог. Ингэхийн ашиг тус нь юунд байна аа? Яагаад гэвэл надад үнэндээ юу ч хэрэггүй. Инээдтэй нь, Библид ингэж бичсэн байдаг юм: Юмтай хүн улам их юмтай болно. Юмгүй хоосон хүн улам л бага хүргэнэ. Гэхдээ энэ нь танд юу ч байхгүй бол танд юм бага байх болно гэсэн үг биш. Гол нь танд юу ч байхгүй үед, та ихэнхдээ юм хүсэхээ үргэлжлүүлээд л байдаг, хүсэхүйн энерги чинь тан луу ирэх бүх зүйлийг зогсоогоод яг л хана мэт үүрэг гүйцэтгэдэг.

Яг үүн шиг, бид сүнслэг бясалгал дадуулахдаа чин сэтгэлээсээ хандах ёстой, шунаг сувдаг байх хэрэггүй, материаллаг зүйлийг дээдэлдэг сүнслэг бясалгагчтай адилхан байх ёсгүй. Миний өчигдрийн хэлсэн шиг бүх зүйл аяндаа ирнэ. Бид залбирч болно, гэхдээ шунаж сувдаглалгүй, нэхэж шаардалгүйгээр чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй. Тийм шүү, үүнд тун өчүүхэн ялгаа бий. Хэрвээ та гэтлэхүйд тэмүүлэх, билиг ухаанд тэмүүлэх, Үнэнийг таньж мэдэхэд тэмүүлэх, шунал хүсэл болон эрмэлзэл тэмүүллийн хоорондох ялгааг мэдэж чадвал; Үнэнийг таньж мэдэхийн төлөөх хүсэл тэмүүлэл болон шунал хүслийн хооронд маш бага ялгаа бийг мэдчихнэ. Хэрэв бид тэнцвэрээ сайн олохгүй бол аль нэг тал руу нь хөл алдана. Бид нөгөө тал руугаа - илүү сүнслэг хүсэл тэмүүлэл рүү алхах нь сайн хэрэг. Тэгвэл л тэр өдөртөө бид маш сайн бясалгана. Гэвч бид өдөр бүр ингэж залбирах албагүй. Зөвхөн юм болж өгөхгүй байх үед л тэг. Заримдаа бүх зүйл хав хар, эсвэл бүүдгэр харанхуй мэт санагдах үед та Их Багшдаа чин сэтгэлээсээ залбир, тэр

үед л ийм зүйл тохиолдоно. Үргэлж ингэдэг юм.

Би энэ “ажил хэрэг”-ийг хүлээн авах хүртлээ Их Багш хариу өгөхгүй байхыг маш ховор харсан. Дотоодын Их Багш таны залбирлаас татгалзах нь тун ховор. Их Багш татгалзсан бол тэр хүсэлт гуйлт надад тохирохгүй зүйл гэсэн үг. Ердөө л энэ. Би сүүлд нь л ойлгосон.

Заримдаа Их Багш биднээс ямар нэг зүйлийг минь авчихаар бид маш их өрөвдөм золгүй хүн болчихсон мэт санагддаг. Бид Их Багш намайг хайхарсангүй, “Дотоодын Багш минь намайг үүнд дуртайг мэддэг мөртлөө яагаад авчихав аа?” гэж боддог. Гэхдээ энэ үнэн биш. Хожим нь өөрийн чинь төлөө үүнээс ангижируулсанд нь та түүнд маш их баярлана. Тийм шүү, ийм л байдаг.

Заримдаа бид хэн нэгэнд хайртай болдог, хүнд дурлах гэх мэтийн иймэрхүү зүйл болдог. Тэгтэл Их Багш гэнэт сэтгэл татам, маш үзэсгэлэнтэй, ухаалаг өөр нэгнийг илгээдэг. Бид “Бурхан минь, би сайхан эмэгтэй дэгээдэх нь тун ховор байхад Их Багш өөр хүнд түүнийг надаас булааж ав гэж тушаасан байна” гэж боддог. Тэгээд л бид энэ зүйлээс болж усан нүдэлдэг. Хожим нь бид илүү сайн хүнтэй учирсныхаа дараа өнгөрснийг эргэж хараад “Өө! Энэ нь хамаагүй дээр юм байна” гэдэг. Тэр цагт бид Их Багшдаа хандан: “Их Багш минь, та үүнийг ч бас авмаар байвал зүгээр ээ, авч болно, (Их Багш болон бүгд инээв) яагаад гэвэл та ирээдүйд надад бүүр сайныг өгөх ч юм билүү, тэгвэл ч болно шүү” гэж залбирч ч мэднэ.

Бидэнд үнэхээр юу сайныг бид хэзээ ч мэддэггүй. Бид үргэлж нээлтэй байж, хүлээж авах ёстой. Тэр үед л бид амьдрал маань юутай гайхалтай сайхан, тэр чигтээ зохицол нийцэлтэй, үзэсгэлэн төгөлдөр, хоногийн хорин дөрвөн цагийн турш адислал ерөөлтэй байгаагаа мэдэх болно. Ямар ч асуудалгүй. Энэ бол бид жинхэнэ хайрыг мэдэх тэр цаг мөч; энэ бол урьдчилсан нөхцөл болзолгүй, нэхэж шаарддаггүй хайр; юу ч горьддоггүй хайр юм, яагаад гэвэл бүх зүйл адис буянтай болж, бүх зүйл бидэнд таатай сайхан болно. Харин дараа нь, хааяа, хэрэв Бурхан бидний хайртай хүнийг, эсвэл эд зүйлийг нь авчихсан ч, хожим нь “Хөөх! Хамаагүй дээр юм. Би чөлөөлөгдөж, гэтлэгдсэн” гэж ойлгодог.

Нөгөө хүн бидэнд ямар хайрыг санал болгох нь хамаагүй, ямар нэг асуудал, ямар нэг хүлээс үргэлж л байдаг, учир нь бид тэр хүнийг анхааран халамжлах ёстой болдог, бид түүнд сайхан сэтгэлээр сайнаар хандаж, нөхөрсөг байх хэрэгтэй болдог. Эс бөгөөс зөвхөн нэг өгүүлбэр буруу хэлэхэд л, эсвэл заримдаа бид зөв зүйл хийсэн ч нөгөө хүн буруугаар ойлгоход л бүх зүйл дуусна. Тэр цагт бид үргэлж санаа зовж: “Тэр энэнээс, тэрнээс болоод л намайг орхино. Үүний төлөө л тэр ирсэн...” “Тэр яагаад явчихав даа?” гэдэг. Та тэр эмэгтэйд баярлуулан жаргуулж, тухайлбал үнэт гоёл чимэг ахиухан авч өгөх ёстой, тэгэхгүй бол бүсгүй чинь явчихна.

Мэдээжээр, эрдэнэс, үнэтэй нандин зүйл бүхэн үргэлж гэрэлтэн гялалзаж байхын тулд биднээс асар их анхаарал шаарддаг, эрч хүчийг маань үрэн таран болгодог. Тэр бүү хэл, хайр дурлал, гэрлэлт ч бас нөр их хүчин чармайлт, хөдөлмөр шаарддаг. Тийм биш гэж үү? Танд ийм туршлага байсан уу? Танд уу? Ингэх нь үргэлж бүтэмжтэй байдаггүй. Дараа нь бид энэ бүхнийг эхлүүлэх ёсгүй байж дээ гээд л толгойгоо өвтгөж, таагүй асуудалтай тулгардаг. Гэтэл энэ нь аль хэдийн эхэлчихсэн тул өөрийгөө буруутгахгүй, бас өөрийгөө болон бусдыг зэмлэхгүйгээр, таагүй уур амьсгал үүсгэхгүйгээр, тэр зуураа нэн гашуун туршлага амсаж туулахгүйгээр үүнээс хол байна гэдэг хэцүү. Заримдаа бид бас эргэж хараад, үүндээ маш их харамсдаг.

Заримдаа бидний харилцаа, бусад хүнтэй үүсгэсэн хэвийн харилцаанд ч энэ азгүй хайр нөлөөлдөг, тэр үед бид орхин оддог. Бид хүмүүсээс айдаг, үүнээс болж бид нийгэмд тэрслэгч, эсвэл хурыцлыг жигшдэг нэгэн болдог гэх жишээтэй. Ийм сэтгэлийн шарх эдгэтэл их хугацаа орно. Тиймээс энэ дэлхий дээр бидэнд сайн зүйл үнэндээ байхгүй, байдаг гэж би бодохгүй байна.

Тиймээс тэд зугтаж, гэлэн, гэлэнмаа болж, сайн дурын ажил хийж, амьдралын илүү утга учиртай зорилгод цаг хугацаа, залуу нас, эрч хүчээ зориулдаг. Тэгвэл л энэ нь бас үйлийн үрийг тэнцвэржүүлдэг. Ийм хүмүүс бол илүү хүчтэй, хажуу дэргэдээ, эсвэл ар талдаа дэмжлэг шаарддаггүй. Тэд ганцаараа үүнийг хийж чадна. Гэвч ихэнх хүн амьдрал маш их ганцаардмал, утга учиргүй гэж үздэг учраас тэдэнд амьдралын өөдлөлт, уруудалт, сайн муу, зовлон зүдүүрийг хуваалцах хэн нэг хүн хэрэгтэй байдаг. Зүгээр дээ. Аль аль нь зүгээр.

Ганцаараа амьдардаг хүн ажил хөдөлмөр, золиослол, амьдралын бусад хэрэг явдлаар өөрийгөө хүчирхэгжүүлдэг; бас хамтдаа амьдардаг хүмүүс ч бие биеийнхээ давуу талыг бэхжүүлдэг. Тиймээс аль аль нь өөр өөр арга замаар ямартаа ч хүчирхэгжинэ.

Ямар ч байлаа гэсэн, Бурхан дутагдсан зүйлийг маань үргэлж нөхөж өгдөг, тиймээс хэрэв бидэнд дотоодын нөөц юмуу, Их Багшийн хүч байвал бидний хувьд амьдрал хэзээ ч дэндүү зовлонтой, тэвчихийн аргагүй байхгүй. Бид бясалгадаг, тэгээд ч үнэндээ энэ амьдралаас тийм ч ихийг хүсдэггүй. Амьдрал амар хөнгөн, өдөр хоног амархан өнгөрдөг. Тэр цагт бид аливаа бүхнийг уягдаж хүлэгдэлгүй хийдэг болчихдог, бие биеэ шунал хүсэлгүй шахам хардаг, энэ нь дотоод Хүчийг бясалган дадуулахын нэн сайн тал юм.

Нэг л өдөр хүсэл шунал ул мөргүй арилж одно. Бусад хүнд бидний хэрэг гараагүй л бол бид дотооддоо нэн аз жаргалтай, сэтгэл хангалуун байж байдаг, тэр бүү хэл таагүй зүйл хайдаг ч үгүй. Бид “Чи тун зовлонтой өрөвдөм харагдаж байна, би чамд туслана” гэхчилэн ярьж, тусламж дэмжлэг хайж явдаггүй. Үгүй үгүй, тэгэхгүй. Бид алзахгүй.

Бид тусалсан ч, туслаагүй ч, ярьсан ч яриагүй ч, заасан ч заагаагүй ч бидний хувьд бүх зүйл хэвийн. Бид дотооддоо бүрмөсөн нэгэн бүхэл болж, сэтгэл хангалуун байх учраас бидэнд гадна талын ямар ч түлхэц хэрэггүй, эсвэл гүйцэлдүүлэх санаа сэдэл, эсхүл зорилгодоо хүрэх, сайрхан магтах энэрэл нигүүлсэл, эсвэл хариуцлага хүлээх хайр дурлал гэх мэтийн зүйл хэрэггүй болно.

## СЭТГЭЛИЙН АВШИГ-АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг сэтгэлийн авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажиг” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Тэрэл” ба “Аялгуу”-г ажиг багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон сүнслэг бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг.

Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Shadb”, “Дао”, “Аялгууны урсгал”, “ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авхуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, сэтгэлийн авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Сэтгэлийн авшиг хүртэх үеэр гэрэл ба аялгуу ажиглах онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ. Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь сэтгэлийн авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй.

Сэтгэлийн авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан сэтгэлийн авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Танаас харин ургамал хоолтон болохыг хүсэх болно. Насаараа веган хоолтон байх нь сэтгэлийн авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Сэтгэлийн авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь сэтгэлийн авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм. Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал сэтгэлийн авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө сүнслэг дадал бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө дадуулан бясалгаж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй.

Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод сүнслэг дадал бясалгалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

## ТАВАН САХИЛ

1. Амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ;\*
2. Үнэн бус зүйл хэлэхийг цээрлэнэ;
3. Өөрийн бус юмыг авахыг цээрлэнэ;
4. Садар самуун явдлыг цээрлэнэ;
5. Хорт бодис хэрэглэхийг цээрлэнэ;\*\*

\* Энэ сахилыг сахигч нь цэвэр веган хоолтон байх ёстой. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, тахиа, өндөг (үр тогтсон болон тогтоогүй өндөг, өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

\*\* Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг, уран зохиол, компьютер тоглоом тоглох зэрэг зүйлээс зайлсхийх явдал багтана.

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Сэтгэл санаагаа дээшлүүлж, өдөр тутмын амьдралд урам зориг өгөхөд зориулан Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургаал айлдварын баялаг цуглуулгыг ном, видео бичлэг, аудио бичлэг, хөгжмийн кассет, DVD, MP3, CD хэлбэрээр авах боломжтой.

Хэвлэгдсэн ном, хуурцгаас гадна Их Багшийн олон төрлийн сургаалыг интернетээс хурдан бөгөөд үнэ төлбөргүй авах боломжтой. Жишээлбэл, байнга хэвлэгддэг Мэдээний сэтгүүлийг хэд хэдэн вэб хуудсаар хандаж унших боломжтой. (“Гуан Инь вэб сайтууд” хэсгийг үзнэ үү). Бусад онцлох онлайн хэвлэлүүд нь Их Багшийн яруу найраг, урам зориг сэргээх онч үгс, түүнчлэн видео болон аудио файл хэлбэрээр байгаа лекцүүдээс бүрддэг.

### Ном

Завгүй өдрийн дундуур Их Багшийн номнуудаас нэгийг сөхөн унших нь чухам л аврал гэлтэй. Түүний үгс нь бидний жинхэнэ Мөн чанарыг тод сануулдаг. Түүний “Агшин Зуур Гэгээрэхийн түлхүүр” цуврал номууд дахь сүнлэг мэдээллийн айлдварууд эсвэл “Аниргүйхэн нулимсыг хайрлахуй” номын нигүүлсэнгүй яруу найргуудын алийг ч бай унших нь танд мэргэн ухааны эрдэнэс хүртээх мэт билээ.

Дараах номын жагсаалтад бэлэн байгаа ботиудын дугаарыг хэл тус бүрээр хаалтанд бичсэн. Эдгээр болон бусад номыг олж авах дэлгэрэнгүй мэдээллийг “Ном хэвлэлийг олж авах” хэсгээс авна уу.

### Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр:

Ау Лак (1-15), Хятад (1-10), Англи (1-5), Франц (1-2), Фин(1), Герман (1-2), Унгар (1), Индонез (1- 5), Япон (1-4), Солонгос (1-11), Монгол (1,2,6,8), Португал (1-2), Польш (1-2), Испани (1-3), Швед(1),Тай (1-6), Төвөд (1),

### Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт

Ау Лак (1-4), Хятад (1-3), Болгар (1), Англи (1-2), Монгол(1-2),Франц (1), Герман, Унгар, Индонез (1- 3), Япон, Солонгос (1-4), Чех (1), Польш (1), Португал (1), Орос (1)



**Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр** – Тусгай хэвлэл: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал

Англи (1-6), Хятад (1-6)

**Тусгай хэвлэл/1992 оны Долоон хоногийн дияан:**

Англи ба Ау Лак хэлээр

**Багш шавийн хоорондын захиа**

Англи (1), Хятад (1-3), Ау Лак (1-2), Испани (1),

**Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд**

Ау Лак (1-2), Хятад (1-2)

**Багш үлгэр ярьж байна**

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

**Амьдралаа өнгөлөг болгож, солонгоруулья**

Хятад, Монгол, Англи, Ау Лак

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг**

Ау Лак, Хятад, Англи, Франц, Япон, Солонгос, Монгол

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**

Англи ба Хятад

**Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**

Хятад, Англи, Ау Лак

**Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам**

Хятад, Англи

**Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн үлгэрүүдийг ухаарахуй**

Хятад, Англи

**Эрүүл мэндээ ухаарахуй - Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй**

Хятад, Англи

**Гэрт чинь хүргэж өгөхөөр Би ирлээ**

Араб, Ау Лак, Болгар, Чех, Хятад, Англи, Франц, Герман, Грек, Унгар, Индонез, Итали, Солонгос, Монгол, Польш, Испани, Түрк, Румин, Орос

**Онч үгс**

Ау Лак/ Англи/ Хятад, Испани/Португал, Франц/Герман, Англи/Япон, Солонгос/Англи хос хэлээр нэгтгэсэн ботиуд, Хятад болон Англи

**Тэнгэрлэг зоог (1)- Олон улсын ургамал хоолны гал тогоо**

Англи/Хятад хос хэлээр нэгтгэсэн боть, Ау Лак болон Япон

**Тэнгэрлэг зоог (2)– Гэрийн хоолны амтат сонголт**

Англи/Хятад хос хэлээр нэгтгэсэн боть

**Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй** (тусгай хэвлэл)

Англи/Ау Лак/Хятад хос хэлээр нэгтгэсэн боть

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Урлагийн бүтээлийн цоморлог - Уран зургийн цувралууд**

Англи болон Хятад хэлээр

**Тэнгэрийн хувцас**

Англи/Хятад хос хэлээр нэгтгэсэн боть

**Ноход миний амьдралд**

Англи, Ау Лак, Хятад, Герман, Монгол, Испани, Солонгос, Япон, Польш

**Шувууд миний амьдралд**

Англи, Ау Лак, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

**Эрхэм ариун амьтад**

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

**Тэнгэрийн Урлаг**

Англи, Хятад

**Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс**

Англи, Хятад, Солонгос, Франц, Индонез, Испани, Португал, Польш, Орос, Румин, Монгол

**Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:**

Доктор Жанезын бичсэн ном Хятад хэл дээр

**Яруу найргийн цомирлогууд****Аниргүйхэн нулимсыг хайрлахуй**

Их Багшийн яруу найргуудын ном: Англи/Хятад, Герман/Франц, Ау Лак, Англи, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

**Вуузуу шүлгүүд**

Ау Лак, Хятад Англи хэл дээр байгаа Их Багшийн яруу найраг

**Эрвээхэйн мөрөөдөл**

Англи, Ау Лак, Хятад

**Өмнөх амьдралын зам мөр**

Англи, Ау Лак, Хятад

**Хуучин цаг**

Англи, Ау Лак, Хятад

**Хайрга ба Алт**

Англи, Ау Лак, Хятад

**Мартагдсан дурсамж**

Англи, Ау Лак, Хятад

**Эрин зууны хайр**

Англи, Ау Лак, Хятад, Франц, Герман, Монгол, Солонгос, Испани

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, хөгжим, концертуудын MP3, MP4, DVD, CD зэргийг Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филиппин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэл дээр олж танилцах боломжтой. Шууд асууж лавлаж болно.

**Ном хэвлэлүүдийг олж авах**

Бүх ном хэвлэлийг өртөг зардалтай нь дөхүү үнээр санал болгодог. Хэрэв та ном хэвлүүдээс худалдан авах эсвэл захиалах бол эхлээд орон нутгийнхаа Төв эсвэл Холбогч хүнээс бэлэн байгаа эсхийг лавлана уу. Бэлэн байгаа ном хэвлэлүүдийн жагсаалтыг авахын тулд та орон нутгийнхаа Төвөөс лавлаж эсвэл дараах вэб сайтад зочилж болно:

<http://smchbooks.com/new-c/cover/cover.htm>

Celestial: <http://www.thecelestialshop.com>

Eden Rules: <http://www.edentules.com>

Түүнчлэн, Мэдээний сэтгүүлүүдийн онлайн хувилбарт шинээр хэвлэгдсэн ном, хуурцгуудын жагсаалтыг хэвлэсэн байдаг. Дияаны үеэр гардаг Үзэсгэлэнгийн хэсэг бол Их Багшийн ном, хуурцаг, фото зураг, уран зураг, гоёл чимэглэлийн зүйлсийг нүдээр үзэх сайхан газар юм.

Танд хэрэв хэрэгцээ гарах юм бол Формоса дахь Төв Албанаас дараах хаягаар захиалгаа шууд өгөх боломжтой: Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса, БНХАУ (36899). Дэлгэрэнгүй катологийг хүсэлт гарган авах боломжтой.

### Гуань Инь веб сайтууд:

Бурхантай шууд холбогдох- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг: <http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm>

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Гуань Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой. Мөн олон орны хэл дээр “Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно.

## “АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР ҮЛГЭР ДЭВТЭР”

“Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр: Үлгэр дэвтэр” хэмээх товхимол нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургаал айлдварын танилцуулга юм.

Цахимаар энэхүү товхимлыг дэлхийн өнцөг булан бүрээс уншигчид үнэ төлбөргүй татаж авах, эсвэл интернет хэрэглэх боломжтой хаана ч онлайн хэлбэрээр унших боломжтой. Африк, Зулу, Бенгал, Урду, Македон, Малай гээд дэлхийн 80 гаруй хэлээр энэхүү билиг ухааны сувд орчуулагдсан байдаг.

Энэхүү товхимолд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өдөр тутмын амьдралд бясалгалыг дадуулахын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байдаг. Түүний оюун санааны дээд хэмжээсүүд, болон ургамал хоолны дэглэмийн ашиг тусын тухай айлдварууд, мөн эцсийн бөгөөд хамгийн дээд зам мөр Гуань Инь бясалгалын сэтгэлийн авшиг хүртэх тухай мэдээллийг багтаасан болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр” номонд хуваалцсан оюун санааг дэвшүүлэх ухаарлууд нь Үнэнийг эрэлхийлэгч хэнд ч итгэл найдвар төрүүлдэг юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ийнхүү айлджээ: “Дотоод амар амарлингуйгаа олж авснаар бид бусад бүх зүйлийг олж авна. Сэтгэл бүрэн ханаж, тэнгэрлэг диваажин болоод газар дэлхийн эрмэлзэл хүслэн бүхэн биелэн гүйцэлдэх нь бидний хамгийг чадагч хүч, мөнхийн билгүүн ухаан, мөнхийн нийцэл зохирлын дотоод ухаарахуй болох - Бурхны орноос ирдэг юм. Энэ бүхнээ эс олвоос бид хэчнээн их мөнгө хөрөнгөтэй, нийгэмд хэчнээн өндөр байр суурьтай байлаа ч хэзээ ч сэтгэл хангалуун болж чадахгүй.”

Үлгэр дэвтрийг дараах хаягаар шууд үзэх боломжтой:  
<http://sb.godsdirectcontact.net/>

Энэхүү вэбсайт нь Их Багшийн Үлгэр дэвтэр товхимлыг олон хэл дээр санал болгодог. Бурханы илгээлтийг хуваалцаж, хүмүүн төрөлхтний ухамсарыг дээшлүүлэх замаар даян дэлхийд хамгийн сайхан бэлэг өргөн барихын төлөө бидэнтэй нэгдээрэй. Хэрэв таны өөрийн төрөлх хэл манай жагсаалтад байхгүй байх юм бол эсвэл товхимлыг өөрийн сонгосон хэл рүү орчуулахыг хүсэж байвал бидэнтэй холбоо барина уу: [divine@Godsdirectcontact.org](mailto:divine@Godsdirectcontact.org)

Үлгэр дэвтрийг Үнэгүй татаж авах:

<http://sb.godsdirectcontact.net> (Формоса) (АНУ)

<http://www.direkter-kontakt-mit-ott.org/booklet> (Австри)

**БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг  
 Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса, БНХАУ (36899)  
 Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни 95173-0247, АНУ  
 Суприм Мастер Телевиз  
 И-мэйл: pease@SupremeMasterTV.com  
 Утас: 1-626-444-4385 / Факс: 1-626-444-4386  
<http://www.suprememastertv.com/>  
 Ном орчуулгын групп:  
 И-мэйл: divine@godsdirectcontact.org  
 (Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд оролцож болно.)  
 Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэгийн  
 Хэвлэлийн ХХК, Тайбэй, Формоса.  
 И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org  
 Утас: 886-2-23759688 / Факс: 886-2-23757689  
<http://www.smchbooks.com>

Мэдээний групп:  
 И-мэйл: lovenews@godsdirectcontact.org  
 Асуулт хариултын баг:  
 И-мэйл: lovenews@godsdirectcontact.org  
 S.M. Celestial Co., Ltd:  
 И-мэйл: smclothes123@gmail.com;  
 Vegan999@hotmail.com  
 Утас: 886-3-4601391  
 Факс: 886-3-460285722261345  
<http://www.sm-cj.com>  
 Онлайн Дэлгүүр  
<http://www.theCelestialShop.com>  
 Eden Rules: <http://www.EdenRules.com/>

Loving Hut - Олон Улсын Ургамал Хоолны Сүлжээ ресторан  
 Утас: 886-3-4683345 / Факс: 886-3-4681581  
 И-мэйл: service@lovinghut.com  
 Веб сайт: <http://www.lovinghut.com/tw/>

Цэвэр веган бүтээгдэхүүний “Loving Food” онлайн дэлгүүр  
<http://www.lovingfood.com.tw> ”

## АГШИН ЗУУР

### Гэгээрэхийн Түлхүүр – 7

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
 Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай –  
 Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн ХХК  
 БНХАУ, Формоса, Тайбэй хот,  
 Жүнзэн дүүргийн баруун замын 1-р хэсэг, 72-8-16  
 Утас: 886-2-23759688 / Факс: 886-2-23757689  
 И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org  
 Шуудангийн дугаар: 19259438

Анхны хэвлэл: 1996 оны 2 дугаар сар  
 Хоёр дахь хэвлэл: 2002 оны 9 дүгээр сар  
 Гутгаар хэвлэл: 2007 оны 10 дугаар сар  
 Дөтгөөр хэвлэл: 2011 оны 9 дүгээр сар  
 БНХАУ, Формасад хэвлэв  
 ISBN: 978-986-6895-18-0

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1996~2015

Зохиогчийн эрх хамгаалагдсан.

Энэхүү номын агуулгыг хэвлэлийн компаниас зөвшөөрөл авсны  
 дараа хуулбарлаж болно

Бидний хэдэн шавь нар өөрсдийн туулж өнгөрүүлсэн Үнэн ёсыг эрж хайсан зүдгүүрт аянаасаа энэ дэлхийд морилон саатаж буй Төгс Гэгээрсэн Их Багштай учрахад нэн бэрх, жинхэнэ номыг хүртэхэд хэцүү болохыг бүрэн ойлгосон билээ.

Энэхүү ном нь жинхэнэ эртний Их Багшаас уламжлагдан ирсэн хамгийн дээд номын судас мөн тул хүний уг чанарын билиг ухааныг сэрээж, тэдэнд Үнэн ёсыг ойлгуулж чадна.

Бид Арьяабалын аргаар дадуулан бясалгаж арвин их ололтыг олсон тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чинхайн дэлхийн олон оронд айлдсан айлдваруудын агуулгыг эмхэтгэж ном болгов. Энэ төрөлдөө сансрын хүрднээс гэтлэхийг хүсэн эрмэлзэж буй Үнэн ёсыг хайгчид болон хүний үхэж төрөхийн утга учир, сүнслэг дадал бясалгал хийхийн ач холбогдол, гэгээрэл, Үнэн Ёсны талаархи асуултуудад хариулт авахыг хүссэн хүмүүст туслахыг зорилоо.